The State Great Hural of Mongolia,
Standing Committee on Security and Foreign Policy
Office of the President of Mongolia
The Ministry of Foreign Affairs
The Parliamentary Research and Development Institute

National University of Mongolia
Mongolian National University of Education
Otgontenger University
Institute for Strategic Studies

SPSIRPA FORUM 2025

Regions and States at the Crossroads of a New World Order

Date

2025.05.16-17 / 09:00-18:00

Venue:

Consensus Hall, Ministry of Foreign Affairs of Mongolia
National University of Mongolia

ISBN 978-9919-521-84-4

ISBN 978-9919-521-84-4

Editor in Chief: S.Munkhbat

Editorial Address:

School of Political Sciece, International Relations And Public Administration, National University of Mongolia

NUM Building V, Sh.Kh-6. Ulaanbaatar - 46A, Baga Toiruu 1,

Ulaanbaatar, Mongolia

Tel: 77307730-5101

Webpage: https://spsirpa.num.edu.mn/

AGENDA

OPENNING REMARKS Venue: Chinggis Khan Hall, the State Palace, Ulaanbaatar

09:00-09:10 **Temuulen G.**
Chair of the Standing Committee on Security and Foreign Policy of the Parliament, Member of Parliament

09:10-09:20 **Odbayar E.**
Foreign Policy Advisor to the President of Mongolia

09:20-09:30 **Battsetseg B.**
Minister of Foreign Affairs, Member of Parliament

09:30-09:40 **Munkhbat S.**
Ph.D., Dean of School of Political Science, International Relations and Public Administration, NUM / President of Mongolian Political Science Association

KEYNOTE SPEECHES

09:40-10:00 **"Changing Geopolitical Environment: Foreign Policy of Small States (The Case of Mongolia)"**
Munkhbat S., Ph.D., Professor, Dean of School of Political Science, International Relations and Public Administration, NUM / President of Mongolian Political Science Association
Bayasgalan S., Ph.D., Associate professor, Chair, Department of International Relations, NUM, Mongolia

10:00-10:20 **"Geopolitical Implications of Mongolia's Strategic Partnership with Third Neighbours"**
Sharad Kumar Soni, Ph.D., Professor, Jawharlal Nehru University, India

10:20-10:50 **Tea break**

10:50-11:10 **"The US-China Competition, the Disruptions of Supply Chains, and Competing Regionalism in Asia"**
Hyun-Chin Lim, Professor Emeritus, Seoul National University, South Korea
Turtogtokh J., Professor, Department of Political Science, National University of Mongolia

11:10-11:40 **Discussion Q&A**

12:00-14:00 **Lunch break**

14:00-17:30 **Sessions conference** Venue:

Session 1:	**National and Regional Reactions to a New World Order**	Academic round Hall, NUM Main Building
Session 2:	**Changing Geopolitical Environment: Mongolia and Its Neighbors**	502, Development Center for Faculties and Students, NUM
Session 3:	**Public Governance**	Meeting Hall, Mongolia – Japan Center, NUM
Session 4:	**National and Regional Reactions to a New World Order**	320, 3rd floor, Main building, NUM
Session 5:	**Changing Geopolitical Environment: Mongolia and Its Neighbors**	506, Development Center for Faculties and Students, NUM
Session 6:	**Public Administration**	Meeting Hall, Mongolia – Japan Center, NUM

17:30-17:40 **Closing remarks (Academic Round Hall, 2nd floor, Main Building, NUM)**

OPENING REMARKS

С.МӨНХБАТ

МУИС-ИЙН УТСОУХНУС-ИЙН ЗАХИРАЛ

Эрхэм хүндэт УИХ-ын гишүүн, АБГББХ-ны дарга Г.Тэмүүлэн

Эрхэм хүн хүндэт УИХ-ын гишүүн, Гадаад Харилцааны сайд Б.Батцэцэг

Эрхэм хүндэт эрдэмтэн судлаачид, хүндэт зочид оо

Та бүхний энэ өглөөний амар амгаланг айлтган мэндчилье.

МУИС-ийн Улс төр судлал, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулиас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг SPSIRPA олон улсын эрдэм шинжилгээний хурал энэ жил 8 дахь удаагаа ийнхүү зохион байгуулагдаж байна. Энэ жил өмнөх жилүүдтэйгээ харьцуулахад хуралд оролцогчид болон хамтран зохион байгуулагчдын хүрээг тэлж, олон орны эрдэмтэн мэргэд, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагыг хамран, УИХ-ын АБГББХ-ны ивээл дор, ГХЯ, ЕТГ-ын дэмжлэгтэйгээр зохион байгуулагдаж хурлын чанар чансаа дээшилж, хамрах хүрээ тэлж, ач холбогдол улам бүр нэмэгдэж байгаагаараа онцлогтой болж байна.

Юуны өмнө энэхүү олон улсын эрдэм шинжилгээний хурлыг ивээлдээ авч хамтран ажиллаж байгаа УИХ-ын гишүүн АБГГБХ-н дарга Г.Тэмүүлэн, дэмжин ажиллаж байгаа УИХ-ын гишүүн, ГХ-ны сайд Б.Батцэцэг, Ерөнхийлөгчийн гадаад бодлогын зөвлөх Э.Одбаяр Та бүхэнд хүрэлцэн ирсэн гадаад, дотоодын судлаачид, нийт оролцогсодынхоо нэрийн өмнөөс чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Хурлын зохион байгуулахад хамтран ажиллаж байгаа МУБИС, ПСХХ, ОТИС, ССХ зэрэг сургалт, эрдэм шинжилгээний байгууллагын удирдлага, хамт олон чин сэтгэлийн талархал илэрхийлж байна.

Дэлхийн улс төр, олон улсын харилцаа ээдрээтэй, их гүрнүүдийн бодлогын сөргөлдөөн түүнийг дагасан геополитикийн шинэ орчин, нэг туйлт олон улсын харилцаанаас олон туйлт олон улсын харилцааны шинэ дэг жаяг тогтох нь нэгэнт тодорхой болож байгаа энэ үед “Дэлхийн шинэ дэг жаягийн уулзвар дахь бүс нутаг ба улс орнууд” сэдвийн дор зохион байгуулагдаж байгаа нь энэхүү олон улсын эрдэм шинжилгээний хурал ач холбогдолтой болж байна.

Олон улсын харилцаа, геополитикийн шинэ орчин бүрэлдэж буй цаг үед Монголын Улсын гадаар харилцааг эрс сэргэж энхийг эрхэмлэсэн олон талт хамтын ажиллагааг бүс нутгийн хийгээд дэлхий дахинд явуулах бодлогыг тууштай хэрэгжүүлж олон улсад Монгол Улсыг байр суурийг бэхжүүлэхэд урьд байгаагүй дэвшилтэт бодлого, алхамууд хийгдэж байгаа билээ. Төрийн өндөр дээд хэмжээний айлчлалууд шил шилээ даран хийгдэж Монгол Улсын нэр хүнд олон улсын тавцанд өссөөр байна. Үүнд Монгол Улсын Ерөнхийлөгч У. Хүрэлсүх, ГХ-ны сайд Б.Батцэцэг, Ерөнхийлөгчийн гадаад бодлогын зөвлөх Э.Одбаяр нарын гүйцэтгэж буй үүрэг ролийг их гэдгийг хурлын энэхүү индрээс хэлэхэд таатай байна.

С.МӨНХБАТ

МУИС-ИЙН УТСОУХНУС-ИЙН ЗАХИРАЛ

...

Өнөөдрийн хуралд дэлхийн 9 орны 20 гаруй их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын эрдэмтэн судлаачид нэгдсэн хуралдаан болон 6 салбар хуралдаанаар нийт 66 илтгэл хэлэлцүүлнэ. Орчин үед олон улсын харилцааны нэг чухал хэрэгсэл болж буй Science Diplomacy нь эрдэмтэн судлаачдын хамтын судалгаа, судалгааны үр дүнгээ хуваалцах, харилцан мэдлэг солилцох үйл явцаар өрнөж байдгийн тод жишээ нь өнөөдрийн олон улсын эрдэм шинжилгээний хурал гэж үзэж байна.

Хурлаас гарсан үр дүнг зөвлөмж болгон боловсруулж, төрийн байгууллагад хүргэж, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулж нийтийн хүртээл болгох ажлыг цаашид зохион байгуулж ажиллах болно.

Төгсөлд нь эрдэм шинжилгээ судалгааныхаа үр дүнг хэлэлцүүлж, харилцан мэдлэг солилцох, шинжлэх ухааны дипломат харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилго тээж ирсэн гадаад дотоодын нийт судлаачид, хуралд оролцогчдод баяр хүргэж, хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.

Анхаарал хандуулсан Та бүхэнд баярлалаа.

OPENING REMARKS

Г.ТЭМҮҮЛЭН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Өнөөдрийн эрдэм шинжилгээний хуралд хүрэлцэн ирсэн Эрхэм хүндэт зочид төлөөлөгчид Та бүхэндээ болон гадаад бодлого, ҮАБ-ийн чиглэлээр мэдлэг оюунаа чилээгч, эрдэмтэн судлаачид, шинжээчиддээ энэ өдрийн мэндийг хүргэн мэндчилж байна.

Сүүлийн жилүүдэд дэлхий ертөнц асар хурдацтайгаар өөрчлөгдөж байна. Глобалчлал, эдийн засгийн интеграцчлал, улс хоорондын харилцан хамаарал, ОУ-ын тогтсон, **хүлээн зөвшөөрөгдсөн, олон туйлт дэг журам, геополитикийн уламжлалт чиг хандлага, хүчний тэнцвэрт харьцаа** энэ цаг үед хувьсан өөрчлөгдөж байна;

- Дэлхий дахинд өрнөж байгаа улс хоорондын үл ойлголцол, зэвсэгт мөргөлдөөний олон асуудлууд **энх тайванч байдлыг** улам бүр холдуулж байна.
    - Улс гүрнүүд зэвсэглэлээр хөөцөлдөж, цөмийн зэвсгээ устгах бус нэмэгдүүлэхийг ярьдаг боллоо.
    - НҮБ-ийн Аюулгүйн зөвлөлийн гишүүн улс зөвхөн өөрийн ашиг сонирхлоо хамгаалахын тулд гэрээгээ зөрчдөг болсон.
- Улс гүрнүүдийн сонирхлын зөрчил идэвхижиж, зарим гүрнүүдийн 1 талт буюу **үндсэрхэг бодлого** газар авч байна.
    - **Неореалист, супер прагматик** бодлого ОУ-д ноёлж эхэллээ. **Бодит харилцааны цаг үе** эхэлж байна.
    - Их гүрнүүдийн бодлогын энэ өөрчлөлт бусад улс, бүс нутагт ямар өөрчлөлт оруулж байгааг тогтмол үнэлж дүгнэх шаардлага бидэнд үүсгэж байна.
- Гадаад бодлогын **шинэ парадигм, шинэ хэв шинж буюу** хүчний шилжилт хөдөлгөөн, **дахин хуваарилалт, туйлшрах хандлага** илүү эрчимжиж байна.
- **Олон улсын ээдрээтэй, тодорхойгүй өнөөгийн нөхцөл** байдал судлаачдын үзэж байгаагаар олон жилийн хугацаанд үргэлжлэх төлөвтэй байна.

Олон улсын харилцааны **шинэ тэнцвэрийн энэ үед** МУ-ын хувьд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа өөрчлөлт оруулахаар төлөвлөж байгааг Та бүхэндээ дуулгах байна;

- Хүчний тэнцвэр барих бодлого буюу **тэнцвэртэй гадаад бодлого илүү** чухал болж байна.
- **Олон хэмжээст гадаад бодлого, дипломат ажиллагаа**гаа эрчимжүүлэх шаардлага үүсэж байна.
- Нөхцөл байдлыг тал бүрээс нь бодитойгоор дүгнэн, шинжилдэг байх, ШУ-ны үндэслэлтэй илүү **тооцоо судалгаанд суурилсан бодлого**, **зохион байгуулалттай шийдвэр гаргах механизм**, механизмын төлөвшил чухал болж байна.

Г.ТЭМҮҮЛЭН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

...

Өнөөдөр энэ ч үүднээс Монгол Улсын Их Хурал, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо энэхүү Олон Улсын эрдэм шинжилгээний хурлыг МУИС-ийн Улс төр судлал, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуультай хамтран зохион байгуулж байна. МУИС-ийн Улс төр судлал, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийнхандаа болон бусад оролцогчиддоо гүн талархал илэрхийлье.

Олон улсын өнөөгийн нөхцөл байдал **улам бүр тааварлашгүй** болж байгаа өнөө цаг үед бид **гадаад бодлогыг илүү эрдэмжүүлэх,** ОУ-ын харилцааны судалгааны **институцилэгдсэн тогтолцоо, судалгааны механизм** бий болгох чиглэлээр төрийн зүгээс анхаарах болохоо судлаачид Та бүхэндээ дуулгах байна.

Судалгаа шинжилгээний процессийг эрчимжүүлэх үүднээс Бодлогын судалгаа хөгжүүлэлтийг илүү дэмжих болно.

Өнөөдрийн энэхүү олон улсын эрдэм шинжилгээний хуралд БНХАУ, БНИтали Улс, Япон Улс, БНСолонгос Улс, БНЭнэтхэг Улс, Ираакаас зочид, судлаачид хүрэлцэн ирсэн байна. Та бүхэнд Монгол Улсын УИХ-ын нэрийн өмнөөс чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Эрхэм судлаачид Та бүхний байр суурийг сонсож, хэлэлцэх боломж бид бүхэнд бүрдэж байна.

Олон улсын эрдэм шинжилгээний хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.

Б.БАТЦЭЦЭГ

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

“ӨӨРЧЛӨГДӨН БУЙ ГЕОПОЛИТИКИЙН УУЛЗВАР ДАХЬ БҮС НУТАГ, УЛС ОРОН” ОЛОН УЛСЫН ФОРУМД ХЭЛЭХ ҮГ

Эрхэм хүндэт эрдэмтэн судлаачид, форумын нийт оролцогч та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Өнөөдөр Төрийн ордны хүндэт танхимд олон улсын харилцаа, аюулгүй байдлын судалгаа, сургалтын тэргүүлэх байгууллагууд, дотоод, гадаадын эрдэмтэн мэргэд, судлаачид болон шийдвэр гаргагчдын төлөөллийг оролцуулан олон улсын харилцаа, геополитикийн орчинд гарч буй өөрчлөлтийн талаар хэлэлцэж буйд Гадаад харилцааны сайдын хувьд баяртай байна.

Сүүлийн жилүүдэд дэлхий дахинд улс төр, аюулгүй байдал, геополитикийн орчин ихээхэн өөрчлөгдөж, их гүрнүүдийн өрсөлдөөн, талцал хуваагдал гүнзгийрч, олон улсын харилцааны цаашдын хандлага, төлөвийг таамаглах аргагүй болж байна. Хүйтэн дайны дараа тогтсон дэг журам, олон талт хамтын ажиллагаа, холбоотны харилцаа, эдийн засгийн интеграцийг өөрчилсөн парадигм шилжилт болж буйг зарим судлаач өгүүлж байна. Чухам ийм эгзэгтэй цаг үед, чухал сэдвээр өнөөдрийн форум зохион байгуулагдаж буйд олзуурхаж байна.

Монголчууд бид төрт ёсны эртний уламжлалтай, дэлхийн дахины үйл явдал, олон улсын харилцаанд өөрийн гэсэн зам мөрийг гаргаж явсан баялаг түүхтэй. Энэхүү түүхэн уламжлал, улс орныхоо өнөө үеийн онцлогт тулгуурлан бие даасан, нээлттэй, энхийг эрхэмлэсэн, олон тулгуурт гадаад бодлогын зарчмуудаа тунхаглаж, тууштай баримталж ирсэн нь геополитикийн хувьсал өөрчлөлт, эздрээ төвөгтэй нөхцөлд ч цагийн шалгуурыг давж, чигч, зөв болох нь улам тодорч байгаа билээ.

Монгол Улс НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн, цөмийн зэвсэгтэй хоёр их гүрний дунд, далайд гарцгүй газар зүйн байрлалтай төдийгүй шашин, соёл, эдийн засаг, засаглалын эрс ялгаатай орнуудыг багтаасан бүс нутгийн зааг дээр оршдог онцлогтой. Бид гадаад бодлогоо оновчтой тодорхойлж, үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд нэн түрүүнд оршин буй орчин, бүс нутгийн нөхцөл байдлыг зөв үнэлэх, нөөц боломжоо зохистой ашиглах шаардлагатай тулгардаг. Түүнчлэн цахим хөгжил, технологийн дэвшлийн дүнд олон улсын харилцааны динамик өөрчлөлт улам бүр эрчимжиж, та биднийг урьд өмнөхөөсөө илүү мэдрэг, шуурхай байхыг шаардаж байна. Иймд та бүхний зохион байгуулж буй энэхүү форум бидний үйл ажиллагаа, гадаад бодлогын шийдвэр гаргалтад чухал нөлөөтэй болохыг онцлон тэмдэглэе.

Нийгмийн шинжлэх ухааны аливаа судлагдахуун бүтээлч хэлэлцүүлэг, шүүмжлэлт сэтгэлгээгээр баяжин хөгждөг. Олон улсын харилцаа, гадаад бодлогын оновчтой дүгнэлт ч эрдэмтдийн бүтээлч санал, олныг хамарсан хэлэлцүүлгээс гардаг. Монгол Улсын Гадаад харилцааны яам аливаа шийдвэр гаргахдаа судалгаа, дүн шинжилгээнд тулгуурласан олон талын байр суурийг харгалзаж, салбарын судлаач, эрдэмтдээ сонсдог.

Б.БАТЦЭЦЭГ

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

...

Энэ удаагийн форумаар та бүхэн олон улсын харилцаанд өрнөж буй өөрчлөлт, цаашдын хандлагын талаар судалгаа шинжилгээнийхээ үр дүнгээс хуваалцаж, үзэл бодлоо уралдуулах гэж байна. Цаашилбал, энэхүү шинээр бүрэлдэх суурь нөхцөл, өгөгдөлд улс орнуудын бодлого, үйл ажиллагаа ямар байвал оновчтой талаар чухал санал, дүгнэлтүүд гарна гэдэгт итгэлтэй байна. Манай орны улс төр, нийгэм, эдийн засагт гарч буй өөрчлөлт, хөгжлийн бодлого зорилтууд гадаад бодлого, үйл ажиллагаатай хэрхэн уялдах талаар ч санаа бодлоо илэрхийлнэ хэмээн найдаж байна.

Тухайлбал, улс орны дотоодод чиглэсэн бодлого, хөтөлбөрүүд, Хүнсний хувьсгал, Эрчим хүчний шилжилт, Бүсчилсэн хөгжлийн бодлого зэрэг нь гадаад орчны өөрчлөлттэй хэрхэн уялдуулан хэрэгжүүлэх талаар хэлэлцэж, санал бодлоо хуваалцвал баяртай байх болно. Тиймээс нийт илтгэгчид, хэлэлцүүлэгт оролцогчид өнөөдрийн хуралд идэвхтэй оролцож, саналаа бодлоо илэн далангүй хуваалцахыг хүсье.

Манай улсын гадаад харилцаа сүүлийн жилүүдэд бүхий л салбарт хурдацтай өргөжин тэлж, үүнд оролцогч субъектүүдийн тоо ч нэмэгдсэн. Тэдний идэвхтэй оролцоог дэмжихийн сацуу гадаад харилцааг үндэсний эрх ашиг, аюулгүй байдалд нийцүүлэн, нэгдмэл байдлаар уялдуулах зайлшгүй шаардлага урган гарч байна. Өөрөөр хэлбэл, гадаад харилцааг цогцоор харж, нэгтгэн зангидах процессын шинжтэй эрх зүйн зохицуулалт үгүйлэгдэж байна. Гадаад харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, баримтлах зарчмыг тогтоож, эрх зүйн орчныг боловсронгуй, тодорхой болгохоор төлөвлөж буй ажлууд бий. Энэ зорилгоор эрдэмтэн судлаачид, мэргэжилтнүүд та бүхний санал, зөвлөгөөг авч, өргөн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулахаар төлөвлөж байна.

Төгсгөлд нь, “Олон улсын харилцаанд дан ганц итгэл, найдвар дээр тулгуурлан ажиллаж болдоггүй юм” гэх Европын Комиссын дэд Ерөнхийлөгч, Италийн Гадаад хэргийн сайд асан Федерика Могеринигийн үгийг эшлэе. Энэ бол гадаад бодлого үргэлж, судалгаа, шинжилгээнд суурилах ёстойг илэрхийлсэн оновчтой үг хэмээн үздэг тул ийнхүү онцолж байгаа юм.

Өнөөдрийн форумын нийт оролцогчид, хилийн чанадаас хүрэлцэн ирсэн болон цахимаар оролцож байгаа эрдэмтэн, судлаачдадаа гүн талархал илэрхийлье.

Та бүхний өнөөдрийн хурал, хэлэлцүүлэгт болон цаашдын судалгааны ажилд амжилт хүсье.

CONTENTS

KEYNOTE SPEECHES

“Changing Geopolitical Environment: Foreign Policy of Small States (The Case of Mongolia)”

Munkhbat S., Ph.D., Professor, Dean of School of Political Science, International Relations and Public Administration, NUM, Mongolia

Bayasgalan S., Ph.D., Associate professor, Chair, Department of International Relations, NUM, Mongolia

16

“Geopolitical Implications of Mongolia’s Strategic Partnership with Third Neighbours”

Sharad Kumar Soni, Ph.D., Professor, Jawharlal Nehru University, India

26

“The US-China Competition, the Disruptions of Supply Chains, and Competing Regionalism in Asia”

Hyun-Chin Lim, Professor Emeritus, Seoul National University, South Korea

Turtogtokh J., Professor, Department of Political Science, National University of Mongolia

CONTENTS

SESSION 1 National and Regional Reactions to a New World Order

“Straddling over Algocracy and Care Democracy in the Digital Platform Economy in South Korea”

Suk-Ki Kong, Ph.D., Research Professor, Seoul National University Asia Center, South Korea

“Aid for Security: South Korea’s ODA in Africa” 33

Jiyoung Kim, Ph.D, Professor, Chair of Department of Political Science and International Relations, Soongsil University, South Korea

Junho Jo, Graduate Student, Department of Political Science and International Relations, Soongsil University, South Korea

"Youth Perspectives and Attitudes on International Relations and Foreign Policy Issues" 59

Ariunbold Ts., Senior Analyst, Institute for Strategic Studies, Mongolia

Tsogtgerel N., Analyst, Institute for Strategic Studies, Mongolia

“From National Agents to Transnational Elites: The Evolution of WTO Panelist Networks” 73

Seulah Choi, Ph.D, Assistant Professor, Department of Political Science and International Relations, Soongsil University, South Korea

Hyo Won Lee, Ph.D., Professor, Incheon National University, South Korea Sijeong Lim, Ph.D., Professor, Korea University, South Korea

“Shifts in Energy Geopolitics and Mongolia” 96

Myagmarsuren D., Ph.D, Professor, School of Social Sciences and Humanities, Mongolian University of Science and Technology

“A Study on the Kim Jong Un Regime’s Awareness of North Korea’s Food Shortage and Response Policies Related to Climate Change” 113

SungChul Kang, Ph.D, Researcher, Soongsil Institute for Peace and Unification, South Korea

“Identifying (Un)common Patterns of Democratic Backsliding”

Geser G., Head of research division, Parliamentary Research and Development Institute, Mongolia

“Analyzing Political Settlements and Development in Mongolia” 134

Munkhjargal O., Lecturer, Department of Political Science, SPSIRPA, NUM, Mongolia

"Mongolia’s Efforts to Strengthen Parliamentary Representation: Initiatives and Outcomes" 141

Gerelt-Od E., Ph.D., School of Humanity and Social Sciences, Mongolian State University of Education

"From Kinship to Civil Society: The Struggle for Community Among Mongolian Nomads" 153

Yesukhei T., Lecturer, Department of Political Science, SPSIRPA, NUM, Mongolia

CONTENTS

SESSION 2 Changing Geopolitical Environment: Mongolia and Its Neighbors

"World Order and Disorder: World Political Map as a Tool to Explore World Politics"
Igor Okunev, Ph.D., Moscow State Institute of International Relations, Russia (online)

"Peace Through Development": China's Peace Initiative for the Middle Eastern Conflict Resolution" 161
Sun Degang, Center for Middle Eastern Studies, Fudan University, China (online)

"Influence of social media towards voting intention in India" 182
Massoud Moslehpour, Department of Management, California State University, USA
Suman Kumar, Department of Business Administration, College of Management, Asia University, Taiwan (online)

"The Role of Social Media in Elections: A Systematic Review" 203
Massoud Moslehpour, Department of Management, California State University, USA
Ankita Manohar Walawalkar, Department of Business Administration, College of Management, Asia University, Taiwan (online)

"China's Impact on Mongolian Exchange Rate"
Wing Keung Wong, Ph.D., Asia University, Taiwan (online)

"The Influence of Sino-Russian Relations on Mongolia's Foreign Policy: Evidence from UNGA Voting and ICEWS." 218
Chien-Wu Hsueh, Ph.D., National Chengchi University (online)

"The Contemporary Korean Politics and its Policies towards the US"
Kim Euikon, Ph.D., Inha University, South Korea

"The Securitization of Foreign Aid: The Case of Japan's ODA" 234
Susumu Ito, Ph.D., Professor, University of Niigata Prefecture, Japan

"Chinggisid Diplomacy and its Legacy in Modern Eurasia"
Francesca Fiaschetti, University of Vienna, Austria

"How Japan might behave in the crossroads of the world order¬?---The completion of the multipolarization and policy towards Northeast Asia"
Mitsuhiro Mimura, Ph.D., Professor, the Economic and Social Research Institute for Northeast Asia, the University of Niigata Prefecture, Japan

"Mongolia Between the Duality of Historical Heritage and Changes in the new world"
Abdulrahman F. Haider, Professor, College of Arts, University of Baghdad

"Mongolia's Economic Diplomacy and Policy: Challenges, Financial Sector Growth, and International Influences" 249
Munkh-Ulzii B., Ph.D., Associate professor, Department of International Relations, SPSIRPA, NUM, Mongolia

"Education diplomacy – One of the Instruments of Soft Power: Case on Comparison Among the U.S., ROK, and Japan's Scholarship Programs to Mongolia."
Budsuren D., Ph.D., Senior lecturer, Department of International Relations, SPSIRPA, NUM, Mongolia

CONTENTS

SESSION 3 Public Governance

"Decentralization vs. Centralization: Governance Models for the New World Order" 251
Altantuya D., Ph.D., Associate professor, Department of Public Administration, SPSIRPA, NUM, Mongolia

"Global Governance in Disorder: Deficiencies and Recommendations" 262
Quanyi Zhang, Ph.D., Professor, Shandong Vocational University of Foreign Affairs and Director of Qilu Public Diplomacy and Peace Promotion Research Centre

"Korean State Policy in Changing Domestic and International Environments" 271
Kim Seok Woo, Ph.D., Professor, University of Seoul, South Korea

"State Intervention and Labour Market Outcomes: A Study of Governance in Mongolia" 281
Enkhchimeg E., Ph.D., Senior lecturer, Department of Public Administration, SPSIRPA, NUM, Mongolia

"Impacts of Community-Based Rangeland Management in Mongolia"
Tsermaa N., Ph.D., Chair, Department of Public Administration, SPSIRPA, NUM, Mongolia

"The Current Situation of Informal Employment: A Case Study of Mongolia" 283
Munkhbat N., Senior lecturer at Department of Public Administration, SPSIRPA, NUM, Mongolia

"State Regulation and Preparedness for Artificial Intelligence" 301
Ariungerel Ts., Lecturer at Department of Public Administration, SPSIRPA, NUM, Mongolia

"Opportunities and Challenge of Implementing Artificial Intelligence in Government Decision-Making"
Lkhagvabayar N., Host of the "Nuudel Shiidel" program

"Some Ways to Improve Forest Sustainable Management Policies and Regulations: A Case Study of Alxa League, Inner Mongolia Autonomous Region" 314
Daichin, Ph. D candidate of Department of Public Administration, SPSIRPA, NUM, Mongolia

CONTENTS

SESSION 4 National and Regional Reactions to a New World Order

"The China-Mongolia-Russia Economic Corridor and China-Mongolia Cooperation" 328

Fan Li Jun, Director, "One Belt, One Road" Research Institute, Social Science Academy of Inner Mongolia, China

"A Public Opinion Survey on Local Elections" 341

Undrakh D., Ph.D., Chair, Associate professor, Department of Political Science, SPSIRPA, NUM, Mongolia

Erdenedalai B., Ph.D., Associate professor, Department of Political Science, SPSIRPA, NUM, Mongolia

Tumenjargal D., Ph.D.., Associate professor, Department of Political Science, SPSIRPA, NUM, Mongolia

"A Study on China-Mongolia Cooperation in Renewable Energy within the Framework of the Belt and Road Initiative" 359

Zorigt, Deputy Director and Associate Researcher at the Belt and Road Institute, Inner Mongolia Academy of Social Sciences

"Transformations in the Islamic World and Mongolia" 369

Enkhbat A., Ph.D, Professor, School of Social Science and Humanities, Mongolian University of Science and Technology

"Voter Turnout in Mongolia and Its Influencing Factors" 380

Myagmartsooj D., Ph.D, Dean, School of Humanities and Social Sciences, Mongolian National University of Education

"**Russia–North Korea Relations at a New Stage: Implications for the Northeast Asian Region"**

Oyuntsetseg D., Ph.D, Senior Lecturer Department of Asian Studies, SAS, NUM, Mongolia

"Democratization in Mongolia: Lessons and Mistakes"

Tuyagerel G., Ph.D, Associate professor, Department of Political Science, SPSIRPA, NUM, Mongolia

"On the Forms and Organizational Aspects of Coalition Governments in Different Countries" 402

Zolzaya G., Chair, Department of International Relations, Otgontenger University, Mongolia

"An Analysis of Factors Influencing Voter Behavior in Mongolia: The Case of Parliamentary Elections"

Sarantsetseg E., Ph.D, Senior Lecturer, Department of Political Science, SPSIRPA, NUM, Mongolia

CONTENTS

SESSION 5 Changing Geopolitical Environment: Mongolia and Its Neighbors

“Historical Periodization of MongoliaKhalmic Cooperation” 414
Naranjargal N., Ph.D., Institute for International Studies, Academy of Science of Mongolia

“Russia-Ukraine War Effect on Cultural Issues” 433
Munkhtsetseg B., Ph.D., Institute for International Studies, Academy of Science of Mongolia

“Emerging Challenges in the International Security Environment Since 2024 and Strategic Responses for their Mitigation” 448
Munkh-Orgil T., Ph.D., Dean, Institute for Defense Studies, Mongolia Batbayar D., Center for Security Studies, Mongolia

“Tourism Trade between China and Mongolia under the Production of New Technology: Opportunities and Challenges” 461
Alatan, Ph.D., Center for Studies of Mongolia, Inner Mongolia University, China

“Current Issues of Mongolia-Russia Border Cooperation” 465
Tsatsral P., Lieutenant Colonel, Management Academy of the University of Internal Affairs, Mongolia

“A Study on the Operational Mechanism of Mongolia's "Multipilar" Balanced Diplomacy” 467
Shurentana, Ph.D., Center for Studies of Mongolia, Inner Mongolia University, China

"Mongolian regional policy: Cooperation and Challenges in New Era" 478
Battur J., Ph.D., Associate professor, Department of International Relations, SPSIRPA, NUM, Mongolia

“Future Perspective and Opportunities in Mongolia-China Railroad Cooperation” 480
Tod G., University of Humanities, Mongolia

“Public-Private Sector Participation and Partnerships in the Implementation of the Sustainable Development Goals in the Case of Mongolia” 494
Namuun B., Mongolian Institute of Northeast Asian Security and Strategy, Mongolia

“Implementation of Mongolia's Foreign Policy in the Context of Regional and Multilateral Cooperation”
Oyunsuren S., Ph.D., Associate professor, Department of International Relations, SPSIRPA, NUM, Mongolia

"China's Conception of Hierarchical World Order and the Balance of Relations" 507
Baasankhuu G., Senior lecturer, Department of International Relations, SPSIRPA, NUM, Mongolia

"Current trend in Cooperation of Mongolia-China Border Region"
Unurmaa D., Ph.D., Senior lecturer, Department of International Relations, SPSIRPA, NUM, Mongolia
Batchimeg B., Senior Lecturer, Department of International Relations, SPSIRPA, NUM, Mongolia

"A quantum economics perspective on foreign trade policy: The effects of interference in the Mongolian milk and dairy products market."
Lkhamsuren P., Ph.D, Director, Monitoring, Evaluation, and Internal Audit office, NUM, Mongolia
Begzsuren T., Ph.D, Associate professor, Department of Physics, SAS, NUM, Mongolia

CONTENTS

SESSION 6 Public Administration

“Future Trends in Human Resource Development in the Forestry Sector: A Case Study of Mongolia” 509
Burmaa N., Ph.D., Professor, Department of Public Administration, SPSIRPA, NUM, Mongolia

“Some Challenges Facing the Constitution of Mongolia” 521
Amarjargal P., Ph.D., Associate professor, Department of Public Administration, SPSIRPA, NUM, Mongolia

“Public service – Ethical Leadership” 536
Myagmar G., Ph.D., Senior lecturer at Department of Public Administration, SPSIRPA, NUM, Mongolia

“Analysis of Human Resource Policy and Regulation in Civil Service: A Case Study of Mongolia”
Bolormaa A., Ph.D., Associate professor, Department of Public Administration, SPSIRPA, NUM, Mongolia

“Implementation of Inclusive Education Policy” 549
Tsog B., Senior Lecturer at Department of Social and Humanities, Eastern Regional Branch, NUM, Mongolia

“Challenges in Employment Relations of Civil Servants: A Case Study of Local Governments” 561
Ganzorig U., Ph. D candidate of Department of Public Administration, SPSIRPA, NUM, Mongolia

"Some Issues in Human Resource Recruitment in Government Organizations" 575
Bumnaran B., Ph. D candidate of Department of Public Administration, SPSIRPA, NUM, Mongolia

“The Quality Management System of Government Organizations: A Case Study of Ulaanbaatar City Emergency Management Coordination Center”
Banzragch Ts., master’s student of Department of Public Administration, SPSIRPA, NUM, Mongolia

"Stability of Operations in Government Organizations" 588
Khoroljusem B., master’s student of Department of Public Administration, SPSIRPA, NUM, Mongolia
Chantsal D., master’s student of Department of Public Administration, SPSIRPA, NUM, Mongolia

SPSIRPA FORUM 2025

Keynote speeches 1

Changing Geopolitical Environment: Foreign Policy of Small States (The Case of Mongolia)

ӨӨРЧЛӨГДӨН БУЙ ГЕОПОЛИТИКИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ЖИЖИГ ОРНУУДЫН ГАДААД БОДЛОГО МОНГОЛ УЛСЫН ЖИШЭЭН ДЭЭР

С.Мөнхбат

Др. профессор

С.Баясгалан

Др. дэд профессор

Хураангуй

Хүйтэн дайн дууссанаас хойш АНУ тэргүүтэй олон улсын харилцааны нэг туйлт систем ОХУ, БНХАУ хэмээх хоёр том хүчтэй тоглогч гарч ирснээр 2022 онд Орос Украйны дайрснаар олон туйлт дэлхийн дэг журам руу шилжих үйл явцад байна. АНУ-ын манлайл дор либерал ардчилсан дэг журамтай байсан ОУХ-ны нөхцөл байдал геополитикийн хүчтэй тоглогч болсон АНУ, БНХАУ, ОХУ гэсэн оролцогдын бодлогоор өөрчлөгдөж байна.

Их гүрнүүдийн гадаад бодлого нь ОУХ-ын дэг журмыг өөрчилж байгаа нь дэлхийн дахиныг тогтвортой, урьчилан харах боломжтой либерал ардчилсан тогтолцооноос хурдацтай, огцом өөрчлөгдөх, эрсдэл өндөртэй реализмын шинж чанарыг агуулсан ширүүн орчин бүрдэж байна. Үүсээд буй ОУХ-ны энэхүү нөхцөл байдалд жижиг улсуудад тулгарч буй нэн тэргүүний асуудал бол аюулгүй байдлаа хэрхэн хангах вэ? гэсэн асуулт юм. Нөлөө бүхий их гүрнүүд тоглоомын дүрмийг гэнэт өөрчилж байгаа нь түүнд нөлөө үзүүлэх хүч чадал байхгүй жижиг орнууд зохицон орших шаардлагатай болж байна.

Энэ өнцгөөс энэхүү судалгаа нь хурдацтай өөрчлөгдөж байгаа геополитикийн нөхцөл байдалд Монгол Улс шиг жижиг орон хэрхэн дасан зохицож, ямар чиг баримжаатай гадаад бодлого явуулах талаар судлав.

Түлхүүр үг: геополитик, жижиг улсын аюулгүй байдал, Монгол улсын гадаад бодлого, ОУХ-ны дэг журам, их гүрнүүдийн гадаад бодлого

Оршил

Олон улсын харилцааны нөхцөл байдал байнга өөрчлөгдөн хувьсаж байдаг.

1990-ээд оноос хойш түүхэн олон үйл явдлууд болж өнгөрсөн. Тухайлбал, хүйтэн дайн дууссан, олон улсын харилцаанд хоёр туйлт дэг журам байсан нь ЗХУ задарснаар үндсэндээ АНУ тэргүүтэй нэг туйлт дэг журам руу шилжив.

Гэвч Орос, Хятад улсууд дахин хүчээ авч гарч ирснээр АНУ-ын жанжлалд сорилт болж олон туйлт дэг журмын талаар ярих болов.

Үндсэндээ олон улсын харилцааны нөхцөл байдлыг түүнд нөлөө бүхий тоглогч (actors) гол ихгүрнүүдийн (АНУ, ОХУ, БНХАУ) тоглоомын талбар болж, хүчтэй нь тоглоомын дүрмээ хэрхэн тогтоодогоос хамаардаг. Энэхүү үйл явдлыг олон улсын харилцааны реалист дэг сургуулийн сэтгэгчид болон судлаачид онцолсоор ирсэн. Хүйтэн дайны дараа АНУ тэргүүтэй нэг туйлт дэг журам бий болох үед либерал дэг сургуулийн үзэл санаа зонхилж байсныг бид сайн мэдэх билээ. АНУ-ын профессор Френцис Фукуяма “The End of History and the Last Man” хэмээх бүтээлдээ хүн төрөлхтний хөгжлийн үйл явц либерал ардчилал ялснаар дуусаж байна гэсэн байдаг. Дуусаж байгаа гэдэг нь дахиж дэлхийг хамарсан, дэлхийг хуваах зорилготой дайн болохгүй, хүн төрөлхтөн хөгжлийн дээд үе шатандаа орсон хэмээн бичиж байжээ.

Үнэхээр дэлхий дахинд ч нөхцөл байдал тайван болж, дайн, зэвсэгт мөргөлдөөн байхгүй болсон мэт нөхцөл байдал бий болсон нь зэвсэглэл, түүн дотроо цөмийн зэвсэгийг хураах, устгах хэрэгтэй гэж ярьж байв. Мөн түүнчлэн АНУ дангаараа ноёлж байсан учраас их гүрнүүдийн зүгээс жижиг улс орнуудад ашиг сонирхол дээрээ тулгуурласан дарамт шахалт үзүүлэх нь бусад үетэй харьцуулахад харьцангуй бага байв.

Гэвч Франсис Фукуямагийн энэхүү санааг С.Хантингтон няцааж соёл иргэншлүүдийн хоорондын мөргөлдөөн гарч болох юм гэсэн санааг дэвшүүлж байв. Энэ нь ч нотлогдож байгаа мэт нөхцөл байдал ОУХ-нд өрнөж эхлэв. Гэхдээ энэхүү нөхцөл байдал Орос, Хятад гэсэн хоёр их гүрэн АНУ-ын жанжлалд сорилт болон гарч ирснээр ОУХ-ны дэг журамд дахин өөрчлөлт гарахад хүргэв.

Энэхүү үйл явц бүр 2012 оноос эхэлсэн байдаг. Тухайлбал, Хятад улс Дэн Сяопиний номлож байсан даруу байж хүчээ нөөх зарчмаас татгалзан, дэлхийн бодлогод идэвхтэй оролцохоо зарлаж, “Бүс ба Зам” санаачилгаа танилцуулав. Дэд бүтцийн салбарт улс орнуудад зээл олгох замаар мега төслүүдийг хэрэгжүүлж, их бүтээн байгуулалт хийж байв. Үүний дараа, барууны судлаачдын онцлон хэлдэгээр, дэлхийн зах зээлийг бүтээдэхүүнээрээ живүүлэх бодлого явуулж байна. Ингэснээр гол өрсөлдөгч Барууны орнуудын зах зээлийг эзэгнэж эхэлж байна. Өөрөөр хэлбэл үүнийг судлаачид Хятад улс зөөлөн хүч буюу эдийн засгийн арга замаар өрсөлдөгчдөө дампууруулах бодлого барьж болох юм.

Хятад улс бүс ба зам санаачилгыг хэрэгжүүлэхээр тавьж буй хүчин чармайлт, ойлгомжгүй байдал нь Хятад улс өөрийн геополитикийн давуу талыг ашиглан дэлхийн болон бүс нутгийн дэг журмыг өөрчлөх гэж байгаа мэт ойлгогдон бүхий л том гүрнүүдэд түгшүүрийн дохио өгөв. Жишээ нь: АНУ Зүүн өмнөд Азид чиглэсэн стратегидаа тулгуурлан Хятадыг тогтоон барих арга хэмжээг авч эхэлсэн. Японы ерөнхий сайд Шинзо Абэгийн санаачилсан дөрвөн талт аюулгүй байдлын яриа хэлэлцээг дэмжиж Хятадын эдийн засаг, цэргийн хүчин чадалд болгоомжтой ханддаг Энэтхэг, Мьянмар, Сингапур, Вьетнамтай найрсаг харилцаагаа бэхжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж иржээ.

Оросын зүгээс Украйныг НАТО-д элсэх санаачилгатай холбогдуулан 2014 онд Крымийн хойгийг хүчээр нэгтгэн Зүүн Украйнд төлөөллийн дайны (proxy war) ажиллагаа явуулж байна.

2022 онд Орос Украйн руу дайран орсны дараа Орос, Хятад хоёр улс дэлхийн шинэ дэг журмын талаар их ярих болов.

Олон улсын харилцааны хүчтэй тоглогчид нэмэгдэхийн хэрээр нөхцөл байдал тогтворгүй болж болохыг Кеннет Уолц the Theory of International Politics хэмээх бүтээлдээ тайлбарласан байдаг. Үүндээ тэрээр манлайлагч хоёр их гүрэн байх нь гэнэтийн, тодорхойгүй зүйл гарах нь бага, эзэн, хаяг нь тодорхой. Ингэснээр буруу тооцоолох, үл ойлголцол гарах нь хязгаарлагдмал гэж үзэж байв. Харин үүний эсэргээр их гүрнүүд олон байх тусам тодорхойгүй байдал, үл ойлголцол хаанаас ч ирж болно. Хэн худал, үнэн яриад байгааг тодорхойлох боломжгүй гэдэг байр сууринаас хандаж байв. Үүнтэй холбоотойгоор олон хүчтэй тоглогчид нэмэгдэхийн хэрээр тэдгээрийн ашиг сонирхолоо хамгаалсан жижиг улсуудад үзүүлэх дарамт шахалт ч нэмэгддэг. Чухамдаа ийм нөхцөл байдал 2022 онд эхэлсэн Украйны дайны үед Монгол улсад ч тод харагдсан.

Нөгөө талаас АНУ-ын ерөнхийлөгч Д.Трампын хувьд одоо явуулж байгаа бодлогын суурь шалтгаан нь 1990-ээд оноос эхэлсэн байдаг. Тухайлбал, худалдааны хувьд АНУ, Хятадын худалдаанд АНУ асах их алдагдалд орж байгааг бүр 1996 онд Ардчилсан намын Нэнси Пелоси хэлж байсан. Д.Трамп бусад ерөнхийлөгч нарын хийж зүрхлэхгүй байсан зүйлийг хийж эхлэв.

Тийм учраас Д.Трампын бодлогыг дараагийн ерөнхийлөгч Ардчилсан намаас гарсан ч одоо байгаа нөхцөл байдлыг буцаах боломжгүй билээ.

Олон туйлт дэлхийн дэг журмыг ярьж байгаа Орос, Хятадын эсрэг байр сууриа хадгалах гэж оролдох АНУ-ын хувьд 2000 оноос Орос, Хятад хоёрыг ойртуулах нөхцлийг өөрөө бүрдүүлсэн байдаг. Харин өнөөдөр Д.Трамп Орос, Хятад хоёрыг холдуулах Никсоны үеийн аргыг хэрэглэхийг оролдож байна. Ингэхдээ Д.Трамп хоёр гүрний нөхцөл байдлыг орхигдуулсан төдийгүй түүнээс гарах дэлхийн хэмжээнд нөлөөлөх үр дагаврыг тооцоогүй мэт санагдана.

Трампын үед болж энэхүү нөхцөл байдал шинэ биш юм. 2016 онд Барак Обама Евро-Атлантын аюулгүй байдлын асуудал тэр чигтээ ганхаж байна. Трамп, Зеленскийн уулзалтын дараа Орос Баруун задарч эхэлж байна гэсэн зүйлийг хэлжээ.[1]

Байдены үед авторитар дэглэмүүд хүчээ аван гарч ирж байгаа нь либерал ардчилсан тогтолцоог сулрахад хүргэж байгаа нь үндсэндээ дэлхийн дэг журмыг өөрчлөхөд хүргэж байна.[2]

Д.Трампын хэрэгжүүлж буй арга нь хэдийгээр реалистуудын тайлбарладаг арга барил боловч олон улсын дэг журам, хууль эрх зүйг шууд орхиж болохгүй гэдгийг санах хэрэгтэй болов уу.

Гэсэн хэдий ч Д.Трамп өөрийн хэрэгжүүлж байгаа хүчтэй, огцом бодлогоороо дангаараа тэргүүлэх байр сууриа эргүүлэн авч чадахгүй, олон туйлд ОУХ-ны дэг журам нэгэнт эргэлт буцалгүй болсон нь тодорхой болж байна.

[1] https://www.bbc.com/news/articles/c2er9j83x0zo
[2] https://www.vanityfair.com/news/story/donald-trumps-new-world-order?srsltid=AfmBOoo7wT1P2Qdb-_ev0Yg1JJbxdMrREoOa5kBiT83B_ZT3PE31YG6w

Д.Трампын хувьд АНУ-г дахин хүчирхэг болгоход үндсэн хэдэн зүйлийг хэлээд байгаа:

Холбоотон орнуудын, тэр дундаа НАТО-ын гишүүн орнуудын аюулгүй байдлын асуудлыг бүрэн шийдэхгүй, эдгээр орнууд аюулгүй байдлаа тодорхой хэмжээнд өөрсдөө хариуцах ёстой. Тэр тусмаа Украйныг НАТО-д элсүүлэхгүй гэсэн байр суурь баримтлаж байна. Үүнийг ялангуяа Европчууд барууны үнэт зүйлийг хамгаалдаг цэргийн гол эвслийн баталгааг сулруулж байна. Энэ нь Орос, Хятадад ашигтай нөхцөл байдлыг үүсэгж байна гэж үзэж байна.[3]

Европын ихэнх орнууд, тэр дундаа Франц, Их Британи, Дани зэрэг улсууд АНУ-ыг найдаж болох холбоотон гэж үзэхгүй болсныг санал асуулгад оролцсон дийлэх хүмүүс хэлсэн байна. Тухайлбал, Брукингс институтын судлаач Роберт Каган Трампын явуулж буй энэхүү бодлого нь барууны ертөнц дэх АНУ-ын байр суурийг эргэлт буцалтгүй ганхууллаа гэж үзэж байна.[4]

Худалдааны хувьд Д.Трамп дэлхийн улс орнууд АНУ-г ашиглаж байна гэж үзсэн учраас их хэмжээний татвар ногдуулах замаар протекционист бодлого явуулах болов. Тэрээр өмнө нь ч ерөнхийлөгч байхдаа Хятадтай худалдааны дайн хийж байсан билээ.

Германы Канцлер Фридрих Мерц Европ АНУ-аас хамааралгүй болох хэрэгтэй. НАТО-г Европын цэргийн эвсэл болгох хэрэгтэй гэх байр суурийг илэрхийлж байв.[5]

Үүнтэй холбоотой АНУ-ын Гадаад бодлого, аюулгүй байдлын зөвлөх асан Хенри Киссинжерийн хэлсэнчлэн АНУ-д байнгын нөхөр ч байхгүй, байнгын дайсан ч байхгүй, зөвхөн ашиг сонирхол л байдаг гэж хэлсэн байдаг. Энэ зарчмыг мөн Д.Трамп баримталж байна. АНУ-ын 47 дахь Ерөнхийлөгч болох Трамп АНУ-ын анхны холбоотон болох Францын ерөнхийлөгчтэй Украйны дайныг хэрхэн зогсоох талаар ярилцаж байхдаа Миний бүхий л амьдрал яриа хэлэлцээ[6] байсан гэж хэлжээ.[7]

АНУ-ын ерөнхийлөгч Д.Трамп АНУ-ыг хүчирхэг болгох протекционист бодлого нь дэлхийн дэг журмыг дахин өөрчлөх хэмжээнд хүргэж байна.

Зарим судлаачдын үзэж байгаагаар АНУ-ын хатуу гадаад бодлого хуучны колоний үеийн маягийн шинжийг агуулсан гурван том гүрний нөлөөний хүрээгээ хуваах бодлого болж харагдаад байгаа юм.[8]

Өөрөөр хэлбэл өнөөгийн дэлхийн дэг журам нь шинэ дэг журам биш харин ч хүчинд тулгуурласан хуучны дэг журам эргэн ирж байна.

Үүнийг яагаад АНУ-тай холбон авч үзэж байна вэ гэхлээр АНУ дэлхийн хоёрдугаар дайны дараа либерал ардчилал бүхий дэлхийн дэг журмыг тогтоосон, харин одоо АНУ

[3] https://www.bbc.com/news/articles/c2er9j83x0zo
[4] https://www.bbc.com/news/articles/c2er9j83x0zo
[5] https://www.bbc.com/news/articles/c2er9j83x0zo
[6] Deal гэдгийг улс орнуудтай ашиг сонирхолоо хамгаалсан болон тулгасан тохиролцоо хийхийг ойлгож байв. Үүний жишээ нь улс орнуудад импортын татвар ногдуулсан ч наймаалцаж байгаа.
[7] https://www.vanityfair.com/news/story/donald-trumps-new-world-order?srsltid=AfmBOoo7wT1P2Qdb-_ev0Yg1JJbxdMrREoOa5kBiT83B_ZT3PE31YG6w
[8] https://www.vanityfair.com/news/story/donald-trumps-new-world-order?srsltid=AfmBOoo7wT1P2Qdb-_ev0Yg1JJbxdMrREoOa5kBiT83B_ZT3PE31YG6w

үүнийгээ нурааж байна. Өөрөөр хэлбэл, хэдийгээр Европ либерал ардчиллыг тогтоохыг, хадгалахыг оролдох боловч АНУ-гүйгээр үүнийг хийж чадахгүй.[9]

Д.Трамп хугацаа нь дуусаад бууна гэж бодсон ч, энэхүү бодлого нь үргэлжлэхгүй либерал ардчилалыг сэргээнэ гэж бодсон ч дэлхийн улс орнуудын өөртөө найдах, АНУ-д үл итгэх асуудал арилахгүй ул мөр үлдээх нь дамжиггүй учраас бид дэлхийн дэг журам өөрчлөгдөж байгаа, урьдных шигээ байхгүй болохыг авч үзээд байгаа юм.

Д.Трампын хэрэгжүүлж буй энэхүү бодлогын загвар зарим газарт нааштай хүлээж авч байна. Тухайлбал, Нигер улсын Худалдааны сайд Жүмоке Одүволе хэлэхдээ бидэнд Нигер ялна, Африк ялна гэж байв.[10]

Сүүлийн үед зүүн Африкийн Буркино Фасо хэмээх улсад цэргийн эргэлт гарсан ч аюулгүй байдлаа бие даан хамгаалахыг хичээж байна. Түүний Путинтэй ойр байх, олон туйлтын асуудал, уламжлалт холбоотны ойлголтыг үгүй хийж байна.

Жижиг орнуудын гадаад бодлого

Юуны өмнө ОУХ-ны дэг журмыг өөрчилж, олон туйлт дэг журам бий болгох тухай, АНУ-ын жанжлалын чадлыг сорьж байгаа нь Монгол Улсын хоёр хөрш орнууд болохыг энд цохон тэмдэглэх хэрэгтэй.

Жижиг орнууд үндсэндээ нийтлэг, төстэй сорилтуудыг шийдвэрлэж, даван туулах талын асуудлыг боловсруулдаг ч газар зүйн байршил, хөрш орнуудын нөхцөл байдал болон нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсээс хамаарч улс бүр өөрийн гэсэн онцлог асуудалтай байдаг.

Үүний зэрэгцээ жижиг улс орнууд газар зүйн нөхцөл байдлаа тооцохоос гадна өөрийн нөөц бололцоон дээр тулгуурлан гадаад бодлогоо явуулдаг. Монгол шиг жижиг орон өөрийн нөөц бололцоогоо тооцоолоход хүчинд тулгуурласан реалист бодлого явуулах боломжгүй учраас либерал чиг баримжаатай бодлого явуулдаг. Үүнийгээ ч Үндсэн хууль болон Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа “гадаад бодлогоо улс төр-дипломатын” арга замаар явуулна гээд заачихсан байгаа. Монгол Улс энэхүү бодлогоо 1990 оноос бие даасан гадаад бодлого явуулж эхлэх үеэсээ эхлэн тууштай баримтлан явж байгаа билээ. Мөн бүх орнуудтай найрсаг харилцаатай байж, цэргийн аливаа эвсэл холбоонд нэгдэхгүйгээр дэлхийн хамтын нийгэмлэгийн идэвхтэй гишүүдийн нэг нь байж ирсэн.

Жижиг улсуудын гадаад бодлого нь үндсэндээ НҮБ зэрэг олон улсын байгууллага, олон улсын дэг журамд тулгуурласан, олон улсын эрх зүйгээр нийтийн аюулгүй байдлыг хангах замаар өөрсдийн аюулгүй байдлын баталгааг бий болгохыг зорьсон, зөөлөн хүчийг илүүд үзэх буюу Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд зааснаар улс төр-дипломатын арга замаар авч хэрэгжүүлдэг, аливаа зэвсэгт мөргөлдөөнөөс холуур

[9] https://www.vanityfair.com/news/story/donald-trumps-new-world-order?srsltid=AfmBOoo7wT1P2Qdb-_ev0Yg1JJbxdMrREoOa5kBiT83B_ZT3PE31YG6w

[10] https://www.vanityfair.com/news/story/donald-trumps-new-world-order?srsltid=AfmBOoo7wT1P2Qdb-_ev0Yg1JJbxdMrREoOa5kBiT83B_ZT3PE31YG6w

байж, олон улсын тавцанд нэр хүндээ өсгөх зорилгоор дайтагч, сөргөлдөгч талуудад зуучлагчийн үүрэг гүйцэтгэхийг хичээдэг байна.

Илүү өргөн хүрээнд авч үзвэл жижиг улсууд нь аюулгүй байдлаа хангах өөр арга замуудыг ч сонгох тохиолдол байна. Тухайлбал, Их гүрнүүдийн ивээл, хамгаалалтанд орох эсвэл тэдгээрийн эвсэлд орох байж болно, НАТО үүний нэг тод жишээ. Мөн худалдаа, эдийн засгийн холбогдолтой гэрээ байгуулж, нөлөө бүхий орнуудын хөрөнгө оруулалтыг татах, хөгжлийн тусламж авах замаар тэдний ашиг сонирхолыг татах, нөгөө талаар санхүү, эдийн засгийн боломжоо стретегийн гадаад бодлогодоо ашиглах боломжтой юм.

Монгол улсын гадаад бодлого

Монгол Улсын гадаад бодлогын чиг шугамыг товчоор хэлэхэд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх НҮБ-ын Ерөнхий Ассамблейд хэлсэн үгнээс тодорхой харж болно. Тэрээр: “Монгол Улс олон улсын эрх зүй, НҮБ-ын Дүрмийг дээдэлсэн олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэх нь олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хангах гол арга зам хэмээн үздэг бөгөөд түүний дотор яриа хэлэлцээ, харилцан ойлголцол харилцан итгэлцлийг бэхжүүлэх нь дэлхий нийтийн тогтвортой байдал, энх тайвнаар зэрэгцэн орших гол үндэс суурь юм.” гэжээ.

Дэлхийн дэг журам өөрчлөгдөж байгаа энэ үед Монголын стратегийн нөхцөл байдал нэлээд эмзэг бөгөөд чухал ач холбогдолтой болж байна.

Монгол Улсын аюулгүй байдлыг хангахад чиглэсэн гадаад бодлогод геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалан хөрш орон болон бусад аливаа улс руу хэт нэг талыг барин хазайхгүй байхыг хичээдэг.

Реалист онолчдын үздэгээр жижиг, бага улсуудын орших, эс орших нь их гүрнүүдийн бодлогоос хамаарч байдаг.

Судлаачид бага улсын гадаад бодлого нь дотоод бодлогоос нь илүү олон улсын харилцааны системээс хамаардаг гэж үздэг.

Монгол Улсын гадаад бодлого нь газар зүйн нөхцөл байдал дээр суурилна:

- тэргүүлэх чиглэл нь хоёр хөрш
- хоёр дахь чиглэл нь “гуравдагч хөрш” орнууд юм.[11]

Монгол Улсын дотоод, гадаад аюулгүй байдлыг хангахын тулд эрх зүйн баримт бичгүүдэд дараах заалтууд орсон байдаг. Тухайлбал, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ.[12]

Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр-дипломатын аргаар хангах нь гадаад бодлогын тэргүүлэх зорилт мөн.

Монгол Улс энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулна.

[11] Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал

[12] *Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал*

Олон улсын харилцааны хөгжил, дэлхийн болон бүс нутгийн улс төрийн нөхцөл байдалтай уялдуулан гадаад бодлогын чиглэл, зорилтыг уян хатан тогтооно.[13]

Монгол Улс сүүлийн хоёр жилийн хугацаанд идэвхтэй гадаад бодлого явуулсан нь олон улс орнуудын төрийн тэргүүн нар Монгол Улсад айлчилснаар харж болно. Ингэхдээ бид Баруун, Зүүн гэж ялгалгүй бүгдийг нь хүлээн авч уузлсан байдаг. Манайд 13 улсын төрийн тэргүүн нар төрийн айлчилал хийсэн нь Монгол Улсын энхийг эрхэмлэсэн, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлого хэрхэн амжилттай явж байгааг харуулсан юм.

Хөрш орнуудыг авч үзвэл: Монгол Улсын худалдааны хамгийн том түнш нь Хятад улс юм, Монголын худалдааны 90 гаруй хувийг Хятад эзэлдэг. Тухайлбал, 2023 оны байдлаар Монголын нийт экспортын 92 хувийг Хятад руу хийсэн байна. Үүнд: 8.43 тэрбум ам долларын нүүрс, 2,.65 тэрбум ам долларын зэс, 365 сая ам долларын төмрийн хүдэр гаргасан байдаг. Нийтдээ 13.1 тэрбум ам долларын худалдаа хийсэн байдаг.

Гэтэл 2022 оны байдлаар Монгол Орос руу 2.16 сая ам долларын экспорт хийсэн бол 99.8 сая ам долларын импорт хийснээр Монголын худалдааны тэнцэл нь 97.6 сая ам долларын алдагдалтай гарч байна.

АНУ, БНХАУ-ын хоорондын худалдааны дайн нь Монгол Улсын худалдаа, эдийн засгийн асуудалд сөрөг нөлөө үзүүлэх боломжтой байна. Тухайлбал, Монгол Улсын экспортын гол бүтээгдэхүүн нүүрс, зэс зэрэг байгалийн баялгийг гагцхүү Хятад авдаг гэж үзвэл АНУ, Хятадын хоорондын худалдааны дайнаас үүдэлтэй эрэлт, нийлүүлэлтийн асуудал Монголд нөлөө үзүүлэх нь дамжиггүй юм.

Монгол Улсад гаднаас нөлөөлөх нөлөө нь голдуу эдийн засгийн хөшүүргээр илэрч байгааг ажиглаж болохоор байна.

Тухайлбал, ОХУ “Сибирийн хүч-2” төслийг хэрэгжүүлж газар доогуур 960 км замыг туулах төсөл хэрэгжиж байна, 2010 онд Оросын шатхууны станцуудыг Монголд оруулж ирэх талаар яригдаж байан, одоо онгоцны түлш нийлүүлэх 60:40 хувийн хамтарсан компани байгуулах саналууд тавьж байна. Хятадын зүгээс Бүс ба зам, мега төслүүд яригдаж байна. Үндсэндээ Монгол улсын хувьд ямар нэгэн мега төсөл, бүтээн байгуулалт ярихад хүртэл хоёр их гүрний дунд орших жижиг, ардчилсан Монгол улс хэрхэх вэ гэдэгт стратегийн шинж чанартай боловсруулалт хийх шаардлагатай болдог.

Хэдийгээр Монгол Улсын гадаад бодлого үндсэн чиглэлээ бариад явж байгаа боловч худалдаа, эдийн засгийн хувьд хүчний шижилт болж байгааг анхаарахгүй байж болохгүй билээ.

Үүгээр ч зогсохгүй илүү өргөн хүрээтэй, холын бодлого явагдаж байгаа нь Монгол Улсыг Евразийн эдийн засгийн холбоонд гишүүн болгох, мөн ШХАБ-т орохыг санал болгож байгаа, зарим талаар хоёр хөрш шахалт үзүүлж байгааг харж болно.

Трампын өмнөх засаглалын үед АНУ дэлхийн манлайлагч болох, мөн холбоотон орнуудаа орхих хэмжээний асуудлыг ярьж байсан. Тэдгээр орнууд нь Монгол Улсын гуравдагч хөршийн орнуудад ордог. Хоёр авторитар их гүрний дунд орших Монгол

[13] Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал

Улсын хувьд энэхүү нөхцөл байдал нь тодорхой сорилтыг бий болгож байна. АНУ тэргүүтэй барууны гэгдэх орнууд сулрах нь Монголоос үл шалтгаалан гуравдагч хөршийн орнуудын харилцаа сулрах боломжтой.

Монголын хувьд тусгаар тогтнол нь олон улсын хамтын нийгэмлэг, хуульд тулгуурласан дэг журам зэрэг тодорхой, тогтвортой зүйлд тулгуурладаг учраас гэнэтийн сорилттой тулгарахад бэлэн байх хэрэгтэйг Д.Трампын тодорхой бус, тогтворгүй бодлого явуулж байгаагаас харж болохоор байна. Гадаад орчны тодорхойгүй, төвөгтэй байдал нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдалд заасан гадаад, дотоод орчин тогтвортой байх нөхцөл байдлыг сулруулж байна.

Монгол Улс ЗХУ-аас хараат бус, бие даасан гадаад бодлого явуулж эхэлснээс хойш дараах үндсэн үндсэн зарчмыг баримталж ирсэн байдаг. Үүнд: аливаа цэргийн эвсэлд нэгдэхгүй, гадаад бодлогын тэргүүлэх чиглэл нь хоёр хөрш байна, үүний зэрэгцээ тэнцвэртэй гадаад бодлого явуулах арга хэмжээ авах болсон, бас эдийн засгаа хөгжүүлэх шаардлагатай болсон зэрэг нь гуравдагч хөршийн бодлого явуулах хэрэгтэй болсон. Энэхүү харьцангуй тайван тогтвортой бодлого 2022 онд Орос Украйн руу халдан довтолсонтой холбоотойгоор өөрчлөгдсөн. Монгол Улсын хувьд гадаад орчин дахин өөрчлөгдсөнийг дараах байдлаар тайлбарлаж болно. Жишээ нь: Монгол Улсын хувьд хамгийн түрүүнд тавигдсан асуудал нь аль нэг талыг баримтлах хэрэгтэй юу. Гэхдээ үндсэндээ бид 1990-ээд оноос хойш аливаа эвсэлд үл нэгдэх бодлого барихаас гадна хэдийгээр албан ёсоор төвийг сахиад түүнийгээ баталгаажуулаагүй боловч бодит байдал дээр төвийг сахисан бодлого явуулж ирсэн. Бидний энэхүү бодлого Украйны дайнтай холбоотойгоор сорилтонд орсон.

Тэгэхлээр Монгол Улс хэмжээгээрээ жижиг ч гэсэн өргөн хүрээний том стратеги бодлоготой байх хэрэгтэй байгаа юм.

Энэ нь авторитар дэглэмтэй хоёр хөршийн дунд хавчуулагдсан Монгол Улс ардчилсан тогтолцоотой байх нь зарим судлаачийн хэлдгээр тусгаар тогтнолын нэг баталгаа нь юм. Өөрөөр хэлбэл үүгээрээ Монгол нь авторитар дэглэмтэй улсуудын хүчийг тэнцвэржүүлэн тогтоож, ардчилсан орнуудыг “хамгаалж” байгаа өрнөдийн өндөр хөгжилтэй орнуудад тодрон харагдаж байгаа юм.

АНУ, БНХАУ-ын өрсөлдөөн, Оросын дахин сэргэлт, түүнтэй холбоотой Украйны дайн, Орос, Хятадын зүтгүүлж байгаа олон туйлт дэлхийн дэг журам. Энэхүү нөхцөл байдалд Монгол Улс хэрхэн зохицож байгааг дараах хэсгүүдээс харъя.

"Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого	2020	Хөдөлмөрийн зах зээлийн хүрээнд албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулах, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн онцлогт нийцсэн нийгмийн даатгалын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх талаар тусгасан.
Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	2020	Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулах арга хэмжээг төлөвлөсөн.
Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр	2020	Тогтвортой ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд бизнес эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг татвар, эдийн засгийн бодлогоор дэмжинэ.

Эх үүсвэр: Даяаршлын нөхцөлд Орос, Монгол дахь албан бус хөдөлмөр эрхлэлт" судалгааны үр дүнгээс

Үүнээс үзэхэд бодлогын түвшинд албан бус салбарт ажиллагчдыг бүртгэлжүүлэх үйл ажиллагаанд онцгойлон ач холбогдол өгч байна. Учир нь албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдийг албан болгох, нийгмийн хамгаалалд хамрагдах боломжийг бүрдүүлэх, татвар төлөлтийг сайжруулах гэх мэт бүхий л үйл ажиллагааны эхлэл нь бүртгэл юм.

Монгол Улсад албан бус хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах тусгайлсан хууль байхгүй боловч дараах хуулиудад албан бус хөдөлмөр эрхлэлтийг зохицуулахтай холбоотой заалтууд орсон байна.

Хүснэгт 3.Албан бус хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хуулиуд, агуулга

Хууль	**Батлагдсан он**	**Гол зохицуулалт**
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль	2008	Хуулийн үйлчлэх хүрээг хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, гэрээний үндсэн дээр болон бусад хэлбэрээр ажил, хөдөлмөр эрхэлж буй иргэн гэж өргөн хүрээнд тодорхойлсноор албан бус хөдөлмөр эрхлэгчид хамрагдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд ажиллах эрхтэй болохыг тодорхойлсон байна.
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (шинэчилсэн найруулга)	2011	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч хамрагдана гэж зааж, эдгээр иргэдийг дэмжихэд чиглэсэн бие даасан бүлэг оруулсан.
Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль	2019	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр ахуйн үйлчилгээний салбарт дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, стандартад нийцсэн үйлчилгээг ард иргэдэд хүргэх, албан бус хөдөлмөр эрхлэлтийг багасгаж, ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн дунд хугацааны хөтөлбөртэй байна гэж заажээ.
Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга)	2021	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, нөхөрлөл, хоршооны гишүүн, дагалдан ба дадлагажигч зэрэг албан болон албан бус эдийн засагт ажиллаж, ажил хайж, мэргэжил эзэмшиж байгаа хүн бүр ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны суурь зарчим, үндсэн эрхийг эдэлж, холбогдох үүргийг хүлээхээр заасан.
Нийгмийн даатгалын ерөнхий хууль	2023	Албан бус хөдөлмөр эрхлэгчид сайн дураар нийгмийн даатгалд (тэтгэврийн даатгал, тэтгэмжийн даатгал, үйлдвэрлэлийн осол,

		мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал) хамрагдаж болно гэж зааснаар албан бус хөдөлмөр эрхлэгчид нийгмийн хамгаалалд хамрагдах боломжийг нээж өгсөн.

Эх үүсвэр: Даяаршлын нөхцөлд Орос, Монгол дахь албан бус хөдөлмөр эрхлэлт" судалгааны үр дүнгээс

"Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль"-ийн агуулга нь хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг хамарч, ажлын байр нь аюулгүй, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байх талаар тусгасан байна. "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай" хуульд албан бус хөдөлмөр эрхлэгчдэд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлдэг хөтөлбөрүүдэд хамрагдаж, бизнесээ өргөжүүлэх чиглэлээр санхүүгийн дэмжлэг, зээл авах, зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдах боломжийг олгосон.

"Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль"-д албан бус хөдөлмөр эрхлэлтийг бууруулахад чиглэсэн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхээр тусгасан байна. Улмаар Засгийн газрын 2019 оны 156 дугаар тогтоолоор "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийг баталж, хөтөлбөрийн зорилгыг "*жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг дэмжих замаар бүтээмжийг өсгөх, зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ажлын байрыг нэмэгдүүлэх"* гэсэн байдлаар томьёолж, энэ хүрээнд холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүнээс хөтөлбөрийн зорилго, үйл ажиллагаа нь албан бус хөдөлмөр эрхлэлтийг бууруулахад шууд чиглээгүй, харин уг хөтөлбөр хэрэгжсэний үр дүнд албан бус хөдөлмөр эрхлэлтийн хүрээ хумигдаж болохоор нөхцөл байдал ажиглагдаж байна.

"Хөдөлмөрийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгад үл ялгаварлан гадуурхах, эрх чөлөөг баталгаажуулах, ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, аятай нөхцөлөөр хангагдах, цалин хөлс авах, амрах, дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох гэх мэт хөдөлмөрийн хүрээний суурь эрх, зарчмыг хэрэгжүүлэхээр заасан нь албан бус хөдөлмөр эрхлэгчдийг хамгаалах, улмаар зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чухал зохицуулалт болж байна.

1994 онд батлагдсан "Нийгмийн даатгалын тухай хууль"-иас улбаатай албан салбарт хөдөлмөр эрхлээгүй иргэдэд сайн дураар нийгмийн даатгалд хамрагдах боломж "Нийгмийн даатгалын ерөнхий хууль"-д мөн адил туссан байна. Өөрөөр хэлбэл, албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчид нийгмийн даатгалд хамрагдах боломжийг эрх зүйн хувьд бүрдүүлсэн.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн амьдралын төлөв байдал

ҮСХ-ны мэдээллээр 2010 онд 154 мянган хүн албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байсан бол 2015 онд 205,7 мянга болж, 2020 онд 209,4 мянга, 2023 онд өмнөх оноосо 20735 хүнээр буурсан төлөв ажиглагдаж байна.

Хүснэгт 4. 2015-2023 оны албан бус салбарт ажиллагсдын тоо, эзлэх хувь

	Онууд	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023

Албан бус хөдөлмөр эрхлэгчид	Бүгд	**205710**	**159687**	**220683**	**219996**	**187990**	**209474**	**180348**	**215186**	**194451**
	Эрэгтэй	120864	94470	131269	131687	110320	135205	117050	129898	122515
	Эмэгтэй	84846	65217	89414	88309	77669	74268	63297	85288	71935
Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувийн жин, %	Бүгд	**25**	**20**	**25**	**23.9**	**21.9**	**23.3**	**20.9**	**23.1**	**20.8**
	Эрэгтэй	28.4	23.2	29.2	27.5	24.7	28.6	25.6	26.8	24.9
	Эмэгтэй	21.3	16.7	20.7	20.1	18.9	17.5	15.6	19.1	16.3

Эх сурвалж: ҮСХ, 2015-2023 он

Монгол Улсад 2015 онд НӨАТ-ын тухай эрх зүйн зохицуулалт нэвтэрсэн нь албан бус салбарт ажиллагсдын тооны өсөлтөд нөлөөлж, харин 2020 оноос хойших татвар төлөгчдийн цахим бүртгэлийн тогтолцоо сайжирч байгаатай уялдан буурсан байна. Ийнхүү татвар, нийгмийн даатгалын зохицуулалт, ковид-19 хөл хорионы гадаад болон дотоодын хөл хорио нь албан бус салбарын ажиллагсдын тооны өсөлт бууралт ихээхэн нөлөөтэй байгааг дээрх баримтууд харуулж байна.

Хүснэгт 5. Албан бус хөдөлмөр эрхлэгчид. (ажил үйлчилгээний хэлбэр, хувиар)

Ажил үйлчилгээ	**Тоо**	**Хувь**
ХАА (туслах малчин, ногоочин)	124	12.4
Нийтийн хоолны үйлчилгээ (цайны газар ажиллуулдаг, тогооч, үйлчлэгч)	101	10.1
Бөөний болон жижиглэн худалдаа, засвар, үйлчилгээ	323	32.2
Эрүүл мэнд (сувилагч, бариа засалч)	21	2.1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа (утас засвар, үсчин, гоо сайхан г.м)	66	6.6
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа (менежер, нягтлан бодогч г.м)	20	2
Барилга (барилгачин, инженер, гагнуурчин, туслах)	81	8.1
Хөнгөн буюу боловсруулах үйлдвэрлэл (мужаан, хүнс, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, тавилгын үйлдвэрлэл г.м)	64	6.4
Тээвэр, агуулах (авто тээвэр, такси, агуулахын ажилтан, оператор)	130	13
Үл хөдлөх хөрөнгө	4	0.4
Боловсрол (багш, туслах)	14	1.4
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа (хүүхэд асрагч, дуудлагын хивс цэвэрлэгч г.м)	9	0.9
Ус хангамж (сантехникч)	4	0.4

Мэдээлэл, холбоо (мэдээллийн ажилтан)	8	0.8
Урлаг, үзвэр, тоглоом наадам (биллиард ажиллуулдаг г.м)	2	0.2
Санхүү (ломбард)	3	0.3
Хариулаагүй	27	2.7
Бүгд	1002	100

Эх үүсвэр: "Даяаршлын нөхцөлд Орос, Монгол дахь албан бус хөдөлмөр эрхлэлт" судалгааны үр дүнгээс

Судалгааны дүнгээр албан бус хөдөлмөр эрхлэгчийн 49.4 хувь нь (n=495) эрэгтэйчүүд, 50.6 хувийг (n=507) эмэгтэйчүүд эзэлж байна. Эмэгтэйчүүдийн 33.1 хувь нь худалдаа, 12.6 хувь нь ХАА-н, 11.6 хувь нь нийтийн хоолны салбарт төвлөрч байхад, эрэгтэйчүүдийн 31.3 хувь нь худалдаа, 18.8 хувь нь тээврийн салбарт, 12.1 хувь нь ХАА, 9.9 хувь нь барилгын салбарт албан бусаар хөдөлмөр эрхэлж байна. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын судалгаагаар эмэгтэйчүүд гол төлөв худалдаа, арилжаа, зоогийн газар, зочид буудал, санхүүгийн үйлчилгээний салбарт албан бусаар ажиллаж байна. ОУХБ-ын мэдээгээр эмэгтэйчүүд ХАА-аас бусад эдийн засгийн салбарт албан бусаар хөдөлмөрлөх нь эрэгтэйчүүдээс илүү байна (Lota Bertulfo, 2011). Монгол Улсад нь энэ байдал статистикийн тоо баримтаас тодорхой харагдаж байна.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн боловсролын байдал

Өндөр чадвартай нэг ажилтны бүтээмж нь чадвар муутай ажилтныхаас их байдаг учир боловсрол нь хөдөлмөрийн чанар болон бүтээмжид нөлөөлдөг гол хүчин зүйл гэж олон эрдэмтдийн бүтээлд тусгагджээ (Arrow.K.J, 1962) (Paul M. Romer. , 1986) (Mankiw NG, Romer D, Weil D. A , 1992). Түүнчлэн Rubb,S. судалгаа нь боловсролын түвшин нэмэгдэх тусам хөдөлмөрийн зах зээлд оролцох оролцоо нь нэмэгдэж, ажилгүйдэл буурахад нөлөөлдөг гэжээ (Keith M. Lewin, 1997).

Судалгаанд оролцогчдын 35.3 хувь нь бүрэн дунд боловсролтой, 30.1 хувь нь дээд, 16.2 хувь нь тусгай дунд, 13.9 хувь нь бүрэн бус дунд боловсролтой байна. Харин цөөн тооны буюу 3.1 хувь нь бага, 1.5 хувь нь боловсролгүй иргэд хамрагдсан. 2021 оны ОУХБ, ХНХЯ ХНХСИ-ийн хамтарсан Монгол Улсын албан бус хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал судалгааны тайланд (ОУХБ, ХНХЯ, ХНХСИ, 2021, p. 35) албан бус хөдөлмөр эрхлэгчдийн талаас илүү хувь нь бүрэн дунд боловсролтой байна гэсэн дүгнэлттэй ойролцоо юм.

Зураг 4. Сүүлийн 5 жилийн хугацаанд мэдлэг, мэргэжлээ дээшлүүлсэн байдал, хувиар

Албан бус хөдөлмөр эрхэлж буй хүн амын дийлэнх нь буюу 27.7 хувь нь сургалтад хамрагдах шаардлагагүй, 26.3 хувь нь хамрагдах талаар бодож байгаагүй, 22.7 хувь нь сурах боломжгүй гэжээ. Сургалтад хамрагдсан бүлгийн 23.3 хувийг задлан авч үзвэл 8.2 хувь нь их, дээд сургуульд, 5.6 хувь нь мэргэжил дээшлүүлэх, 4.3 хувь нь шинэ мэргэжил эзэмшихээр, 3.6 хувь нь мэргэжлийн боловсролын сургуульд, 1.6 хувь нь бие дааж компьютер дээр ажиллах чадвараа сайжруулсан байна.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эрүүл мэндийн байдал

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас XXI зуунд ажлын байрыг эрүүл мэндийг дэмжих тэргүүлэгч орчин байх болно гэж уриалга гаргасан. Үүнд: а) Ажлын байрны зохион байгуулалт, ажиллах орчныг сайжруулах, б) Хүн бүрийн идэвхтэй оролцоог дэмжих, в) Хувь хүний хөгжлийг дэмжих гэж тусгасан.

Албан салбарт хөдөлмөр эрхлэгчид ээлжийн амралт эмнэлэг, сувиллын үйлчилгээ, мөн эмчилгээ листээрээ цалин хөлснийхөө тодорхой хувийг авдаг бол албан бус салбарын хувьд тэтгэврээ тогтоолгосон ахмадын хувьд хөнгөлөлттэй сувиллаас өөр алийг нь ч авч чадахгүй байна.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 38.6 хувь нь эрүүл мэнд сайн, ямар нэг асуудалгүй гэж хариулсан. Харин 32.8 хувь нь бага зэргийн зовуурьтай, 24.3 хувь нь үе үе өвддөг, гэхдээ эмчилгээ хийлгэдэг, 4.3 хувь нь хүнд өвчтэй гэжээ. Гол асуудал нь албан бус салбарын онцлог буюу өөртөө ажил олгогчийн хувьд ажлаа зогсооход орлого тэр чинээгээр буурах эрсдэлтэй тул эрүүл мэндийн асуудал байгаа ч өөрийгөө орхигдуулах асуудал гарч байна.

Эрүүл мэндийн байдлыг хөдөлмөр эрхэлж буй салбартай нь харьцуулан үзвэл худалдаа наймаа, үйлчилгээ (27.6%), ахуй үйлчилгээ (17.6%), ХАА-н үйлчилгээ, байгалийн баялаг ашиглах үйл ажиллагаа (10.3%)-ны салбарынхан эрүүл мэнд сайн, ямар нэг асуудалгүй гэж бусад салбарынхаас харьцангуй өндөр хувьтай хариулжээ. Харин хүнд өвчтэй гэж хариулагсад ахуй үйлчилгээний салбарт хамгийн өндөр хувьтай байв. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх нь буюу 36.8 хувь нь сүүлийн хэдэн жил эмнэлэгт үзүүлээгүй, үйлчилгээ аваагүй, 29.7 хувь нь жилд нэг удаа эрүүл мэндийн үйлчилгээ авдаг, 20.5 хувь нь хагас жилд нэг удаа, 13 хувь нь улирал бүр эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагддаг аж.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдэд тулгамдаж буй асуудал, бэрхшээл

Албан бус хөдөлмөр эрхлэгчид ямар салбарт ажиллаж байгаагаас хамаарч шинж чанар болон тулгамдаж буй асуудал бэрхшээлийн хувьд онцлог, ялгаатай байдаг. Дэлхийн улс орон бүрд албан бус салбарын талаар судалж, тус салбарт ажиллаж буй хүмүүст дараах нийтлэг бэрхшээл тулгардаг гэж үзжээ. Үүнд: төрийн байгууллагын дарамт, албан бус салбарын ажиллагсад нэгдэх боломж хязгаарлагдмал, бизнесийг хөгжүүлэх үйлчилгээ байхгүй, эрсдэл, тодорхой бус байдал болон нийгмийн хамгаалал байхгүй зэрэг асуудал бэрхшээл багтдаг байна. Мөн, тус салбарт Ковид-19 цар тахлын нөлөө их байсан гэж 28.6 хувь, үйлчилгээ эрхлэх явцад татвар, нийгмийн даатгал төлбөртэй холбоотой хүндрэл бэрхшээл нийтлэг тохиолддог гэж 26.6 хувь нь үзжээ. Эдгээрийн зэрэгцээ үйлчлүүлэгчтэй холбоотой асуудал үүсдэг гэж 25.3 хувь нь, түүхий эдийн үнийн өсөлт хомсдолтой гэж 22.9 хувь нь, зах зээл борлуулалттай холбоотой гэж 22.8 хувь нь, өрсөлдөгчидтэй холбоотой асуудал үүсдэг гэж 22.7 хувь нь тус тус үзжээ. Түүнчлэн дараагийн эрэмбэд ажлын байрны түрээслэгчтэй холбоотой гэж 20.8% нь, зээл, барьцаа төвөгтэй гэж 20.6% нь, хууль эрх зүйн орчин бүрдээгүй гэж 20.2% нь тус тус үзсэн байна.

Албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдэд тулгамдаж буй хүндрэл бэрхшээлийг даван туулах, дэмжих олон төрлийн арга зам бий. Судалгаанд оролцогчдын үзсэнээр хүндрэл бэрхшээлийг даван туулах үндсэн арга замын нэг бол ажлын байр бий болгох явдал гэж 10.4%,, нийгмийн даатгалын дарамт шахалтыг бууруулах (7.3%), төрөөс дэмжлэг үзүүлэх (7.2%), зээлд хамруулах (7.2 %) явдал болно.

Макро түвшинд эдийн засгийг төрөлжүүлж, албан ёсны салбар өсөн нэмэгдэх нь албан бус хөдөлмөр эрхлэгчдийг албан ёсны салбарт шилжихэд түлхэц болох юм. Судалгаанд оролцогчдын дурдсанаар,

- ✓ НӨАТ-аас хөнгөлөх, чөлөөлөх, буцаан олголтыг хувийг нэмэгдүүлэх (33.4%)
- ✓ Албан бус хөдөлмөр эрхлэгчдийг бүртгэлжүүлэх (30.0%)
- ✓ НДШ-ийн хөнгөлөлт, чөлөөлөх (29.0%)

зэрэг бодлогын арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзжээ. Түүнчлэн бичил бизнесийг дэмжих бага хүүтэй зээл олгох (24.7%), орлогын албан татвараас тодорхой хугацаанд чөлөөлөх (19.0%), санхүүгийн буцалтгүй дэмжлэг үзүүлэх (18.3%) зэргийг бодлогын чухал арга хэмжээ мөн гэж үзжээ. Эдгээр саналуудыг харгалзан албан бус салбарт хөдөлмөр эрхлэгч бүлгүүдэд тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэхэд чиглэсэн тусгай хөтөлбөр, стратегийг боловсруулан хэрэгжүүлэх нь чухал юм.

Монгол Улсад 2021 оны байдлаар 464.0 мянган хүн албан бусаар хөдөлмөр эрхэлж, албан бус хөдөлмөр эрхлэлтийн түвшин (ХАА-г оролцуулан) 41.2 хувь байв. Өөрөөр хэлбэл, хөдөлмөр эрхэлж буй 100 хүн тутмын 41 нь албан бус хөдөлмөр эрхлэгч байна.

Албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааны үр дүнгээс үзэхэд тухайн салбарт ажиллагсад өөрсдийн ажил, хөдөлмөр эрхлэлтийн байдлаа өнгөрсөн хоёр жилтэй харьцуулахад хэвэндээ байна (36.2%) гэсэн байр суурь бусад хариултаас бага зэрэг өндөр байна.

Өмнөх хоёр жилийн хугацаанд албан бус салбар дахь хөдөлмөр эрхлэлтийн байдал сайжирснаасаа (8.5%) илүү дордсон (33.2%) буюу 24.7 хувийн зөрүүтэй, их сайжирснаасаа (2.0%) илүү их дордсон (15.9%) гэсэн хариулт өндөр буюу 13.9 хувийн зөрүүтэй тус тус байгаа нь анхаарал татаж байна.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг цаашид ямар болох талаар судалгаанд оролцогчдын 15.2 хувь нь харьцангуй сайжирна гэсэн өөдрөг хариултыг өгсөн ба хариулж мэдэхгүй байна гэсэн хариулт нэмэгдэж 14.6 хувь болсон байна.

Албан бус хөдөлмөр эрхлэх нь а)ажил, амралтын цагийг зохицуулах боломжтой, б)татвар, нийгмийн даатгал төлөх шаардлагагүй, в)цалин сайтай, г)эзэмшсэн мэргэжлийн дагуу тул хийхэд хялбар, д)гэр бүлээрээ хөдөлмөрлөх боломжтой гэх мэт давуу талуудтай хэмээн үзсэн. Дурдан буй үзүүлэлт нь бусад үзүүлэлтээс тэргүүлж байв.

Хүснэгт 6.Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эрхэлж буй ажлын сул тал, хувиар

№	Шалтгаан нөхцөл байдал	Хувь
Төрийн дэмжлэг, бодлогоор хамгаалагдах байдал		**25.8**
1	Нийгмийн хамгаалалд хамрагдах боломжгүй	9.4
2	Эрүүл мэндийн үйлчилгээ авах боломж муу	8.1
3	Өөрт эсвэл гэр бүлд асуудал гарахад (өвдөх г.м) ажлаа алдах, орлогын эх үүсвэргүй болох зэрэг өндөр эрсдэлтэй	4.3
4	Төрийн бодлого, зохицуулалт сул	4.0
Ажлын байртай холбоотой хүчин зүйлс		**47.3**
5	Цалин, орлого тогтмол биш	12.1
6	Ажиллах орчин, нөхцөл муу	9.3
7	Ажлын байр баталгаагүй	8.8
8	Ажлын байранд өсөж хөгжих боломж бага	6.3
9	Банкны зээл авахад бэрхшээлтэй	5.4
10	Ажил олгогчийн зүгээс дэмжлэг сул	2.7
11	Тээвэр, гаалийн хүндрэл	2.7
Аюулгүй байдал		**16.7**
12	Гэмтэж бэртэх эрсдэл ихтэй	4.9
13	Дарамт, шахалт, ялгаварлан гадуурхалд өртөх эрсдэлтэй	4.6
14	Гэмт хэрэг зөрчилд өртөх эрсдэлтэй	3.8
15	Цаг агаар, байгалийн хүнд нөхцөл	3.4
Бусад хүчин зүйлс		**10.2**

16	Урт цагаар эсвэл амралтгүйгээр ажилладаг	4.4
17	Гэр бүл, үр хүүхдээсээ хол амьдардаг	3.3
18	Ажлын хамт олонтой байх, бусадтай хамтрах, нөхөрлөх, боломж хомс	2.5
НИЙТ		**100.0**

Эх үүсвэр: Даяаршлын нөхцөлд Орос, Монгол дахь албан бус хөдөлмөр эрхлэлт" судалгааны үр дүнгээс

Албан бус салбарт хөдөлмөр эрхлэхийн сул талыг судалгаанд оролцогчдоор тодорхойлууллаа. Оролцогчдын өгсөн хариултыг агуулгаар нь төрийн дэмжлэг, бодлогоор хамгаалагдах байдал (25.8), ажлын байртай холбоотой хүчин зүйлс (47.3), аюулгүй байдал (16.7), бусад хүчин зүйлс (10.2) гэж 4 ангилж үзлээ. Тодруулж үзвэл албан бус хөдөлмөр эрхлэхийн сул тал нь цалин, орлого тогтмол биш, нийгмийн хамгаалалд хамрагдах боломжгүй, ажиллах орчин, нөхцөл муу, ажлын байр баталгаагүй, эрүүл мэндийн үйлчилгээ авах боломж муу зэрэг нь өндөр хувьтай байна.

Дүгнэлт

“Даяаршлын нөхцөлд Орос ба Монгол дахь албан бус хөдөлмөр эрхлэлт” судалгаагаар хөдөлмөр эрхэлж буй хүн амаас хамгийн бага судлагдсан хэсэг болох албан бус буюу хувираа хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийхийг зорьсон. Монгол Улсад 2023 оны байдлаар 194 мянган хүн албан бусаар хөдөлмөр эрхэлж, албан бус хөдөлмөр эрхлэлтийн түвшин 20.8 хувьтай байв. Өөрөөр хэлбэл, хөдөлмөр эрхэлж буй 100 хүн тутмын 20-21 нь албан бус хөдөлмөр эрхлэгч байна.

Албан бус салбарт хөдөлмөр эрхэлж буй ажилтнуудын цалин хөлс нь хүйсээс хамааралтай эдийн засгийн үйл ажиллагааны салбартай нягт уялдаатай байна. Ялангуяа цар тахлын үед ажлын байр багасаж, орлого буурснаар албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдийн амьжиргаанд эрсдэл учирсан. Судалгаанд оролцсон албан бус салбарт ажиллагсдын 60 орчим хувь нь өрхийн орлого ахуй амьдралд дөнгөж хүрэлцэж байгааг дурдсан юм. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хувьд орлогоо нэмэгдүүлэх арга хэлбэрийг эрэмбэлж үзэхэд дараах таван төрлийн арга хэмжээ түгээмэл байна. Үүнд: худалдаа наймаа хийх, үйлдвэрлэл, гар урлал, оёдол үйл, нарийн боов, хоол хийх, хэд хэдэн газарт ажилладаг, зээл авч бизнесээ өргөжүүлдэг, янз бүрийн үйлчилгээний ажил хийдэг зэрэг арга хэлбэрүүд багтаж байна. Үүнээс үзэхэд олон төрлийн ажил хийх нь албан бус салбарт ажил хөдөлмөр эрхлэгчдийн хувьд орлогоо нэмэгдүүлэх үндсэн боломж ажээ.

Албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдэд тулгамдаж буй хүндрэл бэрхшээлийг даван туулах, дэмжих олон төрлийн арга зам бий. Судалгаанд оролцогчдын үзсэнээр ажлын байр бий болгох, татвар, нийгмийн даатгалын дарамт шахалтыг бууруулах, төрөөс дэмжлэг үзүүлэх, зээлд хамруулах эдгээр болно.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийг албан хэлбэрт шилжихэд албан ёсны зохицуулалт, төрийн нэгдсэн бодлого, үйл ажиллагаагаар дэмжих, цаашид өргөжин хөгжих таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх нь чухал ач холбогдолтой.

Макро түвшинд эдийн засгийг төрөлжүүлж, албан ёсны салбар өсөн нэмэгдэх нь албан бус хөдөлмөр эрхлэгчдийг албан ёсны салбарт шилжихэд түлхэц болох юм. Судалгаанд оролцогчдын дурдсанаар, НӨАТ-аас хөнгөлөх, чөлөөлөх, буцаан олголтыг хувийг нэмэгдүүлэх, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг бүртгэлжүүлэх, НДШ-ийн хөнгөлөлт, чөлөөлөх зэрэг бодлогын арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзжээ.

Албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар эс тухайлсан хууль байхгүй зохицуулж буй хууль эрх зүйн, бодлогын баримт бичиг гарсан ч хэрэгжилтийн түвшин хангалтгүй байгааг анхаарч цаашид албан бус гэсэн тодотголоос илүү хөдөлмөр эрхлэгч гэдэг утгаар эрх зүйн зохицуулалт үйл ажиллагаа явуулах таатай орчин, санхүүгийн дэмжлэг, нийгмийн хамгаалал, бүртгэл зэрэгт бодлогын зохицуулалт үгүйлэгдэж буйг харж болохоор байна.

Ашигласан ном зүйн жагсаалт

1. Европын холбоо, SECIM төсөл. (2020). Албан бус хөдөлмөр эрхлэлтээс албан ёсны хөдөлмөр эрхлэлтэд шилжүүлэх нь. Улаанбаатар.

2. Arrow.K.J. (1962). The Economic Implications of Learning by Doing. The Review of Economic Studies, 29 (3).

3. Bangasser Paul E. (2000). The ILO and the informal sector: an institutional history. .

4. Bikales, Bill, Chimed Khurelbaatar. (2000). Mongolian Urban Informal Sector. Development Alternative Inc. for Economic Policy Support Project (EPSP/USAID). Ulaanbaatar.

5. Hart K. (1973). Informal income opportunities and urban employment in Ghana.

6. ILO. (1972). Employment, incomes and equality: A strategy for increasing productive employment in Kenya. – International Labour Office,.

7. Keith M. Lewin. (1997). Educational Development in Asia: Issues in Planning, Policy. Asian Development Review, 86-130.

8. Lota Bertulfo. (2011). Lota Bertulfo, November 2011. Women and the informal economy /in Australian Government/AusAid Office of development effectiveness. Улаанбаатар.

9. Mankiw NG, Romer D, Weil D. A . (1992). Contribution to the Empirics of Economic Growth. Quarterly Journal of Economics.

10. Morris, Elizabeth. (2001). The Informal Sector in Mongolia. Ulaanbaatar.

11. Paul M. Romer. . (1986). The Journal of Political Economy, Vol. 94, No. 5.

12. W. Turner, M. Koenig. (2015). The informal economy in ulaanbaatar: policy options to promote growth in the ger areas. Ulaanbaatar.

13. МУИС, О. А. (2006). Албан бусаар алт/жонш олборлож буй ажиллах хүчний суурь судалгаа. Улаанбаатар.

14. НҮБ. (2015). Тогтвортой хөгжлийн зорилго 2016-2030. Рио Де Жанейро.

15. ОУХБ, ХНХЯ, ХНХСИ. (2021). Монгол Улсын албан бус хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал. Улаанбаатар.

16. УИХ. (2006). Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого. Улаанбаатар.

17. ҮСХ, Х. (2019). Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал. Улаанбаатар.

18. Ц.Цэцэнбилэг бусад. (2024). Монгол дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийг ангилахуй. Философи, эрх зүйн судлал., 49-52.

SPSIRPA FORUM 2025

Session 3-7

State Regulation and Preparedness for Artificial Intelligence

Хиймэл оюуны төрийн зохицуулалт ба бэлэн байдал

Ariungerel Ts., Lecturer at Department of Public Administration, SPSIRPA, NUM, Mongolia

Илтгэлийн хураангуй:

Хиймэл оюун дэлхий даяар эдийн засаг, засаглалын тогтолцоог өөрчилж буй энэ үед дэлхийн улс орон бодлого, стратеги боловсруулах, эрх зүйн орчин бүрдүүлэн бэлдэж байна. Монгол Улс хиймэл оюуны зохицуулалтын эрх зүйн орчныг бүрдүүлэх, төрийн байгууллагуудын бэлэн байдлыг хангах, хиймэл оюуны стратеги батлах чухал сорилттой тулгарч байна. Монгол Улсын хиймэл оюуны зохицуулалтын өнөөгийн байдал, төрийн байгууллагуудын бэлтгэл, төрийн үйл ажиллагаанд хиймэл оюун ухааныг нэвтрүүлэхэд тулгарч буй гол бэрхшээлүүдийг тодорхойлон авч үзнэ. Үүнд хууль, бодлогын орчны дутагдал, ёс зүйн асуудлууд, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл, төрийн албанд хиймэл оюуны чиглэлээр мэргэшсэн хүний нөөцийн хомсдол зэрэг асуудлууд хамаарна. Мөн хиймэл оюуны төрийн үйлчилгээнд үзүүлэх эерэг нөлөөллийн зэрэгцээ, кибер аюулгүй байдлын эрсдэл зэрэг сөрөг үр дагаврыг хянах шаардлага үүссэн байна.

State Regulation and Preparedness for Artificial Intelligence

Abstract:

Artificial intelligence is transforming economic systems and governance structures worldwide. In response, countries across the globe are developing policies and strategies and establishing legal frameworks to prepare for this technological shift. Mongolia is currently facing a critical challenge: the need to establish a regulatory legal environment for artificial intelligence, ensure the institutional readiness of government bodies, and adopt a comprehensive national AI strategy. This analysis examines the current state of AI regulation in Mongolia, the preparedness of public institutions, and the key challenges encountered in integrating it into public administration. These challenges include the absence of a comprehensive legal and policy framework, unresolved ethical concerns, risks to information security, and a shortage of AI-specialized human resources within the civil service. Alongside the potential positive impacts of artificial intelligence on public service delivery, there is also a pressing need to address its negative consequences, particularly the growing risks to cybersecurity.

Keywords: Artificial intelligence, AI regulations, AI in Mongolia

Оршил

Хиймэл оюун нь өнөөдөр зөвхөн ирээдүйн асуудал биш, харин бидний өнөөгийн өдөр тутмын амьдралын салшгүй хэсэг болжээ. Эрчимтэй, хурдацтай хөгжиж буй энэ технологийн салбар дэлхий даяар технологийн тогтолцоо, эдийн засгийн тогтолцоогоор зогсохгүй засаглалын арга барилд ч гүнзгий өөрчлөлтүүдийг авчирч байна. Хиймэл оюун нь 20-р зууны дунд үеэс шинжлэх ухааны судалгааны салбарт анх үүсэж хөгжиж эхэлсэн ч XXI зуунд илүү хурдацтай хөгжиж, хэрэглээний түвшинд нэвтрэн, хүн төрөлхтний амьдралын бүхий л хүрээнд нөлөөлөх болсон байна.

Ялангуяа сүүлийн жилүүдэд ChatGPT, Google Bard, Claude зэрэг хиймэл оюун ухаанд суурилсан харилцах чадвартай чатботууд зах зээлд гарч, хүнтэй ярилцах чадвар, шийдвэр гаргах болон мэдээлэл боловсруулалтын шинэ түвшинг харуулж, олон нийтийг гайхшируулсан. Ар араасаа хиймэл оюунд тулгуурласан программ хангамж, үйлчилгээ,

автоматжуулалтын системүүд хурдтайгаар гарч ирсээр байна. Ингэснээр хиймэл оюуныг зөвхөн технологийн салбарт бус бизнес, боловсрол, эрүүл мэнд, төрийн удирдлага зэрэг олон салбарт ашиглах нь эрс нэмэгдсээр байна.

Үүнтэй холбоотой хиймэл оюуны хөгжлийн бодлого, зохицуулалтын өнөөгийн түвшинг тодорхойлох, төрийн байгууллагуудын бэлэн байдлыг үнэлэх, цаашдын стратегийн зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах асуудалд зайлшгүй анхаарах цаг болсон. Төрийн байгууллагуудын зүгээс хиймэл оюуны хөгжлийг дэмжихийн зэрэгцээ, эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлого боловсруулах, олон улсын шилдэг туршлагаас суралцах, үндэсний онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэх шаардлага үүсэж байна. Үүний үр дүнд Монгол Улс хиймэл оюуны эрин үед өөрийн хөгжлийн шинэ замыг тодорхойлох, олон улсын өрсөлдөх чадвараа дээшлүүлэх бодит боломжийг бий болгох боломжтой.

Хиймэл оюуныг зохистой ашиглах, хөгжүүлэхэд дэлхийн улс орнууд нийтлэг үнэт зүйл, эрх зүйн үндсийг бий болгохыг зорьж, зохицуулалтын бодлогодоо дараах үндсэн зарчмуудыг баримталж байна[63]. Үүнд:

- Хүн төвтэй байх (Human-centricity): Хиймэл оюуны хөгжүүлэлт, хэрэглээ нь хүний эрх, эрх чөлөө, амьдралын чанарыг дээдэлсэн, хүний сайн сайхны төлөө чиглэсэн
- Шударга байх (Fairness): Хиймэл оюуны систем нь аливаа ялгаварлан гадуурхал, гаднын дарамт, сөрөг нөлөөгүй, бүх хүнд тэгш боломжийг хангах
- Ил тод байх (Transparency): Хиймэл оюуны шийдвэр гаргах үйл явц, өгөгдөл, логик үндэслэл нь хянах буюу мониторинг хийх боломжтой, ил тод, ойлгомжтой байх
- Тайлбарлагдах (Explainability): Системийн шийдвэр, үйлдэл нь хүнд ойлгомжтой байж, шалтгааныг нь тайлбарлах боломжтой байх
- Хариуцлагатай байх (Accountability): Хиймэл оюуны системийн үйл ажиллагаанд хяналт тавих ба зөрчил илэрсэн тохиолдолд хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалт, институцийн тогтолцоо бүрдсэн байх
- Дэлхий нийтийн уялдаа холбоо (Global alignment): Хиймэл оюуны зохицуулалт нь олон улсын стандарт, ёс зүй, хүний эрхийн нийтлэг хэм хэмжээнд нийцсэн, олон улсын хамтын ажиллагааг дэмждэг чиглэлтэй байх[64].

Олон улсын туршлага

Хиймэл оюуны технологиуд дэлхий даяар идэвхтэй ашиглагдах болсон. Гэсэн хэдий ч хиймэл оюуны загваруудыг хөгжүүлэх, ашиглах түвшинд улс орнуудын технологийн түвшин хооронд мэдэгдэхүйц зөрүү үүсээд байна. 2017 онд БНХАУ, Канад, АНЭУ, Франц зэрэг дөрвөн улс

[63] Ozmen Garibay, O., Winslow, B., Andolina, S., Antona, M., Bodenschatz, A., Coursaris, C., … Xu, W. (2023). Six Human-Centered Artificial Intelligence Grand Challenges. *International Journal of Human–Computer Interaction, 39*(3), 391–437. https://doi.org/10.1080/10447318.2022.2153320

[64] Ozmen Garibay, O., Winslow, B., Andolina, S., Antona, M., Bodenschatz, A., Coursaris, C., … Xu, W. (2023). Six Human-Centered Artificial Intelligence Grand Challenges. *International Journal of Human–Computer Interaction, 39*(3), 391–437. https://doi.org/10.1080/10447318.2022.2153320

хиймэл оюуны стратегиа дэлхий дахинд анхлан зарлаж байсан бол өдгөө 77 улс стратегиа баталж, түүний хөгжүүлэлт, зохицуулалт, ёс зүйн асуудалд чиглүүлэх бодлогоо боловсруулсан талаар Oxford Insight байгууллагын 2024 онд гаргасан тайланд дурджээ. Эдгээр 77 орон дунд бага орлоготой улс орнууд нэлээдгүй багтсан.[65]

Өнөөдрийн байдлаар хиймэл оюун ухааны загваруудыг боловсруулах, технологийг хөгжүүлэх салбар нь АНУ болон БНХАУ-ын хоорондын эдийн засгийн өрсөлдөөний гол талбар босон. АНУ болон БНХАУ хиймэл оюуны салбарт амжилтад хүрсэн тэргүүлэгч улсууд. Харин Европын Холбоо болон бусад орнууд голчлон хиймэл оюуны хэрэглэгчийн байр суурьтай. Хиймэл оюуныг хуулиар зохицуулах оролдлого эрчимжиж, өрсөлдөөн үүссэнийг "race to AI regulation" ч гэж нэрлэсэн байдаг[66]. Засгийн газрууд хиймэл оюуны чиглэлд зохицуулалт болон хөрөнгө оруулалтаа нэмж байгаа нь Стэнфордын Их Сургуулийн судалгааны дараах тоо мэдээллээс харагдана. 2024 онд АНУ-ын холбооны агентлагууд хиймэл оюунд хамаарах 59 шинэ зохицуулалт гаргасан нь 2023 оныхоос хоёр дахин олон бөгөөд энэ удаа хоёр дахин олон агентлаг оролцсон байна. 75 улсад хиймэл оюуны талаарх хууль тогтоомжид дурдагдсан тоо 2023 оноос хойш 21.3%-аар өсч, 2016 оноос хойш ес дахин нэмэгдээд байна. Засгийн газрууд томоохон хэмжээний хөрөнгө оруулалт хийж байна. Тухайлбал:

- Канад хиймэл оюуны хөгжилд 2.4 тэрбум ам.доллар
- БНХАУ 47.5 тэрбум ам.доллар хагас дамжуулагчийн санд
- Франц 109 тэрбум евро
- Энэтхэг 1.25 тэрбум ам.долларын амлалт
- Саудын Араб "Project Transcendence" нэртэй 100 тэрбум ам.долларын санаачилгыг эхлүүлсэн байна[67].

Тус судалгаагаар дэлхийн улс орны гуравны хоёр нь бага, дунд боловсролын түвшинд компьютерын шинжлэх ухааны хичээл заах эсвэл хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа нь 2019 оноос хойш хоёр дахин өссөн гэсэн үзүүлэлт гарчээ. АНУ-д компьютер технологийн чиглэлээр бакалаврын зэрэгтэй төгсөгчдийн тоо сүүлийн 10 жилд 22%-аар өссөн боловч бусад орлогын түвшин бага улс орнуудад суурь дэд бүтцийн дутагдлаас үүдэн боловсролын хүртээмж муугаас энэ үзүүлэлт доогуур байна. АНУ-ын К–12(цэцэрлэгээс 12 дугаар анги хүртэлх боловсролын тогтолцоо) түвшний компьютерын шинжлэх ухааны багш нарын 81% нь хиймэл оюуныг суурь хичээлийн бүрэлдэхүүнд оруулах шаардлагатай гэж үзэж байгаа ч тэдний тал хүртэлх хувь нь үүнийг заахад хангалттай мэдлэг, бэлэн байдалгүй байгаагаа илэрхийлжээ[68].

Улс орнуудын хиймэл оюунтай холбоотой төрийн зохицуулалтуудын ялгаатай байдал нь юуны түрүүнд хиймэл оюуны технологи хөгжүүлэгч, бүтээгдэхүүн үйлчилгээ үйлдвэрлэгч эсэхээс хамаарч байна. АНУ, БНХАУ болон Европ тивийн улсууд шинжлэх ухаан, судалгаа, хэрэглээний салбарт хиймэл оюуны хөгжлийг дэмжиж, энэ салбарт их хэмжээний хөрөнгө оруулалт хийж байна. Эдгээр улс орнууд үндэсний хэмжээнд стратегийн бодлого боловсруулж, хиймэл оюуныг эдийн засаг, нийгмийн хөгжилд үр ашигтайгаар ашиглахын

[65] Government AI Readiness Index - Oxford Insights

[66] Smuha, N. A. (2021). From a 'race to AI' to a 'race to AI regulation': regulatory competition for artificial intelligence. *Law, Innovation and Technology*, *13*(1), 57–84. https://doi.org/10.1080/17579961.2021.1898300

[67] *The AI Index Report 2025*. Stanford Institute for Human-Centered Artificial Intelligence. https://hai.stanford.edu/ai-index/2025-ai-index-report

тулд системтэй арга хэмжээ авч эхэлжээ. Харин Сингапур, БНСУ, Япон зэрэг азийн өндөр хөгжилтэй орнууд хиймэл оюуныг эдийн засгийн өсөлт, технологийн тэргүүлэгч байх стратегийн гол хөшүүрэг хэмээн тодорхойлон, төрийн бодлогоо чиглүүлж байна. Тэд шинжлэх ухаан-технологийн инновацыг дэмжих, хүний нөөцийг бэлтгэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зэрэг олон талт бодлого хэрэгжүүлж байна. Хөрш орон болон ОХУ 2019 онд Үндэсний хиймэл оюуны стратеги гаргаж, өнгөрч 2024 онд шинэчлэн баталсан.[69] Энэ төлөвлөгөөндөө хиймэл оюуны салбарт 850 тэрбум рублийн хөрөнгө оруулахаар заажээ. Харин Тусгаар улсуудын хамтын нийгэмлэг /ТУХН/-ийн орнууд хиймэл оюуны технологийг зохицуулах хуулийн төслийг 2025 онд дуусгахаар төлөвлөснийг Беларусийн Үндэсний шинжлэх ухааны академийн Мэдээллийн технологийн асуудлын нэгдсэн хүрээлэнгээс мэдээлсэн[70].

Европын Холбоо (ЕХ) нь өөрийн гэсэн хиймэл оюуны загваруудыг хөгжүүлэн нийлүүлдэггүй хэдий ч, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үүднээс хиймэл оюун ухааны хэрэглээг зохицуулах хуулийн иж бүрэн цогцыг(EU AI Act) баталсан байдаг. Европын холбооны зарим улс chatGPT-ний хэрэглээг хязгаарлах бодлого ч хэрэгжүүлж байсан ба 2023 онд Итали улс chatGPT ашиглалтад хориг тавьж байсан удаатай. ЕХ-ны хиймэл оюуны тухай хууль нь 2024 оны 8-р сарын 1-нд батлагдсан бөгөөд шаталсан хугацаагаар хэрэгжиж 2027 оны 8-р сарын 2-ны өдөр бүрэн хэмжээгээр хэрэгжинэ. Уг хуульдаа хиймэл оюуны эрсдэлийн ангиллыг системийн хэрэглэгчдэд үзүүлэх эрсдэлийн байдлаар нь шинжилж дараах дөрвөн түвшний эрсдэлийг тодорхойлон тусгасан байна. (Report, 2025)

- Хүлээн зөвшөөршгүй эрсдэл (Unacceptable risk): Хүний зан төлөвийг далд удирдах, бодит цагаар биометрийн танилт хийх (нийтийн газарт нүүр таних), нийгмийн оноо тогтоох зэрэгт хиймэл оюуны хэрэглээг бүрэн хориглосон.
- Өндөр эрсдэл (High-risk): Эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, шүүх, хууль сахиулах зэрэг салбарт ашиглагдах хиймэл оюун нь чанар, ил тод байдал, хүний хяналт, аюулгүй байдлын шаардлагыг хангаж, зах зээлд нэвтрэхийн өмнө болон дараа нь нийцлийн үнэлгээ хийлгэх ёстой.
- Хязгаарлагдмал эрсдэл (Limited risk): Хэрэглэгч хиймэл оюунтай харилцаж буйгаа мэддэг байх, ил тод байх шаардлага тавигдана.
- Бага эрсдэл(Minimal risk): Ихэнх хиймэл оюун энэ ангилалд багтдаг бөгөөд нэмэлт зохицуулалт шаардахгүй.
- Ерөнхий зориулалттай хиймэл оюун (General-purpose AI), ChatGPT зэрэг хиймэл оюунд ил тод байдлын шаардлага тавигдах ба өндөр хүчин чадалтай загварууд нь нэмэлт үнэлгээ, зохицуулалт шаардана.

Энэхүү цогц хууль үлгэр жишээ, сайн хууль болсон гэсэн үнэлгээ авч байгаа. Европын холбоо нь энэ хуулиа дэлхий даяр мөрдөх стандарт болгох зорилготойгоо илэрхийлсэн. Хиймэл оюуны хэрэглэгчид төвлөрсөн түүнийг эрсдэлээс хамгаалах зорилготой сайн хууль хэдий ч хиймэл оюун хөгжүүлэлтийг хязгаарлах сөрөг нөлөөлөл үүсэх магадлалтай.

Хүний нөөцийн тухайд Европын мэдээллийн технологийн салбарын хүчтэй өсөлтийн үе үргэлжилсээр байгаа. Сүүлийн таван жилийн хугацаанд Европын мэдээлэл технологийн

[69] https://www.comnews.ru/content/231631/2024-02-19/2024-w08/1008/prezident-rf-obnovil-strategiyu-razvitiya-iskusstvennogo-intellekta

[70] https://e-cis.info/news/566/121052/

салбарын ажиллах хүч 750,000 ажилтнаас 2.3 саяд хүрч огцом өссөн гэж Atomico компанийн 2023 оны судалгаанд дурджээ. Мөн 10 жилийн дотор Европт хиймэл оюуны салбарт ажиллагсдын тоо 1,000 хувиар буюу арван дахин нэмэгдсэн гэсэн байна.[71] Шалтгаан нь АНУ-руу чиглэдэг ажиллах хүч одоо Европ руу чиглэдэг болсон ба ЕХ-ны тогтвортой байдал зэргээр тайлбарласан.

АНУ тухайд одоогийн байдлаар хиймэл оюуныг хөгжүүлэх эсвэл ашиглахыг тусгайлан хориглосон, хязгаарласан цогц хууль байхгүй. 2025 оны 1-р сард Ерөнхийлөгч Дональд Трамп "Хиймэл оюуны салбарт Америкийн тэргүүлэх байр суурийг баталгаажуулахад саад болж буй зохицуулалтыг цуцлах тухай Ерөнхийлөгчийн зарлиг" (Removing Barriers Executive Order)[72] гаргаж, өмнөх Ерөнхийлөгч Байдены "Хиймэл оюуныг аюулгүй, найдвартай, итгэлтэй хөгжүүлж ашиглах тухай Ерөнхийлөгчийн зарлиг"-ийг (Biden EO)[73] цуцалсан. Трампын Removing Barriers зарлигт, бүх холбооны агентлаг болон яамдууд Байдены үед гаргасан холбогдох бодлого, журам, захирамж, зохицуулалтыг шинэчлэн үзэх эсвэл хүчингүй болгохыг үүрэгдсэн. Хиймэл оюуны технологи хөгжүүлэгч компаниуд нь хуулиас илүүтэйгээр ёс зүйтэй байж аюулгүй байдлаа хамгаалах тал дээр анхаарахаа илэрхийлсэн байдаг. Adobe, Amazon, Anthropic, Cohere, Google, IBM, Inflection, Meta, Microsoft, Nvidia, OpenAI, Palantir, Salesforce, Scale AI, Stability AI зэрэг томоохон хиймэл оюуны компаниуд хиймэл оюуны системийг нэвтрүүлэхээс өмнө дотоод ба гадаад аюулгүй байдлын хангах, эрсдэлийн менежментийн туршлага, мэдээллийг харилцан солилцох, аюулгүй байдлын хамгаалалтад хөрөнгө оруулах зэргээр аюулгүй, найдвартай, ил тод хиймэл оюуны хөгжлийг дэмжих амлалт өгсөн байдаг[74].

АНУ-ын засгийн газраас илүүтэйгээр муж улсуудын түвшинд хэрэгжүүлэх нөхцөл бүрэлдэж мужуудад хиймэл оюуны зохицуулалтууд бий болсон. Жишээлбэл:

- Калифорнийн Хувийн Нууцыг Хамгаалах Хууль (CPPA)[75]-Автомат шийдвэр гаргалтыг зохицуулдаг
- Иллинойс мужийн Биометрийн мэдээллийн тухай хууль (BIPA)[76]
- Колорадо мужийн Хиймэл оюунаас хэрэглэгчийг хамгаалах хууль[77]

Трампын засаг ажлаа авсан эхний өдрөөс хиймэл оюуны хөгжүүлэгч компаниудаа дэмжиж байгаагаа илэрхийлсэн. АНУ-ын Конгресс хиймэл оюуны талаар олон төрлийн хуулийн төслүүдийг хэлэлцэж байгаа ч технологийн өрсөлдөөнд (ялангуяа БНХАУ-тай) хоцрохгүй байх зорилго тээж байгаагийн хувьд хатуу зохицуулалттай хууль батлах эсэх нь тодорхойгүй байна. Мөн хиймэл оюуны дэд бүтцийн хөгжилд зориулж 500 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийхээ зарлаж энэ салбарт зуун мянган ажлын байр бий болгохыг төлөвлөж байна. Эндээс харахад АНУ хиймэл оюуны салбарыг ихэд чухалчлан үзэж дэмжиж байна.

---

[71] Macaulay, T. (n.d.). *Europe has more AI talent than US, study finds: The continent's tech sector has also taken a lead in entrepreneurship*. Atomico.

[72] https://www.whitehouse.gov/presidential-actions/2025/01/removing-barriers-to-american-leadership-in-artificial-intelligence/

[73] https://www.congress.gov/crs-product/R47843

[74] https://ailabwatch.org/resources/commitments/#ai-safety-policies

[75] https://cppa.ca.gov/regulations/

[76] https://www.aclu-il.org/en/campaigns/biometric-information-privacy-act-bipa

[77] https://leg.colorado.gov/bills/sb24-205

Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ) 2024 оны 12-р сард "Хиймэл оюуны тухай хууль"-ийг Үндэсний Ассамблейгаар батлсан нь тус улсын хиймэл оюуны салбарт хийх бодлогын томоохон алхам болсон. Европын Холбооны дараагаар хиймэл оюуны цогц хууль батлсан 2дах улс болсон. Хэдий БНСУ-д одоогоор дэлхийн түвшний томоохон хиймэл оюуны компани байхгүй ч, тус улс хиймэл оюуны хөгжлөөр АНУ, БНХАУ зэрэг тэргүүлэгч орнуудтай өрсөлдөх томоохон амбицтай. АНУ, БНХАУ-тай зэрэгцэн "AI G3" буюу хиймэл оюуны тэргүүлэгч 3 орны тоонд багтах зорилготой улс юм. Иймээс хуулийн гол зорилго нь хиймэл оюуны технологийг хөгжүүлэх, инновацыг дэмжих явдал бөгөөд үүний зэрэгцээ хэрэглэгчийн эрх, аюулгүй байдлыг хамгаалах зохицуулалтыг ч мөн тусгасан нь онцлогтой. БНСУ-ын хууль 2026 оны 1-р сараас хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх бөгөөд дараах гол агуулгыг багтаасан байна[78].

Үндэсний хиймэл оюуны(AI) хөгжлийн стратеги

- Шинжлэх ухаан, мэдээлэл, харилцаа холбооны сайд нь 3 жил тутамд үндэсний AI хөгжлийн үндсэн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- Ерөнхийлөгчийн удирдлага дор ажиллах Үндэсний Хиймэл Оюуны Хороо байгуулагдана.
- AI-аас үүдэлтэй эрсдэлийг судлах, урьдчилан сэргийлэх зорилгоор Хиймэл Оюуны Аюулгүй Байдлын Судалгааны Төв байгуулагдана.

Хиймэл оюуны салбарын хөгжлийг дэмжих

- AI судалгаа, хөгжлийг дэмжих, стандартчилал, сургалтын мэдээллийн бодлого боловсруулна.
- AI төвлөрсөн бүс нутаг, өгөгдлийн төвүүдийг байгуулах, AI нэгдсэн хэрэглээг дэмжих.
- AI мэргэжилтэн бэлтгэх, жижиг, дунд үйлдвэрүүдийг дэмжих, гарааны бизнесийг хөгжүүлэх.

Өндөр нөлөөтэй хиймэл оюуны зохицуулалт

- Хүний амь нас, бие махбод, үндсэн эрхэд ноцтой нөлөө үзүүлэх AI-ийг "өндөр нөлөөтэй AI" гэж тодорхойлно.
- AI-ийн ил тод байдал, аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээлгэнэ.
- AI үйлчилгээ үзүүлэгчид аюулгүй байдлын баталгаажуулалт, нөлөөллийн үнэлгээ хийх үүрэгтэй.
- БНСУ-ын хиймэл оюуны хууль нь AI салбарын хөгжлийг дэмжих, аюулгүй байдлыг хангах, хүний эрхийг хамгаалах үндэс суурийг бүрдүүлнэ[79].

ЕХ-ны хуулиас ялгаатай нь хиймэл оюуны сөрөг талыг зохицуулахдаа ЕХ нь "эрсдэл" гэдэг үгийг ашигласан бол БНСУ-д "нөлөөлөл" гэдэг үгийн ашигласан. Үүнээс харахад тухайн 2 улсын хиймэл оюун ухааны үзэл баримтлалын ялгаа харагдана. Анхаарал татах бас нэгэн зүйл нь хиймэл оюунаар бүтээгдсэн контентод 2026 оны 1-р сараас эхлэн, хиймэл оюуны бүтээл

[78] https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=268543&efYd=20260122#0000
[79] https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=268543&efYd=20260122#0000

болохыг тодорхой харуулсан таних тэмдэг заавал оруулах зохицуулалт юм. Тус хуульд Засгийн газрын урьдчилсан зөвшөөрөлгүйгээр аливаа хэрэглэгч шинэ хиймэл оюуны загвар бүтээхийг зөвшөөрөх зохицуулалт багтсан. Мөн хувийн мэдээлэл хамгаалах хороо (Personal Information Protection Commission) нь ерөнхий хиймэл оюуны хөгжүүлэлтэд биометрийн өгөгдлийг хамгаалах тогтолцоог дахин шинээр авч үзэх зорилготой ажлын хэсэг байгуулах төлөвлөгөөгөө зарласан байна[80].

БНХАУ нь хиймэл оюуны салбарт АНУ-тай энэ зэрэгцэн өрсөлдөж буй дэлхийд тэргүүлэгч улс гүрэн. Хиймэл оюуны стратеги баталсан анхны улсын нэг. АНУ-д хараахан хиймэл оюуныг зохицуулах хуульгүй бол БНХАУ хатуу хуультай. Хуульд компаниудын боловсруулсан хиймэл оюуны системүүд нь социалист үнэт зүйлсийг баримтлах ёстой бөгөөд үндэс угсаа, итгэл үнэмшил, улс орон, бүс нутаг, хүйс, нас зэрэг үзүүлэлтээр хэрэглэгчийг ялгаварлан гадуурхах ёсгүй гэж заасан. Мөн оюуны өмчийн эрх болон бизнесийн ёс зүйг хүндэтгэх үүрэгтэй ба хиймэл оюуны алгоритм хөгжүүлэгчид хүний хууль ёсны эрх ашигт халдахгүй байх, бие махбод ба сэтгэл санааны эрүүл мэндэд аюул учруулахгүй байх, эрхийг зөрчихгүй байх үүрэг хүлээнэ. Хятадын засгийн газар ерөнхий хиймэл оюуны шинэчлэлд суурилсан хэрэглээг салбар бүрт дэмжих, ерөнхий хиймэл оюуны дэд бүтцийг байгуулах, мөн сургалтын өгөгдөл цуглуулах нэгдсэн платформ бий болгохыг уриалж байна.

Хятад ба АНУ-ын хиймэл оюуны зохицуулалтын товч харьцуулж үзвэл[81]:

- Шинэ үйлчилгээ нэвтрүүлэх:
  Хятадад хиймэл оюуны үйлчилгээг эхлүүлэхийн өмнө аюулгүй байдлын шалгалт заавал хийдэг. АНУ-д ийм шаардлага бараг байхгүй.
- Контентын тэмдэглэгээ:
  Хятадад AI-гаар үүсгэсэн контентыг заавал тэмдэглэх ёстой. АНУ-д хуульчлаагүй.
- Оюуны өмчийн хамгаалалт:
  Хятад хууль ёсны өгөгдөл ашиглахыг шаарддаг, зөрчвөл торгуультай. АНУ-д зохицуулалт сул.
- Нийтийн хяналт ба тайлагнал:
  Хятадад компаниуд нийтийн хяналтын механизм нэвтрүүлэх үүрэгтэй. АНУ ил тод байдалд анхаардаг ч тайлагнах шаардлагагүй.

Сингапур улс нь Зүүн Өмнөд Азид үндэсний хиймэл оюуны стратеги нэвтрүүлсэн анхны улс юм. 2023 онд эхлүүлсэн Сингапурын Үндэсний Хиймэл Оюуны Стратеги 2.0 нь Ухаалаг үндэстэн болох дэлхийн инновац, хиймэл оюуны чиг хандлагыг манлайлах зорилгын хүрээнд боловсруулагдсан[82]. Анх 2019 онд Үндэсний Хиймэл Оюуны Стратегиа (National AI Strategy) танилцуулж, эдийн засгаа хиймэл оюуны тусламжтайгаар шинэчлэн хөгжүүлэх зорилго бүхий төлөвлөгөөгөө зарласнаар үр дүнд нь 150 орчим судалгаа, хөгжлийн баг ажиллаж эхэлсэн ба 900 гаруй гарааны бизнес хиймэл оюунд суурилсан шинэ санааг туршиж эхэлсэн байна.

[80] https://www.lawtimes.co.kr/LawFirm-NewsLetter/204461

[81] Евгений Тонких “Опыт Китая в регулировании ИИ”, Российский Совет по Международным Делам (RSMD) https://russiancouncil.ru/analytics-and-comments/analytics/opyt-kitaya-v-regulirovanii-ii-mezhdu-stsilloy-i-kharibdoy/?sphrase_id=202429820

[82] https://www.edb.gov.sg/en/business-insights/market-and-industry-reports/singapores-national-ai-strategy-ai-for-the-public-good-for-singapore-and-the-world.html

Амжилттай хөгжсөн салбарын бодлогыг шинэчлэн 2023 онд үргэлжлэл болон Сингапурын Үндэсний Хиймэл Оюуны Стратеги 2.0 (NAIS 2.0)-ийг албан ёсоор хэрэгжүүлж эхлүүлсэн[83].Энэхүү стратегийн баримт бичиг нь таван жилийн хиймэл оюуны хөгжлийн алсын хараа, зорилго, төлөвлөгөөг тодорхойлсон бөгөөд дараах үндсэн агуулгатай:

- Хүний нөөц ба экосистемийн хөгжил: Инновацыг хөтлөх хамтын түншлэлийн идэвхтэй сүлжээ бий болгоход чиглэсэн төлөвлөгөө
- Хиймэл оюуныг нэвтрүүлэх таван стратегийн салбар:
    - Эрүүл мэнд
    - Ухаалаг хот, орон сууц
    - Боловсрол
    - Аюулгүй байдал ба хамгаалалт
    - Логистик
- Ёс зүйтэй нэвтрүүлэлт: Хиймэл оюуныг ил тод, шударга, хариуцлагатай байдлаар хэрэгжүүлэхэд анхаарах

Сингапур нь Зүүн Өмнөд Азийн бүс нутагт технологийн засаглалаар манлайлагч бөгөөд хиймэл оюуны дэлхийн төв болох зорилгоо тодорхойлсон. Төрөөс AI судалгаа, хөгжүүлэлтэд өндөр түвшний дэмжлэг үзүүлж, хүний нөөц бэлтгэх, гарааны бизнесүүдийг дэмжих зэрэг цогц арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. ДНБ-ий хэмжээнд тооцвол хиймэл оюунд чиглэсэн төрийн санхүүжилт нь АНУ-тай харьцуулахад 18 дахин их. Судалгааны тоон үзүүлэлтээр 2020 он хүртэлх хугацаанд хиймэл оюуны патентын тоогоор дэлхийд 12-т, батлагдсан патентаар 14-т, холбогдох судалгааны ажлын хэмжээгээр 15-д эрэмбэлэгджээ[84]. Дэлхийн болон бүс нутгийн олон улс орон Сингапур улсын жишээнээс суралцаж, туршлага судалж байна.

Монгол Улсын хиймэл оюуны түвшин, зохицуулалтын эрх зүйн орчин, төрийн байгууллагуудын бэлэн байдал болон хиймэл оюуны стратеги ямар түвшинд байгааг авч үзвэл хиймэл оюун ухаан, их өгөгдлийн бодлого, зохицуулалтыг хөгжүүлэх ажил эхлэлийн шатандаа явж байна гэж болно. “Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-д цахим засаглалыг хөгжүүлэх эрх зүйн орчныг тухайд мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, цахим засаглалыг хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдэж, орон зайнаас үл хамааран төрийн үйлчилгээ шат дамжлагагүй, шуурхай болгох зорилт тавьсан.

Хиймэл оюуны бэлэн байдлын Oxford Insight байгууллагын гаргасан судалгаанд 2024 онд “Хиймэл оюун ухааны бэлэн байдлын индекс”-ээр 11 байр урагшилж, 188 орноос 98 дугаарт эрэмбэлэгдсэн[85]. Мөн НҮБ-аас хоёр жил тутамд шинэчлэн гаргадаг “Цахим засаглалын хөгжлийн индекс”-ээр Монгол Улс 2024 онд 193 орноос 46 дугаар байрт орсон. 2022 онд энэ үзүүлэлтээр 74 дүгээр байрт жагсаж байсан бөгөөд 2024 онд 28 байраар урагшилсан амжилт гаргасан. Эдгээрээс харахад бид энэ салбарт дээгүүр ороогүй ч сүүл мушгиж хоцроогүй нь

[83] https://www.smartnation.gov.sg/nais/

[84] https://cset.georgetown.edu/wp-content/uploads/CSET-Examining-Singapores-AI-Progress.pdf

[85] Government AI Readiness Index - Oxford Insights

төрөөс авч байгаа бодлого зохицуулалтын үр дүн юм. Хиймэл ухааны чиглэлд анхаарлаа хандуулж, үндэсний хэмжээний хиймэл оюуны стратеги боловсруулах ажлыг эрчимжүүлж эхэлсэн бөгөөд өнгөрсөн 2-аар сард Монгол Улсын “Их өгөгдөл, хиймэл оюуны үндэстний стратеги хэлэлцүүлэх анхдугаар чуулган” болж стратегийн төслөө олон нийтэд танилцуулж, хэлэлцүүлсэн. Хиймэл оюуны алсын харааг тодорхойлох нь зөвхөн технологийн хөгжлийг бус үндэсний тогтвортой хөгжил, иргэдийн сайн сайхан байдал, улс орны дэлхийн тавцанд өрсөлдөхүйц байр суурь эзлэх гол хүчин зүйл болох юм.

Хууль эрх зүйн орчныг авч үзвэл Монгол Улсын “Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай” хуулиар хувь хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулсан. Монгол Улсад хиймэл оюун болон их өгөгдөлтэй холбогдох дараах хууль тогтоомжууд байна:

- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль
- Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль
- Зөвшөөрлийн тухай хууль
- Харилцаа холбооны тухай хууль
- Өрсөлдөөний хууль
- Цахим гарын үсгийн тухай хууль
- Кибер аюулгүй байдлын тухай хууль

Эдгээрээс харахад хиймэл оюунтай шууд холбогдох хууль одоогоор байхгүй байна. Хиймэл оюуны хэрэглэгч улсын хувьд Европын Холбооны хиймэл оюуны хуулийн жишгээр хэрэглэгчээ хамгаалсан, хиймэл ухааны хөгжүүлэгчийн ёс зүйг бататгасан, мөн хиймэл оюуны хөгжүүлэгчдээ хамгаалан дэмжсэн хууль дүрэм яах араггүй шаардлагатай. Бусад улсын баримталж буй human-centric, fairness, transpareny, explainability, accountability, global aligment зарчмуудыг барин хиймэл оюуны зохицуулалтыг хийх хэрэгцээ бидэнд тулгарч байна.

Хүний нөөцийн чадавхгүйгээр хиймэл оюуны салбарын тогтвортой хөгжил боломжгүй юм. Хиймэл оюуныг хөгжүүлэх, хууль эрх зүйн болон бодлогын баримт бичгүүдийг боловсруулах, төрийн болон хувийн хэвшлийн үйлчилгээний салбаруудад үр ашигтайгаар нэвтрүүлэх, мөн уг технологид дагалдах эрсдэлүүдийг урьдчилан танин мэдэх, хариу арга хэмжээ авах зэрэг бүх шатны үйл ажиллагаанд чадварлаг, мэргэшсэн хүний нөөц зайлшгүй шаардлагатай. Монгол Улсад хиймэл оюуны чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх ажил 2020 онд анхны бакалаврын хөтөлбөрийн элсэлтээр эхэлсэн нь дотооддоо боловсон хүчин бүрдүүлэх чухал алхам болсон. Мөн Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас 2024 оны 3 дугаар сард улс даяар “Хиймэл оюуны элч” хөтөлбөрийг хэрэгжүүлж, 1000 залуу манлайлагчийг бэлтгэх ажил эхлүүлсэн нь хүний нөөцийн хөгжлийг дэмжих бодлогын нэг жишээ юм[86]. Цаашид төрийн түвшинд урт хугацааны, тогтвортой хүний нөөцийн бодлого боловсруулах, хиймэл оюуны чиглэлээр мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх тогтолцоог их, дээд сургууль, судалгааны байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурлан хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Хиймэл оюуны хөгжлийг бодлогоор дэмжих, хариуцлагатай ашиглалтыг хангах хүрээнд төр дараах чиглэлээр голлох үүрэгтэй байна.

[86] https://mddic.gov.mn/mn/category/news/

1. Эрх зүйн орчин, бодлогын зохицуулалт
   Эцэст нь төрийн зүгээс хиймэл оюуныг зохистой хөгжүүлэх, ёс зүйтэй, хариуцлагатай ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн:
   - эрх зүйн зохицуулалтыг бий болгох,
   - технологийн хөгжилтэй уялдсан стратегийн бодлого боловсруулах шаардлагатай.
2. Өгөгдлөөр хангах
   Хиймэл оюун нь өгөгдөлд суурилсан технологи учраас түүнийг хөгжүүлэхэд чанартай, зохистой өгөгдөл зайлшгүй шаардлагатай. Төр бол хамгийн том өгөгдөл эзэмшигч байгууллага учраас, төрийн зүгээс өгөгдлийг:
   - зохистой боловсруулж нэгтгэх
   - шаардлагатай бол нээлттэй болгож,
   - Хиймэл оюун хөгжүүлэгч байгууллага, компаниудад ил тод, хариуцлагатай байдлаар дамжуулах шаардлагатай.
3. Кибер аюулгүй байдал ба технологийн дэд бүтэц
   Өгөгдөл болон систем нь кибер халдлага, мэдээллийн алдагдалд эмзэг тул төр:
   - мэдээллийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо,
   - дэвшилтэт тооцоолол, дата хадгалалт зэрэг технологийн дэд бүтцийг төлөвлөн хөгжүүлэх нь чухал.
4. Хүний нөөцийн бэлэн байдал
   Технологийн хөгжлийг дагаад чадварлаг хүний нөөцийн эрэлт нэмэгдэж, төрийн зүгээс:
   - тухайн салбарт шаардагдах ур чадвар бүхий хүний нөөцийг тодорхойлох,
   - урьдчилан бэлтгэх бодлого хэрэгжүүлэх,
   - их, дээд сургууль, судалгааны байгууллага, хувийн хэвшилтэй стратегийн түншлэл хөгжүүлэх шаардлагатай.
5. Хөрөнгө оруулалт ба санхүүгийн дэмжлэг
   Хиймэл оюуны хөгжлийг хангахад:
   - төрөөс хөрөнгө оруулалт хийх,
   - хувийн хэвшлийг урамшуулах зорилгоор татварын хөнгөлөлт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх,
   - инновацын сан, буцалтгүй тусламж, урамшууллын хөтөлбөр зэрэг механизмыг нэвтрүүлэх шаардлагатай.

Дүгнэлт

Хиймэл оюуны технологи дэлхийн эдийн засаг, засаглалын тогтолцоонд гүнзгий нөлөө үзүүлж буй энэ цаг үед улс орнууд бодлогын түвшинд стратеги боловсруулж, эрх зүйн зохицуулалт, дэд бүтцийн суурийг бүрдүүлж байна. Судалгаанаас харахад өндөр хөгжилтэй улсууд хиймэл оюуныг хөгжлийн стратегийн төвд байлгаж, эрх зүйн тогтолцоогоо боловсронгуй болгож, хүний нөөц, инновац, технологийн дэд бүтцэд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийж байна. Үүний зэрэгцээ ёс зүй, мэдээллийн аюулгүй байдал, ил тод байдал зэрэг үнэт зүйлсийг эрх зүйн зохицуулалтаар баталгаажуулж байна.

Монгол Улсын хувьд хиймэл оюуны хөгжлийг дэмжих үндэсний бодлого боловсруулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх, төрийн байгууллагуудын бэлэн байдлыг сайжруулах, хиймэл оюуныг төрийн үйлчилгээнд нэвтрүүлэх, ёс зүй, аюулгүй байдлын зохицуулалт бий болгох шаардлага тулгарч байна. Үүнээс гадна хүний нөөцийн дутагдал, өгөгдлийн хүртээмжийн асуудал, бодлогын уялдаа холбоо сул зэрэг тулгамдсан асуудлуудыг илрүүлж, цогц шийдэл шаардлагатай байна..

Монгол Улс олон улсын судалгааны байгууллагуудаар үнэлэгдэж, үндэсний стратегийн хэлэлцүүлж байгаа нь бодлогын шинэчлэлийн эхлэл болж байна. Бодит ахиц дэвшил гаргахын тулд төрөөс дараах таван чиглэлд цогц бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна: (1) эрх зүйн цогц орчныг бүрдүүлэх, (2) өгөгдлийн бодлогыг хөгжүүлэх, (3) мэдээллийн аюулгүй байдал ба технологийн дэд бүтцийг сайжруулах, (4) хүний нөөцийг урт хугацаанд бэлтгэх, (5) хөрөнгө оруулалт ба санхүүгийн урамшууллын тогтолцоог бүрдүүлэх.

Эцэст нь, Монгол Улс олон улсын шилдэг туршлага, үндэсний онцлогт нийцсэн бодлогын шийдлүүдийг нэгтгэн, бүтээмжтэй, ёс зүйтэй, хариуцлагатай, хүртээмжтэй хиймэл оюуны хөгжлийн тогтолцоо бүрдүүлэх замаар технологийн эринд өөрийн байр суурыа бататгах бүрэн боломжтой байна.

Ашигласан ном, зохиолын жагсаалт:

1. Ozmen Garibay, O., Winslow, B., Andolina, S., Antona, M., Bodenschatz, A., Coursaris, C., … Xu, W. (2023). Six Human-Centered Artificial Intelligence Grand Challenges. *International Journal of Human–Computer Interaction*, *39*(3), 391–437. https://doi.org/10.1080/10447318.2022.2153320
2. Macaulay, T. (n.d.). *Europe has more AI talent than US, study finds: The continent's tech sector has also taken a lead in entrepreneurship*. Atomico.
3. Smuha, N. A. (2021). From a ‘race to AI’ to a ‘race to AI regulation’: Regulatory competition for artificial intelligence. *Law, Innovation and Technology, 13*(1), 57–84. https://doi.org/10.1080/17579961.2021.1898300
4. Stanford Institute for Human-Centered Artificial Intelligence. (2025). *The AI Index Report 2025*. https://hai.stanford.edu/ai-index/2025-ai-index-report
5. Oxford Insights. (2024). *Government AI Readiness Index*. https://www.oxfordinsights.com/government-ai-readiness-index

6. President of Russia. (2024, February 19). *Обновление стратегии развития искусственного интеллекта*. ComNews. https://www.comnews.ru/content/231631/2024-02-19/2024-w08/1008/prezident-rf-obnovil-strategiyu-razvitiya-iskusstvennogo-intellekta
7. Тонких, Е. (2024). *Опыт Китая в регулировании ИИ: между Сциллой и Харибдой*. Российский Совет по Международным Делам. https://russiancouncil.ru/analytics-and-comments/analytics/opyt-kitaya-v-regulirovanii-ii-mezhdu-stsilloy-i-kharibdoy/?sphrase_id=202429820
8. e-CIS. (2024). *В СНГ в 2025 году завершат разработку модельного закона о технологиях искусственного интеллекта*. https://e-cis.info/news/566/121052/
9. The White House. (2025, January). *Removing barriers to American leadership in artificial intelligence*. https://www.whitehouse.gov/presidential-actions/2025/01/removing-barriers-to-american-leadership-in-artificial-intelligence/
10. U.S. Congress. (2024). *Artificial Intelligence: Overview and Issues for Congress (CRS Report R47843)*. https://www.congress.gov/crs-product/R47843
11. AI Lab Watch. (n.d.). *AI Safety Policies and Commitments*. https://ailabwatch.org/resources/commitments/#ai-safety-policies
12. California Privacy Protection Agency (CPPA). (n.d.). *Regulations*. https://cppa.ca.gov/regulations/
13. American Civil Liberties Union of Illinois (ACLU-IL). (n.d.). *Biometric Information Privacy Act (BIPA)*. https://www.aclu-il.org/en/campaigns/biometric-information-privacy-act-bipa
14. Colorado General Assembly. (2024). *SB24-205: Consumer Protections for Artificial Intelligence*. https://leg.colorado.gov/bills/sb24-205
15. Korea Law Information Center. (2024). *Artificial Intelligence Act [AI 법률]*. https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=268543&efYd=20260122#0000
16. Law Times Korea. (2024). *AI 관련 법률 정비 논의 본격화*. https://www.lawtimes.co.kr/LawFirm-NewsLetter/204461
17. Singapore Economic Development Board. (n.d.). *Singapore's National AI Strategy – AI for the Public Good for Singapore and the World*. https://www.edb.gov.sg/en/business-insights/market-and-industry-reports/singapores-national-ai-strategy-ai-for-the-public-good-for-singapore-and-the-world.html
18. Smart Nation Singapore. (n.d.). *Singapore's National AI Strategy (NAIS)*. https://www.smartnation.gov.sg/nais/
19. Georgetown University CSET. (2023). *Examining Singapore's AI Progress*. https://cset.georgetown.edu/wp-content/uploads/CSET-Examining-Singapores-AI-Progress.pdf
20. Цахим хөгжил, харилцаа холбоо, инновацын яам. (2025, 3-р сарын 31). *1000 хиймэл оюуны элч бэлтгэх хөтөлбөрийг эхлүүллээ*. https://mddic.gov.mn/mn/2025/03/21078/

SPSIRPA FORUM 2025

Session 3-9

Some Ways to Improve Forest Sustainable Management Policies and Regulations: A Case Study of Alxa League, Inner Mongolia Autonomous Region

Ойн тогтвортой менежментийн бодлого, зохицуулалтыг сайжруулах зарим арга зам: ӨМӨЗО-ны Алшаа аймгийн жишээн дээр

Daiqing

Хураангуй

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, биологийн олон янз байдлын алдагдал нь ойн экосистемийн тогтвортой байдлыг алдагдуулж, улмаар эдийн засаг, нийгмийн хөгжилд сөргөөр нөлөөлөх болсон. Иймээс ойн нөөцийг хамгаалах, зөв зохистой ашиглах, нөхөн сэргээхэд чиглэсэн тогтвортой менежментийн бодлого зайлшгүй хэрэгтэй. Монгол Улс болон БНХАУ-ын хил залгаа бүс нутаг болох Өвөр Монголын Алшаа аймаг нь цөлжилтөд хамгийн их өртсөн бүс нутгийн нэг бөгөөд ойн нөөцийн хамгаалалт, нөхөн сэргээлт, эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх шаардлагатай байна....

Түлхүүр үг: Уур амьсгал, цөлжилт, экосистем, зохицуулалт, менежмент

Оршил

Сүүлийн жилүүдэд дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн хурдац, биологийн олон янз байдлын алдагдал зэрэг байгаль орчны асуудлууд улам бүр хурцдаж, байгалийн нөөцийн тогтвортой ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн асуудал олон улсын болон бүс нутгийн хэмжээнд онцгой анхаарал татах болсон. Ялангуяа ойн экосистем нь эдгээр өөрчлөлтөд хамгийн эмзэг хариу үзүүлдэг, экологийн хувьд чухал үүрэгтэй бөгөөд нүүрстөрөгчийн шингээлт, уур амьсгалын зохицуулалт, ус ба хөрсний хамгаалалт, биологийн олон янз байдлын хадгалалт зэрэг олон чиг үүргийг гүйцэтгэдэг.

Ойн тогтвортой менежмент нь байгалийн экосистемийн хэвийн ажиллагааг хангахын зэрэгцээ нийгэм, эдийн засгийн хэрэгцээг зохистой тэнцвэртэй хангах зорилготой цогц хандлага бөгөөд олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн менежментийн гол чиглэлүүдийн нэг болж байна. Энэхүү хандлага нь зөвхөн ойн экологи, биологи талаас бус, хууль эрх зүй, нийгмийн оролцоо, эдийн засгийн зохицуулалт зэрэг олон талт хүчин зүйлсийг хамарч, үр ашигтай хэрэгжих боломжийг бүрдүүлдэг.

Өвөр Монголын Өөртөө Засах Орны Алшаа аймаг нь цөлжилтийн эрсдэл хамгийн өндөртэй бүс нутагт тооцогддог бөгөөд уур амьсгалын эрс тэс байдал, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс шалтгаалан ойн нөөц эрчимтэй буурах, биологийн олон янз байдал алдагдах хандлагатай болжээ. Ийм нөхцөлд тус аймагт хэрэгжүүлж буй ойн менежментийн бодлого, эрх зүйн зохицуулалт, нөхөн сэргээлтийн бодит байдалд үнэлгээ өгөх, үр ашигтай арга замуудыг тодорхойлох нь чухал ач холбогдолтой юм.

Иймээс энэхүү өгүүлэл нь ойн тогтвортой менежментийн онолын үндэс, олон улсын туршлага, Алшаа аймаг дахь бодлого, хэрэгжилт, сорилт, сайжруулах боломжуудыг судлан шинжилж, ойн менежментийн илүү үр дүнтэй загварыг боловсруулахад хувь нэмэр оруулах зорилготой болно.

1. Онолын үндэс

Ойн тогтвортой менежмент нь үндсэндээ антропоцентризмын өрсөлдөх чадвартай эдийн засаг, ойн бүс нутгийг удирдахад ойн экологи, нийгмийн үнэ цэнийг харгалзан үздэг. Ойн

тогтвортой менежментийн үзэл баримтлал нь ой нь олон төрлийн үйлчилгээ үзүүлдэг гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Хүмүүс ойн олон төрлийн үйлчилгээг мэддэг учраас түүний бүх үнэт зүйлс хэрэгжиж, тогтвортой хөгжихийн тулд ойг удирдах шаардлагатай байдаг. Үүнээс харахад ойн тогтвортой менежментийн талаарх нэгдсэн тодорхойлолт одоогоор гараагүй байгаа бөгөөд энэ нь "тогтвортой хөгжил" гэх мэт олон улсын ярианы хоорондын зөрүү билээ. Ойн тогтвортой менежментэд тавигдах шаардлагууд нь нэгдмэл биш, хэрэгжүүлэх механизмгүй байдаг бөгөөд хүмүүс ойн тогтвортой менежментийн ойлголтыг зарим талаар хийсвэр гэж үздэг. Хэдийгээр энэ үзэл баримтлал нь хангалттай тодорхой нарийн биш ч ядаж л дэлхийн ойн менежментийн ерөнхий зорилго нь ойн тогтвортой менежментийг бий болгоход чиглэх ёстой гэсэн зарчмын тохиролцоо, тодорхой санал нэгдсэн байгааг харж болох юм. (Rawat, 2008)

Ойн тогтвортой менежмент нь глобалчлагдсан засаглалын ерөнхий зорилго болсон билээ. Энэхүү үзэл баримтлал нь байнга хувьсан өөрчлөгдөж байдаг бөгөөд ой модтой холбоотой бүх үнэт зүйлсийг багтааж, хүлээн зөвшөөрдөг бөгөөд эдгээр ялгаатай болон зөрчилтэй үнэт зүйлсийг тэнцвэржүүлэхийг оролддог. Ойн бүс нутгийн нийтлэг үнэт зүйлд экологи, байгаль орчны үнэт зүйлс, нийгэм, соёлын үнэт зүйлс, худалдаа, хөгжлийн үнэт зүйлс ордог. Эдгээр бүх үнэт зүйлсийг хууль эрх зүйн хүрээнд хүлээн зөвшөөрч, тусгах нь дэлхийн бодлого боловсруулагчид төдийгүй дотоодын хууль эрх зүй, бодлогын түвшинд хэцүү байх хандлагатай юм. Ойн менежменттэй холбоотой янз бүрийн үнэт зүйлсийг хуулийн тогтолцоонд хэрхэн тусгаж, нэгтгэх нь ойн тогтвортой менежментийн эрх зүйн зохицуулалтад тулгарч буй бэрхшээл юм. (Cerutti, 2008)

Ойн талбайн менежмент, ашиглалтын хурд нь тэдний биологийн төрөл зүйл, бүтээмж, нөхөн сэргэх чадвар, амьдрах чадвараа хадгалах, экологи, эдийн засаг, нийгмийн чадавхийг хангадаг бөгөөд одоо болон ирээдүйд орон нутаг, үндэсний болон дэлхийн хэмжээнд бусад экосистемд хохирол учруулж болзошгүй. (SAYER, 1997)

Байгаль орчны хуулиар байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, бохирдлыг хязгаарлах зэрэг үндсэн чиглэлүүдийг тодорхойлдог. Харин төлөвлөлт, хөгжлийн тухай хуулиар ойн бүсийн байршил, хамгаалалтын зэрэглэл, хот суурин газрын тэлэлтийг зохицуулж, ойн газар ашиглалтад байгаль орчны нөлөөллийн үнэлгээ (БОНБҮ) хийлгэх шаардлага тавьдаг. Өмчийн тухай хууль нь ойн талбайг эзэмших, ашиглах, хамгаалах эрхийг тодорхойлдог бол үндсэн хууль иргэдийн цэвэр, эрүүл орчинд амьдрах эрхийг баталгаажуулан, төрийн үүргийг тодорхойлдог. (Sayer, 1997)

Ойн тогтвортой менежментэд эдгээр хууль эрх зүйн үндэслэлээс гадна экологи, эдийн засаг, нийгмийн хүчин зүйлс харилцан уялдаатайгаар нөлөөлдөг. Экологийн түвшинд биологийн олон янз байдал, экосистемийн тогтвортой байдал, модны насны бүтэц, ойн нөхөн сэргээлтийн чадавх зэрэг үзүүлэлтүүд чухал. Эрүүл, насны хувьд тэнцвэртэй ой нь нүүрстөрөгчийг илүү үр дүнтэй шингээж, усыг хадгалах, хөрсийг элэгдлээс хамгаалах зэргээр экосистемийн үйлчилгээг хангаж чаддаг. (Routledge, 2014)

Эдийн засгийн хувьд ой нь мод, түлш, эмийн ургамал, аялал жуулчлалын зэрэг олон чиглэлээр шууд болон шууд бусаар орлого бий болгодог. Ойн менежмент нь зөвхөн орлого төвтэй байж болохгүй бөгөөд хөрөнгө оруулалт, нөхөн сэргээлтийн зардал, татварын урамшуулал, санхүүгийн дэмжлэг зэрэг бодлогын арга хэмжээнүүдийг тэнцвэртэй авч үзэх шаардлагатай.

Харин нийгэм-соёлын хувьд нутгийн иргэдийн уламжлалт мэдлэг, хэрэглээ, ойн соёлын үнэ цэнийг хүндэтгэж, оролцоог дэмжсэн бодлого нь ойн менежментийг илүү тогтвортой, ард нийтийн дэмжлэгтэй болгодог.

Олон улсын туршлагыг авч үзвэл ОХУ-ын Сибирьт экосистемийн хамгаалал, эко аялал жуулчлал хөгжүүлэх, ойн түймрээс сэргийлэх чиглэлд бодлогын түвшинд хүчтэй арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. АНУ-ын Орегон мужид 1972 онд баталсан ойн хууль нь нөхөн тарилт, химийн бодисын хэрэглээ, хувийн болон төрийн эзэмшлийн тэнцвэрийг хангах замаар ойн тогтвортой менежментийн цогц загварыг хэрэгжүүлж байгаа нь онцлог юм.

Эцэст нь, ойн тогтвортой менежмент нь зөвхөн байгаль хамгаллын асуудал бус, хүний амьдрал, эдийн засаг, соёл иргэншилтэй салшгүй холбоотой цогц үйл явц юм. Уг үзэл баримтлалыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд олон талын бодлого, менежмент, хууль эрх зүйн уялдааг хослуулах шаардлагатай байна. (Mayijune, 2000)

Алшаа аймгийн ойн менежментийн өнөөгийн байдал, эрх зүйн орчин

ӨМӨЗО-ны Алшаа аймаг нь БНХАУ-ын баруун хойд хэсэгт оршдог, цөлжилт хамгийн хурдацтай явагдаж буй бүс нутаг бөгөөд 73.67%-ийн цөлжилтийн түвшинтэй. Цаг уурын өөрчлөлт, хэт маллагаа, усны хомсдол зэрэг хүчин зүйлс нь тус аймгийн ойн экосистемд шууд сөрөг нөлөө үзүүлж, ойн хучаасын талбайг бууруулах, биологийн олон янз байдлыг доройтуулах үндсэн шалтгаан болж байна. Энэхүү байгаль орчны ноцтой асуудалтай тэмцэхийн тулд БНХАУ-ын Засгийн газар, тэр дундаа аймгийн нутгийн захиргаа тогтвортой ойн менежментийн бодлогыг стратегийн төвшинд хэрэгжүүлж байна.

График 1.

Алшаа аймгийн цөлжилттэй газар нутгийн хэмжээ

Эх сурвалж. Чуанян, 2015.

2000 оноос хойш “Цөлжилтийн эсрэг тэмцэх үндэсний хөтөлбөр”, “Экологийн бүсийг нөхөн сэргээх стратеги”, “Ойн бүс нутгийн хамгаалалтын бүсийн зохион байгуулалт” зэрэг томоохон арга хэмжээнүүдийг Алшаа аймагт хэрэгжүүлж ирсэн. Тухайлбал, “Хойд гурван хамгаалалтын бүс”-ийн төсөл нь тус аймагт заг, сухай зэрэг ганд тэсвэртэй модны тариалалтыг нэмэгдүүлэх, ойн санг өргөтгөхөд чиглэсэн. Энэхүү төсөл хэрэгжиж эхэлснээр 1.29 сая га газрыг ойжуулж, 20 сая гаруй мод тарьсан бөгөөд ойжуулалтын нийт хувь хэмжээг 7.65%-д хүргэж чадсан нь улс болон бүс нутгийн хэмжээнд өндөр амжилтад тооцогдож байна.

Судалгаанд тусгагдсанаар, Алшаа аймгийн нийт ойн талбай 2.159 сая га бөгөөд голчлон элсэн манхантай, хээрийн бүсэд байрладаг. Эдгээр ойд зонхилон ургадаг моддын төрөл зүйлд заг, торой, сухай зэрэг хуурай, ганд тэсвэртэй ургамал багтдаг. Тус ургамлууд нь хөрс тогтоон барих, салхи шуургыг багасгах, нүүрстөрөгч шингээх зэрэг экосистемийн үйлчилгээг хангаж, байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах чухал үүрэгтэй. Мөн Алшаа аймаг нь эмийн ургамлын төрөл зүйлээр баялаг бөгөөд тэдгээрийг нөхөн сэргээх, хамгаалах бодлого тусгайлсан журмаар хэрэгжиж байна.

Алшаа аймагт хэрэгжиж буй менежментийн стратеги нь БНХАУ-ын “14-р таван жилийн үндэсний төлөвлөгөө”-нд суурилсан бөгөөд байгаль хамгааллын чиглэлээр тодорхой заавал биелүүлэх зургаан үзүүлэлттэй. (Лиан, 2020)Үүнд:

Ойн бүрхэвчийн хэмжээ 10%-иар нэмэгдүүлэх

Нөхөн сэргээлтийн ногоон байгууламжийн индексийг 15%-д хүргэх

Хортон шавжийн тархалтыг 20%-иар бууруулах

Усны хэрэглээг 10%-иар бууруулах

Хөрсний элэгдлийг 25%-иар багасгах

Орон нутгийн иргэдийн экологийн боловсролыг нэмэгдүүлэх зэрэг орно

Эдгээр үзүүлэлтийг хэрэгжүүлэхэд холбогдох байгууллагууд уялдаа холбоотой ажиллаж байгаа бөгөөд нийт 9 байгууллага ойн салбарын удирдлага, хяналт, гүйцэтгэлд оролцож байна.

Алшаа аймгийн ой, бэлчээрийн салбарыг удирдах байгууллагуудын бүтцэд “Ой, бэлчээрийн товчоо”, “Ой, бэлчээр ба суулгацын станц”, “Хортон шавжтай тэмцэх, сэргийлэх станц”, “Цөлжилтийн менежментийн байгууллага”, “Экологийн аж үйлдвэрийн хөгжлийн төв” зэрэг байгууллагууд багтдаг. Эдгээр байгууллагуудын нийт ажиллагсад 100 гаруй бөгөөд ихэнх нь захирал, дэд дарга, салбарын дарга зэрэг мэргэжлийн боловсон хүчнээр бүрддэг. Энэ нь менежментийн төвлөрсөн, шат дараалсан бүтэцтэй гэдгийг харуулж байгаа бөгөөд тус бүтэц нь орон нутгийн онцлогт тулгуурлан хэрэгжихүйц уян хатан механизмаар зохицуулагддаг.

Хууль эрх зүйн хувьд Алшаа аймаг нь БНХАУ-ын “Ойн тухай хууль”, “Цөлжилтөөс сэргийлэх хууль”, “Бэлчээрийн тухай хууль”-д үндэслэн ойн менежментийн бодлогоо хэрэгжүүлдэг. “Ойн тухай хууль”-д ойн ангилал, эзэмшлийн хэлбэр, нөхөн сэргээлтийн үүрэг, ойн сэргээлтийн хөрөнгө оруулалтын хариуцлагыг тодорхойлсон бол “Цөлжилтөөс сэргийлэх хууль”-д экологийн хариуцлагын тогтолцоо, экосистемийн доройтлын үнэлгээний журам, газар ашиглалтын хязгаарлалт, хамгаалалтын бүсийн эрх зүйн үндэс зэрэг тусгасан. “Бэлчээрийн тухай хууль”-д цөлжилтөөс урьдчилан сэргийлэх зорилгоор бэлчээр ашиглалтын нягтрал, тэнцвэрийг хангах тогтолцоог бүрдүүлж өгсөн. (Чуанян, 2015)

Гэсэн хэдий ч тус бүс нутагт тулгарч буй сорилтууд хэвээр байсаар байна. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй хуурайшилт, усны нөөцийн хомсдол, биологийн олон янз байдлын алдагдал зэрэг асуудал нь ойн менежментэд шинэ сорилт учруулж байгаа юм. Үүнээс гадна зарим тохиолдолд суулгацын чанар хангалтгүй, нөхөн сэргээлтийн ажилд иргэдийн оролцоо сул, хяналт үнэлгээний тогтолцоо бүрэн боловсронгуй биш зэрэг бодит хүндрэлүүд оршсоор байна.

Иймд Алшаа аймгийн ойн тогтвортой менежментийг үр дүнтэй болгоход олон улсын сайн туршлага нутагшуулах, орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, суулгацын чанар,

усалгааны тогтолцоог сайжруулах, эрх зүйн хэрэгжилтийн мониторингийг чанаржуулах зэрэг алхам зайлшгүй шаардлагатай юм. Мөн технологид суурилсан аргачлал нэвтрүүлэх, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт бий болгох зэрэг орчин үеийн чиг хандлагыг тусган хэрэгжүүлэх боломжтой байна.

3. Алшаа аймгийн ойн тогвортой менежментэд тулгамдаж буй асуудлууд

Тулгамдаж буй гол асуудал нь

Экологийн орчин эмзэг хэвээр байгаа бөгөөд зарим бүс нутагт цөлжилт эрчимжиж байна

Алшаа аймаг нь 270,000 хавтгай дөрвөлжин км газар нутаг, элсэн цөл, говь, цөлөрхөг хээр тус бүр нь хүчтэй салхи, элс, ган, бороо багатай, сийрэг ургамалтай, баруун хойд муссон гарцын завсарт байрладаг. 1/3, цөлийн талбай нь тус улсын 1/3, нийт нутаг дэвсгэрийн 13.5%, 63.1% -ийг эзэлдэг. Цөлжсөн газар нутгийн нийт нутаг дэвсгэрийн 11%, нийт бүс нутгийн 49.45% -ийг эзэлдэг бөгөөд жилийн дундаж хур тунадас 20 мм-ээс багагүй, жилийн дундаж ууршилт нь 4200 мм хүртэл байдаг. Мөн “Улаан Бух”-ын цөлүүд нь бүхэл бүтэн газар нутгийг хамардаг бөгөөд баруун хойд улирлын салхины нөлөөгөөр байнга өргөжиж байдаг элсэн манхан гурван цөлд давамгайлдаг. Жилд Тэнгэр цөл болон Улаан-Бөхийн цөл ойртож, 12 том түргэн элсний бүс үүсч, 14 сая гаруй акр газар хүрч байна. Алшаа аймаг нь экологийн хамгийн эмзэг орчинтой, хамгийн ноцтой цөлжилттэй, байгалийн хамгийн хүнд нөхцөлтэй, менежмент нь хамгийн хэцүү бүсүүдийн нэг юм. (Алшаа аймгийн бэлчээр, 2020)

Ойн тогтвортой менежментийн тулгамдаж буй асуудал нь Алшаа аймагт модны хэт их ашиглалт, хууль бус огтлолцол зэргээс шалтгаалж ойн сан устаж байна. Энэ нь ойн экосистемд сөрөг нөлөө үзүүлж, биологийн олон янз байдлыг алдагдуулж байгаа юм. Түүнчлэн хуурайшилт, улмаар гал түймрийн эрсдэл нэмэгдэж буй нь ноцтой байдалд хүргэж байна. Эдгээр гал түймрүүд нь олон удаа ойн их хэмжээний газруудыг сүйтгэн, амьд биетүүдийн оршин тогтнох нөхцөлд хүндрэл учруулдаг. Ихэнхдээ, дулааны нэмэгдэл ба усны хомсдол нь ойн ургамлын төрөл зүйлийн амьдрах боломжийг хязгаарлаж,. ойн нөөцийг хэт ашигласан, ойн сангийн нөхөн сэргээлтийн дутагдлын улмаас биологийн олон янз байдлын алдагдал маш их байна. Энэ нь ургамлын ба амьтдын популяциудад сөрөг нөлөөлж, экосистемийн тогтвортой байдлыг алдагдуулж байна. Ойн салбар нь орон нутгийн иргэдийн амьжиргаанд томоохон үүрэг гүйцэтгэдэг. Гэхдээ ойн сангийн бууралт нь ажлын байр, орлого буурах зэрэг эдийн засгийн сорилтуудыг үүсгэдэг учраас ойн тогтвортой менежтийн томоохон асуудал билээ. Ойн удирдлагын технологи, мэдлэгийн дутагдал нь ойн салбарын үр дүнгүй байдлыг улам бүр нэмэгдүүлсээр л байна. Мэдээллийн систем ба дата боловсруулалтын дутагдлыг арилгах шаардлагатай байна. Эдгээр тулгамдсан асуудлуудыг зохицуулахад анхаарч, ойн тогтвортой менежментийн стратегиудыг хэрэгжүүлэх нь чухал юм.

Бодлого-Төрийн бодлогоос үүдэж бэлчээрийн даац хэтэрсэн асуудалтай тулгарч байна.

Тус улс 2011 оноос хойш ӨМӨЗО-ны 13 муж оронд төрийн бодлогыг хэрэгжүүлж эхэлжээ. "14-р таван жил"-ийн хугацаанд бэлчээрийн урамшуулал, тэтгэмжийн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, бэлчээрийн экологийн хамгаалалтыг ахиулах ажлыг зохицуулж, бэлчээрийн малын тэнцвэрт байдал, бэлчээрийг хориглох тогтолцоог хэрэгжүүлж, бэлчээрийн малын өөрчлөлт, тогтвортой хөгжлийг ахиулах болно. Алшаа аймаг бэлчээрийн экологийг хамгаалах

татаасын гурав дахь шатны урамшууллын төрийн бодлогыг хэрэгжүүлж, 3-р ээлжийн бэлчээрийн экологийн татаас, урамшууллын бодлогын төлөвлөгөөг 2025 онд хэрэгжүүлж дуусгахад бэлчээр дахин малжиж болох асуудал тулгарна. Одоогийн байдлаар манай аймгийн бэлчээрийн даац хэтрэх үзэгдэл 2021 онд өөр өөр бүс нутагт байгалийн бэлчээрийн эрчмийг мэдээлсэнээр Алшаа аймгийн бэлчээрийн талбайн хэмжээ 3.02 сая акр болжээ. Байгалийн экологийн орон зайн хяналттай газар нутаг нь том бөгөөд хөгжлийг хязгаарласан.

Одоогийн байдлаар Алшаа аймаг нь байгалийн нөхцөл байдал, газар нутгийн төлөвлөлтийн хязгаарлалтаас болж ойжуулалт, зүлэг тарихад тохиромжтой газар олоход улам бүр хэцүү болж, ойжуулалтын тохиромжтой талбай бараг байхгүй байна. 2022 онд ӨМӨЗО-ны Байгалийн нөөцийн газар, Ойн аж ахуй, бэлчээрийн товчооны мэдээлснээр, "ӨМӨЗО-ны төлөвлөгөөт ойжуулалт, ногоон байгууламжийн газрын орон зай төлөвлөлтийн судалгаа, үнэлгээ, хадгалалтын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан. ӨМӨЗО-ны газар нутаг, орон зайн төлөвлөлтөд ойжуулалт, ногоон байгууламжийг төлөвлөсөн. 2019 онд ойн сан бүхий газрын "Нэг зураг"-ийн үр дүнд тулгуурлан таван төрлийн судалгаа, үнэлгээний газрын зургийн нөхөөсийг нэмсэн "бутлаг газар", бусад ойн сан, ойжуулалт, ногоон байгууламжид тохиромжтой бусад газар", удирдлага нь тухайн нутаг дэвсгэрт тохирсон ойжуулалт, ногоон байгууламжийн газрын зургийн талбайг сайжруулсан байна. Ойжуулалтын талбайн эцсийн үнэлгээний үр дүнд ойжуулалт, ногоон байгууламжийн талбайн нийт талбайн хэмжээ 4.53 сая акр байна. Ойжуулалтын талбай, нийт 4,45 сая акр талбайтай (үүнд 2021-2025 он хүртэл 2,83 сая акр ойжуулалтын төслийн талбай, 1,62 сая акр ойжуулалтын талбайн талбай гол төлөв Алшааны зүүн хошуу Тэнгэр элсэн цөлд), газрын энэ хэсэг нь элсэрхэг бүсэд усны нөөцийн менежментийн хязгаарлалттай тул шинээр худаг өрөмдөх замаар ойжуулалт, усалгааг их хэмжээгээр хийх боломж хомс, шинжлэх ухааны үндэслэлтэй ойжуулалт, ногоон байгууламжийн шаардлага хангахгүй байна.

<u>Хэрэгжилт</u>-Засаглалын квотын стандарт бага, төслийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна. Сүүлийн жилүүдэд түүхий эд, тээвэрлэлт, барилгын зардал нэмэгдэж, талбайн нөхцөл байдал улам хүндэрч байгаа зэргээс шалтгаалж элс бэхэлгээний төслийн нэг мкв тутамд хөрөнгө оруулалтын зардал жил ирэх тусам нэмэгдэж байна. Төслийн одоогийн элс бэхэлгээний зардал нь ойролцоогоор 1 сая тооцож байгаа бөгөөд хэрэв био нөхөн сэргээх арга хэмжээг нэгтгэвэл зардал нь сая 200 мянган болж өснө. Одоогийн байдлаар үндэсний ойн аж ахуйн гол төслүүдийн элс бэхэлгээний хөрөнгө оруулалт 300,000 төгрөг, хиймэл ойжуулалт 260,000 хиймэл зүлэг тарихад биологийн арга хэмжээ нийлсэн элс тогтоох зардал нь бодит хэрэгцээг хангахаас хол байна . Айл болгонд газар гэрээ байгуулсан, газар түрээслэх, нөхөн олговор олгох асуудал гардаг. Одоогийн байдлаар ойжуулалтын талбайн дийлэнх хэсэг нь нэгдлийн газар бөгөөд бэлчээрийн гэрээгээр тариаланч, малчдын эзэмшиж байгаа газар мөн элсэрхэг газар, нүцгэн газар, халцгай чулуурхаг хайрга гэх мэтээр хязгаарлагддаг. Тухайн талбайн нөхцөл байдлын шинжилгээнээс харахад энэ төрлийн газар нь усны нөөцөөр хязгаарлагдмал, ойжуулалт, ногоон байгууламжийн үйл ажиллагаа явуулах боломж үндсэндээ байхгүй. Түүнчлэн 30.3647 сая акр ойн сан бүхий газар байгаа гэдгийг гурав дахь газрын судалгааны үндсэн мэдээллийн эмхэтгэлд тусгалаа. Улсын нийтийн халамжийн ой, үүнээс: 2.87 сая акр нь төрийн өмчид, 20.03 сая акр талбай бөгөөд үүний 77% нь эвдэрсэн гол талбайг засварласан тохиолдолд ойн сан бүхий газар юм. Шинэчлэгдсэнээр газар ашиглах эрхээ авч чадахгүй,

түрээсийн нөхөн төлбөрийг тариаланч, малчдад цаг тухайд нь өгөхгүй, маргаан үүсгэхэд амархан.

Нөлөөлөх хүчин зүйлсийн тулгамдсан зарим асуудлуудыг дурдвал:

Ойн нөөц ашиглалтын зөрчил: Алшаа аймгийн ойн нөөц нь уул уурхайн үйл ажиллагаа, хөдөө аж ахуйн талбайн өргөтгөл, мөн зам барилгын төслүүдээс болж хүндрэлтэй байдаг. Эдгээр үйл ажиллагаа нь ойн санг алдагдуулж, био-олон янз байдлыг сүйрүүлдэг.

Түймэр ба мал аж ахуйн нөлөө: Түймэр нь ойн сүйрлийг хурдасгаж, мал аж ахуй нь ойн газар дээрхи малаа бэлчээрлэх замаар тэдгээрийн сэргэлтийг удаашруулж байна. Энэ нь байгаль орчны бүрэн бүтэн байдлыг хангалтгүй хамгаалж чадахгүй байгаа асуудлыг үүсгэдэг.

Уул уурхайн нөлөөлөл: Уул уурхайн үйл ажиллагаа нь хөрс, усны чанарыг муудуулах, эко-системд нөлөөлөх, мөн амьд орчны өөрчлөлтүүдийг дагуулж ирдэг. Өндөр ач холбогдолтой ойн хэсгүүдэд хийгдэх уул уурхайн ажил нь түүхий эдийн нөөцөд хязгаар тавих шаардлагатай болдог.

Жуулчдын нөлөөлөл: Алшаа аймгийн газрын үзэсгэлэнт байгалийн үзэмжийг жуулчид ихээр татдаг боловч, энэ нь ойн сангуудын дээр ачаалал үүсгэж, хог хаягдлын асуудал үүсгэдэг. Жуулчлалыг зохистой зохион байгуулах нь чухал бөгөөд энэ нь байгальд ээлтэй жуулчлалыг дэмжих зорилгоор байх ёстой. Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд ойн менежментийн бодлого боловсруулахдаа дээрх зүйлсийг тусгах, байгаль орчныг хамгаалж, ашиглалтыг зохицуулах зорилгоор тогтвортой хөгжлийн стратеги хэрэгжүүлэх хэрэгтэй.

4. Алшаа аймгийн ойн тогтвортой менежментийг сайжруулах арга замууд

Ойн тогтвортой менежментийн бодлого, зохицуулалтыг сайжруулах нь бүх нийтийн асуудал бөгөөд урьдчилан хамгаалах, экологийн нөхөн сэргээлт болон байгаль хамгаалах ойн менежментийн ашиг тусад холбогдож, үндэсний болон орон нутгийн засаг захиргаа, нийгмийн аж ахуйн нэгж, бэлчээрийн тариаланчид, малчид, олон нийтийн хамтын хүчин чармайлтыг шаарддаг цогц систем юм. Тиймээс засгийн газар тэргүүлэх үүргээ бүрэн дүүрэн биелүүлж, үр дүнтэй уялдуулах ажлыг сайн хийх ёстой. Үүн дээр Алшаа аймгийн ойн менежментийн хэд хэдэн чухал хэсгүүдийг анхаарах хэрэгтэй. Энэ нь ойн байгаль орчныг хамгаалах, ойн бүтээмжийг нэмэгдүүлэх, болон аймгийн экономи, нийгмийн хөгжилд ойн салбарын нөлөөг сайжруулах зорилгоор бэлтгэгдсэн бодлого, арга хэмжээг хамруулах гэх мэт зөвлөмжийг бидний судалгаанд энэхүү саналыг тусгаж байна. Засгийн газар тэргүүлэх үүргээ бүрэн биелүүлж, үр дүнтэй уялдуулах ажлыг сайн хийх ёстой ба үүрэг хариуцлагыг хуулийн тогтолцооны дагуу хатуу хэрэгжүүлэх хэрэгтэй. Энэ нь экологийн бүтээн байгуулалтыг хөгжүүлэхэд хуулийг ямагт нэгдүгээрт тавьж, цөлжилттэй тэмцэх бодлогыг бүрэн хэрэгжүүлэхийг батлах, хуулийн зааварчилгаагүй бол цөлжилтийн эсрэг бодлого нь ямар ч хэрэггүй билээ. Учир нь байгаль орчныг хамгаалах тогтолцоог хуулийн дагуу шинэчилж, зорилтот хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлэх шаардлагатай. Нийгмийн шинэ бүтцийн хүрээнд дотоодын ногоон менежментийн загвар ч өдөр өдрөөр шинэчлэгдсээр байна. Хэчнээн баялаг үр өгөөжтэй байсан ч экологийн хохиролтой байж болхуйц юм. Энэ нь төр засаг хандлагаа өөрчлөх, улс төрийн ололт амжилтаар хязгаарлагдахгүй, байгаль орчныг хамгаалах асуудлыг нэн тэргүүнд тавьж, экологид хэт их хор хөнөөл учруулж буй аж ахуйн нэгжүүдийг

өрөвдөхгүй байх ёстой гэсэн үг юм. Нөгөөтэйгүүр ойн нөөцийг зөв удирдахад ойн нөөцийг зөв түвшинд ашиглах, тэр дундаа тогтвортой хэмжээнд хүртэлх ашиглалтыг хангах мөн түүхий эд, биологийн олон янз байдлыг хамгаалах бодлого хэрэгжүүлж, тогтвортой ойн аж ахуй бий болгоход ойгоос олборлох бүтээгдэхүүнийг зохистой ашиглах, орон нутгийн иргэдийг ойн салбарт ажлын байр бий болгож ойн бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд шинэ мод тарих, эрүүл мэндийг дэмжих ажиллагааг зохион байгуулах хэрэгтэй билээ. Ойн менежмент болон байгаль орчныг хамгаалахад гал түймрийн эрсдэл бууруулах, ойн сангийн нөхөн сэргээлтийг тогтмол хийн ойн амьтдын орон зай, нөөцийг хамгаалахад анхаарах нь оновчтой ба ойн менежментийн мэдлэг, технологи шинэчлэлтийг хөрс, усны нөөцийг хамгаалах, бохирдлыг бууруулах шийдлүүдийг нэвтрүүлнэ. Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх нь ойн салбарт хийгдэж буй ажил, төлөвлөгөөнд иргэдийн оролцоог хангах, тэдний санал бодлыг сонсох нь чухал. Эко аялал, байгалийн боловсрол олгох хөтөлбөрүүдийг дэмжих, хөгжилтэй орнуудын туршлагыг судлах хэрэгтэй. Жишээлбэл Америкийн Нэгдсэн Улс, Оросын Холбооны Улс зэрэг хөгжилтэй орнуудын ойн менежментийн туршлагыг судлах нь Алшаа аймгийн ойн менежментийг сайжруулах боломжийг эрэлхийлсэн. Эдгээр улсуудад амжилттай хэрэгжсэн ойн менежментийн бодлого, зохицуулалтын арга хэмжээг авч хэрэглэх нь үр өгөөжтэй байх болно.

Экологийн тэнцвэрт байдлыг хадгалахын тулд ойн тогтвортой менежментийн бодлогыг сайжруулан түүний экологийн тэнцвэрт байдлыг хадгалах биологийн олон янз байдлыг хамгаалахад тусална. ӨМӨЗО-ны Алшаа аймгийн жишээнд эдийн засаг, нийгэм, байгаль орчныг уялдаа холбоотойгоор ашиглалтыг зохион байгуулах шаардлагатай. Ойн менежментийг бүрэн бүтэн, системтэй байдлаар зохион байгуулах нь нэн тэргүүнд юм. Энэ нь ойн нөөцөөр дамжуулан нийгэм, эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх боломжийг олгоно. Олон нийтэд ойлгомжтой мэдээллийг түгээхийн тулд ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхдээ хууль, эрх зүйн орчныг сайжруулахаас гадна олон нийтэд ойлгомжтой, тодорхой мэдээллийг түгээх нь чухал. Энэ нь ойн аж ахуйн хяналт, зохицуулалтыг илүү үр дүнтэй болгох юм.

Засгийн газрын бодлогод хэрхэн оролцох вэ гэвэл орон нутгийн засаг захиргааны бодлого, төлөвлөгөөнд ойн тогтвортой менежментийн үзэл баримтлалыг тусгах, мөн энэ салбарт мэргэжлийн хүмүүсийн оролцоог дэмжих эдгээр зөвлөмжүүдийг хэрэгжүүлснээр Алшаа аймгийн ойн тогтвортой менежментийг илүү үр дүнтэй, бодитой болгоход туслах болно. Америкийн Нэгдсэн Улс болон Оросын Холбооны Улсад хэрэгжүүлж буй ойн менежментийн бодлого, зохицуулалтын хувьд ӨМ-ын Алшаа аймагт тулгамдаж буй асуудлуудад хэрэгжүүлэх боломжтой санал зөвлөмжүүдийг дурдсан болно:

АНУ: Тогтвортой хөгжилд анхаарах, тухайлбал, нөөцийн удирдлагад хатуу стандартуудыг тогтоосон байдаг. Ойн санг бодлогын хүрээнд арчилж, өвөрмөц төрлийн амьтан, ургамлын хамгаалалтад анхаарч, биологийн олон янз байдлыг хадгалан ашиглалтад тэнцвэртэй хангахаас гадна нийтийн оролцоог уриалж, ойн менежментийн төлөвлөгөөнд иргэдийн санал бодлыг тусгадаг. Мөн хэрэгжилтийг шүүмжлэх, дэмжих механизмуудыг бий болгох. Нийтийн оролцоог уриалж, ойн менежментийн төлөвлөгөөнд иргэдийн санал бодлыг тлэрхийлж хэрэгжилтийг шүүмжлэх, дэмжих механизмуудыг бий болгох.

ОХУ: Тэд ойн нөөцийг ил уурхайн аж ахуй, мод боловсруулах үйлдвэрлэлээс тусгаарлан, тогтвортой ашиглалтыг хангахын тулд ойг сэргээн нөхөн сэргээх арга хэмжээг ихээхэн хэрэгжүүлдэг. Төрөлхийн бус байгууллагууд болон иргэдтэй хамтран ажиллах, ойн түймрийн

эрсдэлийг бууруулах, ойг сэргээн нөхөн сэргээх ажлуудад иргэний нийгэмийн оролцоог дэмжин биологийн олон янз байдлыг хамгаалах, ойн ашиглалт ба нөхөн сэргээлтийг зохицуулах адилхан технологийг нэвтрүүлдэг билээ.

Үүнээс авч үзэхэд АНУ болон ОХУ: улс нь дотоод болон олон улсын түвшинд ойн удирдлагыг харилцан өрсөлдөхүйц түвшинд авчирч, ойн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлдэг учраас засгийн газар үнэлгээний загварыг сайжруулахад бүх хүчээ зориулж, төв засгийн газраас өгсөн хүрээнд илүү шинжлэх ухааанч, найдвартай гүйцэтгэлийн төлөвлөгөөг судлах ёстой.

Дүгнэлт

Энэхүү судалгаа нь ӨМӨЗО-ны Алшаа аймгийн ойн тогтвортой менежментийн төрийн бодлого, ой бэлчээрийн оролцоог сайжруулах зорилготой бөгөөд онолын гүнзгийрүүлсэн хэлэлцүүлэг, ой бэлчээрийн судалгааны үр дүнд ойн менежментийн онолын үндэслэл, арга зүй, төрийн бодлогын үе шат, гадаадын туршлагад системтэй дүн шинжилгээ хийсэн. Үүний зэрэгцээ, ӨМӨЗО, Алша аймгийн ой, бэлчээрийн өнөөгийн байдлыг судалж, бэлчээрийн экологийн хамгаалалт, соёлын өв, тогтвортой менежментийн талаарх онцлог үйл ажиллагаа, асуудлыг судлав. Дараах нь судалгааны янз бүрийн талуудын иж бүрэн хураангуй юм. Нийгмийн тогтвортой хөгжлийн нэг хэсэг нь ойн тогтвортой менежмент юм.

Ойн тогтвортой менежментийн онолын талаар гүнзгийрүүлэн ярилцсанаар бид ойн тогтвортой менежментийн бодлого, зохицуулалт нь нийгмийн засаглалын нэг арга зам төдийгүй тогтвортой хөгжлийг дэмжих тулгуур багана гэдгийг ойлгож байна. ӨМӨЗО-ны Алшаа аймгийн ойн тогтвортой менежментэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлон сайжруулах санал, зөвлөмжийг дээшлүүлэхэд бидний судалгааны зорилго оршино.

Ойн тогтвортой менежментийн талаарх нэгдсэн тодорхойлолт одоогоор гараагүй байгаа бөгөөд энэ нь "тогтвортой хөгжил" гэх мэт олон улсын ярианы хоорондын зөрүү билээ. Ойн тогтвортой менежментэд тавигдах шаардлагууд нь нэгдмэл биш, хэрэгжүүлэх механизмгүй байдаг бөгөөд хүмүүс ойн тогтвортой менежментийн ойлголтыг зарим талаар хийсвэр гэж үздэг. Хэдийгээр энэ үзэл баримтлал нь хангалттай тодорхой нарийн биш ч ядаж л дэлхийн ойн менежментийн ерөнхий зорилго нь ойн тогтвортой менежментийг бий болгоход чиглэх ёстой гэсэн зарчмын тохиролцоо, тодорхой санал нэгдэх ёстойг судалгаа харуулж байна. Гадаадын жишээн дээр үндэслэн бид зарим улс орнууд ойн тогтвортой менежментээр ой түймрээс сэргийлэх, нөхөн сэргээх, ойн нөөц бий болгосныг олж мэдсэн. Эдгээр туршлага нь илүү нээлттэй оролцооны тогтолцоог бүрдүүлэхэд манай улсын хувьд жишиг чухал ач холбогдолтой юм.

Ойн тогтвортой менежментийн хэрэгжилт нь хууль тогтоомжийн олон талыг хамардаг бөгөөд энэ нь хууль тогтоомж, дүрэм журам, бодлого, стандарт, зэрэг олон төрлийн ойн менежмент, хяналт, зохицуулалтыг бүхэлд нь хэрэгжүүлэх боломжгүй хууль ёсны бус юм. Ойн тухай бүх хууль тогтоомжууд хоорондоо уялдаатай байх ёстой бөгөөд давхардал, тодорхой бус байдлаас зайлсхийх хэрэгтэй ба ойн менежмент, зохицуулалтад гүйцэтгэх үүргээ тодорхой болгож, олон нийтэд ойлгомжтой, дагаж мөрдөхөд хялбар хэлбэрээр өгөх ёстой. Алшаа аймгийн ойн тогтвортой менежментийн нь байгаль орчин, хүний нөөцийн удирдлага, экологийн нөхөн сэргээлтэд нөлөөлөх хүчин зүйл гэсэн гурван нөлөөлөх хүчин зүйлтэй. Ойн тогтвортой менежментийн байгаль орчинд нөлөөлөх хүчин зүйлүүд нь усны нөөц, биологийн олон янз байдал, уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагаа зэрэг орно. Хүний нөөцийн хэрэгцээ, чадварыг дээшлүүлэх арга, хүний нөөцийн удирдлагын арга бодлого, ердийн тохиолдлын шинжилгээ зэрэг нь хүний нөөцийн удирдлагын нөлөөлөх хүчин зүйлд багтдаг. Харин экологийн нөхөн сэргээлтэд нөлөөлөх хүчин зүйлс нь улсын бодлогын дэмжлэг, зах зээлийн механизм, технологийн дэвшил, нийгмийн танин мэдэхүй, үйл ажиллагаа, хүний нөөцийн менежмеэт, экологийн нөхөн сэргээлтийн загвар гэх мэт орно. Эдгээр хүчин зүйлүүд нь хоорондоо уялдаа холбоотой бөгөөд Алшаа аймгийн ойн экологийн эрүүл мэнд, тогтвортой хөгжилд хамтдаа нөлөөлдөг. Эдгээр хүчин зүйлүүд нь үндэсний бодлогын дэмжлэг, зах зээлийн механизм, шинжлэх ухаан, технологийн дэвшил, нийгмийн танин мэдэхүй, зан үйл

гэх мэт ойн тогтвортой менежментэд үзүүлэх нөлөөг нарийвчлан шинжлэн энэхүү судалгааг хийсэн.

Ойн тогтвортой менежментийн талаарх хүний үйл ажиллагаа, түүнчлэн түймрийн улмаас болох тохиолдол, ойн усны чанар ба хангамж, төрийн зохицуулалт хангалтгүй, олон нийтийн оролцооны үйл явцын ил тод байдал хангалтгүй зэрэг асуудлууд өргөн цар хүрээг хязгаарлаж, гүнзгийрүүлж байна. Дээрх асуудлуудыг шийдвэрлэхийн тулд бид шат дараалсан арга хэмжээ, саналуудыг дэвшүүлж байна. Нэгдүгээрт, ойн хамгаалалт, ашиглалтыг хяналт тавих, мөн хууль бус үйл ажиллагааг зогсоох зорилгоор хууль эрх зүйн орчныг бэхжүүлэх, хоёрдугаарт, ойн эрүүл мэндийг хангах, түүнчлэн ойн өвөрмөц бүтцийг бэхжүүлэх, био-олон янз байдлыг хадгалах, ойн өвөрмөц төрөл зүйлүүдийг хамгаалах зорилгоор байгальд ээлтэй арга хэмжээ авахыг зөвлөж байна, мөн тодорхой, хэмжигдэхүйц зорилт, зорилго дэвшүүлэх боломжийг олгохын тулд ойн удирдлагын төлөвлөгөөг боловсруулахдаа технологийн шинэчлэл, орон нутгийн иргэдийн оролцоог дэмжих, мөн ойн ашиглалтыг тогтвортой болгох зорилгоор бүх талын хамтын ажиллагааг дэмжих боломжтой.

Энэхүү судалгаагаар бид ойн тогтвортой менежментийн онол практикт гүнзгий дүн шинжилгээ хийж, ӨМӨЗО, Алшаа аймгийн ойн тогтвортой менежментийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлыг цогцоор нь ойлгосон. Ойн тогтвортой менежмеэтийг дэмжихийн тулд засгийн газар, олон нийт, олон нийт хамтран хамтын ажиллагааг бий болгох хэрэгтэй. Энэхүү судалгаа нь ижил төстэй салбар дахь нийгмийн засаглал, иргэдэд лавлагаа болж, орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжинэ гэж найдаж байна.

Ашигласан ном зүй

1. Жин, Ж. (2014). Ойн тогтвортой менежментийн тухай-Дэлхийн засаглал ба дэлхийн ойн хамгаалахад гүйцэтгэх үүрэг. *Аньхуй Агри сэтгүүл, Шинжлэх ухаан*.
2. Wikipedia. (n.d.). *Sustainable forest management*. Retrieved April 27, 2025, from https://en.wikipedia.org/wiki/Sustainable_forest_management
3. Sayer, J. A., Vanclay, J. K., & Byron, N. (1997). Technologies for sustainable forest management: Challenges for the 21st century. *The Commonwealth Forestry Review, 76*(3), 162–170.
4. Wunder, S. (2005). *Payments for environmental services: Some nuts and bolts* (Occasional Paper No. 42). Center for International Forestry Research. https://doi.org/10.17528/cifor/001760
5. Universitat Politècnica de València. (2014). *Routledge*. Retrieved October 27, 2014.
6. Universitat Politècnica de València. (2014, October 27).
7. *The Forestry Chronicle*. (2000). Vol. 76, No. 3 (May/June issue).
8. Muhammed, N., Koike, M., & Haque, F. (2008). Forest policy and sustainable forest management in Bangladesh: An analysis from national and international perspectives. *Environmental Management, 26*(6), 659–673.
9. Larson, A. M., & Ribot, J. C. (2007). The poverty of forestry policy: Double standards on an uneven playing field.
10. Chazdon, R. L., & Brancalion, P. H. S. (2016). When is a forest a forest? Forest concepts and definitions in the era of forest and landscape restoration. *Ambio, 45*(5), 538–550. https://doi.org/10.1007/s13280-016-0772-y
11. Torres-Rojo, J. M. (2016). Sustainable forest management in Mexico. Retrieved April 11, 2016.
12. Foster, B. C. (2010). Implementing sustainable forest management using six concepts in an adaptive management framework. *Journal of Sustainable Forestry, 29*(1), 79–108. https://doi.org/10.1080/10549810903463494
13. Chinese Academy of Forestry. (n.d.). *Forest Policy and Information Research Institute*. Beijing, China.
14. Цао, В. (2000). Канад улсын ойн тогтвортой менежментийн шалгуур үзүүлэлтүүд. *Хөдөөгийн эко орчин*, Боловсролын яамны судлалын хүрээлэн буй орчны шинжлэх ухааны гол лаборатори.
15. Rawat, T. S., Menaria, B. L., Dugaya, D., & Kotwal, P. C. (2008). Sustainable forest management in India. *Journal of Sustainable Forestry, 94*.
16. Ван, К. (2001). АНУ-ын Орегон муж дахь ойн менежмент. *Хятадын ойн аж ахуй*.
17. Шу, Л. (2022). АНУ-ын Калифорни дахь түймрийн орон зайн менежментийн стратегийн дүн шинжилгээ. *Хуурай газрын экосистем ба хамгаалал*.
18. Жин, Ж. (2015). Дэлхийн ойн засаглал.
19. Хай, Л. (2020). Алшаа аймаг дахь цөлжилттэй тэмцэх үйл явцын талаархи зарим бодол.
20. Жао, Ч. (2015). Алшаа аймгийн цөлжилтийн үйл явц дахь хүний үйл ажиллагаа, байгалийн элементүүдийн харьцангуй үүрэг.
21. Алшаа аймгийн зүүн хошуу. (2020). Ногоон хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлж, ойн аж ахуй, бэлчээрийн салбарт шинэ хуудсыг нэмэх нь.
22. Ма, Ш. (2022). Алшаа аймгийн ой, өвс, экологийн хамгаалалтын бүтээн байгуулалт шинэ алхамуудыг хийж байна.

23. Луо, В. (2023). Алшаа аймгийн ойн аж ахуй, бэлчээрийн салбарт шинэ нөхцөл байдлыг бий болгох нь. ӨМӨЗО Алшаа ойн ба бэлчээрийн товчоо.
24. Ли, Ю., Жан, И., & Юан, Б. (2021). Алшаа аймгийн экологийн орчны байдал, барилгын арга хэмжээ.
25. Алшаа аймгийн засгийн газар. (n.d.). Цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, хянах чиглэлээр Алшаа аймагт тулгарч буй асуудал, арга хэмжээний талаархи судалгааны тайлан.
26. Алшаа аймгийн ой, бэлчээрийн товчоо. (n.d.). Retrieved from Алшаа аймгийн ой, бэлчээрийн товчооны вэбсайт.
27. Cerutti, P. O., Nasi, R., & Tacconi, L. (2008). Sustainable forest management in Cameroon needs more than approved forest management plans. *Ecology and Society, 13*(2). https://doi.org/10.5751/ES-02591-130236

SPSIRPA FORUM 2025

Session 4-1

The China-Mongolia-Russia Economic Corridor and China-Mongolia Cooperation

ХЯТАД-МОНГОЛ-ОРОСЫН ЭДИЙН ЗАСГИЙН КОРИДОР БА ХЯТАД-МОНГОЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ИРЭЭДҮЙН ЧИГ ХАНДЛАГА

Х. Тунгалаг, БНХАУ-ын Шанхайн Жиао Тонг их сургуулийн
Олон улсын болон олон нийттэй харилцах сургууль,
Шанхайн Жиао Тон их сургуулийн
Эрчим хүчний инженерийн сургууль.Пост доктор.

Фан Лижун, БНХАУ-ын ӨМӨЗО-ны
“Бүс ба Зам” хүрээлэнгийн захирал, судлаач.

Нарангарав, Хилийн боомтын захиргааны
Гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн,
Монгол Улсын Их Сургуулийн Олон улсын харилцааны магистр

Товч утга: Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридор нь "Нэг бүс, нэг зам"-ын хүрээнд хамтарсан эдийн засгийн хамтын ажиллагааны анхны коридор бөгөөд "цэг-шугам-талбай" гэсэн гурван хэмжээст хөгжлийн загварыг бүрдүүлснээр хамтын ажиллагааг бэхжүүлж, бэрхшээлийг даван туулж, бүс нутгийн удирдлагын үр дүнтэй загварыг судалснаар Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын хөгжил, бүс нутгийн эдийн засгийн интеграцийг гүнзгийрүүлж, гурван орны хамтарсан цэцэглэлт, хөгжлийг хангах боломжтой. Хятадын хувьд энэхүү коридор нь Зүүн Хойд Ази, Европын хоорондын хуурай замын холболтыг бий болгож, Хятад-Европын худалдааны шинэ суварийг нээсэн. Монгол, Оросын хуурай замын холболтоор олон талт олон улсын логистикийн системийг бүрдүүлж байна. Монгол Улсын хувьд коридорын хөгжил нь "гол мөрөн, далайд гарцтай" болох боломжийг олгож, гадаад худалдааг олон талт хөгжүүлэхэд тусална. Харин Орос улс коридораар дамжуулан Зүүн Хойд Азийн бүс нутгийн хамтын ажиллагаанд гүнзгий оролцох боломжтой болж байна.

Түлхүүр үгс: Хятад-Монгол-Орос, эдийн засгийн коридор, Хятад-Монгол, хамтын ажиллагаа

Хятад-Монгол-Орос эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын “Бүс ба Зам” санаачилга, Монгол Улсын “Талын зам хөтөлбөр”, Оросын Холбооны Улсын “Их Евразийн санаачилга”-ын хүрээнд гурван улсын хамтын ажиллагааг эрчимжүүлэн хөгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх юм.

Түүнчлэн тус гурван улсын эдийн засгийн коридор нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын "Бүс ба Зам" санаачлагын хүрээнд хэрэгжүүлж буй анхны олон талт эдийн засгийн хамтын ажиллагааны коридор юм. Гурван хэмжээст хөгжлийн "цэг-шугам-талбай" загварыг бүтээж, хамтын ажиллагааг өргөжүүлэх, сорилтыг даван туулах, үр дүнтэй бүсийн удирдлагын загварыг тодорхойлох замаар коридорын бүтээн байгуулалтыг урагшлуулж, бүс нутгийн

эдийн засгийн интеграцийн хөгжилд хүрч, гурван улсын хамтын цэцэглэлт, хөгжлийн зорилгыг биелүүлнэ.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хувьд тус коридор нь "Зүүн Өмнөд Азийн эдийн засгийн бүс" болон "Баруун Европын эдийн засгийн бүс"-ийг хуурай замаар холбож, Хятад, Европын худалдааны шинэ гарцыг нээн, Монгол Улс, Оросын Холбооны Улсын хуурай замын тээврийн сүлжээгээр дамжуулан олон улсын логистикийн системийг бүрдүүлж буйгаараа онцлог юм. Монгол Улсын хувьд коридорын бүтээн байгуулалт нь "далайд гарах" боломжийг олгож, эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Оросын Холбооны Улс энэ коридороор дамжуулан "Алс дорнодыг хөгжүүлэх" стратегийг хэрэгжүүлж, Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагаанд идэвхитэй оролцох боломж бүрдэнэ.

Нэг. "Цэг"-ийг "шугам" болгон холбож эдийн засгийн коридорын дагуух хотуудын хөгжлийг дэмжих.

Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридор дагуух гурван улсын төв зангилаа хотуудад тулгуурлан, төмөр зам, авто зам, агаарын тээврийг идэвхтэй ашиглан, эдийн засгийн зангилаа хотуудын хүн хүч, технологийн интеграцид нэгдэж, бараа бүтээгдэхүүнийг шинэ түвшинд дамжуулан тээвэрлэж, бүс нутгийн эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийг дэмжих зорилготой хийгээд хил залгаа орших хотуудыг холбох үүрэгтэй. Эдгээр боомт хотуудаар дамжуулан Хятад-Монгол, Хятад-Орос, Орос-Монголын хил дагуух чухал аж үйлдвэр, хөдөө аж ахуй, худалдааны төвүүдийг нэгтгэн, гурван улсын логистикийн урсгалыг бүрдүүлж, хоёр талын хамтын ажиллагааг хангаж, цаашлаад гурван улсын бүс нутгийн хөгжлийг дэмжих юм.

Өнөөгийн байдлаар Хятад-Монголын хил дээр 17 боомтоос (Эрээн-Замын-Үүд, Бичигт-Зүүнхатавч, Гашуунсухайт-Ганцмод, Шивээхүрэн- Сэхэ 4 төмөр замын боомт болон 13 авто замын боомт) 13 боомт идэвхтэй ажиллаж, Орос-Монголын хилийн 16 боомтоос (Сүхбаатар-Наушки, Эрээнцав-Соловьевск төмөр замын боомт болон 14 авто замын боомт) 10 боомт байнгын үйл ажиллагаа явуулж байна. Түүнчлэн агаарын замын 6 боомтоос зөвхөн “Чингис хаан” ОУНБ ажиллаж, хил дамнасан хамтын ажиллагааны стратегийн чухал нөхцөлийг бүрдүүлж байна.

Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын бүтээн байгуулалт нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 24 боомтод тулгуурлан, зангилаа хотуудын хөгжлийг дэмжих бөгөөд ингэснээр "цэг"-ийг "шугам" болгон холбож, хөгжүүлэх боломж бүрдэнэ хэмээн үзэж байна.

1. Хятад - Монголын хилийн боомтын өнөөгийн нөхцөл байдал болон эдийн засагт үзүүлж буй үр нөлөө

БНХАУ-ын ӨМӨЗО, ШУӨЗО-той Монгол Улс нь хил залгадаг. Хятад, Монгол хоёр орны хилийн боомтуудын тоо 1990-ээд оноос хойш нэмэгдэн, хилийн бүс нутгийн хөгжлийн төв болж ирсэн. Хилийн боомтуудын өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан үйл ажиллагааны төрөл, эдийн засгийн үр өгөөжөөр хоёр үндсэн төрөлд хуваан үзэж байна. Үүнд: Нэгдүгээрт, нөөцийн төрөлт (уул уурхай, эрдэс баялагийн) боомтууд, жишээлбэл, Гашуунсухайт-Ганцмод, Шивээхүрэн-Сэхээ; Хоёрдугаарт, цогц төрлийн (олон төрөлт ачаа бараа, зорчигч тээврийн) боомтууд, жишээлбэл, Эрээн-Замын-Үүд орно. (2024 оны Статистик дурьдах)

Хүснэгт 1. Монгол-Хятадын хилийн боомтууд.

Монголын аймаг, сум	Боомтын нэр
Дорнод аймаг Халхгол сум, Чойбалсан сум	Баянхошуу-Өвдөг (Өвөр Монголын Хөлөнбуйр хот) авто замын боомт, хоёр талын зэрэглэлтэй, байнгын ажиллагаатай. Хавирга-Архашаат (Өвөр Монголын Хөлөнбуйр хот) авто замын боомт, хоёр талын зэрэглэлтэй, байнгын ажиллагаатай. Сүмбэр-Рашаант (Өвөр Монголын Хянган аймаг) авто замын боомт, олон улсын зэрэглэлтэй, түр ажиллагаатай.
Сүхбаатар аймаг, Эрдэнэцагаан сум	Бичигт-Зүүнхатавч (Өвөр Монголын Шилийн гол аймаг) авто замын боомт, олон улсын зэрэглэлтэй, байнгын ажиллагаатай. Бичигт-Зүүнхатавч (Өвөр Монголын Шилийн гол аймаг) төмөр замын боомт.
Дорноговь аймаг Замын- Үүд сум, Хатанбулаг сум	Замын-Үүд-Эрээн (Өвөр Монголын Эрээн хот) авто замын боомт, олон улсын зэрэглэлтэй, байнгын ажиллагаатай. Замын-Үүд-Эрээн (Өвөр Монголын Эрээн хот) төмөр замын боомт, олон улсын галт тэрэгний цагийн хуваарийн дагуу ажиллана. Ханги-Мандал (Өвөр Монголын Бугат хот) авто замын боомт, хоёр талын зэрэглэлтэй, байнгын ажиллагаатай.
Өмнөговь аймаг Ханбогд сум, Хүрмэн сум Гурвантэс сум,	Гашуунсухайт-Ганцмод (Өвөр Монголын Баяннуур хот) авто замын боомт, хоёр талын зэрэглэлтэй, байнгын ажиллагаатай. Гашуунсухайт-Ганцмод (Өвөр Монголын Баяннуур хот) төмөр замын боомт Цагаандэл-Уул-Өлзий авто замын боомт, хоёр талын зэрэглэлтэй, байнгын ажиллагаатай. Шивээхүрэн-Сэхээ (Өвөр Монголын Алшаан аймаг) авто замын боомт, хоёр талын зэрэглэлтэй, байнгын ажиллагаатай. Шивээхүрэн-Сэхээ (Өвөр Монголын Алшаан аймаг) төмөр замын боомтын боомт.
Говь-Алтай аймаг Бугат сум	Бургастай-Лаоемяо (Шинжаан Хами аймаг Баркун сум) авто замын боомт, олон улсын зэрэглэлтэй, байнгын ажиллагаатай.
Ховд аймаг Булган сум	Булган-Такашикен (Шинжаан Алтай аймаг Чинх сум) авто замын боомт, олон улсын зэрэглэлтэй, байнгын ажиллагаатай.

	Байтаг-Улиастай (Шинжаан Чанжи хот Куйтай сум) авто замын боомт, хоёр талын зэрэглэлтэй, түр ажиллагаатай.
Баян-Өлгий аймаг Сагсай сум	Даян-Хуншаньзюй (Шинжаан Алтай аймаг Фухай сум) авто замын боомт, хоёр талын зэрэглэлтэй, түр ажиллагаатай.

Эх сурвалж: Хилийн боомтын захиргаа

2. Монгол-Оросын хилийн боомтын өнөөгийн нөхцөл байдал болон эдийн засагт үзүүлж буй үр нөлөө

Монгол Улс нь ОХУ-ын Бүгд Найрамдах Алтай Улс, Бүгд Найрамдах Тыва Улс, Бүгд Найрамдах Буриад Улс, Өвөрбайгалийн хязгаартай хил залгадаг (2 төмөр замын боомт, 8 авто замын боомт). Сүхбаатар-Наушки төмөр замын боомт (Улаанбаатар хотыг Сибирийн төмөр замтай холбодог), Алтанбулаг-Хиагт (ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улс), Цагааннуур-Ташанта (ОХУ-ын Бүгд Найрамдах Алтай Улс) авто замын боомтууд нь гурван улсын чухал зангилаа боомтуудад тооцогдож байна. Эдгээр боомтууд нь Монгол-Оросын худалдааны 85%-ийг хариуцдаг ба 2024 онд хилийн худалдааны хэмжээг 17 тэрбум ам.доллар даван гарсан байна. (Эх сурвалжийг дурьдах).

Түүнчлэн Монгол-Оросын хилийн боомтуудыг аялал жуулчлал (Ханх-Монд, Ульхан-Дээд Ульхан), худалдааны (Алтанбулаг-Хиагт, Сүхбаатар-Наушки) зэрэг чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлэх боломжтой байна.

Хүснэгт 2. Монгол-Оросын хилийн боомтууд

Монголын аймаг, сум	Боомтын нэр
Дорнод аймаг Баян-Уул сум, Чулуухороот сум	Эрээнцав-Соловьевск (Өвөрбайгалийн хязгаар) авто замын боомт, олон улсын зэрэглэлтэй, байнгын ажиллагаатай. Эрээнцав-Соловьевск (Өвөрбайгалийн хязгаар) төмөр замын боомт, хоёр талын зэрэглэлтэй, байнгын ажиллагаатай. Ульхан-Дээд Ульхан (Өвөрбайгалийн хязгаар) авто замын боомт, хоёр талын зэрэглэлтэй, байнгын ажиллагаатай.
Сэлэнгэ аймаг, Алтанбулаг сум, Сүхбаатар сум	Алтанбулаг-Хиагт (Бүгд Найрамдах Буриад Улс) авто замын боомт, олон улсын зэрэглэлтэй, байнгын ажиллагаатай. Сүхбаатар-Наушки (Бүгд Найрамдах Буриад Улс) төмөр замын боомт, олон улсын зэрэглэлтэй, байнгын ажиллагаатай.
Хөвсгөл аймаг, Ханх сум	Ханх- Монд (Бүгд Найрамдах Буриад Улс), авто замын боомт, олон улсын зэрэглэлтэй, байнгын ажиллагаатай.
Завхан аймаг, Тэс сум	Арцсуурь-Цагаантолгой (Бүгд Найрамдах Тыва Улс) авто замын боомт, хоёр талын зэрэглэлтэй, байнгын ажиллагаатай.

Увс аймаг Давст сум, Тэс сум	Боршоо-Хандгайт (Бүгд Найрамдах Тыва Улс) авто замын боомт, олон улсын зэрэглэлтэй, байнгын ажиллагаатай. Тэс- Шарсуурь (Бүгд Найрамдах Тыва Улс) авто замын боомт, хоёр талын зэрэглэлтэй, байнгын ажиллагаатай.
Баян-Өлгий аймаг Ногоон сум	Цагааннуур-Ташанта (Бүгд Найрамдах Алтай Улс) авто замын боомт, олон улсын зэрэглэлтэй, байнгын ажиллагаатай.

Эх сурвалж: Хилийн боомтын захиргаа.

2. Хятад-Оросын боомтын талаар мэдээлэл

Хятад-Оросын хилийн нийт 25 боомт байгаа бөгөөд эдгээрээс 22 нь авто замын боомт, 3 нь төмөр замын (Забайкальск-Маньчжурия, Пограничный-Суйфэнхэ, Нижнеленинское-Тунзцян) боомт юм. (Зураг 1)

Зураг 1. Хятад, Оросын хилийн боомтуудын голлох боомтууд, статистик, боомтуудыг хэрхэн ангилж буйг дурьдах.

（4）Дэд суурин хотуудыг "Олон улсын хот" болгон хөгжүүлэх

Хятад-Монгол-Орос гурван улсын дотоодын төмөр зам, авто замын сүлжээний зангилаа хотуудыг хилийн боомтуудтай холбон Монгол-Хятад-Оросын эдийн засгийн коридорын дагуух "Олон улсын хот" болгон хөгжүүлэх боломжтой хэмээн үзэж байна. Хөх хот, Харбин, Улаанбаатар, Чойбалсан, Улаан-Үд, Чита зэрэг хотуудыг "Олон улсын хүмүүнлэгийн хамтын ажиллагааны төв" болгон хөгжүүлэх нь зүйтэй. Яагаад ингэж үзэж буйг дурьдах, төр засгийн шийдвэр, Улсын стратеги зорилт бий эсэхийг тодотгон бичих. Сайншанд, Чойр, Эрдэнэт, Бугат, Чифэн, Тунляо, Ухань, Новосибирск, Хабаровск зэрэг аж үйлдвэрийн хотуудыг "Олон

улсын үйлдвэрлэлийн төв" болгон хөгжүүлэх нь зохилтой. Яагаад ингэж үзэж буйг дурьдах, төр засгийн шийдвэр, Улсын стратеги зорилт бий эсэхийг тодотгон бичих. Эрээн, Замын-Үүд, Улаанбаатар, Сүхбаатар, Чита, Улаан-Үд, Новосибирск, Хабаровск, Шилийн хот, Хайлаар, Манжуур, Хөх хот, Ордос, Владивосток зэрэг түүхэн өвийн баялагтай хотуудыг "Олон улсын аялал жуулчлалын хот" болгон хөгжүүлж, бүс нутгийн аялал жуулчлалын эдийн засгийг хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ. Яагаад ингэж үзэж буйг дурьдах, төр засгийн шийдвэр, Улсын стратеги зорилт бий эсэхийг тодотгон бичих.

1. Зүүн коридорын шугам: Оросын Алс Дорнодын чухал боомт Владивостокоос эхлэн, Пограничний хилийн боомтоор дамжин Хятадын зүүн хойд хэсгийн Суйфэньхэ (100 жилийн түүхтэй хилийн боомт), Харбин (бүсийн зангилаа), Манжуур (хамгийн том хилийн боомт) хотуудаар дамжин, Монголын зүүн хэсгийн аж үйлдвэрийн хот Чойбалсан, нийслэл Улаанбаатар хүртэл үргэлжилж, Японы тэнгистэй Монголын өндөрлөгийг холбосон худалдааны коридорыг бүрдүүлнэ.

2. Зүүн хойд Азийн гурвалжин шугам: Оросын Краскино хилийн боомтоос эхлэн, Хятадын Хүнчүнь (Хятад-Орос-БНСУ-ын хилийн цэг), Жилинь (аж үйлдвэрийн төв), Рашаант (байгалийн аялал жуулчлалын бүс) хотуудаар дамжин, Монголын зүүн хэсгийн нөөцөд баян бүс (Чойбалсаны зэсийн уурхай, Сүхбаатарын тээврийн зангилаа, Эрдэнэцавын хөдөө аж ахуйн бүс) дайран, эцэст нь Оросын Байгаль нуурын бүсийн Улаан-Үд (соёлын төв), Забайкальск (төмөр замын зангилаа) хүртэл холбогдоно.

3. Ляо-Монголын эдийн засгийн бүс: Хятадын Жиньжоу боомт (Бохай булангийн зангилаа), Жуунгадабучи хилийн боомтоос (Монголтой худалдааны гол цэг) эхлэн, Монголын төв хэсгийн Хөөт (эрчим хүчний төв), Чойбалсан (аж үйлдвэрийн хот), Сүхбаатар (тээврийн гол цэг), Эрдэнэцав (хөдөө аж ахуйн бүс) хүртэл тус тус дэлгэрэх бөгөөд Оросын Улаан-Үд хүртэл сунжирч, Зүүн хойд Азийн далай, газар хоорондын тээврийн сүлжээг бүрдүүлнэ.

4. Төвийн газар дамжин холбогдох коридор: Хятадын Жинин (логистикийн төв), Эрээн хот (Монголтой хиллэдэг хамгийн том хилийн боомт) хотоос эхлэн, Монголын Замын-Үүд (хил дамнасан эдийн засгийн бүс), Улаанбаатар (улс төр, эдийн засгийн төв), Алтанбулаг (чөлөөт худалдааны бүс) хотуудаар дамжин, Оросын Улаан-Үд хүртэл шууд холбогдож, Хятадын хойд бүсийг Сибирьтэй холбосон төмөр замын гол судас болно.

5. Баруун экологи коридор: Хятадын Такашикен хилийн боомтоос (Монголтой холбох чухал гарц) эхлэн, Монголын Булган хилийн боомт (ашигт малтмалын тээврийн зангилаа), Цагааннуур (байгалийн цэнгэг усны нуур) хүртэл үргэлжилж, Оросын Бүгд Найрамдах Алтай Улс (байгалийн өвийн бүс), Алтайн хилийн нутаг (биологийн олон янз байдлын хамгаалалтын бүс) хүртэл үргэлжилж, байгальд ээлтэй аялал жуулчлал, тогтвортой хөгжлийг онцлон тодорхойлно.

Бүх шугам нь хилийн боомтыг өргөн холбоосоор тойруулж, тээврийн зангилаа, нөөцөд (эрдэс баялаг, уул уурхайд) тулгуурлан, түүх, соёлын онцлог-оороо ижилдсэн хот, мужуудыг холбон бүсийн хамтын ажиллагааны интеграцид орох боломжийг бүрдүүлдэг.

Хотын татах хүч нь түүний олон талт функцтэй нягт холбоотой. Нийслэл хотууд улс төр, эдийн засаг, соёл гэх мэт олон талын функцээрээ илүү өндөр татах хүчийг бий болгодог. Мөн хотын

бүтээн байгуулалт дахь түүхэн соёлын өв, хотын онцлогийн тод байдал, хүний орчин болон гадаад үйлчлэлийн чанарын түвшин зэрэг нь хотын татах хүчинд нөлөөлөх чухал хүчин зүйлс юм.

Хоёр. "Шугам" дээр тулгуурлан, олон талт "хамтын ажиллагааны талбайг" бүтээх

Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын бүтээн байгуулалт эдгээр хотуудын онцлогт тулгуурлан хөгжих бөгөөд ялангуяа хилийн боомт хотууд "олон улсын соёл"-ын онцлогтой, хөгжүүлэх нөөц ихтэй, ирээдүйд хамтын ажиллагааны өргөн боломжтой. Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын бүтээн байгуулалтаар бүсийн эдийн засгийн нэгдлийг дэмжиж, олон талт системтэй зохицуулсан хөгжлийн "хамтын ажиллагааны талбайг" бүтээх болно.

"Талбай"-гийн өргөн хүрээ нь долоон хамтын ажиллагааны чиглэлд илэрхийлэгдэнэ: Дэд бүтэц хоорондын холболтоос гадна үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт, худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа, соёл гэх мэт орно. Хилийн чанадад эдийн засгийн хамтын ажиллагааны бүс (Эрээн-Замын Үүд), нэгдсэн онцгой гаалийн бүс зэрэг платформуудаар дамжуулан бүсийн эдийн засгийн нэгдлийн шинэ дэглэмийг бүрдүүлэхэд чиглэнэ.

2024 оны хамгийн сүүлийн мэдээллээр энэ коридор гурван орны худалдааны хэмжээг 2000 тэрбум ам.доллараас давж, Зүүн хойд Азийн бүсийн эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгүүр болсон байна. (Юун тухай ярьж буйг тодорхой гаргах)

1. Дээд түвшний удирдлагаар чиглүүлсэн гурван талын хамтын ажиллагааны механизм нь суурь болно

Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридор нь гурван орны төрийн тэргүүнүүдийн хэмжээнд эхлүүлсэн өндөр дээд түвшний хөтөлбөр юм. Дээд түвшинд тэргүүнүүдийн уулзалт, ерөнхий сайд, гадаад хэргийн сайд нарын зөвлөлдөх механизм дээр тулгуурлана. Дунд түвшинд Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (Монгол Улс ажиглагчаар), Азийн хамтын ажиллагааны яриа, хэлэлцээ зэрэг олон талт механизмыг бүрдүүлж, суурь түвшний хэрэгжилт нь "Хайлаар-Чита-Чойбалсан" хамтын ажиллагаа зэрэг гурван орны орон нутгийн засаг захиргааны нэгжүүдээр хэрэгжинэ. Өнөөгийн нөхцөл байдлаар хамтын ажиллагаа нь дэд бүтцийн "хатуу холболтоос"-оос дүрэм, стандартын "зөөлөн холболт" руу шилжиж, гаалийн дижиталчлал, үндсэн мөнгөн тэмдэгтээр тооцоо хийх зэрэг системийн шинэчлэлийг түлхүү хэрэгжүүлснээр Зүүн хойд Азийн бүсийн эдийн засгийн нэгдэлд зориулсан институцын нийтээр хэрэглэгдэх бүтээгдэхүүнийг бүрдүүлж байна. Ирээдүйд "сэтгэлгээний танхим" гэх мэт "хоёрдугаар төвөг"-ийн дипломат механизмуудыг бэхжүүлж, илүү хүлээн авах чадвартай бүсийн хамтын ажиллагааны загварыг бүрдүүлэх шаардлагатай.

2. Гурван талын "давхар эргэлт"-тэй харилцан үйлчлэлийн загвартай

Хятад, Монгол, Орос гурван улс дэлхийн худалдааны байгууллагын гишүүн бөгөөд олон талт худалдааны системийн суурьтай. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн "Түмэн голын санаачлага"-д хамтран оролцож, Зүүн хойд Азийн бүсийн хөгжлийг дэмжиж байна. Олон улсын хамтын ажиллагааны платформууд нь дэлхий дахины хамтын ажиллагаанд оролцох суурь болдог. Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкны (AIIB) үүсгэн байгуулагч гишүүн орнуудын хувьд дэд бүтцийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хамтын

ажиллагааг бэхжүүлдэг; Азийн харилцан яриа, итгэлцлийг бэхжүүлэх хэлэлцээрийн хүрээнд бүсийн аюулгүй байдал, хөгжлийг хамтран дэмжинэ. Энэ нь гурван орны "олон улсын эргэлт"-д нэгдэх суурь болдог. Бүсийн эргэлт нь "Евразийн эдийн засгийн холбоо", "Нэг бүс нэг зам", "Талын зам"-ын хооронд байгуулсан хамтын ажиллагааны платформуудаар хэрэгждэг. Ялангуяа Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридор нь "Нэг бүс нэг зам"-ын тэргүүлэх төсөл бөгөөд Оросын "Даяар Евразийн тээврийн коридор", Монгол Улсын "Талын зам", Хятадын "Торгоны замын эдийн засгийн бүс"-ийг стратегийн хувьд нэгтгэдэг. Хятад, Оросын хамтарсан оролцоотой G20, Ази-Номхон далайн хамтын ажиллагааны зөвлөл (APEC) нь Монгол Улсын тэргүүлсэн "Далайн гарцгүй орнуудын хамтын ажиллагааны холбоо"-той функциональ нэмэрлэлтэй. Ингэснээр Хятад-Монгол-Оросын хооронд "цөм-тархалт"-ын орон зайн бүтэц бий болсон гэж хэлж болно. Манжуур, Суйфэньхэ, Эрээн зэрэг хилийн боомт хотуудыг гол цэг болгон, Харбин, Улаанбаатар, Чита зэрэг зангилаа хотуудыг холбосноор Зүүн хойд Азийг хамарсан "суваг + зангилаа + сүлжээ"-ний системийг бүрдүүлсэн. Энэхүү орон зайн зохион байгуулалт нь нөөц, хүчин зүйлсийн үр ашигтай урсгалыг хангахын зэрэгцээ хилийн бүс нутаг, дотоодын өргөн хүрээний хөгжилд хосолсон нөлөө үзүүлдэг.

Зураг 2. Хятад-Монгол-Оросын бүсийн хамтын ажиллагааны "талбай"-гийн замнал



Эх сурвалж: Хувийн зохиосон.

Гурав. Хятад-Монгол-Оросын бүсийн эдийн засгийн нэгдлийн хамтын ажиллагааны замнал

Хилийн чанадад эдийн засгийн хамтын ажиллагааны бүс гэдэг нь хилийн бүс нутагт хоёр ба түүнээс дээш улсын засгийн газраас хамтран тогтоосон онцгой бүс бөгөөд экспортын боловсруулалтын бүс, онцгой гаалийн бүс, чөлөөт худалдааны бүс зэрэг дэмжлэгтэй бодлогод хамрагдана. Үүнтэй зэрэгцэн энэхүү бүс нь хил залгаа орнуудаас олгосон онцгой санхүү-татварын, хөрөнгө оруулалт-худалдааны болон холбогдох аж үйлдвэрийн бодлогын тусгай дэмжлэгтэй байх ба бүсийн зарим хэсэгт хилийн гаалийн онцгой хяналтыг хэрэгжүүлж, хүн хүч, бараа материал, санхүү, технологи, мэдээллийн урсгал зэрэг үйлдвэрлэлийн хүчин зүйлсийг төвлөрүүлэн, тухайн бүсийн хөгжийг хурдасгах, цацрагийн үр нөлөөгөөр хил залгаа бүс нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлдэг.

Одоогоор Хятад-Монгол-Орос гурван улс томоохон хилийн чанадад эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулаагүй байна. Гэхдээ, хоёр талын хилийн хамтын ажиллагаа нь гурван талын хамтын ажиллагаанд материаллаг суурь, хамтын ажиллагааны зарчим, хууль эрх зүйн

үндэс суурийг бэлтгэснээр Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын бүтээн байгуулалтыг цаашид дэмжиж, бүсийн эдийн засгийн нэгдлийг хөхүүлэн дэмжих боломжтой.

1. Хилийн боомт дахь иргэдийн харилцан худалдааны бүсийг хилийн чөлөөт худалдааны бүс болгон өргөтгөх

Хилийн боомт дахь иргэдийн харилцан худалдааны бүсийг хилийн чөлөөт худалдааны бүс болгон шинэчлэх нь зөвхөн нэршилд гарсан өөрчлөлт биш, харин эдийн засгийн бүтэц, удирдлагын загварын гүнзгий шинэчлэл юм. Энэхүү арга хэмжээ нь Суйфэньхэ, Хүнчүнь, Манжуур, Эрээн, Такешкен зэрэг бүс нутагт эдийн засгийн нээлттэй байдал, бүсийн хамтын ажиллагааны чиглэлээр чухал алхам хийснийг илтгэнэ. Энэ нь зөвхөн хил залгаа орнуудын хоорондын худалдааг өргөжүүлэхэд туслахаас гадна хилийн бүс нутгийн эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлж, бүсийн хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, дотоод гадаадын хөрөнгө оруулагчдыг татах боломжтой.

Үүний үндсэн дээр хилийн чөлөөт худалдааны бүс байгуулах нь эдгээр бүс нутагт шинэ хөгжлийн боломжийг бий болгож, орон нутгийн эдийн засгийн олон талт хөгжилд дэмжлэг үзүүлэхээс гадна улс орны гадаад нээлттэй бодлогод шинэ хүч нэмж оруулах болно. Түүнчлэн, хилийн чөлөөт худалдааны бүсийн байгуулалт нь хилийн бүс нутагт дэд бүтцийн бүтээн байгуулалтыг өргөжүүлж, тээвэр логистикийн нөхцөлийг сайжруулж, хил залгаа орнуудын хоорондын холболтыг бэхжүүлснээр бүсийн эдийн засгийн нэгдлийн суурийг бэхжүүлнэ. Хилийн бүс нутаг дэлхийн эдийн засагт илүү сайн нийцэж, улс орны эдийн засгийн өсөлтийг хөхүүлэн дэмжих шинэ хөдөлгүүр болох болно.

2. Хилийн эдийн засгийн бүсийг хилийн чанадад эдийн засгийн хамтын ажиллагааны бүс болгон өргөтгөх

2024 оны байдлаар Хятад-Орос хоёр улс албан ёсоор чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулаагүй байна. Гэхдээ, Оросын үйлдвэрүүд Хятадын (Чиндао) чөлөөт худалдааны туршилтын бүсэд орж ирээд байна. 2024 оны 3-р сард Хятад, Монгол улс Эрээн-Замын Үүд хилийн чанадад эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах талаар санал нэгдсэн. Орос, Монгол улс Монгол улсыг Оросын тэргүүлсэн "Евразийн эдийн засгийн холбоо"-нд элсүүлэх, Цагааннуурын чөлөөт эдийн засгийн бүс (хилийн чанадад эдийн засгийн хамтын ажиллагааны бүс) байгуулах талаар хэлэлцээр хийж байна. 2012 онд Монгол улс Орос-Монголын хилийн орон нутагт байгуулсан Алтанбулагын эдийн засгийн чөлөөт хамтын ажиллагааны бүс нь Монгол, Оросын хилийн хамтын ажиллагааны суурь болсон.

Гурван улс хилийн хамтын ажиллагаа явуулах суурь нөхцөлтэй. Монгол улсыг төвлөрүүлж түүний зүүн ба баруун талд томоохон хилийн хамтын ажиллагааны бүс байгуулах боломжтой. Зүүн бүсэд "Хайлар (Хятад)-Чита (Орос)-Чойбалсан (Монгол)" гэсэн гурван орны орон нутгийн захиргааны нэгжүүд голлох болно. Баруун бүсэд "Алтайн уулархаг дэд бүсийн хамтын ажиллагаа" голлох болно.

Одоогоор Өвөр Монголын нам, засгийн газрын идэвхтэй дэмжлэгээр Орос, Монгол, Казахстан улсуудын хилийн орон нутгийн засаг захиргаанууд ч мөн идэвхтэй ажиллаж байна. Эдгээр орон нутгийн засаг захиргааны хүчин чармайлт нь Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын бүтээн байгуулалт, бүсийн эдийн засгийн нэгдлийг дэмжихэд чиглэгдсэн байна.

Дөрөв. Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын бүтээн байгуулалтад нөлөөлж буй гол хүчин зүйлс ба дэмжлэг үзүүлэх арга хэмжээ

1. Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын бүтээн байгуулалтад нөлөөлж буй гол хүчин зүйлс

(1) Улс төрийн харилцан итгэлцэлд тэгш бус байдал байна

Албан ёсны түвшин болон хилийн залгаа орон нутгийн засаг захиргааны хооронд өндөр түвшний улс төрийн харилцан итгэлцэл тогтсон бөгөөд энэ нь тогтмол уулзалт, засгийн газрын хоорондын баримт бичгийн солилцоонд илэрхийлэгддэг. Гэхдээ, иргэдийн түвшинд улс төрийн харилцан итгэлцэл илүү төвөгтэй бөгөөд иргэдийн хоорондын дотно байдал мэдэгдэхүйц ялгаатай байна. Тодруулбал, Монгол-Оросын хоорондын харилцан итгэлцэл Хятад-Монгол, Хятад-Оросын харилцан итгэлцлээс илүү өндөр байна.

(2) Худалдааны хэмжээний тэгш бус байдал

Хятад-Оросын хоорондын худалдааны хэмжээ 100 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд энэ тооны ард "эрчим хүчний аюул" гэх онол нуугдаж байна. Үүнтэй зэрэгцэн Хятад-Монголын хоорондын худалдааны хэмжээ 10 тэрбум ам.доллар бөгөөд энэ тооны эргэн тойронд "эдийн засгийн аюул" гэх хэлэлцээ гардаг. Харин Орос-Монголын хоорондын худалдааны хэмжээ ердөө 2.3 тэрбум ам.доллар бөгөөд Хятад-Орос, Хятад-Монголын худалдаанаас хол түрүүлж байна. Иймээс Хятад улс Орос, Монголын "нийтлэг дайсан" буюу "аюултай улс" болж хувирсан. Хятадын 1.4 тэрбум хүн ам, том зах зээл, их хэрэгцээ нь хил залгаа орнуудад ашигтай мэдээ боловч Хятад улс үнэ төлбөргүй, стандарт худалдааны хэлбэрээр хил залгаа орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг хийж, хоёр талд ашигтай байх ёстой.

(3) Соёлын өөр өөр ойлголт нь ялгаа үүсгэдэг

Хятадын соёл нь Конфуци, Буддын шашин, Дао гэх гурван их сэтгэлгээний системээс урган гарсан "эвлэлдэх соёл" юм. Энэхүү соёл нийгмийн эв нэгдэл, хүмүүсийн харилцааны зохицол, хүн ба байгалийн нэгдлийн гүн ухаант үзэл санааг онцлон тэмдэглэдэг. Монгол улс нь лам нар буюу Төвдийн Буддын шашны гүн нөлөөн дор "байгальтай эвлэрсэн" нээлттэй, тэвчээртэй нүүдэлчдийн соёлыг бүрдүүлсэн. Энэхүү соёл нь байгальд итгэлцэх, чөлөөт нүүдлийн амьдралыг хүсэх зорилгыг илэрхийлдэг. Орос улс болон Оросын үндэсний уламжлалаар бүрдсэн "өөртөө итгэлтэй, бардам харилцан ашиггүй соёл" юм. Энэхүү соёл нь улс орны тусгаар тогтнол, үндэсний бахархал, гадны нөлөөнд болгоомжтой хандах үзлийг онцлон тэмдэглэдэг.

Соёлын ялгаа нь ойлголтын ялгааг бий болгож, гурван орны хамтын ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлдэг бөгөөд Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын бүтээн байгуулалт, бүсийн эдийн засгийн нэгдлийн хөгжилд нөлөөлж буй гол хүчин зүйл бол гурван орны хоорондох "дотоод хүчин зүйлс" юм. Энэ нь бодлогын харилцан ойлголт, дэд бүтцийн холболт, худалдааны чөлөөт байдал, санхүүжилтийн урсгал, иргэдийн хоорондын харилцаа гэх таван чиглэлд "холбогдсон ч гүйцэд бус" байдлыг үүсгэдэг. Ирээдүйд эдгээр таван чиглэлд идэвхтэй ажиллаж, Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын бүтээн байгуулалтыг хөдөлгүүр

болгон бүсийн эдийн засгийн нэгдлийг дэмжиж, гурван орны хамтарсан цэцэглэлтийг бий болгох шаардлагатай.

2. Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын бүтээн байгуулалтыг тогтвортой хөгжүүлэх дэмжлэг үзүүлэх арга хэмжээ

(1) Баталсан хамтын ажиллагааны баримт бичгүүдийг удирдамж болгон, ажлын чанарыг дээшлүүлэх

Хятад-Монгол-Орос гурван улс "Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын төлөвлөгөөний хүрээ"-г гол хүрээ болгон, одоо хэрэгжиж буй хамтын ажиллагааны баримт бичгүүдэд заасан гол ажлуудыг системтэйгээр зохион байгуулж, төслүүдийн бүртгэл, явцын хяналтын механизмыг бүрдүүлэх хэрэгтэй. Эрчим хүчний хоолой, хилийн төмөр зам зэрэг 32 шилдэг төслийг тэргүүлэн хэрэгжүүлж, төлөвлөгөөг бодит зураг төсөл болгон хувиргах ёстой. Гурван орны хамтарсан нарийн бичгийн газрыг байгуулж, "Хятад-Монгол-Оросын хөгжлийн гурван талын хамтын ажиллагааны дунд хугацааны замнал" зэрэг баримт бичгүүдийн хэрэгжилтийг тогтмол үнэлж, хилийн боомтын гаалийн үр ашиг бага, стандарт нэгдээгүй зэрэг саадыг арилгах чиглэлээр тусгай арга хэмжээ авахыг зөвлөж байна. Хятад-Монголын Эрээн-Замын Үүд хилийн чанадад эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн туршлагад суурилан Хүнчүнь, Манжуур зэрэг зангилаа хотуудад "хоёр улс-нэг бүс, хилийн чанадад" загварыг нэвтрүүлж, бодлогын ашиг сонирхлыг бодит үр дүнд хүргэхэд чиглэх хэрэгтэй.

(2) Гурван орны элчин сайдын яам, консулын газар хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд үүрэг гүйцэтгэх

Дипломат байгууллагууд "аж ахуйн нэгжийн хэрэгцээний мэдээллийн сан + төслийн мэдээллийн платформ"-ын хоёр чиглэлийн уялдаа холбооны механизмыг бүрдүүлж, гурван орны аж үйлдвэр, худалдааны салбарын уулзалтыг тогтмол зохион байгуулах хэрэгтэй. Жижиг, дунд үйлдвэрлэгчдэд хууль зүйн зөвлөгөө, эрсдэлийн анхааруулга зэрэг нийтлэг үйлчилгээг үзүүлж, хилийн үйл ажиллагааны зардлыг бууруулах шаардлагатай. Консулын бичиг баримтын "ногоон суваг"-ыг бий болгож, бизнес виз олгох үйл явцыг хялбарчлах хэрэгтэй. Улаанбаатар, Иркутск зэрэг хотуудад бизнесийн зөвлөх алба нэмж байгуулж, тухайн бүс нутгийн аж үйлдвэрийн бодлогын динамикийг цуглуулж, Хятадын компаниуд Орос, Монголын эрчим хүч, хөдөө аж ахуй зэрэг салбарт хөрөнгө оруулалт хийхэд зориулсан нарийн чиглүүлэлт үзүүлэх хэрэгтэй. Олон улсын худалдааны маргаан зөрчлийг шийдвэрлэх төвийг байгуулж, консулын хамгааллын хамтын ажиллагааны сүлжээг бүрдүүлэх шаардлагатай.

(3) Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд үнэн, объектив, бүрэн дүүрэн мэдээлэл өгч, тасдагдуулсан мэдээллээс зайлсхийх

Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын олон хэлний мэдээллийн хуваалцах платформыг бий болгож, дэд бүтэц, худалдааны хялбарчлал зэрэг чиглэлээр гарч буй дэвшлийн товч мэдээг тогтмол нийтлэх хэрэгтэй. Хилийн үзэсгэлэнт газруудаар аялан явах үйл ажиллагааг зохион байгуулж, Монголын малчид хилийн жуулчлалд оролцож, Оросын Алс Дорнодын иргэд Хятадын хөрөнгө оруулалтын ашиг хүртэж буй амьд дурсгалт жишээг объективоор тусгах хэрэгтэй. Шинэ медиа матрицыг бэхжүүлж, богино видео, виртуал бодит

байдал зэрэг технологийг ашиглан залуучуудын бүсийн хамтын ажиллагааны талаарх ойлголтыг нэмэгдүүлэх шаардлагатай.

(4) Харилцан хүндэтгэлтэй хандаж, бие биенээсээ суралцаж, үр дүнг хамтран бүтээж, хуваалцах

Эрчим хүчний хамтын ажиллагаанд "нөөц-төсөл" загварыг шинэчлэн, Монголын тал уул уурхайн бүтээгдэхүүний орлогоор Хятадын дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг төлөх хугацаатай төлбөрийн схемийг зөвшөөрөх хэрэгтэй. Гурван талын сэтгэлгээний танхимын холбоог байгуулж, Зүүн хойд Азийн үнэ цэнийн гинжин хэлхээний судалгааг хамтарсан хийж, ижил төстэй өрсөлдөөнөөс зайлсхийх хэрэгтэй. Алтайн бүс нутагт экологийн нөхөн төлбөрийн механизмыг туршиж, нөөцийн хайгуул, байгаль орчны хамгааллыг тэнцвэржүүлэх шаардлагатай. Хятад-Монгол-Оросын залуучуудын бизнес эрхлэх сан байгуулж, цахим худалдаа, байгальд ээлтэй аялал жуулчлал зэрэг нийтэд ашигтай төслүүдийг дэмжиж, коридорын дагуух иргэдэд нэгдлийн ашиг сонирхлыг бодитоор хүртээмжтэй болгох хэрэгтэй.

Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридор нь Хятад-Монгол-Оросын бүсийн хамтын ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд тодорхой алхам мөн чухал платформ юм. Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын бүтээн байгуулалт нь Хятад-Монгол-Оросын гурван талын хамтарсан дэмжлэгтэйгээр хилийн бүсийн хамтын ажиллагааг бий болгох шаардлагатай. Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорыг Хятад-Монгол-Оросын хилийн боомт хотуудаас эхлүүлж, жишээ үзүүлэх үүрэг гүйцэтгэх ёстой. Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын бүтээн байгуулалтыг саатуулж буй саад тотгоруудыг цэгнэж, арилгахын тулд Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын бүтээн байгуулалтаар бүсийн эдийн засгийн нэгдлийг дэмжих шаардлагатай. "Хятад-Европын галт тэрэг"-ээр Хятад-Монгол-Оросын коридорын дагуух аймаг, хотуудын эдийн засгийг хөдөлгөж, "салхины үр нөлөө"-г бий болгож, Хятад-Монгол-Оросын хамтын ажиллагааны "талбай"-гийг бүрдүүлж, механизмжсэн, институцижсан, стандартчилсан хөгжилд хүргэж, Хятад-Монгол-Оросын бүсийн хамтын ажиллагааны "загвар"-ыг бий болгож, хамтарсан цэцэглэлийг дэмжих ёстой.

Ашигласан материал:

1.田浩. (2023). 中蒙俄经济走廊：全球新挑战下的交通基础设施发展. 东北亚经济研究(6), 64-76.

2.米军 & 李娜. (2018). 中蒙俄经济走廊建设:基础、挑战及路径. 亚太经济(5), 5-12.

3.范丽君. (2024). "中蒙俄经济走廊"建设与新时代东北全面振兴战略研究. 学理论(2), 13-17.

4.郭连成,姜岩 & 孟一哲. (2022). 中蒙俄经济走廊的研究现状与未来展望. 欧亚经济, 96-111.

5.鄂晓梅. (2017). 中蒙俄经济走廊"五通"建设中的问题与对策. 内蒙古社会科学.

SPSIRPA FORUM 2025

Session 4-2

A Public Opinion Survey on Local Elections

Орон нутгийн сонгуулийн үр дүн болон олон нийтийн санаа бодлын судалгааны харьцуулсан шинжилгээ

Д.Ундрах

МУИС-ийн УТСОУХНУС-ийн Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч,

дэд профессор

Б.Эрдэнэдалай

МУИС-ийн УТСОУХНУС-ийн Улс төр судлалын тэнхимийн дэд профессор

Д.Түмэнжаргал

МУИС-ийн УТСОУХНУС-ийн Улс төр судлалын тэнхимийн дэд профессор

Удиртгал

УИХ-ын, Ерөнхийлөгчийн болон орон нутгийн сонгуульд оролцох сонгогчдын оролцоо 2000 оноос хойш буурсаар байгаа. 1992 оны орон нутгийн сонгуулийн ирцтэй харьцуулахад 2020 онд ирц 56% байсан нь 16%-аар, 2024 онд ирц 53.1% байсан нь 18.9%-аар[87] буурсан үзүүлэлттэй байна. Сонгуулийн ирц улам багасч 50%+1[88] гэсэн үндсэн шалгуурыг хангахгүй нэмэлт санал хураалт явуулах байдал 2020 он хүртэлх орон нутгийн сонгуулиудад ажиглагддаг байсан. Энэ нь орон нутгийн сонгуульд сонгогчдын санал ихээр гээгдэх, ИТХ-д ялалт байгуулсан төлөөлөгч сонгогчдын төлөөллийг хангаж чадахгүй байх нөхцөлийг бүрдүүлсээр байна. Гэхдээ 2020, 2024 оны орон нутгийн сонгуулийн ирцийн улсын дундаж дүн 56%, 53.1% байгаа ч, олон хэсгийн хороодод 50%-аас доош ирцтэй сонгууль болсон. Нөгөө талаараа, орон нутгийн сонгуулийг зохион байгуулах, төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд, улс төрийн намуудаас орон нутгийн сонгуульд ач холбогдол өгөх, орон нутгийн сонгуулийн мэдээллийг сонгогчдод хангалттай түгээх, мэдээлэх, цэгцтэй ойлголт өгөх зэрэг тулгамдаад байгаа асуудлуудыг шийдэхэд анхаарал хандуулдаггүй зэрэг олон хүчин зүйлс нөлөөлж байгаа юм.

Судалгааны арга, хамрах хүрээ, түүвэр. Судалгааг тоон судалгааны аргыг ашиглан Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн төлөөллийг оролцуулан судалгааны мэдээллийг цуглууллаа. Ингэхдээ 2021 оны 06 сард болсон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох сонгогчдын нэрсийн жагсаалтад 2,099,118 сонгогч бүртгэгдсэнийг үндэслэн 1268 иргэнийг “Орон нутгийн сонгуулийн талаарх иргэдийн ойлголт, хандлага тодорхойлох судалгаа”-нд хамруулан орон нутгийн сонгуульд ач холбогдол өгдөг эсэх, оролцоо, хандлага, хүчин зүйлийн хамт судлахыг зорьсон болно.

Орон нутгийн сонгууль, сонгогчдын оролцоо, үйл байдлын талаарх олон улсын судалгааны тойм

[87] Статистикийн үндэсний хорооны сайт дээрээс орон нутгийн сонгуулийн ирцийг авсан. www.1212.mn

[88] 2012 онд батлагдсан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль”-ийн 55-р зүйл “Сонгуулийн хэсгийн хороонд явуулсан санал хураалтыг хүчингүйд тооцох, дахин санал хураах” гэсэн заалтын 55.1.5-д “сум, баг, хороонд тухайн сум, баг, хорооны сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн нийт сонгогчийн 50-аас дээш хувь нь оролцоогүй бол уг сум, баг, хорооны 50-аас дээш хувь нь оролцоогүй хэсэг тус бүрд” гэж заажээ.

Орчин үед ардчилсан улс орнуудад үндэстэн дамнасан засгийн газрын хэрэгцээ, үүрэг өсөн нэмэгдэж, олон шатлалт засаглалын тогтолцоо хөгжиж байгаа хэдий ч орон нутгийн сонгууль, тэдгээрийн институциональ өөрчлөлт, сонгогчдын үйл байдлын талаарх нэгдсэн ойлголт, мэдээлэл хаа сайгүй хангалтгүй, хуваагдмал шинжтэй байна. Энэ чиглэлд хийгдсэн судалгааны ажлууд хийгээд хэвлэгдсэн бүтээлүүдийг шүүж үзэхэд орон нутгийн сонгуульд хандах хандлага нийтдээ адилхан хангалтгүй буюу доод түвшний сонгууль гэж үзэх хэвшмэл ойлголт тогтож, орон нутгийн сонгуулийг улс төрийн ач холбогдол багатай гэж үзсээр ирсэн болохыг судлаачид тэмдэглэсэн байдаг[89]. Сүүлийн үед Европын улсуудад орон нутгийн засаг захиргаа, орон нутгийн улс төрийг харьцуулан судлах сонирхол нэмэгдэж байгаа ба жишээлбэл, орон нутгийн бие даасан байдлын индексийн судалгаагаар орон нутгийн институциудын нөхцөл байдал болон Европ дахь төвлөрлийг сааруулах динамикийг системтэйгээр судлахыг зорьсон судалгаанууд хийгдэх болсон байна[90].

Орон нутгийн сонгууль хийгээд орон нутгийн сонгуулийн эргэн тойронд өрнөх улс төрийг судлах явдал нь төлөөллийн ардчилал, сонгуулийн хариуцлагын механизмыг ойлгоход онцгой чухал[91] хэмээн тэмдэглэснээс гадна орон нутгийн улс төрийн институциуд нь иргэдтэйгээ ойр байдаг бөгөөд орон нутгийн сонгуулийн тойргуудад нэг саналын үнэ цэнэ харьцангуй өндөр байдаг тул зайлшгүй судлан тодруулж, анхаарал хандуулах нь чухлыг цохон тэмдэглэсэн байдаг [92]. Оролцоо, өрсөлдөөн, сонгогчдын санал өгөлт зэрэг нь ихээхэн ялгаатай байдаг ч сонгуулийн чиг үүрэг нь үндэсний хэмжээнд биш орон нутагт илүү чухал байдаг тухай судлаач Веттер “Өрнөд Европын ардчиллын нөөц: Орон нутгийн улс төр үү?” бүтээлдээ цохон тэмдэглэжээ[93].

Орон нутгийн сонгуулийн ирц үндэсний хэмжээнд зохион байгуулагддаг бусад сонгуулиудаас ихэвчлэн бага байдаг ч ирцийн зөрүү нь улс орон болон цаг хугацаанаас хамаарч ихээхэн ялгаатай байгааг Их Британи ба Францын орон нутгийн сонгуулийн жишээн дээр хийсэн судалгаа харуулж байна[94]. Ван Хоувелингений 2017 онд хийсэн мета-шинжилгээгээр Нидерландад хотын хүн амын тоо нэмэгдэхийн хэрээр орон нутгийн сонгуулийн ирц буурч байгааг дурдаад үүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодруулах судалгаа зайлшгүй шаардлагатай байгааг тэмдэглэсэн[95] байна.

Орон нутгийн сонгууль дахь иргэдийн оролцоо, хандлага тодорхойлох судалгааны дүн

---

[89] Miller, W. L. (1988). Irrelevant elections? The quality of local democracy in Britain. Oxford University Press.

[90] Ladner, A., Keuffer, N., & Baldersheim, H. (2016). Measuring Local Autonomy in 39 Countries (1990–2014). Regional & Federal Studies, 26(3), 321-357.

[91] Clark, A., & Krebs, T. B. (2012). Elections and policy responsiveness. In: Mossberger, K., Clarke, S. E., & John, P. (Eds.). The Oxford handbook of urban politics. Oxford University Press.

[92] Blais, A. (2000). To vote or not to vote? The merits and limits of rational choice theory. University of Pittsburgh Press. Oliver, J. E., Ha, S. E., & Callen, Z. (2012). Local elections and the politics of small-scale democracy. Princeton University Press.

[93] Vetter, A. (2007). Local politics: a resource for democracy in Western Europe? Local autonomy, local integrative capacity, and citizens’ attitudes toward politics. Lexington Books

[94] Hoffmann-Martinot, V., Rallings, C., Thrasher, M. (1996), Comparing local electoral turnout in Great Britain and France: More similarities than differences? European Journal of Political Research, 30(2): 241-257.

Frandsen, A. G. (2002). Size and electoral participation in local elections. Environment and Planning C: Government and Policy, 20(6), 853-869.

[95] van Houwelingen, P. (2017). Political participation and municipal population size: A meta-study. Local Government Studies, 43(3), 408-428.

Судалгааны энэ хэсэгт орон нутгийн сонгуульд оролцож саналаа өгч буй болон өгөхгүй байгаа иргэдийн оролцоо, хандлагыг авч үзлээ.

Зураг 1. Сонгуульд оролцож саналаа өгөх нь чухал эсэх

“Таны бодлоор дараах сонгуулиудад оролцож саналаа өгөх нь хэр чухал вэ?” гэсэн асуултад УИХ болон Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох нь “маш чухал” гэж судалгаанд оролцогчдын 64%-68% нь хариулсан бол, 59% нь орон нутгийн сонгуульд оролцох нь “маш чухал” гэж хариулсан. Тодруулбал, иргэд орон нутгийн сонгуульд бага ач холбогдол өгдөг нь харагдаж байна.

Бүх түвшний сонгууль, түүний ач холбогдлын талаар сонгогчдод таниулах үйл ажиллагаанууд жигд, хүртээмжтэй хийгдэх ёстой ч УИХ-ын болон ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр энэ ажлууд илүү хийгддэг, орон нутгийн сонгуулийн үеэр багасдаг нь сонгогчдод орон нутгийн сонгуулийг ач холбогдолгүй мэт бодох, анхаарахгүй байх суурийг бий болгодог. Нөгөө талаасаа сонгогчдын орон нутгийн сонгуульд ач холбогдол өгөхгүй байх, нэмэлт санал хураалтыг тоохгүй, саналаа өгдөггүй зэргээс шалтгаалан 2020 оны Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн сонгуулийн тухай хуульд ирцийн 50%+1 босгыг байхгүй болгосон нь орон нутгийн сонгуулийн санал хураалтыг ямар ч тохиолдолд хүчинтэй байлгах заалт болсон. Гэвч энэ нь ардчилсан сонгуулийн суурь шаардлагыг хангахгүй байдалд хүргэж байна. Эндээс харахад цаашид сонгогчийн боловсролыг нэмэгдүүлэх, ялангуяа орон нутгийн сонгууль, орон нутгийн сонгуулиар бүрддэг тухайн орон нутгийн ИТХ-ын эрх үүрэг, ойлголтыг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага их байна.

Хүснэгт 1. Орон нутгийн сонгуульд санал өгч оролцох ач холбогдол, бүс нутгаар

Байршил	Маш чухал	Ер нь чухал	Нэг их чухал биш	Огт чухал биш	Мэдэхгүй	нийт
Баруун бүс	63%	30%	5%	1%	1%	100%
Зүүн бүс	64%	26%	3%	3%	3%	100%
Төвийн бүс	56%	29%	11%	1%	3%	100%
Улаанбаатар	55%	31%	10%	1%	3%	100%
Хангайн бүс	67%	29%	4%	0%	1%	100%
дундаж	59%	30%	8%	1%	2%	100%

Орон нутгийн сонгуульд санал өгөхийн ач холбогдлыг бүс нутгаар нь авч үзвэл, Баруун, Зүүн болон Хангайн бүс нутгийн аймгийн иргэд жигд 63%-67% нь “маш чухал” гэж үзсэн бол

Төвийн бүсийн аймгууд болон Улаанбаатар хотын иргэд 55%-56% нь “маш чухал”гэжээ. Харин эсрэгээрээр Төвийн бүсийн аймгууд болон Улаанбаатар хотын иргэд бусад бүс нутгаасаа илүү буюу 10-11% нь орон нутгийн сонгуульд оролцох нь “нэг их чухал биш” гэсэн хариултыг өгчээ. Төв бүсийн аймгууд болон Улаанбаатар хотын иргэд орон нутгийн сонгуульд ач холбогдол өгөх нь муу байна. Энэ нь орон нутагт аймаг, сумын сонгогчид тооны хувьд цөөн, орон нутгийн иргэдийг таньдаг, сонгуулийн сурталчилгаа өрх бүрт хүрэх боломжтой зэргээр сонгогчдыг сонгуулийн ач холбогдлыг илүү ойлгоход эерэг нөлөө үзүүлж байх талтай.

Зураг 2. Сонгуульд оролцож саналаа өгдөг эсэх

Хэдийгээр судалгаанд оролцогчид сонгуулийн оролцоог маш чухал хэмээн үнэлсэн боловч 69% нь УИХ-ын сонгуульд, 71% нь Ерөнхийлөгчийн сонгуульд, 54% орон нутгийн сонгуульд тогтмол оролцдог хэмээн хариулсан байна. Өөрөөр хэлбэл, иргэдийн 89% нь орон нутгийн сонгуулийг чухал хэмээн үзэж байгаа ч ердөө 54% нь тус сонгуульд тогтмол оролцдог гэж хариулсан.

Хүснэгт 2. Ажил эрхлэлтийн байдал ба орон нутгийн сонгуулийн оролцооны түвшин

	Тогтмол	Ихэвчлэн	Заримдаа	Саналаа өгдөггүй	Санал өгөх нас болоогүй байсан
Төрийн байгууллагад	66%	14%	11%	7%	1%
Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	59%	20%	12%	9%	1%
ОУБ-д	69%	23%	8%	0%	0%
ТББ-д	67%	19%	10%	4%	0%
Хувийн байгууллагад	48%	20%	17%	14%	1%
Малчин	61%	24%	12%	2%	0%
Тэтгэвэрт	86%	5%	8%	2%	0%
Группт	47%	33%	13%	7%	0%

Оюутан	34%	18%	17%	11%	20%
Ажил эрхлээгүй байна	49%	24%	12%	12%	4%

Дээрх хүснэгтэд ажил эрхлэлтийн байдал болон орон нутгийн сонгуулийн оролцоо хоорондын хамаарлыг харуулав. Тэтгэвэрт байгаа иргэдийн 86% нь орон нутгийн сонгуульд тогтмол оролцдог хэмээн хариулсан нь бусад бүлгийн иргэдтэй харьцуулахад илт давамгай өндөр байсан. Нөгөөтэйгүүр, оюутнуудын ердөө 34% нь орон нутгийн сонгуульд тогтмол оролцдог гэсэн хариултыг өгсөн байна. Хувийн байгууллагад ажиллагсдын ердөө 48% нь орон нутгийн сонгуульдаа тогтмол оролцдог гэсэн бол, энэ салбарт ажиллагсад хамгийн их буюу 14% нь орон нутгийн сонгуульд саналаа өгдөггүй болохоо илэрхийлжээ. Эндээс хувийн хэвшлийнхний орон нутгийн сонгуулийн оролцоо оюутнуудтай хамгийн ойролцоо буюу хангалтгүй хэмээн дүгнэхэд хүргэж байна.

Дээрх судалгааны дүнгүүдээс харахад, орон нутгийн сонгуулийг ер нь чухал, ач холбогдолтой гэж үздэг ч тухайн сонгуульд оролцож саналаа өгөх байдал муу байгааг тодруулах, цаашид орон нутгийн сонгуулийн ирц, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах хэрэгтэй. Энэ үүднээс орон нутгийн сонгуульд оролцох нь ач холбогдолтой гэж үзсэн ч сонгуульд саналаа өгөх оролцоо муу байгаа шалтгааныг тодруулах зорилгоор дараах асуултыг судалгаанд оролцогчдоос асуусан юм.

Хүснэгт 3. Орон нутгийн сонгуульд оролцож чадаагүй шалтгаан

Орон нутгийн сонгуульд оролцож чадаагүй шалтгаан	Хувь
Тухайн үед өөр газар байсан, шилжилт хөдөлгөөнөө урьдчилан хийлгэж чадаагүй, орон нутаг руугаа очиж саналаа өгөхөд цаг хугацаа, зардал мөнгө гарах тул орон нутгийн сонгуульд оролцож чадаагүй.	30%
Намууд, нэр дэвшигчид шударга биш, тэдний талаарх мэдээлэл ойлгомжгүй, хангалтгүй, бүрэн бус, итгэл хүлээлгэх нам, нэр дэвшигч байгаагүй учир санал өгмөөргүй санагдсан.	26%
Орон нутгийн сонгуульд санал өгөх нь ач холбогдолгүй, үр дүнг сонирхдоггүй, надтай надгүй сонгууль болдогоороо болно.	15.2%
Орон нутгийн сонгуульд оролцож, санал өгөх нь төвөгтэй, саналаа хэрхэн өгөх талаарх ойлголт байхгүй байсан учраас.	11%
Сонгуулийн үр дүнд итгэдэггүй учраас.	5.6%
Өмнө нь олон сонгогдсон төлөөлөгчид л дахин нэр дэвшдэг.	4.6%
Орон нутгийн ИТХ-ын хэт улс төржилтөөс залхсан учраас.	4.1%
Санал хураах байр хөгжлийн бэрхшээлтэй сонгогч надад хүртээмжгүй байсан учраас.	1.4%
Намайг хэнд саналаа өгч байгааг мэдчих вий гэж бодсон учраас.	1.2%

Мөнгө болон надад ашигтай зүйл өгөөгүй учраас.	0.6%
Нийт	100%

Орон нутгийн сонгуульд оролцож чадаагүй шалтгаан олон байсан боловч шалтгаануудыг нь багцлан харвал, шилжилт хөдөлгөөнөөс хамаарч 30% нь оролцож чадаагүй, улс төрийн шалтгаан буюу “намууд, нэр дэвшигчид шударга биш, тэдний талаарх мэдээлэл ойлгомжгүй, хангалтгүй, бүрэн бус, итгэл хүлээлгэх нам, нэр дэвшигч байгаагүй учир санал өгмөөргүй санагдсан”, “сонгуулийн үр дүнд итгэдэггүй, орон нутгийн ИТХ-ын хэт улс төржилтөөс залхсан учраас” гэж судалгаанд оролцогчдын 35.7% нь хариулсан байна. Харин “орон нутгийн сонгуульд ач холбогдол өгдөггүй” гэсэн шалтгаанаар судалгаанд оролцогчдын 15.2% нь саналаа өгөөгүй гэж хариулжээ.

Эндээс дүгнэхэд, шилжилт хөдөлгөөнөөс болж саналаа өгөөгүй, орон нутгийн сонгуульд ач холбогдол өгдөггүй гэж хариулсан иргэдээс гадна намууд, нэр дэвшигчид шударга биш, тэдний талаарх мэдээлэл ойлгомжгүй, хангалтгүй, бүрэн бус, итгэл хүлээлгэх нам, нэр дэвшигч байгаагүй учир санал өгмөөргүй санагдсан, сонгуулийн үр дүнд итгэдэггүй, орон нутгийн ИТХ-ын хэт улс төржилтөөс залхсан гэсэн хариултуудыг судалгаанд оролцогчдын 35.7% нь хариулсан нь цаашид орон нутгийн сонгууль зохион байгуулалт, үр дүн гаргах тогтолцоог сонгогчдод нээлттэй, хүртээмжтэй байдлаар зохион байгуулах, нэр дэвшигчдийн өрсөлдөөнийг шударга байлгах, орон нутгийн сонгуулийн талаарх мэдээллээс гадна нэр дэвшигчдийн мэдээллийг ойлгомжтой байдлаар сонгогчдод хүргэх, дээрх асуудлуудад иргэд болон иргэний нийгмийн байгууллагуудын мониторинг, хяналтыг нэмэгдүүлэх, ингэхдээ тухайн орон нутгийн иргэдийг оролцуулан зохион байгуулах зэрэгт анхаарах шаардлагатайг харуулж байна.

Орон нутгийн сонгуульд иргэд хэр зэрэг ач холбогдол өгдөг, тухайн сонгуульд оролцож саналаа өгдөг эсэх зэргээс гадна орон нутгийн сонгуулийг зохион байгуулахтай холбоотой оролцооны олон хэлбэрүүд байдгийг судалгаанд оролцогчдод таниулах, ойлголт өгөх, тэдний оролцдог байдлыг судлах зорилгоор дараах асуултыг тодрууллаа.

Хүснэгт 4. Орон нутгийн сонгуульд оролцдог хэлбэр

Оролцооны хэлбэр	Байнга	Заримдаа	Огт үгүй	Энэ талаарх ойлголт байхгүй
Орон нутгийн сонгуульд саналаа өгч оролцдог.	57%	25%	16%	2%
Орон нутгийн сонгуульд нэр дэвшиж байсан.	5%	9%	81%	5%
Орон нутгийн сонгуулийн үеэр Фейсбүүк/Твиттер зэрэг цахим орчинд санал бодлоо илэрхийлдэг.	12%	39%	46%	4%
Хэвлэл мэдээллийн хэрэгслээр (сонин, сэтгүүл, радио, телевиз гэх мэт) байр сууриа илэрхийлдэг.	7%	21%	68%	4%
Орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулгад саналаа өгдөг.	16%	28%	51%	5%
Жагсаал, цуглаанд оролцож байсан.	8%	28%	60%	4%

Улс төрийн намыг идэвхтэй дэмжиж оролцдог.	14%	25%	57%	4%
Санал хүсэлтээ бичгээр холбогдох газарт хүргүүлж оролцдог.	9%	20%	66%	5%
Нэр дэвшигчийн уулзалтад оролцож, саналаа илэрхийлдэг.	12%	29%	55%	4%
Амьдарч буй орон нутгийн удирдлагатай /Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал/ уулзаж, санал бодлоо илэрхийлдэг.	10%	28%	57%	4%
Орон нутгийн сонгуульд нэр дэвшиж буй нам, нэр дэвшигчид сонгуулийн хандив өгдөг.	6%	15%	74%	6%
Орон нутгийн сонгуулийн үйл ажиллагааны ажиглагчаар ажиллаж оролцдог.	9%	17%	69%	6%
Дундаж	14%	24%	59%	4%

Орон нутгийн сонгуулийн хувьд, судалгаанд оролцогчид сонгуульд саналаа өгөхөөс бусад оролцооны хэлбэрт огт үгүй гэсэн хариултыг давамгай өгсөн байна. Тодруулбал, иргэдийн 81% нь орон нутгийн сонгуульд огт нэр дэвшиж байгаагүй, 46% нь орон нутгийн сонгуулийн үеэр цахим орчинд үзэл бодлоо илэрхийлдэггүй, 68% нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлд байр сууриа илэрхийлдэггүй, 51% нь орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулгад саналаа өгдөггүй, 60% нь жагсаал, цуглаанд оролцож байгаагүй, 57% нь улс төрийн намыг идэвхтэй дэмждэггүй, 66% нь санал хүсэлтээ бичгээр холбогдох газарт хүргүүлж байгаагүй гэжээ. Харин орон нутгийн сонгуульд саналаа байнга өгдөг гэж судалгаанд оролцогчдын 57% нь хариулсан байна. Энэ хувь 1992 оноос хойш болсон орон нутгийн сонгуулиудын дундаж ирц болох 63%-аас бага байлаа. Эндээс цаашид орон нутгийн сонгууль, ИТХ-ын талаарх ойлголт, мэдээллийг иргэдэд түгээх, үр дүнтэй нөлөөллийн ажлууд хийхэд илүү анхаарах хэрэгтэйг харуулж байна.

Дээрх асуултаас сонирхол татсан хариулт бол, судалгаанд оролцогчдын 51% нь орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулгад саналаа өгдөггүй, 5% нь энэ талаар ойлголт байхгүй гэж хариулсан нь орон нутгийн шийдвэрлэх нэн шаардлагатай асуудлуудад иргэд оролцдоггүй, анхаардаггүйг харуулж байгаа төдийгүй, тухайн асуудлыг шийдвэрлэх эрх бүхий нутгийн өөрийн удирдлагын эрх, үүргийг мэдэхгүй байх талтай болох нь ажиглагдлаа. Судалгаанд оролцогчдын зөвхөн 16% нь орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулгад саналаа байнга өгдөг, харин 28% нь заримдаа саналаа өгдөг гэж хариулсан нь хангалтгүй үр дүн байв.

Орон нутгийн сонгуулийн талаарх иргэдийн ойлголт, сонирхлыг авч үзэхдээ улс төр хэр сонирхдог, орон нутгийн сонгуульд оролцож саналаа өгөхдөө чухалчилдаг зүйлс, сонгуулийн мөрийн хөтөлбөр уншиж танилцдаг байдал ба тухайн орон нутгаас сонгогдсон төлөөлөгчдийн таньдаг эсэх, орон нутгийн сонгуулийн зохион байгуулалт, тогтолцоо, нутгийн өөрийн удирдах байгууллагад нийгмийн бүлгүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх зэрэгтэй холбоотой зарим асуудлуудын талаарх ойлголт, сонирхлыг тодруулан харахыг зорилоо.

Зураг 3. Орон нутгийн сонгуульд саналаа өгөхөд чухалчилдаг хүчин зүйлс



Орон нутгийн сонгуульд оролцож саналаа өгөхдөө юуг нь илүү чухалчилж сонголтоо хийдэг вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 25% нь буюу 4 хүн тутмын нэг нь “мөрийн

хөтөлбөрийг нь уншиж танилцан сонголтоо хийдэг” гэсэн бол 32% нь “нэр дэвшигч нь хэн байгааг чухалчилдаг” буюу хүнийг нь харж сонголт хийдэг гэсэн хариулт өндөр хувьтай байна. Тэгвэл тухайн сонгогчид сонгуульд оролцож саналаа өгөхдөө нэр дэвшигчийн хэн байгааг чухалчлан үздэг бол тухайн тойргийн сонгуульд ялалт байгуулсан төлөөлөгчдийг таньж байгаа эсэхийг асуусан юм.

Зураг 4. Тодорхой албан тушаалтнуудыг таних эсэх



Иргэдийн дийлэнх хувь нь тухайн тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүн, Ерөнхий сайд, УИХ-ын дарга болон Ерөнхийлөгчөө таньж байсан бол ердөө 43%-44% нь өөрийн тойргоос сонгогдсон аймаг/нийслэл, сум/дүүргийн ИТХ-ын төлөөлөгчөө танина гэв.

Энэ нь орон нутгийн сонгуульд нэр дэвшигчид орон нутгийн сонгууль, түүний зохион байгуулалтын талаарх мэдээллийг сонгогчдод төдийлөн хүртээмжтэй хүргэж чаддаггүй, бүүр цаашилбал сонгуулийн ирц бага байсныг харуулж байна. Үүнээс гадна сонгогчдын орон нутгийн сонгуульд санал өгч оролцох оролцоо сул, орон нутгийн сонгуультай холбоотой асуудалд хайхрамжгүй ханддаг байдалтай холбоотой. Нөгөөтэйгүүр, нутгийн өөрөө удирдах байгууллагын төлөөлөгчид сонгогдсоныхоо дараа ИТХ-ын үйл ажиллагаанд иргэдтэйгээ хамтрах, санал солилцох, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, ИТХ-ын үйл ажиллагааг иргэдэд мэдээлэх зэрэг ажил сул хийдгийг харуулж болох юм.

Сонгогчдын зүгээс тухайн сонгуульд оролцож саналаа өгөхдөө чухалчилдаг зүйлийг судлахаас гадна аль ч сонгуулийн хувьд нэр дэвшигчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг уншиж судлан, харьцуулж сонголтоо хийх нь ардчиллын суурь зарчим байдаг. Тэгвэл судалгаанд оролцогчид орон нутгийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг уншдаг эсэхийг дараах асуултад тодрууллаа.

Зураг 5. Орон нутгийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг уншдаг эсэх



Судалгаанд оролцогчдын 59% нь орон нутгийн сонгуульд нэр дэвшиж буй нам, нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрийг тодорхой хэмжээгээр уншиж судлан сонголтоо хийдэг гэж хариулсан байна. Харин 15% нь мөрийн хөтөлбөрөөс өөр зүйлийг харгалзаж буюу нэр дэвшигчийн өөр бусад зүйлсийг хардаг, 7% нь гэр бүл ойр дотны хүмүүсийнхээ зөвлөгөөгөөр сонголтоо хийдэг бол 18% нь энэ асуултад хариулт өгөхөөс татгалзсан. Угаас орон нутгийн сонгуульд ач холбогдол өгөх нь бага, тухайн сонгуулийн өдөр саналаа өгөх боломжгүй буюу өөр газар шилжсэн байдаг, нэр дэвшигчдийн өрсөлдөөн шударга бус, ёс зүйгүй болдог зэрэг судалгааны дээрх хэсгүүдэд дурдагдсан шалтгаанууд байгаа бол орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрийг унших байдал бага байх нь ойлгомжтой. Харин орон нутгийн сонгуульд тогтмол, идэвхтэй оролцож байгаа иргэдийн хувьд сонгуулийн мөрийн хөтөлбөрийг уншиж танилцан сонголтоо хийдэг байх магадлалтай. Уг нь сонгуулийн мөрийн хөтөлбөр гэдэг бол тухайн сонгуульд нэр дэвшигчдийн зүгээс орон нутгийг хөгжүүлэх хөгжлийн бодлогыг сонгогчдод санал болгож байгаа баримт бичиг тул сонгогчид уг мөрийн хөтөлбөрийг сайтар уншиж танилцан, харьцуулж сонголтоо хийх ёстой байтал судалгаанд оролцсон иргэдийн 40% нь сонгуулийн мөрийн хөтөлбөрийг уншдаггүй, цаашилбал бүрэн уншдаггүй, ер нь уншдаггүй судалгаанд оролцогчдын хувь 65% байгаа нь орон нутгийн сонгуулийн мөн чанарын талаарх ойлголтгүй байгааг харуулж байна.

Манай улсад орон нутгийн сонгуулийг мажоритар тогтолцоогоор зохион байгуулдаг учраас тухайн нутгийн өөрөө удирдах байгууллагад ихэвчлэн 2-3 улс төрийн нам, эвсэл сонгогддог[96]. УИХ-ын сонгуульд мөн адил 2-3 улс төрийн нам, эвсэл олонх болж байсан. Эндээс судалгаанд оролцогчид орон нутгийн сонгуульд сонголт хийхэд нь УИХ-ын сонгуульд санал өгсөн байдал нөлөөлдөг эсэхийг тодруулах зорилгоор “УИХ-ын сонгуульд саналаа өгч дэмжсэн улс төрийн намыг орон нутгийн сонгуулийн үеэр дэмжин сонгож байсан уу?” гэсэн асуултыг асуулаа.

Зураг 6. УИХ-ын сонгуульд саналаа өгч дэмжсэн улс төрийн намыг орон нутгийн сонгуулийн үеэр дэмжин сонгож байсан эсэх, бүс нутгаар

[96] Азийн сангийн дэмжлэгээр МУИС-ийн Ардчилал судлалын төвийн багш, судлаачдын гүйцэтгэсэн “Монгол Улсын 2000 оноос хойших орон нутгийн сонгуулийн үр дүнд хийсэн шинжилгээ” судалгааны тайлан. УБ.,2022

Судалгаанд оролцогчдын хариултыг бүс нутгаар ангилж, харуулав. Хангайн бүсийн сонгогчдын хувьд УИХ-ын сонгуульд саналаа өгсөн намдаа орон нутгийн сонгуулиар дахин санал өгөх хувь (73%) харьцангуй өндөр байсан бол Улаанбаатар хотын сонгогчдын хувьд харьцангуй бага буюу (59%) байв. Эндээс орон нутгийн сонгогчид УИХ болон орон нутгийн сонгуульд нэг намын нэр дэвшигчдийг дэмжих хандлага илүү байна.

Зураг 7. Орон нутгийн сонгуульд нэр дэвшигчид бодлогын мэтгэлцээн хийж байсан эсэх, бүс нутгаар



Өмнө дурдсанчлан орон нутгийн сонгуульд нэр дэвшигчид бодлогын мэтгэлцээн хийдэггүй гэж судалгаанд оролцогчид дүгнэснийг бүс нутгаар ангилж харуулав. Баруун бүсийн иргэд энэ төрлийн мэтгэлцээн болдоггүй гэсэн бол, төвийн бүсийн иргэд харьцангуй өндөр хувьтайгаар орон нутгийн сонгуульд нэр дэвшигчид бодлогын мэтгэлцээн хийдэг, заримдаа хийдэг гэсэн хариултууд өгсөн байна.

Хүснэгт 5. Орон нутгийн сонгуультай холбоотой зарим асуудал оновчтой эсэх

Үзүүлэлт	Оновчтой	Дунд зэрэг	Оновчгүй	Энэ талаарх ойлголт алга	Нийт
Орон нутгийн сонгуулийн тогтолцоо	12%	54%	24%	10%	100%
Орон нутгийн сонгууль хүчин төгөлдөр болох ИРЦийн 50%+1 гэсэн "босго" байхгүй болсон.	15%	38%	28%	19%	100%
Орон нутгийн сонгуулийн санал хураах үеэр өөр газар ажиллаж, сурч, амьдарч байгаа бол тухайн байгаа газраасаа сонгуульд оролцож саналаа өгөх	39%	32%	18%	11%	100%
Орон нутгийн сонгуульд улс төрийн намаас нэр дэвшигчийг дэвшүүлэх	17%	39%	32%	13%	100%
Орон нутгийн сонгуульд улс төрийн намаас бус орон нутгийн иргэдээс нэр дэвшигч дэвших	35%	38%	16%	11%	100%

Судалгаанд оролцогчдын 78% нь орон нутгийн сонгуулийн тогтолцоог, 66% нь орон нутгийн сонгууль хүчин төгөлдөр болох ирцийн 50%+1 гэсэн “босго” байхгүй болсон, 71% нь орон нутгийн сонгуульд улс төрийн намаас нэр дэвшигчийг дэвшүүлэх нь “дунд зэрэг оновчтой” болон “оновчгүй” хэмээн дүгнэлээ. Мажоритар сонгуулийн тогтолцооны сул талууд болох сонгогчдын саналыг нутгийн өөрөө удирдах байгууллагад төлөөлж чадахгүй ихээр гээж байгаа, нөгөө талаас иргэд орон нутгийн сонгуулийг тоохгүй байх, саналаа өгөхгүй байгаагаас дахин болон нэмэлт санал хураалтыг зохион байгуулдаг. Мөн 2020 болон 2024 оны орон нутгийн сонгуульд ирцийн босгыг байхгүй болгосон нь сонгуулийн тогтолцооны сул талыг улам нэмж байна.

Судалгаанд оролцогчдын 71% нь орон нутгийн сонгуулийн санал хураах үеэр өөр газар ажиллаж, сурч, амьдарч байгаа бол тухайн байгаа газраасаа сонгуульд оролцож саналаа өгөхийг ихээр дэмжсэн байгаа нь бодлогын хувьд шийдэх хэрэгтэйг харууллаа. Харин судалгаанд оролцогчдын 73% нь орон нутгийн сонгуульд улс төрийн намаас бус орон нутгийн иргэдээс нэр дэвшигч дэвшихийг “дунд зэрэг оновчтой”, “бүрэн оновчтой” гэж хариулсан нь цаашид орон нутгийн ИТХ-ыг тойрсон улс төржих, улс төрийн намаар талцах зэрэг асуудлыг шийдэх шаардлагатай байна. Уг асуултуудад “энэ талаарх ойлголт алга” гэж хариулсан судалгаанд оролцогчдын хувь энэхүү судалгааны бусад асуултын хариултуудтай харьцуулахад хамгийн өндөр байсан нь цаашид энэ талаарх ойлголтуудыг өгөх, ач холбогдлыг ойлгуулах нэн хэрэгцээтэйг харуулж байлаа.

Нутгийн өөрөө удирдах байгууллагад нийгмийн зарим бүлгийн төлөөлөл байх хэрэгцээ шаардлагыг иргэд хэрхэн харж буйг тодруулах зорилгоор дараах асуултуудыг асуулаа.

Зураг 8. Иргэдийн төлөөлөгчдийн хуралд тодорхой бүлгийн төлөөллийг нэмэгдүүлэх тухай



Судалгаанд оролцогчдын 95% нь залуучуудын төлөөллийг, 94% нь эмэгтэйчүүдийн төлөөллийг, 89% нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд (ХБИ)-ийн төлөөллийг ИТХ-д нэмэгдүүлэхийг дэмжсэн. Эндээс сонгогчид ИТХ-д тодорхой бүлгийн төлөөллийг нэмэгдүүлэх нь ач холбогдолтойг анзаарч байна. Ер нь өмнөх жилүүдийн орон нутгийн сонгуулийн үр дүнгээс харахад өнөөдрийг хүртэл ИТХ нь тодорхой бүлгийн төлөөллийг харгалзахгүй, үүнд ач холбогдол өгөхгүй байгаа. Зөвхөн эмэгтэйчүүдийн квотыг сонгуулийн тухай хуульд тусгадаг ч сонгогдсон төлөөлөгчдийг хүйсээр ялган дүгнэлт хийх боломж Сонгуулийн ерөнхий хорооны нэгтгэгдсэн мэдээллийн санд байхгүй.

Орон нутгийн сонгуулийн талаарх мэдээллийг хэрхэн хүлээн авдаг, тэдгээр мэдээллүүд хэр хүртээмжтэй байдаг зэргийг дараах асуултаар тодруулсан юм.

Зураг 9. Орон нутгийн сонгуулийн талаарх мэдээллийн хүртээмжийн үнэлгээ



Орон нутгийн сонгуулийн талаарх мэдээллийг сонгогчдод түгээж байгаа нь сонгогчдод хэр зэрэг хүртээмжтэй эсэхийг үнэлэх асуултад судалгаанд оролцогчдын 31% нь сайн, 42% нь дунд, 27% нь муу, огт авдаггүй болон энэ талаарх ойлголт алга гэж хариулсан. Гэхдээ тухайн сонгогч орон нутгийн сонгуулийн талаарх мэдээллийг хэр зэрэг сонирхдог вэ, сонгогчийн боловсрол олгох мэдээллийг хүлээн авч байна уу, нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааны мэдээлэл, мөрийн хөтөлбөрийн талаарх мэдээлэл зэргийн алийг түлхүү хүлээн авдгийг ялгаж судлах хэрэгтэй байна. Иргэдийн мэдээлэл хүлээн авдаг суваг (зөвхөн улс төрийн бус) болон тухайн мэдээллийг ямар

хэлбэрээр хүлээн авахыг хүсдэг нь мэдээллийн хүртээмжийг, мөн сонгуулийн талаарх мэдээллийг тэдэнд хүргэх, ач холбогдлыг нэмэгдүүлэх зэрэг ач холбогдолтой билээ.

Тухайн орон нутгийн хөгжлийн талаарх иргэдийн үнэлгээ

Судалгааны энэ хэсэгт тухайн орон нутгийн нөхцөл байдалд иргэд хэр сэтгэл хангалуун байдгийг тодруулсан.

Хүснэгт 6. Орон нутгийн нөхцөл байдалд сэтгэл хангалуун байдал, бүс нутгаар

	Баруун бүс	Зүүн бүс	Төвийн бүс	УБ	Хангайн бүс	Үндэсний дундаж
Орон нутгийн бодлого, төлөвлөлт	66%	68%	71%	51%	61%	59%
Орон нутгийн өрсөлдөх чадвар	56%	67%	63%	48%	49%	53%
Орон нутгийн төсөв	49%	53%	52%	41%	42%	45%
Орон нутгийн дэд бүтэц	50%	56%	61%	45%	50%	49%
Боловсролын хүртээмж	64%	73%	60%	46%	56%	54%
Эрүүл мэндийн үйлчилгээ	52%	46%	55%	44%	44%	47%
Орон нутгийн иргэдийн амьдрал, амьжиргааны түвшин	48%	44%	52%	38%	47%	43%
Ажлын байр	49%	42%	42%	36%	40%	40%
Бизнес эрхлэх таатай орчин	47%	43%	46%	35%	42%	40%
Амьдрах орчин, ахмад настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдал	45%	44%	49%	35%	45%	41%
Орон нутгийн удирдлагад цахимаар санал хүсэлтээ өгөх, холбогдох боломж	46%	45%	48%	37%	49%	43%
Бусад	46%	45%	47%	33%	42%	39%

*мөр бүрээс хамгийн өндөр болон хамгийн бага хувийг тодруулав.

Дээрх хүснэгтэд иргэдийн орон нутгийн нөхцөл байдлын талаарх сэтгэл хангалуун байдлыг бүс нутгаар ангилж харуулсан. Улаанбаатар хотын нөхцөл байдал (бизнес эрхлэх орчин, хүртээмж, амьжиргааны түвшин зэрэг)-д сэтгэл хангалуун иргэдийн хувь бусад аймгуудтай харьцуулахад бүх үзүүлэлтээр хамгийн доогуур байлаа. Тухайлбал, орон нутгийн төлөвлөлтийн талаар төвийн бүсээс судалгаанд оролцсон иргэдийн 71% нь маш сэтгэл хангалуун болон зарим талаар сэтгэл хангалуун гэсэн хариултыг өгчээ. Харин Улаанбаатар хотын хувьд тухайн хэмжээ 51% болон буурсан байна.

ДҮГНЭЛТ

Орон нутгийн сонгуульд оролцож саналаа өгөх, бүр тодруулбал нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн оролцоо, хяналт маш чухал нөлөөтэй бөгөөд тухайн амьдарч буй орон нутгийн иргэдэд тулгарч буй асуудлуудыг иргэдийн оролцоотойгоор, иргэдийн өөрсдийнх нь саналаар шийдэх тогтолцоо юм. Гэтэл орон нутгийн төлөөллийн байгууллагын үйл ажиллагаанд иргэд оролцдоггүй, анхаарч үздэггүй зэрэг нь орон нутгийн сонгуульд саналаа өгөхгүй байгаатай адил болсон. Эндээс харахад, орон нутгийн сонгууль дахь сонгогчдын ирц, оролцоо хангалтгүй, хязгаарлагдмал байна. Цаашид орон нутгийн сонгуулийн талаарх иргэдийн ойлголт тодорхойлох, сонгогчдын хэрэгцээ шаардлага, үйл байдлыг, орон нутгийн сонгуульд саналаа өгөхөд тулгамдаж буй асуудлуудыг нарийн судлах, судалгааны үр дүнд үндэслэн шийдвэрлэх арга замыг тодорхойлох, олон нийтэд орон нутгийн сонгуулийн талаарх зөв, цэгцтэй мэдээллийг өгөх, нөлөөллийн ажлуудыг хийх боломжтой.

Иймээс Сонгуулийн ерөнхий хороо, төрийн болон төрийн бус байгууллагууд, улс төрийн нам, ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулийн удирдлага, багш, судлаачид сонгогчдыг орчин үеийн мэдээллийн технологийн дэвшил, хэвлэл мэдээллийн хэрэгслийг нийгмийн амьдралд илүү идэвхтэй оролцоход ашиглах боломж нээлттэй байгаа зэргийг бүрэн ашиглаж сонгуульдаа идэвхтэй оролцохыг уриалах, идэвхжүүлэх, заах, үлгэрлэх зэргээр ажиллах нэн шаардлагатай байна.

САНАЛ

Хууль, эрх зүйн зохицуулалтын хүрээнд:

- Монгол Улсын Үндсэн хууль, Сонгуулийн тухай хууль, Намын тухай хууль зэрэг хуулиудад сонгогчдын улс төрийн эрх, үүрэг болон сонгуульд оролцох оролцоотой холбоотой бүхий л асуудлыг нарийн тусгаж, сонгогчдын улс төрийн идэвхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн зүйл заалтуудыг тусгаж өгөх.
- Сонгогчдын улс төрийн боловсролыг дээшлүүлэх, сонгуулийн хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, мэдээ мэдээллийг олон нийтэд таниулах ухуулга сурталчилгааг зөвхөн иргэний нийгмийн байгууллага гэхгүйгээр төрийн байгууллагууд, улс төрийн намууд санаачилдаг, зохион байгуулдаг зохицуулалт бий болгох.

Бүтэц, зохион байгуулалтын асуудлын хүрээнд:

- Орон нутгийн сонгуулийг зохион байгуулах, уг сонгуультай холбоотой мэдээллийг түгээх, сонгуульд өрсөлдөх гэж байгаа нэр дэвшигчдийг бүртгэх зэрэг асуудлыг технологийн дэвшлийг ашиглах, цахим байдлаар зохион байгуулах.
- Гадаадад оршин суугаа, бүртгэлтэй хаяг дээрээ амьдраагүй, ковид зэргээс шалтгаалсан олон нийтийг хамарсан хөл хорионы улмаас саналаа өгч чадахгүй байгаа иргэдийн саналыг авах дэвшилтэт аргуудыг орон нутгийн сонгуулийн үйл ажиллагаанд яаралтай нэвтрүүлэх. Тухайлбал, мэйлээр, онлайнаар саналаа өгөх зэрэг аргуудыг хэрэглэх. Ингэхдээ нууцлал, аюулгүй байдлыг сайтар хангах.

- Тусгай зориулалтын брайль үсэг бүхий хавтас санал хураах байр бүрд байх, санал авах байр тэргэнцэртэй сонгогчид чөлөөтэй нэвтрэх боломжтой байх, мөн хэл, ярианы бэрхшээлтэй сонгогчдод өгсөн заавар бүхий контентуудыг сонгогчдод нээлттэй түгээх. Тухайн нөхцөл байдлыг бодит байдал дээр хүртээмжтэй байгаа эсэхэд хяналт, мониторинг хийж алдаатай, дутуу зүйлсийг засах, яаралтай шийдвэрлэдэг байхыг тухайн хэсгийн хороодод үүрэг болгох.
- Орон нутгийн сонгуулиар дамжуулан иргэдийн төлөөлөгчдийн хуралд нийгмийн тодорхой бүлгийн буюу залуучууд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байгааг улс төрийн нам, нэр дэвшигчид анхаарах, тэднийг чадавхжуулах хөтөлбөр бий болгох.

Орон нутгийн сонгуулийн талаарх мэдлэг, ойлголтыг түгээх ажлын хүрээнд:

- Орон нутгийн сонгуулийн ач холбогдол, санал өгөхөд анхаарах зүйлсийн талаарх ойлголт, мэдээллийг ойлгомжтой, хялбар байдлаар сонгогчдод хүргэх.
- ИТХ-ын талаарх ойлголт бага учраас орон нутгийн сонгуулийг иргэд үл тоомсорлох, саналаа өгөхгүй байх хандлага судалгааны хүрээнд ажиглагдсан. Иймээс орон нутгийн сонгуулиар бүрддэг буюу иргэдэд хамгийн ойр шийдвэр гаргадаг төлөөллийн байгууллага болох ИТХ-ийн талаарх ойлголт, мэдээллийг иргэдэд ойлгомжтой, хялбар байдлаар, тогтмол хүргэж хэвших.
- Иргэдийн сонгуулийн оролцоог зөвхөн санал өгөх хязгаарлагдмал хүрээнд авч үзэлгүй улс төрийн нам, бүх шатны сонгуульд нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөртэй танилцах, уулзалтад очих, үзэл бодлоо илэрхийлэх, хандив өгөх, өөрөө нэр дэвших, холбогдох газарт санал хүсэлт гаргах зэрэг өргөн хүрээнд сурталчлан таниулах.
- Орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдийн дэвшүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, биелэлтийг тухайн орон нутгийн иргэд хянах, сонгогчдод мэдээлэх, хэлэлцэх. Ингэхдээ тухайн орон нутгийн иргэдийн дунд цахим нээлттэй талбаруудыг нээн тогтмол ажиллуулах.
- Орон нутгийн сонгуульд сонгогчдын оролцоо хандлагыг нэмэгдүүлэх чиглэлд нөлөөллийн ажлыг сонгууль зохион байгуулах чиг үүрэг бүхий байгууллагууд сонгогчид, иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагууд, улс төрийн намуудын дэмжлэгтэйгээр тогтмол зохион байгуулж хэвших. Ингэхдээ тухайн орон нутгийн иргэдийг оролцуулан зохион байгуулахыг анхаарах.

НОМ ЗҮЙ

- Blais, A. (2000). To vote or not to vote? The merits and limits of rational choice theory. University of Pittsburgh Press.
- Clark, A., & Krebs, T. B. (2012). Elections and policy responsiveness. In: Mossberger, K., Clarke, S. E., & John, P. (Eds.). The Oxford handbook of urban politics. Oxford University Press.
- Hoffmann-Martinot, V., Rallings, C., Thrasher, M. (1996), Comparing local electoral turnout in Great Britain and France: More similarities than differences? European Journal of Political Research, 30(2): 241-257.
- Ladner, A., Keuffer, N., & Baldersheim, H. (2016). Measuring Local Autonomy in 39 Countries (1990–2014). Regional & Federal Studies, 26(3), 321-357.
- Marschall, M. (2010). The Study of Local Elections in American Politics. J. Leighley (Ed.) The Oxford Handbook of American Elections and Political Behavior. Oxford University Press.
- Miller, W. L. (1988). Irrelevant elections? The quality of local democracy in Britain. Oxford University Press.
- Oliver, J. E., Ha, S. E., & Callen, Z. (2012). Local elections and the politics of small-scale democracy. Princeton University Press.
- Van der Kolk, H. (2007). Local electoral systems in Western Europe. Local Government Studies, 33(2), 159-180.
- Van Houwelingen, P. (2017). Political participation and municipal population size: A meta-study. Local Government Studies, 43(3), 408-428.
- Vetter, A. (2007). Local politics: a resource for democracy in Western Europe? Local autonomy, local integrative capacity, and citizens' attitudes toward politics. Lexington Books.

SPSIRPA FORUM 2025

Session 4-3

A Study on China-Mongolia Cooperation in Renewable Energy within the Framework of the Belt and Road Initiative

共建“一带一路”视域下中蒙可再生能源合作研究

照日格图[1],黄佟拉嘎[2]

（1.　　内蒙古自治区社会科学院 内蒙古一带一路研究所，内蒙古 呼和浩特010010；2.上海交通大学国际与公共事务学院博士后，上海交通大学动力与工程学院（联合培养），研究方向为国际关系研究）

摘要：应对气候变化，推进可再生能源国际合作是共建“一带一路”的重要内容之一。在全球能源转型加剧背景下，中蒙两国就应对气候危机达成共识，坚持绿色、低碳和可持续发展理念，促进两国绿色发展政策沟通，推进可再生能源领域合作，取得了积极成效。在共建“一带一路”倡议下，借力可再生能源产业的互补性，在水力、风能、太阳能等可再生能源领域加强合作，统筹推进标志性工程和“小而美”民生项目，可以全面提升两国经贸合作的规模、质量和水平，共同实现两国可持续发展的目标。

关键词：中蒙；可再生能源；“一带一路”；合作

可再生能源是指在自然界中可以不断再生、永续利用的资源，它对环境无害或危害极小，而且资源分布广泛，适宜就地开发利用，主要包括太阳能、风能、水能、生物质能、地热能和海洋能等。蒙古国地处东北亚，国土面积156.65万平方公里，是世界第二大内陆国，是共建“一带一路”之中蒙俄经济走廊的重要结点国家，蒙古国太阳能、风能等可再生能源资源丰富，在可再生能源国际合作中具有潜在的机遇和优势。中蒙两国可再生能源合作不仅可以推动两国可持续发展，也未全球能源转型和环境保护具有重要意义。

一、蒙古国可再生能源资源开发利用现状

为充分挖掘可再生能源的潜力，推进可再生能源的发展，近年来，蒙古国确定可再生能源发展的短期和中长期目标，推出诸多激励和优惠政策，将发展可再生能源列为能源领域的优先发展方向。

（一）蒙古国可再生能源资源禀赋

蒙古国水资源比较丰富，但是大多数的水资源集中在国家的西部和北部山区。目前，蒙古国大约有13个水力发电厂正在运营，装机容量从150千瓦到12兆瓦，现有水电站规模普遍较小，在全国装机容量中占比只有2%，发电量占全国电力生产的0.75%(不含进口)。[1]

蒙古国拥有大量的太阳能潜力。蒙古国总国土面积的71%接收的太阳能能量密度为每天每平米5.5—6千瓦时，每年2900—
3000小时的日照时间。[1]另外，还有18%的国土面积接收的太阳能能量密度为每天每平米4.5—5.5千瓦时，每年2600—2900小时的日照时间。[1]

风能也是蒙古国最重要的可再生能源之一。据美国可再生能源实验室（NREL）在2001年对蒙古国的评估，在其国土上有16万平方公里（占总国土面积的10%）适合建造高功率的风力发电场，在上述风力资源最为富集的地区，以30米高度为标准，预计装机总容量为1.1太瓦，年均发电2550太瓦时。[2]近年来，蒙古国越来越重视风力发电项目，位于中央省的Salkhit、南戈壁省的Tsetsii、东戈壁省的Sainshand等三大风力发电厂先后投入运行。据世界可再生能源协会预测，蒙古国包括太阳能、风能和水能在内的可再生能源总量在2.6太瓦左右，仅风、光发电两项，就可以满足2030年整个中国的用电需求。[3]

（二）蒙古国可再生能源发展目标

2014年，蒙古国国家大呼拉尔（议会）通过的《国家绿色发展政策》，提出可再生能源发展的两阶段目标，即到2020年，可再生能源发电的装机比重将从014年的7%上升到20%，到2030年，再上升到30%。[4]2016年，蒙古国国家大呼拉尔（议会）通过的《蒙古国2030可持续性发展目标》，提出2016—
2030年，分三阶段实现可再生能源占国家能源消费的比例分别达到20%、25%和30%。[5]2020年，蒙古国国家大呼拉尔（议会）通过的蒙古国“远景—2050”（“Алсын хараа-2050”）
长期发展政策，重新提出可再生能源发展目标，到2030年将可再生能源装机容量提高到30%，到2030年减少温室气体排放22.7%（1690万吨），其中能源生产和供应领域到2030年水平将减少834万吨。[6]蒙古国先后加入《联合国气候变化框架公约》《巴黎协定》，设定其碳减排目标为：到2030年将碳排放总量从7420万吨降低至1690万吨。[7]

（三）蒙古国可再生能源发展的政策法律支持

2007年蒙古国国家大呼拉尔（议会）通过了《可再生能源法》[8]，明确了国家机关在可再生能源发展中的权力与义务，建立了可再生能源的许可证制度以及电价标准。《可再生能源法》的颁布实施，在整体上规范了蒙古国国内可再生能源的开发和利用行为。据统计，
蒙古国能源监管委员会在2008年至2018年向39个法人实体授予了可再生能源特别建设许可证，总容量达到1352.4兆瓦。[9]为了加快可再生能源发电的并网进程并提高其使用效率，蒙古国国家大呼拉尔（议会）分别于2015年和2019年对《可再生能源法》进行了修订，进一步规范了可再生能源发展的补贴政策。2019年修订的《可再生能源法》特别明确了在不同规模和不同时间段内，风电、太阳能等可再生能源发电的上网电价[10]，具体实际价格则由电力协调委员会制定连接电网可再生能源电厂输送的电力价。[8]这一举措不仅为可再生能源的投资者提供了更加明

确的市场预期，还降低了投资风险，吸引了更多的国内外投资者参与到蒙古国的可再生能源项目中。

（四）蒙古国可再生能源发展国际合作

政策扶持方面，2024年9月蒙古国政府公布了2024—2028年将要实施的14个大项目，其中包括推动额尔登布伦水电站项目、额吉河水电站项目、可再生能源及分布式资源开发项目。[11]这些大型项目的实施将提升蒙古国水电站发电量，推动可再生能源的利用，有利于优化能源结构，促进政府将更多的资金和资源投入到可再生能源领域。招商引资方面，2018年11月，亚洲开发银行（ADB）与蒙古国政府签署了总金额为8560万美元的可再生能源开发及税收管理项目的协议。[12]2022年美国政府提供了300万美元用于实现蒙古国能源部门的现代化。[13]2024年6月，蒙古国与国际金融公司（IFC）达成协议，旨在推动风能项目的发展，利用私人投资支持该国的风能开发。[14]目前，蒙古国风能装机容量为155兆瓦，但其风能潜力估计高达209000兆瓦，足以满足国内电力需求，为能源结构多样化提供新的动力。推动能源出口方面，通过发展可再生能源，蒙古国不仅可以满足国内电力需求，还可以依靠丰富的可再生能源资源，生产清洁电力，通过连接东北亚超级网络，建设连接两个邻国的高压输电线路等举措，将可再生能源资源出口至邻国或东北亚地区，增加外汇收入。

二、中蒙两国可再生能源合作现状

（一）推进可再生能源合作成为中蒙两国的战略共识

2014年，中蒙两国签署了《中华人民共和国和蒙古国关于建立和发展全面战略伙伴关系的联合宣言》（以下简称《宣言》），《宣言》指出两国将“结合本国能源发展战略和各自实际需求，进一步加强电力、可再生能源领域合作。”[15]2022年，中蒙两国政府共同发布了《中华人民共和国政府和蒙古国政府联合声明》（以下简称《声明》），《声明》提出“支持两国企业按照市场原则和商业规则就扩大煤炭等矿产品贸易开展长期稳定合作，探讨在蒙古国南部地区实施太阳能、风能等可再生能源项目。”[16]2022年，两国共同发布了《中华人民共和国和蒙古国关于新时代推进全面战略伙伴关系的联合声明》，双方商定“将加快推动中蒙铁路、公路、口岸等基础设施和矿能资源大项目合作，在清洁能源领域打造示范性项目，全面提升中蒙经贸合作的规模、质量和水平。”[17]2023年，在“一带一路”国际合作高峰论坛期间，中蒙双方签署了《额尔登布伦水电站建设项目专项贷款协议》。可见，好邻居、好朋友、好伙伴的双边关系以及坚实良好的政治关系是未来中蒙两国深化可再生能源合作的重要政治和法律基础。

（二）务实合作为中蒙可再生能源合作提供了经验

共建“一带一路”是中蒙两国可再生能源合作的重要引擎。随着中国共建“一带一路”倡议和蒙古国“草原之路”发展战略的对接，两国能源领域务实合作不断加强

，重大合作项目不断得到落实，为两国可再生能源合作创造了新机遇。一方面，中蒙电网互联互通的首期项目——
锡伯敖包煤电输一体化项目，中蒙能源领域合作的标志性项目——
巴格诺尔电站项目，共建中蒙俄经济走廊的重大合作成果——
乌兰巴托市至曼德勒戈壁输变电线路、变电站建设项目，共建中蒙俄经济走廊的标志性项目——
额尔登特铜矿自备电厂等重大能源项目先后启动完成[18]，为双方在可再生能源等领域合作打下了坚实基础。另一方面，中国内蒙古自治区深度服务和融入共建“一带一路”，全面参与中蒙俄经济走廊建设，在中蒙陆地边界线上，已建成8条向蒙古国南部地区供电通道。通过巴彦淖尔市甘其毛都、阿拉善盟策克、包头市满都拉、锡林郭勒盟嘎达布其和二连浩特5个口岸，向蒙古国南部边境口岸、厂矿企业输送着源源不断的电能[19]，这进一步推动了内蒙古风电、光伏等可再生能源的外送蒙古国，为蒙古国南部边境地区的经济社会发展提供充足的电能，为促进中蒙可再生能源等领域深化合作提供了更多可能。

三、中蒙可再生能源合作的前景展望

（一）中蒙可再生能源合作，可实现共同的发展目标

2014年，蒙古国提出“国家绿色发展政策”，2015年加入“巴黎协定”，并承诺到2030年减少温室气体排放22.7%。[20]2020年5月13日，蒙古国国家大呼拉尔（议会）审议通过了蒙古国长期发展规划纲要性文件“远景-2050”（“Алсын хараа-2050”），作为其国家长期发展的路线指引，重点是构建、发展国家绿色金融体系，支持环保高效清洁技术和节能消费；减少能源、农牧业、建筑、运输、工业、垃圾处理等领域碳排放。[21]2020年9月22日，习近平在第七十五届联合国大会一般性辩论上发表重要讲话，并提出中国“二氧化碳排放力争于2030年前达到峰值，努力争取2060年前实现碳中和”的目标。[22]2022年6月1日，中国国家能源局发布《“十四五”可再生能源发展规划》（以下简称《规划》），《规划》提出“2025年，可再生能源年发电量达到3.3万亿千瓦时左右”的目标，同时《规划》还重点强调要加强应对气候变化国际合作，积极参与全球能源转型变革，深层次推进可再生能源产业国际合作。[23]因此，中蒙两国将可再生能源合作列为两国经贸合作的重要内容，可实现两国共同的可持续发展目标。

（二）中蒙可再生能源合作，可实现市场优势互补

中国在全球可再生能源发展中发挥着举足轻重的作用。2023年全球可再生能源新增装机5.1亿千瓦，其中中国的贡献超过了50%。[24]2023年，中国可再生能源总装机达到14.5亿千瓦，占全国发电总装机超过50%，历史性超过火电装机，风电光伏年新增装机接近全球年新增装机的60%。[25]中国风电光伏产业国际竞争优势进一步提升，已经成

为全球可再生能源发展的不可或缺的力量。国际可再生能源署报告指出，过去十年间，全球风电和光伏发电项目平均度电成本分别累计下降超过了60%和80%，这其中很大一部分归功于中国创新、中国制造、中国工程。从贸易结构来看，中蒙两国资源禀赋市场互补性较强。因此，中蒙加强可再生能源合作，发挥两国经贸合作的独特优势，可实现互利共赢。

（三）中蒙可再生能源合作，可共同应对气候变化挑战

蒙古国官方数据显示，在过去的80年中，蒙古国平均气温上升约2.25摄氏度，是世界平均水平的两倍；在过去的40年中，蒙古国每年的炎热天数增加了近20天；而在过去不到15年中，蒙古国经历了过去80年中最热的10年；在过去的10年里，蒙古国的气候灾害数量比1990年增加了两倍。[26]目前，蒙古国国土面积的76.9%，即1.2亿公顷土地受到荒漠化和退化的影响，其中51%是气候变化引起的，49%是人为因素造成的。[26]可见，中蒙可再生能源合作，可全面有效持续实施《联合国气候变化框架公约》及其《巴黎协定》，脚踏实地落实国家自主贡献目标，强化温室气体排放控制，提升适应气候变化能力水平，为推动构建两国命运共同体作出更大贡献。

（四）中蒙可再生能源合作，可推动两国绿色转型发展

目前，蒙古国温室气体排放量虽然仅占全球的0.1%，但蒙古国正面临着气候变化、能源依赖和环境恶化的严峻挑战。[27]为推动落实《巴黎协定》，引领绿色转型发展，蒙古国明确了2030年温室气体排放量减少22.7%的目标，包括能源领域排放温室气体减少49.4%，交通领域减少6.2%、农牧业领域减少31.3%、工业领域减少7.6%的具体目标。[27]为落实上述目标，蒙古国在可再生能源、绿色建筑、防止和减少污染、可持续森林管理、垃圾再加工等多方面列出了115亿美元的投资计划。其中，为降低温室气体排放量需要63亿美元，应对气候变化需要52亿美元。[27]依据2022年4月份公布的数据，蒙古国气候绿色基金已通过4.36亿美元的投资项目和计划，但上述资金仅占落实蒙古国国家贡献目标总资金的13%。[27]当前，中国经济社会虽然进入加快绿色化、低碳化的高质量发展阶段。可见，中蒙可再生能源合作，不仅有效应对气候变化挑战，更可推动两国经济社会绿色转型发展。

四、共建“一带一路”视域下中蒙可再生能源合作的对策建议

可再生能源国际合作是共建绿色“一带一路”的重点领域。当前，应对气候变化和全球能源转型发展等诸多新问题新挑战下，中蒙两国推动可再生能源合作，可以共同维护国际能源产业链供应链安全，也可以积极应对全球气候变化，有效促进两国经济社会绿色低碳发展，推动构建可再生能源命运共同体。

（一）通过政策沟通保障中蒙可再生能源合作

近年来，中蒙两国通过政策沟通不断加强双边发展战略、制度机制以及各类平台的深度对接，为推进设施联通、贸易畅通、资金融通和民心相通提供了重要保障。因此，双方有必要在总结政策沟通经验基础上，进一步健全长效化政策沟通机制和全方位政策沟通平台，推进两国可再生能源合作。一是以政策沟通加强两国可再生能源发展战略。为应对全球气候变化、能源转型、可持续发展，中蒙两国结合各自可再生能源资源禀赋，制定出台了具有全局性、战略性、长期性、引领性的可再生能源发展战略。可再生能源发展战略对接，应加强两国政策沟通与协调，找准可再生能源合作的契合点，增进两国之间的政治互信与合作共识，推进两国可再生能源战略对接。通过建立健两国各部委发展规划对接，推动两国可再生能源合作目标。二是以政策沟通加强两国可再生能源发展的机制对接。在共建“一带一路”框架下，强化双边、多边合作机制，借助联合国、金砖国家、中国—东盟（10+1）、上海合作组织、亚欧会议等重要国际机制，构建全方位、多层次、宽领域的合作架构，为两国可再生能源合作提供机制保障。在双边多边合作的基础上，坚持互利互惠的原则，在“一带一路”能源合作伙伴关系框架内，进一步完善第三方市场合作机制，有效拓展第三方市场，加强协同合作，取长补短，充分发挥“1+1+1>3”的效果。三是以政策沟通加强两国可再生能源合作发展的平台对接。政策沟通不仅能够推进实现发展战略与规划的落实落地，而且通过国际合作平台对接，在更宽领域、更深层次促进两国可再生能源合作发展。借助亚太经合组织可持续能源中心、中国—东盟清洁能源合作中心等区域能源合作平台，坚持开放、绿色、廉洁理念，务实推进两国可再生能源合作。

（二）发挥优势促进中蒙可再生能源合作

秉持“和平合作、开放包容、互学互鉴、互利共赢”的丝路精神，秉承“共商共建共享”原则，立足中蒙两国可再生能源发展需求，优化可再生能源合作布局，推动实现两国人民享有可再生能源目标。一是规划先行。依据中蒙两国可再生能源资源禀赋、市场需要，通过优化双边可再生能源合作布局，优先发展双方边境地区可再生能源项目，延伸至双边、中俄蒙经济走廊及东北亚区域合作，逐步形成由点到面，争取互信，寻求伙伴，先打基础，再求壮大的发展格局。二是加强技术支持。中国的可再生能源项目因其技术可靠、质量优异、成本适宜等优势。在中蒙可再生能源合作中，要积极参与国际规则、规制、标准的制定，积极主动对接蒙古国的制度、标准，加强标准、认证认可互认等，促进形成“一带一路”可再生能源国际合作的标准及规范、指南互认体系，形成多层次、国际化的可再生能源国际标准合作体系，为两国可再生能源合作提供技术保障。三是拓展融资渠道。为分担风险、解决融资中的担保问题，探索多家融资机构、多种担保方式，通过有机设计进行债务乃至资本融资的模式。借助中国高水平绿色金融发展平台、亚洲基础设施投资银行、中国国家开发银行、中国进出口银行等多边开发性金融机构，积极引入丝路基金、中国各类绿色产业基金等以

股权投资方式，丰富蒙古国可再生能源项目开发融资渠道，深度参与蒙古国可再生能源开发项目，为两国可再生能源合作提供资金保障。

（三）统筹实施标志性工程和“小而美”可再生能源合作项目

蒙古国是共建“一带一路”的重要参与方，共建“一带一路”倡议实施以来，中蒙两国务实合作不断深入，在能源领域建成了一大批重大标志性工程项目和“小而美”民生项目，有力促进了蒙古国经济社会发展和民生改善。因此，抓好高质量共建“一带一路”八项行动的落实落地，统筹推进重大标志性工程和“小而美”民生项目，形成更多聚人心、接地气的合作成果。一是聚焦新领域合作。相对于蒙古国地域广、人口密度低、电力设施落后、电力供需不均衡、生态环境脆弱等特征，坚持以生态优先、绿色发展为导向，依托蒙古国风能、太阳能、水能、热能等可再生能源优势，大力拓展可再生能源发展合作空间，聚焦绿色基建、绿色生态、绿色能源、绿色交通、绿色金融等方面与之加强合作，应将风电、光伏，水电作为优先重点投资方向，探索对蒙古国可再生能源全产业链开发模式，进而扎实推动中蒙可再生能源合作发展。二是聚焦民生，深入推进可再生能源“小而美”项目建设。聚焦蒙古国民众“看得见、摸得着”，容易提升获得感、幸福感的基础设施建设、绿色生态、绿色农牧业、绿色就业、水利、林草发展、减贫人道主义、教育培训等重点领域用能需求有效结合，以接地气、聚人心、低成本、可持续为导向，深入推进偏远地区、欠发达地区、农村牧区，实施可再生能源“小而美”项目建设，发挥好民营企业和中小企业在“小而美”项目建设中的独特优势，以可持续的方式为蒙古国创造社会、经济和环境效益。

注释：

①本文发表于《中国石油大学学报（哲学社会科学版）》2025年第3期。

参考文献：

[1] 中国银行乌兰巴托代表处蒙古经济金融研究中心.蒙古国电力行业分析报告（2022年版）[EB/OL].（2022-09-20）[2024-08-25].https://mp.weixin.qq.com/s/NpcinIW9Z-MIr0NPDch6fQ.

[2] Monglia Renewables Readiness Assessment[R/OL].(2016-03)[2025-01-12].

[3] https://www.irena.org/-/media/Files/IRENA/Agency/Publication/2016/IRENA_RRA_Mongolia_2016.pdf.

[3]刘伟.蒙古国：2019年最值得期待的可再生能源新兴市场[EB/OL].（（2010-01-30）[2024-08-29].https://www.desn.com.cn/news/show-707989.htm.

[4]Монгол Улсын Их Хурлын тогтоол. Ногоон хөгжлийн бодлого батлах тухай[EB/OL].（2014-06-13）[2024-11-20].https://sdg.1212.mn/Content/files/Green_development_decision.pdf.

[5]Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030[EB/OL].（2016-02-05）[2024-11-20].http://nda.gov.mn/backend/f/PtNQFjbNQ6.pdf.

[6]"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай[EB/OL].（2020-05-13）[2024-11-20].https://legalinfo.mn/mn/detail/15406.

[7]"Эрчим хүчний реформ нь судалгаанд суурилсан цогц шийдэл байх ёстой"[EB/OL]. (2024-08-14) [2024-11-24].https://news.mn/r/2744583/.

[8]蒙古国再生能源法[EB/OL]. (2007-01-11日) [2024-08-25].https://www.parliament.mn/.

[9]特·阿努达热.介绍可再生能源价率、坚持的政策和前景[EB/OL]. (2024-04-15) [2024-08-25].https://montsame.mn/cn.

[10]Цахилгаан эрчим хүчний үнэ тарифууд.Эрчим хүчний зохицуулах хорооны 203-р тогтоол.[EB/OL].[2024-08-29].https://obtsts.mn/news/136/single/61.

[11]Хамтарсан Засгийн газрын хамгийн том зорилт 14 мега төсөл.[EB/OL].(2024-09-18)[2024-11-20].https://eagle.mn/r/130801.

[12]Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, төсвийн хөрөнгө оруулалт болон татварын ил тод байдал, үр ашгийг дээшлүүлэх төслүүдийн гэрээнд гарын үсэг зурлаа.[EB/OL].(2018-11-02)[2024-11-20].https://www.adb.org/mn/news/adb-signs-projects-develop-renewable-energy-and-improve-tax-administration-mongolia.

[13]U. S. Embassy Ulaanbaatar.АНУ-ын Засгийн газраас Монгол Улсын эрчим хүчний салбарыг шинэчлэх, сайн засаглалыг дэмжих зорилгоор 3 сая ам. доллар олгоно [EB/OL]. (2022-09-22) [2024-08-29].https://mn.usembassy.gov/mn/pr-092122-mn/.

[14]Монгол Улсын Засгийн газар сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн анхны өрсөлдөөнт сонгон шалгаруулалт явуулахад ОУСК-аас зөвлөнө[EB/OL].(2024-06-06)[2024-11-20].

https://www.ifc.org/mn/pressroom/2024/28212.

[15]中华人民共和国和蒙古国关于建立和发展全面战略伙伴关系的联合声明[N].人民日报，2014-08-22（2）.

[16]中华人民共和国政府和蒙古国政府联合声明[N].人民日报，2022-02-07（2）.

[17]中华人民共和国和蒙古国关于新时代推进全面战略伙伴关系的联合声明[N].人民日报，2022-11-29（2）.

[18]伙伴关系成员国-蒙古国[EB/OL]. (2020-08-05) [2024-08-25].https://obor.nea.gov.cn/pictureDetails.html?id=2619.

[19]张海峰.深入贯彻能源安全新战略为内蒙古“闯新路、进中游”贡献蒙电力量[N].内蒙古电力报，2024-08-21（2）.

[20]乌·呼日勒苏赫.到2030年蒙古国温室气体排放量将减少22.7%[EB/OL]. (2022-06-01) [2024-08-25].https://montsame.mn/mn/read/293324.

[21]商务部对外投资和经济合作司，商务部国际贸易经济合作研究院，中国住蒙古国大使馆经济商务处.对外投资合作国别（地区）指南蒙古国（2023年版）[EB/OL]. (2024-05-27) [2024-08-25].http://www.mofcom.gov.cn.

[22]习近平在第七十五届联合国大会一般性辩论上的讲话，人民日报，2020-09-23（2）.

[23]国家能源局.“十四五”可再生能源发展规划（发布搞）[EB/OL].（2022-03-29）[2024-08-25].https://www.ndrc.gov.cn/xwdt/tzgg.

[24潘慧敏.2023年全球可再生能源新增装机5.1亿千瓦，中国贡献超过50%[EB/OL].（2024-01-15）[2024-08-25].https://www.nea.gov.cn/2024-01/25/c_1310761971.htm.

[25]王轶辰.能源绿色转型步伐加快[N].经济日报，2024-02-21（1）.

[26]照日格图，赵珈艺.蒙古国生态安全形势及中蒙生态安全治理[J].北方经济，2023（11）：31-34.

[27]蒙古国将确定和谐自然的绿色发展之示范模式[EB/OL].（2022-04-07）[2024-08-25].https://montsame.mn/mn/read/293784.

SPSIRPA FORUM 2025

Session 4-4

Transformations in the Islamic World and Mongolia

Исламын ертөнцийн өөрчлөлт ба Монгол улс

А. Энхбат

Монгол улс, ШУТИС-ийн Нийгэм, Хүмүүнлэгийн сургууль

Товчлол

Ирээдүйн олон соёлт ертөнцөд хүн амын тоо, эдийн засаг, санхүү, шинжлэх ухаан, технологийн хувьд тэргүүлэх хэмжээнд очих Исламын ертөнцтэй Монгол улс хэрхэн харилцах нь өөрөө бас нэг том судалгааны сэдэв болж буйг тэмдэглэх хэрэгтэй.

Сүүлийн жилүүдэд Монгол улсын гадаад харилцаа, эдийн засгийн болон соёлын хамтын ажиллагаа Исламын шашинтай орнууд ихээхэн хөгжих болсон. Ялангуяа түүх, хэл, соёл, угсаа гарлын ижилсэлтэй Дундад Азийн орнуудтай илүү ойртох, харилцаагаа хөгжүүлэх алхмууд хийгдээд байна. Нөгөө талаар дэлхийн олон улсын харилцаа, эдийн засаг, соёлд Исламын шашинтай орнуудын байр суурь улам бүр бэхжиж, жин нөлөө нь илт нэмэгдэх болов. Саудын Арабаар тэргүүлүүлсэн Исламын лигийн орнуудын Исламын шашинтай орнуудынхаа харилцааг тусад авч үздэг болсон. Монгол улс хүссэн ч эс хүссэн ч Исламын шашинтай орнуудтай идэвхтэй харилцаанд орох нь гарцаагүй.

Исламын ертөнцийн талаарх уламжлалт ойлголт ч өөр болж байна. Ялангуяа Исламын улс нэртэй бүлэглэл мөхөж, шинэ Исламын үзэл санааг тугаа болгосон Исламын лидерүүд илүүтэйгээр барууны ертөнц, тэр дундаа хамгийн их баруунжсан Турк улсыг чиг баримжаа болгох хандлага илэрч байна. Үүнийг бид Сирийн шинэ удирдагчдаас харж болно. Нөгөө талаар Исламын ертөнц нь шашны урсгал хоорондын гэхээсээ Түрэг хэлтний, Арабчуудын, Персүүдийн гэх ондоошил нь илүү хүчтэй илрэх болсон.

Гэхдээ Исламын ертөнц дэх дотоод зөрчил, дайн төгсөх болоогүй, шийтийг дэмжигч Ираны хүч нөлөө суларч, Ойрх Дорнодод Исламын гэхээсээ илүү угсаатны, мөн Исламаас өмнөх шашинтнууд, Христийн шашинтнуудын шинэ бүлэглэл дэлхийн анхааралд илүүтэйгээр өртөх болоод байна. Хэдий Исламын тэлэлт зогссон ч нефтийн орлогоо зөв ашиглаж эдийн засгаа солонгоруулж чадсан Арабын орнуудын нөлөөгөөр олон улсад Исламын ертөнц улам жин дарах, бодлого тодорхойлогч нарт нөлөөлөх хэмжээнд очжээ.

Түлхүүр үг: *Ислам, Монгол, Дундад Ази, харилцаа*

Исламын Ертөнц: Исламын ертөнц гэдэг ойлголтод зөнч Мухамедын үндэслэсэн Лалын шашин шүтдэг, өдөр тутмын амьдралаа энэ шашны сургаал, номлолоор зохицуулдаг соёлт нийгмүүдийг орууллаа. Хавирган сарыг гол бэлгэдлээ болгож, ногоон өнгийг эрхэмлэж, араб хэл шашин соёлын үндсэн хэл болдог. Дэлхийн хүн ам зүйн чиг хандлага энэ хэвээр үргэлжлэх юм бол судлаачдын тооцож байгаар 2070 он гэхэд Мусульманчуудын тоо Христийн шашинтан нартай тэнцүү болно. (https://www.pewresearch.org/religion/2015/04/02/religious-projections-2010-2050/, 2015) Өөрөөр хэлбэл 2070 оноос цааш дэлхийн хамгийн их хүн шүтдэг шашин Исламын шашин болох юм. Үүний гол хүчин зүйл нь Ислам шашинтай улс орнуудын хүн амын өсөлт. (Энхбат, 2024, хууд. 9) Исламын ертөнцийг шашны суннит, шийт урсгал болон бусад олон хуваагдах урсгалуудаас нь гадна хэл, уламжлалт соёлын хүчин зүйл, газар

зүйн байрлалаар олон дэд бүлэгт хуваагдаж болно. Харин бид дээрх хүчин зүйлүүд тулгуурлан тун ерөнхий байдлаар Исламын ертөнцийг таван тулгуур голомт болгон хуваан авч үзлээ. Энэ ангилал маань ч дотроо бас өөрийн онцлог, нийтлэгүүдээр дахин хэд ч хуваагдах бололцоотой.

Нэг. Арабын ертөнц, Араб хэлээр ярилцдаг, Исламын суннит урсгалыг шүтдэг, нүүдэлчин араб аймгуудын уламжлалт соёлыг хадгалсан голдуу хаант засаглалтай улс орнуудыг орно. Арабын булангийн буюу Арабын лигийн орнууд, мөн парламентын засаглалтай Ирак, Египет зэрэг Араб хэлтэй улсуудыг багтааж болно. Тэд зөнч Мухамедтай хэл, соёл нэг төдийгүй, түүний ариун шарил, Исламын шашны шүтээн, түүхэн үйл явдал өрнөсөн Мекка, Медине тэргүүтэй хотууд, дурсгалт газруудыг эзэмшдэг төдийгүй зарим нь нефтийн баялаг, түүний зөв зарцуулалтын үр өгөөжөөр өндөр хөгжиж, Исламын шашин, соёл дэлгэрүүлэгч, гол санхүүжүүлэгч гэдгээрээ манлайлах байр суурь эзэлдэг. Тэд шинжлэх ухаан, технологийн ололт амжилтыг маш хурдтай зөвшөөрч, өөриймшүүлж АНУ тэргүүтэй Өрнөдийн орнуудтай сайн харилцаатай. Гэхдээ Ойрх Дорнодод орчин үеийн ололт, амжилтыг үгүйсгэдэг Исламын улс зэрэг хэт радикал бүлэглэлүүдийг санхүүжүүлдэг гэгдэх ч бий.

Хоёр. Исламын шашны шийтийн урсгалыг шүтдэг, эртний Персийн соёлын уламжлалыг хадгалдаг Иран тэргүүтэй энэ бүлэгт Пакистан, Афганистан, Тажикстан зэрэг орнуудыг оруулж болохоос гадна Ираны улс төр, шашны нөлөөний зарим бүс нутгийг ч хамруулж болно. Тухайлбал Палестин, Сири, Ливаны зарим шийтийн хяналт тогтсон бүс нутгуудыг оруулж болно. Исламын шийтийн урсгалыг дэлгэрүүлэгч, тэдний оюун санааны удирдагч нь эдүгээ Ираны төрийн дээр дээд удирдагч болон заларч байдаг онцлогтой.

Гурав. Түрэг хэлээр ярилцдаг, голдуу Исламын шашны суннит урсгалыг шүтдэг, эртний нүүдэлчин Түрэг аймгууд, Иран Туран, Анатолийн болон Византын соёлын уламжлалыг хадгалсан орчин цагийн Европтой хил залгадаг, Мустафа Ататуркийн шинэчлэлээр баруунжсан БНТУ энэ бүлгийг манлайлж бас пан-турк, Османы эзэнт улсын амбицаа зарим нуулгүй олон улсын тавцанд илэрхийлж байгаа. Алтай язгуурын Түрэг хэлний олон аялгуунуудаас бүрэлдэх нэгдмэл Түрэг хэл, Орхон бичиг, Түрэг, Селжүк, Османы эзэнт улсын уламжлал, нүүдэлчин соёлын онцлог бусад мусульманчуудаас тэднийг онцгойруулдаг. Турк, *Азербайжан*, хуучин Зөвлөлтийн бүрэлдэхүүнд багтаж байсан Узбекистан, Туркменстан, Казахстан, Киргизстан зэрэг орнуудыг энэ бүлэгт багтааж болно. Мөн хэл, соёлын нийтлэгээр нь Хятад улсын Шинжаан дахь Уйгурууд, Балкан болон Зүүн Европ дахь турк гаралтай болон мусульманчуудыг багтаах боломжтой. Эдгээр түрэгтэй хэлтэй исламын орнуудын бас нэг томоохон онцлог, давуу тал бол шашин, төрийг зааглаж чадсан. Гэхдээ энэхүү Түрэгийн ертөнц дотроо хангалтай өрсөлдөөнтэй, зөрчилтэй. Эдийн засаг, газар нутгийн хэмжээгээрээ энэ бүлэг дотор Казахстан зарим талаараа Турк улстай өрсөлддөг.

Энэхүү гурван том бүлэг болох Араб, Перс, Түрэг хэлтэнгүүд нь мөн хоорондоо соёлын асар их солилцоонд орсныг бас тэмдэглэх хэрэгтэй. Тэд харилцан нэгнийхээ газар нутгийг байлдаан дагуулж, хүн амд нь өөрийн хэл соёлыг тулгаж байлаа. Тиймээс хэл, соёлоос нь ч аль нэгнийхэн нөлөө, уламжлалыг шууд харж болно. Арабын соёлд Персүүд

онцгой нөлөө үзүүлсэн бол Түрэгүүд Селжук, Османы эзэнт улсын үед Араб, Персүүдийг эрхшээж байсан бол эртний Персийн хэл, соёлын нөлөө Анатолийн хойгоос гадна, Дундад Ази, Шинжаан дахь Уйгурууд, Монголын баруун хэсэг Алтайн уулс хүртэл өргөн тархсан. Османы эзэнт улс Араб бичиг үсэг авч Перс хэл, соёлын олон ололтыг өөрийн болгон нэгэн үе Исламын ертөнцийг манлайлж, баруун Европ хүртэл байлдан дагуулал хийж байсан. Мөн өнөө хүртэл харилцан холилдон оршдог гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Туркийн Курдууд, Ираны *Азербайжан*чууд, Ирак дахь Курдууд, Сирийн Туркменчүүд гээд нэрлээд байвал тун олон. Эдгээр хүн ам ч Ислам шашинтай эдгээр орнуудын харилцаанд ихээхэн чухал үүрэгтэй. Жишээ нь Иран-Туркийн харилцаа хүйтрэхэд Иран дахь *Азербайжан*чууд, Турк дэхь Курдуудын хөдөлгөөн идэвхжиж эхэлдгийг дурдаж болох юм.

Дөрөв. Дээрх бүлгүүдээс хэл, соёлоос гадна газар зүйн хүчин зүйлээр алслагдсан боловч хамгийн их Ислам шашинтай хүн ам оршин суудаг зүүн өмнөд Азийн Индонез, Малайз тэргүүтэй өвөрмөц хэсэг бий. Араб худалдаачдын нөлөөгөөр мусульман болсон эдгээр улсууд хүн амынхаа өсөлт, хөгжлөөрөө удахгүй томоохон нөлөө бүхий хүчин болох нь гарцаагүй.

Тав. Хойд Африк, Сахарын Исламын шашинтай орнуудыг тусгайлан авч үзэх бололцоотой. Эртнээс Исламын ертөнцийн зүүн хэсэгтэй, улс төр, соёлын өргөн харилцаатай байсан энэ бүс нутагт Исламын шашин дэлгэрч түүний нөлөөгөөр Судан, Ливи, Тунис, Алжир, Марокко, Мавритан, Сомали, Жибути улсын албан ёсны хэл нь Араб хэл болжээ. Гэсэн хэдий ч тэд орон нутгийн олон хэл, аялгуу, соёлын онцлогийг тэд хүчтэй хадгалсан хэвээрээ байна.

Тэд бидний талаар: Исламын ертөнц Монголчуудын талаар ямар мэдлэгтэй вэ? Монголын түүхийн талаар Турк, Иран, Дундад Азийн орнууд харьцангуй сайн мэдлэгтэй бөгөөд дунд сургууль, их сургуулийн түүхийн хичээлийн хөтөлбөрт Монголын түүхийг ямар нэгэн байдлаар үздэг. Учир нь эдгээр улсуудын түүхийн бүхэл бүтэн нэг үе нь Монголын үе байдаг. Жишээлбэл Монголын түүхийн Манжийн үеийн түүхтэй адилтгаж болно.

БНТУ-ын Күтахя Думлупинар Их Сургуулийн Түүхийн тэнхимийн багш доктор, дэд профессор Алтай Таяфун Өзжан 2018 онд Туркийн Шинжлэх Ухааны Академийн шилдэг зохиогчийн шагналыг 2017 онд хэвлүүлсэн “Монгол-Оросын харилцаа” (1223-1341) бүтээлээр авсан. (https://haber.dpu.edu.tr/tr/haber_oku/5c23897ac4c7d/doc-dr-altay-tayfun-ozcan-dpunun-gururu-oldu , 2018) Турк улсын түүх, соёл, хэл судлалын тэргүүлэх чиглэл нь сүүлийн жилүүдэд Алтан ордны түүх болоод байгаа. Өөрөөр хэлбэл Орос орныг Монголчууд хэрхэн байлдан дагуулж, олон зуун жил захирч байсан түүхэнд ихээхэн анхаарал хандуулах болсон. Мөн Хүннү, эртний Түрэг, Уйгурын түүх ч тэргүүлэх сэдэвт орох бөгөөд хэл шинжлэлийн хүрээнд Алтай хэлний бүлэг, Монгол нутаг дахь руни бичгийн дурсгалуудын судалгаанд гол ач холбогдол өгдөг.

Иран түүхч, Тегераны Их Сургуулийн профессор Ширин Байани "Монголын үеийн Иран дахь шашин ба төр" (1991) гурван боть номоороо Ираны оны шилдэг номын шагналыг хүртэж байв. (https://fa.wikipedia.org/wiki/%D8%B4%DB%8C%D8%B1%DB%8C%D9%86_%D8%A8

%DB%8C%D8%A7%D9%86%DB%8C, n.d.) Тэрээр Монголын нууц товчоог Перс хэлээр орчуулсан бөгөөд түүний “Монголын үеийн Иран дахь эмэгтэйчүүд” номыг Чингис хааны өв, соёлын хүрээлэн А. Анхбаяр, Ш. Бэлгүүн нар 2022 онд Перс хэлнээс орчуулан гаргасан байдаг. Зөвхөн дээрх хоёр эрдэмтний судалгаа, түүнд өгч байгаа төр засгийн анхаарал нь эдгээр улсуудад Монголын түүхийг маш өндөр түвшинд судалж, үнэлж байгааг харуулна.

Мөн Казахстан тэргүүтэй Дундад Азийн Түрэг хэлтэй орнуудын хувьд Алтай судлал, Хүннү, эртний Түрэг, Уйгарын түүхийн тэргүүлэх байр суурьтай. Үүний зэрэгцээ Алтан Ордон, Цагаадайн хаант улсын түүхэнд гол ач холбогдол өгдөг. Учир нь бараг XX зуун хүртэл эдгээр бүс нутагт төр барих хамгийн эрх нь Чингисийн алтан ураг байснаар хангагдаж байлаа.

Нөгөө талаар улс төр, цэрэг, олон улсын харилцаанд Монголын түүхийн одоо хүртэл ач холбогдолтой байсаар буйн сонирхолтой. Өнөөгийн БНТУ-ын ерөнхийлөгч Т. Эрдагон 2018 онд Шударга ёс, хөгжлийн намын цуглаан дээр: *Чингис хаан Анотолийг газрын хөрштэй тэгшлэн урагшлахдаа нэгэн хотыг бүсэлсэн, хот бууж өгсөн. Хотыг авсан Чингис хаан гартаа зэвсэг барьж чадах настай, хөгшин, залуу бүх эрчүүдийг нэг дор цуглуулсан. Тэгээд өөрсдийнхөө булшны нүхийг ухахыг хүссэн. Энэ үед нэгэн настан гуйж, сөгдсөөр Чингис хааны дэргэд ирсэн. Тэгээд тэр булшны нүхээ ухаж байгаа 20 настай залуу бол миний хүү. Их залуухан та түүнийг өршөөгөөч хэмээсэн түүний нулимс Чингис хааны гутлыг бүрхсэн. Харин Чингис хаан өндөр настай эрд ийнхүү хэлсэн. Би өршөөхгүй, чи хүүгээ булшныхаа нүхийг ухаж байхад уйлж байна. Дайсан эх орны чинь зах хязгаарт ирээд байхад чи юу ч хийлгүй харж байсан шүү дээ гэсэн. Тиймээ харин бид эх орны минь хил дээр дайсан ирвэл зүгээр хараад суухгүй. Бид хөвгүүдээ булшныхаа нүхийг ухахад уйлахгүй. Бид нэгэн зууны өмнө ширээний ард улсын минь, бүс нутгийн минь талаар хийгдсэн төлөвлөгөө, зурагдсан газрын зургийг урж хаяж байсан шигээ, өнөөдөр ч Аллахын тусламжаар дахин тийм зүйлийг урж хаях болно* (Erdoğan, https://www.youtube.com/watch?v=B2xX5GCq-8M, 2017) гэсэн байдаг.

Мөн 2021 онд нэгэн уулзалтад үг хэлэхдээ Туркийн ерөнхийлөгч Хүлэгү ханы дараах түүхээр жишээ авсан байдаг: *Монголын эзэнт улсыг үндэслэгч Чингис хааны ач Хүлэгү Багдадыг эзлэн юу ч үгүй дээрэмдсэн зарим сурвалжийн мэдээгээр 200 000, зарим сурвалжийн мэдээгээр 400 000 хүн алсан гэдэг. Олон зуун жил Багдадын нэр нүүр болсон сүмүүд, орд харш, номын санг Хүлэгүгийн цэргүүд газартай тэгшилсэн. Хотын гадна хуарагнан буусан энэ харгис удирдагч элч илгээн тэр бүс нутгийн хамгийн мундаг эрдэмтэнтэй уулзахыг хүссэн. Мэдээж ямар ч эрдэмтэн Хүлэгүтэй нүүр тулахыг хүсээгүй. Гэвч эцэст нь Кадихан нэртэй сахал нь ч ургаж гүйцээгүй залуухан сүмийн багш энэ уулзалтад явахаар зөвшөөрсөн. Их сонирхолтой. Үүнийг анхааралтай сонсохыг хүсье. Тэр явахдаа нэг тэмээ, нэг ямаа, нэг азарган тахиа авч явсан. Хүлэгүгийн цэргийн хуаранд очсон. Хүлэгү эрдэмтэн залууг үл тоосон байдалтай хараад надтай уулзуулах гэж одоо чамайг олсон хэрэг үү? хэмээсэн. Кадихан: Танд уулзах хүч чадалтан хэрэгтэй гэвэл гадаа нэг тэмээ байгаа, сахалтай нэгэн хэрэгтэй гэвэл гадаа нэг ямаа байгаа, дуу чангатай нэгэнтэй уулзана гэвэл гадаа нэг азарган тахиа байна. Та хүссэнээ дуудаж болно гэв. Хүлэгү өмнө зогсох залууг хоосонгүйг мэдээд алив надад хэлээч намайг энд*

авчирсан шалтгаан юу вэ? гэсэн. Залуу эрдэмтэн ийнхүү хариулсан. Их ойлгомжтой. Чамайг энд бидний үйлдэл авчирсан. Аллахын бидэнд өгсөн адисллийн үнэ цэнийг бид мэдээгүй. Аз жаргалдаа хэтэрхий автсан. Албан тушаал, эрх мэдэл, эд хөрөнгөний араас шунасан. Аллах адисаллаа буцааж авахын тулд чамайг илгээсэн. Үүний дараа Хүлэгү тэгвэл намайг эндээс юу буцааж чадах вэ? гэж хоёр дахь асуултаа тавьсан. Энэ их сонирхолтой. Кадихан хариулсан. Бидний мөн чанар буцан ирж, Аллахын бидэнд өгсөн адислалын үнэ цэнийг мэдэж, өөр хоорондоо тэмцэлдэхээ больсон цагт чи энд байх аргагүй болно гэсэн. Бид өөр хоорондоо тэмцэлдэхээ больцгооё. Нэг нэгнээ Аллахын төлөө хайрлацгаая гэсэн. (Erdoğan, https://www.youtube.com/watch?v=hXI9i6wZD0A, 2020) гэсэн. Түүний жишээ авсан Монголын түүхээс Чингис хаан болон түүний үр удмын хийсэн аян дайн бол Аллахын зүгээс илгээсэн шийтгэл юм гэх тэртээ 800 жилийн өмнөх үзэл харагдаж байна. Нөгөөтээгүүр Монголын түүх өнөө ч ач холбогдолтой сургамж болсоор буй илтгэнэ.

Ираны дээд удирдагч Али Хамейни Монгол улсын ерөнхийлөгч Ц. Элбэгдоржийг хүлээн авч уулзахдаа: “Би Монгол Улсын Ерөнхийлөгчид зориуд баяр хүргэх гэсэн юм. Ил хаант улс байх үед монголчууд та нар бидний дайсан уулын өвгөд буюу исмайлитуудыг устган цэвэрлэж өгсөн. Монголчууд та нар Иранд одон орон судлалын төв, их сургууль байгуулж, тэр ч байтугай сэтгэл мэдрэлийн өвчтэй хүмүүсийг эмчлэх эмнэлэг барьж өгч байсан. Чингис хааны тав дахь үе /Өлзийт хааныг хэлэв бололтой/ Исламын шашны шийт урсгалыг Ираны төрийн шашин болгосон. Ийм учир би өнөөдөр Исламын шашны шийтийн урсгалын тэргүүн болоод сууж байна. Мөн Монголчууд перс хэлийг дэмжиж, хааны ордны хэл болгоод Энэтхэг хүртэл тархаасан. Британийн эзэнт улс л үүнийг өөрчилж англи хэлийг ордны хэл болгосон (Д. Анхбаяр, Б. Батхишиг , 2016, хууд. 197) гэсэн байдаг.

Казахстанд 2020 онд Алтан Ордны улсын 750 жилийн ойг ерөнхийлөгч Касым-Жомарт Токаев зарлиг гарган тэмдэглэсэн. Тэрээр Зүчийн бунханд зочилж, “Жошы хаан” номыг даалгавар өгч хэвлүүлсэн байдаг. (Abai.kz, 2020) Энэ бүгдээс үзэхэд Исламын шашинтай орнууд Монголчуудын талаар, Монголын түүхийн талаар чамгүй мэдлэгтэй нь харагдаж байна. Мөн тэдний Монголчуудын түүхэн үүргийг үнэлж дүгнэх, Монголын түүхийн талаар ойлголтууд нь ч өөр хоорондоо зөрчилтэй байдгийг тэмдэглэх хэрэгтэй. Монголчууд тэдний түүхэн дайсан ч юм шиг, нэг бол угсаа гарал нэгтээ ахан дүүс ч юм шиг эрс тэс үзлүүд бий.

Исламын ертөнц хэрхэн өөрчлөгдөж байна: Исламын ертөнцийн талаарх уламжлалт ойлголт өөр болж байна. Ялангуяа Исламын улс нэртэй бүлэглэл мөхөж, шинэ Исламын үзэл санааг тугаа болгосон Исламын лидерүүд илүүтэйгээр барууны ертөнц, тэр дундаа хамгийн их баруунжсан Турк улсыг чиг баримжаа болгох хандлага илэрч байна. Үүнийг бид Сирийн шинэ удирдагчдаас харж болно. Нөгөө талаар Исламын ертөнц нь шашны урсгал хоорондын гэхээсээ Түрэг хэлтний, Арабчуудын, Персүүдийн гэх ондоошил нь илүү хүчтэй илрэх болсон.

Исламын ертөнц дэх дотоод зөрчил, дайн төгсөх болоогүй, шийтийг дэмжигч Ираны хүч нөлөө суларч, Ойрх Дорнодод Исламын гэхээсээ илүү угсаатны, мөн Исламаас өмнөх шашинтнууд, Христийн шашинтнуудын шинэ бүлэглэл дэлхийн анхааралд илүүтэйгээр

өртөх болоод байна. Хэдий Исламын тэлэлт зогссон ч нефтийн орлогоо зөв ашиглаж эдийн засгаа солонгоруулж чадсан Арабын орнуудын нөлөөгөөр олон улсад Исламын ертөнц улам жин дарах, бодлого тодорхойлогч нарт нөлөөлөх хэмжээнд очжээ.

Израйлын Ерөнхий сайд Нетаньяху 1996 онд бичсэн "Терроризмтой тэмцэх нь" номдоо шинэ стратегийг дэвшүүлсэн. Израил террористуудтай тулалдахгүй; харин террористуудыг дэмждэг улсуудтай байлдах болно. Өөрөөр хэлбэл, энэ нь АНУ-ыг Израилын өөрийнхөө төлөөх дайнд оруулах болно. Түүний 2001 онд тайлбарласнаар: Ойлгох ёстой хамгийн эхний, чухал зүйл бол: Тусгаар тогтносон улсуудын дэмжлэггүйгээр олон улсын терроризм гэж байхгүй.... Энэхүү төрийн дэмжлэгийг нь авч хаявал олон улсын терроризмын тулгуур бүхэлдээ тоос болон сүйрэх болно.Нетаньяхугийн энэ стратеги АНУ-ын гадаад бодлоготой уялдсан. Сирийг устгах нь энэхүү төлөвлөгөөний чухал хэсэг байсаар ирсэн. Үүнийг 9 сарын 11-ний дараа генерал Уэсли Кларк баталжээ. Пентагонд айлчлах үеэрээ "бид таван жилийн дотор долоон улсын засгийн газар луу довтолж устгана: Иракаас эхэлж, Сири, Ливан, Ливи, Сомали, Судан, Ираныг бай болгоно" гэж хэлсэн. Эхлээд Ирак, дараа нь Сири, бусад нь дараагийнх нь байх болно. (Sachs, 2024) Хэдийгээр цаг хугацааны хувьд таван жилийн дотор багтахгүй ч Ирак (2003 онд АНУ довтолсон), Ливан (АНУ Израйлыг санхүүжүүлж, зэвсэглэсэн), Ливи (2011 онд НАТО-гийн бөмбөгдөлт), Сири (2024 онд дэглэм унасан), Судан (2011 онд Суданыг задлахад босогчдыг дэмжсэн) болон Сомали дахь дайныг удирдаж, ивээн тэтгэсэн. 2006) үйл явдлууд өрнөсөн. Харин одоо Израйл Ирантай дайны байдалд орж байна. Үүнд өнгөрсөн онд Израйл, Иран харилцан пуужин харвалцсаныг тэмдэглэх хэрэгтэй.

Эдгээр үйл ажиллагаанд олон мянган энгийн иргэд үрэгдэж, гашуун зовлонд унасан нь харамсалтай. Гэхдээ Нетаньяхугийн стратеги Израйлын хувьд зөв юм. Олон улсын террорист бүлэглэлүүдтэй сунжирсан дайн хийх нь үр дүн багатай. Эдгээр бүлэглэлүүд бараг алдах юм байхгүй. Тэдний гарт аюултай зэвсэг орох юм бол бодох санах юм байхгүй шууд л хэрэглэнэ. Харин улс орныг удирдаж байгаа дэглэм бол ондоо, тэд алдах юмтай оршин тогтохын үндэс болсон засгийн эрхээ алдах эрсдэлтэй.

Энд бас нэгэн зүйлийг дурдахгүй өнгөрч болохгүй. Энэ бол Израйл болон Арабын орнуудын ойртолт, тэдний хамтын ажиллагаа. Хэрэв нөхцөл байдал энэ хэвээрээ үргэлжилбэл тун удахгүй Ираны эсрэг тэд холбоотны хэмжээнд түншлэх бололцоотой. Нэг үгээр хэлбэл Исламын ертөнцөд Ираны байр суурь үлэмж буурч, шийтийн урсгал ихээхэн хумигдах өөрчлөлт гарч болох юм. Ийм нөхцөл байдалд өндөр настай дээд удирдагчийн тэргүүлсэн Ираны өнөөгийн дэглэм удаан тэсэх үү, яг одоо Ираны ерөнхийлөгчөөр ажиллаж байгаа Азербайжан гаралтай Масуд Пекешкян улс орондоо ямар шинэчлэл авчрах бол. Ямартаа ч тэрээр охид, эмэгтэйчүүдийн толгойны алчууртай зууралдахгүй гэдгээ мэдэгдсэн бол ердөө хэдхэн хоногийн өмнө Азербайжанд хийсэн айлчлалынхаа үеэрээ өөрийн төрлөх хэлээр Азербайжанчуудын өмнөд болон хойд гэж хоёр улсад хуваагдан зүдэрсэн тухай шүлэг уншсан нь ид шуугиан тарьж байна.

Исламын ертөнцөд гарч болох бас нэг томоохон өөрчлөлт бол Дундад Азийн Түрэг хэлтэй орнуудын хамтын ажиллагаа нягтрал юм. Турк улсын идэвх, манлайлал дор хэд хэдэн байгууллага бий болсон. Эдгээр дараах гурван байгууллагыг танилцуулж байна.

Турксой буюу Туркийн соёлын олон улсын байгууллага. Түрэг хэлтэй орнуудын анхны хамтын ажиллагааны байгууллага бөгөөд 1993 онд Азербайжан, Казахстан, Киргизстан, Узбекистан, Туркменистан, Бүгд Найрамдах Турк улсын Соёлын сайд нарын хэлэлцээрээр байгуулагдсан. Ажиглагч гишүүнээр Хойд Кипр Туркийн Бүгд Найрамдах Улс, ОХУ-ын Бүгд Найрамдах Татарстан, Башкортостан, Алтай, Саха, Тыва, Хакас, Молдавын Бүгд Найрамдах Гагауз улсууд элссэн. Туркийн ард түмний эв нэгдэл, ахан дүүсийн найрамдлыг бэхжүүлэх, Туркийн нийтлэг соёлыг хойч үедээ өвлүүлэн үлдээх, дэлхий дахинд таниулах чиглэлээр ажилладаг.

Түрэг улсуудын байгууллага 2009 оны 10 сарын 03-нд байгуулагдсан. Түрэг хэлтэй орнуудын иж бүрэн хамтын ажиллагааг дэмжих үндсэн зорилго бүхий Засгийн газар хоорондын байгууллага, төв нь Станбул хотод байрладаг. Турк, Азербайжан, Казахстан, Кыргызстан, Узбекистан улс бүрэн эрхт гишүүн бол Унгар, Туркменистан улсууд ажиглагч гишүүнээр элсжээ. Тус байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга ноён Кубанычбек Өмүралиев Монгол Улсын Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгийн урилгаар энэ оны 3 сарын 18-22-нд Монгол Улсад ажлын айлчлал хийсэн.

Олон улсын Түрэг академи 2012 онд Казахстан улсын санаачилагаар байгуулагдсан. Төв нь Астана хотод байрладаг. Түрэг хэлтэй улс орнуудын түүх, соёлыг судлах, энэ чиглэлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилготой. Азербайжан, Казахстан, Киргиз, Турк улс бүрэн эрхт гишүүн бөгөөд Узбекистан, Унгар улс ажиглагч гишүүний статустай.

Ямартаа ч дээрх Түрэг хэлтэй орнуудын түүх, соёлын байгууллагуудтай Монгол улсын ШУА-ийн Түүх угсаатны зүйн хүрээлэн, Археологийн хүрээлэнгүүд, их сургуулиуд хамтын ажиллагаатай, Монгол оронд хамтарсан археологийн малтлага судалгаа, эрдэм шинжилгээний хурлуудыг хийж байсан, одоо ч зарим судалгааны ажлууд үргэлжилж байгаа.

Монгол улсын гадаад харилцаа ба Исламын шашинт орнууд: Монгол улсын хувьд эдгээр таван Исламын ертөнцийн голомтоос Арабын орнууд, Египет болон Турк улс, Дундад Азийн орнуудтай найрсаг, олон жилийн хамтын ажиллагаатай. Монгол улсын гурав дахь хөршийн бодлогыг тусгасан Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлалд гурав дахь хөршөөр нэрлэсэн зургаан субъектийн нэг БНТУ юм. Өөрөөр хэлбэл Исламын ертөнцийн улс орнуудаас бид дан ганц Турк улсыг онцгойлон өөрийн гурав дахь хөршөөр сонгосон. Энэ онд Монгол улсын ерөнхийлөгчийн БНТУ-д хийсэн айлчлалын үеэр хоёр орны харилцааг Стратегийн түншлэлд хүргэсэн. (https://president.mn/31791/, 2025)

Монгол улсын ерөнхийлөгч У. Хүрэлсүх Дундад Азийн Ислам шашинтай улс орнуудтай идэвхтэй харилцаа хөгжүүлж, харилцааг илт сэргээж байгаа билээ. Түүх, хэл, соёл, угсаа гарлын ижилсэлтэй Дундад Азийн эдгээр орнуудтай илүү ойртох, харилцааг шинэ шатанд авчирсан эдгээр алхмуудыг цаашдаа хадгалж идэвхжүүлэх нь үнэхээр чухал юм. Монгол улс нь Иран улстай найрсаг харилцаатай бөгөөд Монгол улсын ерөнхийлөгч айлчилж, түүх, соёлын идэвхтэй харилцааг Ц. Элбэгдорж ерөнхийлөгчийн үед өрнүүлсэн. Үүний нөлөө одоо ч хэвээрээ соёлын салбарт үргэлжилж байна. Мөн зүүн

өмнөд Азийн Исламын ертөнцийн голомт болсон Малайз, Индонез, Сингапуртай сайн харилцаатайг тэмдэглэх хэрэгтэй. Харин Африкийн Исламын шашинт улсуудтай манай орны хувьд харилцаа сул хөгжсөн, эдгээр орнуудтай харилцах нь ч ач холбогдол багатай.

Исламын ертөнцөд гарч буй өөрчлөлтүүдээс бидэнд хамгийн бодиттой мэдэгдэх, нөлөөлөх нь газар зүйн хувьд ойр байрлах Дундад Азийн орнуудын нягтрал юм. Орос нөлөөнөөс аажмаар гарч байгаа эдгээр улсуудтай бид хэрхэн харилцах стратеги боловсруулах зайлшгүй шаардлагатай. Дундад Азийн түрэг хэлтэй орнууд биднээс хүн ам, зах зээлийн багтаамжаар том, хамгийн бага хүн амтай Киргизстан гэхэд Монгол улсаас даруй хоёр дахин их хүн амтай. Казахстан, Киргизстан, Узбекистан, Азербайжан нь дэд бүтэц, хотжилтын хувьд манай орноос илүү, өөрсдийн гэсэн үйлдвэрлэлтэй, эдийн засаг бидэнтэй төстэй хамтрагч гэхээсээ илүү өрсөлдөгч шинжтэй уул уурхай, аялал жуулчлал, хөдөө аж ахуй зонхилдог.

Монгол улсын Их Хурлын дарга Г. Занданшатарын санаачилгаар “Алтай дамнасан тогтвортой байдлын яриа хэлэлцээ” хэмээн олон улсын чуулга уулзалтыг 2023, 2024 онуудад Монгол улс зохион байгуулсан нь ихээхэн үр дүнтэй болсон. Турк, Унгар, Дундад Азийн орнууд, Өмнөд Солонгос, Японы эрдэмтэн судлаач, төлөөлөгчдийг урьж оролцуулсан нь “Алтай” хэмээн эртний түүх, хэл, соёлын шүхэр дор Монгол улсыг эдгээр орнуудтай ойртуулахад чухал алхам, гарц болох боломжийг харуулсан. Мөн МУИС, ШУТИС, МУБИС, Станбулын их сургууль, Ургэнчийн их сургуулийн эрдэмтэн судлаачид тэргүүлэн Монгол-Турк түүхчдийн зөвлөгөөнийг дөрвөн удаа, Монгол-Узбек түүхчдийн зөвлөгөөнийг хоёр удаа зохион байгуулсан нь маш амжилттай болсон. Цаашдаа ч ийм зөөлөн хүчний бодлого ашигласан арга хэмжээнүүд тогтмол зохион байгуулах нь манай улсыг олон улсад ганцаардуулахгүй байхад чухал нөлөөтэй.

Дүгнэлтийн оронд: Исламын ертөнцөд ойрын үед гурван томоохон өөрчлөлт явагдаж байна. Нэгдүгээр Саудын Араб, Кувейт, Катар тэргүүтэй улс орнууд нефтийн баялгаар эдийн засгаа амжилттай солонгоруулж дуусгаад аялал жуулчлал, шинжлэх ухаан, технологийн дэлхийн шинэ төв болох зам руугаа орж байна. Өөрөөр хэлбэл мөнгө болон технологийн төвлөрөл тэнд бий болж байна. Тиймээс энэ төвтэй харилцах, энэ төвийн соёл, хэл, шашныг мэддэг хүний нөөцөө манай улс бэлдэх хэрэгтэй.

Хоёрдугаарт Ойрх Дорнод тэр дундаа Иранд дэглэм солигдох, эсвэл олон жил үргэлжлэх шинэ дайн гарч магадгүй. Иран бол 90 орчим сая хүнтэй, их удаан жил олон улсын хоригт байсан учир дотооддоо үйлдвэр, технологи хөгжүүлж чадсан улс. Тиймээс энэ бүс нутгийн хямралын дам нөлөөг бид судлах ёстой.

Гуравдугаарт Дундад Азийн Түрэг хэлтэй Казахстан, Киргизстан, Узбекистан, Туркмен, Азербайжан дээрээс нь Турк улс нэмэгдсэн хэл, соёл, шашны нийтлэг дээр тулгуурласан улс төр, эдийн засаг магадгүй цэргийн шинэ холбоо бий болох нь. Яг үнэндээ манай их сургуулиудад Араб, Перс, Түрэг судлал маш сул хөгжсөнийг тэмдэглэх хэрэгтэй. Тиймээс юуны өмнө бидэнд энэ чиглэлээр мэргэжсэн хүний нөөц хэрэгтэй. Эдгээр орнуудад Америк, барууны орнууд, Орос, Хятад, Япон, Өмнөд Солонгостой харьцуулахад маш бага оюутнууд сурдаг. Үүнийгээ дагаад Турк улсыг эс тооцвол боловсрол, соёл, шинжлэх ухааны харилцаа сул, хаалттай байна. Тиймээс аль

болох их мэдээлэлтэй байх, өмнөх харилцааны түүх, соёлын ижил төстэй байдлаа судлах, илүү нээлттэй олон талт гадаад харилцаагаа тууштай баримтлах нь чухал юм.

болон технологийн төвлөрөл тэнд бий болж байна. Тиймээс энэ төвтэй харилцах, энэ төвийн соёл, хэл, шашныг мэддэг хүний нөөцөө манай улс бэлдэх хэрэгтэй.

Хоёрдугаарт Ойрх Дорнод тэр дундаа Иранд дэглэм солигдох, эсвэл олон жил үргэлжлэх шинэ дайн гарч магадгүй. Иран бол 90 орчим сая хүнтэй, их удаан жил олон улсын хоригт байсан учир дотооддоо үйлдвэр, технологи хөгжүүлж чадсан улс. Тиймээс энэ бүс нутгийн хямралын дам нөлөөг бид судлах ёстой.

Гуравдугаарт Дундад Азийн Түрэг хэлтэй Казахстан, Киргизстан, Узбекистан, Туркмен, Азербайжан дээрээс нь Турк улс нэмэгдсэн хэл, соёл, шашны нийтлэг дээр тулгуурласан улс төр, эдийн засаг магадгүй цэргийн шинэ холбоо бий болох нь. Яг үнэндээ манай их сургуулиудад Араб, Перс, Түрэг судлал маш сул хөгжсөнийг тэмдэглэх хэрэгтэй. Тиймээс юуны өмнө бидэнд энэ чиглэлээр мэргэжсэн хүний нөөц хэрэгтэй. Эдгээр орнуудад Америк, барууны орнууд, Орос, Хятад, Япон, Өмнөд Солонгостой харьцуулахад маш бага оюутнууд сурдаг. Үүнийгээ дагаад Турк улсыг эс тооцвол боловсрол, соёл, шинжлэх ухааны харилцаа сул, хаалттай байна. Тиймээс аль болох их мэдээлэлтэй байх, өмнөх харилцааны түүх, соёлын ижил төстэй байдлаа судлах, илүү нээлттэй олон талт гадаад харилцаагаа тууштай баримтлах нь чухал юм.

Ашигласан материал

Abai.kz. (2020, 09 12). https://abai.kz/post/122009. Retrieved from https://abai.kz/: https://abai.kz

Erdoğan, R. T. (2017). https://www.youtube.com/watch?v=B2xX5GCq-8M.

Erdoğan, R. T. (2020). https://www.youtube.com/watch?v=hXI9i6wZD0A.

https://fa.wikipedia.org/wiki/%D8%B4%DB%8C%D8%B1%DB%8C%D9%86_%D8%A8%DB%8C%D8%A7%D9%86%DB%8C. (n.d.). Retrieved from https://fa.wikipedia.org/: https://fa.wikipedia.org/

https://haber.dpu.edu.tr/tr/haber_oku/5c23897ac4c7d/doc-dr-altay-tayfun-ozcan-dpunun-gururu-oldu . (2018, Dec 26). Retrieved from https://haber.dpu.edu.tr/: https://haber.dpu.edu.tr/

https://president.mn/31791/. (2025, 01 17). Retrieved from https://president.mn: https://president.mn

https://www.pewresearch.org/religion/2015/04/02/religious-projections-2010-2050/. (2015, Apr 02). Retrieved from https://www.pewresearch.org/r: https://www.pewresearch.org/

Sachs, J. D. (2024, Dec 12). https://www.commondreams.org/opinion/us-israel-syria. Retrieved from https://www.commondreams.org/: ttps://www.commondreams.org

Д. Анхбаяр, Б. Батхишиг . (2016). Ил хаадын замаар . Улаанбаатар : Соёмбо принтинг.

Энхбат, А. (2024). Исламын ертөнц ба Монголчууд . Улаанбаатар: Мөнхийн Үсэг .

SPSIRPA FORUM 2025

Session 4-5

Voter Turnout in Mongolia and Its Influencing Factors

Монголын сонгогчдын оролцоо, түүнд нөлөөлөгч хүчин зүйлс

Н.Мягмарцоож

Доктор (PhD), дэд профессор

Сонгогчдын оролцоо /ирц/ гэдэг нь сонгуулийн санал хураах өдөр сонгогчид санал өгөх эрхээ хэрхэн ашиглаж байгааг илэрхийлдэг бөгөөд саналаа өгсөн сонгогчдын саналын хүчинтэй, хүчингүй, санал тэмдэглээгүй зэргийг оруулан тооцдог. Сонгогчдын ирцийг сонгууль зохион байгуулах эрх бүхий байгууллагаас гаргасан албан ёсны бүртгэлтэй сонгогчдоос эсвэл тухайн улсын сонгуулийн насны хүн амын тооноос тооцох гэсэн хоёр аргыг хэрэглэн гаргадаг. (Abdurashid 2016)

Хүн төрөлхтөн сонгуулийн эртний уламжлалтай хэдий ч ард түмэн төр засгаа сонгож байгуулдаг улс орнуудын тоо 1990 оноос хойш эрчимтэй нэмэгдсэн. Тухайлбал 1971-1980 онд 94 улс, 1981-1990 онд 114 улс төр засгаа сонгуулийн зарчмаар байгуулж байсан бол, 1991-2000 онд 176 улс, 2001 оноос 194 улс болж нэмэгджээ. Энэ нь сонгогчдын тоо нэмэгдэхэд нөлөөлсөн ч, санал өгөх эрхээ эдэлж буй сонгогчдын ирц буурсаар байна. 1940-1980 аад оны хооронд сонгогчдын ирц 78%-аас 76% болж ялимгүй буурсан бол 1990 онд 70%, 2011 он 66%, 2021 оны байдлаар 60% болтлоо буураад байна. (Abdurashid 2016)

Ялангуяа посткоммунист орнуудад сонгогчдын ирц огцом буурч байна. Тухайлбал, 1990 оноос хойш Европын посткоммунист 22 орноос ОХУ, Беларус гэсэн хоёр улсын сонгогчдын ирц тогтвортой, нэмэгдэх төлөвтэй байгаа бол бусад улс орнуудад сонгогчдын ирц дунджаар 18%-иар, Албани улсад сонгогчдын ирц хамгийн их буюу 46%-аар буурчээ. (Abdurashid 2016) Судлаачид посткоммунист орнуудад сонгогчдын ирц буурч байгаа шалтгааныг улс төр, эдийн засаг, нийгмийн тогтолцооны шилжилтийн үеийн хүнд хэцүү байдал, түүнд сэтгэл дундуур байгаатай холбон тайлбарладаг (Mason 2003/04; Kobach 2001; Krastev 2002). Монгол улс посткоммунист орны тоонд орох бөгөөд Ерөнхийлөгч, УИХ, Орон нутгийн сонгуульд оролцох сонгогчдын ирц сүүлийн гучин жил буурсаар байна.

Монголын сонгогчдын ирц (1992 - 2024)

1990 оны ардчилсан хувьсгалын үр дүнд Монгол Улс ардчилсан тогтолцоонд шилжин улс төр, эдийн засаг, эрх зүйн гээд нийгмийн бүхий л тогтолцоо үндсэндээ өөрчлөгдсөн. Ийнхүү Монголын ард түмэн шууд болон төлөөллийн байгууллагаараа дамжуулан төрийг удирдах хэрэгт оролцох боломж бүрдэж, чөлөөт ардчилсан сонгуулиар өөрсдийн төлөөллийг сонгодог болсон. 1992 оны шинэ Үндсэн хууль батлагдсан цагаас хойш манай улсын иргэд төрийн эрх барих дээд байгууллага болох УИХ – ын 9 удаагийн, Ерөнхийлөгчийн 8 удаагийн, ИТХ -ын 8 удаагийн нийт 25 сонгуульд оролцсон байна.

Зураг 1. УИХ, Ерөнхийлөгчийн сонгуулийн ирц (1992 - 2021)



Сонгогчид 1992 оноос парламентын 8 удаагийн сонгуульд оролцохдоо 1992 – 2012 оны хооронд ирц 28,32% - иар буурсан бол 2016 оноос нэмэгдэн 73.58% болж, 2020 онд тогтворжин 73,64% болсон бол 2024 онд 69,4% болж мөн буурчээ. 2024 оны сонгуулийг 1992 онтой харьцуулахад 26,2% - иар буурсан байна. Энэ нь Латви, Украйн, Молдав зэрэг посткоммунист орнуудтай ижил үзүүлэлт юм. (Abdurashid 2016)

Ерөнхийлөгчийн 8 удаагийн сонгуульд 2017 оны 2% - ийн өсөлтийг эс тооцвол 2021 оны сонгуулийн ирцийг 1993 оны сонгогчдын ирцтэй харьцуулахад 33,38% - иар буурчээ. Энэ нь Словани, Болгар, Румын зэрэг посткоммунист орнуудын сонгогчдын ирцийн бууралттай ижил үзүүлэлт юм. (Abdurashid 2016)

Ийнхүү Монголын сонгогчдын ирц буурч байгаа шалтгааныг социализмаас ардчилалд шилжих үеийн улс төр, нийгэм, эдийн засгийн хүндрэл бэрхшээл, сонгуульд оролцох нь иргэний үүрэг биш эрх болсонтой, төрийн байгууллага, албан тушаалтан, улс төрийн намуудад итгэх итгэл буурч байгаа зэрэг хүчин зүйлтэй холбон тайлбарладаг.

Сонгогчдын ирцийг тоон болон хувьчилсан үзүүлэлтээр гаргахаас гадна нас, хүйс зэрэг үзүүлэлтээр шинжилж, харьцуулах нь танин мэдэхүйн болон шинжлэх ухааны судалгааны чухал ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл энэ нь сонгогчдын ирцтэй холбоотой үндсэн асуудлууд, нөлөөлөгч хүчин зүйлс, бэрхшээл зэргийг илрүүлэх замаар ирцийг тогтвортой байлгах, эсвэл нэмэгдүүлэх арга замыг тодорхойлоход чухал нөлөөтэй.

- **Нас.** Сонгогчдын насны тухай мэдээллийг ил тод нарийвчлалтай болгох шаардлага үүсдэг тул Монгол Улс 2016, 2020 онуудад сонгогчдын ирцийг 18-25 нас, 26-35 нас, 36-45 нас, 46-55 нас, 55-аас дээш нас гэсэн 5 бүлэгт хуваажбайсан. 2024 оны УИХ-ын сонгуульд оролцсон иргэдийн ирцийн хувьд нас ахих тусам ирц нэмэгддэг байдал хэвээр хадгалагдаж тэр дундаа 60 – 69 насны иргэдийн ирц хамгийн өндөр буюу 84% – 84,9% байв. Мөн онд 20-24 насныхан 53,1% ирцтэй байгаа нь хамгийн бага үзүүлэлт бөгөөд 18-34 насны залуучуудын ирц 62,1% байжээ. 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар сонгогчдын ирцийн мэдээллийг нийт 12 бүлгээр задлан харуулдаг болсон. (https://turnout.gec.gov.mn/) Сонгогчдын нас ахих тусам сонгуулийн ирц өндөр болдог гэж үздэг ба 2021 оны сонгуулийн үр дүнг харахад 20 ба түүнээс дээш насны сонгогчдын нас ахих тусам ирц нь нэмэгдэж байна. Харин 18-19 настай сонгогчдын ирц бусад залуу сонгогчдын ирцээс илүү байна. (Хүснэгт 1)
- **Хүйс.** Сонгогчдын ирц дэх жендэрийн ялгааны тухай асуудлыг судлаачид олон талаас нь судлан эмэгтэйчүүдийн оролцоо эрэгтэйчүүдээс илүү байдаг талаар хэд

хэдэн судалгааны үр дүн гарсан байдаг (CAWP 2015; Abdurashid 2016). Монголд ч дээрхтэй ойролцоо үр дүн гарч байгаа нь сүүлийн үеийн сонгуулиудаас харагдаж байна. Жишээ нь: 2016 оны сонгуульд эрэгтэйчүүдийн 70,6%, эмэгтэйчүүдийн 76,6% оролцсон бол 2021 онд эрэгтэйчүүд 55,6%, эмэгтэйчүүд 62,83% оролцжээ. Энэ нь 2012 оны УИХ-ын сонгогчдын ирцээр нотлогддог. Насны бүлэг ахих тусам эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 17 хувиар илүү оролцож байсан. Харин 2024 оны УИХ-ын сонгуульд сонгуулийн насны эрэгтэйчүүдийн 65,9%, эмэгтэйчүүдийн 74,1% саналаа өгсөн бөгөөд зөрүү нь 8,2% байна.

Хүснэгт 1. Сонгогчдын ирц ба нийгэм эдийн засгийн зарим үзүүлэлт

№	Аймгууд	2021 оны Ерөнхийлөгчийн сонгууль						Хүн ам	1 хүнд ногдох ДНБ	Өрсөлдөх чадвар 2020
		Нийт ирц	18-19 нас	20-24 нас	25-29 нас	30-34 нас	18-34 нас			
1	Архангай	55.80%	41.41%	31.62%	39.95%	53.02%	41,50%	95067	5875	XVII
2	Баян-Өлгий	58.69%	50.91%	45.89%	45.97%	56.19%	49,74%	105853	3946	XIII
3	Баянхонгор	55.91%	49.47%	36.52%	43.98%	52.87%	45,71%	89329	5636	XIX
4	Булган	56.14%	43.06%	29.52%	35.93%	45.73%	38,56%	61516	5867	XXI
5	Говь-Алтай	57.77%	50.35%	34.93%	40.32%	55.14%	45,19%	88974	5882	XX
6	Говьсүмбэр	61.14%	55.60%	42.33%	48.91%	58.51%	51,33%	18008	6463	V
7	Дархан-Уул	55.95%	55.69%	37.47%	38.61%	49.25%	42,25%	103580	5499	III
8	Дорноговь	60.97%	60.53%	46.18%	49.61%	57.01%	53,33%	71233	5840	II
9	Дорнод	55.69%	57.56%	35.03%	41.12%	49.24%	45,73%	83473	11446	VIII
10	Дундговь	53.29%	47.15%	33.18%	39.58%	46.94%	41,71%	47274	8199	XVI
11	Завхан	61.10%	55.58%	38.73%	44.25%	56.39%	48,73%	73231	5785	XVIII
12	Өвөрхангай	55.80%	48.66%	34.43%	39.72%	52.20%	43,75%	116785	5286	VII
13	Өмнөговь	52.66%	52.40%	38.15%	40.05%	45.76%	44,09%	71248	11870	IV
14	Орхон	58.93%	61.93%	39.44%	44.14%	52.29%	49,45%	105361	20316	I
15	Сүхбаатар	64.75%	59.20%	42.91%	50.13%	60.65%	53,22%	64307	8574	X
16	Сэлэнгэ	51.17%	47.45%	30.25%	33.79%	43.47%	38,74%	108370	7398	IX
17	Төв	54.50%	48.34%	33.20%	36.72%	47.05%	41,32%	93332	7241	XV
18	Увс	58.75%	51.09%	39.43%	43.99%	58.48%	48,24%	84294	5019	VI
19	Ховд	60.65%	55.68%	42.86%	44.92%	57.75%	50,30%	88974	4461	XI
20	Хөвсгөл	55.89%	48.89%	35.98%	41.14%	50.12%	44,03%	136058	5348	XIV
21	Хэнтий	63.75%	58.44%	42.33%	47.15%	59.45%	51,84%	78507	6491	XII
22	Улаанбаатар	61.75%	63.63%	54.08%	51.68%	55.72%	56,27%	1499140	16960	
	Нийт	**59.35%**	**56.45%**	**43.72%**	**46.32%**	**54.04%**	**50,13%**	**3357542**	**11680**	

Сонгогчдын ирцэд нөлөөлөгч хүчин зүйлс

Сонгогчид сонгуулийн өдөр саналаа өгөх шийдвэр гарган оролцоход олон хүчин зүйлс нөлөөлдөг бөгөөд энэ нь нарийн төвөгтэй асуудал учир судлаачид олон талаас нь удаан хугацааны туршид судалсаар ирсэн байдаг (Blais and Dobrzynska 1998; Geys 2006; Abdurashid 2016).

Нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс

Хүн амын тоо. Цөөн хүн амтай орнуудад санал тус бүрийн нөлөө илүү их байдаг тул сонгуульд олон хүн саналаа өгөхөөр ирдэг гэж үздэг.

Хүн амын тогтвортой байдал. Нэг газарт удаан хугацаагаар оршин суудаг хүмүүс ихэвчлэн орон нутгийн асуудал, нэр дэвшигчдийн талаар илүү сайн мэдлэгтэй байдаг бөгөөд тэдний өдөр тутмын амьдралд нөлөөлөх улс төрийн шийдвэрт илүү их санаа зовдог. Тиймээс тэд сонгуульд санал өгөх магадлал өндөр байдаг. Нөгөө талаар нэг газраас нөгөөд ойр ойрхон нүүдэллэх нь хүмүүсийн улс төрийн үйл явцад оролцох хүслийг бууруулж болзошгүй юм.

Эдийн засгийн хөгжил. Өндөр хөгжилтэй орнуудад хүмүүс илүү их мэдээлэлтэй, улс төрийн үйл явцад оролцдог гэсэн нийтлэг ойлголт байдаг бол эдийн засгийн бэрхшээл нь сонгогчдын хайхрамжгүй байдлыг үүсгэж, хүмүүсийг улс төрөөс холдоход хүргэж, үндсэн хэрэгцээгээ хангахад анхаарлаа төвлөрүүлдэг тул эдийн засгийн бэрхшээл нь улс төрийн оролцоонд сөргөөр нөлөөлдөг гэж үздэг.

Улс төрийн хүчин зүйлс

Улс төрийн бодлого, зорилт. Сонгуульд оролцож байгаа нам эвсэл, нэр дэвшигчид сонгогчдын тодорхой хэсгийн дэмжлэгийг авахаар, тэдэнд ашигтай, сонгуульд оролцох сэдэл төрүүлсэн бодлого зорилтыг дэвшүүлэх нь сонгогчдын оролцоонд нөлөөлдөг гэж үздэг.

Улс төрийн институцид итгэх итгэл. Ерөнхийлөгч, УИХ, ИТХ зэрэг иргэд өөрсдөө сонгодог улс төрийн институциас гадна бусад төрийн байгууллагад итгэх итгэл сул байх нь сонгогчдын ирцэд сөргөөр нөлөөлдөг.

Сонголт хийх боломж. Сонгуульд өрсөлдөх нам эвсэл, нэр дэвшигчдийн тоо болон сонголт хийх боломж өргөн байх нь сонгогчдын ирцэд эерэгээр, бага байх нь сөргөөр нөлөөлдөг байна.

Тогтолцооны хүчин зүйлс

Сонгуулийн тогтолцоо. Сонгуулийн пропорциональ тогтолцоог ашигладаг сонгуульд сонгогчдын ирц мажоритар системийг ашигладаг сонгуулиудаас илүү өндөр байдаг.

Албадан санал хураалт. Мэдээжийн хэрэг сонгогчид хуулийн дагуу санал өгөх үүрэг хүлээсэн тохиолдолд ирц эрс нэмэгддэг.

Зэрэгцээ сонгууль. Нэг өдөр хэд хэдэн сонгууль болоход сонгогчдын ирц ихэвчлэн өндөр байдаг.

Санал хураалтын зохион байгуулалт. Санал хураалтын янз бүрийн зохион байгуулалтын загвар нь сонгогчдын ирцэд нөлөөлж болно. Үүнд санал өгөх өдөр, амралтын эсвэл ажлын өдрүүдэд явагдах сонгууль, санал өгөх технологийн боломж, санал авах байрны байршил, урьдчилсан санал хураалт, шуудангаар болон цахимаар санал өгөх, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр санал өгөх зэрэг олон асуудлууд нөлөөлж болно.

Хувь хүний хүчин зүйл

Нас. Нас бол сонгогчдын ирцэд нөлөөлөх хамгийн чухал хүчин зүйлүүдийн нэг юм. Монголын залуу сонгогчдын ирц тухайн жилийн сонгуулийнхаа дундажаас 2012 онд 26,2%, 2016 онд 22,8%, 2020 онд 9,6%, 2021 онд 8,2%, 2024 онд 16,1% доогуур байсан нь нас ахих тусам сонгогсчдын оролцоо нэмэгддэг олон улсын зүй тогтолтой ижил үр дүнг харуулж байна.

Боловсрол. Боловсролын түвшин өндөр байх нь ерөнхийдөө сонгогчдын ирц өндөр байгаатай холбоотой байж ч зарим судалгаагаар энэхүү үр дүн өөр байх тохиолдлууд байна (International IDEA 2006).

Улс төрийн боловсрол. Улс төрийг сонирхох нь сонгуулийн ирцэд нөлөөлөх чухал хүчин зүйл байж болно. Сургууль болон залуучуудын дунд иргэний боловсролыг олгохдоо улс төрийн үйл явцыг сонирхох сонирхлыг хөхиүлэн дэмжиж, нийгэм, улс төрийн хэлэлцүүлэг, мэтгэлцээн, сургалт, семинар зохион байгуулах зэргээр улс төрийн боловсролыг нэмэгдүүлэх боломжтой.

Иргэний үүрэг. Иргэний үүргийн тухай ойлголт нь сонгуульд санал өгөх хандлагад нөлөөлдөг хамгийн чухал хүчин зүйлүүдийн нэг юм. Олон хүмүүс улс төрийн шийдвэр гаргахад хувь нэмэр оруулах нь тэдний үүрэг гэж ойлгодог. Тухайлбал энэ нь анх сонгуулийн насанд хүрч буй залуучуудад илүү ажиглагддаг. Жишээ нь: 2021 оны сонгуулиар 18-19 насны сонгогчдын ирц 20-24 насны сонгогчдоос 12,73%, 25-29 насны сонгогчдоос 10,13%, 30-34 насны сонгогчдоос 2,41% - иар тус тус их байна. 2024 онд 18-19 насны иргэдийн ирц 63% байсан нь 20-29 насны иргэдээс өндөр үзүүлэлт байжээ.

Дүгнэлт

Л.Даймонд “Сонгогчдын оролцоо бага байгаа нь ардчиллын дархлаа сул байгаагийн шинж” гэсэн нь сонгууль ардчилал, түүний хөгжилд хэр ач холбогдолтойг нотолж буй хэрэг юм хэмээн дүгнэсэн байдаг.

Сонгогчдын ирцэд нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах нь нарийн төвөгтэй, цаг хугацаа шаардсан, тухайн улсын нийгэм улс төрийн тогтолцоо, нийгмийн байдал зэрэг олон зүйлтэй хамааралтай учир цаашид нарийвчилан судлах шаардлагатай.

Сонгогчдын ирцийг нэмэгдүүлэхийн тулд дараах арга замыг ашиглах хэрэгтэй. Үүнд:

- Эрх зүйн орчныг боловсронгуй болгох. Сонгуулийн хууль тогтоомжид урьдчилан санал өгөх, шуудангаар санал өгөх гэх мэт хэлбэрүүдийг нэмэх, боловсронгуй болгох, Ерөнхийлөгчийн сонгуулийн үед шилжилт хөдөлгөөн хийхгүйгээр байгаа газраа саналаа өгөх боломжийг сонгогчдод олгох гэх мэт.
- Мэдээллээр хангах. Сонгогчид тэр дундаа залуучуудад зориулсан сонгуулийн ач холбогдол, сонголт хийхийн давуу тал, үр өгөөж, сонгууль өгөх заавар, зөвлөмж зэргийг мэдээллийн төрөл бүрийн сувгийг ашиглан түгээдэг байх
- Залуучуудад улс төрийн боловсрол /иргэний боловсрол/ олгох тогтолцоог бий болгох, боловсронгуй болгох.

SPSIRPA FORUM 2025

Session 4-6

Russia–North Korea Relations at a New Stage: Implications for the Northeast Asian Region

ОХУ, БНАСАУ-ын харилцаа шинэ шатанд: Зүүн Хойд Азийн бүс нутагт нөлөөлөх нь

Д.Оюунцэцэг (Ph.D)[97]

Хураангуй

ОХУ-ын ерөнхийлөгч Владимир Путины БНАСАУ-д хийсэн төрийн айлчлалын үр дүнд хоёр улсын харилцаа иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны түвшинд шат ахисан юм. 2024 оны 6-р сарын 19-ны өдөр үзэглэсэн ОХУ, БНАСАУ-ын стратегийн түншлэлийн харилцааны тухай гэрээний IV зүйл, цэргийн харилцан дэмжлэг үзүүлэх тухай заалт хэрэгжиж эхэлснээр уг гэрээ нь энгийн гэрээний агуулгаар хязгаарлагдахгүй нь тодорхой болж, хоёр улсын стратегийн түншлэлийн харилцаа мөн чанарын хувьд холбоотны харилцаанд хүрээд байна. Энэхүү илтгэлд шинэ шатанд гарсан БНАСАУ, ОХУ хоорондын харилцаа, цэрэг улс төрийн хамтын ажиллагаа хэрхэн өрнөж байгаа хийгээд тэрхүү өрнөлт хоёр орны Зүүн Хойд Азийн бүс нутгийн орнуудтайгаа харилцах харилцаанд хэрхэн нөлөөлж байгаа талаар авч үзнэ. Илтгэлд хоёр талын өндөр албан тушаалтнуудын харилцан айлчлалын үеэр хэлсэн үг, мэдэгдлүүд, цаг үеийн мэдээ мэдээллийг үндсэн эх сурвалж болгон анализ хийхийг хичээсэн болно.

Түлхүүр үг: ОХУ, БНАСАУ-ын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа, Умард Солонгосоос ОХУ руу цэрэг илгээсэн асуудал, Зүүн хойд Ази, Япон, БНСУ, БНХАУ-ын гурван талт хамтын ажиллагаа.

1. БНАСАУ, ОХУ-ын түншлэлийн харилцаа, нягт хамтын ажиллагаа

БНАСАУ-ын төр засгийн улс төрийн үүрэг, гадаад бодлогын эрхэм зорилго бол улс төрийн тогтолцоо, үзэл баримтлал, түүнчлэн цөмийн зэвсэгтэй улс хэмээх статусаа олон улсын тавцанд бүрэн хүлээн зөвшөөрүүлэх нь юм. Энэхүү эрхэм зорилгынхоо хүрээнд тус улс өнгөрсөн хоёр жилд дотоод, гадаад бодлогодоо стратегийн эрс өөрчлөлтүүдийг хийж, түүнийг дагасан томоохон алхамууд хийсэн. Үүнд “Хоёр үндэстэн, дайсагнагч хоёр улсын тухай үзэл баримтлал” хэмээх БНСУ-тай харилцах шинэ чиг шугам болон шинэ шатанд ахиулсан ОХУ-тай харилцах “иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа”, эдгээр стратегийн өөрчлөлтүүдийн хүрээнд авч хэрэгжүүлсэн улс төрийн арга хэмжээ, цэргийн ажиллагаанууд нэн тэргүүнд эрэмбэлэгдэнэ.

БНАСАУ нь “Хоёр үндэстэн, дайсагнагч хоёр улсын тухай үзэл баримтлал”-тай холбоотойгоор өмнөд Солонгосоос бүрмөсөн тусгаарлах, цэргийн үйлдвэрлэлийн технологийг боловсронгуй болгон хөгжүүлэх замаар батлан хамгаалах хүчнийг бэхжүүлэх, цаашлаад БНСУ-АНУ-Японы эвслийн эсрэг ОХУ-тай харилцаагаа улам бүр идэвхижүүлэн хөгжүүлэх бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлсэн юм.

[97] МУИС-ийн ШУС-ийн Ази судлалын тэнхмийн ахлах багш
oyuntsetsegd@num.edu.mn ; oyuna@snu.ac.kr

Шинэ эрин үеийн ОХУ, БНАСАУ-ын харилцаа 2018 онд боловсрол, шинжлэх ухаан, тээврийн салбарын хамтын ажиллагааны тухай протоколд гарын үсэг зурснаас хойш идэвхжиж эхэлсэн. 2019 оны 4-р сарын 24-нд ОХУ-ын Владивосток хотод болсон дээд хэмжээний уулзалтаар ОХУ, БНАСАУ-ын уламжлалт найрсаг харилцааг улам бүр бэхжүүлэн хөгжүүлэх талаар тохиролцож, Солонгосын хойгийн байдал, цөмийн зэвсгийн асуудал, БНАСАУ-ын аюулгүй байдлын талаарх олон улсын баталгаа зэрэг асуудлаар санал солилцжээ.[98] Орос Украины дайн эхэлснээс хойш умард Солонгос ОХУ-ын талд зогсож, Украины асуудлаарх Оросын эсрэг НҮБ-ын тогтоолын төсөлд татгалзсан санал өгөх зэргээр олон улсын тавцанд ч байр сууриа илэрхийлсээр ирсэн нь хоёр улсын харилцааг улам бүр ойртуулсан юм. 2023 оны 9-р сарын 13-нд БНАСАУ болон ОХУ-ын төрийн тэргүүд ОХУ-ын Восточный сансрын баазад хийсэн дээд хэмжээний уулзалт 2024 онд өрнөсөн хоёр улсын ойр дотно харилцааны эхлэл болжээ. Уг уулзалтын үеэр хоёр тал улс орныхоо бүрэн эрх, бүс нутаг, дэлхий нийтийн энх тайван, аюулгүй байдал, шударга ёсыг хамгаалахад стратеги, тактикийн хамтын ажиллагаагаа улам бүр нягтруулан, хамтын хүчээ нэгтгэн тэмцэхээ илэрхийлж, хамтран туслалцах асуудлуудыг хэлэлцсэн байна.[99]

2024 оны 6-р сарын 19-ний өдөр ОХУ-ын ерөнхийлөгч Владимир Путин нөхөр Ким Жон Уны урилгаар БНАСАУ-д дээд хэмжээний айлчлал хийв. Тус айлчлалын үеэр хоёр улсын тэргүүд “ОХУ, БНАСАУ-ын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны тухай гэрээ”-нд гарын үсэг зурж, хамтарсан мэдэгдэл хийсэн юм. Уг хамтарсан мэдэгдэлд дурдсанчлан, нөхөр Ким Жон Ун “БНАСАУ-ын засгийн газар ОХУ-тай байгуулсан иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа, *ялагдашгүй холбоотны харилцаагаа* тасралтгүй хөгжүүлэхийн тулд энэхүү *гэрээгээр хүлээсэн үүргээ* өчүүхэн ч эргэлзээгүй *чин үнэнчээр биелүүлэх болно*” хэмээн хатуу мэдэгдсэн. Энэ нь шинэ түвшинд гарсан харилцаа холбоотноо харилцаа мөн гэдгийг шууд илэрхийлсэн хэрэг бөгөөд батлан хамгаалах салбарын харилцаа, тухайлбал маргаан дэгдээгээд байгаа цэрэг, зэвсгийн асуудал хэдийнээ шийдэгдсэн байх магадлалтайг харуулж байна.

ОХУ-ын ерөнхийлөгч Владимир Путин "БНАСАУ, ОХУ-ын хооронд байгуулсан иж бүрэн стратегийн түншлэлийн тухай гэрээ нь хоёр улс хоорондын харилцаагаа *чанарын шинэ түвшинд гаргах* хүсэл эрмэлзлийг бодит амжилт болгосон баримт бичиг юм" онцлон тэмдэглэсэн байна. Тэрээр “... БНАСАУ нь өөрийн батлан хамгаалах чадвараа бататган бэхжүүлж, улс орныхоо аюулгүй байдлыг батлан хамгаалах, бие даасан байдлаа сахин хамгаалах бүрэн эрхтэй гээд ОХУ нь цаашид Солонгосын хойг дээр зэвсэгт мөргөлдөөн дахин үүсэх аюул заналыг устгаж, энэ бүс нутагт урт хугацааны энхтайван, тогтвортой байдлын тогтолцоо бүрэлдэн тогтоход *улс төр, дипломатын хүчин чармайлт гаргах болно*” хэмээн мэдэгдсэн. Үүгээрээ ОХУ Зүүн хойд Азийн аливаа асуудалд шууд оролцох болно гэдгээ илэрхийлсэн гэж үзэж болно. Мөн “ ... *Өнөөдөр байгуулсан энэхүү баримт бичгийг үзэглэсэн улсуудын аль нэг тал гадны дайралт, түрэмгийлэлд өртсөн тохиолдолд харилцан туслалцах ... шаардлагатай үед БНАСАУ-д цэргийн техник*

[98] “Итоги встречи Владимир Путина и Ким Чен Ына”, ТАСС, 2019.04.25.
[99] 김정은총비서 로씨야대통령과 회담, 조선중앙통신, 2023.09.14.

технологийн туслалцаа үзүүлэх замаар хамтран ажиллахыг үгүйсгэхгүй.”[100] гээд *“НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс умард Солонгосын эсрэг тавьсан хугацаагүй хоригийг эргэн харах хэрэгтэй гээд Солонгосын хойгийн хурцадмал байдал хурцадсанд Хойд Солонгосыг буруутгахыг хэзээ ч зөвшөөрөхгүй”*[101]гэж онцлон тэмдэглэсэн нь хоёр улсын хооронд цэргийн холбоотны харилцаа тогтоосон гэдгийг дахин нотолсон явдал юм.

“ОХУ, БНАСАУ-ын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны тухай гэрээ”-ний заалтуудаас тодорхой харагдана. Гэрээний I зүйлд ерөнхий харилцааны зарчмыг зааж өгсөн бол II зүйлд олон улсын тавцан дахь хамтын ажиллагаа, ялангуяа олон улсын шинэ дэг журам тогтоохын төлөө стратеги тактикийн хамтын ажиллагаагаа бэхжүүлнэ гэж заажээ. Дэлхий нийтийн анхаарлыг хамгийн ихээр анхаарал татсан зүйл бол уг гэрээний III-V зүйлд цэргийн хамтын ажиллагаа, цэргийн холбоотны үүрэг хүлээсэн агуулга бүхий заалтууд юм. Гэрээний III зүйлд гэрээнд оролцогч талуудын аль нэгд нь зэвсэгт түрэмгийллийн шууд аюул заналхийлсэн тохиолдолд хоёр тал хариу арга хэмжээний талаар тохиролцох зорилгоор яриа хэлэлцээрийн сувгийг нэн даруй идэхжүүлэх тухай заасан. Гэрээний IV зүйлд талуудын аль нэг нь зэвсэгт түрэмгийлэлд өртөж, дайны нөхцөл байдалд шилжсэн тохиолдолд нөгөө тал нь өөрийн мэдэлд буй бүх хэрэгслээр цэргийн болон бусад тусламжийг цаг алдалгүй үзүүлэхээр заасан. Харин гэрээний V зүйлд талууд нөгөө талын эрх ашигт халдсан аливаа гэрээг гуравдагч улстай байгуулахгүй, эрх ашгийг хөндсөн аливаа үйл ажиллагаанд оролцохгүй, нутаг дэвсгэрээ ашиглуулахгүй байхыг үүрэг болгосон байна.[102] 1961 онд байгуулсан ЗХУ, БНАСАУ-ын найрсаг хамтын ажиллагаа, харилцан туслалцах тухай гэрээнд ижил төстэй агуулгатай зүйл заалтууд байсан бол 2000 онд шинэчлэн байгуулсан “ОХУ, БНАСАУ-ын сайн хөршийн найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ”-нээс хасагдсан байжээ.

Түүнчлэн сансар судлал, биологи, энхтайвны цөмийн эрчим хүч, хиймэл оюун ухаан, мэдээллийн технологи гэх мэт шинжлэх ухаан, технолгийн салбарт хамтран ажиллах, хамтарсан судалгаа явуулахыг дэмжих тухай заасан Х зүйлийн заалт нь ОХУ-ын зүгээс умард Солонгосын цөмийн технологийн хөгжүүлэлтэд туслалцаа үзүүлэх эрх зүйн орчинг хангаж өгсөн гэж өмнөд Солонгосын судлаачид үзэж байна. Өмнө байгуулагдаж байсан хоёр талт гэрээнүүдээс ялгаатай нь умард, өмнөд Солонгосын нэгдлийн талаар уг гэрээнд огт дурдаагүй явдал нь “Хоёр үндэстэн, дайсагнагч хоёр улсын үзэл баримтлал”-ыг ОХУ-ын тал хүлээн зөвшөөрсний илэрхийлэл хэмээн судлаач Ча Дү Хёнь үзжээ.[103] Уг гэрээг 2024 оны 11-р сарын 11-ний өдөр Пёнян хотноо, 12-р сарын 4-ний өдөр Москва хотноо тус тус соёрхон батлснаар гэрээ албан ёсоор хүчин төгөлдөр болсон.

Хоёр улсын харилцааг шинэ шатанд ахиулсан ОХУ-ын ерөнхийлөгч Владимир Путины дээд хэмжээний айлчлалын бэлтгэл ажил хийгээд уг айлчлалын үеэр хийгдсэн иж бүрэн

[100] 김정은 총비서 조로 전략적동반자 관계 조약에 서명, 조선중앙통신, 2024.06.20.

[101] Мөн тэнд.

[102] 조선과 로씨야 사이의 포괄적인 전략적동반자관계에 관한 조약 전문, 조선중앙통신, 2024.06.20.

[103] 차두현, 북러 밀착관계와 ‘북러 포괄적인 전략적 동반자관계에 관한 조약’의 함축성, 아산정책연구원 이슈브리프, 2024.07.31. https://www.asaninst.org/

стратегийн түншлэлийн гэрээний зүйл заалтуудыг хэрэгжүүлэх асуудлаарх хоёр талын өндөр албан тушаалтнуудын харилцан айлчлалыг өргөн хүрээнд зохион байгуулсан. Богино хугацаанд эрс идэвхжсэн ОХУ, БНАСАУ-ын ойр дотно харилцаа нь хоёр талд асар их нийтлэг ашиг сонирхол байгааг харуулж байна. Айлчлалын үеэр хийгдсэн уулзалтууд хоёр талын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны ач холбогдлыг онцлон тэмдэглэж, гэрээний зүйл заалтыг бодитоор ажил хэрэг болгон хэрэгжүүлэх талаар санал солилцоход чиглэсэн. Цэрэг арми, улс төрийн албаны төлөөлөгчид Орос Украины дайны асуудлаар харилцан ойлголцол, зорилго нэгтэй байгаагаа илэрхийлсэн.

2024 онд хоёр улсын хооронд өндөр түвшний төлөөлөгчдийн 20 удаагийн албан ёсны болон ажлын айлчлал зохион байгуулагдсны дотор БНАСАУ-ын Гадаад хэргийн сайд Чүэ Сон Хигийн ОХУ-д хийсэн удаа дараагийн айлчлал, ОХУ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Сергей Шойгу, Батлан хамгаалах яамны сайд Андрей Белоусов, дэд сайд Алексей Криворучко нарын БНАСАУ-д ажилласан айчлалуудыг онцлон дурдаж болно.

Гадаад хэргийн сайд Чүэ Сон Хи өнгөрсөн онд ОХУ-д гурван удаа айлчилж, ерөнхийлөгч Владимир Путинд бараалхаж, Гадаад хэргийн сайд Сергей Лавровтай уулзалт хийсэн. 2024 оны 1-р сарын 15-17-ны өдрүүдэд хийсэн эхний айлчлал нь Пёнянд болсон дээд хэмжээний уулзалтын бэлтгэл ажлын хүрээнд хийгдсэн, өндөр ач холбогдолтой, үр дүнтэй айлчлал болсон гэж үзэж болно. 9-р сард хийсэн түүний дараагийн айлчлал Санкт Петербург хотноо зохион байгуулагдсан Евроазийн эмэгтэйчүүдийн IV форум болон БРИКС-ийн эмэгтэйчүүдийн форумд оролцох зорилготой байсан бол гурав дахь айлчлал нь 10-р сарын 28-наас 11-р сарын 6-ны өдрүүдэд үргэлжилж, 6-р сард үзэглэсэн иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны тухай гэрээний зүйл заалтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодит асуудлуудыг хэлэлцэж, “Харилцаа холбоо, мэдээлэл технологи, усны нөөцийг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах тухай хэлэлцээр (2024.10.30)”-т гарын үсэг зурсан. Тэрээр 11-р сарын 1-ний өдөр болсон Гадаад хэргийн сайд нар стратегийн яриа хэлэлцээрийн үеэр Чүэ Сон Хи сайд “Бид Орос нөхдийн ялалтын өдрийг хүртэл тууштай хамт байх болно” хэмээн Орос Украины асуудлаарх Засгийн газрын байр суурыг илэрхийлсэн байна. [104]

Харин ОХУ-ын талаас хийсэн айлчлалуудын тухайд, стратегийн түншлэлийн гэрээ хийснээс хойш цэрэг аюулгүй байдал, батлан хамгаалахын өндөр дээд албан тушаалтнуудын айлчлал голлсон. Тухайлбал, Батлан хамгаалах яамны дэд сайд Алексей Криворучко (2024.07.18), Аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Сергей Шойгу (2024.09.13), Батлан хамгаалах яамны сайд Андрей Белоусов (2024.11.29-30) нар БНАСАУ-д албан ёсны айлчлал хийсэн. ОХУ-ын зэвсэгт хүчин, батлан хамгаалахын дээд удирдлагууд айлчлалынхаа үеэр Ким Жон Унтай уулзалт хийж, хоёр улс иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаагаа батлан хамгаалах салбараас авхуулаад бүх салбарт

[104] 최선희 외무상 로씨야대통령을 의례방문, 조선중앙통신, 2024.01.17.
조로외무상의 회담, 조선중앙통신, 2024.01.17.
최선희 외무상 로씨야외무상과 담화, 조선중앙통신, 2024.09.19.
조로 체신 및 정보기술, 수자발전분야 협조에 대한 합의서 조인, 조선중앙통신, 2024.10.31.
최선희 외무상과 로씨야외무상 사이의 전략대화에 대한 공보문, 조선중앙통신, 2024.11.02.

гүнзгийрүүлэн хөгжүүлэх, хурдацтай өөрчлөгдөж буй бүс нутаг, олон улсын аюулгүй байдлын орчинд харилцан ашиг сонирхлоо хамгаалах зэрэг асуудлаар өргөн хүрээтэй санал солилцож, нэгдмэл ойлголтод хүрсэн бүтээлч яриа хэлэлцээ өрнүүлсэн хэмээн умард Солонгосын төв хэвлэлүүд мэдээлсэн байна. Нөхөр Ким Жон Ун 9-р сарын 13-ны өдөр Сергей Шойгутай хийсэн уулзалтынхаа үеэр шинэ эрин үеийн БНАСАУ, ОХУ-ын харилцаа нь бүс нутаг, дэлхий дахинд энхтайван, шударга ёсыг сахин хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэх болно гээд үүнд хоёр талын цэрэг армийн хамтын ажиллагааг улам бүр батжуулан бэхжүүлэх нь чухал болохыг онцолсон. Тэрээр Андрей Белоусовтой уулзах үеэрээ хоёр талын шат ахисан харилцаа нь бүс нутгийн болон олон улсын тогтвортой байдлыг хангах *аюулгүй байдлын хүчирхэг механизм* болохыг онцлон тэмдэглэхийн сацуу БНАСАУ-ын төр засаг, цэрэг арми, ард түмэн Украины асуудлаарх ОХУ-ын бодлого шийдвэрийг цаашид ч хэлбэрэлтгүй дэмжих болно гэжээ. Алексей Криворучкотой уулзах үеэрээ манай хоёр улсын уламжлалт түүхэн харилцаа шинэ нөхцөл байдалд *цэргийн холбоотны харилцаа*-гаар үргэлжилж байна хэмээгээд Украинд өрнөж буй нөхцөл байдалд ОХУ-ыг тууштай дэмжихээ илэрхийлсэн байна. [105] Умард Солонгосын тал хоёр тал стратегийн түншлэлийн харилцааг давсан цэргийн холбоотны харилцаа тогтоосондоо, цаашлаад бүс нутгийн болон олон улсын тавцанд хамтран ажиллаж, харилцан туслалцах хүчирхэг анд нөхөртэй болсондоо ихэд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн хэрэг юм.

Он гарсаар эхний таван сарын хугацаанд хоёр талын өндөр албан тушаалтнуудын харилцан айлчлал 10 гаруй удаа явагдсан байна. 2025 онд хийгдсэн айлчлалуудын дотроос ОХУ-ын АБЗ-ийн нарийн бичгийн дарга Сергей Шойгугийн нэг өдрийн айлчлал өндөр ач холбогдолтой болж өнгөрсөн. Нөхөр Ким Жон Ун Сергей Шойгуг хүлээн авч уулзан, хоёр талын харилцаа, аюулгүй байдал, ашиг сонирхол, бүс нутаг, олон улсын нөхцөл байдлын талаар өргөн хүрээнд санал бодлоо солилцож, нэгдмэл байр суурьтай байгаагаа харилцан илэрхийлжээ. Талууд хоёр орны хооронд байгуулсан иж бүрэн стратегийн түншлэлийн тухай гэрээний заалтуудыг *болзолгүй хэрэгжүүлэх* нь зүйтэй гээд аюулгүй байдал төдийгүй бүхий л салбарын солилцоо, хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэх, бэхжүүлэх хэтийн төслүүдийн талаар ярилцсан байна. Нөхөр Ким Жон Ун “Оросын арми, ард түмний хийж буй цэргийн тусгай ажиллагаа нь тэдний эх оронч үзэл, шударга ёсны төлөөх тэмцэл гээд ОХУ-ын бүрэн эрх, тусгаар тогтнол, эх орныхоо ирээдүйн ашиг сонирхлыг хамгаалах тэмцлийг ямагт дэмжих нь БНАСАУ-ын засгийн газрын *тууштай сонголт, гуйвшгүй хүсэл* юм” хэмээн өөрийн улсын байр сууриа илэрхийлсэн байна.[106] Хоёр цаг гаруй үргэлжилсэн хэлэлцээний төгсгөлд Шойгу хэвлэлийнхэнд хандаж хэлэхдээ, "Орос улс стратегийн түншлэлийн түвшинд хүрсэн харилцаагаа өндрөөр үнэлж, улам бүр гүнзгийрүүлэхийг зорьж байна гэж онцлон

[105] 김정은총비서 로씨야 군사대표단 접견, 조선중앙통신, 2024.07.19.
김정은총비서 로씨야 안전리사회 서기장을 접견, 조선중앙통신, 2024.09.14.
김정은총비서 로씨야 국방상 접견, 조선중앙통신, 2024.11.30.
[106] 김정은총비서 로씨야 안전리사회 서기장을 접견, 조선중앙통신, 2025.03.22.

тэмдэглээд өнөөдрийн эрчимтэй өөрчлөгдөж буй нөхцөл байдалд хангалттай ашигтай, нилээн чухал, нэн шаардлагатай яриа хэлэлцээ хийсэн" гэж дүгнэжээ.[107]

СХН-ын ТХ-ны Улс төрийн товчооны гишүүн, Намын ТХ-ны нарийн бичгийн дарга Ли Хи Ён айчлалынхаа үеэр ОХУ-ын ерөнхийлөгч Владимир Путинд бараалхаж, ОХУ-ын Аюулгүйн зөвлөлийн орлогч дарга, "Нэгдсэн Орос" намын дарга Дмитрий Медведев нарын албаны хүмүүстэй уулзсан нь түүний айлчлалыг ОХУ-ын зүгээс чухалчлан авч үзсэнийг харуулж байна.[108] Уулзалтын үеэр нөхөр Медведев Орос, умард Солонгосын харилцаанд хөгжлийн шинэ эрин үе ирсэн гээд өнгөрсөн онд байгуулсан стратегийн түншлэлийн харилцааны тухай гэрээ нь олон улсын эрх зүйд бүрэн нийцсэн, өөрчлөгдөж буй бодит байдлыг бүрэн харгалзан үзсэн гэрээ болсон гэж сайшаагаад БНАСАУ нь ОХУ-ыг дэмжиж байгаад талархлаа илэрхийлээд өөртөө эзэн байх бүрэн эрхээ хамгаалах, аюулгүй байдлаа хангахын тулд танай улсын авч явуулж буй бүр арга хэмжээ *хуульд нийцсэн, зөв зохистой* зүйл гэж онцлон тэмдэглэсэн. [109] Сергей Шойгугийн айлчлалын дөнгөж өмнөхөн Гадаад хэргийн дэд сайд Андрей Руденко тэргүүтэй төлөөлөгчид Пёнян хотод ГХЯ хоорондын зөвлөлдөх уулзалт хийж, иж бүрэн стратегийн түншлэлийн гэрээний дагуу хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх бодит арга хэмжээний талаар дэлгэрэнгүй ярилцаж, олон улсын тавцанд харилцан дэмжлэг, хамтын ажиллагаагаа бэхжүүлэх алхмуудыг тохиролцсон байна.[110] Энэ үед умард Солонгосын цэрэг ОХУ-ын Украинтай хийж буй тусгай ажиллагаанд оролцсон талаар албан ёсны мэдэгдлүүд гараагүй байсан хэдий ч хоёр улсын өндөр албан тушаалтнуудын айлчлалын үеэр хийсэн мэдэгдлүүдээс талууд цэрэг, батлан хамгаалах, аюулгүй байдлын салбарт илүү нягт ажиллаж байгаа хийгээд стратегийн түншлэлийн гэрээний III, IV заалтууд энгийн гэрээний агуулгаар хязгаарлагдахгүй болсныг тодорхойлж байна.

Хоёр улсын ойр дотно харилцааг илэрхийлэх томоохон үйл явдал болсны нэг нь 2025 оны 5-р сарын 9-ны өдөр нөхөр Ким Жон Ун БНАСАУ-д суугаа ОХУ-ын элчин сайдын яаманд зочилж, Оросын ард түмэнд аугаа их ялалтын 80 жилийн ойн баярын мэндчилгээ дэвшүүлсэн явдал байлаа. Тэрээр хэлсэн үгэндээ "БНАСАУ, ОХУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны гэрээ байгуулсан явдал нь хоёр улсын ард түмэн мөнхийн ахан дүүс байж, *холбоотон улсуудын хувиар* зовлон жаргалаа хуваалцан, дэлхий дахины энх тайван, стратегийн тогтвортой байдлыг хангахад хувь нэмэр оруулахыг эрмэлзсэн хүсэл зоригийн хамгийн тод илэрхийлэл байлаа" гээд "*хоёр улсын харилцаа холбоотны мөн чанараа сэргээж*, энэ нь өөрөөр байх боломжгүй хувь заяаны сонголт байсан юм" хэмээн холбоотон улс гэж үзэж байгаа илэрхийлсэн.*[111]*

---

[107] "Секретарь Совета Безопасности России Сергей Шойгу прибыл в Пхеньян, где провел переговоры с Председателем Государственных дел КНДР Ким Чен Ыном", Совета Безопасности Российской Федерации, 2025.03.21.

[108] Путин встретился в Кремле с секретарем ЦК Трудовой партии Кореи Ли Хи Ёном, Известия, 2025.02.27.

[109] 리히용비서 "통일로씨야" 위원장을 만났다. 조선중앙통신, 2025.02.28.

[110] Руденко обсудил в Пхеньяне ситуацию на Корейском полуострове", ТАСС, 2025.03.17.

[111] 김정은총비서주조 로씨야대사관에서 축하연설, 조선중앙통신, 2025.05.10.

2. БНАСАУ-аас ОХУ руу цэрэг илгээсэн асуудлын тухайд

ОХУ-ын цэрэг улс төрийн өндөр албан тушаалтнуудын айлчлалын дараа “БНАСАУ болон ОХУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны тухай гэрээ”-нд тусгасан цэргийн холбоотны үүрэг хүлээсэн агуулга бүхий заалтууд бодитоор хэрэгжих болсон тухай мэдээ олон улсын мэдээллийн агентлагуудаар дамжин тархсан. Украины ерөнхийлөгч Володимир Зеленский 2024 оны 10-р сарын 13-ны өдөр Дээд Рада буюу парламентын танхимд хийсэн мэдэгдэлдээ өөрийн тагнуулын албанаас авсан мэдээгээр умард Солонгос Орос руу цэрэг илгээсэн талаар мэдэгдсэн. Түүний мэдэгдлийн дараахан Украины болон өрнөдийн мэдээллийн агентлагууд умард Солонгос ОХУ руу цэрэг илгээсэн тухай мэдээлж эхэлсэн.[112] Украины БХЯ-ны тагнуулын албаны дарга Кирилл Буданов “Алс дорнодод сургуулилт хийж байгаа хойд Солонгосын 10 мянган цэрэг ирэх сарын 1 гэхэд байлдааны бэлэн байдалд орно. Тэдний 2600 цэрэг нь Курскт ирнэ” гэж мэдэгдэж байв. Өмнөд Солонгосын Үндэсний тагнуулын алба 2024 оны 10-р сарын 18-ны өдөр ОХУ-ын тэнгисийн цэргийн тээврийн хөлөг онгоцоор умард Солонгосын ардын армийн тусгай хүчнийхнийг Владивосток руу тээвэрлэж байгааг илрүүлсэн тухай мэдээлж байсан юм.[113]

Тагнуулын байгууллагууд, мэдээллийн эх сурвалжууд умард Солонгосоос ОХУ руу цэрэг илгээсэн тухай удаа дараа мэдээлсэн. Харин ОХУ болон БНАСАУ-ын зүгээс тухайн мэдээллүүдийг албан ёсоор баталгаажуулаагүй ч үгүйсгэж няцаагаагүй нь сүүлд хүлээн зөвшөөрөх ёстой болсон үед боломжийг нээлттэй орхисон хэрэг байсан юм. Үнэндээ ОХУ руу цэрэг илгээх тухай яриа хэлэлцээ 2023 оны 9-р сард ОХУ-ын Восточный сансрын баазад болсон ОХУ, БНАСАУ-ын дээд хэмжээний уулзалтаас хойш үргэлжилсэн байх магадлалтай. Тэрхүү уулзалтын үеэр хоёр тал Солонгосын хойг болон Европ дахь цэрэг, улс төрийн байдал, стратеги, тактикийн хамтын ажиллагааны талаар гүнзгий ярилцаж, ОХУ-ын аюулгүй байдал, бүрэн эрхээ хамгаалах тэмцэл, бүс нутаг төдийгүй дэлхий дахинд тогтвортой энх тайвны баталгааг бий болгох хичээл зүтгэлд дэмжлэг үзүүлэх талаар нийтлэг ойлголтод хүрсэн гэж мэдэгдэж байсан юм.[114] Түүний дараа 2024 оны 2-р сараас хойш Орос, Украины байлдааны ажиллагааны талаар, 6-р

---

[112] North Korea has sent 10.000 soldiers to Russia, Western source says, The Kyiv Independent, 2024.10.15. https://kyivindependent.com/north-korea-has-sent-10-000-soldiers-to-russia-western-source-says/
Russia is forming a battalion of North Korean soldiers due to severe manpower shortages, intel sources says, Kyiv Post, 2024.10.15. https://www.kyivpost.com/post/40556
Are North Korean troops joining Russia’s war in Ukraine? BBC News, 2024.10.17. https://www.bbc.com/news/articles/c4g5vwxgyx3o
‘북한군 러시아 파병설' 관련 외교부 입장 "사실이면 '전쟁 참여' 의미…매우 심각’, KBS News, 2024.10.17. https://www.youtube.com/watch?v=rFC97lwjxqU

[113] ‘북, 우크라전에 특수부대 1만2천명 파병…1천500명 이미 러시아로’, 연합뉴스, 2024.10.18. https://www.yna.co.kr/view/AKR20241018132651504
북한군 러시아 파병에 국제사회 촉각…파장은?, KBS News, 2024.10.24. https://www.youtube.com/watch?v=wYr1HAgyNGo

[114] “Официальный обед в честь Председателя Государственных дел КНДР Ким Чен Ына”, Администрация Президента России, 2023.09.13.

сараас эхлэн ОХУ-ын эсрэг барууны дэмжлэгийг эсэргүүцэн буруушаасан нийтлэл, мэдээллүүдийг “Хөдөлмөрийн сонин” гэх мэт төв хэвлэлүүдэд нийтлэх болсон[115] нь ОХУ руу цэрэг илгээх явдалд ард түмнийг сэтгэл зүйн хувьд бэлтгэх зорилготой байсан гэж үзэж болох юм.

Өмнө дурдсанчлан, 2024 оны 10-р сарын 13-ны өдөр умард Солонгос ОХУ руу цэрэг илгээсэн тухай Украины ерөнхийлөгч мэдэгдсэн бол умардын арми Украины эсрэг байлдааны ажиллагаанд оролцож эхэлсэн тухай мэдээллийг 2024 оны 11-р сарын 12-нд АНУ-ын Төрийн Департаментын хэвлэлийн албанаас сэтгүүлчдэд мэдээлсэн.[116] Умард Солонгосоос Орос руу 11 мянган цэрэг (Украины тооцоолсноор 12 мянга) илгээсэн, Алс дорнодод цэргийн сургуулилт хийж байгаа, Курскийн фронт руу шилжсэн, байлдааны ажиллагаанд оролцсон, нэмэлт цэрэг илгээсэн тухай, умардын армийн хохирол, фронтоос оргосон, алагдсан солонгос цэргүүдийн талаарх гэх мэт агуулгатай олон тооны мэдээ, мэдээлэлүүд Reuters, BBC, AFP, DW, Washington Post гэх мэт дэлхийн томоохон мэдээллийн агентлагууд, өмнөд Солонгосын Ёнхап мэдээллийн агентлаг, Украины хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр Украины тагнуулын алба болон Өмнөд Солонгосын Үндэсний тагнуулын албаны эх сурвалжтай гэх тайлбартайгаар өнгөрөгч оны 10-р сараас эхлээд энэ оны эхний улирлыг дуустал цацагдсан. Тагнуулын мэдээллээс эх сурвалжтай гэх тоо баримтууд, мэдээ мэдээллийг Оросын тал ч тэр, умард Солонгосын тал ч тэр тухайн үед нь нэг ч удаа албан ёсоор баталгаажуулсангүй.

2025 оны 4-р сарын 28-нд ОХУ-ын ерөнхийлөгч Путин Курск мужийг Украины армиас чөлөөлөх байлдааны ажиллагаанд оролцож, ялалт байгуулахад хүчин зүтгэсэн Солонгосын ардын арми, ард түмэнд талархал илэрхийлж, мэдэгдэл хийсэн нь БНАСАУ-ын зэвсэгт хүчний анги нэгтгэлүүд Орос Украины байлдааны ажиллагаанд оролцсон болохыг нотолсон албан ёсны мэдэгдэл болсон юм. Тэрээр Солонгосын ардын армийн анги нэгтгэлүүдийн оролцоо нь Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны тухай гэрээний IV заалтын үзэл санаа, олон улсын хууль тогтоомжид нийцсэн хэрэг гэдгийг онцлон тэмдэглээд БНАСАУ-ын удирдлага, ард түмэнд гүнээ талархаж байгаагаа илэрхийлсэн юм.[117] ОХУ-ын Зэвсэгт хүчний жанжин штабын дарга Валерий Герасимов 4-р сарын 26-ны өдөр Курск мужийг чөлөөлөх ажиллагаа амжилттай дууссан тухай ерөнхийлөгч Владимир Путинд тайлагнахдаа Солонгосын ардын армийн оролцооны талаар онцлон дурдсан.[118]

Курск мужийг чөлөөлөх ажиллагаанд оролцсон БНАСАУ-ын зэвсэгт хүчний байлдааны анги нэгтгэлүүдийг СХН-ын Цэргийн төв хороо өндрөөр үнэлж, Курскийн тулалдаанд Солонгосын дайчдын байгуулсан баатарлаг гавьяа нь хоёр орны эв нэгдэл, хамтын ажиллагааны хөгжил дэвшлийн баталгаа болж, ард түмэн хоорондын ахан дүүсийн нөхөрлөл, улс хоорондын найрсаг харилцаанд асар том хувь нэмэр оруулахыг онцлон

[115] БНАСАУ-ын мэдээллийн төв агентлагийн цахим хуудсанд 2023.01.01-2025.05.10 хооронд нийтлэгдсэн цаг үеийн мэдээнүүдийг шүүв.

[116] “США: Солдаты КНДР уже участвуют в войне против Украины”, DW новости, 2024.11.13.

[117] “Заявление Президента Российской Федерации”, Администрация Президента России, 2025.04.28.

[118] “Встреча с начальником Генштаба ВС РФ Валерием Герасимовым”, Администрация Президента России, 2025.04.26.

тэмдэглэлээ. Цэргийн хорооны мэдэгдэл нь Умард Солонгосын зэвсэгт хүчнийг байлдааны тусгай ажиллагаанд оролцуулах шийдвэрийг нөхөр Ким Жон Ун гаргаж, ОХУ-ын талд мэдэгдсэн гэдгийг дурдсан анхны албан ёсны баримт болно.[119]

Нөхөр Ким Жон Уны Курскийн тулалдаанд ялалт байгуулсан Оросын ард түмэнд баярын мэндчилгээ, Солонгосын ардын армийн баатрууддаа талархал илэрхийлсэн илгээлт үгийг уг мэдэгдэлд багтаасан байна. Тэрээр "БНАСАУ ОХУ-ын цэргийн тусгай ажиллагаанд хувь нэмрээ оруулж байгаад баяртай байна. Манай улс *ОХУ шиг хүчирхэг улстай эвсэх* нь нэр төрийн хэрэг бөгөөд манай зэвсэгт хүчний оролцоо нь хоёр улсын цэрэг улс төрийн хэлхээ холбоог улам бүр бэхжүүлэх болно" гээд "ОХУ-ын зэвсэгт хүчин, ард түмний үйлсийг ямагт, бүрэн дэмжиж, бидний байгуулсан иж бүрэн стратегийн түншлэлийн гэрээний үзэл санааг *сайн дурын үндсэн дээр үнэнчээр* хэрэгжүүлэх болно" гэж онцлон тэмдэглэжээ.[120]

3. Шинэ шатанд хүрсэн ОХУ, БНАСАУ-ын харилцаа бүс нутагт

ОХУ-тай илүү ойр дотно харилцаатай болсон БНАСАУ-ын хувьд уламжлалт найрсаг харилцаат түнш болох БНХАУ-тай харилцах харилцаа нь өмнөх жилүүдээс эрс өөр, хүйтэн хөндий уур амьсгалд өрнөх болсон. 2024 он БНАСАУ, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ой тохиосон тэмдэглэлт жил байсан. 2023 оны 12-р сард БНХАУ-ын ГХЯ-ны дэд сайд Сүн Вэйдун, БНАСАУ-ын Гадаад хэргийн дэд сайд Пак Мён Хо нар хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан хоёр орны найрсаг хамтын ажиллагааны харилцааг бэхжүүлэхээр тохиролцож, 2024 оны 1-р сарын 1-нд Ши Жиньпин дарга шинэ оны мэндчилгээндээ 2024 оныг "Хятад, БНАСАУ-ын найрамдлын жил" болгон зарласнаа мэдэгдэж байсан. Оны эхний улиралд хийсэн харилцан айлчлалуудын үеэр тэмдэглэлт ойг тохиолдуулан дээд хэмжээний айлчлал хийгдэх тухай яригдаж байсан авч сүүлийн хагаст нөхцөл байдал өөрөөр эргэж, 10-р сарын 6-нд дипломат харилцаа тогтоосны ойн үеэр дээд хэмжээний уулзалт, баяр ёслолын арга хэмжээ зохион байгуулсангүй, хоёр талын удирдагчид зөвхөн албан ёсны мэндчилгээ илгээж, цэцэг өргөх зэргээр дипломат ёсыг сахих хэмжээнд л өнгөрүүлсэн байна.

Хоёр улсын харилцааны уур амьсгал хүйтэрч хөндийрснийг нотлох хэд хэдэн үйл явдал болсон. 2024 оны 5-р сарын 27-нд БНАСАУ-ын Гадаад хэргийн дэд сайд Пак Мён Хо мөн сарын 25-26-ны өдрүүдэд болсон БНСУ, БНХАУ, Японы дээд хэмжээний уулзалтын хамтарсан мэдэгдлийг шүүмжилсэн байр суурьтай мэдэгдэл хийж, Хятдад сэтгэл дундуур байгаагаа илэрхийлсэн.[121] Дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ойг тохиолдуулан нээх байсан хоёр улсын худалдааны бэлгэ тэмдэг болсон Ялу голын шинэ гүүрийг нээх ёслолыг хойшлуулж, дипломат харилцаа тогтоосон өдөр самбарыг нь буулгасан.[122] 2018 онд Ляонин мужийн Далянь хотод барьсан хоёр удирдагчид

[119] 조선로동당 중앙군사위원회가 로씨야련방의 꾸르스크지역해방작전에 참전하여 영웅적위훈을 세운 조선민주주의인민공화국무력 전투구분들을 높이 평가, 조선중앙통신, 2025.04.28.

[120] Мөн тэнд.

[121] 조선외무성 한일중3자수뇌 《공동선언》 규탄, 조선중앙통신, 2024.10.31.

[122] 북·중 수교 75주년인데 '신압록강 대교' 현판도 철거, YTN News, 2024.10.06. https://www.ytn.co.kr/_ln/0104_202410062010385639_001

зориулсан дурсгал (гишгэсэн мөр)-ыг хурааж[123], Бээжин дэхь умард Солонгосын элчин сайдын яамны мэдээллийн самбараас дурсгалын гэрэл зургуудыг буулгасан байна.[124] Умард Солонгосын тал гадаадад мэдээ, нэвтрүүлэг дамжуулахдаа ашиглаж байсан Хятадын хиймэл дагуулыг Оросын хиймэл дагуулаар сольсон[125] бол Хятдад ажиллж байсан Солонгосын ажилчдын визний хугацаа дуусмагц сунгалгүй нутаг буцаахыг шаардсан[126] гэх мэт үл ойлголцолд хүргэсэн үйл явдлууд өрнөжээ.

Хоёр улсын олон жилийн түүхтэй ойр дотно харилцаанд үүссэн хүйтэн хөндий байдалд хоёр улсын олон улсын дэг журамд хандах ойлголт, хандлагын зөрүүтэй байдал нөлөөлсөн гэж судлаачид үзэж байна. Өөрөөр хэлбэл, БНАСАУ-ын олон улсын хамтын нийгэмлэгт бие даасан байр сууриа бэхжүүлэхийг эрмэлзэж, ОХУ-тай явуулах бодлого, цэргийн үйл ажиллагаандаа ихээхэн ач холбогдол өгч байсан явдал нь БНХАУ-тай улс төр, дипломат үзэл бодлын зөрүүтэй байдал үүсгэхэд хүргэсэн хэрэг.

БНХАУ-ын хувьд гадаад бодлогын тэргүүлэх чиглэл нь АНУ юм. Хятад улс АНУ-ын стратегийн ширүүн өрсөлдөөнийг даван туулахын тулд дэлхийн хамтын ажиллагааг үнэлж, прагматик, эвлэрэх дипломат бодлого баримтлах болсон. Тиймдээ ч Украины мөргөлдөөнд төвийг сахиж, Оросын талыг барихаас зайлсхийсээр ирсэн. Энэ байр суурь нь ч умард Солонгосын талтай харилцах харилцаанд нь нөлөөлсөн гэж үзэж болно. Гэвч умард Солонгосын эдийн засагт Хятадын эзлэх хувийг авч үзвэл, тэд ОХУ-тай харилцах холбоотны харилцаанаасаа болж БНХАУ-тай харилцаагаа муутгахыг хүсэхгүй байх нь тодорхой. 2023 оны байдлаар хоёр улсын худалдааны хэмжээ 1 тэрбум 900 сая гаран долларын үзүүлэлттэй, өмнөх жилийнхээс 400 сая ам доллараас буурсан байна.[127] Хэдийгээр Оросын тал ойр дотно харилцаатай байж, шаардлагатай эдийн засгийн харилцаа, дэмжлэг үзүүлэх боломжтой ч урт хугацаандаа хязгаарлагдмал юм.

Хоёр талыг гэрээ хийсний дараа Япон болон БНСУ-ын тал цэргийн холбоотны харилцаа бодит болохын сацуу улмаар энэ харилцаа нь зөвхөн хоёр орны харилцаагаар хязгаарлагдах бүс нутгийн тогтвортой байдалд нөлөөлөхүйц стратегийн шинж чанарыг агуулсан хэмээн ихэд болгоомжилсон. Тодруулж хэлбэл, Умард Солонгосын цэрэг Орос Украины тусгай ажиллагаанд орсон нь Европт өрнөж буй дайн Зүүн Хойд Азид нөлөөлөх нь тодорхой болж, цаашлаад Солонгосын хойгийн маргаантай асуудалд Орос оролцох магадлал нэмэгдэх нь хойгийн энхтайван, аюулгүй байдалд шинэ аюул занал болно гэж үзсэн хэрэг.

БНСУ-ын хувьд, Умард Солонгосын зүгээс БНСУ-ыг дайсагнасан харилцаатай улс гэж тодорхойлоод, АНУ, Япон, БНСУ-ын холбоотнуудын эсрэг шаардлагатай тохиолдолд

---

[123] '북·중 밀월 징표' 김정은 발자국 동판, 중국서 사라졌다, 중앙일보신문, 2024.06.11.
https://www.joongang.co.kr/article/25255484

[124] '김정은 발자국' 지우고 북중 정상회담 사진 내리고…북-중 '이상 기류', KBS news, 2024.06.12
https://news.kbs.co.kr/news/pc/view/view.do?ncd=7985513

[125] 북한 방송 위성 중→러로 교체…통일부 "모니터링 유지", 동아일보, 2024.07.02.
https://www.donga.com/news/Politics/article/all/20240702/125729624/1

[126] 중, 북러 밀착 견제하나…"북한 근로자 모두 나가라" 요구, 연합뉴스, 2024.07.06.
https://www.yna.co.kr/view/MYH20240709026200641

[127] 2025 한반도 정세 전망, 연례정세보고서 2024, 통일연구원.

зэвсэглэхэд эргэлзэх зүйлгүй хэмээн зарлаж, бүх холбоо харилцааны сувгаа бүрмөсөн тасалсан ийм нөхцөлд ОХУ-тай стратегийн түншлэлийн гэрээ байгуулагдах нь тодорхой болмогц нэн яаралтай авсан арга хэмжээ нь БНСУ-ыг тойрсон гурван талт хамтын ажиллагааны зорилгыг Солонгосын хойгийн тогтвортой байдлын төлөө чиглүүлэхэд чиглэсэн уулзалт хэлэлцээрүүдийг зохион байгуулах явдал байв. Юуны өмнө 2019 оноос хойш тасраад байсан БНСУ, Япон, БНХАУ-ын гурван талт дээд хэмжээний уулзалтыг үргэлжлүүлэх явдал байв. 2024 оны 5-р сарын 27-ны өдөр Сөүл хотноо зохион байгуулагдсан 9 дэхь удаагийн гурван талт дээд хэмжээний уулзалтын дараа гаргасан хамтарсан мэдэгдэлд Зүүн Хойд Азийн энх тайван, тогтвортой байдал, цөмийн зэвсэггүйжүүлэх тухай асуудал, хулгайлагдсан иргэдийн асуудлаар талууд байр сууриа илэрхийлэв гээд Солонгосын хойгийн асуудлыг улс төрийн арга замаар шийдвэрлэхийн төлөөр хүчин чармайлтаа үргэлжлүүлэх болно хэмээн тусгажээ.[128] Уг дээд хэмжээний уулзалтын үеэр Солонгосын хойгийг цөмийн зэвсгийн асуудлаар тодорхой шийдвэрт хүрнэ гэж хүлээж байсан нь талаар болсон байна. Хэлэлцээр эхлэх өдөр буюу 27-ны үүрээр умардын тал пуужин харвах тухай мэдэгдэл хийсэн явдлыг БНСУ, Японы тал хатуу буруушаан НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолыг зөрчсөн хэрэг гэж үзээд умард Солонгосын үйлдлийг таслан зогсоох ёстой гэж үзсэн бол БНХАУ-ын тал Солонгосын хойгийн асуудалд талууд болгоомжтой хандаж, байдлыг улам бүр муутгаж, ээдрээтэй болгохоос зайлсхийх хэрэгтэй” гэсэн байр суурьтай байсан тул хамтарсан мэдэгдэлд БНАСАУ-ын нэр цохон дурдагдаагүй хэрэг.

Гурван талт харилцаанд БНСУ, БНХАУ илүү дотно байсан бол ОХУ, умард Солонгосын асуудлаарх БНХАУ-ын болгоомжилсон, идэвхгүй байр суурь Япон, өмнөд Солонгосыг хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэхэд хүргэсэн. 2024 оны 7-р сарын 10-нд АНУ-ын Вашингтон хотноо НАТО-гийн дээд хэмжээний уулзалтын үеэр Япон улсын ерөнхий сайд Кишида Фүмио БНСУ-ын ерөнхийлөгч Юн Сон Нёльтой уулзах үеэрээ ОХУ, БНАСАУ-ын дээд хэмжээний уулзалтын үр дүн бүс нутгийн аюулгүй байдалд хэрхэн нөлөөлөх вэ гэдэгт асар ихээр санаа зовниж байна гээд цаашид хоёр улсын өмнө нягт хамтран ажиллах зүй ёсны шаардлага тавигдаж байгаад санал нэгджээ. Түүнээс хойш хоёр улсын хооронд “shuttle diplomacy” эрчимжиж, дээд хэмжээний уулзалтууд, утсаар хийсэн яриа хэлэлцээрүүд бараг сар тутамд үргэлжилсэн. 2024 оны 9-р сарын 6-7-ны өдрүүдэд Япон, БНСУ-ын 12 дахь удаагийн дээд хэмжээний уулзалтаар хоёр тал умард Солонгос Зүүн Хойд Азийн бүс нутгийн энхтайван, тогтвортой байдалд аюул занал учруулсаар байна гээд умардын тасралтгүй үргэлжлэх турхиралт, ОХУ-тай тогтоосон ойр дотно харилцаанаас гарах нөхцөл байдалд хатуу байр суурьтай байна гэдэгт санал нэгдсэн байна.[129] Түүний дараахан, 2024 оны 10-р сарын 10-ны өдөр АСЕАН-ы дээд хэмжээний уулзалтын үеэр, 2024 оны 11-р сарын 16-ны өдөр АПЕК-ийн уулзалтын хийсэн дээд хэмжээний уулзалтын үеэр талууд умард Солонгосын цөмийн зэвсэг, пуужингийн асуудал, ОХУ руу цэрэг илгээх зэргээр ОХУ, БНАСАУ-ын цэргийн хамтын ажиллагаа улам бүр батжин бэхжиж байгаад асар их санаа зовниж байна гээд умардын

[128] 제9차 한일중 3국 정상회의 공동선언, 대한민국 외교부, 2024.05.27.
https://www.mofa.go.kr/www/brd/m_26779/view.do?seq=546
[129] 한일 정상회담 결과, 대한민국 외교부, 2024.09.06.
https://www.mofa.go.kr/www/brd/m_26779/view.do?seq=546

тухайд Япон, өмнөд Солонгос, АНУ-ын гурван тал нэгдмэл байр суурь ажиллах нь чухал гэдэгтэй санал нэг байгаагаа илэрхийлсэн байна.[130] БНСУ-ын ерөнхийлөгч Юн Сон Нёлийн онц байдал зарласнаас хойш түүнийг огцрох хүртэлх хугацаанд хоёр талын дээд хэмжээний уулзалт зохион байгуулагдаагүй боловч гадаад хэргийн сайд нарын уулзалт хэлэлцээрүүд идэвхижсэн байна.

АНУ, БНСУ, Японы дээд хэмжээний уулзалтууд өмнө нь одоо ч Зүүн хойд Азийн бүс нутгийн тогтвортой байдал, умард Солонгосын цөмийн асуудлын эсрэг дуу хоолойгоо нэгтгэж ирсэн. 2024 оны 11-р сарын 15-нд АПЕК-ийн дээд хэмжээний уулзалтын үеэр зохион байгуулагдсан гурван талт дээд хэмжээний уулзалт, 2025 оны 2-р сарын 15-нд Мюнхенд болсон гурван улсын Гадаад хэргийн сайд нарын хэлэлцээрийн үеэр ОХУ, БНАСАУ-ын цэргийн хамтын ажиллагаа өргөжиж буй явдал, умард Солонгос ОХУ руу цэрэг илгээсэн асуудал, умардын цөмийн хөтөлбөрийг санхүүжүүлдэг гэх кибер ажиллагаа зэрэг умардыг тойрсон асуудлуудад талууд хариу арга хэмжээ авахаар тохиролцсон байна.[131]

Ямартаа ч ОХУ, БНАСАУ-ын нягт харилцаа сүүлийн жилүүдэд хөндий байсан Япон, БНСУ-ын харилцааг ойртоход хүргэсэн. ОХУ, БНАСАУ-ын харилцааны асуудлаар Япон, БНСУ, БНХАУ-ын гурван талт харилцаанд Япон, БНСУ-ын тал нэгдмэл санаатай, байр суурьтай байна. 2025 оны 3-р сарын 22-ны өдөр Япон улсын Токио хотод нээгдсэн Япон, БНСУ, БНХАУ-ын Гадаад хэргийн сайд нарын хэлэлцээр гурван тал хамгийн сүүлийн байдлаар уг асуудлаар байр сууриа илэрхийлэх тавцан болсон. Уг хэлэлцээрийн үеэр Япон улсын ГХЯ-ны сайд Иваяа Такэши, БНСУ-ын ГХЯ-ны сайд Жу Тэ Ёль нар ОХУ, умард Солонгосын зэвсэгт хүчний хамтын ажиллагааг таслан зогсоох ёстой гээд Украины дайны шувтаргын үед байлдааны ажиллагаанд оролцсон нь маш буруу алхам хэмээн эрс буруушаасан. БНХАУ-ын Гадаад хэргийн дэд сайд Ван И “БНХАУ олон улсын нийгэмлэгтэй хамт Солонгосын хойгийн энхтайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах, Солонгосын хойгийн асуудлыг улс төрийн замаар шийдвэрлэхэд хүчин чармайлт гаргах болно” хэмээн байр сууриа илэрхийлсэн.[132]

Дүгнэлт

БНАСАУ улс төрийн тогтолцоо, үзэл баримтлал, цөмийн зэвсэгтэй улсын статусаа олон улсын тавцанд хүлээн зөвшөөрүүлснээр дотоодын системийнхээ тогтвортой байдлыг хангах үүднээс олон улсын харилцаанд үүсээд байгаа нөхцөл байдал буюу “шинэ хүйтэн дайны” бүтцийг ашиглах алхмуудыг идэвхтэй хийсний нэг ОХУ-тай харилцаагаа нягт

[130] 일한 정상회담, 주대한민국 일본대사관, 2024.10.10.
https://www.kr.emb-japan.go.jp/itpr_ko/news_20241010.html
일한 정상회담, 주대한민국 일본대사관, 2024.11.16.
https://www.kr.emb-japan.go.jp/itpr_ko/news_20241116.html
[131] 일한미 정상회담, 주대한민국 일본대사관, 2024.11.15.
https://www.kr.emb-japan.go.jp/itpr_ko/news_20241115_3.html
일한미 외상회의, 주대한민국 일본대사관, 2025.02.15.
https://www.kr.emb-japan.go.jp/itpr_ko/news_20250215.html
[132] 한중일 “한반도 평화는 공동 이익” … 도쿄서 외교장관회의(종합), 연합뉴스, 2025.03.22.
https://www.yna.co.kr/view/AKR20250322027251073

гүнзгийрүүлэх явдал байсан юм. 2024 оны 6-р сарын 19-ны үзэглэсэн ОХУ, БНАСАУ-ын стратегийн түншлэлийн харилцааны тухай гэрээний 4-р зүйл, цэргийн харилцан дэмжлэг үзүүлэх тухай заалтын хэрэгжилтээр уг гэрээ нь энгийн гэрээний агуулгаар хязгаарлагдахгүй нь тодорхой болж, хоёр улсын стратегийн түншлэлийн харилцаа мөн чанарын хувьд холбоотны харилцаанд хүрсэн. ОХУ, БНАСАУ-ны шинэ шатанд ахисан харилцаа зөвхөн хоёр орны харилцаагаар хязгаарлагдах бүс нутаг, олон улсын харилцааны дэг журамд ч нөлөөлөхүйц стратегийн шинж чанарыг агуулсан гэж дүгнэж болно. БНАСАУ-ын ардын армийн анги нэгтгэлүүд Орос Украины дайнд орсноор улам бүх бэхжиж буй хоёр улсын холбоотны харилцаа Солонгосын хойгийн маргаантай асуудалд ОХУ оролцох магадлалыг өсгөж байна. Үүнийг БНСУ, Япон, АНУ-ын тал аюул занал гэж үзэж байна.

БНАСАУ-ын тухайд, олон улсын тавцанд өөрийн улсын засаглалын систем, статусаа хүлээн зөвшөөрүүлэхэд томоохон дэмжлэг үзүүлэх ашиг сонирхлын үүднээс ОХУ-тай харилцаагаа ойртуулан нягтруулж, улмаар БНСУ, АНУ, Япон голлох үүрэг гүйцэтгэдэг Зүүн Хойд Азид БНАСАУ, ОХУ, БНХАУ-ын гурван талт харилцааг холбоотны харилцааг бүс нутагт бэхжүүлэхийг эрмэлзэж байна. ОХУ-ын хувьд, Украин дахь цэргийн ажиллагаа, олон улсын хамтын нийгэмлэгээс тавьсан хоригт байгаа хүнд үед үргэлжийн ашиг сонирхлын бүс байсаар ирсэн Алс дорнодын цаадах Зүүн хойд Ази дахь байр сууриа хадгалах нь чухал байсны зэрэгцээ нөгөө талаар, цэрэг зэвсгийн харилцан туслалцах ашиг сонирхол байсан тул БНАСАУ-тай харилцаагаа шинэ түвшинд ахиулан, бэхжүүлэн хөгжүүлж байна.

ОХУ, БНАСАУ-ын шинэ шатны харилцаа нь бүс нутаг дахь Япон, өмнөд Солонгосын санаа зовниж байгаачлан АНУ, БНСУ, Японы холбоотны харилцааг сөрөн зогсоход чиглэсэн гэж үзвэл Зүүн Хойд Азийн аюулгүй байдлын дэг журмыг дахин тогтооход нөлөө үзүүлэх нь тодорхой. Цэргийн хамтын ажиллагаа нь бүс нутгийн аюулгүй байдлын орчинд нөлөөлж байгаа нь дамжиггүй. Цэргийн хамтын ажиллагааны цаана цэргийн үйлдвэрлэлийн, ялангуяа цөмийн зэвсгийн технологи хөгжүүлэлт явагдаж байгаа гэсэн сөргөлдөгч холбоотнуудын таамаглал бодит болбол бүс нутагт “шинэ хүйтэн дайн”-ы нөхцөл байдал улам бүр хурцдах магадлалтай.

Гэвч ОХУ-ын Зүүн хойд Ази дахь ашиг сонирхол бүс нутаг дахь АНУ-ны нөлөөг хязгаарлахад чиглэхээс бус БНХАУ-тай сөргөлдөхийг хүсэхгүй тул БНАСАУ-тай явуулах холбоотны харилцаагаа бүс нутгийн түвшинд тэнцвэртэй барихыг хичээх магалдал өндөр тул Япон, өмнөд Солонгосын зовниж байгаа шиг байдалд хүрэхгүй болов уу. Харин БНХАУ-ын хувьд умард Солонгосыг хянах бүрэн чадвартайн дээр БНХАУ, ОХУ, БНАСАУ гэсэн гурван талт харилцаа гэхээсээ илүү хоёр талт харилцааг чухалчилж байгаа нь 2025 оны 5-р сарын 8-нд хийсэн ОХУ,БНХАУ-ын дээд хэмжээний уулзалтын үр дүнгээс харагдаж байна. Бүс нутагт үүсээд байгаа энэхүү олон талт харилцаан дунд Монгол улс хэрхэх вэ гэдэг нь л бидний хувьд сорилт болно.

Ашигласан материал

БНАСАУ-ын Гадаад хэргийн яамны цахим хуудас. http://www.mfa.gov.kp/

БНАСАУ-ын мэдээллийн төв агентлагийн цахим хуудас. https://kcnawatch.org/

ОХУ-ын Ерөнхийлөгчийн тамгын газрын цахим хуудас. http://www.kremlin.ru/

ОХУ-ын мэдээллийн агентлагуудын цахим хуудсууд.

БНСУ-ын Гадаад хэргийн яамны цахим хуудас. https://www.mofa.go.kr/

БНСУ-ын мэдээллийн агентлагуудын цахим хуудсууд.

БНСУ-д Япон улсын суугаа Элчин сайдын яамны цахим хуудас. https://www.kr.emb-japan.go.jp

SPSIRPA FORUM 2025

Session 4-8

On the Forms and Organizational Aspects of Coalition Governments in Different Countries

УЛС ОРНУУДЫН ЭВСЛИЙН ЗАСГИЙН ГАЗРУУДЫН ХЭЛБЭР, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛД

Г.Золзаяа, МУИС-Улс төр судлалын докторант,

Отгонтэнгэр Их Сургуулийн Олон улсын харилцааны тэнхимийн эрхлэгч

Хураангуй

Эвслийн засгийн газар нь улс төрийн олон ургалч байдлыг хангасан, намуудын хоорондын тохиролцоон дээр суурилсан засаглалын хэлбэр юм. Энэхүү судалгаанд гадаад орнуудын эвслийн засгийн газрын бүтэц, улс төрийн тогтвортой байдалд үзүүлэх нөлөө, улс орнуудын туршлага зэрэг асуудлыг авч үзэв. Герман, Нидерланд, Япон зэрэг улс орнуудын жишээн дээр эвслийн засаглалын давуу болон сул талуудыг судалж, улс төрийн тогтолцоо, соёлын онцлог нь эвслийн тогтвортой байдалд хэрхэн нөлөөлдгийг харуулсан. Судалгааны үр дүнд эвслийн засгийн газар нь ардчиллын чухал илэрхийлэл боловч улс төрийн хямрал, тогтворгүй байдлын эрсдэлтэй болохыг дүгнэв. Гэсэн хэдий ч зарим улс орнууд эвслийн засгийн газрыг тогтвортой, үр дүнтэй ажиллуулсан туршлагатай байна.

THE FORMATION AND ORGANIZATION OF COALITION GOVERNMENTS IN DIFFERENT COUNTRIES

Abstract

A coalition government is a form of governance based on political pluralism and inter-party agreements. This article studies coalition governments' formation, structure, and impact on political stability, drawing on experiences from countries such as Germany, the Netherlands, and Japan. By analyzing these cases, the study highlights both the advantages and challenges of coalition governance and demonstrates how political systems and cultural factors influence their stability. The findings suggest that while coalition governments embody democratic principles and pose risks of political instability, some countries have successfully maintained stable and effective coalition governments.

Оршил

Эвслийн засгийн газар нь парламентын ардчиллын орнуудад засгийн эрхийг олон намын хооронд хуваарилан, харилцан зөвшилцлийн зарчимд тулгуурлан засаглалын тогтвортой байдлыг хангах чухал механизм болж ирсэн. Европын улс орнуудын эвслийн засгийн газрын хэлбэр, бүтэц, үйл ажиллагаа нь улс төрийн тогтолцоо, сонгуулийн систем, намын системийн олон талт байдал, институцийн зохицуулалт зэрэг олон хүчин зүйлээс хамаарч өөр өөрөөр илэрдэг. Энэхүү судалгаанд Герман, Швейцарь, Швед, Унгар, Румын зэрэг улсуудын эвслийн засгийн газрын түүхэн хувьсал, тогтвортой байдлын хүчин зүйлс, институцийн эрх мэдлийн хуваарилалт, эвслийн төрлүүдийн

харьцуулалтыг хийсэн болно. Өөр өөр институцийн болон улс төрийн суурьтай хэдий ч, эвслийн засгийн газар байгуулах хэрэгцээ шаардлага, хэрэгжилтийн хэлбэр, түүнийг дагасан сорилт, боломжууд төстэй шинжтэй байдаг. Тухайлбал, Германд эвслийн хэлбэрийг нарийн бүтэцтэй эвслийн гэрээгээр зохицуулдаг бол Швейцарьт "их эвсэл" гэсэн тогтолцоо тогтвортой төлөөллийг бий болгож, харин Шведэд цөөнхийн засгийн газар түгээмэл байдаг. Унгар, Румын зэрэг улсуудад ерөнхий сайдын эрх мэдлийн төвлөрөл болон улс төрийн элитүүдийн стратеги сонголт эвслийн засгийн газрын амьдралын мөчлөгт шууд нөлөөлж ирсэн байна. Эдгээр улсуудын жишээн дээр тулгуурлан эвслийн засгийн газар бүрэлдэх, үйл ажиллагаа явуулах, тогтвортой байдал хадгалах үйл явцын харьцуулалт хийж, институцийн тогтолцоо, намуудын стратеги, сонгуулийн дүн, засаглал дахь тэнцвэр зэрэг хүчин зүйлсийг тодорхойлох зорилготой юм.

Үндсэн хэсэг

- **ХБНГУ-ын эвслийн засгийн газрууд**

Эвслийн засгийн газар байгуулах шаардлага нь Германы олон намын тогтолцоотой холбоотой. Холбооны Парламентын сонгуулийн үр дүнд нэг ч нам дангаараа олонхийн суудал эзлэх боломжгүй байдал бий болдог тул намууд хамтарч засгийн газар байгуулдаг. Ийнхүү эвслийн засгийн газар нь тухайн намын бодлогыг хэрэгжүүлэх, тогтвортой байдлыг хангах чухал механизм болдог. (Anderson, 2013) Германы эвслийн засгийн газруудын онцлог нь **эвслийн гэрээний** (Koalitionsvertrag) хүрээнд тохиролцоонд хүрч, засгийн газрын хөтөлбөрийг тодорхойлох явдал юм. Энэ нь эвсэлд оролцогч намуудын хооронд бодлогын чиглэл, үйл ажиллагааны хүрээг нарийн зааж өгдөг бөгөөд улс төрийн харилцан хүндэтгэлийг баталгаажуулдаг. (Debus, 2008)

1950-аад оны сүүлээс 1980-аад оны дунд үе хүртэл оршин тогтнож байсан “хоёр дээр нэмэх нь хагас”[133] намын тогтолцоо үйлчилж байсан бол 1990-ээд онд Ногоон нам эвслийн засгийн газруудад чухал үүрэг гүйцэтгэгч болсон үед ч эвслийн засгийн газрууд маш тогтвортой байсан. (Saafield, 2000) Гэвч энэ чиг хандлага 2000 оноос хойш эрс өөрчлөгдсөн. Эдгээр өөрчлөлтийн нэг шалтгаан нь сонгогчдын уламжлалт намын сонголтод нийцсэн үйл явц бөгөөд үүний үр дүн Христийн ардчилсан нам, Социал демократ, Либерал чөлөөт ардчилсан нам, Ногоон нам гэсэн парламентын дөрвөн намаас социалист зүүн нам, 2007 оноос хойш Германы альтернатив зэрэг 6 хүртэлх намын бүлэгтэй парламент болж хувирсан явдал юм.

Баруун Германы үед олонхийн эвсэл нь засаглалын онцлог шинж чанартай. Эвслийн засгийн газрын гол үүргийг цөөн суудал авдаг Чөлөөт Ардчилсан нам гүйцэтгэдэг. Тус нам хоёр том нам болох Социаль демократууд эсвэл Христийн ардчилсан намуудын аль нь засгийн газрыг байгуулахыг шийдэх стратегийн чухал үүрэг гүйцэтгэдэг. Бодлогын

[133] 'two-and-a-half' гэсэн нэр томьёо нь улс төрийн хоёр том нам давамгайлж, түүнээс гадна гурав дахь дунд хэмжээний нам байнгын тоглогчоор эвслийн тэнцвэртэй байдалд нөлөөлж байдаг намын тогтолцоог хэлдэг.

тодорхой асуудлуудад өргөн хүрээний олон янз байдлыг үл харгалзан эвслийн улс төрийн орчин үеийн загвар нь баруун-зүүн шугамыг дагасан хэвээр байна. Германы эвслийн засгийн газруудын бүтэц нь эвслийн онолын үндсэн таамаглалд маш сайн нийцдэг. Төвийн сахигч [134] нам нь засгийн газрын бүрэлдэхүүнийг тодорхойлдог. Чөлөөт ардчилсан нам парламентад цөөн суудал авдаг хэдий ч байнгын төвийг сахигч намын үүрэг гүйцэтгэдэг. ХБНГУ байгуулагдсанаас хойш эвсэл нь засгийн газрын байнгын хэлбэр байсаар иржээ. Зөвхөн нэг удаа буюу 1957 онд Христийн ардчилсан нам Баруун Германы Бундестагт үнэмлэхүй олонхийн суудал авч байжээ.

Германд улс төрч нь Бундестагийн гишүүдийн олонхийн дэмжлэгийг авч, төрийн тэргүүн томилсон тохиолдолд л канцлер болох боломжтой. Энэ нь канцлерыг амжилттай томилж, Засгийн газрын болон яамдын албан тушаалыг авахын тулд олонхийн эвсэл байгуулах хүчтэй хөшүүрэг болдог. (Christian, 2016)

Хүснэгт №1.1949-2020 оныг хүртэлх ХБНГУ-ын эвслийн засгийн газрууд

№	Засгийн газрууд	Хугацаа	ЗГ-д орсон намын тоо	Төрөл	ЗГ-ын байр суурийн хувь	Парламентын суудал	Парламентад суудалтай намууд	Намын нөлөөний хувь (ENPP)
1	Аденауэр 1	1949.09.15	4	ЯОЭ	52.0	402	9	3.99
2	Аденауэр 2	1953.10.09	5	ХОЭ	68.6	487	6	2.77
3	Аденауэр 3	1955.07.23	4	ХОЭ	64.7	487	6	2.67
4	Аденауэр 4	1956.02.25	4	ХОЭ	57.7	487	7	2.7
5	Аденауэр 5	1957.10.22	3	ХОЭ	57.7	497	4	2.39
6	Аденауэр 6	1960.07.02	2	ЯОЭ	54.5	497	4	2.38
7	Аденауэр 7	1961.11.07	3	ЯОЭ	61.9	499	3	2.51
8	Аденауэр 8	1962.11.19	2	ЦЭ	48.3	499	3	2.52
9	Аденауэр 9	1962.12.13	3	ЯОЭ	61.7)	499	3	2.52
10	Эрхард 1	1963.10.16	3	ЯОЭ	61.7)	499	3	2.52
11	Эрхард 2	1965.10.16	3	ЯОЭ	59.3	496	3	2.38
12	Эдхард 3	1966.10.28	2	ЦЭ	49.4	496	3	2.38
13	Киесингжер	1966.12.01	3	ЯОЭ	90.1	496	3	2.38
14	Бранд 1	1969.10.21	2	ЯОЭ	51.2	496	3	2.24
15	Бранд 2	1972.12.14	2	ЯОЭ	54.6	496	3	2.34
16	Шмидт 1	1974.05.16	2	ЯОЭ	54.6	496	3	2.34
17	Шмидт 2	1976.12.15	2	ЯОЭ	51	496	3	2.31

[134] “Median legislator” буюу Төвийг сахигч нам гэдэг нь парламенит дахь бүх гишүүдийг зүүнээс баруун тийш улс төрийн байр сууриар эрэмбэлэхэд дунд байрлах нам юм.

18	Шмидт 3	1980.11.05	2	ЯОЭ	54.5	497	3	2.44
19	Кол 1	1982.10.01	3	ЯОЭ	56.1	497	3	2.47
20	Кол 2	1983.03.29	3	ЯОЭ	55.8	498	4	2.51
21	Кол 3	1987.03.11	3	ЯОЭ	54.1	497	4	2.8
22	Кол 4	1990.10.30	2	ХО	546	663	5	2.93
23	Кол 5	1991.01.17	3	ЯОЭ	60.1	662	5	2.65
24	Кол 6	1994.11.15	3	ЯОЭ	50.7	672	5	2.91
25	Шроедер 1	1998.10.27	2	ЯОЭ	51.6	669	5	2.9
26	Шроедер 2	2002.10.22	2	ЯОЭ	50.7	603	5	2.8
27	Меркел 1	2005.11.22	3	ЯОЭ	73	614	5	3.44
28	Меркел 2	2009.10.28	3	ЯОЭ	53.4	622	5	3.97
29	Меркел 3	2013.12.17	3	ЯОЭ	79.9	631	4	2.8
30	Меркел 4	2018.03.14	3	ЯОЭ	56.3	709	6	4.64

- **Их эвсэлийн жишээ Швейцарь Улс**

Швейцарь Улс нь улс төрийн тогтолцоондоо их эвсэл хэмээх эвслийн засгийн газрыг байгуулдаг. Энэ нь улс орны гол намуудын төлөөллийг гүйцэтгэх засаглалд нэгтгэж, хамтран шийдвэр гаргах зарчмаар ажилладаг онцлогтой. Их эвсэл нь улс төрийн өргөн хүрээний хамтын шийдвэр гаргалтыг дэмжиж, үндэсний эв нэгдлийг хангахад чиглэсэн засаглалын хэлбэр юм. (Mueller, 2021)

Швейцарь улсын их эвслийн гол бүтэц нь **Холбооны Зөвлөл** бөгөөд энэ нь долоон гишүүнтэй, улс төрийн гол намуудын төлөөллийг хамруулсан бүтэц юм. Гишүүдийг парламентын хоёр танхимын хамтарсан хуралдаанаар сонгодог бөгөөд Холбооны Зөвлөлийн тэргүүн (ерөнхийлөгч) нь жил бүр ээлжлэн томилогддог. Энэ бүтэц нь намын хэт давамгайлал, эсвэл засаглалын төвлөрлийг багасгах зорилготой бөгөөд Швейцарийн шууд ардчиллын тогтолцоотой уялдсан байдаг. (Vatter, 2020) Швейцарийн улс төрийн тогтолцоо 1848 онд батлагдсан Холбооны Үндсэн Хуулийн дагуу байгуулагдсан бөгөөд тэр цагаас эхлэн их эвслийн үндэс тавигдсан. Анхных нь нэг намын давамгайлсан засаглал байсан бөгөөд Радикал чөлөөт ардчилсан нам засгийн эрхийг барьж байв. Харин 1891 оноос бусад намуудыг аажмаар гүйцэтгэх засаглалд оруулж эхэлсэн бөгөөд энэ нь үндэсний эвслийн хөгжлийн эхлэл болсон. (Church, 2004) 1959 онд Швейцарийн улс төрд “Шидэт найрлага” гэх эвслийн хуваарилалтын систем бий болсон. Энэ нь Холбооны Зөвлөлийн долоон суудлыг сонгуульд намуудын авсан саналын хувьтай уялдуулан хуваарилдаг зарчим байв. Тухайн үед суудлыг Щвейцарийн ардын нам, Социал демократ нам, Христийн Ардчилсан нам гэсэн намуудад хуваарилсан бөгөөд энэ хуваарилалт улс төрийн тогтвортой байдлыг хангахад ихээхэн ач холбогдолтой байсан. (Mueller, 2021)Их эвслийн тогтолцоо нь Швейцарийн улс төрийн тогтвортой байдлыг хангах чухал хүчин зүйл болж, нийгмийн янз бүрийн бүлгүүдийн

ашиг сонирхлыг нэгтгэх боломжийг олгодог. Холбооны Зөвлөлд төлөөлөлтэй намууд хамтран ажиллаж, төрийн бодлого, хууль тогтоомжийг харилцан зөвшилцлөөр гаргадаг. Энэ нь Швейцарийн нийгэмд хуваагдлыг багасгаж, нийтийн эрх ашгийг хангахад чиглэгддэг (Linder & Mueller, 2021). Гэсэн хэдий ч их эвслийн сул тал нь нам хоорондын тохиролцоо хийх явцад шийдвэр гаргалт удаашрахад хүргэдэг. Жишээлбэл, холимог систем дэх өргөн зөвшилцлийн шаардлага нь яаралтай шийдвэр гаргах боломжийг хязгаарлахад хүргэж болзошгүй. Түүнчлэн, хамтарсан засаглалын үед хариуцлага тодорхой нэг намд ногддоггүй тул улс төрийн хариуцлагын асуудал үүсдэг. (Vatter, 2020)

Швейцарийн их эвслийн тогтолцоо нь бусад улс орнуудад үлгэр жишээ болж, олон нийтийн оролцоог дэмжих, нийгмийн зөвшилцлийг хангах боломжийг харуулсан. Энэхүү тогтолцоо нь зөвхөн улс төрийн тогтвортой байдлыг хангаад зогсохгүй, ардчиллын зарчмыг бататгасан онцлогтой юм. (Church, 2004)

- **Шведийн Улсын Эвслийн засгийн газрууд**

Швед улс нь парламентийн системтэй бөгөөд цөөнхийн засгийн газар байгуулах үзэгдэл олонтоо тохиолддог. Цөөнхийн засгийн газар гэдэг нь парламент дахь олонхийн дэмжлэгийг хангахгүй ч тодорхой хэмжээний дэмжлэгтэйгээр ажиллах чадвартай засгийн газрыг хэлдэг. Шведэд 20-р зуунаас хойш ийм төрлийн засгийн газар байгуулагдаж байсан түүх нь улс төрийн системийн онцлогийг тодорхойлох чухал хүчин зүйл юм. 1920-иод эхлэн олон намын тогтолцоо бүрэлдэж, эвслийн хэлбэрээр засгийн газар байгуулах үзэгдэл өргөнөөр ажиглагдах болсон. Тухайлбал, 1920-1930-аад онд Социал Демократ Намаас цөөнхийн засгийн газрууд байгуулагдаж эхэлсэн бөгөөд парламент дахь бусад намтай хамтран ажиллах замаар бодлогын хэрэгжилтийг хангаж байв. (Bergman, 2000) Дэлхийн II дайны дараа Шведийн Социал Демократ Нам цөөнхийн засгийн газрыг үргэлжлүүлэн удирдаж, улс төрийн тогтвортой байдлыг хадгалсан. 1976-1982 оны хооронд тус нам парламентад олонхийн суудлаа алдаж, барууны намуудын эвсэл давамгайлах болсон ч эдгээр нь мөн л цөөнхийн засгийн газрын хэлбэрээр ажиллаж байлаа. (Bolin, 2015)

Шведийн цөөнхийн засгийн газар нь улс төрийн хамтын шийдвэр гаргалтад тулгуурладаг. Засгийн газар нь парламентын бусад намаас дэмжлэг авч, чухал шийдвэрүүдийг олон талын зөвшилцлөөр батлах шаардлагатай болдог. (Lindvall, 2017) Энэ тогтолцоо нь дараах онцлогтой байв. Үүнд: Нэгдүгээрт, Засгийн газар бүрэн дэмжлэггүй ч парламентын дэмжлэгийг хангахын тулд тодорхой асуудлуудаар бусад намуудтай тохиролцдог. Хоёрдугаарт, цөөнхийн засгийн газрууд парламентын бусад намуудтай албан бус эвсэл байгуулж ажилладаг. Цөөнхийн засгийн газар нь парламент дахь олон намын саналыг харгалзах шаардлагатай тул бодлогын шийдвэр гаргалт илүү уян хатан байдаг. Энэ нь улс төрийн тогтолцоонд ил тод байдал, нээлттэй байдлыг бий болгодог. (Bergman, 2000) Шведэд цөөнхийн засгийн газрууд нь тогтворгүй байх магадлал өндөртэй мэт санагддаг ч бодит байдалд харьцангуй тогтвортой байдаг. Тухайлбал, Социал демократ намаас удирдсан цөөнхийн засгийн газрууд хэдэн арван жилийн турш улс төрийн тогтвортой байдлыг хангаж байсан. (Lindvall, 2017)Цөөнхийн

засгийн газар нь парламент дахь сөрөг хүчний үүргийг нэмэгдүүлж, хууль тогтоох үйл явцыг хяналттай болгож өгдөг. Энэ нь парламентад шийдвэр гаргах үйл явцыг олон нийтийн өмнө илүү хариуцлагатай болгодог. (Bolin, 2015) Цөөнхийн засгийн газрын нэг сул тал нь парламент дахь тохиролцоог хангах үйл явц удааширч, чухал асуудлууд дээр бодлого гаргалт удаашрах магадлалтай байдаг. (Bergman, 2000) 2014 оны сонгуулийн дараа Социал демократ нам болон Ногоон Намийн хамтарсан засгийн газар байгуулагдсан бөгөөд парламентын дэмжлэг хангалтгүй байсан тул *Зүүний нам*аас албан бус дэмжлэг авч ажиллаж байв. Энэ үеийн бодлогын хэрэгжилт нь өргөн хүрээний зөвшилцөлд тулгуурлаж, сангийн бодлого, цагаачлалын бодлогын асуудлуудад төвлөрсөн. Үүнээс харахад Шведийн цөөнхийн засгийн газрын түүх нь улс төрийн тогтолцооны онцлогийг тодорхойлж, хамтын шийдвэр гаргалт, тогтвортой байдлыг хангах механизм болж ирсэн. Цөөнхийн засгийн газар нь ил тод байдал, олон нийтийн оролцоог нэмэгдүүлдэг ч бодлого гаргалт удаашрах эрсдэлтэй байдаг. Гэсэн хэдий ч Шведийн туршлагаас харахад цөөнхийн засгийн газар нь парламентын үүргийг нэмэгдүүлэх, улс төрийн тогтвортой байдлыг хангах чухал хэрэгсэл болж чаджээ.

- **Унгар улсын эвслийн засгийн газрууд**

Унгарын эвслийн засгийн газрын талаарх өмнөх судалгаанууд ерөнхий сайдын давамгай байр суурь, улс төрийн удирдлагын хэв маяг давамгай байдгаараа онцлог юм. (Ilonszki G, 2019) Ерөнхий сайд нь засгийн газрын гишүүдийг томилох, огцруулах, засгийн газрын бүтцийг өөрчлөх зэрэгт өргөн эрх мэдэлтэй байв. 2000 оноос хойш энэ байр суурь нь улам бэхжиж, улс төрийн албан тушаалтан томилох, төрийн захиргааг төвлөрүүлэх хандлага нэмэгдсэн. (Goetz & Meyer-Sahling, 2008; Meyer-Sahling & Veen, 2012; Kopecký et al., 2022). Ийм нөхцөлд, ардчилсан системд шилжсэнээс хойш 20 жилийн хугацаанд Унгарт тогтвортой, эвслийн засгийн газрууд зонхилж байв. Ганц онцгой тохиолдол нь 2008–2010 оны хоорондын үе юм. (Vanyi, 2018)

Хүснэгт №2.1990-2021 оныг хүртэлх Унгар улсын эвслийн засгийн газрууд

№	Засгийн газрууд	Хугацаа	ЗГ-д орсон намын тоо	Төрөл	ЗГ-ын байр суурийн хувь	Парламентын суудал	Парламентад суудалтай намууд	Намын нөлөөний хувь (ENPP)
1	Антал 1	1990.05.23	3	ХОЭ	230 (59.6)	386	6	3.72
2	Антал 2	1992.02.24	3	ХОЭ	214 (55.7)	384	7	4.01
3	Боросс	1993.12.21	3	ЯОЭ	196 (51.3)	382	8	4.86
4	Хорн	1994.07.15	2	ХОЭ	279 (72.3)	386	6	2.89
5	Орбан 1	1998.07.06	3	ХОЭ	213 (55.2)	386	6	3.45
6	Медгиси	2002.05.27	2	ЯОЭ	198 (51.3)	386	4	2.5
7	Дюркан 1	2004.09.29	2	ЯОЭ	198 (51.6)	384	4	2.54
8	Дюркан 2	2006.06.09	2	ЯОЭ	210 (54.4)	386	6	2.61

9	Дюркан 3	2008.05.01	2	ЦЭ	191 (49.5)	386	6	2.64
10	Бажня	2009.04.14	1	ЦЭ	189 (49.2)	384	6	2.63
11	Орбан 2	2010.05.29	2	ХОЭ	263 (68.1)	386	5	2.54
12	Орбан 3	2014.06.06	2	ХОЭ	133 (66.8)	199	7	2.58
13	Орбан 4	2018.05.18	2	ХОЭ	133 (66.8)	199	7	2.63

Тайлбар: ХОЭ-Хэт олонхийн засгийн газар буюу (Surplus government)

ЯОЭ- Ялимгүй олонхийн эвсэл (Minimal winning coalition)

ЦЭ- Цөөнхий эвсэл (Minority coalition)

Эх сурвалж: Coalition governments in Center Eastern Europe, 2024

Хүснэгтэд харуулсанчлан Унгарт эвслийн засгийн газар зонхилж байсан ба зүүний ба барууны эвслийн ялгаа тодорхой байсан бөгөөд тус улсад эдийн засгийн хүндрэл нь 2008 оны санхүүгийн хямралаас өмнө ч байсан. Дюркан II эвслийн засгийн газар 2008 онд эдийн засгийн огцорсон бөгөөд тухайн үед Цөөнхийн эвсэлд байсан нам засгийн газраас гарсан. Үүний дараа Дюркан 3 нэг намын засгийн газар байгуулагдсан. Дараа нь байгуулагдсан Бажняйн засгийн газрыг “мэргэжилтний засгийн газар” гэж нэрлэсэн хэдий ч гол намуудаар дэмжигдээгүй. Хэдийгээр тус засгийн газар эдийн засгийн хямралыг амжилттай удирдсан ч, зүүн төвийн эвслийн уналт нь 2010 оны сонгуульд өрсөлдөг нам эвслийн том ялалт байгуулах нөхцөл болсон. 2010 оноос хойш Үндсэн хууль болон сонгуулийн тогтолцоонд өөрчлөлт орж, Ерөнхий сайдын эрх мэдэл улам бэхжсэн. Нөгөөтэйгүүр парламентын суудлын тоог бууруулж, олонхийн сонгуулийн элемент давамгайлсан нь сөрөг хүчний боломжийг хязгаарласан. (Meyer-Sahling, 2012) Намын системийн хувьд Фидес нам популист чиг хандлагатай болсон. Эвслийн засгийн газар байгуулах асуудлын хувьд 2010 оноос хойш эвслийн гэрээ байгуулахгүйгээр, урьдчилан тохирсон эвслийн хэлбэр (pre-electoral coalition) ашиглан засгийн газар байгуулсан. Яамд, сайдуудын хуваарилалт Ерөнхий сайдын бүрэн хяналтад байдаг. Христийн ардчилсан нам цөөн хэдэн яам (шашин, нийгмийн асуудал) өгсөн ч гол шийдвэрт нөлөөлөхгүй. (Dudzinska, 2021)

Хүснэгт №3. 2006-2011 оны эвслийн засгийн газруудын эрх мэдлийн хуваарилалт

Засгийн газар	**Он**	**ЗГ орсон нам**	**Сайдын тоо**	**Яамны тоо**	**ЕС**	**Сангийн яам**	**ГХЯ**	**ХНХЯ**	**ХЗДХЯ**
Дюркан 2	2006	Социалист нам, Чөлөөт ардчилсан холбоо	13	12	УСН	УСН	УСН	УСН	УСН
Дюркан 3	2008	Социалист нам,	16	13	УСН[135]	УСН	УСН	УСН	УСН

[135] Унгарын социалист нам

		Соможэвсэл							
Орбан 2	2010	Иргэний Холбоо, Христийн ардчилсан нам	10	8	УИХН[136]	УИХН	УИХН	УИХН	УИХН
Орбан 3	2014	Иргэний Холбоо, Христийн ардчилсан нам	12	9	УИХН	УИХН	УИХН	УИХН	УИХН
Орбан 4	2018	Иргэний Холбоо, Христийн ардчилсан нам	14	10	УИХН	УИХН	УИХН	УИХН	УИХН

Эх сурвалж: *Coalition governments in Center Eastern Europe, 2024*

Хүснэгтээс харахад олон суудал авсан нам гол эрх мэдэл бүхий сайдуудыг авсан нь зорилгын хувьд албан тушаал авахад төвлөрсөн байна. “Удирдлагын хэв маяг нь бюрократ биш, Ерөнхий сайдын улс төрийн зорилго дээр тулгуурласан. "Үндэсний зөвлөлдөөн" зэрэг популист аргуудыг ашиглан бодлогын шийдвэрийг сурталчилж, төвлөрлийг нэмэгдүүлсэн.” (Kaltwasser, 2012) Гэхдээ 2010 оноос хойш бүх Засгийн газрууд бүрэн эрхийн хугацаагаа дуусгасан. Үүний шалтгаан нь институцийн өөрчлөлт, популист суртал ухуулга, олонхийн дэмжлэг зэргээс шалтгаалсан. (Vanyi, 2018)

Румын Улсын эвслийн засгийн газрууд

Румыны улс төрийн элитүүд улс төрийн шууд холбоогүй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд хямралын мөчүүдийг стратегийн хувьд ашигласан. Улс төрчид засгийн газрын өөрчлөлтийг хүчээр хийхдээ ашигласан механизм нь тус улсын ардчиллын ухралтын эрсдэлийг нэмэгдүүлжээ. 2008 оны санхүүгийн хямрал болон Ковид-19 цар тахлын үед эрх баригчид институцийн үйл ажиллагааг өөрчлөх, урам зөрчих хэлбэрээр Засгийн газрыг солих оролдлого хийсэн бөгөөд парламентын гишүүдийг нам нь солих, дэмжлэх авахын тулд ил тод бус, хувь хүн рүү чиглэсэн урамшуулал ашиглаж байжээ. (Eihmanis, 2022) Гадаад хүчин зүйлс болох хямралууд нь эвслийн тогтворгүй байдлын шууд шалтгаан биш байсан ч тогтворгүй байсан эвслийн засгийн газруудын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байв. Тухайлбал, Ерөнхийлөгчийн гүйцэтгэдэг үүрэг, улс төрийн намуудын уян хатан, үзэл баримтлалын хувьд тогтворгүй байдал, байр сууриа амархан

[136] Унгарын Иргэний Холбоо нам

өөрчилдөг шинж, мөн парламент дахь нам солих үзэгдэл зэрэг нь эвслийн засгийн газруудын тогтворгүй байдалд нөлөөлдөг байна.

1990-2022 оны хооронд Румын улсад 36 Засгийн газар, 21 ерөнхий сайд үйл ажиллагаа явуулжээ. Энэ нь тус улс Зүүн Европын бүс нутагтаа хамгийн тогтворгүй орны нэг болгож байна. Дөрвөн засгийн газар тутмын гурав нь эвслийн засгийн газар байсан. Улс төрийн элитүүд хямралтын үеийг аливаа холбоо эвсэл шинээр бүрдүүлэх замаар албан тушаал, бодлогын зорилгодоо хүрэх боломж болгон ашиглахыг зорьсон. Гэвч энэ нь тухайн хямралын шийдэлтэй холбоогүй байв. Энэ нь Ерөнхийлөгч өөрт үнэнч засгийн газар байгуулж эрх мэдлээ нэмэгдүүлэх, намын удирдлагууд улс төрийн өрсөлдөгчдөө дарах, хувийн ашиг сонирхол бүхий авлигын шинжтэй бодлогын зорилго хэрэгжүүлэх, парламентын гишүүдийн нам солих замаар хувийн зорилгоо биелүүлэх зэрэгтэй холбоотой байна. Ялангуяа намын гишүүнчлэлээ солих, авлига зэрэг нь Румын дахь ардчиллын тогтвортой байдалд учирч буй томоохон сорилтуудын нэг байв. (Anghel V. a., 2022)

Хүснэгт №4. 1990-2022 оныг хүртэлх Румыны эвслийн засгийн газрууд

№	Засгийн газрууд	Хугацаа	ЗГ-д орсон намын тоо	Төрөл	Засгийн газрын хувь	Парламентын гишүүд	Суудалтай намын тоо	Намын нөлөөний хувь
2	Столоян	1991-10-17	4	ХЭ	78.8	396	10	2.22
3	Вэкэрою I	1992-11-20	1	ЦЭ	34.3	341	12	5.86
4	Вэкэрою II	1994-08-18	2	ЦЭ	42.5	341	12	5.96
5	Вэкэрою III	1996-09-03	1	ЦЭ	30.9	340	12	6.31
6	Чорбеа I	1996-12-12	6	ХЭ	55.7	343	11	6.1
7	Чорбеа II	1997-12-05	5	ХЭ	54.7	342	10	6.6
8	Чорбеа III	1998-02-11	5	ЦЭ	43.4	341	10	6.58
9	Василе I	1998-04-17	6	ХЭ	55.1	343	10	6.58
10	Василе II	1998-10-27	5	ХЭ	54.8	343	10	6.52
11	Исереску I	1999-12-22	5	ЯОЭ	51.9	343	10	6.55
12	Исереску II	2000-09-14	4	ЦЭ	46.9	343	10	6.68
13	Нэстасе I	2000-12-28	3	ЦЭ	44.9	345	7	4.08
14	Нэстасе II	2003-06-19	1	ЦЭ	46.6	343	6	3.54
15	Попеску I	2004-12-29	4	ЦЭ	46.1	332	6	4.87
16	Попеску II	2006-12-04	3	ЦЭ	42.4	330	6	5.07
17	Попеску III	2007-04-05	2	ЦЭ	22.2	329	6	5.21
18	Бок I	2008-12-22	2	ЯОЭ	67.4	334	5	3.67

19	Бок II	2009-10-01	1	ЦЭ	34.4	334	5	3.72
20	Бок III	2009-12-23	3	ЦЭ	43.5	333	6	3.93
21	Унгуряну	2012-02-09	3	ЦЭ	48.2	328	6	4.0
22	Понта I	2012-05-07	3	ЦЭ	46.5	325	6	4.07
23	Понта II	2012-12-21	4	ХЭ	66.3	412	8	4.41
24	Понта III	2014-02-26	3	ЦЭ	49.7	386	8	4.1
25	Понта IV	2014-03-05	4	ЯОЭ	54.4	386	8	4.47
26	Понта V	2014-12-17	4	ХЭ	55.4	401	8	4.09
27	Чиолош	2015-11-17	Нам бус	-		370	7	3.32
28	Гриндеану	2017-01-04	2	ЯОЭ	52.9	329	6	3.51
29	Тудосе	2017-06-29	2	ХЭ	51.1	329	6	3.51
30	Дэнчиле I	2018-01-29	2	ЯОЭ	48.5	328	7	3.56
34	Кицю I	2020-12-23	4	ЯОЭ	51.2	330	6	4.25
35	Кицю II	2021-09-06	2	ЦЭ	34.5	330	6	4.25
36	Чюке	2021-11-25	3	ХЭ	62.1	330	7	4.71

Румыны эвслийн засгийн газрын хэлбэрт Хэт эвсэл, Цөөнхийн эвсэл дийлэнх хувийг эзэлж байна. Харин сүүлийн жилүүдэд Ялимгүй олонхийн эвсэл түгээмэл болж байна. Эвслийн засгийн газарт Ерөнхийлөгч эвсэл бүрдүүлэхэд чухал үүрэгтэй байна. Жишээ нь ерөнхий сайд, ерөнхийлөгч хоёр өөр намд харьяалагддаг нөхцөлд эвслийн тогтворгүй байдлыг нэмэгдүүлдэг болох нь ажиглагджээ. 1991 оны Үндсэн хуулиар Румын нь ерөнхийлөгч, ерөнхий сайдын хосолмол эрх мэдэл бүхий хагас ерөнхийлөгчийн тогтолцоотой болсон. Уг тогтолцоо нь эрх мэдлийн төвлөрөл, сөргөлдөөнд хүргэдэг ч тухайн хоёр институцийн хоорондын тэнцвэржилт нь ардчиллаас ухрахаас сэргийлэх хүчин зүйл болдог. (Anghel V. , 2018) 2020 оны Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр ерөнхийлөгч ерөнхий сайдыг нэр дэвшүүлэх эрхийг хязгаарласан. Улмаар ерөнхийлөгч зөвхөн парламентын үнэмлэхүй олонхийн итгэлийг авах бодит боломжтой нэр дэвшигчийг томилох эрхтэй болсон бөгөөд ингэснээр эвслийн тогтворгүй байдал буурах магадлалтай гэж судлаачид үзэж байна.

Дүгнэлт

Судалгаанаас харахад эвслийн засгийн газар бол олон намтай улс төрийн системийн үр дагавар төдийгүй тухайн улсын институцийн зохион байгуулалт, улс төрийн соёл, нам хоорондын итгэлцэл, хууль эрх зүйн зохицуулалтын үр дүн байдаг. Германд эвслийн гэрээний нарийн тогтолцоо, Швейцарьт төлөөллийн зарчимд суурилсан их эвсэл, Шведэд зөвшилцөлд тулгуурласан цөөнхийн засгийн газар, Унгарт ерөнхий сайдын давамгай байдал, Румынд ерөнхийлөгчийн институцийн оролцоо зэрэг нь тус тусын онцлог жишээ юм. Швейцарь, Швед зэрэг Европын зарим улсуудад эвслийн засгийн газар тогтвортой байхад, Румын улсад харьцангуй тогтворгүй байдаг нь институцийн

тэнцвэртэй байдал, албан ба албан бус механизм, намуудын үзэл баримтлалын уян хатан байдал, эвслийн гэрээний оршин тогтнол зэрэг олон хүчин зүйлээс хамаарч байгааг харуулж байна.

Эвслийн засгийн газрын үр нөлөөг үнэлэхдээ зөвхөн парламент дахь олонхийн харьцаа бус, итгэлцэл, үйл ажиллагааны механизмууд, албан тушаалын хуваарилалт дахь тэнцвэр, институцийн хязгаарлалт, ардчиллын гүнзгийрэлд үзүүлэх нөлөө зэрэг үзүүлэлтийг хамтад нь авч үзэх шаардлагатай байна.

Ном зүй

1. Anderson, J. J. (2013). *German Politics and Society.*
2. Debus, M. (2008). Office and Policy Payyoffs in Coalition Governments. *Party Politics, 14*(5), 45-64.
3. Saafield, T. (2000). Members of Parliament and Governments in Western Europe: Agency Relations and Problems of Oversight. *European Journal of Political research, 37*(3), 363-376.
4. Christian, S. G. (2016). Investiture Rules in Germany. S. M. Bjon Erik Rasch-Д, *Parliaments and Government Formation: Unpacking Investiture Rules* (хуудсд. 67-85). Oxford: Oxford University Press.
5. Mueller, W. L. (2021). *Swiss Democracy: Possible to Conflict in Multicultural Societies.* Palgrave Macmillan.
6. Vatter, A. (2020). *The Swiss Political System: Continuity and Change in a Consensus Democracy.* Springer.
7. Church, C. (2004). *The Politics and Government of Switzerland.* Palgrave Macmillan.
8. Bergman, T. (2000). The Moinority Governments in Sweden: Legislative Strategies and Political Stability. *Scandinavian Political Studies, 23*(3), 181-2000.
9. Bolin, N. A. (2015). The Swedish Party System: Continuity and Change. *Scandinavian Journal of Political Studies, 38*(2), 148-165.
10. Lindvall, J. (2017). Between Stability and Turbulence: Sweden's Political System in Transition. *Nordic Studies in Political Economy, 42*(4), 215-230.
11. Ilonszki G, W. M. (2019). *Coalition Governance in Central and Eastern Europe.* Oxford University Press.
12. Vanyi, E. (2018). Political Predation or Personal Loyalty: The Background of Highly Politicized Senior Civil Servants in Hungary. *Politikatudomany Online*(Special Issue).
13. Meyer-Sahling, T. V. (2012). Governing the post-communist state: Government alternation and senior civil politiciztion in Central and Eastern Europe. *East Europeaan Politics*, 4-22.
14. Dudzinska, G. I. (2021). Opposition behaviour against the third wave of autocratization: Hungary and Poland compared. *European Political Science*, 603-616.
15. Kaltwasser, C. M. (2012). Populism in Europe and the Americas: Threat or Corrective for Democracy. *Populism in Europe and the Americas: Threat or Corrective for Democracy* (хуудсд. 205-222).-Д Cambridge University Press.
16. Eihmanis, D. B. (2022). East Central Europe in the COVID-19 crisis. *East European Politics, 38*(4), 491-506.
17. Anghel, V. (2018). Why can't we be friends? The coalition potential of presidents in semi-presidential republics- Insights from Romania. *East European Politics and Societies: and Cultures, 32*(1), 101-118.
18. Anghel, V. a. (2022). Developments in European Politics. A. Veronica-Д, *Informal Institutions:The world's open secrets'* (хуудсд. 55-66). London: Bloomsbury Academic.

SPSIRPA FORUM 2025

Session 5-1

Historical Periodization of MongoliaKhalmic Cooperation

МОНГОЛ –ХАЛИМАГИЙН ХАРИЛЦААНЫ ТҮҮХИЙГ ҮЕЧЛЭХ НЬ

Н.Наранжаргал

Түүхийн ухааны доктор (Ph.D), Эрдэм шинжилгээний ажилтан

ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн Орос судлалын салбар

Потомки монголов, некогда создавших империю мирового масштаба, сегодня насчитывают около 10 миллионов человек, расселённых по разным странам. Из них 3,5 миллиона проживают в независимом государстве – Монголии, а значительное число монголоязычных народов обитает в КНР и РФ. Монголия, будучи единственным суверенным государством монгольского этноса, традиционно поддерживает связи с монголоязычными народами за рубежом, оказывая им поддержку и содействие.

В данном докладе рассматривается история монголо-калмыцких отношений с общим введением “Кто такие калмыки, которая делится на следующие периоды:

1. начальный период монголо-калмыцких отношений: конец 1800-х – начало 1900-х годов
2. период активного развития монголо-калмыцких отношений: 1921–1925 годы
3. период снижения активности: 1930–1943 годы
4. период разрыва отношений: 1943–1958 годы
5. начальный этап возрождения отношений: 1958–1966 годы
6. период восстановления отношений: 1966–1974 годы
7. период наивысшего расцвета монголо-калмыцких отношений: 1974–1990 годы
8. период ослабления отношений: 1990–2000 годы
9. современный этап возрождения монголо-калмыцких отношений: с 2000 года по настоящее время.

Нэгэн цагт дэлхийн хэмжээний эзэнт гүрэн байгуулж явсан монголчуудын үр удам, монгол угсаатан 10 сая орчим хүмүүс дэлхийн улс орнуудад тархан амьдарч байна. Монгол угсаатнуудаас Монгол Улсад 3,5 сая хүн тусгаар улс болон амьдарч байгаа бол БНХАУ болон ОХУ-д олон тоогоор амьдардаг. Монгол улс нь монгол туургатны цор ганц тусгаар улс болохынхоо хувьд бусад улс дахь монгол угсаатнуудтай харилцаж, тэдний өмөг түшиг болсоор ирсэн юм.

Энэхүү илтгэлдээ монгол-халимагийн харилцааг Халимагууд гэж хэн бэ? хэмээх ерөнхий оршил *1. Монгол-Халимагийн харилцааны эхлэл үе: 1800-аад оны сүүлээс 1900 оны эхэн, 2. Монгол-Халимагийн харилцаа эрчимтэй хөгжсөн үе: 1921-1925 он, 3.*

Монгол-Халимагийн харилцааны эрчим буурсан үе: 1930-1943 он, 4. Монгол-Халимагийн харилцаа тасалдсан үе: 1943-1958 он, 5. Монгол-Халимагийн харилцааны сэргэлтийн эхэн үе: 1958-1966 он, 6. Монгол-Халимагийн харилцааны сэргэлтийн үе: 1966-1974 он, 7. Монгол-Халимагийн харилцааны оргил үе: 1974-1990 он, 8. Монгол-Халимагийн харилцаа саарсан үе: 1990-2000 он, 9. Монгол-Халимагийн харилцааны дахин сэргэлтийн үе: 2000 оноос одоо хүртэл гэсэн 9 хэсэгт хуваан авч үзлээ.

Халимагууд гэж хэн бэ? Зүүнгарын хаант улс хүчирхэгжилт, бэлчээр нутгийн хомсдол зэргээс үүдэн дөрвөд, торгууд аймгийн зарим хэсэг XVII эхээр Сибирийн өмнөд хэсгээр нутаглаж байгаад цааш нүүдэллэн, Каспийн тэнгисийн хойд хэсэг, Ижил мөрний доод урсгалаар сууж болжээ. Ийнхүү 1608-1610 оны Дөрвөдийн Далай тайш, 1628 оны Торгуудын Хо өрлөг (40,0), 1663 оны Хөндлөн Увш, Дорж (10,0), 1674 оны Дөрвөдийн Сономцэрэн (1000 өрх), 1676 оны Доржравдан хатан (1000 өрх), 1686 оны Цагаанбаатар тайш, 1690-ээд оны Аюук хан торгуудын нүүдэл, 1745 оны Дэжид ноён, 1755 оны Шээрэн тайж (10,0 өрх) -ийн нүүдлийн үр дүнд тухайн бүс нутагт ойрад монголчуудын Торгуудын хаант улс (Халимагийн хаант улс) байгуулагдсан билээ. 1771 онд Халимагийн хаант улсын нэлээд хэсэг болох 33 мянган өрхийн 160000 хүн ам Зүүнгарын нутаг руугаа нүүснээр үлдсэн дөрвөд, торгуудуудыг Астархан мужийн захиргаанд оруулсан юм. Энэ бүхний үр дүнд ОХУ-ын бүрэлдэхүүнд 280 мянган хүн амтай Бүгд найрамдах халимаг улс оршиж байна.

Угсаа гарал нэгтэй ч түүхэн нөхцөл шалтгааны улмаас салан холдсон Монгол, Халимаг ахан дүүс 300 жилийн дараа харилцаа холбоогоо идэвхжүүлснээр зогсохгүй нэгдэн нийлэх тухай асуудал хөндөгдөж байсан ч тухайн үеийн улс төрийн нөхцөл байдлын улмаас энэ нь бодитойгоор хэрэгжиж чадаагүй юм.

Монгол-Халимагийн харилцааны сүүлийн 100 гаруй жилийн түүхийг бүхэлд нь авч үзвэл дараах 9 үе болгон авч үзэж болохоор байна. Үүнд:

1. Монгол-Халимагийн харилцааны эхлэл үе: 1800-аад оны сүүлээс 1900 оны эхэн.
Халимагууд эртнээс угсаа гарал нэгтэй монголчууд, шашин шүтлэг нэгтэй төвөдүүдтэй харилцахыг бодлого барьж байсан ч энэ үеийн Монгол-Халимагийн харилцаа зөвхөн шашны хүрээнд хязгаарлагдмал байдлаар явж байв.

Халимаг хаант улсаас Зүүнгарын нутгаар дамжин Төвөд хүрдэг зам[137] 1750-иад онд Зүүнгарт өрнөсөн дайн самууны улмаас хаагдсан бол 1771 онд Увш хаан өөрийн албатуудын ихэнхийг дагуулан Зүүнгарын нутаг руу буцсанаар Оросын нутагт үлдсэн халимагуудыг Астархан мужийн захиргаанд оруулж, гадагшаа харилцах эрхийг нь хассанаар тэдний Төвөд, Монголтой харилцах харилцаа зогссон юм. XIX зууны сүүлээс Хаант оросын дорно дахинд явуулах бодлоготой холбоотойгоор Халимагуудын Монгол, Төвөдтэй харилцах харилцаа сэргэжээ.

[137] Алексеева. П.Э. О людях и времени. Элиста., 2010 стр.106

Ингэснээр Халимагийн Эрхтэн аймгийн лам Дамбо Ульянов 1977, 1884[138], Бага дөрвөд аймгийн Бааза-Багш буюу Меннеджуев Бадам 1891 онд[139] Өргөөгөөр дайран Төвөд руу явж байв. Тэднээс гадна Халимагаас Төвөд болон Хятадад очиж байсан Пурдаш-Очир Джуногруев, Овше Мучкинович Норзунов, Леджин Арлуев, Менке Борманжаев, лхарамба Боован Бадма, шажин лам Шарав Тепкин нар монголоор дайран аялсан нь дамжиггүй.

Халимагууд Төвөд руу явахдаа Монгол нутгаар дайрахаас гадна Богд Жаьзандамба болон Гандан хийдэд мөргөл үйлдэх, бурханы шашны эд зүйл авах зорилгоор Хүрээнд ирдэг байв. Тухайлбал,

1880 онд Хүрээнд Халимагийн нэгэн ноёны бэлэвсэн хатан ирж, VIII Богдод мөргөсөн нь жирийн иргэдээс анхных нь байв. Энэ үеэс хойш Хүрээнд жил бүр 4-10 халимаг ирдэг болсон ба тэд Хүрээнд ирэхдээ саяас цөөнгүй мөнгөн рубль өргөж, Хүрээнээс 1500-аад бурхан, 4 ганжуур, 2 данжуур залж авч”[140] байжээ.

1890 оноос Халимагаас 3 хүн Хүрээнд ирж, Ёнзон хамбын хашаанд гэр барин[141] суурин суух болсноор Монголд очсон халимагууд тэнд байрладаг болжээ.

1900 оны эхээр Их Чоносын хийдийн гэлэн Бовы (Цедена) Кармыкова-Шарапова Өргөөгөөс 100 цутгамал бурхан болон бусад шашны хэрэглэлүүдийг[142] авч хийдээ өргөжүүлсэн баримт бий.

Халимагт шашны дээд боловсрол олгох Бага дөрвөдийн Чойрын сургуулийг 1907 онд, Их цоохорын Чойрын сургуулийг 1908 онд байгуулагдаж[143] тэдгээр сургуульд ажиллах багшийг Буриад, Монгол, Төвөдөөс урин[144] ажиллуулах болов. Ингэснээр 1909 оноос Их Цоохорын Цанидын сургуульд монгол лам Хаянхярваа[145], 1912 оноос аграмба Лувсандорж[146] нар багшлах болжээ.

Халимагууд шашны сургуульдаа Монголоос багш урьж ажиллуулахаас гадна шашны боловсон хүчнээ Монголд бэлдэх хүсэлтэй байв. Энэ ч үүднээс Оргойхны хийдийн залуу лам гэвш Очир Манджиевич Дорджиевыг Монголд сургахаар явуулсан. О.М.Дорджиев Монголын Гандан хийдэд суралцан, гавж цол, Түгмэд гэх шашны нэр хүртэн 1920 онд

---

[138] Ульянов Д. Предсказан

[139] Сарин герл. Хальмг литературин дурсхлмуд (XIII-XX зун жилмүдин эклц). Орчулснь Бадмин Андрей. Элиста., 1991. Стр. 204

[140] А.М.Позднеев Монголия и монголы. Т.1. стр. 563-564

[141] Бадмаев А.В. Сарин герл: хальмг литературин дурсхлмуд (XIII-XX зун жилмүдин эклц) Элиста: Калм.кн.изд-во. 1991 -234 с. с.207

[142] НА РК. Ф.И-9.оп.5. Д.1477. л.122.

[143] История буддизма в СССР и российской федерации в 1985-1999 гг. //под общ. Ред. Н.Г.Очировой (Н.В.Абаев, Э.П.Бакаева, У.П.Бичелдей, Ц.П.Ванчикова, С.Ю.Лепехов, Т.М.Садалова). Элиста: Министерство образования, культуры и науки Республики Калмыкия, 2011. -392 с. ил. стр 210.

[144] НА РК. Ф. И-9. Оп.5.д. 2670. л.84-85

[145] Буддизм в Калмыкии. Бакаева Э.П. Элиста. 1994. -128 с.: стр 43

[146] История калмыкии с древнейших времен до наших дней. В трех томах. Том 3. –Элиста: И 907 ГУ “ издательский дом «Герел», 2009. –Т.3. -752с.: ил .Редакторы В.Л.Теленгидова, А.В.Задорожная. стр 255.

Халимаг нутаг руугаа буцаж[147], шашин номын үйл хэргээ явуулан ард олны дунд Түгмэд гавж нэрээр алдаршсан юм.

1900-аад оны эхээр Хаант Орост хувьсгал хийх оролдлогууд гарч, улс төрийн тогтворгүй байдал үүссэн нь тусгаар улс болохыг эрмэлзэж байсан монголчуудын анхаарлыг татаж байв. Энэ үед Халимагаас шашны сургуульд багш хүссэнийг ашиглан Богд гэгээн өөрийн тагнуул Н.Хаянхярвааг Халимаг руу багшаар явуулсан байдаг. В.И.Ленинийг Сибирт цөллөгт байхад нь Богд гэгээн өөрийн тагнуул Цагаачийг Хөвсгөлийн хязгаараар, Соёны уулыг давуулан нууцаар явуулж, уулзуулж байсан[148] гэх бүрхэг мэдээ ч бий.

Халимагийн талаас шашны эд зүйл авах, шашны ном эрдэмд суралцах, Богд хаанд мөргөх, Төвөд зэрэг дорно дахины улсууд руу дамжин явах зорилгоор Монгол руу ирдэг байжээ. Харин Монголын талаас Халимагтай төдий л идэвхтэй харилцаж байгаагүй боловч Европ болон Орос орныг танин мэдэх, тухайн үед өрнөж байсан үйл явдал, улс төрийн нөхцөл байдлыг тандан судлах үүднээс өөрийн төлөөний хүмүүсийг Халимагийн сүм хийдэд суулгах, шашны сургууль дацанд багш илгээх зэргээр харилцаж байлаа.

<u>2. Монгол-Халимагийн харилцаа эрчимтэй хөгжсөн үе: 1921-1925 он.</u>

Монголын 1921 оны хувьсгалын өрнөл, ЗОУ-аас тусламж дэмжлэг хүссэнтэй холбоотойгоор Орос цэрэг Монголд орж ирэхэд тэдний бүрэлдэхүүнд халимагууд багтжээ. Энэ нь ЗОУ-ын тал халимагуудыг Монгол болон дорно дахинд явуулах улс төрийн бодлогодоо ашиглах бодлого баримталж байсантай холбоотой байв.

Монголд алба хаах халимаг сургагчдыг гурван удаа сонгон авч, хоёр бүлэг болгон зохион байгуулж, 1921 оны 6-р сар, 12-р сард нийтдээ 114 сургагчийг ирүүлсэн байна. 1921-1925 онд Монголд байсан халимаг сургагчдын тоо Монголоор дамжин бусад улс оронд тусгай даалгавар гүйцэтгэсэн, амь үрэгдсэн, эрүүл мэндийн шалтгаанаар цэргээс халагдаж нутаг буцсан, шинээр нэмэгдэж ирэх зэргээр өөрчлөгдөж байсан бөгөөд одоогоор 124 сургагчийн нэр тодорхой[149] болоод байна.

Монголд алба хааж байсан эхний бүлгийн 18 сургагч нь Хиагтын хамгаалалт болон монгол орны төв, зүүн хэсгийг гамин цагаантны үлдэгдлээс цэвэрлэх байлдааны үйл ажиллагаанд тагнуулын хэсэг болон хороо, суман, бригадын сургагч даргаар идэвхтэй оролцжээ. Баруун хязгаарыг чөлөөлөх цэргийн ажиллагаанд ч халимаг байж болох хүмүүс оролцжээ.

Монгол дахь гамин, цагаантны үлдэгдлийг устгасны дараа халимаг сургагчид ардын журамт цэргийн анги салбаруудад сургагчаар томилогдож цэргийн даргын сургуулийн сургалтын хөтөлбөр, цэрэг сурган боловсруулах хөтөлбөр зэргийг боловсруулж, цэрэг

[147] Буддийская традиция в Калмыкии в XX веке: памяти О.М.Дорджиева (Тугмюд-гавджи). 1887-1980. Элиста: КИГИ РАН, 2008,-190с.:ил. +вкл.(1с). стр 6.

[148] С.Баттогтох. Монголын алдарт тагнуулч Н.Хаянхирваагаас Оросын “Улаан империализм”-тай хийсэн тэмцлийн оргил үе. “Өнөөдөр” сонин. 06.01 № 126, 06.04 №128, 06.05 № 129 дугааруудад цувралаар гарав.

[149] Н.Наранжаргал. 1921 оны хувьсгалын үед монголд байсан халимагуудын нэр, тоог тодруулах нь (= Уточнение имен и численности калмыков, проживавших в Монголии во время революции 1921 года) // Бюллетень Калмыцкого научного центра РАН. 2021. № 2. -с. 19-41. DOI: 10.22162/2587-6503-2021-2-18-19-41

дайчдын амьдрах орчныг сайжруулах, цэргүүдийг орчин үеийн цэргийн эрдэмд сургах зэрэгт гар бие оролцож, Нийслэл Хүрээ, Улиастай хотын комендант, Ховдын цэргийн штаб, Нийслэл Хүрээний цагдан сэргийлэх хороо, торгон цэрэг, шорон зэрэг газарт ажиллаж, улмаар ардын журамт цэргийг байнгын арми болгон өөрчлөхөд багагүй нөлөөлсөн байна. Халимаг сургагчид нь зөвхөн цэргийн салбараас гадна нам эвлэл, дотоодыг хамгаалах газар, орон нутгийн засаг захиргааг бэхжүүлэх, шинэ цагийн соёлыг дэлгэрүүлэх зэрэгт идэвх санаачилгатай ажиллаж, өөрсдийн мэдэж чаддаг бүхнээрээ тусалж, ажиллаж байсан[150] юм.

Энэ үед Монгол-Халимагийн харилцаа идэвхжихэд нөөлсөн зүйл бол 1921-1922 онд Халимагт болсон их өлсгөлөн юм. Өлсгөлөнгийн хүнд нөхцөлд орсон Халимагууд Монгол улсаас тусламж хүсэхэд Монголын засгийн газар бэлэн мөнгө төгрөг болон 1000 гаруй шар үхрээр тусалсан. Уг тусламжийг хүргүүлсэн ч Халимагууд өлсгөлөнгийн аюулаас гарч чадаагүй тул дахин тусламж хүсэхэд нь Монголын Засгийн газар Ижил мөрөн дэх халимагуудыг Монгол нутагт нүүлгэн авч ирэх шийдвэр гаргаж, энэхүү асуудал Монгол, Зөвлөлтийн Засгийн газрын түвшинд яригдан эхэндээ бүтэмжтэй байсан ч эцэстээ ЗХУ татгалзсанаар асуудал зогссон[151] байна.

Тухайн үед Монгол улсад алба хааж байсан халимагууд хангамж муу, цалин мөнгө удаан хугацаагаар өгөхгүй байгаа зэрэг асуудлаар ЗХУ-ын цэргийн удирдах албаныхантай маргалдан шөргөлцөлдөх болжээ. Үүний улмаас 1924 оны сүүлээр ардын хувьсгал нэгэнт ялалтад хүрсэн, ЗОУ-ын Монголын төр засагт тодорхой хэмжээний нөлөөтэй болсон, Халимаг цэргүүд ЗОУ-ын бодлогыг Дорно дахинд хэрэгжүүлэхээс илүүтэй Монголчуудыг дэмжих туслах зэрэг байдал илүүтэй ажиглагдах болсноор тэднийг нутаг буцаасан байна. Энэ үйл явдал 1920-иод оны эхэн үед идэвхэжсэн хоёр талын харилцаа сулрахад хүргэжээ.

3. Монгол-Халимагийн харилцааны эрчим буурсан үе: 1930-1943 он.

1925 оноос хойш цэргийн хэргээр цөөн тооны халимаг хүмүүс Монголд ажиллах болсон байна. Харин 1939 оны Халх голын дайны үед тухайн үеийн хэрэгцээ шаардлагын улмаас улаан армид алба хааж байсан халимаг бага дарга нарыг Монгол руу илгээжээ. Тэд Халх голын дайнд оролцон, БНМАУ-ын цэргийн анги дивиз болон улс төрийн газруудад ажиллаж байв[152]. Дайны дараа тэднийг нутаг буцаасан бөгөөд үлдэн ажиллаж байсан хүмүүсийн ихэнхийг 1943 онд ЗХУ халимагуудыг цөлсөнтэй холбогдуулан Монгол нутгаас гаргасан юм. 1945 оны чөлөөлөх дайнд Монголд ажиллаж байсан цөөн

[150] Н.Наранжаргал. Монголын 1921 оны хувьсгалд оролцсон Халимаг сургагчдын намтрын судалгаа. // Bibliotheca oiratica-biography serica-XVII. Ред. На.Сүхбаатар.Улаанбаатар. 2021, -120х,

[151] Н.Наранжаргал. Халимаг дахь өлсгөлөн ба Халимагуудыг монгол улсад нүүлгэн шилжүүлэх гэсэн асуудлын тухай (О голоде в Поволжье в1920-х гг. и вопросе о преслении калмыков в Монголию) // ВЕСТНИК Калмыцкого института гуманитарных исследований РАН. №3, 2014г.: Элиста: Федральное государственное бюджетное учреждение науки Калмыцкий институт гуманитарных исследований Российской академии наук, 2014. –с50-57.

[152] Н.Наранжаргал. Халх голын дайнд оролцсон халимаг дайчид (= О калмыцких военных — участниках событий на Халхин-Голе) // Magna adsurgit: historia studiorum. 2020, №1, стр 96-103.

Халимаг цэргийн сургагч нар болон улаан армид алба хааж байсан[153] Халимаг цэргүүд оролцжээ.

4. Монгол-Халимагийн харилцаа тасалдсан үе: 1943-1958 он.

1943 онд ЗХУ-аас урвасан гэх шалтгаанаар Халимагийн автономит эрхийг устган, ард түмнийг нь Зөвлөлтийн хүнд ширүүн уур амьсгал бүхий нутгуудаар тараан цөлж[154], Монголд ажиллаж байсан цөөн тооны халимагуудыг буцаан татаж нутаг заан суулгаснаар тухайн үед идэвхтэй өрнөж байсан Монгол-Халимагийн харилцаа тасалдан зогсоход хүрсэн байна. Тухайн үед БНМАУ нь тусгаар тогтнол, аюулгүй байдлын хувьд бүрэн бэхжээгүй, улс орны хүч чадал сул дорой, ЗХУ-аас ихээхэн хамааралтай оршиж байсан тул тэдний бодлогыг сөрөн Халимагтай харилцах боломж байгаагүй юм.

5. Монгол-Халимагийн харилцааны сэргэлтийн эхэн үе: 1958-1966 он.

1958 онд Н.С.Хурщевын гаргасан зарлигаар Халимагийн ард түмэн цөллөгөөс чөлөөлөгдөж, Ижил мөрөн дэх нутагтаа буцан ирснээр Монгол-Халимагийн харилцаа дахин сэргэх боломж нээгджээ.

Энэ үед БНМАУ-аас Автономит Халимагт очсон анхны хүмүүс бол Москва дахь Коммунист залуучуудын эвлэлийн дээд сургуулийн төгсөгчид байв. Тэд 1958 онд Халимагт очсон нь албан ёсны айлчлал байгаагүй бөгөөд сургуулиа төгссөн залуус өөрсдийн сонирхлоор угсаа гарал нэгтэй ах дүү нарынхаа нутгаар зочилсон аялал жуулчлалын шинжтэй явдал байв.

Халимагийн талаас ч сэтгүүлч, залуучуудын оролцсон олон хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид анх 1964 онд БНМАУ-д зочилсон байдаг.
Энэ үеийн харилцаанд зохиолчид багагүй үүрэгтэй байсан бөгөөд Монголын зохиолчдоос Чимэд, Тарвай, Доржпалам, Пүрэв, Жамсран[155], Цэнд, Мөнх, Жамсранжав, Пүрвээ, Тарваа, Бааст, Лхамсүрэн[156] нар Халимаг зохиолчидтой хамт суралцаж, тэдэнтэй нөхөрлөж байжээ.

1960-аад оноос Монгол-Зөвлөлтийн харилцаа ч улам өргөжиж, найрамдлын сар, өдрүүдийг тэмдэглэх болсон нь Монгол, Халимагийн харилцаа сэргэхэд чухал түлхэц болсон байна. Энэ үеэс хоёр талын төлөөлөл харилцан айлчлах болж, Монгол, Халимагийн зохиолчид, шинжлэх ухааны салбарт харилцаа холбоо тогтжээ.

Энэ үеийн Монгол-Халимагийн харилцаанд зохиолчид голлох үүрэгтэй оролцож байснаараа онцлог юм. Тухайн үед Москвад сурч байсан Монгол, Халимагийн

---

[153] Н.Наранжаргал. Калмыцко-монгольские отношения (1925-1943 гг.) // ВЕСТНИК Калмыцкого института гуманитарных исследований РАН. № 5, 2016г.: Элиста: Федральное государственное бюджетное учреждение науки Калмыцкий институт гуманитарных исследований Российской академии наук, 2016. –с40-44.

[154] Н.Наранжаргал. Сибирт цөлөгдсөн халимагууд. Редактор Д.Золбоо. Улаанбаатар, Тотопресс. 2024, -182х

[155] А.Амарсанаы нэрэмжит Халимагийн үндэсний төв номын сан. “Хальмг үнн” сонины 1962. 02.03 өдрийн дугаар

[156] А.Амарсанаы нэрэмжит Халимагийн үндэсний төв номын сан. “Хальмг үнн” сонины 1967.07.09 өдрийн дугаар

зохиолчид танилцан нөхөрлөж, Монголын зохиолчид Халимагт нэг бус удаа хоёр гурваараа айлчилж, Халимагийн сонин хэвлэлд Монголын тухай мэдээлэл мэр сэр хэвлэгдэх болжээ.

6. Монгол-Халимагийн харилцааны сэргэлтийн үе: 1966-1974 он.

1966 онд Монгол-Зөвлөлтийн найрамдлын нийгэмлэг байгуулагдаж, түүний бүрэлдэхүүнд Монгол-Халимагийн найрамдлын хэлтэс байгуулагдсан нь хоёр улсын харилцааны цаашдын хөгжилд чухал түлхэц болов.

Энэх үеэс монгол болон халимагийн зохиолчид бие биеийнхээ нутаг оронд харилцан зочилж, очсон газар, үзсэн зүйлсээ тусгасан зохиол бүтээл туурвиж байсан нь хоёр орны ард түмэнд нэг нэгнээ танин мэдэх хэрэглэгдэхүүн болсон. Халимагийн зохиолчдоос Зохиолчдын холбооны тэргүүн О.Т.Бимбаев, ардын уран зохиолч А.И.Сусеев, Д.Н.Кукилтинов, С.К.Каляев, БНМАУ-ын зохиолчдоос Д.Тарва, Д.Цоодол, С.Дашдооров, Д.Цэмбэл[157] нар энэхүү харилцаанд онцгой үүрэг гүйцэтгэсэн юм. Уг харилцааны үр дүнд 1967 онд Халимагийн зохиолчдын шүлгийн түүвэр “Зүрхний аяс” нэртэйгээр Монголд, Монголын зохиолчдын шүлгийн түүврийг 1968 онд Халимагт “Мөнх заль”, 1971 онд “Найрамдал” нэрээр хэвлэгджээ. Нам засгийн зүгээс ч хоёр орны зохиолчдын уран бүтээлээр дамжуулан бие биеийнхээ ахуй амьдрал, соёлоос суралцахыг дэмжиж байлаа.

Халимагийн сэтгүүлч, залуучуудын оролцсон олон хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид 1968, 1970, 1973 онд БНМАУ-д зочилжээ. Эдгээр сэтгүүлч, жуулчид нутаг орондоо буцаж очсоныхоо дараа өдөр тутмын сонин, сэтгүүлд монгол орны тухай нийтлэл, тэмдэглэл бичин хэвлүүлж байжээ.
Энэ үеэс хоёр улсын урлагийн байгууллагуудын хамтын ажиллагаа сэргэж, харилцан айлчилж, урлаг уран сайхнаар үйлчлэн, зохиолчдынхоо зохиол бүтээлийг харилцан орчуулан хэвлэж, сонин, сэтгүүлд хэсэгчлэн болон бүтнээр нийтлүүлж, түүвэр эмхэтгэл болгон гаргах болсон байна. Мөн Халимагийн залуучууд, зураачид зочлон ирж Монгол орон, монголчуудын ахуй амьдралтай танилцах болжээ.

7. Монгол-Халимагийн харилцааны оргил үе: 1974-1990 он.

1974 онд Монгол Оросын найрамдлын нийгэмлэгийн бүрэлдэхүүнд Халимагийн салбар байгуулагдсан явдал нь хоёр талын харилцаа хөгжихөд ихээхэн үүрэг гүйцэтгэв. Энэ үеэс монгол халимагийн харилцаа олон салбарт идэвхтэй хөгжих болов. Энэ үеийн харилцааг 1. Соёлын салбарын хамтын ажиллагаа, 2. Олон нийтийг хамарсан үйл ажиллагаа, 3. Шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа, 4. Орон нутгийн хамтын ажиллагаа хэмээн хуваан үзэж болохоор байна.

1. *Соёлын салбарын хамтын ажиллагаа:*

[157] Н.Наранжаргал. Социализмын үеийн монгол-халимагийн шинжлэх ухаан, соёлын салбарын харилцаанд холбогдох зарим мэдээнүүд (1957–1989 он)// Түүхийн товчоон Ховд их сургуулийн, нийгэм хүмүүнлэгийн сургуулийн түүхийн тэнхимийн эрдэм шинжилгээний сэтгүүл. Дугаарыг эрхэлсэн Г.Пүрэвдорж. УБ., 2019. тал 204-217.

БНМАУ-аас 20 гаруй сэтгүүлчдээс бүрдсэн төлөөлөгчид Халимаг Улсад 1975, 1976, 1978 онд зочилж ирээд өдөр тутмын сонин, сэтгүүлд халимагийн тухай мэдээ, тэмдэглэл бичсэн нь монголчуудад халимагийн тухайн үеийн нөхцөл байдлын тухай мэдээллийг өгчээ.

Баримтаас үзэхэд[158] Халимагийн зураачид 1966, 1979, 1981 онуудад БНМАУ-д айлчлан хөдөө орон нутгаар явж, монголчуудын ахуй амьдралтай танилцсан багагүй бүтээл туурвижээ. Халимаг зураачид нутагтаа буцаж очоод монгол орны тухай бүтээлээрээ болон монгол зураачдын бүтээлээр удаа дараа үзэсгэлэн гаргаж байв. Тухайлбал, Халимаг улсад 1981 онд Монголын зураачдын зургийн үзэсгэлэн, 1987 онд "Монгол Улс Зөвлөлтийн зураачдын нүдээр"[159], 1988 онд Монголд очсон Халимаг зураачид өөрсдийн бүтээлээрээ "Найрамдалын замаар" нэртэй үзэсгэлэн гарган Халимагийн ард олонд монголчуудын аж байдлыг танилцуулж байлаа. Харин БНМАУ-ын зураачдаас Халимаг улсад очсон болон Халимаг зураачдын үзэсгэлэн манай улсад гарч байсан талаар тэмдэглэсэн баримт одоогоор хараахан олсонгүй.

Театр, урлагийн салбарын хамтын ажиллагаа,

Хоёр орны ард түмэн харилцан бие биеийнхээ урлаг соёлтой танилцахад онцгой үүрэг гүйцэтгэсэн хүмүүс бол театр урлагийн салбарынхан юм. Халимагийн үндэсний төв архивт хадгалагдаж байгаа баримтууд[160]-аас үзэхэд БНМАУ-аас 1971, 1980 онд Ховд аймгийн хөгжимт драмын театр, 1978 онд Нацагдоржийн нэрэмжит Монголын Үндэсний Драмын Эрдмийн Театр, 1980 онд Монголын үндэсний дуу бүжгийн чуулгын уран бүтээлчид бүрэлдэхүүнээрээ Халимагт очиж тоглосон бол, тус улсаас Манай улсад 1970 онд Тюльпан, 1979 онд "Байр", "Аранзал", 1984 онд "Хайдрис" хамтлаг, 1988 онд Б.Басанговын нэрэмжит Халимагийн үндэсний театрынхан тоглолтоо хийжээ. Эдгээр урлаг уран сайхны хамтлагууд харилцан бие биедээ зочилж, өөрсдийн тоглолтоо сонирхуулж байсан нь хоёр улсын ард түмэн нэг нэгнийхээ соёл урлагийг танин мэдэхэд ихээхэн түлхэц болов.

2. *<u>Олон нийтийг хамарсан үйл ажиллагаа,</u>*

Энэ үед хоёр орны түүх соёлын сурталчлах олон нийтийг хамарсан үйл ажиллагааг өргөнөөр явуулж байв. Энэ хүрээнд хоёр улсад харилцан түүх соёлын чиглэлийн уран сайхны болон баримтад кино гаргах, тэмдэглэлт баярын өдрүүдээр олон нийтийг хамарсан лекц унших, сонины нүүр солилцох зэрэг ажлууд хийж, 1983 онд Элиста хотод Сүхбаатарын нэрэмжит гудамжийг бий болгож, 1986 онд Элиста хотын 3-р сургууль дээр "Монгол-Халимагийн найрамдалд" зориулсан үзэсгэлэн нээгдсэн[161] байна. Энэхүү ажлын үр дүнд хоёр орны ард түмэн нэг нэгнийхээ социалист бүтээн байгуулалтаас суралцах боломжийг ч олгожээ.

[158] НА РК. Фонд Р-457, оп 1, ед хр 23. Л.11, НА РК. Фонд № П-1 оп 46, ед.хр№18 л.128

[159] НА РК. Фонд№1, оп№56, дело №28. Л.34

[160] НА РК. Фонд Р-457, оп 1, ед хр 13. Л.32, НА РК. Фонд Р-457, оп 1, ед хр 2 3. Л.14, НА РК. Фонд Р-457, оп 1, ед хр 23. Л.10, НАРК фонд Р-457, оп 1, ед-хр 16 л.6, НА РК. Фонд № П-1 оп 46, ед.хр№18 л.21-25

[161] А.Амарсананы нэрэмжит Халимагийн үндэсний төв номын сан. Хальмг үнн. сонины 1986.4.2 өдрийн дугаар

3. *Шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа,*

Монгол –Халимагийн хооронд өрнөж байсан шинжлэх ухааны чиглэлийн харилцаа нь: 1. Судлаач эрдэмтдийг урьж яриа хийлгэх, 2. Түүх соёлын судалгаа хийх, 3. ХАА-н чиглэлээр хамтран ажиллах гэсэн чиглэлээр явагдаж байв.

БНМАУ-аас Л.Жамсран, Э.Вандуй, н.Батбуян, Б.Ренчин, Ц.Дамдинсүрэн, С.Лувсанвандан, Х.Лувсанбалдан, Ч.Лувсандэндэв, Д.Цэнд, П.Хорлоо[162] зэрэг эрдэмтэд ЗХУ-ын Автономит Халимаг Улсад очиж Монголын түүх соёл, тухайн үеийн БНМАУ-ын нөхцөл байдлын талаар яриа хийж байв. Халимагийн талаас Ц-Д.Номинханов, А.И.Сусеев, Н.К. Илишкин, А.Бадмаев зэрэг судлаачид Монгол улсад явагдсан угсаатан зүйн болон хээрийн судалгааны ажил, эрдэм шинжилгээний хурлуудад оролцохын зэрэгцээ ЗХУ-ын Монгол болон Дорно дахины судлалын судалгааны ажилд идэвхтэй оролцож байв. Шинжлэх ухааны салбарын харилцаанд ХАА-н салбарын харилцаа багагүй үр дүнд хүрч байв. БНМАУ нь Халимагийн судлаачид, эрдэм шинжилгээний хүрээлэнтэй махны чиглэлийн үхэр үржүүлэх, төл мал бордох, малын тэжээл бэлтгэх, усалгаат тариалангийн ололт амжилтыг нутагшуулах зэрэг ХАА-г хэрхэн эрчимжүүлэн хөгжүүлэх чиглэлээр хамтран судалгаа хийж, туршлага хуримтлуулж байв.

4. *Орон нутгийн хамтын ажиллагаа*

Монгол халимагийн харилцаанд 1974 онд нэгэн том дэвшил гарсан нь Монгол Зөвлөлтийн найрамдлын нийгэмлэгийн бүрэлдэхүүнд Монгол Халимагийн салбар байгуулагдаж, манай улсын Өвөрхангай аймаг болон Халимагийн хооронд шефийн харилцаа тогтсон явдал юм. Ингэснээр Автономит Халимаг улс болон Өвөрхангай аймгийн нэгдэл, хамтрал, сангийн аж ахуйнууд “Төл мал бордох”, бэлчээр талбайн үржил шимийг сайжруулах, нэгдэл, сангийн аж ахуй, хамтралуудыг үр өгөөжтэй ажиллуулах зэргээр туршлага солилцон хамтран ажиллах болов. Улмаар нэгдэл аж ахуйнууд хоорондоо холбоо тогтоон хамтран ажиллажээ. Жишээ нь Приютенск районы “Дружба” хамтрал – Хужирт сумын “Энхтайван” нэгдэлтэй, Сарпинск районы “Степной” хамтрал – Богд сумын “Сүхбаатарын зам” нэгдэл, Городовиск районы “Южный” хамтрал- Хархорины сангийн аж ахуйтай, Городовиск районы “XXII партсьезд” хамтрал- Сант сумын “Мандах” нэгдэлтэй хамтран ажиллаж[163], туршлага солилцож байв.

БНМАУ-ын төр засгийн зүгээс ч Монгол-Халимагийн харилцаанд ихээхэн анхаарал хандуулж байлаа. Дурдан буй үед Москвад сууж байсан БНМАУ-ын Элчин сайдууд бүгд улсаа төлөөлөн Халимагт айлчилсан[164] нь үүний нэгэн илэрхийлэл юм.

---

[162] А.Амарсананы нэрэмжит Халимагийн үндэсний төв номын сан. Хальмг үнн. сонины 1988 оны така сарын 9

[163] НА РК. Фонд Р-457, оп 1, ед хр 19. Л.16,

[164] Н.Наранжаргал. ЗХУ-д суух Монголын элчин сайд (бүрэн эрхт төлөөлөгч) Халимагтай харилцаж байсан нь // The history and culture of oirat Mongolia (Ойрад монголын түүх, соёл): Залуу судлаачдын эрдэм шинжилгээний бичиг, Tomus XV, Fasciculus 1-19, УБ., 2024, 168х, Соёмбо принтинг ХХК. Дугаарыг эрхэлсэн Y.Мөнхдагва, Б.Солонго, Б.Мөнгөнтулга. ISBN 978-9919-9042-9-6. тал 59-72.

Энэ үед хоёр орны сонин, сэтгүүлүүдэд ард түмний аж амьдрал, нийгмийн хөгжил дэвшлийн тухай мэдээлэл байнга нийтлэн танилцуулж, зохиолчид харилцан айлчилж, тэдний зохиол бүтээлийг сонин хэвлэлд нийтлэхээс гадна зохиол бүтээлийг нь орчуулан түүвэр, эмхэтгэл болгон хэвлүүлж байлаа. Түүнээс гадна хоёр орны ард түмний найрамдал нөхөрлөлийг бэхжүүлэх үүднээс Өвөрхангай аймаг болон Халимагийн найрамдлын сарыг байнга зохион байгуулах болж, уран бүтээлийн хамтлагууд айлчлан тоглолт хийж байсан нь хоёр талын харилцаа хамтын ажиллагааны хөгжилд зохих үр өгөөжөө өгсөн байна.

8. Монгол-Халимагийн харилцаа саарсан үе: 1990-2000 он.

Социалист системийн хүрээнд 1980-аад оны сүүлээр эхэлсэн өөрчлөлт шинэчлэлийн улмаас хоёр орны улс төр, үзэл баримтлал өөрчлөгдсөн юм. Ингэснээр хоёр улсын харилцаанд өөрчлөлт гарч өргөн хүрээнд харилцахыг эрмэлзэх болов. Шинэ үеийн энэ харилцаанд 1990 онд болсон хоёр улсын төрийн тэргүүнүүдийн уулзалт онцгой түлхэц үзүүлсэн. Энэ үеийн харилцааг авч үзвэл, 1990 оноос өмнө идэвхтэй хөгжиж байсан Өвөрхангай аймаг Халимагийн хоорондох шефийн харилцаа, ХАА-н хамтын ажиллагаа зогсож, энэ салбарын төлөөлөгчд харилцан зочлоогүй байна. Гэхдээ Увс аймгаас засаг дарга болон тус аймгийн хөгжимт драмын театр нь халимагт очиж тоглох зэргээр өөр аймаг харилцах оролдлого хийсэн ч үр дүнд хүрэхгүй байна. Харин улс төр, боловсрол гэсэн харилцааны шинэ чиглэлүүд гарч тодорхой хэмжээнд хөгжиж байна.

1. *<u>Улс төрийн харилцаа:</u>*

1990 оноос хоёр улс илүү өргөн хүрээнд харилцах болсны илрэл бол төрийн тэргүүнүүд харилцан зочилсон явдал юм. 1990 оны 5-р сард Москва хотод БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн дарга П.Очирбат, ЗСБНХалимаг Улсын Дээд зөвлөлийн дарга В.М.Басанов нар уулзсан[165] нь хоёр улсын төрийн тэргүүнүүдийн анхны бие даасан уулзалт байв.

2. *<u>Боловсролын салбарын хамтын ажиллагаа:</u>*

Хоёр талын төрийн тэргүүнүүдийн уулзалтын сэдэвт болон бусад эрх бүхий хүмүүсийн хооронд хийгдсэн гэрээ, хэлэлцээрүүдийн нэг гол чиглэл нь боловсролын салбарт чиглэгдэж байв. Ингэснээр хоёр улсын харилцаанд боловсролын салбарын харилцааны чиглэл шинээр бий болсон юм.

Энэхүү харилцаа идэвхтэй хөгжихөд тухайн улсуудын их дээд сургуулиудад оюутан залуучууд суралцах явдал ихээхэн нөлөөлсөн. Тухайн улсын их дээд сургуульд оюутан сургах явдал 1989 оноос эхэлжээ. Манай улсад Халимагийн талаас анх шашны чиглэлээр 5 оюутныг Монгол Улсын Засгийн газрын тэтгэлгээр[166] 1989-1994 онд[167] сургасан.

[165] Монгол Улсын ГХЯ-ны төв архив. Хө №-2, Д№-2, хн-678, хуудас 1

[166] Монгол улсын ГХЯ-ны төв архив. Хө №-2, Д№-2, хн-701, хуудас 20

[167] История буддизма в СССР и российской федерации в 1985-1999гг. / под общ. Ред. Н.Г.Очировой (Н.В.Абаев, Э.П.Бакаева, У.П.Бичелдей, Ц.П.Ванчикова, С.Ю.Лепехов, Т.М.Садалова). Элиста: Министерство образования, культуры и науки Республики Калмыкия, 2011.-392 ё.: ил. С 81.

Халимагийн тал урлагийн чиглэлээр оюутан сургахыг чухалчлан үзэж байснаас 1995-1996 онд Улаанбаатар хотын соёлын коллежид 8 оюутан суралцан төгсжээ.

Монгол оюутнууд Халимагт суралцах нь Орост үүссэн өөрчлөлт шинэчлэлийн улмаас Зөвлөлтийн их дээд сургуулиудад суралцаж байсан оюутнууд 1989 онд Халимагийн улсын их сургуульд шилжин суралцсан[168] -аар эхэлсэн юм. Халимаг нь Москвагаас хэт хол, хөгжлийн хувьд буурай байснаас 1990-ээд онд эдгээр оюутнууд дээр нэмж оюутнууд очоогүй бололтой. Монгол Улсын Их Сургууль, Халимагийн Улсын Их Сургуулийн хооронд 1991 онд хамтран ажиллах тухай гэрээ байгуулсан[169] ч үр дүнтэй хэрэгжихгүй байв.

Боловсролын салбарын харилцааны өөр нэгэн чиглэл нь Халимагт Монгол Улсаас багш урьж ажиллуулах явдал юм. Анх Халимагийн соёлын коллежийн урилгаар үндэсний хөгжмийн багш Ч.Сампилноровыг 1990 онд, лимбийн багш М.Бадам, ятгын багш З.Нарантуяа нарыг 1993 онд урьж ажиллуулсан бол 1996-1997 онд хуучрын багш С.Цэвэлмаа, 1998 онд морин хуурын багш Ганбат, шанзын багш Отгон нар ажиллаж байжээ.

3. <u>Урлаг соёл, олон нийтийн хамтын ажиллагаа</u>

Соёл, урлагийн салбарын харилцаа нь энэ үеэс шинэ агуулга чиглэлээр хөгжих болов. Харилцаа холбооны салбарт техник технологи үсрэнгүй хөгжсөнөөр жирийн иргэдийн харилцаа зохиолч, сэтгүүлч, зураач гэх мэт мэт уран бүтээлчээр хязгаарлагдахгүй болов. Харин дээрх уран бүтээлчдийн бүтээлийн үзэсгэлэнг тус тусын улсад албан ёсоор гаргах явдал зогсонги байдалд орсон ч, цахим орчноор дамжуулан танилцах явдал илүү үр дүнтэй явагдаж байна.

Хоёр улсын соёлын харилцаанд шинээр хүүхэд залуучууд, оюутны наадам зохион байгуулах болсон нь шинэ чиглэл байв. Энэ чиглэлээр Халимагийн талаас санаачилга идэвхтэй гаргаснаар “Монгол туургатны оюутны фестиваль” ийг 1990 онд Улаанбаатарт[170], 1992 онд Улаан Үдэд, 1994 онд Элиста хотод[171], дэлхийн монгол туургатан багачуудын “Алтанбулаг” наадмыг 1994 онд Улаанбаатар хотод [172], зохион байгуулжээ.

Халимагаас 1999 онд “Эрдэм” чуулга, Монгол Улсад тоглолтоо хийсэн бол Монгол Улсаас 1990 онд Чингис хаан хамтлаг[173], Увс аймгийн хөгжимт драмын театр[174],

[168] А.Амарсанаы нэрэмжит Халимагийн үндэсний төв номын сан. Хальмг үнн. сонины 1988 оны Така сарын 9

[169] А.Амарсанаы нэрэмжит Халимагийн үндэсний төв номын сан. Хальмг үнн. сонины 1991 оны Хонь сарын 16

[170] А.Амарсанаы нэрэмжит Халимагийн үндэсний төв номын сан. Хальмг үнн. сонины 1991 оны Нохой сарын 17.

[171] А.Амарсанаы нэрэмжит Халимагийн үндэсний төв номын сан. Хальмг үнн. сонины 1994 оны 5-р сарын 19

[172] Монгол Улсын ГХЯ-ны төв архив. Хө №-2, Д№-2, хн-678, хуудас 57

[173]А.Амарсанаы нэрэмжит Халимагийн үндэсний төв номын сан. Халимаг үнэн сонины 1991 оны туулай сарын 23 дугаар .

[174] А.Амарсанаы нэрэмжит Халимагийн үндэсний төв номын сан. Халимаг үнэн сонины 1990 оны Хонь сарын 17.

Өвөрхангай аймгийн хөгжимт драмын театр, 1995 онд “Дайчин алдар” хамтлаг Халимагт очиж тоглолтоо хийв.

Социалист системийг хамран өрнөсөн өөрчлөлт шинэчлэл, ардчилсан тогтолцоонд, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих амаргүй үйл явцын улмаас 1990 оноос Монгол-Халимагийн харилцааны эрч саарч бууран зогсонги байдалд оржээ. Гэвч энэ нь хоёр талын харилцаа бүрмөсөн тасалдан зогссон гэсэн үг биш юм.

Халимагууд ОХУ-ын бүрэлдэхүүнд багтах өөрийн Халимаг Тангчийн Бүгд найрамдах улсаа байгуулж, В.М.Басанов, Б.И.Михайлов, К.Н.Илюмжинов зэрэг төр засгийн удирдагчид нь анхны гадаад айлчлалаа Монгол улсаас эхэлж байсан нь тэд Монгол улстай тогтоосон уламжлалт харилцаандаа хэр зэрэг ач холбогдол өгч байсныг илтгэнэ.

Харин Монгол улсын хувьд тухайн үеийн бодит нөхцөл байдлын улмаас уламжлалт харилцаагаа хэвийн үргэлжлүүлэх боломж алдагдаж, тэр бүр асуудалд анхаарал хандуулж чадахгүй болсны улмаас Монгол, Халимагийн олон талт харилцаа сааран суларч, зөвхөн боловсрол, соёлын хүрээнд явцуу хэмжээнд явагдах хэмжээнд хүрсэн байна.

Энэ үед төр засаг, үйлдвэр, аж ахуй, соёл урлагийн харилцаа үндсэндээ зогсонги байдалд оржээ. Гэсэн хэдий ч Монголоос 10-аад оюутан Халимагийн Улсын Их Сургуульд суралцаж, монгол туургатны хүүхэд, оюутан залуучуудын урлаг соёлын наадамд төлөөлөгчдөө оролцуулах зэргээр хязгаарлагдмал боловч харилцаа үргэлжилсээр байв.

<u>9. Монгол-Халимагийн харилцааны дахин сэргэлтийн үе: 2000 оноос одоо хүртэл.</u>

1990-ээд оны өөрчлөлт шинэчлэлийн улмаас зогсонги байдалд ороод байсан хоср улсын харилцаа 2000 оноос сэргэж эхэлсэн юм.

1. *<u>Улс төрийн харилцаа:</u>*

Халимагийн талаас Засгийн газрын дарга В.Б.Сенглеев 2008 онд, Төрийн тэргүүн К.Н.Илюмжинов 2009 онд манай улсад ажлын айлчлал хийсэн бол Монгол улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр 2006 онд, Ц.Элбэгдорж 2011 онд Халимагт зочилсон юм.

Эдгээр төр засгийн тэргүүнүүдийн айлчлалын үр дүнд 2008 онд Элиста хотод Монгол Улсын консулын төлөөлөгчийн газар байгуулагдаж, 2009 оны 2 сарын 2-нд Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техник, соёлын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын гадаад харилцааны яам, Бүгд Найрамдах Халимаг Улс (Оросын Холбооны Улс)-ын Засгийн газар хоорондын санамж бичиг[175], 2009 оны 5 сард ОХУ-ын Бүгд Найрамдах Халимаг Улсын Засгийн газар Монгол Улсын ХХААХҮЯамны хооронд Монголын нутаг дэвсгэр дээр мах боловсруулах цогцолбор байгуулах тухай протокол[176], 2010 оны 7-р сарын 21-нд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот болон Халимаг Улсын Элиста

[175] Монгол – Оросын харилцаа: баримт бичгүүд 2005-2020. Эмхэтгэсэн Д.Туул, Редактор О.Батсайхан. УБ., 2020, тал 68-69.

[176] Монгол – Оросын харилцаа: баримт бичгүүд 2005-2020. Эмхэтгэсэн Д.Туул, Редактор О.Батсайхан. УБ., 2020, тал 73.

хотын хооронд ах дүү хотуудын харилцаа тогтоох гэрээ[177], 2015 оны 5 сарын 8-нд Халимаг Улсын (ОХУ) Элиста хотын иргэдийн хурал болон Улаанбаатар хотын (Монгол Улс) Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хоорондын хамтран ажиллах тухай санамж бичигт[178] гарын үсэг зурж, 2016-2020 онд Монгол Улсын Их Хурал дахь "Монгол-халимагийн парламентын бүлэг" байгуулагдсан ч төдийлөн үр дүн гарахгүй байна.

2. *Боловсролын салбарын хамтын ажиллагаа:*

Хоёр талын төрийн тэргүүнүүдийн уулзалтын сэдэвт болон бусад эрх бүхий хүмүүсийн хооронд хийгдсэн гэрээ, хэлэлцээрүүдийн нэг гол чиглэл нь боловсролын салбарт чиглэгдэж байв. Ингэснээр хоёр улсын харилцаанд боловсролын салбарын харилцааны чиглэл шинээр бий болсон юм.

Улаанбаатар хотын соёлын коллежид 8 оюутан, 2005 онд 9 оюутан, 2007 онд 3 оюутан, МУИС-ийн Япон хэлний ангийг 1 оюутан, 2022 онд СУИС-ийг 1 оюутан тус тус суралцан төгсжээ.

Монгол оюутнууд Халимагт суралцах нь Харин 2000 он гарснаар улс орны эдийн засаг хөгжин, дэд бүтэц сайжирч, Их дээд сургуулиуд өмнөх гэрээгээ шинэчлэн байгуулснаар Монголчууд Халимагт очих, суралцах, Халимагууд Монголд ирж суралцах болов. Тухайлбал, 2001 оны хичээлийн жилээс Халимагийн Улсын Их Сургуульд Монгол Улсын 13 оюутан суралцаж эхэлсэн. Эдгээр оюутнуудаас 2006 онд 5 оюутан төгсжээ. 2006 оноос МУИС-ийн орос хэлний ангийн оюутнууд Халимагийн Улсын их сургуульд, Халимагийн Улсын Их сургуулийн дорно дахин судлалын оюутнууд МУИС ирж хэлний дадлага хийх болов. Ийнхүү хоёр их сургууль харилцан оюутан солилцож дадлага хийлгэх явдал 2015 он хүртэл идэвхтэй хөгжөөд идэвх нь саарч байна.

Манай хоёр улсын хооронд оюутан солилцох явдал идэвхжихгүй байгаа нь Монгол Улс болон Халимаг Улс хоорондоо хэт хол, улс орны хөгжлийн түвшин зэргээс хамаарахаас гадна манай улсын гадаад оюутнуудад олгодог сургалтын тэтгэлэг нь маш бага байгаа нь суралцагчдын тоо буурахад гол нөлөө үзүүлж байна. Өөрөөр хэлбэл өмнө нь угсаа гарал, хэл, соёл нэгтэй гэдгээр бие биендээ очиж суралцаж байсан бол одоо өндөр тэтгэлэгтэй улсуудын их дээд сургуулиудад суралцахыг чухалчлан үзэх боллоо. Хоёр улсын их дээд сургуулийн хэлний салбарын оюутнууд харилцан дадлага хийх нь зогссон нь мөн л бие биеэсээ хэт алслагдсан, оюутнууд замынхаа зардлыг хувиасаа гаргадаг нь зэрэг нь санхүүгийн хүндрэл учруулах болсон нь нөлөөлжээ.

2022 оны хоёрдугаар сард үүссэн нөхцөл байдлын улмаас цөөн тооны халимаг залуучууд Монгол Улсад дүрвэн ирж, их дээд сургуулийн хэлний бэлтгэлд суралцах гэдэг нэрийдлээр виз авч оршин суух болов. Тэдний гол зорилго нь суралцах бус суралцах визээр оршин суухад байгаа тул хэчнээн хүн ямар сургуульд суралцаж байгааг нь тогтооход хүндрэлтэй байна.

[177] Монгол – Оросын харилцаа: баримт бичгүүд 2005-2020. Эмхэтгэсэн Д.Туул, Редактор О.Батсайхан. УБ., 2020, тал 402.

[178] Монгол – Оросын харилцаа: баримт бичгүүд 2005-2020. Эмхэтгэсэн Д.Туул, Редактор О.Батсайхан. УБ., 2020, тал 414.

Мөн Монгол судлалын хүрээлэнгээс жил бүрийн зун Монгол Улсад зохион байгуулдаг “Залуу монголч эрдэмтдийн зуны сургууль”-д Халимагийн оюутан, залуу судлаачид тасралтгүй оролцсоор байна.

3. *Урлаг соёл, олон нийтийн хамтын ажиллагаа*

Хоёр талын хамтлаг, чуулгууд харилцан айлчлан тоглолт хийж, олон нийтийг хамарсан арга хэмжээ, төслүүд хэрэгжих болов. Тухайлбал, Монгол туургатан бөхийн наадмыг 2009 онд Элиста хотод зохион байгуулжээ. Халимагаас 2014 онд Халимагийн нэрт дуучин Аркадий Манджиев нар Монгол Улсад тоглолтоо хийсэн бол Монгол Улсаас 2010 онд Морин хуурын чуулга Халимагт очиж тоглолтоо хийв.

Сүүлийн жилүүдэд соёлын салбарт хамтарсан төслүүд амжилттай хэрэгжиж, шинэ чиг хандлагыг бий болгож байна. Эдгээрээс хамгийн үр дүнтэй төслүүдийн нэг нь МУГЖ С.Жавхлангийн санаачилсан "Хамаг Монгол" төсөл юм. Энэхүү төсөлд Халимагийн уран бүтээлчид болох Дима Шараев, Лидже Гаряев, Гиляна Бембаев, Фелекс Шарваев нарын залуу дуучид нэгдэж, 2013 онд Халимагийн нийслэл Элиста хотноо тоглолтоо амжилттай зохион байгуулсан.

Үүнтэй зэрэгцэн идэвхтэй үргэлжилж буй соёлын өөр нэгэн чухал арга хэмжээ бол "Ойрад түмэн" язгуур урлагийн наадам юм. Энэхүү наадам 2005 оноос хойш зохион байгуулагдаж байгаа бөгөөд 2014 оноос эхлэн Халимагийн төлөөлөгчид тогтмол оролцох болжээ. Харин 2018 онд тус наадмыг Халимаг Улсад амжилттай зохион байгуулсан юм.

Эдгээр арга хэмжээний үр дүнд хоёр орны ард түмэн бие биеийнхээ дуу хуур, соёлтой танилцан, харилцан суралцах нь нэмэгдэж байна. Тухайлбал, Халимагийн нэрт жангар ч Цагаанзам (Владмир Каруев) 2000 оны эхээр Монгол Улсад “Ээж минь” дууныхаа клипийг хийж монголын сонсогчдод хүргэсэн нь олон түмний таашаалд хүрсэн бөгөөд 2021-нд түүнийг Монгол тулгатны 100 эрхэм нэвтрүүлэгт урин оролцуулсан байдаг.

Монгол Улсын дуучдаас С.Жавхлан “Насандаан чамдаа дуртав”, “Төрөлүмүүд минь”, Анхбаяр, Чанцалням нар “Цагаан сар” зэрэг халимаг дуу дуулж олон түмэнд өргөн барьж байв. Мөн халимагийн дуучин Гиляна Бямбаевын “Шарка Барка” дууны бүжиг, 2021 оны үеэс монгол төдийгүй, монгол туургатнууд дунд идэвхтэй дэлгэрсэн билээ.

Соёлын салбар дахь хамтын ажиллагааны дараагийн нэгэн томоохон амжилт бол 2019, 2021 оны Ардын хувьсгалын баяр наадам-ын нээлтийн ёслолд Халимагийн дуу, бүжгийг толилуулсан явдал байлаа. Мөн 2022, 2023 оны Улсын баяр наадам-д Халимагийн бөхчүүд хүрэлцэн ирж, зодоглон барилдсан нь монгол туургатны эв нэгдлийг улам бататгасан үйл явдал болсон юм.

4. *Шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа*

Сүүлийн жилүүдэд энэ чиглэлийн харилцаанд өөрчлөлт гарч, шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн хамтын ажиллагаа зогсонги байдалд оржээ. Одоогоор зөвхөн хэл шинжлэлийн салбарын хамтын ажиллагаа тасралтгүй үргэлжилж байна.

Өмнө нь идэвхтэй хөгжиж байсан Хөдөө аж ахуйн хүрээлэнгийн үйл ажиллагаа зогсож, энэ чиглэлийн харилцааг хувийн фермүүд болон бизнес эрхлэгчид үргэлжлүүлэхийг хичээж байна. Харин түүх, соёл, хэл бичгийн салбарт "Тод номын гэрэл" төв зэрэг

төрийн бус байгууллагууд идэвхтэй үйл ажиллагаа явуулж, судалгаа, соёлын солилцоог дэмжсээр байна.

Хүрээлэнгүүдийн албан ёсны хамтын ажиллагаа саарсан хэдий ч хоёр орны эрдэмтэн, судлаачид өөрсдийн судалгааны чиглэлээр эрдэм шинжилгээний хурлуудад оролцож, судалгааны экспедиц зохион байгуулсаар байгаа нь шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа бүрэн тасраагүйг илтгэж байна.

Шинэ зуун, шинэ мянганы эхнээс Монгол-Халимагийн харилцаа дахин сэргэж эхэлжээ. Хоёр улсын Ерөнхийлөгч нар удаа дараа харилцан айлчилж, төр, засгийн түвшинд албан ёсны харилцаа сэргэсэн байна. Гэвч дээд түвшинд яригдсан санал зөвлөмжүүд өнөөдрийг хүртэл ажил хэрэг болж чадахгүй байгаа, энэ талаар тодорхой шийдвэртэй үйл ажиллагаа явуулахгүй байгааг тэмдэглэх хэрэгтэй. Харин хувь хүмүүс, төрийн бус байгууллагууд төр, засгийн шууд оролцоогүйгээр бие даан соёл, урлаг, эрдэм шинжилгээний салбарт хамтран ажиллах явдал энэ үеэс ихээхэн идэвхэжжээ. Тэрчлэн жирийн ард иргэд ч харилцан зочлох нь нэмэгдэж, их сургуулиуд оюутнаа харилцан солилцох явдал нэмэгдэж байна.

Дүгнэлт, санал

Угсаа гарал, хэл соёл, шашин шүтлэг нэгтэй Монгол, Халимагийн харилцааг 9 үед хуваан авч үзэж болохоор байна.

Энэхүү харилцаа 1900 оны эхэн хүртэл шашны хүрээнд, 1945 он хүртэл цэрэг, нам олон нийтийн хүрээнд идэвхтэй явагдаж байгаад халимагууд сибирьт цөлөгдсөнөөр тасалджээ. Халимагууд цөллөгөөс буцан ирж халимагийн автономит улс байгуулагдсанаар энэ харилцаа дахин сэргэж 1990 он хүртэл соёл урлаг, нам олон нийтийн харилцаа идэвхтэй хөгжиж эхэлжээ. Энэ үеийн харилцаанд Монгол Халимагийн найрамдлын нийгэмлэг байгуулагдаж, Халимаг болон Өвөрхангай аймгийн хооронд шифийн харилцаа тогтсон нь томоохон үүрэг гүйцэтгэсэн юм.

1990-ээд оноос өмнөх үеийн Монгол Халимагийн харилцаанд соёл урлаг утга зохиол, шинжлэх ухаан хүрээнд идэвхтэй өрнөж байснаас гадна, БНМАУ-ын Өвөрхангай аймагтай идэвхтэй харилцаж байв. Энэ үеийн харилцааны эхлэлийг зохиолчид тавьсан бөгөөд уран бүтээлчид өөрсдийн бүтээл туурвилаараа ах дүү орнуудын тухайн үеийн байдал, ололт амжилтыг хоёр орны ард иргэдэд сурталчлан таниулж байжээ. Шинжлэх ухааны хүрээнд түүх соёлын судалгааг хамтран хийхээс гадна шинжлэх ухааны тэргүүн туршлагыг нэвтрүүлэх тал дээр хамтран ажиллажээ. Тухайн үеийн харилцаан нь дээрээс доошоо буюу нам засгийн шийдвэр зааврын дагуу явагдаж байв.

1990 - ээд оноос өмнө үеийн орон нутаг, театр урлагийн харилцааны идэвх саарсан ч улс төр, боловсролын харилцааны шинэ чиглэл бий болж, соёлын салбарын харилцаа илүү идэвхтэй хэрэгжиж байна. Энэ үеийн харилцаа нь ямар нэгэн нам, төрийн институтийн зөвшөөрөөгөөр бус нийгмийн хөгжлийн хэрэгцээ шаардлагаар буюу хувь хүмүүс, уран бүтээлчдийн үйл ажиллагааны санаачилга, хэрэгцээнд тулгуурлан доороосоо дээшээ хөгжиж байна.

1990 оноос өмнөх үеийн харилцаанд БНМАУ-ын зүгээс социализмын хөгжлийн арга туршлагаас суралцах үүднээс илүү идэвхтэй харилцаж байсан бол 1990 оноос хойш

Халимаг улсын зүгээс Монгол угсаатны соёл, урлагаас суралцах үүднээс идэвхтэй оролцож байна. Одоо үед боловсролын салбарын харилцааны идэвх буурч байгаа бол соёлын салбарын харилцаа идэвхжиж байна. Хоёр улсын төрийн тэргүүнүүд харилцан зочилсон явдал багагүй үр дүнг авч ирсэн.

Монгол болон Халимагт аль алинд нь харилцаагаа цаашид хөгжүүлэх хэрэгцээ шаардлага байна. Халимагууд хэл, соёлоо сэргээхэд Монголын дэмжлэг чухал гэж үзэн, боловсрол, татварын хөнгөлөлт, давхар иргэншил хүсэж, уламжлалт аж ахуйгаа хөгжүүлэхийг эрмэлзэж байна. Мөн спорт, шашны чиглэлээр хамтран ажиллах сонирхолтой. Монгол Улсын хувьд Халимаг Улстай харилцах нь геополитик, эдийн засгийн ач холбогдолтой. Хоёр улсын хооронд монголын бараа бүтээгдэхүүний эрэлт, хурдан морины үүлдэр сайжруулалт, эрчимжсэн мал аж ахуйн хамтын ажиллагаа өргөжих боломжтой. Тиймээс соёл, боловсролын төв байгуулах, шашны аялал жуулчлалыг хөгжүүлэх, халимаг судлалыг дэмжих, хамтын гэрээ, санамж бичгийг бодит ажил болгох, татварын хөнгөлөлт, визийн уян хатан нөхцөл бүрдүүлэх шаардлагатай.

Өнөөгийн харилцаанд зарим нэгт алдарт нэртэй хүмүүс дээр тулгуурласан ардын дипломатын харилцааны хэлбэр шинээр хөгжиж байна. Мөн техник технологи, цахим харилцаа хөгжсөн нь хоёр талын харилцаанд нөлөөлж зарим эерэг өөрчлөлтүүдийг авч ирж байна.

Ашигласан материал

1. НА РК. Ф. И-9. Оп.5.д. 2670, Д.1477.
2. НА РК. Фонд 1, оп№56, дело №28.
3. НА РК. Фонд П-1 оп 46, ед.хр№18
4. НАРК фонд Р-282, оп 1, ед-хр 25, 111
5. НА РК. Фонд Р-308, оп1, ед 2177,
6. НА РК. Ф.Р-309. Оп. 1. Хр 2473.
7. НА РК. Фонд Р-457, оп 1, ед, хр7, 13, 16, 19, 23
8. МУ ГХЯ-ны төв архив. х 2, д 2, хн-678, 701, 704.

9. Алексеева. П.Э. О людях и времени. Элиста., 2010 стр.106
10. Бадмаев А.В. Сарин герл: хальмг литературин дурсхлмуд (XIII-XX зун жилмүдин эклц) Элиста: Калм.кн.изд-во. 1991 -234 с. с.207
11. Баттогтох С. Монголын алдарт тагнуулч Н.Хаянхирваагаас Оросын “Улаан империализм”-тай хийсэн тэмцлийн оргил үе. “Өнөөдөр” сонин. 06.01 № 126, 06.04 №128, 06.05 № 129 дугааруудад цувралаар гарав.
12. БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл I боть. Эмхэтгэсэн Д.Нямаа. УБ., 1964, тал 56-57.
13. БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл II боть. Эмхэтгэсэн Д.Нямаа. УБ., 1966, тал 74-77.
14. БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл V боть. Эмхэтгэсэн Д.Дүгзиймаа, М.Арслан. УБ., 1980, тал 29-31.
15. Буддизм в Калмыкии. Бакаева Э.П. Элиста. 1994. -128 с.: стр 43
16. Буддийская традиция в Калмыкии в XX веке: памяти О.М.Дорджиева (Тугмюд-гавджи). 1887-1980. Элиста: КИГИ РАН, 2008,-190с.:ил. +вкл.(1с). стр 6.
17. История буддизма в СССР и российской федерации в 1985-1999гг. / под общ. Ред. Н.Г.Очировой (Н.В.Абаев, Э.П.Бакаева, У.П.Бичелдей, Ц.П.Ванчикова, С.Ю.Лепехов, Т.М.Садалова). Элиста: Министерство образования, культуры и науки Республики Калмыкия, 2011.-392 ё.: ил. С 81.
18. История калмыкии с древнейших времен до наших дней. В трех томах. Том 3. – Элиста: И 907 ГУ “ издательский дом «Герел», 2009. –Т.3. -752с.: ил .Редакторы В.Л.Теленгидова, А.В.Задорожная. стр 255.
19. Наранжаргал Н. Социализмын үеийн монгол-халимагийн урлаг, соёлыг салбарын харилцаанд холбогдох зарим мэдээнүүд (1957-1989 он) // Түүхийн товчоон. УБ., 2019, т. 204-217.
20. Наранжаргал Н. Б.Б.Городовиковын БНМАУ-д 1966, 1977 онуудад хийсэн айлчлалыг тодруулах нь // VI Международном научном форуме «Сетевое востоковедение», в Калмыкий город Элиста, 26-27 октября 2023 года. стр . 390-399.
21. Наранжаргал Н. ЗХУ-д суух Монголын элчин сайд (бүрэн эрхт төлөөлөгч) Халимагтай харилцаж байсан нь // The history and culture of oirat Mongolia (Ойрад монголын түүх, соёл): Залуу судлаачдын эрдэм шинжилгээний бичиг, Tomus XV, Fasciculus 1-19, УБ., 2024, 168х,

22. Наранжаргал Н. 1921 оны хувьсгалын үед монголд байсан халимагуудын нэр, тоог тодруулах нь (= Уточнение имен и численности калмыков, проживавших в Монголии во время революции 1921 года) // Бюллетень Калмыцкого научного центра РАН. 2021. № 2. -с. 19-41. DOI: 10.22162/2587-6503-2021-2-18-19-41
23. Наранжаргал Н. Калмыцко-монгольские отношения (1925-1943 гг.) // ВЕСТНИК Калмыцкого института гуманитарных исследований РАН. № 5, 2016г.: Элиста: Федральное государственное бюджетное учреждение науки Калмыцкий институт гуманитарных исследований Российской академии наук, 2016. –с40-44.
24. Наранжаргал Н. Монголын 1921 оны хувьсгалд оролцсон Халимаг сургагчдын намтрын судалгаа. // Bibliotheca oiratica-biography serica-XVII. Ред. На.Сүхбаатар.Улаанбаатар. 2021, -120х,
25. Наранжаргал Н. Сибирт цөлөгдсөн халимагууд. Редактор Д.Золбоо. Улаанбаатар, Тотопресс. 2024, -182х
26. Наранжаргал Н. Халимаг дахь өлсгөлөн ба Халимагуудыг монгол улсад нүүлгэн шилжүүлэх гэсэн асуудлын тухай (О голоде в Поволжье в1920-х гг. и вопросе о преслении калмыков в Монголию) // ВЕСТНИК Калмыцкого института гуманитарных исследований РАН. №3, 2014г.: Элиста: Федральное государственное бюджетное учреждение науки Калмыцкий институт гуманитарных исследований Российской академии наук, 2014. –с50-57.
27. Наранжаргал Н. Халх голын дайнд оролцсон халимаг дайчид (= О калмыцких военных — участниках событий на Халхин-Голе) // Magna adsurgit: historia studiorum. 2020, №1, стр 96-103.
28. Монгол – Оросын харилцаа: баримт бичгүүд 2005-2020. Эмхэтгэсэн Д.Туул, Редактор О.Батсайхан. УБ., 2020, тал 414.
29. Позднеев А.М. Монголия и монголы. Т.1. стр. 563-564
30. Сарин герл. Хальмг литературин дурсхлмуд (XIII-XX зун жилмүдин эклц). Орчулснь Бадмин Андрей. Элиста., 1991. Стр. 204
31. Ульянов Д. Предсказан
32. Халимагийн хүмүүнлэгийн судалгааны хүрээлэнгийн номын сан. Тээгийн гэрэл сэтгүүл. 1964 оны №4. тал 22.
33. Халимагийн хүмүүнлэгийн судалгааны хүрээлэнгийн номын сан. Тээгийн гэрэл сэтгүүл. 1980 оны №1. Тал 119-123
34. А.Амарсананы нэрэмжит Халимагийн үндэсний төв номын сан. Хальмг үнн. сонины 1962. 02.03, 1966.06.22, 1967.07.09, 1968.11.26, 1969.07.11, 1970.09.17, 1971.06.29, 1974.01.03, 1975.7.7, 1978.11.01, 1979.10.27, 1981.07.11, 1984.10.30, 1985.7.12, 1986.4.2, 1988 могой сарын 3 өдрийн дугаар , 1989. Могой сарын 4, 1990 оны Могай сарын 20, 1991 оны туулай сарын 23, 1994 оны 5-р сарын 19, 1998 оны Үхэр сарын 26

SPSIRPA FORUM 2025

Session 5-2

Russia-Ukraine War Effect on Cultural Issues

ОХУ, УКРАИНЫ ДАЙН СОЁЛ, УРЛАГИЙН САЛБАРТ НӨЛӨӨЛСӨН НЬ

Б.Мөнхцэцэг,

ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн

Орос Судлалын салбарын эрдэм шинжилгээний ажилтан

Абстракт

Российско-украинская война оказывает влияние не только в политической и военной сферах, но и в области культуры и искусства. В данном исследовании анализируются изменения, произошедшие в культурно-художественном пространстве, и выделяются три основные направления: символика российской агрессии против Украины, пропаганда в сфере искусства и новые языковые явления, возникшие в результате войны.

Одним из символов российской агрессии стало использование латинских букв Z, V, O, которые превратились в инструмент пропаганды военной операции и приобрели политико-символическое значение. Параллельно с этим усилилось использование искусства как инструмента идеологической борьбы: в России распространяются патриотические произведения, а на украинской стороне активно заявляют о своей позиции художники, выступающие против войны. Кроме того, в ходе вооруженного конфликта в язык и культуру активно внедряются новые термины и выражения, оказывая значительное влияние на общественное сознание.

Результаты исследования показывают, что война и конфликт не ограничиваются лишь политикой и экономикой, но также оказывают мощное воздействие на сферу культуры и искусства, превращая её в арену идеологического противостояния.

Оршил

Орчин үеийн олон улсын харилцаанд дайн болон зөрчилдөөн нь “уламжлалт хүч”-ний арга хэрэгслээс халин улам бүр нарийн, олон талт шинжтэй болж “уламжлалт бус хүч” буюу цэргийн үйл ажиллагааг төдийгүй мэдээллийн урсгал, нийгмийн сэтгэл зүй, соёл, урлаг, үзэл суртлын ухуулга зэргийг хамрах болжээ. Энэ хүрээнд олон улсын харилцааны шинжлэх ухаанд “гибрид дайн”, “зөөлөн дайн” гэх зэрэг шинэ ойлголтууд гарч ирсэн. “Зөөлөн дайн” нь зэвсэгт мөргөлдөөнөөс гадна, соёл, урлаг, мэдээлэл, хууль эрх зүй, эдийн засаг зэрэг хүчин зүйлсийг ашиглан нөлөөлөх стратегийн хэлбэрийг тодорхойлдог ба АНУ-ын Харвардын Их Сургуулийн эрдэмтэн Жозеф Найн тодорхойлсон “зөөлөн хүч”-ний ойлголтоос улбаатай юм. гаргасан **“Bound to Lead: The Changing Nature of American Power”** (Манлайлахуй: Америкийн хүчний мөн чанарын хувьсал) бүтээлдээ “зөөлөн хүч”-ний ойлголтыг “аливаа улс өрсөлдөгч улсыг соёл, үзэл санаа, үнэт зүйлээрээ татах замаар нөлөөлөх явдал” хэмээн анхлан томьёолсон.

Түүнээс хойш 2000-аад оны эхээр Иран Улсын удирдагч асан Али Хаменеи барууны орнуудын соёл, үзэл суртлын нөлөөнд автахаас сэргийлэх зорилготой “зөөлөн дайн” хэмээх ойлголтыг шинээр гаргаж иржээ. Түүний тодорхойлсноор, “зөөлөн дайн” бол Иран улс болон Барууны улс орнуудын хооронд үүссэн үзэл суртал, соёлын өрсөлдөөн бөгөөд энэ нь шууд цэргийн мөргөлдөөнөөс илүүтэйгээр соёлын, улс төрийн нөлөөгөөр өрнөдөг байна. Уг тодорхойлолтыг цааш олон судлаачид баяжуулан өөрсдийн судалгааны бүтээлүүддээ хэрэглэх болжээ. Тухайлбал, Майкл Гросс болон Тамар Мейселс нар 2017 онд гаргасан “Soft War: The Ethics of Unarmed Conflict” (Зөөлөн дайн: Зэвсэггүй мөргөлдөөний ёс зүй) бүтээлдээ "зөөлөн дайн"-ыг эдийн засгийн хориг, суртал ухуулга, соёл урлаг зэрэг хүчирхийллийн бус олон талт арга хэмжээг багтаадаг хэмээн тодорхойлжээ. ОХУ-Украины дайны хувьд, тус дайн нь зөвхөн цэргийн үйл ажиллагаагаар хязгаарлагдахаас гадна, соёлын үзэл суртал, улс төрийн зөрчилд суурилсан өрсөлдөөн болж хувирсан.

Украин улс өөрийн үндэсний соёлыг сэргээх, орчин үеийн нийгэмд дахин хөгжүүлэхэд чиглэсэн стратеги баримталж байгаа бол, ОХУ өөрийн соёлын нөлөөг хадгалах замаар эдийн засаг, улс төрийн нөлөөгөө өргөжүүлэхийг зорьж байна. Энэ өрсөлдөөн нь зөвхөн мэдээллийн болон дотоод улс төрийн шинжтэй биш, олон улсын хэмжээнд үзэл суртал, соёлын хэм хэмжээг тогтоох, олон улсын зүгээс өөртөө дэмжлэг татах үйл явцтай холбогдож буй юм.

2022 оны хоёрдугаар сарын 24-ний өдрөөс эхэлсэн Орос, Украины мөргөлдөөн хоёр орны хүн ам, хөдөлмөрийн нөөц зэрэг эдийн засагт ихээхэн хохирол учруулсан төдийгүй соёл, нийгмийн салбарт ихээхэн өөрчлөлтийг авчирсан юм.

Аливаа дайн техникийн хөгжилд нөлөөлсөн тохиолдол олон бий. Цэргийн зориулалтаар бүтээсэн технологийг энхийн цагт иргэний зориулалтаар ашиглаж байгаа тохиолдол багагүй бөгөөд тухайлбал 1935 онд Робертс Уотсон Уоттын бүтээсэн радарыг Дэлхийн 2-р дайнд өргөнөөр ашиглаж байсан бол хожим 1945 онд Америкийн эрдэмтэн Перси Спенсер радарыг тэжээгч магнетронтой холбоотой сонирхолтой нээлт хийснээр, бичил долгионы зуухыг, бүтээж байв. Үүний зэрэгцээ дайн, мөргөлдөөн бол хүн төрөлхтний оюун санааны баялгын үндсэн эх ундарга гэж үзэх судлаачид ч бий. Тухайлбал дайн судлалд ихээхэн хувь нэмэр оруулсан Францын социологч Гастон Бутуль “дайн бол утга зохиолын эх, учир нь гагцхүү дайн л эхэн үеийн баатарлаг яруу найраг, тухайлсан сэдвийг тусгасан ардын дуу төрөхөд нөлөөлсөн. Дайн бол аливаа лиризмийн /утга уянгын урсгал/ эх үүсвэр. Энх тайвны тухайд гэвэл тэр бидэнд алдар нэр өгдөггүй ядуу төрөл садан шиг л байдаг ” хэмээн өгүүлж байв.

Түүний хэлсэнчлэн, Аугаа их эх орны дайн Зөвлөлтийн нийгэм, утга зохиол, урлагт бүхэлдээ нөлөө үзүүлж, баатарлаг дуу шүлэг, эх оронч сэдэвт кино одоо хүртэл олноор, ар араасаа мэндэлсээр байна. Харин өнөөгийн мөргөлдөөний хувьд үйл явдал хараахан дуусаагүй, ид өрнөж байгаа, дээр нь ОХУ мөргөлдөөн өдөөгчийн хувиар аливаа баатарлаг сэдэвт бүтээл туурвих цаг хугацаа бүрдээгүй гэж хэлж болно.

Энэ мөргөлдөөний улмаас ОХУ-ын урлаг соёлын гадаад хамтын ажиллагааны хүрээ хумигдаж, ихээхэн хязгаарлагдмал байдалд ороод байна. ОХУ “дайн өдөөгч”-ийн

хувиар дэлхий дахинаа шүүмжлэлийн бай болж, ОХУ-ын эрх баригчдад шахалт дарамт үзүүлэх зорилгоор зөвхөн эдийн засгийн хориг төдийгүй урлаг соёлын салбарыг чиглэсэн хоригууд ч үйлчилж эхэлсэн.

ОХУ-ын уран бүтээлчид хилийн чанадад тэмцээн уралдаан, үзэсгэлэн, тоглолтод оролцох боломжгүй болсон бол барууны зарим орнууд Оросын эртний сонгодог бүтээлүүдээс татгалзаж эхлэх зэргээр "cancel culture" буюу татгалзах соёлын давалгаа хүчтэй түрэн орж ирсэн юм.

"Гибрид дайн"-аас ялгаатай нь "зөөлөн дайн" нь хүч үл хэрэглэн бусдаар өөрийн үзэл санаа, соёлыг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын харилцаанд нөлөөлөхөд чиглэдэг агуулгатай тул энэхүү илтгэлийн судлагдахуунд үндэслэн "зөөлөн дайн"-ы ойлголтод хамааруулан авч үзсэн болно.

Соёлын бүрэлдэхүүн хэсэг болох хэл, урлаг, утга зохиолд энэ хугацаанд ямар өөрчлөлт гарсан талаар энэ илтгэлд авч үзэхийг зорилоо.

Аргазүй

Судалгаа хийхийн тулд мөргөлдөөн эхэлснээс хойш ОХУ-ын соёл урлагийн салбарт гарсан үйл явдлын мэдээ, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээлэлд анализ хийх, мэдээлэл цуглуулах, боловсруулах арга ашиглалаа.

Агуулга

Нийгэм соёлд гарсан өөрчлөлтүүдийг

1. Украин руу халдсан ОХУ-ын түрэмгийллийн бэлгэдлүүд
2. Урлагаар дамжсан суртал ухуулга
3. Хэлэнд нэвтэрсэн шинэ үг хэллэг гэж ангилан авч үзлээ

Хэл соёлд гарсан өөрчлөлтүүдийг авч үзэхдээ нэн тэргүүнд Оросын "цэргийн тусгай ажиллагаа" гэж нэрлэгдсэн халдан довтлолтын бэлгэдэл, суртал ухуулгын хэрэгсэл болсон үг, үсгээс эхлэх нь зүйтэй гэж үзлээ.

1. Украин руу халдсан Оросын түрэмгийллийн бэлгэдлүүд

ОХУ Украины нутаг руу түрэмгийлж, дайн дэгдээсний дараа хэвлэл болон олон нийтийн дунд Z, Y, O гэсэн латин үсэгнүүд Оросын түрэмгийллийн бэлгэдэл болсон юм.

Эдгээр нь Оросын цэргийн техник болон дайныг дэмжсэн суртал ухуулга хийхэд ихээхэн ашиглаж байна.

Мөргөлдөөн эхлэхээс долоо хоногийн өмнө хэвлэлүүдээр Оросын техник дээр «Z», «V», «O», «X», «A» гэсэн латин үсэгнүүд бичсэн талаарх анхны мэдээлэл гарч байлаа[179]. Ийм үсэг бичих болсон нь өөрийн талаас галд өртөхөөс зайлсхийх зурвас эсвэл западный

[179] BBC.Переброска войск, поставки оружия и эвакуация из посольств. Как развивается "украинский кризис". 2022.01.24// https://www.bbc.com/russian/news-60077654

восточный зэрэг цэргийн тойрог эсвэл довтлох бүсийг илэрхийлж байгаа гэж судлаачид үзэж байна. Оросын Батлан хамгаалах яам энэ тэмдэгтүүдийг тусгай утга агуулаагүй гэж мэдэгдэж байлаа.

2022 оны хоёрдугаар сарын сүүл, гуравдугаар сарын эхээр «Z» болон «V» үсгүүдийг Оросын түрэмгийллийг дэмжихэд ихээхэн ашиглах болсон. Оросын эрх баригчид Z флешмобыг ивээн тэтгэж, ийм тэмдэгтийг хүмүүс хувцас, барилга, тээврийн хэрэгсэл дээр нааж хэрэглэж эхэлсэн бол энэ үсгийг ашиглахыг эсэргүүцэж байсан хүмүүсийн эсрэг эрүүгийн хэрэг үүсгэж байлаа. 2023 оны эхээр Z, V бэлгэдлүүдийг ашиглах хүрээ хумигдаж, дайныг дэмжигч радикал үзэлтнүүд л ашиглах болсон бол оны сүүлээр Украинд дайтаж буй эр нөхөр төрөл төрөгсдөө буцаан авчрахыг шаардсан эмэгтэйчүүд флешмобдоо энэ үсгийг ашиглаж байв.

Латин үсгийг суртал ухуулгад ашиглах болсон шалтгаан

Орос, Украины хилийн орчимд ОХУ-ын цэргийн техникүүд олноор байршсан талаарх мэдээлэл 2022 оны нэгдүгээр сараас эхлээд гарч эхэлсэн. Хоёрдугаар сарын 19-ны өдөр буюу түрэмгийлэл эхлэхээс тав хоногийн өмнө танк болон цэргийн машинууд дээр “Зет” үсгийг будгаар бичсэн байгаа талаарх мэдээлэл анх гарч байлаа. “Зет” үсгийг танк, ачааны машин зэрэг цэргийн техникүүд дээр цагаан будгаар зурж байлаа. Үүний араас ви, “О”, “Экс”, “Эй” үсгүүд ч гарч ирсэн. Хэвлэл мэдээллээс шүүж харахад чухамхүү “Зет” үсэг бүхий техникүүд Украины хилийг анхлан давжээ.

Ингээд түрэмгийлэл эхлэснээс хэд хоногийн дараа “Зет”, ви үсгүүдийг түрэмгийллийн албан ёсны бэлгэдэл гэж хүмүүс хүлээж авах болсон. Гэхдээ энэ үсгүүдийг чухам ямар утгаар хэрэглэж эхэлсэн нь одоо хүртэл тодорхойгүй. 2014 оноос эхлэн Орос, Украины зөрчилдөөнийг судлаж буй Bellingcat-ын судлаач Арик Толер “өмнө нь ийм бэлгэдэлтэй огт таарч байгаагүй” гэж онцолсон байдаг. Олон шинжээч “энэ латин тэмдэг нь өөрийн талын галаас зайлсхийхийн тулд ашиглах, дэлхийн хоёрдугаар дайны үед ашиглаж байсан арга” гэдэг дээр санал нэгдэж байна[180]. Гэхдээ алсын зайнаас хангалттай харагдахуйц хэмжээтэй биш учир өөрийн талын галаас зайлсхийх арга биш, харин латин үсгүүд нь анхны байршил эсвэл хөдөлгөөний чиглэлийг илтгэхэд зориулагдсан гэж зарим шинжээчид үзэж байгаа юм. Түүнчлэн эдгээр үсгүүд нь цэргийн тойргийг илтгэж байгаа, Z нь Западный военный округ, V нь Восточный военный округ, гурвалжин дүрс нь Южный военный округ гэсэн тайлбар байдгийн дээр дөрвөлжин доторх Z нь Крымийн цэргүүд, О нь Беларусийнх, “Зет” нь ОХУ-ын дорны хүчин, Х нь Чеченийн цэргүүд харин А нь тусгайгийхан гэсэн тайлбар ч байдаг.[181] Гэхдээ энэ хувилбарыг нотлох баримт олдоогүй. Тухайлбал, Чеченийн отрядын техник дээр V үсэг дүрсэлсэн байсан нь дээрх таамаглал эргэлзээтэй гэдгийг харуулж байна.

[180] Jeff Schogol. Here’s what those mysterious white ‘Z’ markings on Russian military equipment may mean. 2022.03.09. // https://taskandpurpose.com/news/russian-military-equipment-white-markings/

[181] Алексей Ковалев, Буква Z — официальный (и зловещий) символ российского вторжения в Украину. 2022.03.15// https://meduza.io/feature/2022/03/15/bukva-z-ofitsialnyy-i-zloveschiy-simvol-rossiyskogo-vtorzheniya-v-ukrainu-my-popytalis-vyyasnit-kto-eto-pridumal-i-vot-chto-iz-etogo-poluchilos

Латин үсгүүдийн хэрэглээ

“Зет” үсгийг кирилл цагаан толгойн “З” үсгийг орлуулахын тулд ашиглаж байгаа. Za победу, Za наших гэх зэргээр. З үсгийг “Зет”-ээр орлуулан ашигласнаар илүүтэй эх оронч утгыг агуулж байгаа гэж хэлж болно. Мөн эх оронч үзэл суртал шингээхийн тулд “Зет” үсгийг георгийн туузаар чимэглэх нь олонтаа. Оросын сөрөг хүчнийхний хувьд энэ нь сөрөг утга агуулах бөгөөд Z хөгжим, Z үзэл суртал, Z гоозүй, Z дуучид зэргээр Кремлийн суртал ухуулгыг дэмжиж байгаа уран бүтээлчид болон тэдний бүтээл туурвилыг нэрлэх болсон юм.

Латин цагаан толгойн энэ үсгийг ийнхүү дайн дэмжсэн суртал ухуулгад хэрэглэх болсон тул Эстони, Украин, Молдав, Литва, Латви, Германы зарим мужуудад Оросын армийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Z үсгийг олон нийтийн дунд дүрслэн харуулахыг хориглосон.

Эдгээр үсгүүдийг цаашлаад Оросын Батлан хамгаалах яам ч албан ёсны хаягуудаараа дамжуулан ашиглах болсон. Тухайлбал, 2022 оны гуравдугаар сарын гуравны өдөр Инстаграм хуудсандаа Za победу, Za мир, Сила V правде, Zakam нацизма гэх зэргээр ашиглаж эхэлсэн юм. Улмаар тавдугаар сарын 26-ны өдөр Оросын гвард “Цэргийн тусгай ажиллагааны оролцогч” гэсэн медаль гаргасан бөгөөд энэ медалийн нүүрэн талд “Зет” үсэг хэлбэртэй туузны наана автомат барьсан цэргийн алба хаагчийг дүрсэлжээ.

АНУ-ын Стратеги, олон улс судлалын төвийн судлаач Мария Снеговагийн үзэж байгаагаар, улбар шар, хар өнгөтэй Z үсэг нь өнөөгийн халдан довтлолт ба Дэлхийн хоёрдугаар дайны ялалт хоорондын уялдаа холбоог үүсгэхийн сацуу “түүхэн ялагч” гэх Оросын үндэсний үзэл санааг дэмжиж байна гэж үзсэн[182]. Харин Зөвлөлтийн түүхч Алексей Новиков Z үсгийг “ард түмэн” гэх ойлголттой дүйцүүлж байлаа.

“Үнэн хэрэгтээ Z үсэг нь латин үсэг биш, харин эртний грекээс гаралтай. X-XI зуунаас манайд ашиглагдаж байгаа. Z бол газар гэсэн утгатай /земля”. Ингэж л нэрлэгдсээр ирсэн. Газар нутаг, хүн ам. Түүнчлэн ард түмэн гэсэн утга ч агуулж байсан. Киевийн Орооос Новгород, Владимирск хүртэл үүнийг ашиглаж байсныг түүхэн олон сурвалж гэрчилдэг” хэмээн өгүүлж байв. [183]

2. Урлагаар дамжуулсан суртал ухуулга

Хүн төрөлхтөн аливаа дайн мөргөлдөөний үеэр ард иргэдэд нөлөөлөхийн тулд урлагийг суртал ухуулгын хэрэгсэл болгон ашигласаар ирсэн. Украин, Оросын мөргөлдөөн ч ийм замыг туулж байгаа юм. Урлагаар дамжуулсан суртал ухуулга дотроо дуу хөгжим, кино урлаг, утга зохиол гэсэн гурван хэлбэрээр явж байна.

ОХУ-ын талд: Мөргөлдөөн эхэлснээс хойш ОХУ-д томоохон урлаг соёлын арга хэмжээ олон зохиогдсон. Украинд үргэлжлүүлж буй Оросын цэргийн ажиллагааг дэмжсэн

[182] Paula Villegas. How “Z” became a symbol for supporting Russia’s invasion of Ukraine.2022.03.09 // https://www.washingtonpost.com/world/2022/03/09/letter-z-russia-symbol-pro-war/

[183] Виталий Мягкий.Историк рассказал об истинном значении букв Z и V для России. 2022.03.17 // https://ura.news/news/1052539321

хамгийн алдартай, шуугиан тарьсан соёлын арга хэмжээ нь “Za Россию”[184] марафон юм.Бүс нутгуудаар тойрон зохион байгуулагдсан энэ аялан тоглолтод цэрэг, эх оронч дуугаараа алдартай Любэ хамтлагийн ахлагч Николай Расторгуев, алдарт дуучин Дмитрий Певцов, «Уматурман», «Пилот», «Самоцветы» хамтлаг, мөн л эх оронч дуугаараа алдартай Олег Газманов нарын олон алдартан оролцож байлаа.

ОХУ-ын поп хөгжмийн одод хуучин дуугаа сэргээн дуулсан аялан тоглолтоор хязгаарлагдалгүй, өнөөгийн мөргөлдөөний сэдэвтэй шинэ уран бүтээл ч туурвисан юм.

Тэдгээрийн дунд найман жилийн өмнөөс л өөрсдийгөө тунхагласан Луганск, Донецк бүгд найрамдах улсуудыг дэмждэг уран бүтээлчид багтаж байсны нэг нь Юлия Чичерина юм. Тэр 2015 оноос Луганск руу явах болж улмаар 2017 онд Луганскийн иргэншил авсан. Улмаар 2016 онд “Тэргүүн шугаманд” нэртэй клип гаргасан нь босогчдын албан бус сүлд дуу болсон юм. Үүний араас “Линия спарта”, “Сайн дурынхан”, “Улаан арми бүхнээс хүчтэй”, “Оросын ой”, “Донбасс” зэрэг уран бүтээлүүд гаргаж байлаа.

Өөр нэг рок дуучин болох Юта Сирид ажиллагаа явуулж эхэлснээс эхлээд л Оросын армийг дэмжиж, үүнийхээ төлөө медаль хүртэж байсны дээр 2016 онд Оросын төлөө уран бүтээл гаргаж байсан юм. Харин 2022 онд гаргасан “Za жизнь” нэртэй дуу нь Оросын армийн анги нэгтгэлүүдийн сүлд дуулал болсон гэдэг.

Бусад уран бүтээлчид ч 2022 оны хоёрдугаар сараас хойш эх оронч сэдэвтэй уран бүтээл туурвисны дотор вика Цыгановагийн Вагнер дуу ихээхэн алдаршсан. “Алив Вагнер, тоглоорой, хөгжимчдөө босгоорой, хөнгөн дэвэлтээр босоцгоо, манай оросын вагнер” хэмээн дуулах энэ дуу Оросын хувийн цэргийн компани болох Вагнерынхны сүлд дуу болжээ. Үүний зэрэгцээ хуучин дуунууд ч шинэ агуулгаар дахин дуулагдах болсон юм. Үүний нэг нь Олег Газмановын Офицерүүд дуу бөгөөд мөргөлдөөн эхэлснээс хойш энэ дууг ашиглан төрөл бүрээр дүрсжүүлсэн хувилбарууд олон гарсан. Газманов эх оронч бусад уран бүтээлчдийн адилаар Донбасст тоглолт хийж, 50 мянган үзэгчийг цуглуулж байлаа. Ийм соёлын арга хэмжээнд Кремлээс олон сая рубль зарцуулдаг, тухайлбал Газмановт Донбасст хийсэн тоглолтынх нь төлөө 17 сая рублийн шан өгсөн гэх мэдээлэл барууны хэвлэлээр гарч байсан ч дуучин өөрөө үүнийг үгүйсгэж байв. [185]

Украины талд: Цэргийн мөргөлдөөн эхэлсний дараа Оросын хүчийг эсэргүүцэн зогсох бэлгэ тэмдэг болсон хоёр дуу ихээхэн алдаршсан. Үүний нэг нь 5низза хамтлагийн гишүүн асан Сергещй Бабкины Цэрэг дуу юм. Нөгөө нь Бумбокс хамтлагийн ахлагч Андрий Хлывнюкийн дуулсан Червона Калына гэх ардын дуу юм. Тэр бээр мөргөлдөөн эхлэх үед АНУ-аар хамтлагийнхантайгаа аялан тоглолт хийж яваад энэ тоглолтоо дуусган Украины зэвсэгт хүчинд нэгдэх шийдвэр гаргасан. Ингээд дайчин эрсийн урам зоригийг сэргээх үүднээс автомат буу үүрч, гудамжинд зогсож байгаад энэ дууг дуулсан юм. Улмаар домогт Пинк Флойд хамтлаг Андрий Хлывнюктэй холбогдон Червона

[184] https://meduza.io/feature/2022/05/11/marafon-za-rossiyu-oboshelsya-pochti-v-100-millionov-rubley-iz-byudzheta-ego-organizoval-ekspertnyy-institut-dalekiy-ot-shou-biznesa-no-blizkiy-k-kremlyu

[185] https://moika78.ru/news/2023-02-04/852047-pevets-oleg-gazmanov-otritsaet-poluchenie-17-mln-rublej-za-katalog-patrioticheskih-pesen/

калына дууг түшиглдэн Hey Hey Rise Up дуу бүтээсэн нь 12 сая гаруй үзэлттэй явж байна. Энэ дуу Украины зэвсэгт хүчин төдийгүй Украины армийг дэмждэг иргэдийн дунд ихээхэн алдаршсан юм.

Түүнээс гадна Раммштаин, Билли Айлиш, Скорпионс зэрэг алдартай дуучид Украины армийг дэмжиж уран бүтээл гаргасан нь энгийн иргэдийн дунд украинчуудыг дэмжих хандлагыг улам нэмэгдүүлэхэд хүчтэй нөлөө үзүүлсэн гэж үзэж байна.

Утга зохиол

Утга зохиолын салбарт суртал ухуулгын шинжтэй уран бүтээл туурвих болсон. Мөн л "Зет" үсгийг ашиглан "Зет" яруу найраг гэх урсгал бий болсон бөгөөд үүнийг "Z орос зуны яруу найраг" нэртэй эмхэтгэлтэй холбоотой дуулианаас үүдэн олон нийт мэддэг болсон юм[186]. ОХУ-ын Засгийн газраас санхүүждэг Russia Today олон улсын сувгийн редакциас бэлтгэсэн энэ эмхэмтгэлийн нэрэнд "Зет" үсэг орсны улмаас Оросын олон хэвлэлийн газар хэвлэхээс татгалзаж байсан нь ихээхэн шуугиан дэгдээсэн. Энэ эмхэтгэлд Донбассын оршин суугч Анна Ревякина, цэргийн сурвалжлагч Семен Пегов, цэргийн сурвалжлагч, яруу найрагч Анна Долгарева нарын олон хүний бүтээл багтсан байна. Шүлгийн эмхэтгэлийг фронт дээр байгаа эрчүүдийг сэтгэл санаагаар дэмжих, олон нийтэд эх оронч шүлгүүдийг хүргэх зорилгоор бэлтгэсэн гэдэг. [187]

"Зет" яруу найраг" нь олон өнгө аястай байна. Зарим шүлэг нь Украинаас салан тусгаарласан бүс нутгуудын оршин суугчид найман жилийн өмнө бичсэн шүлгүүд байгаа бол зарим найрагчид өнөөгийн мөргөлдөөнийг Аугаа их Эх орны дайны үргэлжлэл мэтээр дүрслэн бичжээ.

Украин дахь мөргөлдөөнтэй холбоотой сэдвээр дуу шүлэгнээс өөрөөр томоохон хэлбэрийн уран зохиолын бүтээл гараагүй. "Түүхэн цаг үетэй холбоотой тууж, роман зэрэг аливаа томоохон хэлбэрийн бүтээл гарахад цаг хугацаа шаардлагатай, одоогоор маш богино хугацаа өнгөрсөн" гэж Оросын урлагийн шүүмжлэгч Константин Мильчин RTVI сувагт өгсөн ярилцлагадаа онцолж байв. [188]

Гэхдээ чухамхүү утга зохиол Оросын Батлан хамгаалахын яамны онцгой анхаарлын төвд байгаа гэдгийг онцлох хэрэгтэй. 2022 оны зун буюу ОХУ Украины нутаг руу дайрснаас хэдхэн сарын дараа Оросын Батлан хамгаалах яам Армийн тэмцээн зохион байгуулж, "гар зураг", "яруу найраг", тууж, жүжиг төрлөөр 20 гаруй зохиолчийг шалгаруулан шагнаж байв. [189]

Кино урлагт үзүүлсэн нөлөөлөл

[186] https://ria.ru/20230511/sbornik-1871098248.html
[187] https://ria.ru/20230511/sbornik-1871098248.html
[188] https://rtvi.com/stories/iskusstvo-bez-nenavisti-kak-konflikt-rossii-i-ukrainy-otrazilsya-v-kulture-obeih-stran/
[189] https://rtvi.com/stories/iskusstvo-bez-nenavisti-kak-konflikt-rossii-i-ukrainy-otrazilsya-v-kulture-obeih-stran/

ОХУ-д: Украинд болж буй цэргийн ажиллагааны тухай уран бүтээлийг төрөөс захиалахгүй байгаа талаар кино салбарынхан өгүүлж байв. Энэ нь цэргийн тусгай ажиллагааны тухай түүхийн утга учрыг ухаарах, эргэцүүлэх хэмжээний хангалттай цаг хугацаа өнгөрөөгүйтэй холбоотой , хоёрдугаарт өнөөдөр нэг үйл явдлын талаар кино бүтээлээ гэхэд маргааш энэ нь худал хуурмагт тооцогдох эрсдэлтэй тул хэн ч энэ сэдвийг барьж авахыг хүсэхгүй байгаа гэж нэрээ нууцалсан шинжээч RTVI -д тайлбар өгч байлаа. [190]

Эрх баригчдын зүгээс Украины мөргөлдөөнтэй холбоотой кино захиалгыг ил болон далд хэлбэрээр хийгээгүй, гэхдээ Мариуполийг эзлэсэн тухай бүрэн хэмжээний киноны зураг авалт хийгдэж байгаа аж.

Одоогоор эрэлттэй байгаа цорын ганц жанр нь байлдааны ажиллагааны талаарх баримтат кинонууд бөгөөд эдгээрийг эсвэл захиалгаар эсвэл телевизийн сувгууд худалдан авах гэрээтэйгээр хийж байгаа аж.

Cancel culture буюу татгалзах соёл

Орос, Украины мөргөлдөөний үеэр ОХУ-ын урлагын эсрэг татгалзах соёл ихээр ашиглаж байна. Cansel culture буюу татгалзах соёл нь АНУ, Европт үүссэн нийгэм улс төрийн томъёолол бөгөөд онлайн орчин, олон нийтийн сүлжээ болон бодит байдал дээр тухайн хүн эсвэл тодорхой бүлэг дэмжлэг авахгүй, шүүмжлэлийн бай болохыг хэлж байна. Кембрижийн толь бичигт “татгалзах соёл” гэдэг нь таныг доромжилж буй үйлдэл эсвэл үг хэллэгийнх нь улмаас хэн нэгнийг дэмжихээ бүрэн зогсоож буй, олон нийтийн сүлжээнд, нийгэмд эсвэл бүлэгт илрэх зан байдлын хэв маяг” гэж тодорхойлжээ[191]. Харин Харвардын их сургуулийн профессор П.Норрис “татгалзах соёл”-ыг “нийгмийн хэм хэмжээг зөрчсөнийх нь төлөө хэн нэгнийг үл хайхрах оролдлого” гэж тодорхойлсон байдаг. Дэлхийн олон оронд энэ соёл нь хэрэглэгчид таагүй үзэгдлийг үл хүлээн авч, бойкот хийх байдлаар илэрдэг. Тухайлбал, аливаа компанийн үйл ажиллагаа нь ажилтнууд болон хүрээлэн буй орчинд ёсзүйгүй байдлаар чиглэгдсэн бол хэрэглэгчид тухайн брэндийг бойкотлож, улмаар борлуулалт нь буурдаг.

Татгалзах соёл нь түүнчлэн соёлын бойкот гэдэг утгаар ашиглагддаг. Чухамхүү энэ утгаараа Оросын урлагын эсрэг ашиглагдаж байгаа юм.

“Оросоос татгалзах үзэгдэл” олон улсын түвшинд “татгалзах соёл”-ын илрэл болон гарсан. ОХУ 2022 оны хоёрдугаар сарын 24-ний өдөр Украин руу халдан довтолсны дараа олон улсын зүгээс олон хориг тавьсны зэрэгцээ урлаг соёлоос нь татгалзах давлагаа эхэлсэн юм.

Мөргөлдөөн эхэлсний дараа Оросын урлагийнхныг бойкотлох болж, Евровишн, Каннын Кино наадмаас хасаж, Оросын Их театр ч гадаадын томоохон театруудтай хамтран

[190] https://rtvi.com/stories/iskusstvo-bez-nenavisti-kak-konflikt-rossii-i-ukrainy-otrazilsya-v-kulture-obeih-stran/
[191] https://cyberleninka.ru/article/n/kultura-otmeny-v-otnoshenii-rossii-i-sposoby-borby-s-ney/viewer

ажиллахаа больж, Оросын алдартай удирдаачид гадаад дахь гэрээгээ цуцлуулж байлаа. Мөн Оросын хөгжимчдийн бүтээлийг томоохон театрууд урийн сангаасаа хасаж байв.

Мөргөлдөөн гарсны дараа хоёр тал аль аль нь урлаг соёлынхны бүтээлийг бойкотлож эхлэн, Украинд ерөнхий боловсролын уран зохиолын хөтөлбөрөөс Александр Сергеевич Пушкин, Крылов, Чехов, Тургенев, Бунин, Есенин, Шолохов, Пастернак, Маяковский, Ахматова, Гумилев, Цветаева нарын нийт 40 орос зохиолчийн бүтээлийг сургалтын хөтөлбөрөөс хассан. Сөргөлдөгч талууд нэгнийхээ соёлоос ийнхүү татгалзахыг хүлээн зөвшөөрч болох ч хачирхалтай гэмээр үйл явдлууд ч гарсан юм. Тухайлбал, Миланы их сургууль Достоевскийн бүтээлийг их сургуулийн хөтөлбөрөөс хассан нь ихээхэн шуугиан тарьж байлаа. Түүнчлэн мөргөлдөөн эхэлсний дараахан буюу 2022 оны 03 дугаар сарын есний өдөр Британийн Кардиффын филармони Петр Ильич Чайковскийн "1812" увертюраг урийн сангаасаа хасах шийдвэр гаргаж байлаа[192]. Энэ хөгжмийг одоо тоглох нь зохисгүй гэж үзсэний улмаас ийм шийд гаргаж байв.

Ийхүү дэлхий дахинаа хүлээн зөвшөөрөгдсөн сонгодог зохиолчдын бүтээлийг үл хайхрах үзэгдэл газар авсны зэрэгцээ одоо нэр алдраа цуурайтуулж яваа уран бүтээлчид ихээхэн хямралд орсон юм.

Дэлхийн өвд оруулсан Оросын соёлын хувь нэмэрийг мартуулах, бууруулах гэсэн барууныхны оролдлого нь улс төржсөн сэдэлтэй, олон нийтийн шударга хэрэгцээтэй ямар ч холбоогүй байсан гэж ОХУ-ын ГХЯ-ны Олон улс судлалын хүрээлэнгийн судлаачид болох Л.Р.Рустова, Д.Г.Иванова нар "Оросыг чиглэсэн татгалзах соёл ба түүнтэй тэмцэх аргууд" эрдэм шинжилгээний өгүүлэлдээ үзсэн байдаг. [193]

3. Шинэ үг хэллэг

ОХУ-ын халдан довтлолтоос үүдэлтэй Орос дахь улс төр болон нийгмийн нөхцөл байдалд гарсан хурдацтай, мэдэгдэхүйц өөрчлөлтүүд нь цэргийн шинэ нэр томъёо, үг хэллэг үүсэх нөхцөлийг бүрдүүлсэн бөгөөд эдгээрээр дамжуулан шинэ бодит байдлыг дүрслэн хэлэх болсон юм.

Эдгээр шинэ үг хэллэгүүдийг дотор нь:

1. Цэргийн хэллэг
2. Этгээд хэллэг
3. Дайсныг гутаах үг хэллэгүүд гэж хувааж үзэж болохоор байна

Орос хэлэнд үүссэн шинэ үг хэллэг ОХУ-ын дээд удирдлага, албан тушаалтнуудын яриа, мэдэгдэл, цэргийн тоймч, улс төрчдийн яриа, улс төрийн ток шоу, олон нийтийн сүлжээн дэх нийтлэлүүдэд иххээр хэрэглэгдэх болсон. Оросын медиа орон зайд хамгийн өргөн хүрээнд дэлгэрсэн неологизм буюу шинэ үг хэллэг нь "Цэргийн тусгай ажиллагаа" гэх холбоо үг болж байна. Энэ үгийг анх Владимир Путин 2022 оны хоёрдугаар сарын 24-

[192] https://ria.ru/20220309/chaykovskiy-1777375806.html

[193] https://cyberleninka.ru/article/n/kultura-otmeny-v-otnoshenii-rossii-i-sposoby-borby-s-ney/viewer

ний өдөр ард түмэндээ хандсан мэдэгдэлдээ “Цэргийн тусгай ажиллагаа эхлүүлэх шийдвэр гаргасан” гэж онцолсноор цааш энэ үгийг хэрэглэх болсон юм[194].

Албаны этгээдүүд, төрийн хэвлэлүүд, Украинд өрнөж буй үйл явдал дээр Оросын алхмыг зөвтгөдөг хүмүүс өнөөгийн мөргөлдөөнийг “цэргийн тусгай ажиллагаа” гэх шинэ үг хэллэгээр томъёолдог болсон.

Улс төр болон эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлтийн эринд аливаа хэлэнд ихээхэн өөрчлөлт гарч байдаг. Оросын тухайд ч мөн адил. Оросын түүхэнд Октябрын хувьсгал, ЗХУ үүссэн, хамтрал, Аугаа их эх орны дайн, түүний үр дагавар, технологийн хөгжил, 50-60-аад оны үсрэнгүй хөгжил, 1990-ээд оны үеийн ЗХУ задран унаснаас үүдэлтэй улс төр, эдийн засгийн өөрчлөлтүүд орос хэлэнд ул мөрөө үлдээж, албан болон ахуйн ярианд ихээхэн өөрчлөлт орж байв. Тухайлбал ЗХУ задран унасны дараа албан болон албан бус хэл, олон нийтийн болон хувь хүний хэл ярианы хоорондын зааг хязгаар бүдгэрч эхэлсний дээр ихэвчлэн англи хэлнээс зээлдсэн шинэ үг хэллэгүүд орж ирж байлаа. Үүний адилаар Украины эсрэг түрэмгийлэл ч орос хэлэнд багагүй шинэ хэллэгүүдийг оруулж ирсэн юм.

Шинэ үг хэллэг гэдгийг хэрхэн тодорхойлж байна вэ гэсэн асуулт эндээс гарч ирнэ. Найруулга зүйн онолын үүднээс неологизм буюу шинэ үг хэллэг нь тухайн хэлээр ярьж буй хүн шинэлэг талын нөлөөг мэдэрч буй үг хэллэг юм. Зөвлөлтийн эрдэмтэн А.В. Калинин 1966 онд тодорхойлсноор шинэлэг байдлын мэдрэмж нь шинэ үг хэллэгийн цорын ганц шалгуур бол хэл шинжээч Е.В.Сенькогийн үзсэнээр шинэ үг хэллэг нь өвөрмөц, шинэлэг, өргөн хэрэглээнд хараахан нэвтрээгүй гэсэн үзүүлэлт нь шинэ үг хэллэгийг тодорхойлно[195].

Өмнө нь өгүүлсэн, суртал ухуулгад ашиглагдаж байгаа “Зет” үсэг хэл шинжлэл болон социолингвистикийн талаас ихээхэн сонирхол татаж байгаа юм. Орос болон орос хэлний түүхэнд латин цагаан толгойн ердөө ганц үсэг Оросын нийгэм улс төрийн хэлэнд нөлөөлсөн одоогийнх шиг жишээ олоход бэрх. “Зет” үсэг нь өөрөө фонем буюу үгийн хувьд төдийлөн ач холбогдолгүй **хэлний авиа зүйн системийн дууны хамгийн бага нэгж** бол одоо хэрэглэгдэж байгаа үгс дээр нэмэгдэхээрээ ач холбогдолтой, хүчтэй утга оруулж буй бүтээвэр болж байна.

Хүснэгт 1. Цэргийн шинэ үг хэллэг

Нэг. “Сөргөлдөгч” талыг илтгэх үгс	
1. Антинародная хунта	Ард түмний хунт
2. анти-Россия	Оросын эсрэг
3. Ватник	Оросын дэглэмийг дэмжигч
4. Западные коллеги	Барууны нөхөд
5. Западные партнеры	Барууны түнш

[194] ИТАР ТАСС. Путин объявил о начале специальной военной операции на Украине. 2023.02.24. https://tass.ru/politika/13825671

[195]https://trepo.tuni.fi/bitstream/handle/10024/148164/DobrowolskiTaneli.pdf?sequence=2&isAllowed=y

6. Киевский режим	Киевийн дэглэм
7. Киевская хунта	Киевийн хунт
8. Киевские власти	Киевийн эрх баригчид
9. Коллективный запад	Үгссэн барууныхан
10. Колорад	Орос хэлтэй иргэдийг илэрхийлж буй доромж утга
11. Крайние националисты	Хэт үндсэрхэг үзэлтнүүд
12. Мордор	Сүүдрийн улс
13. Нацики	Үндсэрхэг үзэлтнүүд
14. Неонацисты	неонацистууд
15. Оккупант	Эзлэн түрэмгийлэгч
16. Орки	Оркууд
17. Правящий на территории Украины режим	Украины нутаг дээр эрх барьж буй дэглэм
18. Укроп	Гоньд, Украины зэвсэгт хүчний ажиллагаанд оролцож буй, Украиныг дэмжигч хүн
19. Укрофашист	Украины фашист
20. Баба-яга	Дрон

Зэрэг 50 гаруй шинэ үг хэллэгийг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээс түүсэн.

Украин хэлэнд гарсан этгээд, шинэ үг хэллэг

ОХУ Украин руу түрэмгийлсэн нь украин хэлэнд ч шинэ үг хэллэгийг олноор бий болгосон. Өдөр тутмын хэл ярианд цэргийн этгээд хэллэгүүд нэвтэрч, шинэ үгс үүсч, энэ явц үргэлжилсээр байна.

Цэргийн этгээд хэллэг

Цэргийн албан хаагчид ашигладаг үгс өмнө ч энгийн иргэдийн ярианд орсон байдаг ч мөргөлдөөн хурцдах үед илүүтэй идэвхтэй нэвтэрсэн.

Зөвлөлт Афганы дайны үеэс л бий болсон үгс дахин хэрэглэгдэх болсон. Тухайлбал “200”, “300” гэх талийгаач болон шархагдсдыг хэлдэг үгсээс үйл үг үүсэж “хоёр зуудах”, “гурван зуудах” буюу устгагдах, шархдах гэх утгыг илэрхийлэх болсон.

- **арта -** артиллер, артиллерчид
- **бандеромобиль** – сайн дурынхан нэмэлт тоноглол хийсэн, Украины зэвсэгт хүчинд зориулсан автомашин
- **байрактарить, энлоить, джавелинить, стингерить и хаймарсить** – байрактар, жавелин, хаймсар зэрэг зэвсгийн төрлүүдийн нэрсээс үүссэн үйл үгс. Байрактараар устгах, хаймарсдах гэх мэт
- **дискотека** – байлдааны ажиллагаа
- **зеленка** – бут, сөөг, ой бүхий газар
- **ленточка** – тууз буюу цэргийн техникийн цуваа
- **мамковать** – амь насаа хамгаалахын тулд энгийн үйлдэл хийхгүй байх
- **минус (уходы)** – сөргөлдөгчийн чиглэлд харвасан сум
- **минусовать** – дайсныг устгах

- **мопед** – ираны камиказе дрон
- **прилет, приход и смс-ка** – дайсны пуужин эсвэл сум онох
- **пиксель, цифра** – Украины цэргийн дүрэмт хувцас
- **призрак Киева** – “Киевийн сүнс”- Украины нисгэгчдийн цуглаан
- **передок** – фронтын шугам
- **птичка** – “шувуухай”- нисгэгчгүй нисэх аппарат

Дайсныг гутаах үг хэллэгүүд

Дайны нөхцөлд сөргөлдөгч талууд нөгөө талаа гутаан доромжлох үг хэллэг ашиглах нь мэдээж хэрэг. Украинчуудын ярианд ч ийм үг хэллэг олноор гарч ирсэн юм. Тухайлбал ОХУ-ын **мордор** эсвэл **оркостан,** Оросын армийг **оркууд** гэж нэрлэх болсон. Араатны зэрлэг шинж байдалтай зэрлэг бүдүүлэг амьтныг нэрлэдэг энэ нэршил анх Английн зохиолч Ж.Толкины “Бөгжний эзэн” зохиолд гардгаараа олны дунд тархсан юм.
Түгээмэл хэрэглэгдэж буй бусад үгс :

- **аналоговнет** - /орлуулашгүй/ үнэн хэрэгтээ огт үр дүнгүй төгс боловсруулалт
- **адиннарот** (один народ)/нэг ард түмэн/ -Украин улсыг устгаж буйгаа зөвтгөдөг Оросын үйл ажиллагааг элэглэсэн хэллэг
- **бавовна /хөвөн/** – Оросууд хяналтаа тогтоосон нутаг дэвсгэрт гарсан дэлбэрэлт
- **затридня /гурван өдрийн дотор/**- төлөвлөсөн хугацаанд ялалт байгуулна гэх оросуудын төлөвлөгөө, бүтэшгүй амлалт
- **рашка, расея, кацапия** – ОХУ-ыг нэрлэж буй доромж үгс
- **"привези унитаз"** /суултуур авчрах/- Оросын цэргүүдийн дээрэм тонуулыг илэрхийлэх үгс
- **бандеровский смузи** – Молотовын коктейлын украин нэршил

Улс төрийн шинэ үг хэллэг

Улс төр болон тодорхой улс төрчидтэй холбоотой цэргийн шинэ үг хэллэг ч олноор гарсан. Тухайлбал Оросын үзэл суртлын үндэс, улс төрийн дэглэмийг ерөнхийд нь **“рашизм”** гэж нэрлэх болсон юм. Энэ ойлголтод их гүрний дээрэнгүй үзлээс эхлээд фашизмын нэг утгыг ч багтааж байгаа.

Фашизмыг Оростой холбож нэрлэх болсноос үүдээд Путин болон Гитлер гэсэн хоёр овгийг нийлүүлэн, **Путлер** гэж ярих болсон нь Оросын Ерөнхийлөгчид украинчууд хэрхэн хандаж байгааг илтгэнэ.

Тухайлсан улс төрчидтэй холбоотой хэд хэдэн шинэ үг хэллэг ард түмний дунд гарсан:

- **макронить /макрондах/** -Сүрхий зовнисон царай гаргасан ч үнэндээ юу ч хийхгүй байх гэсэн утгыг илэрхийлэх болсон. Энэ нь Францын Ерөнхийлөгч Эммануэл Макронтой холбоотой бөгөөд дайны эхний үед ихээхэн санаа зовниж байгаагаа илэрхийлсэн ч бодит байдал дээр төдийлөн туслаагүй тул ийм хэллэг үүсэх шалтгаан болжээ. Түүнчлэн энэ үгээр утсаар дэмий чалчих гэсэн утгыг илэрхийлж байна.
- **валять шольца /шольц царайлах/** - Байнга амласан ч бодит байдал дээр огт туслахгүй байхыг энэ үгээр илэрхийлж байна. Германы канцлер Олаф Шольц

шийдэмгий бус байдал гаргаж байгаагийн улмаас Украинд нийлүүлэх зэвсэг шуурхай ирж чадахгүй байгаатай холбоотойгоор ийм хэллэг үүсчээ.

- **Шойгунить /шойгудах/** - бүх зүйл төлөвлөгөөний дагуу явж байгаа гэж итгүүлэх. Энэ нь Оросын Батлан хамгаалахын сайд Сергей Шойгутай холбоотой гарсан үг юм.
- **кадырить /кадырдах/**- Мөрөөдлөө бодит мэт ярих. Ченийн тэргүүн Украиныг эзлэх амбицтай мэдэгдэл нэг бус удаа хийж, тулаан явгдаж байгаа мэт хуурамч бичлэг удаа дараа тавьж байснаас энэ хэллэг үүсчээ.

Шинэ үг хэллэг нь 10 жил орчмын хугацаанд хуучирдаг гэж хэл шинжээчид үздэг. Эндээс үзэхэд, Орос, Украины мөргөлдөөний үеэр үүссэн шинэ үг хэллэг нь 2035 он хүртэл хэл ярианд ашиглагдаж, утга нь хувьсах магадлалтай байгаа юм.

Дүгнэлт

Өнөөгийн мөргөлдөөнд эзлэж буй байр суурь нь ялгаатайн улмаас Украин, Орос улс мөргөлдөөнийг огт өөрөөр тусгаж байна. Украинд цэргийн дайчилгаа төдийгүй уран бүтээлийн дайчилгаа ч явгдаж байгаа бөгөөд найруулагч, зураач, зохиолчид өнөөгийн үйл явдлыг тусган, олон нийтэд харуулах үйл ажиллагааг идэвхжүүлж байна.

Харин Орост уран бүтээлийн хүрээнд цэрэгжих хандлага бага, “хэтэрхий бага цаг хугацаа өнгөрч байна урлаг судлаачид үзэж байгаа юм.

Хоёр жил гаруй үргэлжилж буй Орос, Украины хоорондын мөргөлдөөн орчин цагийн урлагт төдийлөн том ул мөр үлдээгээгүй. Хэдийгээр хоёр оронд хоёуланд нь урлагийн салбарт цэргийн сэдэв байгаа ч ихэвчлэн Донбасс дахь найман жилийн мөргөлдөөний сэдэвд зориулагдсан байна.

Хэл шинжлэлийн үүднээс авч үзвэл цөөн тооны шинэ үг хэллэг нэвтэрсэн ч энэ нь голчлон цэргийн салбарт хамаарч байна. Цаашлаад энгийн ярианд нэвтэрч, улмаар 10 гаруй жилийн дараа хуучирсан үг хэллэг болж мартагдах хандлагатай.

Соёлын солилцооны тухайд, өнөөдөр ОХУ “дайн өдөөгч” гэсэн “шошго”-той болсон тул энэ улсын урлаг соёлынхонтой хамтарч ажиллах барууны орнуудын урлаг соёлын байгууллагын хүрээ хумигдаж, энэ нь мөргөлдөөн шийдэгдтэл, цаашлаад, мөргөлдөөний дараа ч хэдэн жилийн туршид нэр хүнд сэргэх хүртлээ соёлын харилцаа хязгаарлагдмал, хумигдмал байдалтай байх магадлалтай байна. Манай орны хувьд, хөрш, найрсаг харилцаатай ард түмэн гэдгээрээ соёлын харилцаа хэвийн, зарим талаараа илүү эрчимжих хандлагатай байгаа бөгөөд энэ нь ОХУ хөрш орнууд, хуучин зөвлөлтийн бүрэлдэхүүнд байсан орнуудад нөлөөллөө алдахгүй гэсэн зөөлөн хүчний бодлоготой илүүтэй холбоотой гэж харж болохоор байгаа юм.

Ашигласан материал

1. https://www.bbc.com/russian/news-60077654
2. https://www.washingtonpost.com/world/2022/03/09/letter-z-russia-symbol-pro-war/
3. https://ura.news/news/1052539321
4. https://meduza.io/feature/2022/05/11/marafon-za-rossiyu-oboshelsya-pochti-v-100-millionov-rubley-iz-byudzheta-ego-organizoval-ekspertnyy-institut-dalekiy-ot-shou-biznesa-no-blizkiy-k-kremlyu
5. https://moika78.ru/news/2023-02-04/852047-pevets-oleg-gazmanov-otritsaet-poluchenie-17-mln-rublej-za-katalog-patrioticheskih-pesen/
6. https://ria.ru/20230511/sbornik-1871098248.html
7. https://rtvi.com/stories/iskusstvo-bez-nenavisti-kak-konflikt-rossii-i-ukrainy-otrazilsya-v-kulture-obeih-stran/
8. https://cyberleninka.ru/article/n/kultura-otmeny-v-otnoshenii-rossii-i-sposoby-borby-s-ney/viewer
9. https://ria.ru/20220309/chaykovskiy-1777375806.html
10. ИТАР ТАСС. Путин объявил о начале специальной военной операции на Украине. 2023.02.24. https://tass.ru/politika/13825671

SPSIRPA FORUM 2025

Session 5-3

Emerging Challenges in the International Security Environment
Since 2024 and Strategic Responses for their Mitigation

ОЛОН УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОРЧИНД 2024 ОНООС ХОЙШ ТУЛГАРЧ БАЙГАА СОРИЛТ, ТҮҮНИЙГ ДАВАН ТУУЛАХ ШИЙДЭЛ

Т.Мөнх-Оргил

БХЭШХ-ийн дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга доктор, дэд профессор

Д.Батбаяр

Аюулгүй байдал судалын төвийн ахлах эрдэм шинжилгээний ажилтан докторант

Abstract: In 2024, the international security landscape encountered a confluence of unprecedented challenges, characterized by escalating geopolitical rivalries, economic volatility, technological advancements, and environmental crises. This study aims to delineate the most salient issues impacting global security, particularly focusing on the intensifying competition among major powers, including the United States, China, and Russia. The examination extends to the destabilizing effects of regional conflicts, exemplified by the ongoing Ukraine crisis and rising tensions in the Taiwan Strait. Furthermore, the analysis addresses the emergence of novel threats, particularly those posed by cyberattacks and climate-induced displacement, which are increasingly undermining both national and international security frameworks. The findings of this study emphasize the necessity for a holistic approach toward understanding and mitigating the complexities of modern security challenges. The study underscores the critical importance of fostering collaborative efforts among nations and international organizations to craft comprehensive and adaptive strategies. Specifically, it recommends the responsible harnessing of technological innovation to fortify security measures while ensuring ethical considerations are upheld.

Moreover, the proposed solutions advocate for an emphasis on long-term resilience, highlighting the indispensable roles of diplomacy, resource optimization, and collective action in the ongoing pursuit of global peace and security. These recommendations suggest the establishment of multilateral frameworks that facilitate dialogue, enhance trust-building measures, and promote shared goals among state and non-state actors. By adopting a proactive and coordinated approach, the global community can better navigate the evolving security landscape and safeguard against the myriad threats that loom on the horizon.

Keywords: *Security, International Security, Cybersecurity, Artificial Intelligence, Climate Change, Food Security, Energy Supply, International Cooperation, Sustainable Development Policy, Terrorism.*

Хураангуй: 2024 онд олон улсын аюулгүй байдлын орчин геополитикийн өрсөлдөөн, эдийн засгийн тогтворгүй байдал, технологийн дэвшил, байгаль орчны хямралаас үүдсэн олон сорилтуудтай тулгарсан. АНУ, БНХАУ, ОХУ зэрэг их гүрнүүдийн хоорондын өрсөлдөөн нэмэгдсэн, Украйны хямрал, Тайваний хоолойн хурцадмал байдал, бүс нутгийн мөргөлдөөн, кибер халдлага болон цаг уурын өөрчлөлтөөс үүдэлтэй дүрвэгсдийн асуудал зэрэг тулгамдаж буй асуудлууд нэмэгдсээр байна.

Улс орны болон олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, технологийн дэвшлийг хариуцлагатайгаар ашиглах, аюулгүй байдлын эрсдэлийг даван туулах урт хугацааны тогтвортой байдлыг дэмжих арга хэмжээг тусгасан болно. Мөн дэвшүүлсэн шийдлүүд нь дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг хангахад дипломат ажиллагаа, байгалийн нөөцийн зохистой хэрэглээ, хамтын ажиллагааны чухал үүргийг онцолсон болно.

Түлхүүр үгс: *Аюулгүй байдал, олон улсын аюулгүй байдал, кибер аюулгүй байдал, хиймэл оюун ухаан, эрчим хүчний хангамж, тогтвортой хөгжлийн бодлого, терроризм.*

Оршил

Олон улсын аюулгүй байдлын орчин 2024 онд онцгой сорилт, бэрхшээлээр дүүрэн байсан бөгөөд дэлхий дахинд улс төр, цэрэг-стратеги, эдийн засаг, экологийн салбар дахь олон хүчин зүйлс тогтворгүй байдал үүсгэж, олон улсын харилцааны тэнцвэрт байдалд сөргөөр нөлөөлсөн байна. Их гүрнүүдийн геополитикийн өрсөлдөөн улам бүр эрчимжиж, шинэ төрлийн аюул заналхийлэл гарч, зарим улс орны үндэсний аюулгүй байдал, тогтвортой хөгжилд бодит эрсдэл учруулсаар байна.

2024 онд дэлхий нийтэд тулгарсан сорилтууд нь зөвхөн улс төр, эдийн засгийн хүрээнд бус, экологийн аюул, хүнсний хомсдол, технологийн хөгжлөөс үүдэлтэй шинэ төрлийн аюулыг бий болгоод зогсохгүй, кибер аюулгүй байдлын шинэ эрсдлүүдийг нэмэгдүүлж байгаа нь дэлхийн аюулгүй байдлын орчны асуудлыг илүү өргөн хүрээнд авч үзэх шаардлагай болсон. Энэхүү судалгаа нь олон улсын аюулгүй байдлын нөхцөл байдалд гарсан өөрчлөлт, шинэ сорилтуудын ач холбогдлыг тодорхойлох, дэлхийн энх тайваны тогтвортой байдалд үзүүлсэн нөлөөг шинжлэхэд оршиж байгаа болно.

Үүний хүрээнд олон улсын аюулгүй байдалд тулгарсан сорилт, бэрхшээлүүдийг судалж, тэдгээрийн шалтгаан, үр дагаврыг шинжлэх, мөн ирээдүйд улс орон бүр аюулгүй байдлын стратегийг боловсруулах, тодорхой чиглэлээр шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг болно гэж үзэж байна. Олон улсын аюулгүй байдлын орчинд үүсэн сорилтуудыг дараах байдлаар нэгтгэн тодорхойлж байна.[196] Үүнд:

1. Геополитикийн сорилт: АНУ, БНХАУ, ОХУ зэрэг их гүрнүүдийн тогтворгүй харилцаа, хамтын ажиллагаа нь бүс нутаг болон улс орнуудын аюулгүй байдалд нөлөөлж байна.[197]
2. Технологийн сорилт: Кибер халдлага, хиймэл оюун ухааны хөгжлөөс үүдэлтэй эрсдлүүд нь яаралтай хариу арга хэмжээ авч, бодлого боловсруулах түвшинд хүрсэн.
3. Экологийн сорилт: Цаг уурын өөрчлөлтөөс үүдсэн дүрвэгсдийн асуудал, ус, хүнсний хангамжийн аюулгүй байдал нэмэгдсэн.
4. Эдийн засгийн сорилт: Санхүүгийн хямрал, эрчим хүчний хангамжийн асуудал зэрэг гэж тодорхойлж байна.

[196] https://sgp.fas.org/crs/natsec/R43838.pdf?utm_source=chatgpt.com

[197] https://www.brookings.edu/articles/the-china-russia-relationship-and-threats-to-vital-us-interests/?utm_source=chatgpt.com

2024 онд олон улсын аюулгүй байдлын нөхцөл байдлыг тодорхойлон судалж, дэлхийн тогтвортой байдалд тулгарч буй сорилтуудыг даван туулахад тус чиглэлээр стратеги боловсруулан хэрэгжүүлэх нь нэн ач холбогдолтой юм. Үүний үр дүн нь улс орнуудын гадаад бодлого, олон улсын хамтын ажиллагааны нэгдмэл байдалд ач холбогдолтой бөгөөд аюулгүй байдлын олон талын асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдэх болно.

Олон улсад: 2024 онд олон улсын аюулгүй байдлын нөхцөл байдал нь геополитикийн өөрчлөлт, шинэ төрлийн аюул заналхийлэл, олон улсын хамтын ажиллагааны сорилтуудаар тодорхойлогдож байна. Их гүрнүүдийн хооронд үл ойлголцол нэмэгдэж, бүс нутгийн хүчний тэнцвэр өөрчлөгдөн, цэргийн мөргөлдөөн, терроризм, кибер аюул занал гэх мэт шинэ сорилтууд олон улсын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлсөн.

2024 онд дэлхий дахинд гарсан сорилт бэрхшээлийг AI ингэж тодорхойлсон.

АНУ, БНХАУ, ОХУ-ын хоорондын геополитикийн өрсөлдөөн нэмэгдсэн нь олон улсын аюулгүй байдлын хүрээнд хурцадмал нөхцөл байдал, талцал хуваагдал гүнзгийрч болзошгүй юм. АНУ нь дэлхийн тэргүүлэх гүрний байр сууриа хадгасаар байгаа бөгөөд Хятад улс эдийн засгийн болон цэргийн нөлөөллөө нэмж байна. Харин ОХУ бүс нутгийн болон дэлхийн түвшинд байгалийн нөөцөө ашиглан нөлөөллөө бэхжүүлж, цэрэг-улс төрийн стратегиа улам хүчтэйгээр хэрэгжүүлсээр байна.

- АНУ: НАТО-гийн гишүүн орнуудын тоо нэмэгдэж, Азийн бүс нутагт цэргийн хүчээ төвлөрүүлж, нэмэгдүүлэрээр зорьж байна. Энэ нь Хятад, Орос улсын хувьд

таатай бус тодорхой эсэргүүцэлтэй тулгарч, цаашид хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд ихээхэн хүндрэл учруулж болзошгүй байна.[198]

- Хятад: Тайваний асуудал нь Хятад-АНУ-ын харилцааны хэтийн төлөвөөс хамааралтай асуудал болж байна. БНХАУ нь "Нэг бүс, Нэг зам" санаачилгын хүрээнд хөгжиж буй орнуудад эдийн засгийн хөшүүрэг ашиглан өөрийн бүс нутагт нөлөөллөө хэвээр хадгалах бодлого барьж байна.
- ОХУ: Украйны хямрал цаашид хэрхэн шийдэгдэхээс хамаарч, Орос улс барууны хориг арга хэмжээнээс гарах нөхцөл үүсэх юм. Энэ нь АНУ-ын шинэ ерөнхийлөгчийн баримтлах бодлого чиглэлтэй нягт уялдах болно. Улмаар ОХУ-ын Ази, Ойрх Дорнод, Африк дахь холбоотнуудтай хамтын ажиллагааг хэрхэн өрнүүлэх, цаашид хэрхэн нөлөөллөө хадгалж үлдэх зэрэг асуудлууд хэвээр оршсоор байна.

Бүс нутагт: 2024 онд бүс нутгийн тогтвортой байдалд олон туйлт хүчний тэнцвэр (Multipolarity Balance of Power)-ийн өөрчлөлт чухал нөлөө үзүүлсэн. Тухайлбал:

- Европт: Украйны хямрал Европын холбооны улс орнуудын аюулгүй байдалд НАТО-гийн ач холбогдлыг нэмэгдүүлсэн бол Европын холбоо ОХУ-аас эрчим хүчний хараат байдлаа багасгах, цаашид бие даасан байдлаа хадгалахад анхаарч байна.[199]
- Ази-Номхон далай: Тайваний хойгийн асуудал, Өмнөд Хятадын тэнгис буюу БНХАУ-Филлипин улс хоорондын далай дахь хурцадмал нөхцөл байдал, Хойд Солонгосын алсын зайны пуужин болон цөмийн зэвсэгийн туршилтууд бүс нутгийн аюулгүй байдалд шинэ сорилт, хурцадмал бүхий байдлыг бий болгож байна.
- Ойрхи Дорнод: Израйль-Палестины мөргөлдөөн, Иран болон Саудын Арабын харилцааны асуудлууд бүс нутгийн энх тайван, тогтвортой байдалд саад учруулж байна.

Шинэ аюул, сорилт - 2024 онд дэлхийн хэмжээнд зэвсэгт мөргөлдөөн үргэлжилж, улс орнууд зэвсэглэлээр хөөцөлдөх шинэ сорилтыг бий болгож байна.

- Украйны хямрал: Европын аюулгүй байдалд томоохон сорилт болж, ОХУ болон барууны орнуудын зөрчилдөөн гүнзгийрч, тогтворгүй хэвээр байна.

- Тайванийн асуудал: Тайванийн хойгийн хурцадмал байдал нь АНУ, Хятадын хоорондын харилцаа хурцадмал байдал үүсэж цаашид зөрчилдөөнд хүргэх эрсдэлтэй байна.

Терроризм (хэт давар үзэл) - Хэдийгээр терроризмын эрсдэл сүүлийн жилүүдэд буурсан тоон үзүүлэлтүүд байгаа хэдий ч 2024 онд хэт даврууу үзэл дэлхийн зарим бүс нутагт нэмэгдсэн судалгаа гарсан байна.[200]

[198] https://apnews.com/article/sweden-nato-warships-baltic-sabotage-cables-5e47dd20f19da2b5c5e0cccaed71e119

[199] https://www.geopoliticalmonitor.com/backgrounder-natos-pivot-toward-asia/?utm_source=chatgpt.com

[200] https://www.visionofhumanity.org/maps/global-terrorism-index/?utm_source=chatgpt.com#/

- Ойрх Дорнод, Африк: ISIS, Al-Qaeda зэрэг бүлэглэлүүд дахин идэвхжиж, шинэ төрлийн халдлага үйлдэгдэх эрсдэл хэвээр байна.
- Европ: Хэт даврууд үзэл болон дүрвэгсдийн асуудал нь зарим улсуудад улс төрийн тогтворгүй байдлыг үүсгэж байна.[201]

Кибер аюулгүй байдлын сорилтууд - Технологийн хурдацтай хөгжил, хиймэл оюун ухааны өгөгдөл бүхий технологийн өргөн хэрэглээ нь кибер аюулгүй байдалд шинэ төрлийн сорилт, эрсдэлийг бий болгож байна.

- Кибер халдлага: Улс орнуудын дэд бүтэц, төрийн байгууллагууд руу чиглэсэн халдлагууд нэмэгдэж байна.
- Хиймэл оюун ухаан: Хиймэл оюун ухааныг зэвсэглэлд ашиглах нь ёс зүйн болон аюулгүй байдлын сорилтуудыг үүсгэж байна.

Олон улсын хамтын ажиллагаа

НҮБ болон бусад байгууллага - 2024 онд НҮБ болон бусад олон улсын байгууллагуудын үүрэг, оролцоо дэлхийн аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг оролцоотой байсан хэдий ч шийдэгдээгүй асуудлууд хэвээр үлдсээр байна[202].

- НҮБ: Украйны хямрал, Ойрх Дорнодын мөргөлдөөн зэрэг нь тодорхой шийдэлд хүрэхэд ихээхэн хугацаа шаардагдах юм. Мөн цаг уурын өөрчлөлт, дүрвэгсдийн хууль бус шилжилт зэрэг асуудлууд нэмэгдэж байгаа нь НҮБ-ын зэвсэгт мөргөлдөөний хямралыг зохицуулахад саад болж байна.
- НАТО: Одоогоор европын аюулгүй байдлын баталгааг хангаж байгаа цорын ганц байгууллага боловч нөгөөтээгүүр, зүүн Европ дахь цэрэг зэвсэглэлийн эрсдэл бүхий байдлыг шийдвэрлэхэд хүчин чадал, гишүүн орнуудын нэгдмэл байр суурь дутагдалтай байна.

Их гүрнүүд болон глобал тогтворгүй нөхцөл байдал: 2024 онд их гүрнүүдийн хоорондын өрсөлдөөн нь олон улсад тогтворгүй байдлыг бий болгох сөрөг нөлөө үзүүлсэн.

- АНУ ба холбоотнууд: Глобал тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлого чиглэл баримталж байгаа хэдий ч бусад орнуудтай стратегийн өрсөлдөөнд саад болж байна.
- Хятад ба Орос: АНУ болон барууны орнуудаас тусгаарлах стратегийг баримталж, өөрийн холбоотон улсуудын байгууллага болон бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлсээр байна.

Олон улсын аюулгүй байдлын нөхцөл байдалд томоохон өөрчлөлтүүд гарч, дэлхий дахин шинэ төрлийн сорилтуудтай нүүр тулгарлаа. Геополитикийн өрсөлдөөн, шинэ төрлийн аюул занал, олон улсын хамтын ажиллагааны сорилтууд нь дэлхийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна. Эдгээр сорилтуудыг шийдвэрлэхийн тулд олон улсын

[201] https://www.csis.org/analysis/rising-threat-anti-government-domestic-terrorism-what-data-tells-us?utm_source=chatgpt.com

[202] https://apnews.com/article/un-leadership-peace-gaza-ukraine-sudan-biden-7802b51c48347b2004665a6a7725e1dd

хамтын ажиллагааг сайжруулах, шинэ аюул заналхийлэлд тохирсон стратеги боловсруулах шаардлагатай юм.

Бүс нутгийн аюулгүй байдлын сорилтууд - 2024 онд бүс нутгийн аюулгүй байдал томоохон сорилттой тулгарч байна. Геополитикийн өрсөлдөөн өсөн нэмэгдсээр байгаа нь Европ, Ази-Номхон далайн бүс нутаг дахь шинэ нөхцөл байдал сорилтуудтай тулгарахад хүргэж байна. Олон улсад эдийн засаг, улс төрийн харилцаанд томоохон өөрчлөлтүүд гарч, бүс нутгийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж буй нөхцөл байдлуудыг авч үзэх шаардлагатай.

Украйны хямрал ба ОХУ - Барууны орнуудын харилцаа

Украйны хямрал нь Европын аюулгүй байдал, улс төрийн дотоод засаглалыг өөрчлөх, зарим улс орнуудын сонгуулийн үр дүнд хүчтэй нөлөөлж чадсан гэж үзэж байна. Хамгийн том шилжилт нь эрчим хүчний салбарт гарсан ба европын улс орнуудын эрчим хүчний тогтвортой байдалд томоохон сорилт үүсгээд байгаа юм. 2022 онд ОХУ-ын эхлүүлсэн цэргийн тусгай ажиллагаагаа нь өдгөө гуравдах жилдээ дамнан үргэлжилж, барууны улс орнууд Украйн улсад үзүүлэх зэвсэг техник, санхүүгийн тусламж үргэлжилсээр байгаа нь уг хямрал зэвсэгт мөргөлдөөний тэнцвэрт байдлыг хадгалах нөхцөл болж олон улсын тавцанд анхаарлын төвд оршсоор байна.

- Хямралын нөлөө: Украйны хямрал нь Европын орнуудын эрчим хүчний аюулгүй байдалд шууд утгаараа сөрөг нөлөө үзүүлсэн. Оросоос хараат байдлаа багасгахын тулд Европын холбоо сэргээгдэх эрчим хүч болон АНУ-аас шингэрүүлсэн байгалийн хий худалдан авах зэрэг хараат байдлаа хадгалах бодлого барих болсон.
- Барууны хориг арга хэмжээ: Оросын эсрэг эдийн засгийн хориг арга хэмжээнүүд нь дэлхийн эрчим хүчний үнэ өсөхөд нөлөөлж, Европын эдийн засгийн өсөлтийг удаашруулахад нөлөөлж байна.

НАТО, бүс нутагт үзүүлэх нөлөө

НАТО-гийн зүүн Европт хэрэгжүүлж буй бодлого, нөлөөлөл нэмэгдэх нь ОХУ-ын эсэргүүцлийг улам бүр өдөөж болзошгүй байна. Финланд болон Швед улсууд 2024 онд НАТО-ийн гишүүнчлэлээ баталгаажуулсан нь явдал нь Европын аюулгүй байдлын орчныг шинээр бүрэлдүүлэн бий болгох тэнцвэрийг өөрчилж болзошгүй юм.

- ОХУ-ын арга хэмжээ: Орос улс НАТО-гийн зүгээс ирж буй дарамтыг эсэргүүцэн зэвсэглэлээр хөөцөлдөх, батлан хамгаалах салбартаа зарцуулах зардлаа эрс

нэмэгдүүлж, зүүн Европ дахь цэргийн хүчин чадлаа ахиулах бодлого барьсаар байна.

- Европын аюулгүй байдлын хэтийн төлөв: НАТО-гийн тэлэлт нь Европын орнуудын аюулгүй байдалд тодорхой хэмжээний баталгаа болж байгаа ч ОХУ-ын зүгээс хариу арга хэмжээ, шинээр үүсэж болзошгүй зэвсэгт мөргөлдөөн эрсдэлүүдийг дагуулж байна.

Ази, Номхон далайн бүс нутгийн сорилтууд:

Тайванийн хойгийн асуудал АНУ, Хятад хоорондын гол үл ойлголцол болж, Ази-Номхон далайн бүс нутгийн тогтвортой байдалд нөлөөлж, хурцадмал нөхцөл байдал үүсгэж болзошгүй юм. Хятад улс Тайвань улсыг өөрийн нутаг дэвсгэр гэж үзэж байгаа бол АНУ Тайвань улсыг дэмжсээр цаашид тус бүс нутагт өөрийн гол холбоотнуудын нэг гэж үзэж байна.

- Хятадын байр суурь: Хятад улс Тайванийн эргэн тойронд цэргийн сургуулилтуудыг идэвхжүүлж, Тайвань улсыг цэргийн хүчээр нэгтгэх боломж оршсоор байгаа бөгөөд ирээдүйд зөвхөн өөрийн нөлөө тодорхой хязгаарлалтад байлгах нь тус улсын ашиг сонирхолд нийцэж байгаа юм.[203]
- АНУ-ын байр суурь: АНУ нь Тайванийн батлан хамгаалахын чадавхыг нэмэгдүүлэн бэхжүүлэхэд гол дэмжлэг үзүүлж буй улс бөгөөд энэ нь Хятад улстай шууд мөргөлдөөн үүсгэх, үл ойлголцол бүхий эрсдэлтэй нөхцөл байдлыг улам гүнзгийрүүлж болзошгүй юм.

Өмнөд Хятадын тэнгис дэх маргаан - Өмнөд Хятадын тэнгис нь стратегийн чухал ач холбогдолтой бүс нутаг бөгөөд энэхүү усан замаар дэлхийн худалдааны ихэнх тээвэр дамжин өнгөрдөг. Хятад улс энэхүү бүс нутгийг өөрийн хяналтаа хэвээр үлдээх цаашид улам бүр бэхжүүлэхийг эрмэлзэж, хиймэл арлууд бий болгон цэрэг техникийн зориулалтаар ашиглаж байна. Тэгвэл уг нөхцөл байдлын эсрэг бүс нутгийн улс орнууд хариу арга хэмжээ авч болзошгүй юм. Тодруулбал, АНУ болон бүс нутгийн зарим холбоотнууд Өмнөд Хятадын тэнгис дэх Хятадын үйл ажиллагааг шүүмжилж, тэнгисийн зам тээврийг чөлөөтэй байлгах шаардлага гаргаж мэдэгдсээр байгаа юм. Мөн түүнчлэн бүс нутгийн тогтворгүй байдалд нөлөөлөхүйц тус маргаан нь зөвхөн Хятад, АНУ-ын хооронд бус, мөн Вьетнам, Филиппин, Малайз зэрэг бүс нутгийн бусад

[203] https://globaltaiwan.org/2024/10/chinas-military-exercises-around-taiwan-trends-and-patterns/

орнуудыг татан оролцуулах, цаашид уг асуудал даамжрахаас сэргийлэх зуучлалын арга хэмжээ үгүйлэгдэж байна.

БНСУ, БНАСАУ-ын харилцаа, хойгийн тогтворгүй байдал

Солонгосын хойгийн тогтворгүй байдал 2024 онд ч олон улсын харилцаа дахь асуудал хэвээр үлдэж байна. БНАСАУ өнгөрсөн онд алсын зайны пуужин, мөн цөмийн зэвсгийн туршилтаа удаа дараалан хийж идэвхжүүлсээр байгаа нь БНСУ болон АНУ-тай хурцадмал харилцааг үргэлжлүүлсээр байна. БНАСАУ-ын цөмийн хөтөлбөр улс төр болон эдийн засгийн агуулгаар улам өргөжиж байна гэсэн дүгнэлт хийх болсон нь ОХУ-тай хийж буй харилцаа хамтын ажиллагаатай холбон тайлбарлах болсон. Хойд Солонгосын зүгээс цөмийн зэвсэглэлээ өргөжүүлж, шинэ пуужингийн туршилтуудыг явуулж байгаа нь БНСУ төдийгүй Япон АНУ-ын өмнө сорилтуудыг бий болгож байна. Мөн БНСУ АНУ-д нь хариу арга хэмжээ авах нь тодорхойгүй байгаа бөгөөд, БНАСАУ-ын цөмийн бодлогыг сөрөн зогсох бүс нутагт хоёр улсын хамтарсан цэргийн сургуулилтуудаа нэмэгдүүлэх чиглэл баримталж байна.[204]

Нөлөөлж буй хүчин зүйлс

Олон улсын аюулгүй байдал зөвхөн геополитикийн болон цэргийн асуудлаар хязгаарлагдахгүй бөгөөд экологийн өөрчлөлт, эдийн засгийн тогтворгүй байдал, технологийн шинэ аюул зэрэг шинээр бий болж буй уламжлалт бус аюул заналын агуулгаар нэмэгдсээр байна. Эдгээр нь улс орны тогтворгүй байдалд шууд нөлөөлж, дэлхийн аюулгүй байдлын нөхцөл байдлыг улам бүр төвөгтэй шинэ сорилтуудыг бий болгож байна.

Байгалийн гамшиг, цаг уурын өөрчлөлтөөс үүдэлтэй дүрвэгсдийн асуудал

Цаг уурын өөрчлөлт нь дэлхий нийт бүхэлдээ тулгарч буй том сорилтуудын нэг болоод байна. Зөвхөн 2024 оны байдлаар байгалийн гамшигт үзэгдлийн тоо нэмэгдсэн, дэлхийн өнцөг булан бүрд үер ус болон газар хөдлөлтийн давтамж эрх нэмэгдсэн нь хор хөнөөл эдийн засагт учруулж буй дарамтыг нэмэгдүүлсээр байна. Үер, ган, хэт халуун, хэт хүйтэн зэрэг цаг уурын хэт өөрчлөлтүүд нь хүн амын нүүлгэн шилжүүлэлт, дүрвэгсдийн тоонд шууд нөлөөлж, "цаг уурын дүрвэгсэд" гэх шинэ нэр томьёё үзэгдлийг бий болгож байна. Үүний үр дүнд 2024 онд байгалийн гамшигт үзэгдэл хэд дахин давтагдаж, олон сая хүн орон гэрээ орхиход хүрсэн НҮБ-ийн тоо баримтууд нотолж байна. Үүнтэй холбоотойгоор хүнсний хомсдол, эдийн засгийн дарамт, дүрвэгсдийн асуудал зэрэг олон талын аюул сорилтуудыг үүсгэсэн. Африкийн Сахарийн бүс нутаг, Зүүн Өмнөд Ази, Номхон далайн арлын орнууд байгалийн гамшгаас хамгийн их хохирол амсаж байна.[205]

Ус, хүнсний аюулгүй байдал

Цаг уурын өөрчлөлтөөс үүдэн ус, хүнсний хангамжийн асуудал дэлхий дахинд хурцаар тавигдаж байна. Цаг агаарын хэт халалт, ган, үерийн давтамж нэмэгдсэн нь газар

[204] https://www.icanw.org/nuclear_tensions_rise_on_korean_peninsula

[205] https://www.iom.int/news/conflict-drives-displacement-amidst-rising-climate-shocks-new-africa-migration-report?utm_source=chatgpt.com

тариалангийн үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлж, хүнсний хангамжийн хүртээмжтэй байдлыг тасалдуулахад хүргэж байна. Энэ нь нэн тэргүүнд усны хомсдолд ихээхэн нөлөөлж дэлхийн бүс нутагт, ялангуяа Африк, Ойрх Дорнодод усны хангамжийн асуудал хурцаар яригдах болж улс хоорондын маргаан дагуулж байна. Мөн түүнчлэн хүнсний хямралаас үүдэлтэй зөрчил мөргөлдөөн, эдийн засгийн хямралаас шалтгаалан дэлхийн хүнсний хангамжийн тогтвортой байдал алдагдахад хүргэж байна.

Эдийн засгийн тогтворгүй байдал

Эдийн засгийн нөхцөл байдалд эрсдэл дагуулсан гол хүчин зүйл нь санхүүгийн тогтворгүй байдал. Энэ нь глобал санхүүгийн зах зээл дээрх хямрал болон олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлөхөд хүргэж байна. Хямралын шалтгааныг тодруулбал, улс хоорондын геополитикийн өрсөлдөөн, эрчим хүчний үнийн өсөлт, хөгжиж буй орнуудын өрийн дарамт нэмэгдсэн нь эдийн засгийн тогтворгүй байдлын үндсэн шалтгаан болж байна гэж үзжээ. Үүний үрд дүнд санхүүгийн хямрал нь хөгжиж буй орнуудын эдийн засагт хүнд цохилт болж, ажилгүйдэл нэмэгдэж, ядуурал ихэссэн гэж НҮБ-ын хөгжлийн индексийн тайланд мэдээлсэн байна.

Эрчим хүчний хангамжийн аюулгүй байдал

Эрчим хүчтэй холбоотой асуудлууд олон улсын аюулгүй байдалд чухал сорилт болж байна. Европ дахь эрчим хүчний хямрал, Орос-Баруун Европын харилцааны хурцадмал байдал зэрэг хүчин зүйлс нь эрчим хүчний аюулгүй байдлыг тодорхойгүй нөхцөлд хүргэсэн. Тэгвэл сүүлийн 3 жил **с**эргээгдэх эрчим хүчний эх үүсвэл хүчтэй яригдах болсон бөгөөд дэлхий нийтээр өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэглээг хангах чадах гарц болж байна. Дэлхийн эрчим хүчний хэрэглээний ихэнх хувийг нефть, байгалийн хий эзэлж байгаа нь ойрын хугацаанд сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх боломж бага, эрсдэл дагуулсаар байна. Эрчим хүчний өрсөлдөөн, хэрэглээ нэмэгдэж байгаа нь ОХУ-ын эрчим хүч нийлүүлэх бодлого, бололцооноос шууд хараат нөхцөл байдал үүсгээд байсан юм. Энэ нь европын орнууд өөр эх үүсвэр хайх шаардлага хэрэгцээг бий болгосон бөгөөд эрчим хүчний шинэ зах зээлийн зохион байгуулалтыг бий болгож байна.

Кибер халдлага, мэдээллийн аюулгүй байдал

Кибер аюулгүй байдал улс орнуудын дотоод гадаад аюулгүй байдлыг хамгаалах салшгүй хэсэг болсон. Гэтэл техник технологийн хөгжил нэмэгдэхийн хэрээр кибер халдлагын тоо үүнтэй адилаар эрс нэмэгдэх болсон нь кибер аюулгүй байдлын хамгаалалт хөгжил хангалттай бус байгааг илтгэж байна. Мэдээж үүнд улс орнуудын харилцан адилгүй дэд бүтэц, төрийн мэдээллийн системийн хөгжил нөлөөлж байна. Үүнтэй холбоотойгоор цахим валютын хэрэглээ нэмэгдэж үүнийг дагасан санхүүгийн байгууллагууд руу чиглэсэн халдлагууд ихээхэн хохирол учруулах болсон. Мөн түүнчлэн эрчим хүчний дэд бүтэц рүү чиглэсэн кибер халдлагууд ихээр үйлдэгдэх болж, төрийн мэдээллийг алдагдуулах төлбөртэй даркнет ашиглан худалдан борлуулах оролдлогууд ч гарсаар байгаа юм. Уг асуудлын шийдлийг улс орнууд өөр өөрөөр харж

шийдэх оролдлогууд хэрэгжүүлсээр байгаа боловч кибер аюулгүй байдлын бодлогоо шинэчлэхгүйгээр, олон улсын хамтын ажиллагааг идэвхжүүлэхгүйгээр бүрэн шийдэгдэх боломжгүй юм.

Хиймэл оюун ухааны хөгжлийн эрсдэл

Хиймэл оюун ухаан (Artificial intelligence AI)-ы хурдацтай хөгжил нь аюулгүй байдалд шинэ төрлийн эрсдэлүүдийг үүсгэж болзошгүй гэж мэргэжилтнүүд олноор мэдэгдэж байсан. Орчин цагт хиймэл оюун ухааныг зэвсэгт мөргөлдөөнд ашиглах, энэ төрлийн судалгааг гүнзгийрүүлж байгаа нь ирээдүйд ямар үр дүнд хүргэж болохыг таамаглах араггүй юм. Мөн хиймэл оюун ухааныг ашиглахад олон талын ёс зүйн асуудлууд болон хяналтын зохицуулалтгүй байдал зэрэг нь сөргөөр нөлөөлж байна. Тэгвэл зэвсэгт мөргөлдөөнд хиймэл оюун ухааныг түлхүү ашиглах нь ирээдүйд тодорхойгүй байдлыг нэмэгдүүлж, дайн мөргөлдөөнийг хурцатгах магадлалыг бий болгож байна. Үүний эсрэг улс орнууд хиймэл оюун ухааны хөгжлийг зохицуулах олон улсын гэрээ хэлэлцээр байгуулах шаардлагатай байна.

Сорилтуудыг даван туулах арга зам, шийдлүүд

Олон улсын аюулгүй байдалд тулгарч буй сорилтууд нь өргөн цар хүрээтэй бөгөөд дэлхийн улс орнууд хамтын ажиллагааг эрчимжүүлж, шинэ стратеги боловсруулах шаардлагатай юм. Геополитикийн өрсөлдөөн, кибер аюулгүй байдал, терроризм, байгалийн гамшиг зэрэг асуудлууд нь олон улсын хамтын нийгэмлэгийн хариу арга хэмжээ, зохицуулалтыг нэмэгдүүлсэн арга хэмжээг шаарддаг байна.

Олон улсын хамтын ажиллагааг эрчимжүүлснээр НҮБ болон бусад олон улсын байгууллагууд дэлхийн энх тайван, тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг хүлээх бөгөөд тэдний хамтын ажиллагаа, бусад улс орнуудад нөөлөх нөлөө, үр дүнг сайжруулах шаардлагатай байгаа юм. НҮБ нь дэлхийн энх тайвныг сахин хамгаалахаас гадна, байгаль орчин, хүний эрх, эдийн засгийн асуудалд ч анхаарлаа хандуулах шаардлагатай байна. Мөн Аюулгүйн зөвлөлийн бүтэц, ажиллагааг шинэчлэх замаар олон улсын хамтын нийгэмлэгийн гишүүдийн дуу хоолойг тэнцвэртэй тусгах нэн түрүүний хэрэгцээ шаардлага байна.

Дэлхийн түвшинд үүсэж буй сорилтуудыг даван туулах хариу арга хэмжээ авах нь олон улсын гэрээ конвенцийг шинэчлэх замаар, зохицуулалтыг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна. Иймд олон улсын экологийн гэрээгээр зохицуулагддаг цаг уурын өөрчлөлттэй тэмцэх, Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх, илүү хатуу зохицуулалт, хяналт бий болгох хэрэгтэй юм. Кибер аюулгүй байдлын гэрээний хүрээнд улс орнууд кибер халдлагын эсрэг хяналт, хариуцлага бий болгоход чиглэсэн олон улсын гэрээ байгуулах шаардлагатай.

Кибер аюулгүй байдалд чиглэсэн хамтын ажиллагаа

Кибер аюулгүй байдал нь орчин үеийн хамгийн том сорилтуудын нэг болж байна.

- Олон улсын хамтын ажиллагаа: Улс орнуудын хооронд мэдээлэл хуваалцах, технологийн дэмжлэг үзүүлэх механизм бий болгох. Жишээлбэл, Европын холбооны "Cybersecurity Act" хөтөлбөр нь бусад бүс нутгуудад үлгэр жишээ болно.
- Кибер хөтөлбөрүүд: Улс орнууд хамтран кибер аюулгүй байдлын салбарт ажиллах мэргэжилтнүүдийг бэлтгэх, чадавхыг нэмэгдүүлэх хэрэгтэй.

Терроризмтой тэмцэх

Терроризм нь олон улсын аюулгүй байдалд байнга заналхийлэл учруулж байгаа бөгөөд үүнийг хянахын тулд дэлхий дахинаа хамтран ажиллах, хамтын хүчээр хариу арга хэмжээг урьдчилан авах шаардлагатай байна. Гол асуудлын нэг нь терроризмын санхүүжилтийг таслан зогсоох бөгөөд олон улсад хяналтын нэгдсэн механизм бий болгох гэж үзэж байна. Үүний сацуу олон талт ажиллагааг эрчимжүүлж, террорист бүлэглэлүүдийн эсрэг тагнуулын мэдээлэл солилцох, хамтарсан цэргийн ажиллагаа явуулах юм.

Ази, Европ, Африкийн аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн хамтын арга хэмжээ

Бүс нутгийн аюулгүй байдлыг хангахын тулд орон нутгийн болон олон улсын хэмжээнд хамтран ажиллах нь олон улсын аюулгүй байдлын байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх замаар эрчимжих болно. Жишээлбэл, европын аюулгүй байдлыг хангах нь зөвхөн тус бүс нутгийн асуудал биш бөгөөд Украйны хямралыг зохицуулах олон улсын механизм бий болгох, талуудыг яриа хэлэлцээнд уриалах төдий арга хэмжээ хангалтгүй юм. Тухайлбал Африкийн тогтворгүй байдал нь ихэнхдээ эдийн засгийн агуулгатай холбогддог хэдий ч Африкийн холбоо болон НҮБ хамтран эдийн засгийн дэмжлэг үзүүлэх, дотоод зөрчилдөөнийг зохицуулах замаар шийдвэрлэх бүрэн боломжтой юм.[206],[207]

Тайванийн асуудлаар гүрнүүдийн хооронд хэлэлцээрийн механизм бий болгох

Тайванийн асуудал нь АНУ, Хятадын хоорондын зөрчилдөөнийг хурцатгаж байгаа нь бүс нутгийн байгууллагын оролцоотой шийдэгдэх асуудал хэдийнээ биш болсон. Тэгвэл уг асуудлыг намжаан зохицуулахад олон улсын оролцоотой хэлэлцээрийн механизм зайлшгүй шаардлагатай байна. Тайванийн асуудлыг энхийн замаар шийдвэрлэх, БНХАУ-Тайвань хооронд яриа хэлэлцээ хийх механизмыг дэмжих манлайлал дутмаг байна. Хэдийгээр бүс нутгийн эвсэл уг механизмыг бий болгох бүрэн боломж байгаа хэдий ч Ази-Номхон далайн бүс нутгийн улс орнууд Тайванийн хоолой дахь тогтворгүй байдлыг намжаах оролдлого санаачилга хангалтгүй байна.

Дүгнэлт

1. Олон улс аюулгүй байдлын олон сорилтуудыг даван туулахын тулд нэн тэргүүнд улс орнуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэн өргөжүүлэх, шинэ аюул заналхийлэлд

[206] https://www.consilium.europa.eu/en/policies/eu-response-russia-military-aggression-against-ukraine/
[207] https://press.un.org/en/2024/sc15706.doc.htm

тохирсон стратеги боловсруулах, бүс нутгийн түвшинд идэвхтэй арга хэмжээ авах шаардлагатай байна. Мөн урт хугацааны тогтвортой хөгжлийн бодлого хэрэгжүүлэх замаар дэлхийн аюулгүй байдал, тогтвортой байдлыг хангах механизм бий болгох юм. Энэхүү арга зам, шийдлүүдийн үр дүнд улс орнуудын хоорондын итгэлцэл, хамтын ажиллагаа, дэлхийн энх тайван, тогтвортой байдлыг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх юм.

2. Европ, Ази-Номхон далайн бүс нутгуудын аюулгүй байдалд тулгарч буй сорилтууд нь дэлхийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байгаа бөгөөд Украйны хямрал, НАТО-гийн гишүүн орнуудын тоо нэмэгдсэн, Тайванийн асуудал, Өмнөд Хятадын тэнгис дэх маргаан, Солонгосын хойгийн тогтворгүй байдал зэрэг нь дэлхийн их гүрнүүдийн ашиг сонирхлын огтлолцол шууд оршиж байгаагийн илэрхийлэл болж байна. Эгээр сорилтуудыг даван туулахын тулд бүс нутгийн болон олон улсын хамтын ажиллагааг идэвхжүүлж, зөвхөн яриа хэлэлцээр дипломат аргаар тогтвортой байдлыг хангах стратегийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

3. Геополитикийн өрсөлдөөн, цаг уурын өөрчлөлт, кибер аюул зэрэг шинэ сорилтууд нь улс орнуудыг хамтын ажиллагааг эрчимжүүлэх, дэлхий нийтийн нэгдмэл байдлыг хангах шаардлагыг тулгаж байна.

4. Олон улсын аюулгүй байдалд цаг уурын өөрчлөлт, эдийн засгийн тогтворгүй байдал, технологийн шинэ аюул зэрэг хүчин зүйлс ихээхэн нөлөөлж байгаа нь байгалийн гамшиг, хүнсний хомсдол, кибер халдлага зэрэг нь шинэ сорилтуудын эх сурвалж болж байна. Улмаар эдийн засгийн хямрал, эрчим хүчний хомсдолоос үүдэлтэй улс хоорондын харилцааг улам төвөгтэй болгож байна.

Эдгээр асуудлыг шийдвэрлэхэд олон улсын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, тогтвортой хөгжлийн бодлого хэрэгжүүлэх, шинэ аюулд тохирсон зохицуулалтыг боловсруулах шаардлагатай байна. Энэ бүхэн нь дэлхийн аюулгүй байдлыг хангахад чухал хувь нэмэр оруулах юм.

SPSIRPA FORUM 2025

Session 5-4

Tourism Trade between China and Mongolia under the Production of New Technology: Opportunities and Challenges

Орчин үеийн шинэ чанарын үйлдвэрлэлийн хүч ба Хятад-Монголын аялал жуулчлалын худалдаа: Боломж ба сорилтууд

Өвөр Монголын Их Сургуулийн Монгол улс судлах хүрээлэн Altan

Хураангуй : Дэлхийн эдийн засгийн дижитал хувирал, технологийн инновацийн хурдацтай хөгжилтэй холбоотойгоор үйлдвэрлэлийн шинэ чанарын хүч (шинэ чанарын үйлдвэрлэлийн хүч) нь үйлдвэрлэлийн хүчний чанарын шинэчлэл болон дэлхийн эдийн засгийн бүтцийг гүнзгий өөрчлөхөд нөлөөлж байна. Хятад-Монголын хоёр улс сүүлийн жилүүдэд аялал жуулчлалын салбарт улам бүр нягт хамтын ажиллагааг эрхэмлэж, шинэ чанарын үйлдвэрлэлийн хүч энэ хамтын ажиллагаанд шинэ эрч хүч нэмж байна. Энэхүү өгүүлэл нь "Орчин үеийн шинэ чанарын үйлдвэрлэлийн хүч ба Хятад-Монголын аялал жуулчлалын худалдаа: Боломж ба сорилтууд" сэдвээр шинэ чанарын үйлдвэрлэлийн хүч Хятад-Монголын аялал жуулчлалын салбарт үзүүлэх нөлөө, түүний авчирч буй боломж, сорилтуудыг шинжлэн харгалзах бодлогын санал дэвшүүлсэн байна.Үндсэн агуулга:Шинэ чанарын үйлдвэрлэлийн хүчний үндсэн ойлголт ба орчин үеийн эдийн засагт эзлэх байр суурь: Шинэ чанарын үйлдвэрлэлийн хүч нь зөвхөн AI, big data, blockchain зэрэг технологийн хэрэглээг хамардаггүй бөгөөд үйлдвэрлэлийн арга барилын үндсэн өөрчлөлтийг илэрхийлнэ. Аялал жуулчлалын салбарт энэ нь ухаалаг үйлчилгээ, дижитал менежмент, ногоон технологийн өргөн хэрэглээгээр илэрч, тухайн салбарын экосистемийг шинэчлэхэд хувь нэмэр оруулж байна.Хятад-Монголын аялал жуулчлалын салбарын өнөөгийн нөхцөл байдал: Хоёр улс газарзүй, соёлын ойр дотно холбоотойгоор аялал жуулчлалын худалдааны давуу талтай боловч дэд бүтцийн хомсдол, үйлчилгээний чанарын тогтворгүй байдал, соёлын ялгаа зэрэг асуудлууд хамтын ажиллагааг хязгаарлаж байна.Шинэ чанарын үйлдвэрлэлийн хүчний нөлөөллийн шинжилгээ:Технологийн инноваци (жишээ нь: ухаалаг жуулчны систем, mobile payment) нь жуулчдын туршлагыг сайжруулж, Дижитал менежмент (big data шинжилгээ, ухаалаг аялал жуулчлалын платформ) нь нөөцийн зардлыг оновчтой болгож, Ногоон технологи (экологийн аялал, бага нүүрстөрөгчийн хэвлэл) нь байгаль орчинд үзүүлэх дарамтыг бууруулж байна.Сорилт ба бодлогын санал:Технологийн зөрүү, байгаль орчны дарамт, соёлын зөрчил зэрэг асуудлуудыг хоёр улс хамтдаа шийдвэрлэхийн тулд технологийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, дэд бүтцийг сайжруулах, ногоон хөгжилд дэмжлэг үзүүлэх, соёлын харилцааг гүнзгийрүүлэх зэрэг саналуудыг дэвшүүлсэн байна. Дүгнэлт: Шинэ чанарын үйлдвэрлэлийн хүч нь Хятад-Монголын аялал жуулчлалын салбарт шинэ боломжуудыг бий болгож, улс хоорондын эдийн засгийн хамтын ажиллагаанд динамик хүч нэмж байна. Энэхүү судалгаа нь онолын дэмжлэг үзүүлэхээс гадна хоёр улсын аялал жуулчлалын бодит хамтын ажиллагаанд практик удирдамж өгөх зорилготой.

Түлхүүр үгс : Шинэ чанарын үйлдвэрлэлийн хүч, Хятад-Монголын аялал жуулчлалын худалдаа, Тогтвортой хөгжил

Modern New Qualitative Productive Forces and China-Mongolia Tourism Trade: Opportunities and Challenges

Center for Studies of Mongolia, Inner Mongolia University Altan

Regional collaboration on SDGs through transboundary environmental initiatives, trade corridors, and educational exchanges presents an opportunity to build peace and prosperity in Northeast Asia. Mongolia's One Billion Trees Initiative, for example, has been recognized for its potential impact on cross-border dust and sandstorm mitigation, a shared concern with China and Korea. Similarly, Mongolia's renewable energy projects, if connected regionally, could contribute to a broader Northeast Asian supergrid that enhances energy security and reduces carbon footprints across borders.

Moreover, regional forums such as the Northeast Asia Sustainable Development Forum and trilateral dialogues among Mongolia, China, and Russia provide platforms for policy harmonization, technology exchange, and joint project financing. In this context, PPPs can serve not only as domestic development tools but as regional peacebuilding mechanisms that foster interdependence and mutual benefit.

CONCLUSION

In conclusion, Mongolia's commitment to achieving the SDGs through PPP reflects a strategic alignment with global sustainability frameworks, particularly in addressing its unique challenges. The country's legal and institutional frameworks, such as the 2009 PPP Law and the Public-Private Partnership Center, provide a solid foundation for facilitating collaboration between the public and private sectors. Through initiatives like the Salkhit Wind Farm, the New Ulaanbaatar International Airport, and the CHP-5 project, Mongolia has demonstrated the potential of PPPs to bridge infrastructure gaps, enhance service delivery, and support sustainable growth.

Despite challenges such as economic volatility and limited experience in managing complex contracts, Mongolia's ongoing efforts to promote PPPs hold significant promise. These collaborations not only contribute to national development but also foster regional cooperation, particularly in Northeast Asia, where Mongolia's projects, such as the One Billion Trees Initiative and renewable energy ventures, can drive cross-border benefits. As the country continues to refine its PPP framework and expand its partnerships, Mongolia is poised to make meaningful progress toward its SDG targets while strengthening its position within the broader regional and global context.

REFERENCES

Amref Health Africa. (2022). Public-private partnerships for health: Strengthening maternal and child healthcare in Kenya. https://amref.org

Asian Development Bank (ADB). (2020). Public–private partnership monitor: India. https://www.adb.org/documents/public-private-partnership-monitor-india

Asian Development Bank (ADB). (2024). Public-private partnerships in Mongolia: Recent developments and opportunities. https://www.adb.org

Clean Energy LLC. (2014). Salkhit Wind Farm project overview. https://cleanenergy.mn/projects/salkhit-wind-farm

Department for Transport, Government of India. (2018). National Highways Development Project overview. https://morth.nic.in

DNN.mn. (2025, May 1). М.Амгаланбаатар: Хувийн хэвшил төрийг бодвол хурдан шуурхай, чанартай, менежментийн хувьд дэвшилтэй. DNN.mn. https://dnn.mn/news/316032

European Bank for Reconstruction and Development (EBRD). (2014). EBRD's first wind power project in Mongolia wins US Treasury Impact Honors Award. https://www.ebrd.com/news/2014/ebrd-backed-wind-power-project-in-mongolia-wins-award.html

Government of Mongolia. (2016). Sustainable Development Vision 2030. Ulaanbaatar: Parliament of Mongolia.

Government of Mongolia. (2020). Vision 2050: Long-term development policy of Mongolia. Ulaanbaatar: State Great Khural

Government of Mongolia. (2024). Law on Public-Private Partnership. https://legalinfo.mn

Japan International Cooperation Agency (JICA). (2021). New Ulaanbaatar International Airport opened under public-private partnership. https://www.jica.go.jp/english/news/press/2021/20210705.html

Manila Water Company, Inc. (2020). Metro Manila water concession: Case study.

Ministry of Economy and Development of Mongolia. (2022). New Recovery Policy.

Ministry of Road and Transport Development of Mongolia. (2021). Opening of Chinggis Khaan International Airport. https://mrtd.gov.mn/news/view/309

Ministry of Road and Transport Development of Mongolia. (2024). Concession tenders for regional airport upgrades. https://mrtd.gov.mn

Mongolian National Forest Agency. (2024). PPP Forest project in Gorkhi-Terelj launched. https://forest.gov.mn

Stockholm Resilience Centre. (2016, June 14). The SDGs wedding cake. https://www.stockholmresilience.org/research/research-news/2016-06-14-the-sdgs-wedding-cake.html

UB Post. (2014, June 5). Government signs concession agreement for CHP-5 plant. The UB Post. https://theubpost.mn/2014/06/05/government-signs-concession-agreement-for-chp-5-plant/

Ulaanbaatar City Mayor's Office. (2024). Waste-to-energy PPP initiative launched to modernize landfill infrastructure.

United Nations. (2015, September 25). General Assembly adopts 2030 Agenda for Sustainable Development [Press release]. https://press.un.org/en/2015/ga11688.doc.htm

United Nations. (2015). Transforming our world: The 2030 agenda for sustainable development. https://sdgs.un.org/2030agenda

World Bank. (2023). Innovative wastewater reuse in Ulaanbaatar: Circular economy pilot with Coca-Cola. https://www.worldbank.org/en/country/mongolia

SPSIRPA FORUM 2025

Session 5-11

China's Conception of Hierarchical World Order and the Balance of Relations

CHINA'S CONCEPTION OF A HIERARCHICAL WORLD ORDER AND THE BALANCE OF RELATIONS

Дэлхийн шатлалт дэг журмын талаарх Хятадын үзэл ойлголт ба харилцааны тэнцвэрийн асуудалд

Г.Баасанхүү

Abstract: The philosophical interpretation of international order in Chinese political thought has a history spanning thousands of years. As China rises as a global power, its scholars and policymakers have developed theories that diverge from Western perspectives, incorporating Chinese national characteristics and traditional philosophy. The concept of Tianxia (All Under Heaven), Yang Xuetong's moral realism, and other theoretical frameworks have gained international recognition as distinctly Chinese interpretations of global order.

This paper examines how China's historical vision of a hierarchical world order is reflected in the foreign policy of the modern People's Republic of China (PRC). Specifically, it explores how the balance of relationships is expressed through China's position as the central power in this hierarchical structure, with a focus on its relations with neighboring countries, particularly Mongolia. By comparing Western and Chinese scholarly perspectives, this study evaluates whether China's approach fosters balanced partnerships or reinforces dependency.

A key case study is the Joint Statement on Advancing the Comprehensive Strategic Partnership in a New Era issued during Mongolian President U. Khurelsukh's visit to China on November 28, 2022. This paper critically assesses whether Mongolia-China relations can truly be considered a model partnership between a great power and a small state, or whether Mongolia's growing dependence on China reflects an implicit acceptance of China's hierarchical world order.

SPSIRPA FORUM 2025

Session 6-1

Future Trends in Human Resource Development in the Forestry Sector: A Case Study of Mongolia

МУ-Н ОЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦӨД ТУЛГАМДАЖ БУЙ БЭРХШЭЭЛ, ШИЙДВЭРЛЭХ ЗАРИМ АРГА ЗАМ

Проф.Др. Н.Бурмаа

МУИС-н УТСОУХНУС Нийтийн удирдлагын тэнхим

Удиртгал

Дэлхий нийтийг хамарсан эдийн засгийн хөгжлийн үндэс нь улс орнуудын төрийн болон хувийн хэвшлийн бүхий л байгууллагуудад салбарын мэргэшсэн байдал, хөгжлийн түвшинд хүний нөөцийн бодлогын үр нөлөө хүчтэй нөлөөлөгч хүчин зүйл болохыг нотолсон. Хүний нөөцийн түүх бол хүн төрөлхтний соёл, иргэншил, түүх, уламжлал, зан заншил, хөгжилтэй холбоотой. Нийгмийн шинжлэх ухаанд хүний нөөцийн бодлого, удирдлага хэмээх харьцангуй шинэ шинжлэх ухааны салбар хурдацтайгаар хөгжиж[241] буй билээ.

Ой нь дэлхийн хамгийн үр ашигтай, өгөөжтэй, дахин сэргээгдэх нөөцүүдийн нэг, амьдралыг тэтгэгч экосистем мөн. НҮБ-ын 2017 – 2030 оны ойн талаарх стратегийн төлөвлөгөөнд (UNSPF) бүх төрлийн ой, ойн нөөцийг тогтвортой түвшинд удирдан зохицуулах дэлхий нийтийн бодлого, үйл ажиллагааны цар хүрээ, ой устах, доройтох аюулаас хамгаалах олон талт арга хэмжээг тодорхойлсон[242]. Хүний амьдрал, оршин тогтнохуйд нөлөөлөх ойн ач холбогдол, тогтвортой хөгжлийн зорилт-2030 уг төлөвлөгөөнд мөн адил тусгагдсаны зэрэгцээ дэлхийн хуурай газрын нийт талбайд ойн эзлэх хувь хэмжээг тооцжээ. Дэлхийн хүн амын 25 хувийн амьжиргаа, хөдөлмөр эрхлэлт, өрхийн орлогын эх үүсвэр нь ой түүний баялгаас бүрддэг. (UNSPF p.1-ийг үзнэ үү). Тогтвортой хөгжлийн зорилтуудад "ой" гэсэн тусгай томьёолол бүхий зорилт тусгагдаагүй боловч тус хөтөлбөрийн 15 дугаарт ойн асуудлуудыг өргөн хүрээнд авч үзэн, хүрээлэн буй орчин, нийгэм эдийн засгийн хөгжилд оруулах ойн салбарын ач холбогдлыг тодорхойлж, "экосистемийг бүрдүүлэгч ойг тогтвортой ашиглах, нөхөн сэргээх, ойн зохистой менежментийн үйл ажиллагааг дэмжих, цөлжилт, газрын доройтлыг бууруулах, биологийн олон төрөл зүйл устах аюулаас хамгаалах тухай заасан байна. Түүнчлэн ой, түүний нөөцийн тухай асуудлууд нь тогтвортой хөгжлийн бусад олон зорилтуудад шууд болон урт хугацааны нөлөө үзүүлэхүйц чухал хүчин зүйл болохынх нь хувьд тэдгээрт хамааралтайгаар тусгажээ. Улс орнуудын эдийн засгийн интеграц, экосистемийн үйлчлэлээс хамааран бүс нутгийн хувьд ойн нөөцүүд ялгаатай. НҮБ-ын Европын эдийн засгийн комиссын (UNECE) Нээлттэй ажлын хэсэг 2014 оны долдугаар сард (i) ойн тогтвортой менежмент, (ii) эх газрын экосистемийг хамгаалах, нөхөн сэргээх, дэмжих, (iii) цөлжилттэй тэмцэх, (iv) газрын доройтлыг бууруулах, (v)

[241] (Peter Boxall, John Purcell and Patrick M.Wright 2008)

[242]Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ойн Стратеги Төлөвлөгөө, 2017-2030, p.1 http://www.un.org/esa/forests/wp-content/uploads/ 2016 /12 / UNSPF AdvUnedited.pdf

биологийн олон төрөл зүйлийн алдагдлыг зогсоох зорилго бүхий[243] саналуудыг дэвшүүлсэн байдаг.

Онолын ойлголт

Жон Коммонс (John R. Commons) 1893 онд "Баялгийн хуваарилалт" бүтээлдээ хүний нөөцийн тухай товч дурдсан боловч дэлгэрэнгүй тайлбарлаагүй. 1910-1930-аад оны үед хүн төрөлхтөн бол "үнэ цэнтэй" гэсэн санааг, харин 1950-аад оны эхэн үеэр дуусдаг хөрөнгө мөнгө, арга хэрэгсэл гэх агуулгаар ойлгож байв. Харин Гэри Стэнли Бекер (Gary Stanley Becker) эдийн засгийн шинжлэх ухааны үүднээс хүмүн капитал нь хувь хүний хамгийн чухал хөрөнгө оруулалт-боловсрол хэмээн үзэн хүний зан үйлийн олон төрлийг оновчтой ашиг тусыг хамгийн их байлгах боломжтой гэжээ. [244] 1980-аад оны сүүл үеэс дэлхийн улс орнуудад хүний нөөцийн менежмент хурдацтай хөгжиж буй мэдлэгийн салбар болж хувирчээ. Хүн боловсрол, мэдлэг ур чадвараар гүйцэтгэж буй ажлаа амжилттай болоод ахицгүй хийх тохиолдол одоо ба ирээдүйн бүтээмжид тодорхой хэмжээгээр нөлөөлөх нь зайлшгүй. Аливаа улс орны хөгжил, эдийн засгийн байдал тухайн улсын иргэн бүрээс хамаардаг тул иргэн бүрээ хөгжүүлж, мэдлэг боловсрол эзэмшүүлж, ур чадварыг нь дээшлүүлснээр байгууллага, салбар, улсын хөгжил, эдийн засагт эерэг нөлөөлнө. Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх шаардлага нь:[245]

- ✓ Байгууллагын гүйцэтгэл нь албан хаагчдын ур чадвар, чадамжтай (шуурхай байдал, шинийг санаачлагч, үр дүнд чиглэсэн гэх мэт) шууд холбоотой.
- ✓ Орчин үеийн өрсөлдөөнтэй, хувьсан өөрчлөгдөж буй дэлхий ертөнцөд албан хаагчдын ур чадварыг хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай.
- ✓ Гүйцэтгэлийн үр дүнг нэгжийн (албан хаагчдын) гүйцэтгэлийн зорилтуудтай уялдуулах.
- ✓ Албан хаагчдын ур чадварыг байгууллагын стратеги төлөвлөгөөтэй уялдуулах зэрэг болно.

Хүний нөөцийн бодлогын ойлголтыг албан тушаалын шаардлагад нийцүүлэн хүмүүсийг сонгон авах, сургаж хөгжүүлэх, хүний нөөцийг ашиглаж тогтвортой ажиллуулах, цалин урамшуулал олгох зэрэг төлөвлөгдсөн үйл ажиллагааны нийлбэр цогц[246] хэмээн тодорхойлдог. Энэхүү бодлого нь засгийн газрын стратеги төлөвлөгөө, хөгжлийн бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх, үр дүнтэй, уялдаатай зохион байгуулахад төрийн хүний нөөцийг оновчтой, инновацлаг зохицуулан удирддаг. Хүний нөөцийн удирдлагын зорилго нь салбар, байгууллагыг зорилгодоо хүрэхэд туслах; ажиллах хүчний чадвар ба боломжийг үр дүнтэй ашиглах; ажилтнуудыг зорилгоор бэлтгэх, сургалтад хамруулах, сэдэлжүүлэх; ажилтнуудын ажилдаа хандах сэтгэл ханамжийг өсгөх, өөрийгөө дайчлах, чадварыг нэмэгдүүлэх; ажлын нөхцөлийг сайжруулах; хүний нөөцийн удирдлагын

[243]Тогтвортой хөгжлийн зорилтууд ба ой: НҮБ-ын ЕЭЗК-ийн оролцоо, хэтийн төлөвийн тойм, 2015, х.13

[244] Н.Бурмаа, ба бусад: Төрийн албаны хүний нөөцийн удирдлага. Улаанбаатар 2022. х. 16-18.

[245] http://portal.merit.mn/dataset/db3a55ac-e097-4b82-83e9-0dd4140a706b/resource/26b73e86-7b82-45d3-a8cf-242a1e989896/download/merit_hr_ppt_18283-mon-fwrncc-290319_mn.kp.pdf 2024.04.03.

[246] Н.Отгонбаяр: Төрийн захиргааны шинжлэх ухаан. Улаанбаатар 2019. х.88

бодлогыг бүх ажилтнуудад танилцуулах, ойлгуулах; өөрчлөлтийг удирдах[247] зэргээр тодорхойлжээ.

Ойн салбарын олон улсын туршлагаас

Ойн салбараас хүртэх үр өгөөж нийгмийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад хувь нэмрээ оруулдаг, үүний зэрэгцээ тогтвортой менежменттэй байснаар хүмүүсийн амьдралын чанар нэмэгдэж, ойн нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаалах нөхцөл бүрдэнэ.

Хүснэгт 1. Ойн салбарын ажил эрхлэлт, бүсчлэлээр, 1990-2015 он

Д/д	Бүсчлэл	**1990** Нийт (мянган хүнээр)	**2015** Нийт (мянган хүнээр)	Өөрчлөлт
1	Африк (27 орон)	1740	2030	↑
2	Ази (22 орон)	9948	8511	↓
3	Европ (35 орон)	1036	691	↓
4	Хойд ба Төв Америк (7 орон)	220	189	↓
5	Далайн эргийн (4 орон)	6	9	↑
6	Өмнөд Америк (9 орон)	251	301	↑
7	Нийт (104 орон)	13201	11730	↓

Эх үүсвэр: Global Forest Resources Assessment 2020 – Main report, p.104

Ойн аж ахуй, мод бэлтгэлийн чиглэлээр ажилладаг хүмүүсийн тоо 1990-2015 оны хооронд 1.47 саяар буурчээ. Ажиллагсдын тоо Ази, Европ, хойд болон төв Америкт буурсан бол Африк болон өмнөд Америкт өссөн байна. [248]

Ойн салбарын хүний нөөцийн талаарх мэдээлэл дутмаг байх нь улс орнуудад нийтлэг. Ялангуяа ойн нөөцийн ашиглалтын үзүүлэлтүүдийн тайлан хангалтгүй, ойн ашиглалтад ажиллаж буй хүний нөөцийн мэдээлэл байдаггүй. Ойн салбарын ажил эрхлэлтийн үзүүлэлтүүдийг олон улсын хэмжээнд ойгоос орлого олдог өөр хооронд хамааралтай гурван ангилалд хувааж үздэг[249]. Үүнд ойн салбараас амьжиргаагаа залгуулдаг хүмүүс;

[247] Д.Болормаа, Т.Оюунгэрэл: Хүний нөөцийн удирдлага. Улаанбаатар 2008. х.5-7.

[248] Global Forest Resources Assessment 2020 – Main report, p.104.

[249] See BWI Position Paper - January 2017 "Development of a global core set of forest indicators to support the implementation of the 2030 Agenda on Sustainable Development and the IAF Strategic Plan: Identifying economic and social core indicators for the forestry and forest products workforce in a carbon constrained environment"

орон тооны бус ажил эрхлэлт; ойн салбарын үндсэн (орон тооны) ажиллагсад багтана. Амьжиргааны эх үүсвэр: ойн салбараас амьжиргааны эх үүсвэрээ залгуулдаг хүмүүсийн амьдралд ой ямар үүрэгтэй талаар олон янзын хэлэлцүүлэг байдаг. Ойн нөөцийн ашиглалт баталгаатай амьдралын эх үүсвэр эсвэл ядуурлын шалтгаан болох эсэх? Ойгоос хамааралтай амьдарч буй хүмүүс амьдрах байр сууц, хоол тэжээлийн баталгаа гаргах, соёлын давуу байдлыг ойгоос олж авдаг эсэх? Модыг түлшинд хэрэглэхэд үүсдэг нүүрс хүчлийн хийн ялгарал тогтвортой хэрэглээг илэрхийлж байгаа эсэх? Уугуул иргэдийн соёл иргэншил тогтвортой хөгжлийг хангах эцсийн цэг байх эсэх? Эсвэл соёлын энэхүү онцлог хөгжлийн үйл явцын дунд устаж үгүй болж байгаа эсэх. Орон тооны бус ажил эрхлэлт: орон тооны бус ажиллагсдын талаар зарим маргаантай асуудлууд үүсдэг. Орон тооны бус ажиллагсад ажлын цагийн уян хатан байдал, эрх чөлөөг эрхэмлэдэг эсэх эсвэл тэдгээр ажиллагсад амьжиргааны эх үүсвэрээ арай ядан залгуулдаг эсэх нь сонирхол татсан мэтгэлцээний сэдэв. Зарим экспертүүдийн үзсэнээр орон тооны бус ажиллагсад амьжиргааны доод түвшинд амьдарч байгаа ба энэ байдал ойн салбарт ч мөн түгээмэл ажиглагддаг. Зарим тохиолдолд орон тооны бус ажиллагсдын ажил эрхлэлтийн ангиллыг хөдөлмөрийн хууль тогтоомжоор тусгаж өгөөгүй байна.

Ойн салбарын үндсэн (орон тооны) ажиллагсад: уламжлалт хөгжлийн хөтөлбөрүүдэд ойн салбарын ажил эрхлэлтийн үндсэн хэлбэр болох орон тооны ажил эрхлэлтийг тусгасан. Орон тооны ажиллагсад бусад хэлбэрийн ажиллагсдаас илүү давуу талтай гэсэн таамаглал байна. Гэхдээ бодит байдал дээр үндсэн (орон тооны) ажил эрхлэлтийн давуу эсэхийг нотлох баримт, мэдээ одоогоор алга байна. Олон хүчин зүйлүүдээс шалтгаалж орон тооны ажиллагсад ядуу, амьжиргааны доод түвшинд байх тохиолдол байна. Ажил эрхлэлтийн хэлбэрүүдийн давуу болон сул талыг ажиллагсад ажил эрхлэлтийн нөхцөл байдлыг хэрхэн хянаж байгаагаар тодорхойлно. Тухайлбал, орон тооны (цагаач) ажилчдын паспортыг хураан авах, ажлын цагийн хязгаарлалт тавих, хөдөлмөрийн аюулгүй байдал хангагдаагүй зэрэг тохиолдолд орон тооны ажил эрхлэлт орон тооны бус ажил эрхлэлтээс муу нөхцөлтэй байх талтай. Хувь хүн орон тооны хэлбэрээр ажил эрхлэх эсэх нь дийлэнхдээ тухайн хүний эзэмшсэн боловсрол, хамрагдсан сургалтуудаас шалтгаалдаг. Сургалтаар аливаа хүн мэдлэг чадвараа нэмэгдүүлдэг тул сургалт хүний нөөцийн хөгжлийн гол цөм байна.

Ойн салбарын хүний нөөц – Боловсрол: Хойд Америк, Европ, Ази, Номхон далай, Латин Америкийн олон их дээд сургуулиуд ойн чиглэлээр сургалт явуулж, мэргэжилтэн бэлтгэдэг. Тэдгээрийг эрэмбэлэн жагсаасан дэлхийн түвшний үзүүлэлтүүдээс тэргүүлэх зэргийн 50 их сургуулиудын 20 нь АНУ-д, 19 нь Европт, 3 нь номхон далайн орнуудад, 6 нь Азид, 2 нь Латин Америкт байна. Ойн салбарын мэргэжлийн боловсрол олгох энэхүү үзүүлэлтээр АНУ тэргүүлж байгаа бөгөөд бэлтгэгдэж буй мэргэжилтнүүд нь ойн менежмент, үйлдвэрлэл, ашиглалт, хамгаалалтын чиглэлээр суралцдаг байна.Ойн тогтвортой менежмент (ОТМ) нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн тэнцвэрийг хангахуйц зохицуулалт, үйл ажиллагаа бүхий зорилго, одоо болон ирээдүйн ойн ашиглалт, үйлдвэрлэл, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг түүний нөөцийг хамгаалах урт хугацааны зорилтод тулгуурлан хэрэгжүүлэх тогтвортой менежментийн үзэл

баримтлалууд[250] мөн. ОТМ-ын хүрээнд бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээний тасралтгүй үйл ажиллагаа нь менежментийн зохистой төлөвлөлтөөр хангагдана. 1990-2020 онд тус төлөвлөгөөнд хамрагдсан нийт талбай нэмэгдэж, ойн хамгаалалт ба ашиглалт-д чиглэгдсэн байдаг[251].

Ой мод, түүний нөөцийн нийгэм-эдийн засгийн үр өгөөж нь хүмүүсийн үндсэн хэрэгцээ болох мод, модон эдлэл, бараа, үйлчилгээ, хэрэглээ, ашиглалт, амьдралын чанарыг сайжруулах (өндөр эрэлт хэрэгцээг хангах) хэрэгсэл, ой модны салбараас олох орлого, ажил эрхлэлтийг дэмжиж буй үзүүлэлтүүдээр тодорхойлогдоно[252]. Ойн нийгэм-эдийн засгийн үр өгөөжийг хэмжиж, бодит үнэлгээ гаргахын тулд мэдээллийн нэгдсэн сан чухал бөгөөд энэ нь зөвхөн ойн баялаг, нөөцөд чиглэх бус харин түүний үр шимийг хүртэгч хүмүүст чиглэх ёстой. Өөрөөр хэлбэл, хүний хүнс, хоол тэжээл, эрчим хүч, орон байрны хэрэгцээг хангаж буй байдлаар нь үр өгөөжийг тооцох боломжтой. Хамгийн гол нь ойн үйлдвэрлэл, ашиглалтаас дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг тодорхойлох нь чухал. 2015 онд хийгдсэн дэлхийн ойн нөөцийн үнэлгээгээр хөгжил буурай орнуудын үйлдвэрлэлийн зориулалтаар ашигладаг талбай ойролцоогоор 100 сая га байгаа нь өндөр хөгжилтэй орнуудын зургааны нэгтэй тэнцэж байна.

Зураг 5. Монгол Улсын ойн үйлдвэрлэл, мод бэлтгэлийн хэмжээг бусад орнуудтай харьцуулсан харьцуулалт



Эх сурвалж: БОАЖЯ, Ойн бодлого, зохицуулалтын газрын мэдээлэл, 2016

[250] Дэлхийн ойн нөөцийн үнэлгээ 2015 - Дэлхийн ой хэрхэн өөрчлөгдөж байна вэ?, х.21

[251] Global Forest Resources Assessment 2020 (FRA 2020), p.57. https://www.fao.org/interactive/forest-resources-assessment/2020/en/

[252] Food and Agriculture organization of the UN (FAO), "State of the World's forests: Enhancing the socioeconomic benefits from forests" 2014, p.21

Зураг 6. Монгол Улсын мод бэлтгэлийн хэмжээг бусад орнуудтай харьцуулсан харьцуулалт, 2023 он (сая.м^3)[253]



Эх үүсвэр: ОНТХИ 2023 оны судалгаа

Монгол Улсын ой ашиглалт, үйлдвэрлэлийн түвшин хөрш ОХУ, БНХАУ болон Герман, Швед зэрэг улсуудаас нэлээдгүй хэмжээгээр бага байна. Ойн салбар нь дэлхийн ДНБ-д жил бүр 600 тэрбум ам.долларыг оруулж байгаа нь 0.8% -тай тэнцэнэ[254]. Орлого багатай орнууд дэлхийн ДНБ-ний 4% -тай тэнцэх хэмжээний нэмүү өртгийг ойжуулалт, мод бэлтгэлээс олдог байхад, өндөр орлоготой орнуудын ойн ашиглалтын хувь хэмжээ их боловч дэлхийн ДНБ-д эзэлж буй хувь хэмжээ бага байна. Тэдгээрийн ойн ашиглалт нь эцсийн бүтээгдэхүүн хэлбэрээр гардаг боловч эдийн засгийн цар хүрээнээс хамааран өндөр орлоготой орнуудын ДНБ-д эзлэх хувь харьцангуй бага байна.

МУ-н Ойн салбарын тухай

"Алсын хараа"-2050 хөгжлийн бодлого: Монголын эзэнт гүрний түүх, нүүдэлчин соёл иргэншил, үндэсний давтагдашгүй ижилсэл ба ондоошилд суурилж, дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, олон улсын дэвшилтэт үзэл баримтлалтай хослуулсан “Монголын хөгжлийн загвар” бөгөөд Улсын Их Хурал, Засгийн газраар батлагдан гарсан бодлогын баримт бичгүүдийн үргэлжлэл, бас нэгтгэл юм.

“*Алсын хараа-2050*” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын цөм нь хүний хөгжил бөгөөд 9 зорилго, 47 зорилтоос бүрдэх бөгөөд 2021-2030, 2031-2040, 2041-2050 он гэсэн гурван 10 жилээр хөгжлийн үе шатуудаа тодорхойлж, шалгуур үзүүлэлтүүдийг

[253]What are the Top 10 Wood-Producing countries in 2023?, https://www.tradeimex.in/blogs/top-10-wood-exporter#:~:text=The%20pinnacle%2010%20wood%20producers,meters%20(Coniferous%2DSoftwood%20Timber)

[254] Дэлхийн ойн нөөцийн үнэлгээ 2015 - Дэлхийн ой мод хэрхэн өөрчлөгдөж байна вэ?, х.36 http://www.fao.org/fileadmin/user_upload/wfc2015/Documents/Durban_Declaration_draft.pdf

тооцсон. Монгол Улс 2050 онд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар Азид тэргүүлэгч орнуудын нэг болохоор заасан.

Ногоон хөгжил: байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна.

> **Зорилт 6.1.** Байгалийн үнэ цэн, өгөөжийг үнэлэн хамгаалж, анхдагч экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.
>
> **Зорилт 6.2.** Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж хомсдолыг бууруулан, ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлнэ.
>
> **Зорилт 6.3.** Усны нөөцийн хомсдолоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулан, эрэлт хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ
>
> **Зорилт 6.4.** Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулна.[255]

Тэрбум мод Үндэсний хөдөлгөөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлыг бууруулах зорилготойгоор 2021 оноос хэрэгжүүлж эхлээд байгаа билээ.

“Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөний алсын хараа: Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад дорвитой хувь нэмэр оруулах, амьдрах орчноо сайжруулах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг үр дүнтэй өрнүүлж ирээдүй хойч үедээ өвлүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар ногоон эдийн засгийг дэмжинэ.

“Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөний зорилго: “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөн нь 2030 он гэхэд тэрбумаар тоологдох мод тарьж, арчлан хамгаалж, ургуулснаар ойн санг 9.0%-д хүргэж, цөлжилт, газрын доройтлыг бууруулан, хүлэмжийн хийн шингээлт, усны нөөцийг нэмэгдүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулж, ногоон хөгжлийн сэргэлтийг эрчимжүүлнэ.[256] Зорилт:

1. Суурин газрын экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, нэмэгдүүлэх, ард иргэдийн амьжиргааны нөхцөлийг сайжруулах, “Хотын ой” хөгжүүлэх;

2. “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний зорилттой уялдуулан төрөлжсөн ойн аж ахуйг хөгжүүлнэ;

[255] Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа-2050, https://vision2050.gov.mn/
[256] Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, https://terbummod.mn/

3. Судалгаа, шинжилгээ, инновац технологийн хүрээлэн байгуулах, хүний нөөц бүрдүүлэх;

4. Цөлжилт газрын доройтол, шороон шуурганы эх үүсвэрийг бууруулах, элсний нүүдлийг сааруулах;

5. Цогц удирдлага, зохицуулалтын нэгдсэн бодлогоор хангах, дэд бүтэц, эрх зүйн орчныг бий болгох;

6. Ойн хомсдол доройтлыг бууруулан, ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлснээр 15 тэрбум мод тарьж ургуулан ойн санг 9 хувьд хүргэж, цөлжилт, газрын доройтолд нэн хүчтэй өртсөн газар нутгийг 4 хувиар бууруулж, ойн сангийн хүлэмжийн хийн шингээлтийг 11 хувиар нэмэгдүүлнэ.[257]

МУ-н ойн салбарын хүний нөөцийн тухай

Монгол Улсын ойн салбарын хүний нөөцийг тодорхойлохын тулд хөдөлмөр эрхлэлт, боловсрол, мэргэжлийн сургалт, ур чадварын түвшнийг авч үзье. Монгол улсад ойн салбарт сургалт боловсролын чиглэлээр дараах байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна. Үүнд: МУИС, ХААИС, ШУТИС-ийн дэргэдэх сургалт-үйлдвэрлэлийн лаборатори, дендрохнологийн лаборатори, ойн экосистемийн мониторингийн лаборатори; ойн генетик, эко-физиологийн лаборатори; Төв азийн бүсийн түймрийн менежментийн төв; Төв аймаг, Батсүмбэр дэх МУИС-ийн ойн сургалт, судалгааны төв; Төв аймгийн Баянчандмань сумын “ХААИС-ийн мод үржүүлгийн сургалт-судалгаа үйлдвэрлэлийн төв; Сэлэнгэ аймгийн Мандал сумын “ШУТИС-ийн ой модны сургалт, судалгааны хүрээлэнгийн ойжуулалт, мод үржүүлэг, ойн механикжуулалтын хээрийн сургалтын полигоныг нэрлэж болно. Үндэсний ажил мэргэжлийн албан тодорхойлолтод (YAMAT) их дээд сургуульд бэлтгэгдэж буй ойн салбарын хүний нөөц нь ойн аж ахуй, хүрээлэн буй орчин судлал, хүрээлэн буй орчны инженерчлэл, ойжуулалт цэцэрлэгжүүлэлт, ойн инженерчлэл, байгаль ашиглалт, хяналт үнэлгээ, байгаль орчны менежмент, ойн зохион байгуулалт, ойн аж ахуйн инженер, байгаль орчны нөхөн сэргээлт, экологи, байгаль орчныг хамгаалах технологи, ойжуулагч гэсэн мэргэжлүүдээр суралцдаг.

Үндэсний ажил мэргэжлийн албан тодорхойлолтод (YAMAT-08) ойн салбартай холбоотой дараах хоёр мэргэжлийн ангилал байна. Үүнд: 6210-Ойн аж ахуй, холбогдох бусад ажилтан; 9215-Ойн аж ахуйн ажилтан.

Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 сарын 20-ны өдрийн А/146 дугаар тушаалаар дээд боловсролын сургалтын байгууллагын мөрдөх “Мэргэжлийн чиглэл/хөтөлбөрийн нэр, индекс”-ийг шинэчлэн баталсан. Үүнээс ойн салбартай холбоотой дараах 13 мэргэжлүүд байна. Үүнд: Ой судлал 082103, Хүрээлэн буй орчин судлал 052102, Хүрээлэн буй орчны инженечлэл 071201, Хүрээлэн буй орчны

[257] Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар, https://forest.gov.mn/website/news.aspx?id=87

хяналт үнэлгээ 081203, Байгаль орчны зайнаас тандан судлал 063208, Байгалийн нөөц, технологи 072410, Экологи 052101, Байгаль хамгаалал 052202, Мод боловсруулах үйлдвэрлэлийн технологи 072202, Ойн инженечлэл 082102, Ойн аж ахуй 082101, Ойн аж ахуй, зохион байгуулалт 08210101, Ой инженерчлэл 08210203.

Монгол Улсад 2024 оны байдлаар дараах 10 их дээд сургууль ойн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж байна. Үүнд: МУИС-д ойн аж ахуй, хүрээлэн буй орчин судлал, хүрээлэн буй орчны инженерчлэл, хүрээлэн буй орчны хяналт үнэлгээ, байгаль орчны зайнаас тандан судлал, байгаль орчныг хамгаалах технологи, экологи, ойн аж ахуй, ойн зохион байгуулалт, зайнаас тандах судалгаа мэргэжлүүдээр боловсрол олгодог бөгөөд энэ нь эрдэм шинжилгээ, судалгааны чиглэл рүү түлхүү чиглэдэг. Харин ШУТИС ойн инженерчлэл, хүрээлэн буй орчны инженер, ойн аж ахуй, ойн зохион байгуулалт, ХААИС ойн аж ахуйн инженер, экологи байгаль хамгаалал, байгаль хамгаалал хяналт үнэлгээ, байгаль орчны нөхөн сэргээлт, ХААИС Дархан-Уул салбар сургууль нь ойжуулалт цэцэрлэгжүүлэлт, экологи байгаль хамгаалал, байгаль ашиглалт, хяналт үнэлгээ, менежмент байгаль орчин экологи, МУИС-ийн Ховд салбар сургууль Ойн аж ахуй, хүрээлэн буй орчны инженерчлэл чиглэлд дээд боловсрол олгох сургалттай. Бусад хувийн хэвшлийн их дээд сургуулиуд тухайлбал Олон Улсын Улаанбаатар их сургууль, Улаанбаатар Эрдэм их сургууль, Шинэ Монгол технологийн дээд сургууль, GMIT, Идэр их сургуулийн Хөвсгөл салбар, Эко Ази дээд сургууль, МҮИС зэрэг их дээд сургуулиуд ойн аж ахуй, хүрээлэн буй орчны инженерчлэл, экологи, байгаль хамгаалал, ойн менежментийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

эдгээр төгсөгчдийн 70% нь мэргэжлийнхээ салбарт ажиллаж чаддаггүй байна. Жишээлбэл, ойн салбарын мэргэжилтэй ажиллагсдын ажил эрхлэлтийн байдал 2012-2014 онуудад 25%-29%, 2015-2017 онуудад 12%-17% байлаа. Энэ нь жилд дунджаар 400 орчим төгсөгч ажилгүйдлийн тоог нэмэгдүүлж байна. Түүнчлэн хөдөлмөрийн зах зээл дээрх ажил эрхлээгүй ойн мэргэжилтэй хүмүүсийн талаарх статистик тоо баримт, бүртгэл тодорхойгүй, зарим төгсөгчид уул уурхай, үйлдвэрлэлийн бусад салбаруудад ажиллаж байгаа ч, тэдгээр төгсөгчдийг мөшгөх судалгаа хийгддэггүй; статистикийн тоон үзүүлэлт, мэдээ, мэдээлэл, судалгаа бүрхэг, зарим талаар огт байхгүй байгаа нь ойн мэргэжлээр төгсөгчдийн ажил эрхлэлтийн өнөөгийн байдлыг бодитоор тогтоох боломжгүй, мухардалд оруулж байна.

Төгсөгчдийн ажил эрхлэлтэд сөргөөр нөлөөлж буй шалтгаануудыг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- Ажлын байрны алслагдмал байдал
- Ойн салбарын цалин хөлс, хангамж бага
- Мэргэжлийн чиглэлээр ажил олдохгүй
- Ажлын байрны хүрэлцээ муу
- Тухайн салбарт өрсөлдөөн их
- Ойн салбарын хөдөлмөрийн зах зээл бага

Ойн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн ажлын хүрээнд Ой, модны салбарын эмэгтэйчүүдийг чадавхжуулах, хамтын ажиллагааг бэхжүүлэх, мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор “Ой, тогтвортой байдал, эмэгтэйчүүд холбоо”, ЗГХА Ойн газар, “Мөнх ногоон тал” ХХК хамтран “Ой, модны салбарын эмэгтэйчүүдийг чадавхжуулах” сургалт семинарыг 2024 оны 3-р сард зохион байгуулсан. Судалгааны үр дүнд ойн салбарын мэргэжлийн байгууллагуудыг зах зээлийн зарчимд үндэслэсэн, аж ахуйн тооцоонд суурилсан тогтолцоогоор үйл ажиллагаа явуулахыг санал болгожээ. Ойн салбарын үйл ажиллагааг тогтвортой менежментийн зарчимд нийцүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах, үйл ажиллагааны бүтээмж, тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээ, байгаль орчны тогтвортой байдлыг хангахад ойн салбарын үйл ажиллагаанд томоохон өөрчлөлтүүд хийх хэрэгтэйг онцолсон байна. Ойн салбарын хүний нөөцийн чадавхыг системт байдлаар сайжруулахыг судалгааны үр дүнд санал болгон, дээрх өөрчлөлтүүдийг амжилттай нэвтрүүлэхэд улс төрчдийн хүсэл эрмэлзлэл, дээд түвшний удирдлагын хүлээх үүрэг, оролцоо, өөрчлөлтийн үр дүн, түүний баримтжлуулалт, хариуцлага, хувьцаа эзэмшигчдийн оролцоо чухал нөлөөтэй болохыг тодорхойлон гаргасан. Ойн салбарын хүний нөөцийн өнөөгийн байдлын талаар дараах дүгнэлтэд хүрсэн:

Өнөөгийн байдал	**Сайжруулах хувилбар**
Ойн салбарын хүний нөөцийн дийлэнх хэсгийг мэргэжлийн бус ажиллагсад эзэлдэг ба ойн чиглэлийн мэргэжилтэй ажиллагсдын хувь оролцоо бага. Ойн салбарын үйл ажиллагааны ачааллыг өнөөгийн хүний нөөцөөр хангах нь хүндрэлтэй.	Ойн салбарын өнөөгийн болон ирээдүйн хүний нөөцийг шаардлагатай сургалтад хамруулан мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх
Ойн салбарын цөөн тооны ажиллагсад өөрсдийн хариуцсан талбайн хүрээнд үүсч байгаа аливаа хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэж чаддаггүй.	Өнөөгийн институцийн хүрээнд байгууллагын бүтэц, зохион байгуулалтын болон ажиллагсдын чиг үүрэгт шинэчлэлт хийх
Ойн салбарын хүний нөөцийн хүлээж буй үүрэг хариуцлагын хэмжээ нь тэдгээрийн идэвхжүүлэлт, урамшууллын системтэй уялдаагүй байна.	Нийтийн удирдлагын шинэчлэлийн хүрээнд Монгол Улсын нийгэм эдийн засгийн хөгжилд оруулах ойн салбарын нийт хувь нэмэр, үр өгөөжийг тооцоолсны үндсэн дээр ойн салбарт шинэчлэлт хийх
Ойн ангиудын ашиглаж буй техник тоног төхөөрөмжийн хоцрогдмол байдал ажиллагсдын ажлын ачааллыг нэмэгдүүлж, бухимдал төрүүлэх шалтгаан болж байна	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль (2012) –д заасны дагуу байгалийн нөөц ашиглалтын орлогын тодорхой хэсгийг ойн салбарт хөрөнгө оруулалт хийхээр тооцох

Эх үүсвэр: судлаач

Сүүлийн үед хийгдсэн судалгаануудын үр дүнгээс дүгнэхэд ойн салбарын менежментийн үр дүн муутай үйл ажиллагаа нь ойн салбарын хүний нөөцийн чадавхыг хангалтгүй түвшинд хүргэж байна.

Дүгнэлт

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан хүний хөгжлийг дэмжих чиглэлийн хүрээнд нэн тэргүүнд чухалчлан авч үзэж буй салбар бол боловсролын салбар бөгөөд I үе шат (2020-2030): Иргэн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлэн, тэгш хамруулж, бүх шатны боловсролын залгамж холбоог хангаж, сургалт, үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх; II үе шат (2031-2040): Бүх насны иргэд, нийгмийн салбар бүрийг хамарсан насан туршийн боловсролын нээлттэй, уян хатан тогтолцоог бэхжүүлэх; III үе шат (2041-2050): Боловсролын бүх шатанд суралцахыг хүссэн хүнд хоёр дахь боломжийг олгосон, сургалтын уян хатан арга замуудтай, харилцан уялдаа бүхий бусадтай хамтран амьдрах, ажиллах чадавх (үнэт зүйлс, зан үйл, амьдралын хэв маяг) бүхий иргэнийг бэлтгэх[258] тусгасан зорилтын хүрээнд системтэй хэрэгжүүлэх үе шат бүрийг нарийвчлан хяналт хийн хүрсэн үр дүнг хэмжиж дараагийг үе шатанд анхаарах асуудал бүрийг дараагийн үе шатанд анхаарах шаардлагатай.

[258] “Алсын хараа - 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого

SPSIRPA FORUM 2025

Session 6-2

Some Challenges Facing the Constitution of Mongolia

Монгол Улсын Үндсэн хуулийн зарим асуудал

Пэлжидийн Амаржаргал

МУИС-ийн УТСОУХНУС-ийн гэрээт дэд профессор, доктор

Хураангүй

Энэхүү өгүүлэл нь Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад шаардлагатай үндэслэл, оруулсан нэмэлт, өөрчлөлтийн түүх, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл санаачлагчийн он цагийн дараалал, хууль тогтоомжийн зохицуулалт, олон улсын туршлага, өөрийн дүгнэлт, алдаа сургамжийн тухай тусгалаа.

Түлхүүр үг

Үндсэн хууль, Монгол Улсын Үндсэн хууль, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, тулгамдаж буй асуудал

Оршил

Нэг үеэ бодвол манайд 1992 оноос хойш Үндсэн хуулийн эрх зүй сонирхдог судлаач эрдэмтэд бий болж, энэ талаар дорвитой ном, өгүүлэл, сурах бичиг, тайлбар гарсаар байна. Түүнчлэн бид өөрсдөө ардчилсан Үндсэн хуулиа 1992 онд баталж, түүндээ 5 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа хэдий ч, бидэнд суралцах, сургамж авах, алдаа дутагдал байсаар л байна.

Дэлхийн бараг бүх улс өөрийн гэсэн Үндсэн хуультай байдаг. Гэхдээ Үндсэн хуультай байх нэг өөр, түүндээ нэмэлт, өөрчлөлт оруулах нь бас нэг өөр тусдаа асуудал болжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн түүх

Монгол Улсад 1924 оноос өмнө албан ёсоор батлагдсан Үндсэн хууль байгаагүй юм. Харин Анхдугаар Үндсэн хууль батлагдахын өмнө эрх зүйн баримт бичгүүд байсан. Монгол Улсын 1924[259] оноос 1992 он хүртэл Үндсэн хуулиудад нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн зохицуулсан түүхийг товчлон авч үзлээ.

Социализмын үед Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмыг нарийвчлан тогтоож байгаагүй.[260] Оросын Үндсэн хуулийг загвар болгож 1924 онд БНМАУ-ын Үндсэн хуулийг баталжээ. ЗХУ-д гарсан өөрчлөлтийн нөлөөгөөр 1940, 1960 оны Үндсэн хуулийг тус тус шинэчлэн баталжээ.[261]

---

[259]Захиргааны шинжлэх ухааны нэр томьёоны тайлбар толь. Конрад Аденауэр сан. Ерөнхий редактор П.Амаржаргал (2024) 266-272 дахь тал

[260] Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. Ч.Энхбаатар, Том Гинсбург, П.Амаржаргал, Д.Солонго, Ц.Даваадулам, Г.Золжаргал, О.Мөнхсайхан, М.Батчимэг (2016) 191 дэх тал

[261] О.Мөнхсайхан. Үндсэн хуулийн хяналт ба тайлбар: үндсэн эрх (2022) 55 дах тал

1924 оны Анхдугаар Үндсэн хуульд тусгайлан бүлэг байгаагүй бөгөөд Зургадугаар зүйлд “Улсын үндсэн хуулийг өөрчлөх батлах явдлыг гагцхүү Улсын Их Хурлаас эрхлэн шийтгэвэл зохино” гэжээ.[262] 1924 оны Үндсэн хуулийн тодорхой заалтыг зөрчиж өөрчлөлт оруулсан, Үндсэн хуулийн заалтууд өөр хоорондоо зөрчилтэй, мөн ердийн хуулиар Үндсэн хуулийн заалтыг зөрчиж буруу практик тогтоосон зэрэг зүйл Үндсэн хуулийн 20 гаруй зүйлд холбогдож буй.[263]

1940 оны Үндсэн хуулийн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хуулийг өөрчлөх журам гэсэн Арван хоёрдугаар бүлгийн 95 дугаар зүйлд “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хуулийг өөрчлөх явдлыг Улсын Их Хурлаар гүйцэтгэх бөгөөд Их Хурлын тэргүүлэгчдийн гуравны хоёроос доош бус хувийн гар өргөж баталснаар өөрчилнө.” гэж заажээ.[264]

Үндсэн хууль батлагдсанаас хойш 1941, 1944, 1949,1952, 1955, 1956, 1957.1959 онуудад тус тус нэмэлт, өөрчлөлт орсон байдаг.[265]

Түүнчлэн 1949 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт[266] нь шинэ Үндсэн хуулийн шинжтэй болсон. Энэ тухай 2017 онд Б.Баярсайхан доктор өгүүлсэн байдаг.[267]

1960 оны Үндсэн хуулийн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хуулийг өөрчлөх ба халах тухай гэсэн Аравдугаар бүлгийн 93 дугаар зүйлд “БНМАУ-ын Үндсэн хуулинд оруулах өөрчлөлтийг гагцхүү Ардын Их Хурлаар хэлэлцэж, түүний депутатуудын гуравны хоёроос доошгүй нь баталснаар оруулна.” Түүнчлэн 94 дүгээр зүйлд “Коммунизмын үед төрийн зарим үүрэг мөхөх тутам үүргийн тухай Үндсэн хуулинд бичигдсэн зүйлс хүчингүй болж байна. Социализм, коммунизм байгуулах гол зэвсэг болсон төр байх хэрэгцээгүй болж, түүний хөдөлмөрчдийн коммунист эвлэлээр сольсон цагт БНМАУ-ын Үндсэн хууль халагдана.” гэжээ.[268]

1960 оны Үндсэн хуулиа 1963, 1966, 1969, 1970, 1971, 1972, 1973, 1978, 1980, 1981, 1983, 1989, 1990 онуудад тус тус нэмэлт, өөрчлөлт орсон.[269]

---

[262] Ж.Амарсанаа. О.Батсайхан. Монгол Улсын Үндсэн хууль: баримт бичиг (2004) 45 дах тал

[263] Б.Батбаяр. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн түүх ба үндсэн хуулийн зөрчил. Эрх зүй сэтгүүл (2019) № 45

[264] Ж.Амарсанаа. О.Батсайхан. Монгол Улсын Үндсэн хууль: баримт бичиг (2004) 158 дах тал

[265] Б.Батбаяр. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн түүх ба үндсэн хуулийн зөрчил. Эрх зүй сэтгүүл (2019) № 45

[266] Улаан од сонин. 1949.02.26. №47 (3294) Бүрэн хэвлэгдсэн.

[267] Б.Баярсайхан. Монгол Улсын Үндсэн хуульт ёсны уламжлал. БНМАУ-ын 1949 оны Үндсэн хуулийн эрх зүйн шинжилгээ. (2017)

[268] Ж.Амарсанаа. О.Батсайхан. Монгол Улсын Үндсэн хууль: баримт бичиг (2004) 246 дах тал

[269] Б.Батбаяр. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн түүх ба үндсэн хуулийн зөрчил. Эрх зүй сэтгүүл (2019) № 45

1924 оны Үндсэн хуульд дур зоргоор оруулсан өөрчлөлт, 1940, 1960 оны Үндсэн хуульд УБХ, УБХТ, УИХТ, АИХТ-ийн УИХ, АИХ-ын бүрэн эрхэд халдан, Үндсэн хуулиа зөрчиж Үндсэн хуульд зүй бусаар оруулсан өөрчлөлтүүдийн тухай дүгнэлтээр өгүүлсэн юм.[270]

1990 онд баталсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн Хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт БНМАУ-ын Үндсэн хууль батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах онцгой эрхийг Ардын Их Хуралд өгсөн.[271]

1992 онд баталсан Монгол Улсын Улсын Үндсэн хуульд "Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах" гэсэн Зургадугаар бүлгийн Жаран наймдугаар зүйл[272], Жаран ес дүгээр зүйлд[273] тусгайлан зохицуулсан.[274] Гэвч энэхүү зургадугаар бүлэгт зөвхөн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт процессын үйл ажиллагааг тусгаснаас биш, харин Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, үндсэн бүтэц, хөндөж үл болох тухай заагаагүй юм.

1992 оноос хойш Улсын Их Хуралд хууль санаачлагчаас Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 15 төсөл өргөн мэдүүлэгдэж, Монгол Улсын Үндсэн хуульд 1999, 2000, 2019, 2022, 2023 онуудад нийт 5 удаа нэмэлт, өөрчлөлт оржээ.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад Монгол Улсын Үндсэн хууль[275] (1992), Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль[276] (2011), Ард нийтийн санал асуулгын тухай хууль[277] (2016), Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль[278] (2017) болон Монгол Улсын Их Хурлын

---

[270] Б.Батбаяр. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн түүх ба үндсэн хуулийн зөрчил. Эрх зүй сэтгүүл (2019) № 45

[271] Ж.Амарсанаа. О.Батсайхан. Монгол Улсын Үндсэн хууль: баримт бичиг (2004) 333 дах тал

[272] Жаран наймдугаар зүйл

1. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно.

2. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар ард нийтийн санал асуулга явуулж болно. Санал асуулгыг Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16-д заасан үндэслэлийн дагуу явуулна. Төрийн мэдээлэл эмхэтгэл 1992 № 1

[273] Жаран есдүгээр зүйл

1. Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн саналаар батална.

2. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хуралд хоёр удаа авч хэлэлцэхэд ийнхүү нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн санал авч эс чадвал уул төслийг ээлжит сонгуулиар сонгогдсон Улсын Их Хурлын шинэ бүрэлдэхүүн ажлаа эхэлтэл дахин авч хэлэлцэхгүй.

3. Улсын Их Хурал ээлжит сонгууль явуулахын өмнөх зургаан сарын дотор Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж үл болно.

4. Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуулийн нэгэн адил хүчинтэй байна. Төрийн мэдээлэл эмхэтгэл 1992 № 1

[274] Төрийн мэдээлэл эмхэтгэл 1992 № 1

[275] Төрийн мэдээлэл эмхэтгэл 1992 № 1

[276] Төрийн мэдээлэл эмхэтгэл 2011 № 3

[277] Төрийн мэдээлэл эмхэтгэл 2016 № 09

[278] Төрийн мэдээлэл эмхэтгэл 2017 № 09

чуулганы хуралдааны дэгийн тухай хууль[279] (2020) зэрэг эдгээр гол таван хуулиар зохицуулж байна.

Олон Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хураангүй түүх

Үндсэн хууль нь 800 гаруй жилийн түүхтэй бөгөөд дэлхийн ууган Үндсэн хууль нь 1215 оны Английн Магна Хартаас эхтэй бөгөөд 1787 онд АНУ-д, 1791 онд Франц, Польшид, 1889 онд Япон Улсад батлагдсанаас хойш ихэнх улс оронд бүрэн эрхт байдлын нь илэрхийлэл, ард түмний бүрэн эрх, хүний эрх, эрх чөлөө, ардчилсан төрийн баталгаа болсон улс төр, эрх зүйн гол баримт бичиг болно.

Магна Харт нь анх одоогоос 810 жилийн тэртээ бүтээгдсэн, эрх чөлөөний эх сурвалжийг судлаагүй хуульч дэлхийд ховор бөгөөд түүний үзэл санаа шингээгүй Үндсэн хууль гэж бараг үгүй юм.[280]

АНУ-ын Үндсэн хууль 1789 оноос хойш 236 жил оршин тогтнох хугацаандаа 27 удаа нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байна.

Харин Япон Улсын Үндсэн хууль 1947 оноос хойш 78 жилийн турш хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд өнөөдрийг хүртэл нэг ч удаа Үндсэн хуулиндаа нэмэлт, өөрчлөлт хийгээгүй[281] онцлогтой юм.

Дэлхийд хамгийн олон удаа нэмэлт, өөрчлөлт орсон Үндсэн хууль бол Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Үндсэн хууль бөгөөд 1950 онд батлагдсанаас хойш нийт 106 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байдаг.

Мөнхийн Үндсэн хууль гэж байхгүй

Үндсэн хууль бол шууд бий болчихоогүй, нийгэм, улс төрийн амьдралаар нөхцөлдөн, түүхийн бүтээгдэхүүн болж тодорхой нөхцөл байдлын дунд үүсчээ.[282] Монгол Улсын Үндсэн хууль бол Монголын ард түмний оюун ухааны сор бүтээл юм.[283]

Үндсэн хуулийг цаг хугацаанд нь зөв ойлгож, ягштал мөрдөхгүй бол энэ зүгээр л “цаас” төдий зүйл болох юм. Үндсэн хууль нь тасралтгүй, хэлбэрэлтгүй хэрэгжих, нийгмийн хөгжлийн шаардлагаар өөрчлөлт оруулж байх учиртай.[284] Гэхдээ Үндсэн хуульд нэмэлт,

[279] Төрийн мэдээлэл эмхэтгэл 2020 № 22

[280] П.Амаржаргал. “Эрх чөлөөний эх булаг Магна Харт”. Олон Улс судлал-2023: Монголын Британы судлал эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл (2024) 20 дахь тал Шинжлэх Ухааны Академийн Олон Улс судлалын хүрээлэн

[281] Д.Лхагвасүрэн. Р.Уганбаатар. М.Сайнбаяр. Д.Сүхболд. Д.Зоригтбаатар. Бүгд Найрамдах Монгол Ард Улс: Үндсэн хуулийн тайлбар философи. (2020) 367 дахь тал

[282] Т.Сэнгэдорж. Дэлхийн улсуудын Үндсэн хуульт ёсны хөгжил, мөн чанар, онцлог. Шинэ толь (1999) **№ 28**

[283] Н.Лүндэндорж. Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар. Хянан тохиолдуулсан: Н.Жанцан (2022) 15 дахь тал

[284] Ж.Амарсанаа. “Үндсэн хуулийн хэрэгжилт ба цаг хугацааны хамаарал” Парламентын судалгаа шинжилгээ. Эрдэм шинжилгээний сэтгүүл. Тусгай дугаар I (2022) 33 дахь тал

өөрчлөлт оруулахдаа улс төрийн намууд юу хүссэнээ өөрчлөх дур зоргын ажил болгож болохгүй бөгөөд яаран хандах нь нийгэмд тогтворгүй, эмх замбараагүй, хямралт байдал үүсгэх аюултай[285] нөхцөл байдал үүсгэдэг.

1992 оны Үндсэн хуулийн хавсралт хуульд "хуулиар" зохицуулахаар нэр заасан /44 хууль бий/ хуулийг 1993 онд баталсан байхаар заасан. 20 жилийн дараа Шүүхийн ерөнхий зөвлөлийн хуулийг баталсан /2012.04/ боловч 2021 онд багц хууль нэрээр 4 хуулийг 1 хууль болгож, Шүүхийн ерөнхий зөвлөлийн хуулийг нэгтгэсэн. Үндсэн хуулийн дагуу хууль тогтоомжийг 1996 онд дуусгана гэж заасан боловч биелэгдээгүй. 2019 онд оруулсан Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөх шилжилтийн журмын тухай хууль, мөн 2020 оны 02 дугаар тогтоолоор баталсан Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хугацааны хувьд хэрэгжиж, биелэхгүй байна.[286] Өөрөөр хэлбэл, Үндсэн хууль батлах, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлаад дагалдах хуулиуд нь цаг хугацаандаа батлагдахгүй бол зүгээр цаас болох, хэлбэр төдий болж хувирна.

Мөнхийн Үндсэн хууль гэж байхгүй. Бас мөнхөд өөрчилж болдоггүй Үндсэн хууль ч гэж байхгүй. Гэхдээ өөрчилж болохгүй зүйл гэж бас бий. Жишээ нь: Монгол Улсын бүрэн эрхт тусгаар улс, хүний эрхийн халдашгүй байдлыг өөрчилж болохгүй юм.[287]

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагаа нь бусад хууль тогтоомжтой харьцуулахад нэлээд онцлог бөгөөд ард түмний оролцоо, улс төрийн намуудын зөвшилцөл, иргэний нийгмийн оролцоог шаарддаг бөгөөд Үндсэн хуулийн нийгэм, эдийн засаг, эрх зүйн хөгжлийг хангахад оршино.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь ердийн хуулийг хууль тогтоох байгууллага өөрчлөн засварлаж байдаг шиг энгийн, амар хялбар асуудал биш бөгөөд Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухаанд бие даасан судлагдахуун болсон маргаан мэтгэлцээн дагуулсан "том" асуудал юм. Асуудлын том нь Үндсэн хууль бол нийт үндэстний амин чухал эрх ашгийг хамгаалж байдаг оюун санааны их хүч учраас түүнийг өөрчлөх, нэмж завсарлах арга ажиллагааг төгс төгөлдөр зохицуулах нь бараг бололцоогүй шахам учраас ард түмний бүрэн эрхт байдалд байлгах, илүү дээр нэмэлт, өөрчлөлтийг ямагт түүний дотоод үзэл баримтлалд нийцүүлэн хийх ёстой гэсэн номлол өдгөө давамгайлж байна.[288]

Үндсэн хууль өөрчлөх үндэслэл

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахын тулд юу болохгүй байгааг цогцоор нь зөв оношилохоос эхлэх ёстой. Ийм оношилогоог судалгааны үндсэн дээр, иж бүрнээр

[285] Assessment of the performance of the 1992 Constitution of Mongolia. Ch.Enkhbaatar, Tom Ginsburg, D.Solongo, P.Amarjargal, Ts.Davaadulam, G.Zoljargal, M.Batchimeg O.Munkhsaikhan (2016) 189 p

[286] Ж.Амарсанаа. "Үндсэн хуулийн хэрэгжилт ба цаг хугацааны хамаарал" Парламентын судалгаа шинжилгээ. Эрдэм шинжилгээний сэтгүүл. Тусгай дугаар I (2022) 33 дахь тал

[287] Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. Хянан тохиолдуулсан Ж.Амарсанаа (2017) 91 дэх тал

[288] Н.Лүндэндорж. Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар. Хянан тохиолдуулсан: Н.Жанцан (2022) 1018 дахь тал

хийсэн эсэхийг сайтар тунгаах хэрэгтэй. Юу болохгүй байгааг нарийн мэдэхгүйгээр юуг ч оновчтой өөрчилж чаддаггүй билээ.[289]

Монголын бүх улс төрийн намуудын оролцоотой хийсэн Үндсэн хуулийг ганц хоёрхон нам өөрчилж байгаа буруу явдал юм. Гэтэл манайхан тавагт

ай шөл хөрж ч амжаагүй шахам байхад Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудал оруулаад, намууд анализ хийгээд, ард түмэн мэдээд, олонхи нь батлаад явчихдаг. Сүүлд нь үзэхэд гарын үсэг цуглуулаад батлуулчихсан байдаг. Иймэрхүү байдлаар Үндсэн хуулийг өөрчилнө гэдэг бол нэг ёсондоо улс төрийн хуйвалдаан юм шүү.[290]

Ард түмэнд Үндсэн хуульд ямар заалт тусгахыг шийдвэрлэхэд оролцох Үндсэн хуулийг хууль ёсны болгох үйл явц нь ардчиллын зарчмаар явагдаж, олон нийтийн оролцоог хангаж байхыг улс төрийн үгсийн санд "new constitutionalism" шинэ үндсэн хуульт ёс гэдэг нэр томьёо орж ирсэн нь үндсэн хуулийн ач холбогдлыг нотолж буй хэрэг юм.[291]

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам нь бусад хуультай харьцуулахад онцлогтой. Үндсэн хууль нь урт удаан хугацаанд тогтвортой үйлчилж байвал нийгмийн тогтвортой хөгжлийг хангаж чадна. Энэ ч учраас Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмыг нэлээд түвэгтэй байдлаар өөрт нь зааж өгдөг.[292]

Үндсэн хуулийг батлах нь түүнд "*амь оруулж буй*" чухал асуудал. Хэдий чинээ "*амь бөхтэй*" Үндсэн хууль гарна төдий чинээ "*урт насална*". Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь түүнд "*засал хийж буй*" явдал. Хэдий чинээ "сайн засал" авна, төдий чинээ "*нас нь уртасна".* Үндсэн хуулийг "амьдруулахад түүний хэрэгжилтэд *хяналт* тавих асуудал нэн чухал. Үндсэн хууль гагцхүү хэрэгжиж байж л үндсэн хуульт ёс тогтдог. Үндсэн хуулийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах нь нэг хэрэг, хамгийн гол нь түүнийг амьдруулах явдал. Үндсэн хууль батлагдсанаараа бус хэрэгжсэнээрээ жинхэнэ Үндсэн хууль болно.[293]

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт гэдэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн бүлэг, зүйл, хэсэг, заалтад байхгүй шинэ томъёоллыг зохих бүлэгт оруулж байгаа зүйл, хэсэг, заалтыг ойлгоно.

Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлт гэдэг нь Үндсэн хуулийн зохих бүлэг, зүйл, хэсэгт байгаа заалтын нэр томъёог тодруулах, найруулгыг сайжруулахаар оруулж байгаа

---

[289] Н.Лүндэндорж. П.Амаржаргал. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зарим санал. Монголын төр, эрх зүй сэтгүүл (2011) **№ 4**

[290] Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. Хянан тохиолдуулсан Ж.Амарсанаа (2017) 92 дэх тал

[291] Винлук Вахиу. Үндсэн хууль бүтээх практикийн гарын авлага. Орчуулсан. С.Энх-Амгалан. A practical guide to Constitution building an introduction (2011) 3 дахь тал

[292] О.Очиржав. Парламентат ёс ба Үндсэн хууль. Шинэ толь (1999) **№ 28**

[293] Т.Сэнгэдорж. Дэлхийн улсуудын Үндсэн хуульт ёсны хөгжил, мөн чанар, онцлог. Шинэ толь (1999) **№ 28**

заалт юм. Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулиар нэмэлт, өөрчлөлтийг салгаж, ялгаатай гэж хуульчилжээ.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гэсэн үг ярианы эргэн тойронд:

- Үндсэн хуулийг өөрчлөх
- Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
- Үндсэн хуулийг хянан үзэх гэх ойлголт байна.

Өмнөх Үндсэн хуулийг халж (устгаж), шинийг боловсруулж гаргахыг Үндсэн хууль өөрчлөх гэнэ. Ийнхүү өөрчлөх нь нийгмийн хувьсгал гаргах буюу тэр хэмжээний шинэтгэл хийхтэй холбоотой үүсдэг зайлшгүй үйл явдал бөгөөд үр дагавар нь улсын мөн чанар бүхэлдээ өөрчлөгдөх үндэс болно.[294]

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гэдэг нь шинээр үг, үсэг, зүйл, хэсэг, заалт, нэмснийг нэмэлт, өөрчлөлт гэхээс илүүтэй Үндсэн хуулийг улам боловсронгуй болгох, сайжруулах, хөгжүүлэх зорилгоор бичвэрт оруулсан аливаа өөрчлөлтийг нийтлэгээр ойлгоно.[295]

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл гэж хууль санаачлагчаас Үндсэн хуулийн ач холбогдол, өндөр шаардлагыг хангахуйц мэргэжлийн түвшинд боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийн эх бичвэрийг ойлгоно.

Зарим тохиолдолд Үндсэн хуулийг бүтээх гэж бас тодорхойлдог. Доктор Нора Хедлинг тайлбарт Үндсэн хуулийг хэлэлцэх, зөвлөлдөх, боловсруулах, хэрэгжүүлэх, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахаас үүссэн үйл явц. [296]

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Үндсэн хуулийн хэл, найруулга сүүлийн үед анхаарал татах болов. Тухайлбал, Эр хүйсийн төлөөний үг /he, him гэм мэт/ ихэвчлэн хүн гэдэг утгаар, “Mankind- хүн төрөлхтөн”, “Founding father- үүсгэн байгуулагч эцэг” зэрэг үгсийг дурдаж болох юм.

Үндсэн хуулийн үндсэн бүтцийн номлол (basic structure doctrine of Constitution) гэх үзэл санаа нь Үндсэн хуульд тухайн үндсэн хуулийн суурь болон гол шинжийг агуулсан зарчмууд туссан гэх үзэл санаа юм. Үндсэн хуульд хэзээ ч өөрчилж үл болох гол зарчмууд байдаг үзэл санаа юм.[297]

---

[294] Улсын Их Хурлын архив, Д-7, ХН-810. Х 247 /Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн хувийн хэрэг. Боть 3. 2010.10.15-2010.12.23/

[295] Н.Лүндэндорж. Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар. Хянан тохиолдуулсан: Н.Жанцан (2022) 1018 дахь тал

[296] Нора Хедлинг. Үндсэн хууль бүтээх практикийн гарын авлага: зарчим ба нийтлэг үндэслэл Орчуулсан. С.Энх-Амгалан. A practical guide to Constitution building: Principles and Crosscutting themes (2011) 57 дахь тал

[297] Улсын Их Хурлын архив, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам түүний хэрэгжилт ба олон улсын жишиг. Парламент судалгааны эмхэтгэл. Боть 42 (2023) 167 дахь тал. 1960-1970

Үндсэн хуулийн албан ёсны нэмэлт, өөрчлөлтөөс гадуурх өөрчлөлт гэж бас байж болно. Тухайлбал, Үндсэн хуулийн хяналтын тогтолцоо бүхий улс орнуудад Үндсэн хуульд тайлбар хийх замаар түүний зарим зохицуулалтын агуулга, утга үзэл баримтлалыг өөрчилж болдог. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам нь хатуу, чанга байхын хэрээр Үндсэн хуульд тайлбар хийх замаар өөрчлөх явдал нэмэгдэж байна.[298]

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд итгэлцлийг бий болгоё.[299] Үүнд:

1. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах төслийг нийтэд ил тод мэдээлж, олон түмний зүгээс бодол санаагаа илэрхийлэх бололцоо олгох,

2. Ерөнхийлөгч, Улсын Их Хурал санал нэгдсэн байх

3. Үндсэн хуулийн Цэцээс төслийг бүхэлд нь буюу тухайн заалтуудын талаар зөвшөөрөхгүй тухай санал ирүүлээгүй байх зөвхөн ийм нөхцөлд Үндсэн хуульд өөрчлөлт оруулахаар улс төрийн тохиролцоонд урьдчилан хүрэх.

Ингэхгүй бол Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлыг зөвхөн УИХ-ын хүрээнд авч үзэх нь нийгэмд үл итгэх уур амьсгал бий болгодог нь болсон үйл явдлуудаас харагдлаа. Бусадтай тохиролцоонд хүрэхгүйгээр зөвхөн нэг субъект Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг шийдвэрлэх нь тухайн субъектийн явцуу сонирхол өөрчлөлтөд тусгагдах осолтой. Иймээс дээр дурдсан тохиролцоонд хүрвэл улс төрийн хувьд итгэлцэл бий болж, асуудалд ажил хэрэгчээр хандах уур амьсгал бүрдэх үндэстэй гэж үзэж байна.

Төрийн эрх мэдлийн эх үндэс нь ард түмэн гэж хүлээн зөвшөөрсөн улс орны Үндсэн хууль ач холбогдолтой байдаг.[300]

Шүүмжлэл

Орчин үеийн иргэний нийгэмд болон өнөөгийн ардчилсан үндсэн хуульт төрд парламентийн олонхийн зүгээс эрх мэдлээ хортойгоор ашиглах магадлал илэрхий юм.[301]

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт гэдэг бол санааны зоргоор ханддаг асуудал биш бөгөөд батлагдсан цагаас нь эхлээд шүүмжлээд эхэлсэн. Энэ байдал эдүгээ 26 дахь жилдээ орох гээд явж байна.[302]

онд Энэтхэг Улсын Дээд шүүхээс Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэхдээ уг номлолыг анх томьёолсон гэж үздэг. 185 дахь тал

[298] Улсын Их Хурлын архив, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам түүний хэрэгжилт ба олон улсын жишиг. Парламент судалгааны эмхэтгэл. Боть 42 (2023) 167 дахь тал

[299] Д.Ламжав. Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудалд. Шинэ толь (1999) **№ 25**

[300] П.Амаржаргал. Парламентын бүрэн эрх: төлөвшил, хөгжлийн чиг хандлага (2016) 171 дэх тал

[301] Н.Лүндэндорж. Үндсэн хуульт төр ёсны хөгжил. Политологи сэтгүүл МУИС (2002) 60 дахь тал

[302]Д.Лүндээжанцан.“Үндсэн хуулийг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага ба нэмэлт, өөрчлөлт” Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудал: Монгол Улсын жишээ. Олон улсын бага хурал. Гадаад харилцааны яам (2018) 115 дахь тал

Төрийн жинхэнэ албан хаагчид, захиргааны ажилтан нарын Үндсэн хуультай харьцах нийтлэг хандлагыг эрс шинэчлэх цаг болсон. Хууль биелүүлэхээр суугаа тэд улс төрчдийг даган баясаж, хуулиа биелүүлэх бус, шүүмжлээд суудаг болсон.[303]

Монгол Улсын Үндсэн хуулийн 20 жилийн ойн эрдэм шинжилгээний хуралд профессор Н.Лүндэндорж ярихдаа Герман Улсын туршлагаар Үндсэн хуулийг шүүмжлээд байвал Эрүүгийн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулаад Үндсэн хуулийн эсрэг хэвлэл мэдээллээр ийм сөрөг мэдээлэл явуулаад байвал 10 хүртэл жил хорих ийм зүйлийг манай зарим хүмүүс санаулж байсан. Энэ бол буруу хандлага юм. Энд Үндсэн хуулиа улам сайн болгохын тулд тал бүрээс нь шүүмжилж боловсронгуй болгох арга замыг ямагт хайж, энэ олсон үнэ цэнэтэй зүйлийг хамгаалж явах ёстой.[304] гэж хэлж байв.

Тогтвортой байдал

Үндсэн хуулийн заалтуудыг ягштал дагаж мөрдөн биелүүлэхийн тулд түүний заалт бүрийн цаана байх үзэл баримтлал, түүхэн нөхцөл байдлыг ухаж ойлгох нь Үндсэн хуулиа нэг мөр зөв хэрэглэх, эрх зүйн тогтвортой байдалд чухал үүрэгтэй юм.[305]

Үндсэн хуульт ёсны нэг гол зарчим болох Үндсэн хуулийн тогтвортой байдлыг хамгаалах явдал нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам болон Үндсэн хуулийн хяналтын механизмаар хэрэгждэг.[306]

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь ойр зуурын хэрэгцээ, шаардлагаар үүсдэг зүйл биш бөгөөд хүндтэй шалтгаан буй болсон нөхцөлд л хэрэгжүүлдэг, эмзэг нарийн ажил юм.[307] Тухайлбал, Үндсэн хуулийн цэг таслал, үг өгүүлбэр, бүлэг, зүйл, хэсэг, заалт, болгон нь зарчим бөгөөд Үндсэн хуульд гаргасан багахан хэмжээний алдаа нь

[303] Б.Чимид. “Ардчилсан Үндсэн хууль бол монголын ард түмний бүтээл мөн”. Ардчилсан Үндсэн хууль-20 эрдэм шинжилгээний хурал. Эмхэтгэсэн. П.Амаржаргал нар УИХТГ (2012) 33 дахь тал

[304] Ардчилсан Үндсэн хууль-20 эрдэм шинжилгээний хурал. Эмхэтгэсэн. П.Амаржаргал нар УИХТГ (2012) 64 дэх тал

[305] П.Амаржаргал. “Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйл, Япон Улсын Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлийг Үндсэн хуулийн эрх зүйн үүднээс харьцуулах нь”. Хууль дээдлэх ёс сэтгүүл (2012) № 2

[306] П.Амаржаргал. Үндсэн хуулийн эрх зүй: Парламентын онол үзэл баримтлалын асуудал (2015) 204 дэх тал

[307] Н.Лүндэндорж. Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар. Хянан тохиолдуулсан: Н.Жанцан (2022) 15 дахь тал

тухайн орны засаглал, дэглэм, төрийн байгууламжийг өөрчилж, ардчиллаас дарангуйлалд унаж болохыг Наполеон, Ленин, Гитлерийн өөрчлөлтүүд харуулдаг.[308]

Монгол Улсын Үндсэн хууль батлагдсан өдрөөс хойш (1992-2025) 33 жилийн хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг он дараалан авч үзвэл:

	Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн нэр	**Хууль санаачлагч**	**Өргөн мэдүүлсэн огноо**	**Батлагдсан огноо**	**Хувь**
	Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл	Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Үүл нарын 26 гишүүн	1999.12.23	1999.12.24	61-60 гишүүн 98.3
	Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл	Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг нарын 14 гишүүн	1999.12.23	-	-
	Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл	Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 26 гишүүн	1999.12.23	-	-
	Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл	Улсын Их Хурлын гишүүн П.Жасрай нарын 65 гишүүн	2000.11.30	2000.12.14	68 гишүүн 100 хувь
	Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай төсөл	Улсын Их Хурлын гишүүн Д.Энхбат	2011.05.10	-	-
	Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай төсөл	Улсын Их Хурлын гишүүн Д.Энхбат нарын 15 гишүүн	2011.08.09	-	-
	Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл	Улсын Их Хурлын гишүүн Д.Дамба-Очир нарын 5 гишүүн	2011.05.25	-	-

[308] Д.Лхагвасүрэн. Р.Уганбаатар. М.Сайнбаяр. Д.Сүхболд. Д.Зоригтбаатар. Бүгд Найрамдах Монгол Ард Улс: Үндсэн хуулийн тайлбар философи. (2020) 365 дахь тал

	Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт оруулах тухай төсөл	Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар нарын 31 гишүүн	2011.12.23	-	-
	Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл	Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд	2012.01.09	-	-
	Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл	Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн нарын 4 гишүүн	2014.12.24	-	-
	Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл	Улсын Их Хурлын гишүүн Н.Батбаяр нарын 48 гишүүн	2015.11.06	-	-
	Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл	Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 62 гишүүн	2019.06.06	2019.11.14	64 гишүүн 100 хувь
	Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл	Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга	2019.07.16		
	Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл	Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 60 гишүүн	2022.08.25	2022.08.25	62-61 гишүүн 98.4 хувь
	Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	2023.05.03	2023.05.31	68-62 гишүүн 91.2 хувь

Шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш Улсын Их Хуралд сүүлийн 33 жилийн хугацаанд Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн нийт 15 хувилбарыг өргөн мэдүүлсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 1 удаа, Ерөнхий сайдаас 1 удаа, Улсын Их Хурлын гишүүдээс 13 удаа тус тус өргөн мэдүүлсэн байдаг.

Нийт Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай өргөн мэдүүлсэн 15 төслөөс 7 төсөл батлагдаж, үлдсэн 8 төсөл нь хууль санаачлагчдад дэгийн тухай хуулийн дагуу буцаагдсан юм. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсэгт “Өмнөх Улсын Их

Хурлын бүрэн эрхийн хугацаанд хэлэлцэж батлаагүй хууль, тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаасанд тооцно.” гэж заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн өмнөх төслийг хэлэлцээгүй буцаасан юм.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн батлагдсан 7 удаагийн төслийг огноог нэг бүрчлэн харвал 1999 оны 12 дугаар сарын 23 ны өдөр бүгд нэг өдөр, 3 ижил төслийг Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг нарын 14 гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Үүл нарын 26 гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 26 гишүүдээс Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Улсын Их Хурлын дарга Р.Гончигдоржид өргөн мэдүүлсэн, дараа нь Үндсэн хуулийн цэцээр хэлэлцэгдсэн байдаг. 2000 оны 11 дүгээр сарын 30 ны өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Улсын Их Хурлын гишүүн П.Жасрай нарын 65 гишүүн өргөн мэдүүлэн юм. 2019 оны 6 дугаар сарын 06 ны өдөр Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 62 гишүүдээс Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт болон 2019 оны 7 дугаар сарын 16 ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгаас Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг өргөн мэдүүлсэн юм. 2022 оны 8 дугаар сарын 25 ны өдөр Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 60 гишүүдээс Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт өргөн мэдүүлжээ. Түүнчлэн сүүлд 2023 оны 5 дугаар сарын 3 ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнээс Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт өргөн мэдүүлсэн.

1999 оны 12 дугаар сарын 24 ний өдөр Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Улсын Их Хурлын 61 гишүүн санал хураалтад оролцсоноос 60 гишүүн дэмжиж, 1 гишүүн татгалзсанаар 98.3 хувийн саналаар батлагдсан бол, 2000 оны 12 дугаар сарын 14 ны өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Улсын Их Хурлын 68 гишүүн санал хураалтад оролцон 100 хувийн саналаар батлагдсан бол, 2019 оны 11 дүгээр сарын 14 ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Улсын Их Хурлын 64 гишүүн дэмжиж 100 хувийн саналаар батлагдсан бол, 2022 оны 08 дугаар сарын 25 ны өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг Улсын Их Хурлын 62 гишүүн санал хураалтад оролцож 61 гишүүн дэмжиж, 1 гишүүн татгалзсанаар 98.4 хувийн саналаар батлагдсан бол, 2023 оны 05 дугаар сарын 30 ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг Улсын Их Хурлын 68 гишүүн санал хураалтад оролцож, 62 гишүүн дэмжиж, 6 гишүүн татгалзаж, 91.2 хувийн саналаар тус тус батлагджээ.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулийн зүйл, хэсэг, заалтыг онцолбол Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацааг нэг удаад 5 жилээр сонгох, Улсын Их Хурал өөрөө тарах, чуулганы хугацаа, хянан шалгах түр хороо байгуулах, сонгуулийн холимог тогтолцоонд шилжих, гишүүдийн тоо нэмэх, Засгийн газрыг зөвшилцөх, бүтэц зохион байгуулалт, Шүүхийн сахилгын хороог шинээр бий болгох, Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүнийг өөрчлөх, Байгалийн баялаг төрийн нийтийн өмч

болох, Улс төрийн намын эвлэлдэн нэгдэн байгуулах, орлогын эх үүсвэр зэргийг тусгасан.

Иймд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан зүйлийг хэсэгхэн тоймловол бүхэлдээ төрийн эрх мэдлийн байгууллагын бүрэн эрх, орон тоог өргөжүүлсэн, шинээр бүтэц бий болгосон харагдаж байна. Хэлэлцсэн болон батлагдсан цаг хугацааны хувьд 1 өдрөөс эхлэн 150 хоног хүртэлхи хугацаанд байгаа нь улс орны хэмжээний том асуудлыг богино хугацаанд хэлэлцэн баталж байгаа нь дутагдалтай юм. Цаашид хуулийн төслийн хэлэлцүүлгийн хугацааг анхаарах шаардлагатай. Түүнчлэн батлагдсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хуулийг эргэн харахад парламентын ардчиллыг бэхжүүлэх, хүчтэй Ерөнхий сайдыг бий болгохыг зорьж байна гэж үзэж болохоор байна.

Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг Ерөнхийлөгч П.Очирбат агсан тэргүүлж 1990-1991 онд хийж, Улсын Бага Хурлаар 3 удаа хэлэлцүүлж, иргэдийн давхардсан тоогоор 200 гаруй мянган санал гаргасныг нэгтгэж, Ардын Их Хурлын 430 гишүүнээр 70 гаруй хоног хэлэлцэн 1992 оны 1 дүгээр сарын 13 нд шинэ Үндсэн хуулийг баталсан байдаг.

Дүгнэлт

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь эхнээсээ Үндсэн хуулиа хөгжүүлэх, ард иргэдийнхээ төлөө юм уу, эсхүл улс төрчдийн эрх мэдлийг өргөжүүлэх, бататгах юм уу? гэсэн асуулт урган гарна. Миний бодлоор эхнийх нь байгаасай гэж хүсч энэхүү өгүүллийг бичлээ.

Орчин үед иргэд өөрсдийгөө төрийн эрх мэдлийн тулгуур эх сурвалж гэдгийг ойлгож, аливаа Үндсэн хууль болон түүний нэмэлт, өөрчлөлт нь иргэдийн эрх, эрх чөлөөний төлөө, тэдний оролцоотойгоор төрийн өргөн эрх мэдлийг хязгаарлах, хуваарилахад чиглэгдэж ёстой гэж үзэж байна.

Үндсэн хууль бол хэзээ ч өөрчилөгдөшгүй улс төр, эрх зүйн баримт бичиг биш юм. Харин хууль ёсны, хүлээн зөвшөөрөгдсөн, иргэдийн оролцоог боломжийн хүрээнд хангасан, нийгмийн төлөөллийг бүрдүүлсэн, төрийн эрх мэдлийн тэнцвэрийг тодорхой болгох, хязгаарлаж байх юм. Энэ тохиолдолд л Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь хууль ёсны, хүлээн зөвшөөрөгдөх жамтай.

Өгүүллийн явцад дүгнэн үзэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь түүхэн хөгжлийн үе шатаар туулан, алдаа онооны дэнсэнд явж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийг зорин, боловсронгуй болон өөрийн хэмжээнд хөгжиж байна. Гэхдээ өмнө өгүүлсэнчлэн тодорхой асуудал. Тухайлбал, иргэдийн оролцоог бүрэн хангаагүй, улс төрийн намын ашиг сонирхол шингэсэн, иргэдээс зөвлөлдөх санал асуулгаар өгсөн санал нь гээгдсэн г.м асуудлууд байсаар л байна.

Түүнчлэн Ард нийтийн санал асуулга явуулаад санал асуулгын дүнг Улсын Их Хурал дахин хянах нь хэр оновчтой эсэхийг анхаарах шаардлагатай.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийх хянан шийдвэрлэх ажиллагааг Үндсэн хуулиасаа давсан органик, ердийн хуулиараа зохицуулах нь хэр оновчтой эсэхийг дахин анхаарах, эсхүл Үндсэн хуульдаа өөрт нь тусгасан нь зөв гэж үзэж байна.

Эцэст нь хэлэхэд Монгол Улс бол Үндсэн хуультай байх нэг өөр, түүндээ нэмэлт, өөрчлөлт оруулах нь дахин нэг өөр анхаарах чухал асуудал болжээ.

SPSIRPA FORUM 2025

Session 6-3

Public service – Ethical Leadership

Төрийн алба - ёс зүйн манлайлал

МУИС, УТСОУХНУС, Нийтийн удирдлагын тэнхимийн ахлах багш

Др. Г.Мягмар

Хураангуй

Ёс зүйн манлайллын талаарх онол, практикийн судалгаа 2000 оноос хойш хийгдэж буй харьцангуй шинэ салбар боловч сүүлийн жилүүдэд эрчимжих хандлагатай байна. Ёс зүйтэй байх тухай асуудал хувь хүн болон байгууллагад хамаатай боловч манлайлагч нь үлгэр жишээ үзүүлэх, ёс зүйтэй байх орчныг бүрдүүлэхэд онцгой үүрэгтэй (Kabey M, 2018). “Байгууллагын үнэт зүйлс, байгууллагын зорилго, зорилтуудад хүрэх, бусдыг дагуулах, нөлөөлөх үйл явцаас үзэхэд ёс зүй бол манлайллын чухал бүрэлдэхүүн хэсэг” гэж манлайллын онол судлаач Peter Northouse дүгнэжээ.

Түлхүүр үг: манлайлал, ёс зүй, ёс зүйн манлайлал

Үндсэн хэсэг

Манлайлал болон ёс зүйн тухай ойлголтууд салшгүй атал манлайлагч, удирдагчийн ёс зүйн асуудлыг зөвхөн хууль, дүрмийн талаас бичих нь элбэг (Geuras, D., & Garofalo, C. 2011). Манлайлагч байх нь бусдад нөлөөлөх чадварын тухай ойлголт тул хувь хүний хувьд ёс зүйн үлгэр дуурайлал үзүүлэхүйц зан чанар зайлшгүй чухал. Ёс зүйтэй, зөв үлгэр дуурайлал үзүүлснээр манлайлагчийн үзүүлэх үр нөлөө эерэг, ёс зүйтэй байх нь дамжиггүй бөгөөд цаашлаад ёс зүйн соёлыг байгууллагад түгээж, ёс зүйтэй хамт олон, ёс зүйтэй байгууллагыг бий болгох чухал эх үүсвэр болно. Түүнчлэн, ажилтан, албан хаагчид шууд удирдлагын дор бус ажлын байрнаас гадуур бие даан ажиллах болсон шинэ байгууллагын эрин өнөө үед ёс зүйтэй манлайлагчийн үүрэг чухалд тооцогдох болсон (Trevino, L. K., Hartman, L. P., & Brown, M. 2000). Иймээс ёс зүйн манлайллын ойлголтыг судлах хэрэгцээ шаардлага улам бүр өсөн нэмэгдэж байна.

M.E.Brown, L.K.Trevino, D.A.Harrison нарын судлаачид (2000, 2003) ёс зүйтэй манлайлагчийг дараах байдлаар судалгааны бүтээлдээ тодорхойлжээ (Mihelič, K. K., Lipičnik, B., & Tekavčič, M. 2010). Үүнд:

1. Ёс зүйтэй манлайлагч нь дагалдагч нартаа зөв, зохистой зан байдал, үйлдлийг өөрийн биеэр үлгэрлэн үзүүлдэг;
2. Өөрсдийн зан байдал, үйлдэл, шийдвэрээ дагалдагч нартаа үндэслэлтэйгээр тайлбарлаж, тэд нартай харилцдаг;
3. Ёс зүйтэй манлайлагч байнга ёс зүйтэй байхыг хүсдэг учраас байгууллагад ёс зүйн хэм хэмжээг тогтоож, ёс зүйтэй үйлдлийг дэмжин, ёс зүйгүй үйлдлийг шийтгэдэг;
4. Аливаа шийдвэрийг гаргахдаа ёс зүйн хэмжээсийг харгалзан үздэг бөгөөд шийдвэрийнхээ ёс зүйн үр дагаврыг тооцон шударга сонголт хийхийг эрмэлздэг (Jordan, J., Brown, M. E., Treviño, L. K., & Finkelstein, S. 2011).

Харин 2005 онд судлаач M.E.Brown, түүний хамтран зүтгэгчид “Ёс зүйн манлайлал нь хоёр талт харилцаа, шийдвэр гаргалт, идэвхжүүлэлтээр дамжуулан дагагч нарт хувийн зан үйл, харилцааны арга хэрэгслээр зохистой зан үйлийг үзүүлэн таниулах үйл явц” (Heres, L., & Lasthuizen, K. 2012) гэж тодорхойлсон нь эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлүүдэд хамгийн өргөн хэрэглэгдсээр байна. 2008 онд судлаач De Hoogh, Den Hartog нар ёс зүйн манлайллыг ёс суртахуун/ шударга ёс, тодорхой дүр, эрх мэдэл хуваах гэсэн гурван элементтэй (Downe, J., Cowell, R., & Morgan, K. 2016), харин Hassan, Wright, Yukl нарын судлаачид (2014) ёс зүйн үлгэр жишээ болох, хүмүүст шударга хандах, байгууллагад ёс зүйг идэвхтэй дэмжих гэсэн элементүүдтэй гэж үзжээ (Downe, J., Cowell, R., & Morgan, K. 2016).

Судлаач Fernando (2012) ёс зүйн манлайлал дараах зарчмуудыг тодорхойлсон. Үүнд (Kabeyi, M. 2018):

1. Шударга байх, бусдыг өөрийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй байх
2. Үнэнч шударга байх, хууль, дүрэм, журам, ёс зүйн стандартыг мөрдөх
3. Бусдыг хүндлэх, тэдний эрх, бие даасан байдлыг нь ойлгож харьцах
4. Хүнлэг энэрэнгүй, хэнд ч гэм хор хүргэхгүй байх.

Эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлүүдэд ёс зүйн манлайлал нь ёс зүйтэй хувь хүн болон ёс зүйтэй менежер гэсэн хоёр үндсэн багана буюу элементтэй хэмээн үзсэн нь нийтлэг боловч зарим нэг харилцан адилгүй дэд элементүүд байна. Энэхүү ёс зүйн манлайллын хос баганын талаар менежмент болон байгууллагын онолын нэрт эрдэмтэн Chester Barnard одоогоос наян жилийн өмнө бичиж байсан түүхтэй (Treviño, L. K., Hartman, L. P., & Brown, M. 2000). Ёс зүйтэй манлайлагч байх нь нэн тэргүүнд хувь хүний хувьд ёс зүйтэй байх (ёс зүйтэй хувь хүн), нөгөө талаар зөвхөн өөрөө ёс зүйтэй байгаад зогсохгүй, бусдыг ёс зүйтэй байхад уриалан дуудаж, үлгэр дуурайлал үзүүлэн дэмжиж манлайлах (ёс зүйтэй менежер) тухай ойлголт болно (Schaubroeck, J. M., Hannah, S. T., Avolio, B. J., Kozlowski, S. W. J., Lord, R. G., Treviño, L. K., ... & Peng, A. C. 2012).

Хүснэгт 1: Ёс зүйн манлайллын үндсэн хоёр багана

<table>
<tr><th colspan="2">Ёс зүйн манлайлал</th></tr>
<tr><th>Ёс зүйтэй хувь хүн</th><th>Ёс зүйтэй менежер</th></tr>
<tr><td>ҮНЭТ ЗҮЙЛС
Шударга ёсыг баримталдаг
Үнэнч
Итгэл даахуйц</td><td rowspan="2">Бусдад харагдахуйц ёс зүйтэй хүний ҮЛГЭР ЖИШЭЭ БОЛОХ</td></tr>
<tr><td>ЗАН ЧАНАР
Зөв зүйлийг хийдэг
Хүнлэг
Нээлттэй</td></tr>
<tr><td colspan="2">Шагнал урамшуулал, шийтгэл зэргээр дамжуулан ИДЭВХЖҮҮЛЭХ</td></tr>
</table>

• Хувь хүний ёс суртахуун	
ШИЙДВЭР ГАРГАЛТ • Үнэт зүйлст үнэнч • Шударга • Нийгэм, олон нийтийн төлөө • Ёс зүйтэй шийдвэр гаргалт	Ёс зүй, үнэт зүйлсийн талаар **ХАРИЛЦАХ**

Эх сурвалж: Treviño, L. K., Hartman, L. P., & Brown, M. (2000). Moral person and moral manager: How executives develop a reputation for ethical leadership. California Management Review, 42(4), 129.

БАГАНА 1: ЁС ЗҮЙТЭЙ ХУВЬ ХҮН

Ёс зүйтэй хувь хүний тухай ойлголт нь: а) Манлайлагчийн онцлог шинж, баримталдаг үнэт зүйлс; б) Манлайлагчийн зан чанарын онцлог; в) Манлайлагчийн шийдвэр гаргалт гэсэн дэд элементүүдтэй (Heres, L., & Lasthuizen, K. 2012). Ёс зүйтэй хувь хүн байх нь ёс зүйн манлайллын үндсэн суурь болно. Ёс зүйтэй хувь хүн нь ёс зүйн үнэт зүйлстэй, түүнийгээ чанд баримталдаг, тодорхой зан чанарыг тогтмол үзүүлдэг, ёс зүйн зарчимд тулгуурлан шийдвэр гаргадаг байх шаардлагатай (Treviño, L. K., Hartman, L. P., & Brown, M. 2000). Хамгийн чухал нь дээрх бүхэн жинхэнэ буюу чин сэтгэлийн байх ёстой, учир нь хүмүүс үг, үйлдэл зөрдөг хуурамч хүмүүсийг амархан мэдэж, итгэж хүндлэхээ больдог. Сэтгэл зүй, байгууллага, нийгмийн хүчин зүйлс, нөхцөл байдал зэргээс шалтгаалж хувь хүн ёс зүйн хүчтэй хүсэл эрмэлзэлтэй байхад амар биш боловч урт хугацаанд хувь хүн, байгууллага, нийгэмд үзүүлэх эерэг үр нөлөөтэй тул ёс зүйн талаарх ойлголтоо нэмэгдүүлж, ёс зүйтэй байх нь чухал юм (Kabeyi, M. 2018).

Ёс зүйтэй хувь хүн – Үнэт зүйлс

Үнэт зүйлс нь бие хүний юмс үзэгдэлд үнэлгээ өгч, ач холбогдолтой хэмээн үзэж буй зүйлс бөгөөд мэргэжлийн болон ажлын байрны үндсэн шинж чанар, онцлогоор тодорхойлогдохын зэрэгцээ улс орны соёл, зан заншил, түүх нийгмийн өвөрмөц шинж чанар нөлөөлдөг. Аливаа байгууллагын болон хувь хүний үнэт зүйлс бол ямар зан чанар, үг үйлдэл зөв, сайн болох талаарх тунхаглал болдог. Ёс зүйн манлайлал нэн тэргүүнд манлайлагчийн хувийн ёс суртахууны үнэт зүйлс, түүний зан үйлдэлд үндэслэдэг бөгөөд гадаад хүчин зүйлсийн нөлөөлөл, дарамт шахалт, саад бэрхшээл, эрсдэлтэй нөхцөл байдалд ч ёс зүйн үнэт зүйлсээ баримтлах шаардлага тавигддаг (Lawton, A., Rayner, J., & Lasthuizen, K. 2013). Байгууллагын ажиллагчид ажлын байрнаас гадуур, шууд удирдлагагүй, бие даан ажиллах болсон өнөө үед тэднийг нэгтгэдэг гол хүчин зүйл нь байгууллагын үнэт зүйлс болж байна (Treviño, L. K., Hartman, L. P., & Brown, M. 2000). Энэхүү үнэт зүйлсийг тодорхойлох, сахиулах үндсэн үүрэг байгууллагын дээд түвшний удирдлагад ногдож байна. Нөгөө талаар бие даан ажиллаж буй нэг ажилтны ёс зүй болон хууль зөрчсөнөөс үүдэх алдаа бүх байгууллагын нэр хүндэд халтай байх аюултай.

Ёс зүйн манлайлалтай холбоотой хувь хүний үнэт зүйлсээс шударга, итгэл даахуйц, үнэнч гэсэн ойлголтууд хамгийн нийтлэг өргөн тархсан (Treviño, L. K., Hartman, L. P., & Brown, M. 2000). Шударга байх /integrity/ нь үнэнийг хэлдэг, ёс зүйн зарчмаа тууштай баримтлах тухай, харин итгэл даах нь харилцаанд тогтвортой, таамаглахуйц, найдвартай байх тухай ойлголт юм. Үнэнч байх нь худал хуурмагаас хол байх, үнэнийг хэлэх талаарх ойлголт болно. Төрийн албаны хувьд үнэт зүйлс нь олон нийтэд төрийн байгууллагын алсын хараа, үндсэн зорилгын талаарх мэдээллийг өгөөд зогсохгүй, төрийн албан хаагчдад өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөх ерөнхий зааварчилгаа болдог. Олон орнууд төрийн албанд баримтлах гол үнэт зүйлсийг Үндсэн хууль болон бусад хууль тогтоомждоо тусгаж өгсөн байдаг. Ялгаварлахгүй, тэгш хандах (impartiality), хуулийг ёсчлон дагах (legality), шударга байдал (integrity) зэрэг үнэт зүйлс нь нийтийн албаны онцгой шинж чанарыг илэрхийлдэг бөгөөд энэхүү гурван үнэт зүйлс OECD буюу Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн байгууллагын (ЭЗХАХБ) гишүүн орнуудын төрийн албаны үнэт зүйлст хамгийн өргөн тархсан байна (OECD. 2000).

Улс орны төрийн албаны үнэт зүйлс нь тухайн орны үндэсний, нийгмийн, улс төрийн, захиргааны орчноос хамааран харилцан адилгүй байх тохиолдол байдаг ч нийтлэг үнэт зүйлс байдаг. Жишээлбэл, ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын төрийн албаны хамгийн нийтлэг үнэт зүйлсийг дараах байдлаар жагсаасан байна. Үүнд (OECD. 2000).:

1. Тэгш байдал буюу ялгавартай хандахгүй шударга байх (impartiality)
2. Хуулийг ёсчлон дагах (legality)
3. Шударга байдал (integrity)
4. Ил тод, нээлттэй байдал (transparency)
5. Үр ашигтай ажиллах (efficiency)
6. Тэгш эрхийг хангах (equality)
7. Хариуцлагатай байх (responsibility)
8. Шударга ёсыг баримтлах (justice)

Судлаач Carol W.Lewis (2005) төрийн албан хаагчийн гол баримтлах үнэт зүйлс болон үндсэн зарчмуудыг дараах нийтлэг байдлаар тодорхойлсон. Үүнд (Lewis, C. W., & Gilman, S. C. 2012):

1. Хариуцлага (accountability) - үр ашигтай, үр дүнтэй ажиллах, үйлдэл болон эс үйлдэлдээ хариуцлага хүлээх, нээлттэй ил тод байх, бусдыг сонсох, хариу үйлдэл үзүүлэх;
2. Үнэнч шударга байдал (fairness) -хуулийг мөрдөх, үйл явцад шударга үндэслэлтэй хандах, шударга хуваарилалт;
3. Тэгш байдал буюу ялгавартай хандахгүй шударга байх (impartiality)- ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, олон нийтийн ашиг сонирхлын төлөө ажиллах, асуудалд бодитой хандах, олон талын оролцоог хангах;
4. Хор хөнөөл учруулахгүй, мууг хийхээс зайлсхийх (avoid doing harms) -нинжин сэтгэлтэй байх, бусдад туслалцаа үзүүлэх;
5. Сайныг хийх (do good) – үргэлж зөв, сайн үйлдэл хийхийг эрмэлзэх.

Ёс зүйтэй хувь хүн – Зан чанар

“Чиний үйлдэл бүхнийг өгүүлж байгаа учраас юу ярьж байгааг чинь сонсогдохгүй байна”; “Хүмүүс юу хэлж байгаагаар бус юу хийж байгааг харж дүгнэдэг”; “Хүний жинхэнэ мөн чанарыг удаан хугацааны туршид ажиглаж дүгнэж болно” зэрэг хэлц үгсээс хүний зан чанар илтгэл, ярианаас илүү бодит үйлдлээс илэрдэг болохыг харж болно. Шударга, үнэнч, найдвартай байдал, итгэл үнэмшил зэрэг хувь хүний шинж чанартай ёс зүйн манлайлал холбоотой ба ийм манлайлагчид нээлттэй, хүмүүст чиглэсэн, халамжтай, бусдын сайн сайхны төлөө чин сэтгэлтэй хүмүүс байх нь нийтлэг. Linda K Trevino, Laura P Harman, Michael Brown нарын (2000) судалгаанд оролцсон байгууллагын удирдлагууд ёс зүйтэй манлайлагчийн нийтлэг зан чанаруудыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд (Treviño, L. K., Hartman, L. P., & Brown, M. 2000):

1. Ёс зүйтэй манлайлагчид ямар ч нөхцөл байдалд *“зөв зүйлийг” хийдэг*. Өөрөөр хэлбэл, манлайлагч өөрийн үнэт зүйлс, зарчмынхаа дагуу үйлдэл хийдэг бөгөөд энэ нь хэзээд итгэж найдаж болохуйц зан чанарын суурь буюу итгэл, хүлээлтийг бий болгодог.
2. Ёс зүйтэй манлайлагчид *хүнлэг*, хүмүүст чин сэтгэлээсээ анхаарал халамж тавьж, бүх хүмүүст ижил хүндлэлтэй ханддаг. Манлайлагчид өөрөөсөө илүү бусдыг боддог, амжилт ололтоо хуваалцдаг, хүний хичээл зүтгэл, идэвхийг үнэлдэг хүмүүс байх ёстой.
3. *Нээлттэй* байх нь ёс зүйтэй манлайлагчийн хувьд сайн сонсогч байх тухай ойлголт юм. Муу мэдээ байсан ч манлайлагч хүлээн авч, сонсож, асуудлын талаар нээллтэй ярилцаж, өөрийн амжилт, уналтын туршлагаас ярилцдаг байх ёстой.
4. *Хувь хүний ёс суртахуун* нь манлайлагчийн хувьд бусдаас илүү их хариуцлагатай, стандарт өндөртэй байхыг шаардаж буйтай холбоотой. Ажлаас гадуур, хувийн үйл хэрэг байсан ч ёс зүйтэй манлайлагчийн хувьд хувь хүний ёс суртахууныг баримтлах шаардлагатай.

Ёс зүйтэй манлайлагчид үнэнч шударга, итгэл даахуйц, найдвартай, зоригтой, хүчтэй, ёс зүйтэй байдлыг үлгэрлэгч байх ерөнхий шинж чанаруудтай байж, энэхүү зан байдал, үйлдлээ ижил нөхцөл байдалд тогтвортой үзүүлэх шаардлагатай (Heres, L., & Lasthuizen, K. 2012). Хэрэв манлайлагчид өөрийн зан үйлдлээ байнга сольж байвал дагалдагчид нь түүнийг тааварлашгүй, найдваргүй, итгэлгүй гэж үзэх магадлалтай. Түүнчлэн манлайлагчид ямар нэгэн үнэт зүйлийг сурталчлан дэмждэг атал өөрийн үйлдлээрээ тэрхүү үнэт зүйлсээ батлахгүй бол дагалдагч нар итгэхээ больдог. Ёс зүйтэй болон ёс зүйгүй манлайлагчдын зарим зан чанаруудыг Хүснэгт 2-д нэгтгэн харуулав.

Хүснэгт 2: Ёс зүйтэй болон ёс зүйгүй манлайлагчдын зарим зан чанарууд

Ёс зүйтэй манлайлагч	Ёс зүйгүй манлайлагч
Даруухан	Өөрийгөө боддог, онгироо, дээрэлхүү
Олны сайн сайхныг төлөө	Өөрийн ашиг сонирхлыг дээдэлдэг
Үнэнч, шулуун шударга	Хуурч мэхэлж, худлаа ярьдаг

Амлалтаа биелүүлдэг	Амлалт гэрээг зөрчдөг
Шударга байхын төлөө ажилладаг	Шударга бус харилцаа, зан үйлдэл
Хариуцлагаа хүлээдэг	Бусдыг буруутгадаг
Хүн болгоныг хүндэлдэг	Бусдыг үл хүндэлдэг
Бусдыг хөгжүүлж, зоригжуулдаг	Дагалдагчаа хөгжүүлдэггүй
Бусдын төлөө ажилладаг	Тусламж, дэмжлэг үзүүлдэггүй
Зөв зүйлийн төлөө зогсох зоригтой	Ёс зүйгүй, шударга бус үйлдэлтэй нүүр тулах зориггүй

Эх сурвалж: Mihelič, K. K., Lipičnik, B., & Tekavčič, M. (2010). Ethical leadership. *International Journal of Management and Information Systems, 14*(5), 33.

Ёс зүйтэй хувь хүн – Шийдвэр гаргалт

Ёс зүйтэй манлайлагчид тогтвортой, зан үйл болон өөрийн шийдвэртээ тууштай хандаж, үг үйлдэл нь зөрдөггүй шинж чанартай. Шийдвэртээ тууштай хандахын үндэс нь баримталдаг үнэт зүйлс, зарчмаа дагах явдлаас гадна шийдвэрийнхээ үр нөлөөг зөвхөн байгууллагад бус олон нийт, нийгэмд хэрхэн нөлөөлөх талаар бодох шаардлагатай. Аливаа шийдвэрийг гаргахдаа хэрэв миний шийдвэр сонины эхний нүүрэнд гарвал ямар байх вэ гэж төсөөлөн бодсоноор манлайлагч өөрийн шийдвэрийн ёс зүйтэй байдал, нийгэмд үзүүлэх нөлөөллийн талаар эргэцүүлэх боломжтой (Treviño, L. K., Hartman, L. P., & Brown, M. 2000). Мөн тэдний шийдвэр, зан үйл дагагчдад хүчтэй нөлөөлж байдаг тул нээлттэй, хүнлэг, энэрэнгүй байж, дагагч нартаа итгэж, хүндэлж, шударга ханддаг (Heres, L., & Lasthuizen, K. 2012).

БАГАНА 2: ЁС ЗҮЙТЭЙ МЕНЕЖЕР

Ёс зүйтэй хувь хүний багана “хувь хүн өөрөө ёс зүйтэй хүн мөн үү?”, “ёс зүйтэй хүн ямар байх ёстой вэ?” гэсэн ойлголтыг хүмүүст өгдөг хэдий ч ёс зүйтэй байхын тулд юу хийх ёстой болохыг тайлбарладаггүй. Ёс зүйтэй менежерийн элемент нь бусдын ёс зүйтэй шийдвэр гаргалт, зан үйлийг дэмжихийн тулд ёс зүйн талаарх хүчтэй мэдээллийг өгч, хүмүүсийн бодол санаа, зан үйлд нөлөөлж буй манлайлагчийн урьдаас тооцоолон зориудаар гаргаж буй зан үйлийн тухай ойлголтыг багтаадаг.

Ёс зүйтэй менежерийн багана нь: а) Манлайлагч өөрөө ёс зүйн үлгэр жишээ болох; б) Бусдыг ёс зүйтэй байхыг дэмжихийн тулд идэвхжүүлэлтийн арга хэрэгслийг ашиглах; в) Ёс зүй, үнэт зүйлсийн талаарх харилцаа гэсэн дэд элементүүдтэй (Heres, L., & Lasthuizen, K. 2012). Linda K Trevino, Laura P Harman, Michael Brown нарын (2000) судалгааны үр дүнд байгууллагын удирдлагад ажиллаж буй манлайлагчид ёс зүйтэй хувь хүн байх, ёс зүйтэй шийдвэр гаргаж байхад л хангалттай бөгөөд сайн удирдагч болгон ёс зүйтэй удирдагч гэж өрөөсгөл үздэг талаар бичжээ (Heres, L., & Lasthuizen, K. 2012). Тэдгээр манлайлагчид өөрсдийгөө шударга, хүнлэг, үнэнч гэх мэт зан чанартай сайн буюу ёс зүйтэй хувь хүн байхад, бусад хүмүүс мөн адил шууд тэгж харна хэмээн

андуурдаг. Бодит байдалд ажилчид тэр болгон манлайлагчдын хувийн зан чанарыг сайн мэдэж, шууд үлгэрлэн дуурайдаггүй. Иймээс бусдыг ёс зүйтэй байхад уриалан дуудахын тулд зөвхөн өөрөө ёс зүйтэй хувь хүн байгаад зогсохгүй, ёс зүйтэй менежер гэсэн элементийг багтаах шаардлагатай.

Ёс зүйтэй менежер – Үлгэр жишээ үзүүлэх

Ёс зүйтэй хүний үлгэр жишээ үзүүлэх тухай ойлголт нь ёс зүйтэй хувь хүний элементтэй давхцаж буй мэт боловч энэ баганад "бусдад харагдах" зан үйлд илүү ач холбогдол өгдөг (Heres, L., & Lasthuizen, K. 2012).. Манлайлагч ажил дээрээ болон ажлын бус цагаар, санаатай болон санамсаргүй байдлаар баримталдаг үнэт зүйлс, зарчмын талаарх мэдээллээ өөрийн биеэр бусдад түгээж байдаг.

Иймээс манлайлагчид өөрийн үг, үйлдлээ хянаж, ямар мессеж, дохио бусдад түгээж байгаагаа анзаарах шаардлагатай. Манлайлагчид өөрсдийн зан үйлээр үлгэр дуурайлал үзүүлэхгүй бол тэдний үгс хүчгүй байх болно (Lawton, A., Rayner, J., & Lasthuizen, K. 2013). Гэвч, ёс зүйтэй манлайлагчид сөрөг, эсхүл зөрчилдөөнтэй дохиог өгөхгүй байхын тул анхааралтай хандах ёстой. Зарим тохиолдолд, үггүй үйлдэл хүчтэй мессежийг тарааж болно. Ажилтнууд сайн жишээг даган дуурайдаг шиг манлайлагчийн санамсаргүй гаргасан сөрөг үйлдлийг хуулбарладаг. Ёс зүйгүй манлайлал нь идэвхгүй манлайллаас илүү байгууллагад хор хөнөөлтэй (Lawton, A., Rayner, J., & Lasthuizen, K. 2013).

Ёс зүйтэй менежер – Идэвхжүүлэх

Аливаа байгууллагад хүссэн болон хүсээгүй зан үйлдлийг зохицуулах хамгийн үр дүнтэй арга хэлбэрүүдийн нэг нь шагнал, урамшуулал, шийтгэлийн систем юм. Ёс зүйтэй манлайлагч байгууллагын гишүүдийн зан үйлдэлд хариуцлага хүлээлгэх, урамшуулал болон шийтгэлийн тусламжтайгаар ёс зүйн стандартыг бэхжүүлэхэд анхаарал хандуулдаг. Учир нь, ажилтнууд урамшуулдаг зүйлийг илүү их хийж, шийтгэл хүлээх зүйлээс зайлсхийдэг. Хэрэв ёс зүйгүй зан үйл нь санаатай, эсхүл санамсаргүй байсан ч шийтгэгдээгүй, хөнгөн шийтгэсэн, эсхүл урамшуулснаас энэ нь түүнийг хүлээн зөвшөөрөх зан үйл гэж ойлгогдож тухайн үйлдэл ирээдүйд үргэлжлэх магадлалтай (Lawton, A., Rayner, J., & Lasthuizen, K. 2013). Урамшуулал болон шийтгэл ил тод, бусад хүмүүст тайлбарлахад хялбар байвал албадлага нь зөвхөн шийтгэгдсэн эсхүл урамшуулал авсан хүнд бус манлайлагчийн үйлдлийг ажиглаж буй бусад хүмүүст ч сургамж, суралцахуйн туршлага болдог.

Ёс зүйтэй манлайлагч ёс зүйтэй үйлдлийг тогтмол дэмжиж, шагнаж урамшуулан, ёс зүйгүй үйлдэлд хариуцлага тооцдог, ингэснээр байгууллагад ёс зүйн стандарт, хэм хэмжээ, дүрэм журмыг сахиулах боломжтой. Аливаа шийтгэл, шагнал урамшуулал хувь хүнд бус харин үйлдэлд тохирсон байх ёстойг ёс зүйтэй манлайлагч байнга санах ёстой, учир нь ёс зүйн үнэт зүйлс, зарчмууд хувь хүний байр суурь, статус, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, болон бусад хэмжүүрээс үл шалтгаалан хувиршгүй байна.

Ёс зүйтэй менежер – Харилцах

Байгууллагын гишүүд буюу дагалдагчид нь манлайлагч болон хамтран ажиллагсадтайгаа ёс зүйн талаар ярилцахдаа өөрсдийгөө тав тухтай, аюулгүй гэж мэдрэх, тэдэнтэй тулгардаг ёс зүйн эргэлзээтэй асуудлын талаар хэлэлцэх, зөвлөгөө хүсэх, гаргасан алдааныхаа тухай үнэнээ хэлэх, манлайлагчид хүндрэл бэрхшээлээ мэдээлэх, муу мэдээ хүргэхэд бэлэн байх орчныг бүрдүүлэх хэрэгтэй. Манлайлагчид ёс зүйн асуудлыг хүлээн зөвшөөрч, өөрсдийн ёс зүйн сонголт болон шийдвэрээ нээлттэй, ил тод, шударга байлгаснаар энэ төрлийн ёс зүйн орчныг бүрдүүлэхэд дэмжлэг болдог. Манлайлагч ёс зүйн талаар тогтмол ярих нь бусдад “энэ байгууллагад ёс зүйн асуудал чухал” гэсэн мессежийг тараана. Гэвч зөвхөн ёс зүйн талаарх яриа хүссэн үр дүнг хангалттай авчрахгүй тул манлайлагчид өөрт болон байгууллагад чухал гэж үзсэн үнэт зүйлс, зарчмуудын талаар үгээр болон үйлдлээр үзүүлэх ёстой.

ЁС ЗҮЙН МАНЛАЙЛАЛ БА МАНЛАЙЛАГЧИЙН НЭР ХҮНД

Ёс зүйн манлайллын хоёр баганыг матриц хэлбэрт оруулахад ёс зүйн манлайлагчийн дөрвөн төрөл тодорхойлогдоно.

Зураг 1: Ёс зүйн манлайлал ба гүйцэтгэл

Ёс зүйтэй менежер	**Хүчтэй**	“Хуурамч” манлайлагч	Ёс зүйтэй манлайлагч
	Сул	Ёс зүйгүй манлайлагч	Тодорхой бус “саармаг” манлайлагч
		Хүчтэй	**Сул**

Ёс зүйтэй хувь хүн

Эх сурвалж: Treviño, L. K., Hartman, L. P., & Brown, M. (2000). Moral person and moral manager: How executives develop a reputation for ethical leadership. *California Management Review, 42*(4), 129.

Ёс зүйтэй хувь хүн болон менежерийн хүчтэй хослол нь “Ёс зүйтэй манлайлагч” гэсэн нэр хүндийг авчирна. Харин ёс зүйтэй хувь хүн болон менежерийн талууд хоёул сул байх нь “Ёс зүйгүй манлайлагч” байх үндсийг бүрдүүлэх юм. Харин өөрөө хувь хүний хувьд ёс зүйтэй биш хэдий ч ёс зүйн асуудлыг байнга ярьдаг бол “Хуурамч” манлайлагч гэсэн ангилалд хамааруулна. Өөрөөр хэлбэл, ярьдаг боловч үйлдэл хийхгүй байх нь манлайлагчийн үгийг хүчгүй болгодог. Ёс зүйн талаар хэт их яриад энэ талаар бодит үйлдэл дээрээ өөр байх нь огт ярихгүй байснаас илүү хор хөнөөлтэй (Treviño, L. K., Hartman, L. P., & Brown, M. 2000). Учир нь ёс зүйн талаар хэт их ярьснаар хүмүүсийн огт анзаарахгүй байсан асуудлыг ил гаргадаг бөгөөд үүнээс үүдээд манлайлагчийн ярьсан бүхэн үнэ цэнгүй болох магадлалтай. Ёс зүйн хувьд тодорхой бус “саармаг” манлайлагч ангиллын хувьд хэд хэдэн янзаар тайлбарлаж болно. Нэг талаар манлайлагч ёс зүйгүй биш, гэхдээ ёс зүйтэй гэхэд хангалттай бус гэсэн ойлголтыг бусдад төрүүлж болно. Нөгөө талаар, манлайлагч ёс зүйд төдийлөн ач холбогдол өгч, анхаарал хандуулдаггүй учраас энэ ангилалд хамаарагдах магадлалтай (Treviño, L. K., Hartman, L. P., & Brown, M. 2000).

ЁС ЗҮЙН МАНЛАЙЛЛЫН АЧ ХОЛБОГДОЛ

Судлаач Bass (1990) ёс зүйтэй манлайлагч байхын үр ашгийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд (Kabey M, 2018).:

1. Байгууллагад эерэг дүр төрхийг бүрдүүлэх, нэмэгдүүлэх
2. Хөрөнгө оруулагчид, харилцагчдын итгэлийг нэмэгдүүлэх, сэргээх
3. Гэмт хэргийн шинжтэй аливаа торгууль, төлбөрөөс урьдчилан сэргийлэх, багасгах
4. Ажиллагсад байгууллагад шийдэгдээгүй асуудлын улмаас зарга мэдүүлэх, хууль шүүхийн байгууллагад гомдол гаргахаас урьдчилан сэргийлэх
5. Ажиллагсдын сэтгэл ханамж нэмэгдэх, хүний нөөцийн гарах урсгал багасаж, улмаар бүтээмж нэмэгдэх
6. Харилцагчид, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж сайжрах
7. Бусад байгууллагад эерэг үлгэр жишээ болох.

Ёс зүйтэй манлайллын үр дүнд ажилтнуудын сэтгэл ханамж дээшлэх, байгууллагын удирдлагад итгэх итгэл нэмэгдэх, байгууллагынхаа төлөө ажилтнууд дуу хоолойгоо хүргэх гэх мэт бусад олон үр ашигтай үр дагаврууд гардаг болохыг судлаачид онцолдог (Downe, J., Cowell, R., & Morgan, K. 2016). Ёс зүйтэй удирдах нь урт хугацаанд хууль зүйн аливаа асуудал сэргийлдэг. Ёс зүйтэй удирдана гэдэг нь зөв, бурууг сайтар ялгаж, өөрийн үйлдлээр дагагч нартаа тогтмол үлгэр дуурайлал үзүүлж байхыг хэлнэ. Манлайлагч ёс зүйтэй байхын тулд өөрийн баримталдаг зарчим, үнэт зүйлсээ хамгаалсан үйлдэл, шийдвэр гаргах ёстой бөгөөд хамгийн чухал нь байнга, тогтвортой байх нь чухал байдаг байна. Судлаач J.B.Ciulla ёс зүйтэй манлайлагч бол үр дүнтэй манлайлагч байдаг гэж үзсэн байдаг боловч бодит байдалд ёс зүйтэй боловч үр дүн муутай эсвэл үр дүнтэй боловч ёс зүйгүй удирдагч, манлайлагч нар олон байдаг (Mihelič, K. K., Lipičnik, B., & Tekavčič, M. 2010).

Ёс зүйтэй манлайлагч нар өөрсдийн үйлдэл, шийдвэрийн богино болон урт хугацааны үр дагавар, үр ашиг, сул талуудыг бодож, өөрийн үнэт зүйлс, зарчмаа дагадаг. Байгууллагын албан хаагчид манлайлагчийн үйлдлээс үнэт зүйлс, зарчмыг суралцдаг бөгөөд энэ нь байгууллагын соёл болон түгдэг. Манлайлагч үнэт зүйлс, зарчмаа үйлдэл болгон үлгэр дуурайлал үзүүлэх тусам, түүнд итгэл итгэл, хүндэтгэл нэмэгдэнэ. Хэрэв манлайлагч үнэт зүйлс, зарчмаа даган байгууллагын болон албан хаагчдын төлөө хувийн золиос гаргахад бэлэн байвал албан хаагчид мөн адил үйлдэл гаргахад бэлэн байдаг (Mihelič, K. K., Lipičnik, B., & Tekavčič, M. 2010). Сайн манлайлагч өөрийн үйлдлийг олон хүнд нөлөөлнө гэдгийг мэддэг тул хянамгай, няхуур байдаг. Хэрэв манлайлагч албан хаагчдын ёс зүйтэй зан байдалд нөлөөлөх хүсэлтэй бол ёс зүйн хэм хэмжээг тогтоож, тэдэнд мэдээлж, харилцаа тогтоож, бодит жишээгээр үлгэрлэн үзүүлэх нь үр дүнтэй. Энэ нь зөвхөн ёс зүйн кодыг батлах нь хангалттай биш гэсэн үг ба ёс зүйтэй байдлыг байгууллагын бүх үйл ажиллагаанд тогтмол дэмжих ёстой.

Байгууллагад ёс зүйтэй манлайлагч хүмүүсийг буруу үйлдэл, шийдвэр гаргахаас сэргийлэхээс илүү тэднийг зөв үйлдэл, шийдвэрийг гаргахад дэмжихэд анхаарлаа хандуулах ёстойг судлаачид сануулж байна (Mihelič, K. K., Lipičnik, B., & Tekavčič, M.

2010). Байгууллагад ёс зүйтэй байх соёлыг түгээх, зөв зан үйлийг дэмжихэд манлайлагчдын үйлдэл чухал үүрэгтэй. Манлайлагчид албан ёсны дүрэм журамд найдаж хүлээхээс илүү асуудал гарахаас өмнө урьдчилан сэргийлэх, байгууллага дах зөв зан зүйлийг дэмжихэд албан бусаар оролцоход бэлэн байх хэрэгтэй (Downe, J., Cowell, R., & Morgan, K. 2016). Манлайлагчийн хувийн ёс зүй байгууллагын албан ёсны ёс зүйн дүрэм журмын үр дүнтэй байдлыг дэмжихэд чухал үүрэгтэй. Ёс зүйн соёлтой байгууллагад хүмүүс эргэлзээтэй асуудалтай тулгарахад аяндаа зөв зүйлийг хийдэг ба манлайлагчид ёс зүйн соёлыг бий болгоход, түгээн дэлгэрүүлэх, хадгалахад чухал үүрэгтэй (Downe, J., Cowell, R., & Morgan, K. 2016). Ёс зүйтэй манлайлагч нь ёс зүйтэй шийдвэр гарч буй эсэхийг хариуцах, байгууллагад ёс зүйтэй байх уур амьсгалыг дэмжих үүрэгтэйгээс гадна байгууллагын нэр хүндийг гадаад орчинд илэрхийлэх дүр төрх болдог (Mihelič, K. K., Lipičnik, B., & Tekavčič, M. 2010). Манлайлагчид байгууллагын албан хаагчдын ёс зүйн үзэл баримтлалын чухал эх үүсвэр болохын зэрэгцээ байгууллагад ёс зүйг дэмжих үүрэг хариуцлагыг хүлээдэг (Mihelič, K. K., Lipičnik, B., & Tekavčič, M. 2010). Аливаа байгууллагын удирдлагын зан байдал байгууллага даяар тархаж, энэ нь байгууллагын уур амьсгал, магадгүй байгууллагын соёлыг бүрдүүлнэ. Иймээс ёс зүйтэй манлайлагч зөвхөн өөрөө ёс зүйтэй байгаад зогсохгүй, бусдыг ёс зүйтэй байхад уриалан дуудаж, үлгэр дуурайлал үзүүлэн дэмжих ёстой болно. Ёс зүйн манлайллын хамгийн чухал зорилго бол ёс зүйтэй шийдвэр гаргалт, зан үйлийг дэмжих явдал болно (Heres, L., & Lasthuizen, K. 2012).

Хэдийгээр манлайлагчид өөрсдийн зан үйлээр болон захиргааны арга хэрэгслээр дамжуулан бусдын үйлдэлд өөрчлөлт оруулдаг болохыг судлаачид баталж байгаа боловч манлайлагч, ёс зүйн үнэт зүйлсэд суурилсан арга хэрэгсэл болон дүрэм журамд суурилсан арга хэрэгслийн хоорондын харилцаа холбооны талаар тун хангалтгүй судлагдсан байдаг (Downe, J., Cowell, R., & Morgan, K. 2016). Түүнчлэн бизнесийн ёс зүйтэй харьцуулахад төрийн албанд ёс зүйтэй манлайллын үр нөлөөний талаарх судалгаа харьцангуй цөөн байна. Ёс зүйн манлайлал байгууллага дах ёс зүйн орчин болон бусад үйл ажиллагаанд эерэг нөлөөтэй.

ЁС ЗҮЙН МАНЛАЙЛАЛ БА БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ

Байгууллагад ёс зүйтэй байх соёлыг түгээх, зөв зан үйлийг дэмжихэд манлайлагчдын үйлдэл чухал үүрэгтэй (Downe, J., Cowell, R., & Morgan, K. 2016). Манлайлагчид албан ёсны дүрэм журамд найдаж хүлээхээс илүү асуудал гарахаас өмнө урьдчилан сэргийлэх, байгууллага дах зөв зан зүйлийг дэмжихэд албан бусаар оролцоход бэлэн байх хэрэгтэй. Манлайлагчийн хувийн ёс зүй байгууллагын албан ёсны ёс зүйн дүрэм журмын үр дүнтэй байдлыг дэмжихэд чухал үүрэгтэй. Ёс зүй нь сайн засаглалын чухал элемент төдийгүй төрийн бүх хэлбэрийн үйл ажиллагаанд олон нийтийн итгэл нэмэгдүүлэхэд ихээхэн үр нөлөөтэй (Joyce, P. 2014, October).

Ёс зүйн соёлтой байгууллагад хүмүүс эргэлзээтэй асуудалтай тулгарахад аяндаа зөв зүйлийг хийдэг ба манлайлагчид ёс зүйн соёлыг бий болгоход, түгээн дэлгэрүүлэх, хадгалахад чухал үүрэгтэй (Downe, J., Cowell, R., & Morgan, K. 2016). Ёс зүйн соёл нь албан (ёс зүйн кодыг хэрэгжүүлэх бодлого, дүрэм журам, захиргааны бүтэц, шагнал урамшууллын систем, ёс зүйн сургалтын хөтөлбөр) болон албан бус (бүлгийн зан үйл,

ёс зүйн норм, дэг журам, цуу яриа) элементүүдтэй (Schaubroeck, J. M., Hannah, S. T., Avolio, B. J., Kozlowski, S. W. J., Lord, R. G., Treviño, L. K., ... & Peng, A. C. 2012). АНУ-ын 6 их сургуулийн эрдэмтдийн (Michigan State university, Wake Forest university, University of Washington, Akron university, Pennsylvania State university, Georgia State university) хамтарсан АНУ-ын зэвсэгт хүчний 2572 хүнийг хамруулсан судалгааны үр дүн 2012 онд хэвлэгдсэн (Schaubroeck, J. M., Hannah, S. T., Avolio, B. J., Kozlowski, S. W. J., Lord, R. G., Treviño, L. K., ... & Peng, A. C. 2012). Энэхүү судалгаанд шатлан захирах түвшинд ёс зүйн манлайлал болон ёс зүйн соёлын шууд болон шууд бус үр нөлөөний талаар судалсан.

Зураг 2. Шатлан захирах түвшинд ёс зүйн манлайлал болон ёс зүйн соёлын шууд болон шууд бус үр нөлөө



*Тасархай зураасаар “хөндлөнгийн нөлөө” буюу шууд бус үр нөлөө харуулав.

Судалгааны үр дүнд манлайлагчийн албан тушаал дээд түвшинд байх тусмаа ёс зүйн соёлыг илүү олон түвшинд буюу хүмүүст нөлөөлөх боломжтойг харуулсан. Өөрөөр хэлбэл, байгууллагын дээд удирдлагын ёс зүйтэй эсхүл ёс зүйгүй зан үйл нь байгууллага даяар шууд болон шууд бус хэлбэрээр нөлөөлдөг болохыг зураг 2-с харж болно.

Манлайлагчид өөрсдийн түвшинд буюу нэгж, хэлтэс, газартаа ямар зан үйлийг дэмжиж урамшуулах, шийтгэх, хүлцэж өнгөрөөх талаар хүлээлт бий болгодог. Мөн уг манлайлагчид өөрсдийн түвшний дагагч нарт юу зөв, буруу болох талаар үлгэр жишээг өөрийн биеэр үзүүлж байдаг (Schaubroeck, J. M., Hannah, S. T., Avolio, B. J., Kozlowski, S. W. J., Lord, R. G., Treviño, L. K., ... & Peng, A. C. 2012). Edgar Schein-ний тодорхойлсноор “манлайлагчид юунд анхаарал хандуулж, юуг үнэлж, юуг хянаж байгаа нь хамгийн хүчтэй арга хэрэгсэл болно (Schaubroeck, J. M., Hannah, S. T., Avolio, B. J., Kozlowski, S. W. J., Lord, R. G., Treviño, L. K., ... & Peng, A. C. 2012). Түүнчлэн үлгэр жишээ үзүүлэх, зааж сургах, дасгалжуулах болон шагнал урамшуулал, статус түгээх зэрэг нь бусад үндсэн арга хэрэгслүүд багтана.

Дүгнэлт

Аливаа байгууллагад ёс зүйн дүрэм, журмыг идэвхтэй хэрэгжүүлэх эсэх, ёс зүйн соёлыг бүрдүүлэх эсэх нь удирдлага, манлайлагчдаас ихээхэн хамаардаг. Ёс зүйтэй манлайллыг хувь хүний ёс зүйтэй холбон үзэх нь нийтлэг боловч онолын хувьд ёс зүйтэй хувь хүн

болон ёс зүйтэй менежер гэсэн хоёр үндсэн баганын дэд элементүүдийг бүрэн хамруулж ойлгох нь зүйтэй. Ёс зүйтэй манлайлал үр дүнтэй байхын тулд байгууллагад манлайлагчийн хувь хүний нүдэнд харагдахуйц үйлдлүүд бусдад үлгэр жишээ болж, даган дуурайх, дэмжих бололцоог бий болгож, “илтгэж, ярих” бус “бодитоор” үзүүлж харуулах нь чухал. Ёс зүйтэй манлайлал нь зөвхөн хууль, тогтоомж, дүрэм журмыг мөрдөхөөс гадна хувь хүний ёс зүйн үнэт зүйлс тэдгээрийг хэрэгжүүлэх, ёс зүйтэй орчныг бүрдүүлэхэд онцгой ач холбогдолтой. Монгол Улсад ёс зүйн манлайллын судалгаа хомс байгаа бөгөөд цаашид төрийн албанд ёс зүйн манлайллын ойлголтыг нэвтрүүлж, хэрэгжүүлэх нь төрийн албан хаагчдын мэргэшсэн, тогтвортой, ёс зүйтэй, хариуцлагатай ажиллах үндэс суурь болох юм.

Ашигласан материал

Downe, J., Cowell, R., & Morgan, K. (2016). What determines ethical behavior in public organizations: Is it rules or leadership? *Public Administration Review, 76*(6), 898.

Geuras, D., & Garofalo, C. (2011). *Practical ethics in public administration* (p. 260).

Heres, L., & Lasthuizen, K. (2012). What’s the difference? Ethical leadership in public, hybrid and private sector organizations. *Journal of Change Management, 12*(4), 441.

Jordan, J., Brown, M. E., Treviño, L. K., & Finkelstein, S. (2011). Someone to look up to: Executive-follower ethical reasoning and perceptions of ethical leadership. *Journal of Management*, *37*(5), 2.

Joyce, P. (2014, October). The culture of ethics that the public sector needs. *Governing*. http://www.governing.com/columns/smart-mgmt/col-culture-ethics-public-sector-needs.html (accessed December 21, 2024).

Kabeyi, M. (2018). *Ethical and unethical leadership issues, cases, and dilemmas with case studies*. *International Journal of Applied Research, 4*(7), 373.

Lawton, A., Rayner, J., & Lasthuizen, K. (2013). *Ethics and management in the public sector* (p. 159). Routledge.

Lewis, C. W., & Gilman, S. C. (2012). *The ethics challenge in public service: Problem solving guide* (pp. 30–35). A Wiley Imprint.

Mihelič, K. K., Lipičnik, B., & Tekavčič, M. (2010). Ethical leadership. *International Journal of Management and Information Systems, 14*(5), 33.

OECD. (2000). *Trust in government: Ethics measures in OECD countries* (p. 12).

Schaubroeck, J. M., Hannah, S. T., Avolio, B. J., Kozlowski, S. W. J., Lord, R. G., Treviño, L. K., ... & Peng, A. C. (2012). Embedding ethical leadership within and across organization levels. *Academy of Management Journal, 55*(5), 1055–1078.

Trevino, L. K., Hartman, L. P., & Brown, M. (2000). Moral person and moral manager: How executives develop a reputation for ethical leadership. *California Management Review, 42*(4), 128.

SPSIRPA FORUM 2025

Session 6-5

Implementation of Inclusive Education Policy

Монгол Улс дахь тэгш хамруулах боловсролын эрх зүйн орчны агуулгын шинжилгээ

([1]Б.Цог, [2]Ц.Ариунзул, [3]Д.Эрдэнэтуяа)

МУИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны тэнхим

Хураангуй

Монгол улсад тэгш хамруулах боловсролын онол, арга зүйн судалгаа хийх багш, судлаачид нэмэгдэж, тал бүрийн судалгаа хийж байна. Үүний нэг нь 2021-2024 онд хэрэгжсэн Европын холбооны ЭРАСМУС+ хөтөлбөрийн “Монгол улсад тэгш хамруулах боловсролын багш бэлтгэх төсөл”, БШУЯ, АХБ-ны “Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл” зэрэг сургалт, судалгааны томоохон төслүүд хэрэгжиж бодит ажил хэрэг болсон. Эдгээр төслүүд нь их, дээд сургуулийн багш, судлаач, оюутнууд төдийгүй төдийгүй төр, засгийн шийдвэр гаргах түвшний хүмүүс хүртэл тэгш хамруулах боловсролын тухай нэгдсэн ойлголттой байх нь чухал гэж үзэж энэ чиглэлээр хэд хэдэн сургалт, судалгаа хийж гарын авлага хэвлүүлээд байна.

Хэдийгээр төслүүд үр дүнтэй хэрэгжиж байгаа ч төр засгийн бодлого, эрх зүйн орчны нөхцөл байдлыг судлах хэрэгцээ байна. Учир нь тэгш хамруулах боловсрол нь боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал зэрэг салбар дунд асуудал мөн учир маш олон бодлого, хууль, журам, заавар, аргачлал батлагдсан байдаг.

Бид боловсролын салбарын хуулиуд дахь тэгш хамруулах боловсролын судалгааг ойлголтоо нэгтгэж хүрсэн үзэл санаа, агуулгыг үндэслэн дараах индикаторыг боловсруулан энэхүү судалгааг хийв.

Түлхүүр үг

Тэгш хамруулах боловсрол, эрх зүйн агуулга,

Хоёр. Судлагдсан байдал

Нийгмийн гишүүд соёл, боловрол, эрүүл мэнд, эдийн засаг, улс төрийн зэрэг олон анги, бүлэг, нийтлэгт хуваагдаж орших агаад тэдгээрийн сонирхол хэрэгцээ түүнээс ч олон янзаар илэрч, үргэлжлэн оршин байх нь түүхийн үзэгдэл, баримтаар нотлогддог билээ. Тэр хэмжээгээр нийгмийн бараан, гэгээн түмэн асуудлууд шийдэл хүлээсээр цаг хугацаа, орон зай бүхэнд өөр өөрийн төрөл, хэлбэрээр оршин байдаг. Нийгмийн гишүүдийн олон янзын хэрэгцээ, сонирхол, харилцан адилгүй хүсэл нь зөвшилцөх, тохиролцох хийгээд зөрчилдөх тэмцэлдэхийн уулзварт тэнцвэртэй, тэгш байдлыг байгаль, нийгмийн жам ёсыг шаарддаг. Иймийн учир зөвшилцөл, зөрчилдөөнийг шийдвэрлэх, хоорондох харилцааг нь зохицуулахад чухамхүү хууль, эрх зүй чухал шийдвэрлэх үүрэгтэй байдаг. Улс орнуудын засаг төр тэдгээр олон янз сонирхол хэрэгцээг хангах, хамгаалахдаа эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулж байдаг.

Тэгэхлээр хууль нь тухайн улсад амьдарч буй хүмүүс, иргэдийн нийтлэг эрх ашгийг хамгаалахын төлөө үйлчилдэг (БШУЯ, 2019), засаг төрийн дээд эрхийг барих

байгууллагаас улсын хэмжээгээр бүх нийтийг заавал дагаж мөрдүүлэхээр баталсан албан ёсны дүрэм, журам (ШУА, 2025) баримт бичиг мөн.

Монгол улс 1992 онд шинэ Үндсэн хууль баталснаас хойш боловсролын болон бусад салбарын хууль, бодлогоор тал талаас нь ойлгож, тайлбарлаж ирсэн. Харин сүүлийн жилүүдэд тэгш хамруулах боловсролын (inclusive education) асуудал нь дан ганц боловсролын асуудал биш бөгөөд эрүүл мэнд, нийгмийн хамгаалал зэрэг салбар дундын оролцоонд тулгуурласан хуульчилан баталгаажуулж, хэрэгжүүлж байна.

1.Тэгш хамруулах боловсрол гэж юу вэ?

Ойлголт, нэр томьёоны хувьд disability буюу хөгжлийн бэрхшээл, spacial need буюу тусгай хэрэгцээ, integration[309] хэмээх ойлголт нь өөр өөрийн онцлог бүхий агуулгаар судлан, тайлбарлаж ирсэн байна.

XVIII зууны дунд үеэс Европын соён гэгээрлийн нэг илрэл бол хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад зориулсан боловсролын асуудал эхэлж аажимдаа нийгэмд үл тоогдсон бүлгүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, галзуу гэгдэх хүмүүст тулгардаг тэгш бус байдлыг халахыг шаардсан шинэчлэлийн хөдөлгөөн үүссэн байна. XX зууны ихэнх үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн бусад бүлгээс ялгаатай гэж ойлгох, тэднийг тусгай сургуульд хамруулах явдал түгээмэл байв. Харин XX зууны II хагас дахь (1960-аад оны АНУ дахь иргэний эрхийн хөдөлгөөн, 1975 оны Бүх нийтийн боловсролыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгох) тусгаарлагдсан байдлыг халах алхмууд хийж эхэлсэн байдаг. (ERASMUS, 2023)

Олон улсын конвенц, боловсролын онол, үзэл баримтлал, суурь судалгааны тайлангуудад “тэгш хамруулах боловсрол”-ыг дараах байдлаар тайлбарласан байна.

> *“Тэгш хамруулан сургах боловсрол гэдэг нь ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг халан, суралцагчдын харилцан адилгүй байдал, ялгаатай хэрэгцээ, чадвар, онцлог шинж, сурах хүсэл эрмэлзлэлийг нь хүндэтгэн үзэж бүх нийтэд чанартай боловсрол олгоход чиглэгдсэн үйл явц юм” Женев конвеци* (АДРА, 2016)
>
> *“Хүүхэд бүрд өөрийн гэсэн онцлог хэв шинж, сонирхол, авьяас чадвар болон суралцах хүсэл хэрэгцээ байдаг тул тэдний боловсрол эзэмших эрхээ хэрэгжүүлнэ гэдэг нь эдгээр харилцан адилгүй чадвар, хэрэгцээ, шаардлагыг нь тусгасан боловсролын хөтөлбөрүүдэд хамруулахыг хэлнэ”* (Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй , 2010)
>
> *“Тэгш хамруулах боловсрол нь хувь хүний онцлог хэрэгцээ шаардлагад нийцсэн нэмэлт дэмжлэг үзүүлэх замаар бүх хүүхдийг хамтдаа суралцах боломжтой болгодог.”* (Карин Шелциг, 2020)
>
> *“Орчин үеийн inclusive буюу тэгш хамруулан сургах боловсрол нь суралцагчийн хэрэгцээ, сонирхол, авьяас, чадвар, хөгжлийн онцлогт нийцсэн, тэдэнд тэгш боломж олгосон, олон хувибартай, чөлөөтэй, нээлттэй, чанартай, ямарваа нэгэн ялгаварлан гадуурхалтаас ангид боловсрол олгоход чиглэсэн үйл явц”* (АДРА, 2016)

[309] НҮБ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тунхаглал”-д энэ нь хувь хүний асуудал төдийгүй нийгэм, бусад хүмүүст хамаатай гэх үзэл санаа

“Тэгш хамран сургах боловсрол гэж суралцахуйн бүхий л үйл явцад тулгарах аливаа саад бэрхшээлийг тодорхойлж, түүнийг арилгах замаар бүх хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид чанартай, тэгш боломж, нөхцөлд суралцах үйл явцыг хэлнэ. (БШУЯ А. , 2023)

“Тэгш хамран сургах боловсрол гэж суралцахуйн бүхий л үйл явцад тулгарах аливаа саад бэрхшээлийг тодорхойлж, түүнийг арилгх замаар бүх хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид чанартай, тэгш боломж, нөхцөлд суралцах үйл явцыг хэлнэ. (БШУЯ А. , Тэгш хамран сургах боловсролын бодлого, соёл, үйл ажиллагааг хэрэгжүүлэх сургалтын гарын авлага, 2023)

Тэгш хамруулах боловсролын үзэл санааг *1.ээлтэй, таатай орчин, 2.хөгжлийн онцлог, ялгаа, 3.ялгаатай хэрэгцээ, 4.тэгш боломж, 5.чанартай, хүртээмж, 6.ялгаварлан гадуурлалт, 7.авьяас, чадвар* гэх зэрэг ухагдахуунаар төлөөлүүлж авч үзэж болно.Үүнээс үзвэл хүн бүрийн хөгжлийн түвшин, нийгмийн статус, сонирхол, хэрэгцээ олон янз, үүнээс улбаатай нийгмийн сөрөг үзэгдлүүд багагүй байдаг тул эдгээр эдгээрийг хуульчлах замаар тэгш хамруулах боловсролын үзэл санааг хэрэгжүүлж байна. Үүнээс бид тэгш хамруулах боловсролын агуулгыг дараах байдлаар гаргаж байна.



Тэгш харуулах боловсрол нь дан ганц цэцэрлэг, сургуулийн асуудал биш бөгөөд үүнд парламент, засгийн газар, нутгийн удирдлага, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, коллеж, их, дээд сургуулиудын аль алиных нь оролцоогоор тодорхойлох ойлголт юм.

2.Тэгш хамруулах боловсролын үзэл санааг баталгаажуулсан олон улсын эрх зүйн баримт бичгүүд:

Боловсрол эзэмших эрх	Тэгш хамрагдан суралцах эрх
- 1948 он Хүний эрхийн түгээмэл тунхаглал - 1989 он Хүүхдийн эрхийн тухай конвенци - 2000 он Мянганы хөгжлийн зорилтууд - 2000 он Бүх нийтийн боловсролын талаар гаргасан баримт бичиг Дакарын тунхаг - 2000 он Дакарын тунхаглал “Бүх нийтийн боловсролын талаар гаргасан баримт бичиг” - 2015 Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал	- 1994 он Саламанкагийн тунхаглал - 2001 он Биеийн үйлдэл, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (IFC ангилал) ДЭМБ - 2002 он Мадридын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дэлхийн их хурал - 2004 он НҮБ-ын ЮНИСЕФ, ДЭМБ, ОУХБ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сэргээн засах, тэгш боломж олгох, ядуурлыг бууруулах, нийгэмшүүлэх хамтарсан баримт бичиг - 2008 он Женевийн конвеци - 2010 он ДЭМБ, НҮБ ЮНИСЕФ, ОУХБ, Хөгжил, хөгжлийн бэрхшээлийн олон улсын консорциум - 2011 он ДЭМБ, Дэлхийн банк Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн тайлан - 2012 он “АГРА тунхаглал” - 2015 он Инчеоны стратеги

Манай улс дэлхий нийтийн хэмжээнд мөрдөж байгаа дээрх баримт бичгүүд /үзэл баримтлал, конвенци, тунхаг, стратеги, их хурал/-ийг УИХ-аар соёрхон баталсан, нэгдэн орсон байдаг төдийгүй тэгш хамруулах боловсролын асуудлаар олон арван хууль, журмыг УИХ, Засгийн газраар хэлэлцэн баталж мөрдөж байна.

3.Тэгш хамруулах боловсролын талаарх Монгол улсын хууль, журам, заавар:

Монгол улсын Үндсэн хуульд “Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” гэсэн үзэл санаанд хүний сурч боловсрох, хөгжих, хамгуулуулах эрхийн үзэл санааг баттай тусгасан байдаг.

а.Монгол улсын хуулиуд:

Бусад салбарын хуулиуд	Боловсролын салбарын хуулиуд
− Хүүхдийн эрхийн тухай хууль 2016 он − Барилгын тухай − Хөдөлмөрийн тухай − Нийгмийн халамжийн тухай − Эрүүл мэндийн тухай	− Боловсролын ерөнхий тухай − Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай − Дээд боловсролын тухай − Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай

	– Хүүхэд хамгааллын тухай хуулиуд болон – Журамласан акт

б.Боловсролын салбарт мөргдөж буй дүрэм, журам, заавар

Журам, заавар	Байгууллага	Огноо, дугаар
1.“Хөгжлийн бэрхшээлтэй хүний орон тооны бус зөвлөл, аймаг дүүрэгт ажиллах салбар зөвлөлийн ажиллах журам”	Засгийн газар	2016/136
2.“Дээд боловсролын салбарт хөгжлийн бэрхшээлтэй иргэний сурч боловсрох нөхцөлийг хангах тухай”	БСШУ-ны сайд	2018/261
3.“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам”	БСШУ-ны сайд	2019.05.14 а/292
4.“Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журам”	БСШУ-ны сайд	2020.12.11 а/184
5.“Тусгай цэцэрлэг, сургуулийн талаар авах зарим арга хэмжээний тухай”	Засгийн газар	2020/253
6.“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах журам”	БСШУ-ны сайд	2021/179
7.“Тэгш хамран сургах боловсролын талаар авах зарим арга хэмжээний тухай”	БСШУ-ны сайд	2021.12.23 а/173
8.“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн амгаллын комиссын дүрэм”	Засгийн газар	2021/173
9.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах журам”	БСШУ-ны сайд	2021.05.13 а/177
10.“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал, маягтыг шинэчлэн батлах тухай”	ХНХ, БШУ, ЭМ-ийн сайд	2021.12.30 а/220, а/475, а812
11.“Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар”, “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал”	БСШУ-ны сайд	2022.06.10 а/206
12.“Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад ганцаарчилсан сургалт зохион байгуулах журам”	БШУ-ны сайд	2024.09.10 а/81
13.“Ерөнхий боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад ганцаарчилсан сургалт зохион байгуулах журам”		

Гурав. Судалгааны үр дүн

Энэхүү судалгааг тэгш хамруулах боловсролын үзэл санааг тодорхойлох гол ойлголтуудыг индикатор болгон ашигласан бөгөөд боловсролын салбарын 4 хуулиар хязгаарлалт хийж шинжилж үзсэн болно.

Баримт бичгийн шинжилгээний арга: Монгол улсын боловсролын салбарын дахь тэгш хамруулах боловсролын асуудлаар мөрдөгдөж буй хуулиудад агуулгын шинжилгээ хийхдээ *үг хэллэг, үндсэн ойлголт* зэрэг ухагдахууныг баримтлан анализ хийв. Боловсролын салбарт мөрдөж буй хуулиудад тусгагдсан агуулгад дүн шинжилгээ хийхдээ тэгш хамруулах боловсролын үзэл санааг илэрхийлэх түлхүүр үгийг индикатор болгон ашиглав.

1.Ээлтэй, таатай орчин бүрдүүлэх асуудлаар:

- Боловсролын ерөнхий хуулиар орон нутгийн удирдлага нь төсөв санхүүгийн асуудлыг шийдвэрлэх, боловсролын газар нь сургалтын орчны аюулгүй байдлыг хангах, сургалтын байгууллага нь багш, эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдийн суралцахад таатай, ээлтэй орчин нөхцөлийг бүрдүүлэх, аж ахуйн нэгж байгууллага нь хандив дэмжлэг үзүүлэх замаар орчин нөхцөлийг бий болгох тухай зохицуулсан.
- Дээд боловсролын тухай хуулиар дээд боловсролын сургалтын байгууллага нь тусгай хэрэгцээ шаардлагатай суралцагчийг дэмжих хөтөлбөр баталж, шаардагдах орчин нөхцөлийг бүрдүүлэх зохицуулсан.
- Мэргэжлийн болон техникийн боловсролын тухай хуулиар сургалтын байгууллага нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, хүртээмжтэй сургалтын орчин бүрдүүлэх бий болгох харин суралцагч нь ийм орчинд суралцах, түншлэгч байгууллагууд дэмжлэг үзүүлэх тухай зохицуулсан.
- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулиар орон нутгийн удирдлага нь суралцагчийн ялгаатай хэрэгцээг хангах түгээмэл загвар, сургалтын тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчин бүрдүүлэх тухай, сургалтын байгууллага нь суралцагчийн хөгжих, оролцох, хамгаалуулах хэрэгцээг хангасан, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх тухай, багш нь сургалт, үйл ажиллагаанд суралцагчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, хариу арга хэмжээ авч ажиллах тухай, суралцагчийн хувьд тэгш хамруулсан сургалт, үйл ажиллагаанд оролцох эрхийг баталгаажуулсан тухай зохицуулсан.

Боловсролын ерөнхий хуулинд оролцогч талуудын эрх, үүрэгт, дээд боловсролын тухай хуулинд сургалтын байгууллагын үүрэг, хөтөлбөрийн агуулгад, мэргэжлийн болон техникийн боловсролын тухай хуулинд сургалтын байгууллага, түншлэгч байгууллагын оролцоог, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хуулинд орон нутгийн удирдлага, сургалтын байгууллага, багш нарын үүрэгт тусгасан байна. Гол агуулга нь ээлтэй, таатай, аюулгүй орчин бүрдүүлэх хөтөлбөр батлах, түншлэгч байгууллагыг оролцуулах, сургалтын тохирох хэрэглэгдэхүүн бий болгох тухай байна.

2.Хөгжлийн онцлог:

- Боловсролын ерөнхий хуулиар боловсролын хөтөлбөр, агуулга, стандарт нь суралцагчийн хөгжлийн онцлогийг харгалзах тухай, багш нь хөгжлийн онцлогийг харгалзан суралцахуйг дэмжих, хүлээн зөвшөөрөх, чиглүүлэх, хөгжүүлэх тухай, эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдийн хөгжлийн онцлогийг танин мэдэх, хүндэтгэх, туслах, хараа хяналтгүй орхихгүй байх тухай зохицуулсан
- Дээд боловсролын тухай хуульд энэ ойлголтоор тусгайлсан заалт байхгүй байна.
- Мэргэжлийн болон техникийн боловсролын тухай хуулиар суралцагчийн ялгаатай хэрэгцээ, ур чадварын түвшинг харгалзуулан хөтөлбөрт тохируулга хийх тухай зохицуулсан.
- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулиар бүх талын оролцогчдод хүүхдийн онцлог, ялгаатай хэрэгцээнээс үл шалтгаалан хүүхэд бүрт боловсрол эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, хөтөлбөр нь орон нутгийн түүх, соёл, байгаль, газар зүйн онцлогийг тусган хэрэгжүүлэх, суралцагчийн нас, сэтгэхүйн онцлогийг тусгах, сургалтын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог, хэрэгцээнээс хамааран боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх тухай зохицуулсан.

Боловсролын ерөнхий хуулинд боловсролын яамны чиг үүрэгт, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэгт, мэргэжлийн болон техникийн боловсролын тухай хуулинд боловсролын яамны үүрэгт, сургуулийн өмнөх боловсролын тухай хуулинд оролцогч тал бүрийн үүрэгт тусгасан байна. Гол агуулга нь хөтөлбөр, агуулга, стандартад тохируулга хийх, мөн хөгжлийн, амьдарч буй газар орны онцлог зэргийг харгалзах, хүүхдээ танин мэдэх, ойлгох, дэмжих тухай байна.

3.Ялгаатай хэрэгцээ:

- Боловсролын ерөнхий хуулиар улс, орон нутгийн төсвийн санхүүжилт нь суралцагчийн ялгаатай хэрэгцээг харгалзах, суралцагчийн эрх хэсэгт ялгаатай хэрэгцээнээс үл хамааран чанартай боловсрол эзэмших тэгш боломжоор хангагдах, суралцагчийн үүрэг нь бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, ялгаварлан гадуурхах, дарамтлах, доромжлох, нэр төр, алдар хүндийг нь гутаах үйлдэл гаргахгүй байх, багшийн үүрэг нь суралцагчийн ялгаатай хэрэгцээ, сурлагын түвшинг харгалзан сургалтыг үр дүнтэй удирдан зохион байгуулах, чиглүүлэх тухай зохицуулсан.
- Дээд боловсролын тухай хуульд энэ ойлголтоор тусгайлсан заалт байхгүй байна.
- Мэргэжлийн болон техникийн боловсролын тухай хуулиар суралцагчийн ялгаатай хэрэгцээ, ур чадварын түвшинг харгалзуулан хөтөлбөрт тохируулга хийх тухай зохицуулсан.
- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулиар боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь ялгаатай хэрэгцээтэй суралцагчид хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх журмыг хамтран боловсруулж батлах, сургалтын байгууллага нь ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах багшийн туслах, эмч, сувилагч, сэргээх үйлчилгээ үзүүлэх ажилтантай байх, цэцэрлэг, сургууль нь ялгаатай хэрэгцээтэй

суралцагчид зориулсан ганцааарчилсан сургалтын төлөвлөгөөг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн санал, зөвшөөрлийг үндэслэн боловсруулж, тэдний оролцоо, дэмжлэгтэй хэрэгжүүлэх тухай зохицуулсан.

Боловсролын ерөнхий хуулинд засгийн газар болон орон нутгийн удирдлагын үүрэгт, суралцагчийн эрх, үүрэгт, багшийн үүрэгт, мэргэжлийн болон техникийн боловсролын тухай хуулинд боловсролын яамны үүрэгт, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулинд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны үүрэгт, тусгасан байна. Гол агуулга ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, дээрэлхэл, гадуурхах, доромжлохгүй байх, ялгаатай хэрэгцээг сургалтад харгалзах тухай байна.

4.Тэгш боломж:

- Боловсролын ерөнхий хуулиар Монгол улсын боловсролын зорилго нь хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлэх, санхүүжилт нь суралцах тэгш боломж олгох, хөгжлийн бэрхшээлтэй суралцагч нь бусад суралцагчийн адил боловсрол эзэмших тэгш боломж, нөхцөлөөр хангах тухай зохицуулсан.
- Дээд боловсролын тухай хуульд энэ ойлголтоор тусгайлсан заалт байхгүй байна.
- Мэргэжлийн болон техникийн тухай хуулиар сургалтын хөтөлбөрт суралцагч элсүүлэхэд жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 12.7-д заасныг баримтлах тухай зохицуулсан байна.
- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хуульд энэ ойлголтоор тусгайлсан заалт байхгүй байна.

Гол агуулгыг боловсролын ерөнхий хуулинд суралцагчийн тэгш боломж эдлэх эрхийг баталгаажуулсан, санхүүжилтийг мөн үүнд чиглүүлсэн, мэргэжлийн болон техникийн тухай хуулинд жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийг баримтлах талаар зохицуулжээ. Харин оролцогч талуудад энэ асуудлаар тодорхой заалт байхгүй.

5.Чанартай, хүртээмжтэй:

- Боловсролын ерөнхий хуулиар Монгол улсын боловсролын зорилго, зарчим нь боловсрол чанартай, хүртээмжтэй байх, бүх шатны засаг дарга нар хүртээмжийг нэмэгдүүлэх, сургалтын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүний суралцах хүртээмжтэй орчин бүрдүүлэх, суралцагч бүр чанартай боловсрол эзэмших эрхтэй тухай зохицуулсан.

- Дээд боловсролын тухай хуульд энэ ойлголтоор тусгайлсан заалт байхгүй байна.

- Мэргэжлийн болон техникийн тухай хуулиар иргэний эрэлтэд нийцүүлэн чанартай боловсрол эзэмшүүлэх, сургалтын байгууллага нь хүртээмжтэй орчин бүрдүүлэх тухай зохицуулсан байна.
- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хуулиар хамт олон нь суралцагчид ээлтэй, хүртээмжтэй сургалтын орчин бүрдүүлэх тухай зохицуулсан байна.

Боловсролын ерөнхий хуулинд засаг дарга нарын, сургалтын байгууллагын, мэргэжлийн болон техникийн тухай хуулинд сургалтын байгууллагын, сургуулийн өмнөх болон

ерөнхий боловсролын хуульд сургалтын байгууллагын үүрэгт тусгасан байна. Гол агуулга нь сургалтын чанар, хүртээмжтэй сургалтын тухай байна.

6.Ялгаварлан гадуурал.

- Боловсролын ерөнхий хуулинд боловсрол нь бодлого, үйл ажиллагаандаа тэгш хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй, суралцагч нь бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, багш нь суралцагчийг ялгаварлан гадуурхсан аливаа үйлдэл гаргахгүй байх, суралцах арга барилыг дэмжих зэрэг үүрэгтэй болохыг тусгасан байна.
- Дээд боловсролын тухай хуульд энэ ойлголтоор тусгайлсан заалт байхгүй байна.
- Мэргэжлийн болон техникийн боловсролын тухай хуульд энэ ойлголтоор тусгайлсан заалт байхгүй байна.
- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулиар суралцагчийг ялгаварлан гадуурхалтаас ангид, ээлтэй, аюулгүй, хамгаалагдсан орчинд суралцах эрхтэй болохыг зохицуулж, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн зөвлөл нь цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд аливаа дарамт, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтээс сэргийлэх, хүүхэд хамгааллын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, тайланг хэлэлцэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах талаар тусгасан байна.

Боловсролын ерөнхий хуулинд боловсролын яамны, багшийн үүрэгт, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хуулинд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн зөвлөлийн, суралцагчийн, дотуур байрны багшийн тугасан байна. Гол агуулга нь ялгаварлан гадуурхахгүй, ялгаатай байдлыг хүндэтгэх, аливаа үйлдэл гаргахгүй, дарамт, хүчирхийлэлгүй, дэмжлэг үзүүлэх тухай байна.

7.Авьяас, чадвар

- Боловсролын ерөнхий хуулинд багш нь суралцагчийн төлөвшил, хувийн зан чанарыг судлах, сонирхол, сайн тал, авьяас, чадварыг илрүүлэх, хөгжүүлэх, дэмжих үүрэгтэй болохыг тусгасан ба хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх дугуйлангийн зардлын тодорхой хувийг улсын төсвөөс санхүүжүүлнэ гэж зохицуулсан байна.
- Дээд боловсролын тухай хуулинд дээд боловсролын сургалтын байгууллага нь онцгой авьяастай суралцагчийг дэмжих, авьяасыг хөгжүүлэх хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх байдлаар хамтын ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй болохыг тусгасан байна.
- Мэргэжлийн болон техникийн боловсролын тухай хуулиар ур чадварын түвшинг харгалзуулан хөтөлбөрт тохируулга хийх, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэгт хүүхдийнхээ авьяасыг хөгжүүлэх тухай зохицуулсан
- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулинд ерөнхий боловсролын сургууль нь суралцагчийн авьяасыг дэмжих нэмэлт сургалтын

хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж болно хэмээн тусгасан байдаг ба харин багш нь суралцагчийн мэдлэг, чадвар, авьяасаа хөгжүүлэх, төлөвшихөд дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээж, суралцагч нь өөрийн авьяас чадвараа хөгжүүлэх, сурлагын амжилтаа ахиулахад чиглэсэн дэмжлэг авах эрхтэй болохыг зохицуулсан байдаг.

Боловсролын ерөнхий хуулинд яам, орон нутгийн, багшийн үүрэгт, дээд боловсролын тухай хуулинд сургалтын байгууллагын үүрэгт, мэргэжлийн болон техникийн боловсролын тухай хуулинд сургалтын байгууллага, эцэг эхийн үүрэгт, ерөнхий боловсролын хуулинд сургалтын байгууллагын, багш нарын, суралцагчийн үүрэгт тусгасан байна. Гол агуулга нь суралцагчийн хувийн зан чанар, сайн тал, сонирхол, дугуйлан, хамтарсан хөтөлбөр, хөтөлбөрт тохируулга хийх, нэмэлт хөтөлбөр, дэмжлэгийн тухай байна.

Дээрх харгалзсан зааltуудыг нэгтгэн харвал:

№	ТХБ-ын индикатор	Дээд боловсролын тухай хууль	СӨБ болон ЕБС-ийн тухай хууль
1	Суралцагчид ээлтэй, таатай орчинд	17.1.3, 31.1.6	6.2; 12.1.1; 15.1.2; 17.1.5; 17.1.7; 17.3; 23.2.5; 28.6.3
2	Суралцагчийн хөгжлийн онцлог	19.6	6.1; 6.5; 11.10; 18.5
3	Суралцагчийн хэрэгцээ, сонирхолыг харгалзах	—	14.2; 15.2
4	Хөгжлийн ялгаатай байдлыг хүндэтгэх	—	6.3
5	Суралцагч бүрд тэгш боломж олгох	4.1.7; 14.1.2–14.1.5	28.6.1–28.6.5
6	Чанартай, хүртээмжтэй боловсролын үйлчилгээ	—	17.1.3
7	Ямарваа нэгэн ялгаварлалгүй	—	12.1.1; 23.2.5
8	Суралцагч бүрийн авьяас чадварыг дэмжсэн	—	12.1.3; 15.1.3; 20.11

4.Дүгнэлт

Тэгш хамруулан боловсрол (ТХБ)-ын үндсэн индикаторуудыг хууль эрх зүйн хүрээнд хэрхэн тусгаж өгснийг судлахад:

1. **"Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль"** нь ТХБ-ын шалгуур үзүүлэлтүүдийг илүү тодорхой, дэлгэрэнгүй тусгаж, суралцагчийн

хөгжил, **хэрэгцээ**, **тэгш оролцоо**, **аюулгүй байдал**, **ялгаварлалгүй орчин**, **авьяас чадварыг дэмжих** зэрэг гол чиглэлүүдийг бүх шатны удирдлага, багш, ажилтны **үүрэг, хариуцлагатай** уялдуулан тусгасан байна.

2. Харин **"Дээд боловсролын тухай хууль"**-д ТХБ-ын зарим үзэл баримтлал (тэгш боломж, хүртээмжтэй орчин, авьяасыг дэмжих, ялгаварлан гадуурхахгүй байх гэх мэт) багц байдлаар тусгасан ч индикатор тус бүрийн хүрээнд **нарийвчилсан заалт харьцангуй бага** байна.

3. Энэ нь ТХБ-ыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчныг **сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын түвшинд илүү сайн боловсруулсан** болохыг харуулж байна. Харин дээд боловсролын түвшинд энэхүү бодлогын хэрэгжилтийг **цогцоор нь тусгах, нарийвчлах шаардлага** байгааг илтгэж байна.

4. Тиймээс ТХБ-ын үзэл баримтлалыг **бүх шатны боловсролын хууль тогтоомжид тууштай, нэгдсэн байдлаар тусгах**, **дээд боловсролын байгууллагын оролцоог нэмэгдүүлэх**, мөн **тодорхой индикаторуудад тохирсон бодлогын хэрэгжилтийн механизм бүрдүүлэх** нь зүйтэй юм.

5.Ашигласн материал

ERASMUS. (2023). Тэгш хамруулах боловсролын эрх зүйн үндэс. Улаанбаатар: Адмон принт ХХК.

Krippendorf, K. (2004). Content Analysis: An Introduction to Its Methodology. London: International Educational and professional Publisher.

АДРА. (2016). Тэгш хамруулах боловсрол. In АДРА Монгол (pp. 6, 7). Улаанбаатар.

БШУЯ. (2019). Нийгэм судлал-7. Улаабаатар.

БШУЯ, А. (2023). Тэгш хамран сургах боловсролын бодлого, соёл, үйл ажиллагааг хэрэгжүүлэх сургалтын гарын авлага. Улаанбаатар: Очир Принтинг ХХК.

Карин Шелциг, К. Н. (2020). Монгол улсад тэгш хамруулах боловсролыг дэмжих нь. Улаанбаатар.

Р.Жаргалтуяа, Б. н. (2025.01). Бүс нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний судалгаа. Улаанбаатар: Сод пресс ХХК.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй . (2010). In Х. и. сан. Улаанбаатар.

ШУА. (2025, 05 01). Retrieved from www.mongoltoli.mn: https://mongoltoli.mn/dictionary/detail/116605

SPSIRPA FORUM 2025

Session 6-6

Challenges in Employment Relations of Civil Servants: A Case Study of Local Governments

Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцааг сайжруулах арга зам

Ganzorig U., Ph. D candidate of Department of Public Administration, SPSIRPA, NUM, Mongolia

Хураангуй: Энэхүү судалгааны ажил нь төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцааны эрх зүйн зохицуулалт, хүний нөөцийн менежмент, цалин урамшууллын бодлого, сургалт хөгжлийн тогтолцоонд тулгуурлан хөдөлмөрийн харилцааг хэрхэн сайжруулах боломжтойг судалсан байна. Хөдөлмөрийн эрх зүйн үндсэн зарчмууд, ажлын байрны шинжилгээ, тодорхойлолтын оновчтой байдлыг хангах, хүний нөөцийн бодлогыг шатлан дэвших, мерит зарчимд тулгуурлан хэрэгжүүлэх, цалингийн урамшууллын тогтолцоог гүйцэтгэлтэй уялдуулах, төрийн албан хаагчдын сургалт хөгжлийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлага байгааг дүгнэв. Төрийн албан хаагчдын хөдөлмөрийн үр дүн, мэргэжлийн ур чадварыг үнэлэх, сургалтад тогтмол хамруулах нь төрийн үйлчилгээг сайжруулах үндэс болно.

Түлхүүр үг: төрийн албан хаагч, хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцийн менежмент

Үндсэн хэсэг: Хөдөлмөрийн харилцаа гэж ажил олгогч, ажилтан, тэдгээрийн байгууллагууд хоорондоо ажлын байранд буюу ажлын байрнаас гадуурх хүрээнд төрийн зохицуулалттайгаар харилцан ажиллахыг[310] ойлгоно. Сонгодог байдлаар төр, ажил олгогч, ажилчид гэсэн 3 оролцогчийг хөдөлмөрийн харилцааны талууд гэж тодорхойлдог.[311] Төрийн албаны тухай хуулиар тогтоосон дүрэм журмаар эрх үүрэг нь зохицуулагддаг албан хаагчдаас бүрдсэн албыг[312] төрийн алба гэнэ. Хөдөлмөрийн эрх зүйн зарчим нь уг харилцааны 2 талын эрх үүргийг тогтоон баталгаажуулах, улмаар тэдний эрх үүргийг хангах, хамгаалах явцад хөдөлмөрийн эрх зүйн хэм хэмжээ тогтоох эрх бүхий этгээдүүдээс зайлшгүй баримталбал зохих үзэл баритлалуудын нийлбэр байдаг.[313]

Хүснэгт 7. Эрх зүйн зарчим

Нийтлэг зарчим	Хөдөлмөрийн эрх зүйн суурь зарчим (ILO)	МУ-ын Хөдөлмөрийн эрх зүйн салбарын зарчим
✓ Ардчилсан ёсны зарчим ✓ Шударга ёсны зарчим ✓ Үндэсний эв нэгдлийг хангах зарчим ✓ Хууль дээдлэх зарчим	✓ Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон хамтын хэлэлцээр байгуулах эрхийг хүлээн зөвшөөрөх зарчим ✓ Хүүхдийн хөдөлмөрийг хориглох зарчим ✓ Хөдөлмөр, боловсролын салбарт	✓ Чөлөөтэй хөдөлмөрлөх эрхийн зарчим ✓ Ажилтнуудад амрах эрхээр хангах зарчим ✓ Ажилтнуудад ажиллахын хамт мэргэжил боловсролоо дээшлүүлэх бололцоогоор хангах зарчим ✓ Ажилтны хөдөлмөрийн тоо хэмжээ, чанарт тохируулан хөдөлмөрийн хөлс олгох зарчим ✓ Хөдөлмөрийн сахилгыг хангах зарчим

[310] ILO "Хөдөлмөрийн маргааны удирдлагын тогтолцоо" Үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулахад баримтлах удирдамж, 2013 он, Ху.6

[311] Anne Trebilock, Labour relations and Human resources management: an overview, Chapter 21 http://www.ilocis.org/documents/chpt21e.htm 2021.05.30

[312] Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг, Ц. Даваадулам, 2010, УБ, Ху 21

[313] "Хөдөлмөрийн эрх зүй" гарын авлага, УБ, 2007 он, Ху.54

	ялгаварлан гадуурхах явдлыг зогсоох зарчим	✓ Ажилтнуудын эд мөнгөний туслалцаа авах эрхийн зарчим ✓ Үйлдвэрлэлийг удирдахад ажилтны төлөөлөгчдийг оролцуулах зарчим

Эх сурвалж: “Хөдөлмөрийн эрх зүй” гарын авлага, УБ, 2007 он, Ху.54

Эх сурвалж: Ц.Цэцэгмаа, “Хүний нөөцийн менежмент”, УБ, 2014 он, Ху 28

Хүний нөөцийн менежментийг “Хөдөлмөрийн харилцааны мөн чанар, түүнтэй холбоотой бүх шийдвэр, үйлдэл, асуудлыг авч үздэг шинжлэх ухаан, практик үйл ажиллагаа” гэж тодорхойлсон. (Ferris, Rosen and Barnum, 1995). Хүний нөөцийн менежментийн үндсэн үүрэг функц нь:

1. Төлөвлөлт
2. Ажлын байрны шинжилгээ, ажлын байрны тодорхойлолт
3. Ажиллах хүчний нөөц бүрдүүлэх байдаг.

Ажлын байрны шинжилгээ төрийн албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээг тогтооход ашиглагдана.. Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтооход ажлын байрны шинжилгээ хийсний үндсэн дээр тухайн байгууллагын үйл ажиллагааны зохих хүрээ, албан тушаалын чиг үүрэг, хүлээх хариуцлагыг үндэслэн боловсруулж мөрдүүлнэ[314] гэж заасан.

- ✓ Засгийн газрын тогтоол 2022 он, дугаар 487-д Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалт батлах тухай;
- ✓ Засгийн газрын тогтоол 2023 он, дугаар 240-д Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай;
- ✓ Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам[315]

1.5. Албан тушаалын тодорхойлолтыг байгууллагын чиг үүрэг, хууль тогтоомжийн дагуу боловсруулан стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөө, ажлын байрны шинжилгээнд үндэслэн боловсруулна;

2.4. Ажлын байрны шинжилгээг хийхдээ дараах үйл ажиллагааг гүйцэтгэнэ:

2.4.1. Байгууллагын үндсэн зорилго, зорилт, хууль тогтоомжид тусгагдсан чиг үүргүүд нэгжийн чиг үүргүүдэд бүрэн хуваарилагдаж орсон эсэхийг тодорхойлж, давхардал хийдлийг арилгах;

2.4.3. Нэгж доторх ажлын ачаалал жигд эсэхийг шинжилж, чиг үүргийн хуваарилалтыг оновчтой болгох.

Ажлын байрны тодорхойлолт

Төрийн албаны тухай хуульд (2017)

Төрийн жинхэнэ албан хаагч албан тушаалд тавигдах шаардлага болон ажиллах нөхцөл албан тушаалын чиг үүрэг, эрх хэмжээг тогтоосон албан тушаалын тодорхойлолттой

[314] Төрийн албаны тухай хууль (2017) 58.1.1 дэх хэсэг

[315] Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

тухайн албан тушаалд томилогдмогц албан ёсоор танилцах, түүнийг хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэхийг шаардах[316] эрхтэй байна.

Хүний нөөцийн бүрдүүлэлт

Төрийн бодлогыг хэрэгжүүлэх, үйлчилгээг иргэдэд үр нөлөөтэй хүргэх чадвар бүхий орчин үеийн мэргэшсэн төрийн захиргааг бүрдүүлэх. Шинэчлэн батлагдсан Төрийн албаны тухай хуулиар (2017):

- ✓ Удирдах албан тушаалд томилогдох босго, хугацаа
- ✓ Шатлан дэвших зарчим буюу мерит зарчим
- ✓ Төрийн албан хаагчийн ёс зүй, гүйцэтгэлийн удирдлага
- ✓ Төрийн албаны зөвлөлийн хараат бус байдал: ажилд авах, шилжүүлэх, дэвшүүлэх, халахтай холбогдсон дүрэм журам, хууль тогтоомжид хяналт тавих, төрийн албаны хүний нөөцийн мэргэшлийн шалгалттай холбогдох маргааныг хянах, шийдвэрлэх, зөрчлийг арилгах, зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгохоор тусгагдсан.

Хүний нөөцийн сонгон шалгаруулалт

Төрийн жинхэнэ албан тушаалд тавих нийтлэг шаардлага:[317]

- ✓ Монгол Улсын иргэн байх
- ✓ Дээд боловсролтой байх
- ✓ Эрүүгийн хуульд заасан авлига албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх
- ✓ Монгол хэлний ярианы болон бичгийн чадвартай байх
- ✓ Сэтгэцийн өвчин, эмгэггүй байх
- ✓ Хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн үүргээ биелүүлсэн байх.

Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулах зорилгоор улиралд нэгээс доошгүй удаа төрийн албаны мэргэшлийн шалгалтыг авна. [318]

Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий этгээд журмын дагуу орон тоог нөхнө.

Хүснэгт 2. Сул орон тоог нөхөх байдал

Удирдах албан тушаалын сул орон тоо	- Шатлан дэвших зарчмын дагуу - Нөөцөд байгаа иргэдээс

[316] Төрийн албаны тухай хууль 2017 он 38.1.1 дэх хэсэг
[317] Төрийн албаны тухай хууль 2017 он, 22-р зүйл
[318] Төрийн албаны тухай хууль 2017 он, 33-р зүйл

Гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоо	- Ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас - Холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас - Нөхөх боломжгүй бол төрийн албан хаагчийн нөөцөд байгаа иргэдээс

Эх сурвалж: Төрийн албаны тухай хууль (2017) 27 дугаар зүйл

Төрийн жинхэнэ албанд анх орсон иргэнд туршилтын 6-12 сар хүртэл хугацаагаар тогтоохоор заасан байгаа бөгөөд туршилтын хугацааг төрийн алба хаасан хугацаанд оруулж тооцно.[319]

Цалин хөнгөлөлт, урамшуулал

Төрөөс нийтэд хүргэх үйлчилгээг чанартай, үр нөлөөтэй болгохын тулд төрийн албанд дадлага туршлагатай, мэдлэг чадвартай хүмүүсийг ажиллуулж, ажлын гүйцэтгэлийг нь шударга үнэлж цалин хөлс, урамшуулал олгох зарчимтай.

Төрийн албан хаагчийн цалин хөлсний зохицуулалт:

- ✓ Төрийн албаны тухай хууль
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль
- ✓ Бусад хууль тогтоомжоор зохицуулагдана.

Хөдөлмөрийн тухай хуульд цалин хөлс, түүнийг олгох журам, төрөл, хэлбэрийг заадаг бол Төрийн албаны тухай хуульд Төрийн албан хаагчид олгох цалин, тэтгэмж, баталгаа урамшууллын харилцааг зохицуулна.

Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно. Төрийн албан хаагчийн цалин хөлс нь:

- ✓ Улс төрийн албан тушаал эрхэлдэг, төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцлийн, докторын зэргийн нэмэгдлээс;
- ✓ Захиргааны албан тушаал эрхэлдэг, төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон төрийн алба хаасан хугацааны, цолны, зэрэг, дэвийн, докторын зэргийн нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс;
- ✓ Тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцлийн төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын, мэргэшлийн зэргийн болон хуульд заасан бусад нэмэгдлээс;
- ✓ Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон докторын, мэргэшлийн зэрэг, цол, ур чадварын, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон бусад нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс тус тус бүрдэнэ.[320]

[319] Төрийн албаны тухай хууль 2017 он, 28-р зүйл

[320] Төрийн албаны тухай хууль 2017 он, 57.1, 57.2, 57.2.1 – 57.2.4 дэх хэсэг

Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн төрийн албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүнийг албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно.[321] Үүнд:

6-10 жилд – 5%

11-15 жилд – 10%

16-20 жилд – 15%

21-25 жилд – 20%

26 ба түүнээс дээш – 25%

Цалинг хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан нэмдэг бөгөөд төрийн албан хаагчдын цалин хөлсийг эдийн засгийн өсөлт, амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан нэмэгдүүлдэг.

Сургалт, хөгжил

Хүснэгт 3. Сургалт хөгжлийн талаарх хуулийн зохицуулалтын өөрчлөлт

Төрийн албаны тухай хууль (2002)	Төрийн албаны тухай хууль (2017)
✓ 6 сараас дээш хугацааны сургалтаар бэлтгэгдэх болсон төрийн жинхэнэ албан хаагчийг төрийн албанаас түр чөлөөлнө; ✓ Төрийн жинхэнэ албан хаагчийн зохих шатны сургалтад хамруулах асуудлыг ажлын гүйцэтгэл, үр дүнг үндэслэн шийдвэрлэнэ; ✓ Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.	✓ Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг эрх, мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор сургалтад хамрагдах; ✓ Төрийн хөрөнгөөр 6 хүртэлх сарын хугацаагаар давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх сургалтад хамрагдах энэ хугацаанд эрхэлж байгаа албан тушаалын цалинг авах; ✓ Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх үндэслэл 6 сар мэргэшил дээшлүүлэх сургалтад, 2 жил магистр, докторын сургалтад хамрагдах; ✓ Төрийн захиргааны албан хаагчийн мэргэшүүлэх багц сургалт; ✓ Төрийн албан тушаалд иргэнийг томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад хамруулах.

[321] “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам” ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

2002 оны Төрийн албаны тухай хуулиар:

13.1.6. Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэх шаардлагад нийцүүлэн мэргэшлээ дээшлүүлэх;

27.1.9. Төрийн хөрөнгөөр давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх, энэ хугацаанд эрхэлж байгаа албан тушаалынхаа цалин хөлсийг авах[322] хэмээн тус тус заажээ.

2017 оны Төрийн албаны тухай хуулиар:

Төрийн албаны тухай хуулийн 55.3-р зүйлд “Төрийн албан хаагчийн сургалт хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ”[323] хэмээн заасан нь төрийн байгууллага бүр хүний нөөцийн сургалт хөгжлийн хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэлтэй байна. Мөн 37.1.8-д төрийн жинхэнэ албан хаагч нь өөрийн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх үүрэгтэй гэж заасан.

Энэхүү хуулийн 64.2.2-д Засгийн газрын бүрэн эрхийг “төрийн жинхэнэ албан хаагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, удирдах ажилтны манлайлах ур чадварыг хөгжүүлэх, төрийн албан хаагчийн давтан сургах, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг төрийн албаны төв байгууллагатай хамтран боловсруулж хэрэгжүүлэх” гэж заажээ.

“Төрийн албаны тухай хуулийн 23.2, 24-р зүйл Төрийн захиргааны албан хаагчийн мэргэшүүлэх багц сургалтын тухай;

29-р зүйл Төрийн албан тушаалд иргэнийг томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад хамруулах;

38.1.9.Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг эрх: мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор сургалтад хамрагдах;

42.1.4.Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх үндэслэл: 3 сар хүртэлх хугацаагаар мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан, 2 жил хүртэл хугацаагаар өндөр хөгжилтэй оронд магистр, докторын сургалтад хамрагдсан;

64.3. ЗГХЭГ-ын дэргэд төрийн албан хаагчийг сургах, давтан сургах, төрийн албаны хүний нөөцийн менежментийн талаар судалгаа, шинжилгээ хийх, энэ талаар бодлого боловсруулагчид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх үндсэн үүрэг бүхий Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага ажиллана” гэж шинэчилсэн найруулгад сургалтын талаар тус тус зохицуулагдсан байгаа болно.

Эрх зүйн байдлын хувьд 2002 оны Төрийн албаны тухай хуульд сургалтад хамрагдах тухай зүйл заалт төдийлөн дэлгэрэнгүй тусгагдаж өгөөгүй байсан бол 2017 оны Төрийн албаны тухай хуульд нарийн, дэлгэрэнгүй зохицуулагдаж өгчээ.

Төрийн албан хаагчдын сургалтын хэлбэрийг шинжлэн үзвэл:

[322] Төрийн албаны тухай хууль. 2002

[323] Төрийн албаны тухай хууль. 2017, 55-р зүйл

Тусгайлан мэргэшүүлэх сургалт - ТА-ны тухай хуулийн 24.2-т зааснаар Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага буюу ЗГ-ын Хэрэгжүүлэгч Агентлаг **“Удирдлагын академи”** төрийн албан хаагчдыг “мэргэшүүлэх сургалт”-ыг зохион байгуулдаг.

- ✓ Удирдлагын академи нь Төрийн захиргааны Тэргүүн, Эрхэлсэн, Ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох албан хаагчийг бэлтгэх мэргэшүүлэх багц сургалтыг;
- ✓ Төрийн албаны тухай хуулийн 29.1-р зүйлд зааснаар “Иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад хамруулна” гэж заасны дагуу дунд хугацааны сургалтыг тус тус хариуцан зохион байгуулдаг.

Зураг 1. Төрийн албан хаагчийн сургалтын тогтолцоо



Эх сурвалж: Удирдлагын академи, 2019

Тодорхой мэргэжлийн бус сургалт – Ерөнхий мэдлэг олгох зорилготой. Тухайн байгууллагад дотоод буюу байгууллага өөрсдөө явуулж буй сургалт, харилцагч байгууллага, хамтран ажиллагч байгууллага, олон улсын байгууллагаар уг сургалт ихэвчлэн зохион байгуулагддаг. Жишээ нь: Гадаад хэлний мэдлэг, Мэдээллийн технологи, Харилцаа, ерөнхий мэдлэг олгох сургалт гэх мэт.

Ажлын гүйцэтгэл, үр дүн

2017 оны Төрийн албаны тухай хууль

“Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн”-г 13-р бүлэгт нарийвчлан тусгасан болно.

52.2. Төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаал дэвшүүлэх, цалин хөлсийг өөрчлөх, цол, зэрэг дэв олгох, урамшуулах, зохих шатны сургалтад хамруулах, албан тушаал

бууруулах, хариуцлага хүлээлгэх асуудлыг түүний ажлын гүйцэтгэл, үр дүнг үндэслэн шийдвэрлэнэ.

53.1. Стратеги төлөвлөгөө: Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах;

53.1. Хуульд өөрөөр заагаагүй бол стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.

54.1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө: Байгууллага гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан баталж, жил бүрийн 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хэрэгжүүлнэ.

55.1. Төрийн жинхэнэ албан хаагч хууль тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хэрэгжүүлнэ.

Хүснэгт 4. Төрийн албаны тухай хууль (2017) Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх нь

Гүйцэтгэлийн үнэлгээ	Авах арга хэмжээ
Бүрэн хангалттай	А.Төрийн дээд болон салбарын шагналд тодорхойлох Б.Цол зэрэг дэвийг хугацаанаас өмнө ахиулах (3 удаа дарааллан үнэлэгдвэл) В. Цалингийн шатлалыг алгасуулж нэмэгдүүлэх (3 удаа дарааллан үнэлэгдвэл) Г. Албан тушаалд дэвшүүлэх зорилгоор мэргэшүүлэх багц сургалтад хамруулах (3 удаа дарааллан үнэлэгдвэл)
Хангалттай	А. Цол, зэрэг дэвийг ахиулах Б. Мөнгөн болон бусад хэлбэрийн шагнал, урамшуулал олгох
Хангалтгүй	А. Сургалтад хамруулах Б. Албан тушаалын цалинг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах В. Албан тушаал бууруулах (3 удаа дараалан хангалтгүй үнэлэгдвэл) Г.Төрийн албанаас халах (3 ба түүнээс дээш хангалтгүй үнэлэгдвэл)

Төрийн албан хаагчийн ёс суртахуун, ёс зүй, ёс зүйн дүрэм, хариуцлага хөдөлмөрийн харилцаанд нөлөөлөгч хүчин зүйлсийн салшгүй хэсэг юм.

Төрийн албан хаагчийн ёс суртахуун нь төрийн албан хаагчид албан үүргээ гүйцэтгэх явцдаа иргэдийг ойлгож, тэдэнд шударга, хөнгөн шуурхай хандах, хамтран ажиллагчдадаа хүндэтгэлтэй хандах зэргээр зохистой зан суртахуун гаргах үүрэг юм.[324]

Ёс зүй нь албан хаагчид үйл ажиллагааныхаа бүхий л хүрээнд баримтлах ёс суртахууны зарчмууд, эрхэмлэх зүйлс юм. Эдгээр ёс суртахууны зарчимд үнэнч шударга байх, шударга байдал, шударга зан суртахуун, хичээл зүтгэл, итгэлцэл, хүндэтгэл, зарчимч тууштай байх гэсэн үзэл баримтлалууд багтдаг. Ёс зүйд сонирхлын зөрчил, албан тушаалаа зүй бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх явдал мөн хамаарна.[325].

Төрийн албан тушаалтны ёс зүйн дүрэм – Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг стандарттай болгох талаар урьд өмнө хийсэн алхмуудын дотор “Lord Nolan”-ны санаачилгаар Их британид 1994 онд нэвтрүүлсэн төрийн албан хаагчдын зан суртахууны дэлгэрэнгүй дүрэм зүй ёсоор орж байна. Хэдийгээр Их Британий нөхцөлд тохируулан боловсруулсан боловч тус дүрэмд улс төр, түүх, соёлын ялгаанаас үл хамааран улс орнуудын төрийн албанд мөрдөж болох нийтлэг 7 зарчмыг тодорхойлсон (Committee on Standards in Public Life, 1995) байна. Үүнд:

1. Хувийн ашиг сонирхолгүй ажиллах – Төрийн албанд ажиллагчид зөвхөн нийтийн ашиг сонирхолд нийцсэн шийдвэр гаргаж байх. Өөрсдийн болон гэр бүл, найз нөхдийнхөө санхүүгийн болоод материаллаг бусад сонирхлын үүднээс шийдвэр гаргах явдлыг хориглох;
2. Зарчимч, шударга байх – Төрийн албанд ажиллагчид хувь хүн, байгууллагын өмнө албан үүрэгтээ сөргөөр нөлөөлж болох санхүүгийн болон бусад амлалт үүрэг авахгүй байх;
3. Бодитой хандах – Албан тушаалд томилох, гэрээ хэлэлцээр байгуулах, шагнал урамшуулал, тэтгэлэгт тодорхойлох зэрэгтээ зөвхөн уг ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадвар, гавьяа зүтгэлд үндэслэсэн сонголт хийх;
4. Хариуцлагатай байх – Төрийн албан хаагчид гаргасан шийдвэр, үйл ажиллагааныхаа төлөө олон нийтийн өмнө хариуцлага хүлээдэг байх, аливаа хяналт, шалгалтаас зайлсхийхийн хориглох;
5. Нээлттэй байх – Төрийн албан хаагчдын гаргаж байгаа шийдвэр, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ аль болох нээлттэй байх. Гаргасан шийдвэрийнхээ үндэслэлийг олон нийтэд ил тод мэдээлдэг, мэдээллийг зөвхөн нийтийн эрх ашигт илэрхий харшилсан тохиолдолд хязгаарладаг байх;

[324] Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг, Ц. Даваадулам, 2010, УБ, Ху 15

[325] Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг, Ц. Даваадулам, 2010, УБ, Ху 40

6. Үнэнч шударга байх – Төрийн албан хаагчид нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс албан үүрэгтэй нь харшлах хувийн сонирхлынхоо талаар мэдээлж, сонирхлын зөрчилгүй ажиллах;
7. Манлайлах – Төрийн албан хаагчид эдгээр зарчмыг мөрдүүлэх үйл хэрэгт манлайлал, үлгэр дуурайлал үзүүлэх явдал тус тус орж байна.

Захиргааны хариуцлага нь захиргааны ёс зүйн түлхүүр үзүүлэлт тул захиргааны албан хаагчид ёс зүйтэй байснаар хариуцлагаа бүрэн ухамсарлаж чадна.[326]

Зураг 2. Хөдөлмөрийн эрх зүй дэх хариуцлага

Эх сурвалж: МУ-ын Хөдөлмөрийн тухай хууль, 1999 он

Эд хөрөнгийн бүрэн хариуцлага – Ажилтан хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үедээ өөрийн гэм буруутай үйлдэл (эс үйлдэл)-ийнхээ улмаас ажил олгогчийн эд хөрөнгөд бодитой учруулсан хохирлоо бүхэлд нь хариуцаж төлөх явдал.

Эд хөрөнгийн хязгаарлагдмал хариуцлага – Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үедээ гэм буруутай үйлдлийнхээ улмаас ажил олгогчийн мэдлийн эд хөрөнгөд бодитой учруулсан хохирлыг тухайн ажилтны хөдөлмөрийн тодорхой хэсгээр хязгаарлан төлүүлэх явдал. Эд хөрөнгийн хязгаарлагдмал хариуцлага нь ажилтны нэг сарын дундаж цалингаас хэтэрч болохгүй байна.

Хүснэгт 5. Эд хөрөнгийн хариуцлага

Ажилтанд ногдуулах эд хөрөнгийн хариуцлага	Ажилтнуудаас ажил олгогч этгээдэд эд хөрөнгийн хохирол учруулсан, тэрхүү хохирлыг нөхөн арилгахтай холбоотойгоор үүсдэг.

[326] Terry Cooper “The responsible administrator” USA, 2012, p 43-92

Ажил олгогчид хүлээлгэх эд хөрөнгийн хариуцлага	✓ Хүний эрхийг зөрчсөний улмаас ажилтанд эд хөрөнгийн хохирол учруулсан; ✓ Ажилтны цалин хөлсийг үндэслэлгүйгээр суутгах буюу саатуулсан; ✓ Нийгмийн даатгалын дэвтэр бусад баримт бичгийг үндэслэлгүйгээр саатуулсны улмаас ажилтанд эд хөрөнгийн хохирол учруулсан; ✓ Хөдөлмөр хамгааллын хууль тогтоомжийг зөрчсөний улмаас ажилтны амь бие эрүүл мэнд, сэтгэл санаанд гэм хор учруулсан; ✓ Хууль зүйн үндэслэлгүйгээр ажилтныг ажлаас халсан.
Эд хөрөнгийн хариуцлагын үндсэн шинж, онцлог	✓ Иргэд хөдөлмөрийн эрх зүйн харилцаанд оролцох, хөдөлмөрлөх үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой; ✓ Эд хөрөнгийн хариуцлагад татах буюу ажил олгогчид учруулсан хохирлыг нөхөн арилгах явдал ажилтнуудад эрүүгийн, сахилгын, захиргааны арга хэмжээг оногдуулсныг үл харгалзан хэрэгждэг; ✓ Ажилтныг эд хөрөнгийн хариуцлагад татаж байгууллагад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх нь ажил олгогч буюу захиргаа шийдвэр гаргаснаар хэрэгждэг ба маргаантай үед шүүхийн журмаар зохицуулагддаг; ✓ Эд хөрөнгийн хариуцлага нь сахилгыг хангах, ажилтнуудаас эд хөрөнгөдөө арвич хямгачаар хандах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгддэнэ.
Учруулсан хохирлыг нөхөн төлүүлж байгаа хэмжээгээр	✓ Эд хөрөнгийн бүрэн хариуцлага ✓ Эд хөрөнгийн хязгаарлагдмал хариуцлага ✓ Эд хөрөнгийн өсгөн нэмэгдүүлсэн хариуцлага
МУ-ын Хөдөлмөрийн тухай хуулийн 135-р зүйл хариуцлага хүлээлгэх үндэслэл	1. Ажилтны байгууллагад хохирол учруулсан үйлдэл нь гэмт хэрэг болохыг тогтоосон; 2. Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үедээ байгууллагад хохирол учруулсан ажилтан эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэхээр хууль тогтоомжид заасан; 3. Дараа тайлан гаргахаар итгэмжлэл буюу бусад баримт бичгээр хүлээн авсан эд хөрөнгө, үнэ бүхий зүйлийг хугацаанд нь эргүүлж төлөөгүй; 4. Эд хариуцагч биш боловч эрхэлсэн ажилтай нь шууд холбогдуулан өөрт нь бүрэн хариуцуулахаа тавьж олгосон ажлын багаж, хамгаалах хэрэгсэл, тусгай хувцас зэрэг эд хөрөнгийг үрэгдүүлсэн;

	5. Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн, хөдөлмөрлөх үүргээ биелүүлж байгаагүй үедээ байгууллагад хохирол учруулсан.
Эд хөрөнгийн хариуцлагад татах үндэслэл	✓ Ажил олгогчийн мэдлийн эд хөрөнгөд хохирол бодитой учирсан байх; ✓ Хохирол учруулсан хууль бус үйлдэл эс үйлдэлдээ ажилтан гэмт буруутай байх; ✓ Ажилтны учруулсан хохирол ба түүний гэм буруутай үйлдэл эс үйлдлийн хооронд шалтгаант холбоотой байх; ✓ Ажилтан ажил олгогчид хохирол учруулсан үйлдэл эс үйлдэл хууль бус байх зэрэг.

 Эх сурвалж: “Хөдөлмөрийн эрх зүй” гарын авлага, УБ, 2007 он, Ху.116-118

Дүгнэлт:

Монгол Улсад төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцааг зохицуулах эрх зүйн орчин нь тодорхой түвшинд бүрдсэн хэдий ч практикт хэрэгжилтийн үр нөлөө сул, зохицуулалтын зарим заалт нь тодорхойгүй, давхардал, хийдэлтэй байгаа нь тогтвортой, үр ашигтай төрийн албыг бүрдүүлэхэд хүндрэл учруулж байна. Хүний нөөцийн бодлогын хэрэгжилт, албан хаагчдын хөдөлмөрийн үнэлэмж, урамшууллын тогтолцоо нь гүйцэтгэлд суурилаагүй, мерит зарчмыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй байна. Иймд төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаанд тулгамдаж буй асуудлыг цогц байдлаар судлан, эрх зүйн зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох, хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр бодлого, зохицуулалтын шинэчлэл хийх шаардлагатай байна. Үүний зэрэгцээ төрийн албан хаагчийн мэргэшил, ёс зүй, ажлын гүйцэтгэлийг үнэлэх бодит тогтолцоог бүрдүүлж, хөдөлмөрийн аюулгүй байдал, нийгмийн баталгааг хангах чиглэлд онцгой анхаарах нь зүйтэй юм.

Ашигласан материал:

1. ILO. (2013). “Хөдөлмөрийн маргааны удирдлагын тогтолцоо” Үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулахад баримтлах удирдамж. Ху.6.
2. Trebilock, A. (2021). Labour relations and Human resources management: an overview, Chapter 21. Retrieved from ilocis.org.
3. Даваадулам, Ц. (2010). Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг. УБ, Ху 15, 40.
4. “Хөдөлмөрийн эрх зүй” гарын авлага. УБ, 2007 он, Ху.54.
5. Цэцэгмаа, Ц. (2014). “Хүний нөөцийн менежмент”. УБ, Ху 28.
6. Төрийн албаны тухай хууль (2017)
7. Төрийн албаны тухай хууль (2002, 2017).
8. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах Ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам. Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолын хавсралт.
9. “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”. Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт.

SPSIRPA FORUM 2025

Session 6-7

Some Issues in Human Resource Recruitment in Government Organizations

Төрийн захиргааны байгууллагын хүний нөөцийн удирдлагыг сайжруулах арга зам

Bumnaran B., Ph. D candidate of Department of Public Administration, SPSIRPA, NUM, Mongolia

Хураангуй: Төрийн захиргааны байгууллагын хүний нөөцийн удирдлагын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлууд, сайжруулах боломжуудыг судалсан болно. Хүний нөөц бол байгууллагын хамгийн чухал баялаг бөгөөд түүнийг оновчтой удирдаж, төлөвлөх нь төрийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнд шууд нөлөөлдөг. Судалгаанд хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт ба хөгжил, цалин урамшуулал, ажил олгогч–ажилтны харилцаа, өөрчлөлтийн манлайлал зэрэг гол асуудлуудыг авч үзсэн. Мөн олон улсын туршлага болон онолын үндэслэлд тулгуурлан төрийн байгууллагын хүний нөөцийн бодлогыг боловсронгуй болгох стратеги, арга замуудыг санал болгосон.

Түлхүүр үг: хүний нөөцийн удирдлага, төрийн байгууллага, өөрчлөлт шинэчлэл

Үндсэн хэсэг: Байгууллага буюу англиар “organization” нь зохион байгуулалттайгаар хамтран ажилладаг бүлэг хүмүүс, системийн дагуу зохион байгуулагдсан бүлэг, тодорхой зорилгоор хамтран ажилладаг компани эсвэл бүлэг хүмүүс гэх мэт утгыг илэрхийлдэг (Бурмаа, Төрийн байгууллагын хүний нөөцийн аудит, 2021, хууд. 144). Бизнесийн ерөнхий ойлголтоор “Хоёр ба түүнээс дээш хүний ухамсартайгаар зохицуулсан үйл ажиллагаа” хэмээн тодорхойлж, “Зорилгоо биелүүлэх хамтын хүчин чармайлт бий болгох, олон хүний үйл ажиллагааг зохицуулах, нэгдсэн зорилгод сэдэлжүүлэх, чиглүүлэх зорилгоор байгуулсан” (Blau & Scott, 1962, p. 5) үйл ажиллагааг байгууллага гэж үздэг. Харин байгууллагын хандлагаар “Байгууллага бол цогц системт зохион байгуулалтын дэд систем бөгөөд менежмент, харилцан уялдаа, зохих холбоо хамаарлаар нь системийн бүх элементүүдийг зохион байгуулалтад оруулж, тодорхой зорилгод хүрэхэд нэгтгэх үйл ажиллагаа (Lundgren, 1974, p. 7). Эдийн засгийн шинжлэх ухааны үүднээс “Байгууллага нь хүмүүсийг нэгтгэх систем болох ба эрсдэлийг удирдах, эдийн засгийн тодорхойгүй байдлын зохицуулалт, төлөвлөлт ба инноваци, удирдлага, хяналтын утгыг багтаадаг” (Бурмаа, Төрийн байгууллагын хүний нөөцийн аудит, 2021, хууд. 144). Харин байгууллагын сэтгэл судлалын хандлагаас нь “Төвөгтэй ажлуудыг гүйцэтгэхэд зориулагдсан харилцан уялдаатай системүүдийн (ажил, бүтэц, технологи, хүмүүс ба хүрээлэн буй орчин) багц” (Levitt, 1972, p. 265), байгууллагын харилцааны хандлагаар “Нийгмийн нэгдэлд оршин тогтнодог. Байгууллагын болон хувь хүний зорилго, үйл ажиллагаа уялдаа холбоотой, зохион байгуулалтын бүтэц, бусад орчинтой уялдах үндсэн таван шинжийг агуулахыг байгууллага гэж ойлгоно” (Miller, 2012, p. 11) хэмээн өөр, өөр шинжлэх ухааны үүднээс тайлбарласан. “Байгууллага” хэмээх нэр томьёог бүхий л салбарын судлаачид өөр өөрсдийн салбарын шинжлэх ухааны хүрээнд тайлбарласан ч “хүмүүс”, “зорилго”, “бүтэц” гэсэн үндсэн шинж чанарыг агуулж, үүнээс байгууллагын тодорхойлолт болон бүтэцтэй холбоотой тайлбарлагдсан. Төрийн байгууллагыг байгууллагын онолын үзэл хандлагаар хамтын нөхөрлөлийн буюу “commonweal” гэж тодорхойлдог ч төрийн засаглалын хэлбэр, төрийн онолын үзэл баримтлалаар “Төр бол төрийн байгууллага юм” гэсэн санааг дэвшүүлсэн. Энэ талаар Л.Гумплович “Төр ямар тогтолцоотой эсэх, мөн ямар ч зорилгыг өмнөө тавьсан эсэхээс

үл хамаарч төрийг тодорхой нэг дэг журмыг хадгалах зорилгоор үүссэн засаглалын байгууллага” хэмээн тодорхойлж болно гэжээ (Бурмаа, Төрийн байгууллагын хүний нөөцийн аудит, 2021, хуудсд. 144-147). Аливаа байгууллагын нөөц нь хүний нөөц ба материаллаг нөөцөөс бүрдэнэ. Материаллаг нөөцөд байгууллагын эзэмшил газар, барилга байгууламж, техник тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, түүхий эд материал, хөрөнгө мөнгө ордог бол хүний нөөцөд байгууллагад ажиллаж байгаа ажилтан, ажиллагчид болох хүн ордог. Хүнд машин механизм, техник технологид байдаг шиг өндөр чадамжууд байхгүй ч оюун ухаантай, сэтгэлийн мэдрэмжтэй, ёс суртахууны онцгой шинж чанаруудыг агуулсан нийгмийн оршигч юм. Энэ ч утгаараа бусад нөөц баялагт байхгүй зохицуулах, нэгдэх, хамтрах, таамаглах, шийдвэр гаргах зэрэг олон өвөрмөц чадваруудыг өөртөө агуулж байдаг. Байгууллагын материаллаг нөөцийг хөдөлгөгч гол хүч дээрх онцгой шинж чанаруудыг агуулсан хүн байдаг учраас орчин үеийн удирдлагын шинжлэх ухааны гол цөм нь хүний нөөцийн удирдлага болж байна. Мөн аж үйлдвэрийн техник технологийн хөгжлийг дагаад үйлдвэрлэлийн процесс автоматчилагдаж, ажиллах хүч бага шаардагдаж байсан үед хүний нөөцөөс илүү материаллаг нөөцийг чухалд үзэж байсан бол орчин цагт шинжлэх ухаан, техник технологийн үсрэнгүй хөгжлийг дагаад өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах хүчний хэрэгцээ өсөн нэмэгдэх болж хүний нөөцийг чухалчлан үзэх хандлагатай болж байна. Байгууллагын материаллаг нөөцийг үйлдвэрлэлийн менежмент, санхүүгийн менежмент, маркетингийн менежмент, нягтлан бодох бүртгэл зэрэг шинжлэх ухааны хүрээнд хүний нөөцийг хүний нөөцийн менежментийн шинжлэх ухааны хүрээнд тус тус судалдаг. Хүний нөөцийн удирдлага нь материаллаг нөөцийг удирдан зохион байгуулахаас ялгаатай байдаг. Учир нь хүний нөөцийн удирдлагын гол объект болох хүн бол оюун ухаантай, сэтгэл зүйтэй, ёс суртахуунтай, нийгмийн оршигч гэсэн онцлог шинж чанарыг агуулсан байдаг тул хүний нөөцийн удирдлага нь хүнд чиглэсэн, хүмүүнлэг байх ёстой юм. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа хүмүүсээр дамжин хэрэгждэг. Хүмүүс бол аливаа байгууллагын хамгийн чухал нөөц. Хүмүүс байнга боловсронгуй болох, хөгжих чадвартайгаас гадна бусад нөөцүүдээс ялгарах онцлог нь хүний боломж, санаачлага хязгааргүй байдагт оршино (Цэцэгмаа, 2014, хууд. 16).

Эрдэмтэн W.F.Casio, E.M.Awad "Хүний нөөцийн удирдлага нь байгууллагын зорилго болон хувь хүний зорилгыг нэгэн зэрэг биелүүлэхийн тулд хүний нөөцийг татах, сонгох, томилох, хөгжүүлэх, хадгалах үйл явц" гэсэн. Хүний нөөцийн удирдлага нь байгууллага дахь хүний нөөцийг удирдан зохион байгуулахтай холбоотой бүхий л үйл явцыг илэрхийлж байдгийнхаа хувьд хүний нөөцийн төлөвлөлт, ашиглалт, хадгалалт, хөгжил зэрэг үйл ажиллагаануудыг багтаасан удирдлагын нэгэн чухал vйл явц юм. Хүний нөөцийн удирдлагын үндсэн зорилго нь чадварлаг, мэргэшсэн ажил горилогчдыг байгууллагадаа татах, тогтвортой ажиллуулах, идэвхжүүлэх, урамшуулах, авьяас, ур чадварыг хөгжүүлэх зэрэг цогц системт ойлголтыг багтаадаг. Иймд байгууллага ажилтнуудын бүтээмжийг нэмэгдүүлэх, хууль тогтоомж, дүрэм журам сахин мөрдөхийн зэрэгцээ чанарыг сайжруулах зорилтыг давхар хангах үүргийг хүлээнэ (Бурмаа, Төрийн байгууллагын хүний нөөцийн аудит, 2021, хууд. 222). Хүний нөөцийн удирдлагын гол зорилтууд нь хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн амьдралын чанарыг сайжруулах болон хууль тогтоомжийг сахин мөрдөх юм. Менежментийн шинжлэх

ухааны тайлбар тольд “Байгууллагыг ажиллах хүчээр хангах, тэднийг сургаж, хөгжүүлэх, урамшуулж идэвхжүүлэх, ажлын байрны аюулгүй байдал, баталгааг хангах нь хүний нөөцийн удирдлагын үүргүүд” гэж тодорхойлсон. Удирдахуйн шинжлэх ухааны үүднээс хүний нөөцийн удирдлага нь байгууллагын стратегийг дэмжих зорилго бүхий хүний нөөцийн нэгдсэн бодлогыг бий болгоход оршино. Төрийн албаны хүний нөөцийн бодлого нь засгийн газрын стратеги төлөвлөгөө, хөгжлийн бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх, үр дүнтэй, уялдаатай зохион байгуулахад төрийн албаны хүний нөөцийг оновчтой, инновацлаг зохицуулан удирдана (Бурмаа, Төрийн байгууллагын хүний нөөцийн аудит, 2021, хуудсд. 222-236). Gary Dessler “Хүний нөөцийн удирдлага” номондоо ажилтны зан үйлийн, өрсөлдөх чадварын шаардлагуудад хүрэхийн тулд хүний нөөцийн бодлогыг тодорхойлсон. Үүнд:

Зураг 7 Хүний нөөцийн бодлого

Эх сурвалж: (Gary, 2016)

Эрх зүйн орчин: Хүний нөөцийн удирдлага нь эрсдэлийг бууруулахад гол үүрэгтэй тул төрийн албаны тухай хууль тогтоомж, дүрэм журамд заасны дагуу ажиллагсдын үүрэг, хариуцлага, хэрэгцээ, шаардлагыг анхаарч үздэг (Бурмаа, Төрийн байгууллагын хүний нөөцийн аудит, 2021, хууд. 224). Аливаа үйлдвэр, албан газар, байгууллага бүрт ажилтнуудын хөдөлмөрийг зохион байгуулж журамлах нь үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, ажиллагчдын хөдөлмөрийн өгөөж, хөлсийг нэмэгдүүлэх болон бусад зайлшгүй асуудлыг шийдвэрлэх нөхцөл мөн бөгөөд тэр нь хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулагдана. Аливаа үйлдвэр, албан газар, байгууллагууд хөдөлмөрийн дотоод журмаа баталж мөрдүүлэхдээ хууль ёсны шаардлагыг хангах, ил тод, тогтвортой, тухайн

байгууллагын үйл ажиллагааны онцлогийг тусгасан байх шаардлагатай (Цэцэгмаа, 2014, хуудсд. 405-420).

Хүний нөөцийн бүрдүүлэлт: Байгууллагад мэргэшсэн ажилтнуудыг шаардлагатай орон тоонд чадварлаг хүний нөөцөөр хангахад бүрдүүлэлтийн зорилго оршино. Ажлын байрны дүн шинжилгээ, сонгон шалгаруулалт, ажилд авах нь бүрдүүлэлтийн үндсэн үүрэг. Ажилтнууд ажлын байрандаа ямар ажил гүйцэтгэж, хэрхэн нөлөөлөл үзүүлэхийг тогтоох замаар ажлын байрны загвар, түүний дүн шинжилгээ хийх бүхий л үйл явцыг “Хүний нөөцийн менежментийн бүрдүүлэлтийн нэгжийн өртгийн олон улсын ISO30407:2016” стандартын дагуу хийхийг зөвлөдөг. Энэхүү стандарт нь байгууллагад байгаа нээлттэй албан тушаалыг хүний нөөцөөр хангах бүрдүүлэлтийн эдийн засгийн үнэ цэнийг хэмжихэд арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилготой. Шинэ ажилтнуудыг татан оролцуулах, эрж хайхад шаардлага хангах үнэн зөв, бодитой гадаад, дотоод эх үүсвэрийг ашиглана. Гадаад эх үүсвэр нь мэдээлэл харилцааны янз бүрийн хэрэгслийг ашиглаж байгууллагын гадаад орчноос шинэ ажилтныг татах үйл ажиллагаа юм. Дотоод эх үүсвэр нь ажлын сул орон тоонд байгууллагын одоогийн ажиллагсдаас татан оролцуулах үйл ажиллагаа. Зарим байгууллагад үйл ажиллагааны чиглэл, улирлын ажлын онцлог шинж, богино хугацаанд их ажлыг хийж гүйцэтгэх, зардлаа багасгах зэргээс шалтгаалж цагийн, орон тооны бус, түр ажиллагсдыг авах тохиолдол байдаг. Байнгын бус орон тооны ажиллагсдыг байнгын албан тушаалд томилох нь дотоод эх үүсвэрээс татан оролцуулж буй хэлбэр болно (Бурмаа, Төрийн байгууллагын хүний нөөцийн аудит, 2021, хуудсд. 239-240).

Сургалт, хөгжил: Төрийн албанд ажиллаж буй ажилтан бүр сурах, суралцах эрх, үүрэг, хариуцлага хүлээдэг бөгөөд төрийн алба, төрийн байгууллага бүр ажилтнуудаа сургах, сургалтад хамруулах, хөгжүүлэх үүрэг, хариуцлагыг хуулиар хүлээдэг. Иймд сурах, суралцах, хөгжихөд төрийн алба, төрийн байгууллага, төрийн албан хаагч харилцан хамтарсан үүрэг, хариуцлагыг давхар хүлээнэ. Аливаа сургалт суралцагчдыг ирээдүйд бэлтгэх зорилготой тул төрийн захиргааны сургалт нь шинэчлэлийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг бэлтгэхэд тусалж болно. Сургалтаар дамжуулан зарим ур чадварыг хөгжүүлэх боломжтой. Сургалт хөгжил нь шинэ ажиллагсдыг чиглүүлэхээс эхлэн ажилтнуудын ур чадварыг удирдах, хөгжүүлэх төрөл бүрийн сургалтыг агуулна. Иймд сургалтыг ажилтнуудын мэргэжил болон мэргэшил, ажилласан жил, албан тушаал, хариуцан ажиллаж буй ажлын үүрэг, даалгавар, хариуцлага, үнэлгээний үр дүнгээс хамаарч сургалтын төлөвлөгөө гаргана. Сургалтын төрлийг хугацаагаар нь богино, дунд, урт хугацааны, мэргэшлээр нь ерөнхий болон шаталсан түвшний хэмээн ангилна. Сургалтад хамрагдах субъектүүдийг төрийн албанд ажилласан хугацаанаас хамруулан анхан, дунд, мэргэшил болон албан тушаалын ангилал, зэрэглэлээс нь хамруулан холбогдох сургалтад хамруулна. Хүний нөөцийн хөгжил нь байгууллагуудад ажилтнуудаа сургах, ажил мэргэжлийн өсөлт нь ажиллах хүчээ хөгжүүлэхэд тусалдаг нь байгууллагын үр ашиг, гүйцэтгэлийг сайжруулна. Хүний нөөцийн хөгжилд гүйцэтгэлийн удирдлага ба хөгжил, ажилтнуудын сургалт, менторинг, амжилтын төлөвлөгөө, сургалтын төлбөр, байгууллагын хөгжил олон янзын боломж, үйл ажиллагаа багтана (Бурмаа, Төрийн байгууллагын хүний нөөцийн аудит, 2021, хуудсд. 251-252).

Цалин, урамшуулал: Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Цалин хөлсийг хамгаалах тухай” 95 дугаар конвенцод “Цалин хөлс гэж ажилтныг ажилд авсан тухай амаар болон бичгээр байгуулсан гэрээний дагуу түүний хийж, гүйцэтгэсэн, эсхүл хийж гүйцэтгэвэл зохих ажил үйлчилгээнийх нь төлөө ажил олгогчоос үндэсний хууль тогтоомж болон гэрээ хэлэлцээрийн үндсэн дээр тогтоон олгож буй аливаа мөнгөн урамшуулал буюу ажлын хөлсийг хэлнэ” гэж тодорхойлсон. Цалин хөлс нь үндсэн ба хувьсах буюу нэмэгдэл цалин, нэмэгдэл болон шагнал гэсэн хэсгүүдээс бүрддэг. Үндсэн цалин гэдэг нь тухайн ажилтны албан тушаал, хариуцлагын төвшин, ур чадвар, туршлагаас хамааран ажил олгогч ба ажилтан хоёрын хоорондын тохиролцоогоор тогтоосон хөдөлмөрийн хөлсний хэмжээ юм. Харин хувьсах цалин нь хувь хүний ажлын гүйцэтгэлийн тоо хэмжээ, ур чадвар, туршлагаас ихээхэн шалтгаалдаг. Хувьсах цалинг өөрөөр нэмэгдэл хөлс гэж нэрлэх явдал байдаг. Нэмэгдэл хөлс нь сар, улирал, жилийн ажлын үр дүнгийн, мэргэжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласны, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил үүргийг гүйцэтгэсний, шөнийн болон илүү цагаар ажилласны гэсэн нэмэгдэл хөлс гэж байдаг. Нэмэгдэл хөлсийг ажилтны үндсэн цалингаас хуулинд заасан тодорхой хувиар тооцож олгодог. Харин нэмэгдэлд мэргэшлийн зэргийн болон хөдөлмөрийн нөхцөлийн, амьжиргааны тэтгэмжийн зардал, гэр бүлд үзүүлэх тэтгэмж, орон байрны тэтгэмж, тээврийн зардлын болон хоол хүнсний тэтгэмж багтана. Төрийн албаны урамшууллын систем нь одоо ажиллаж байгаа ажиллагсдыг тогтвортой суурьшилтай ажиллуулах, шинэ албан хаагчдыг төрийн албанд татах үйл явцыг дэмждэг санхүүгийн болон санхүүгийн бус багц юм. Ажиллагсдын ажил үүргийн ялгаатай байдал, албан тушаалын зэрэг, шатлалын өөр өөр түвшинд байгаа хүмүүс ялгаатай урамшуулалтай тул тус бүрт нь зохих хэмжээгээр сэдэлжүүлэлт болж өгдөг. Жишээлбэл төрийн албанд албан тушаалын зэрэглэл, шатлалаас хамаарч дооросс дээш чиглэлтэй өсч байдаг. Албан тушаалын зэрэглэл, ажлын гүйцэтгэл, үр дүнгээс хамаарч цалин, урамшуулал өсөх зүй тогтолтой төрийн албаны хүний нөөцийн удирдлагын хөгжил, дэвшилтэй холбоотой. Төрийн албанд хэр удаан ажилласан, туршлагаар цалин, урамшууллын өсөлтийг харгалздаг байсан бол улсын салбарын шинэ удирдлага /New public management/-ын нөлөөгөөр үр дүн, үр ашигт төвлөрч төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнгээр цалин урамшуулал өсөх, албан тушаал дэвшдэг болж байна. Төрийн албаны цалингийн хувь хэмжээний өөрчлөлт нь засгийн газрын тэргүүлэх чиглэл өөрчлөгдсөнтэй холбоотой байж болох ба төрийн албан хаагчдын цалинг хувийн салбарын байгууллагуудын ажилчдын цалинтай харьцуулан үзэх нийгмийн хандлагын нөлөөлөлтэй холбож үзэж болох юм. Төрийн албан хаагчийн цалин урамшуулал, албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн харилцан үйлчлэлийг орц, гарцын харьцаагаар тодорхойлбол: албан хаагч хэдий хэмжээний орц буюу хичээл зүтгэл, хөдөлмөр, өөрийн мэдлэг, ур чадвар мэдлэг, цаг хугацааг тухайн ажлыг гүйцэтгэхэд зарцуулснаар ажлын гүйцэтгэл, үр дүн тооцогдоно. Мөн тухайн хэмжээгээр цалин, урамшуулал олгогдоно. Үүнээс үзэхэд орц, түүний үр дүн, гарцын үр ашгаар бий болно. Төрийн албан хаагчдын нийтлэг болон тусгай журам, нийгмийн баталгааг төрөөс хангадаг. Баталгааг бий болгож өгөхгүйгээр чадварлаг, мэргэжлийн хүмүүсийг татах, хадгалж үлдэхэд бэрхшээлтэй. Тиймээс төрөөс албан хаагчийн ажил үүргийн шинж чанараас хамаарч албаны унаа хэрэглэх, ажилдаа ирэх, буцах зардлын нөхөн олговор олгох, ажил үүрэгтэй холбоотой үүсч болзошгүй гадны нөлөөлөл, заналхийллээс хараат

бус байх, орон байраар хангах, үүргээ гүйцэтгэж байх үед албан хаагчид болон түүний эд хөрөнгөнд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх зохицуулалт зэрэг нийтлэг баталгаагаар зохицуулдаг (Бурмаа, Төрийн байгууллагын хүний нөөцийн аудит, 2021, хуудсд. 226-228).

Ажил олгогч, ажилтнуудын харилцаа: Ажил олгогч ба ажиллагсад хоорондын үл ойлголцох зэрэг бэрхшээлтэй асуудал нь байгууллагын амжилтад сөргөөр нөлөөлөх магадлалтай (Бурмаа, Төрийн байгууллагын хүний нөөцийн аудит, 2021, хууд. 223).

Төрийн байгууллага төрийн албан хаагчдаас бүрдэн үйл ажиллагаагаар зорилго, зорилтоо хэрэгжүүлдэг (Бурмаа, Төрийн байгууллагын хүний нөөцийн аудит, 2021, хууд. 147). Нийтийн салбар "дүрэм тогтоосон" соёлоос "гүйцэтгэлд суурилсан" соёл руу шилжих үед хүний нөөцийн удирдлагыг нэвтрүүлсэн гэж Shim үзсэн (Shim, pp. 323-347). Мөн улсын салбарын шинэ удирдлагыг (NPM) нэвтрүүлснээр менежерүүд хүний нөөцийн удирдлагын нарийн технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх боломжийг нээсэн байж болох юм. Тиймээс улсын салбарын шинэ удирдлагын NPM зарчмууд нь төрийн байгууллагын ажиллагсдыг сонгох, ажиллуулах, хадгалах, сургах, хөгжүүлэх асуудалд илүү уян хатан, хариу үйлдэл үзүүлэх боломж олгодог (Бурмаа, Төрийн байгууллагын хүний нөөцийн аудит, 2021, хууд. 159). Хүний нөөцийн удирдлага нь байгууллагын эрхэм зорилго, ажилтнуудын хүлээлтийг хангахын тулд ажилтнууд болон байгууллагын уялдаа, холбоог бий болгох, хадгалах байгууллагын төлөвлөсөн, хяналттай үйл ажиллагаа (Ulung, 2013, p. 5) бөгөөд үндсэн чиг үүрэг нь байгууллагын хүний нөөцийг бүрдүүлэх, ажиллагсдыг өндөр гүйцэтгэлд чиглүүлэн ажиллуулахад оршино. Мөн хүний нөөцийн удирдлагыг байгууллагын зорилгод хүрэхийн тулд хүний нөөцийг татах, сонгон шалгаруулах, хөгжүүлэх, удирдах зорилгоор хэрэгжүүлсэн бүх практик, систем, журам гэж тодорхойлж болно. Үүнээс дүгнэхэд төрийн байгууллагын хүний нөөцийн удирдлага нь байгууллагын зорилгод хүний нөөцийн үйл ажиллагааг чиглүүлэх, албан хаагчдыг сонгон шалгаруулах, сургаж хөгжүүлэх цогц системт үйл ажиллагаа юм. Төрийн байгууллагын хүний нөөцийн удирдлага нь ажилтнуудад төрийн албаны тогтолцоо, зохицуулалт, эрх зүйн орчин, дүрэм журмыг дагаж мөрдөхийг үүрэг, хариуцлага болгодог. Энэ нь төрийн албанд хүний нөөцийн удирдлагыг үр ашигтай зохион байгуулах зорилготой. Төрийн байгууллагын үйл ажиллагаа иргэдийн сайн сайхны төлөө үйлчилдэг тул хууль, дүрэм журмын дагуу гүйцэтгэхэд мэргэшсэн хүний нөөц шаардлагатай (Бурмаа, Төрийн байгууллагын хүний нөөцийн аудит, 2021, хуудсд. 152-156). Аливаа байгууллагын өрсөлдөх чадвар чанар, үнэ, үйлчилгээ гурван тодорхойлогдох бөгөөд эдгээр нь ажилтан хүнээс хамааралтай байдаг. Төрийн алба нь аливаа улсын төрийн тогтолцооны үндэс суурь тул төрийн албаны гүйцэтгэл хүмүүн капиталын үйл ажиллагааны үр ашгаар тодорхойлогдоно. Төрийн алба бол ажиллагсдыг мэргэшүүлэх, ажиллах ур чадварыг дээшлүүлэх, хадгалах, дэмжих хөдөлмөр эрхлэлт. (Бурмаа, Төрийн байгууллагын хүний нөөцийн аудит, 2021, хуудсд. 224-226). Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын зорилго нь байгууллагын ажиллагсдыг үр ашигтай удирдахад чиглэн тодорхой зарчмыг баримтлах ба дараах нийтлэг шинжийг агуулна. Үүнд (Jerome & Atine, 2015, p. 72):

- Засгийн газар сайн ажил олгогч байх ёстой,

- Хүмүүс бол хамгийн чухал хөрөнгө,
- Төрийн албан хаагчдыг сонгон шалгаруулж, тэднийг чадахуйн болон карьерийн хөгжлийн үндсэн дээр удирддаг,
- Төрийн албан хаагчид хөдөлмөрөө зөв үнэлүүлж цалин хөлс авах, өөрийгөө хөгжүүлэх боломжоор хангагдах эрхтэй,
- Ажилтнуудыг оновчтой удирдах нь бүх шатны удирдлагуудын үүрэг, хариуцлага,
- Байгууллага, нэгжийн боловсруулсан төлөвлөгөө, зорилт хүний нөөцийн сургалт, хөгжлийн зорилтыг зайлшгүй агуулсан байх зэрэг багтана

Эрдэмтэн R.Likert “Хүний нөөц бол байгууллагын хамгийн том хөрөнгө юм. Байгууллагад мэдлэг, чадвартай ажилтан орвол байгууллагын хөрөнгө нэмэгдэж гарвал байгууллагын хөрөнгө багасаж байдаг. Мөн ажиллагчдын дунд ямар эргэн зөрчил, зөрчилдөөн байвал байгууллагын хүний нөөцийн эрч хүч сулардаг бол эв нэгдэлтэй байхад батжин бэхэждэг" гэжээ. Аливаа улс орны шавхагдашгүй үнэт баялаг нь хүмүүн капитал тул түүний нөөцийг бэлтгэх, оновчтой удирдах нь төрийн бодлогын үндэс. Хүний нөөцийн удирдлага нь байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, зорилт, үнэт зүйлд хүрэхийн тулд байгууллагын (ажиллагсад) гишүүдтэй хамтарч ажилладаг мэргэшсэн мэргэжилтнүүдээс бүрдэнэ. Иймээс хүний нөөцийн удирдлага нь бусад үйл ажиллагааны нэгжүүдийн үйлчилгээний хэсэг болж ажилладаг. Гэвч төрийн байгууллага бүрд хүний нөөцийн удирдлагын албан ёсны нэгж байдаггүй, гэхдээ хүний нөөцийн чиг үүргийг хариуцдаг албан хаагч бий. Хүний нөөцийн удирдлагын албаны ёсны нэгжгүй нөхцөлд байгууллагын удирдлага эдгээр үйл ажиллагааг давхар удирддаг. Төрийн албаны хүний нөөцийн удирдлага нь төрийн удирдлагын тогтолцоонд чухал ач холбогдолтой тул дэлхийн ихэнх улс орнууд төрийн албанд шинэчлэл хийхдээ хүний нөөцийн удирдлагын асуудлыг тухайлан чухалчилж үзэн тодорхой хэмжээнд амжилтад хүрсэн нь хүний нөөцийн удирдлага төрийн албанд чухал үүрэгтэйг нотолсон (Бурмаа, Төрийн байгууллагын хүний нөөцийн аудит, 2021, хуудсд. 5-226). Дэлхийн банкны “Өндөр чадавхтай төрийн албыг бий болгох нь: Шинэтгэлийн явц, сургамж” тайланд “Газар зүйн онцлогоос шалтгаантай төрийн үйлчилгээний хэрэгцээг хангахад орон тоог нэмэгдүүлэх нь шийдэл биш гэж уг тайланд үзсэн байна. Харин төлөвлөж буй шинэтгэлийн хүрээнд байгаа хүний нөөцөө үр дүнтэй удирддаг болох нь төрийн үйлчилгээ үзүүлэх бүтээмжийг дээшлүүлэхэд нэн чухал” гэжээ.

Байгууллагад нөлөөлөгч орчны нөлөөллийг судлах нь өнөө үед байгууллагуудад хүний нөөцийн удирдлага хэрхэн хэрэгжиж байгаа, ирээдүйд хэрхэн хэрэгжиж болох талаар ойлголт бий болгоход чухал ач холбогдолтой. Хүний нөөцийн бодлогод гадаад, дотоод хүчин зүйлс нөлөөлнө. Хүний нөөцийн удирдлагын чиг үүрэг, функцүүд нь хүний нөөцийн удирдлагын зорилго, зорилтыг хангахын тулд нягт уялдаатай зохион байгуулагдан гадаад, дотоод орчны нөлөө, хүний нөөцийн удирдлагын хөгжил, өөрчлөлтөөс шалтгаална. Хүний нөөцийн удирдлагад шинжлэх ухааны онолын чиг хандлага, өөрчлөлт хөгжил, эрх зүйн орчин, эдийн засаг, технологи, байгаль орчин, түүх, соёл, уламжлал, улс төр, нийгмийн зэрэг гадаад хүчин зүйлс нөлөөлнө. Төрийн стратеги, бодлого зохицуулалт, хөдөлмөрийн зах зээл, салбар хоорондын уялдаа холбоо, хөрөнгө

оруулалтын бодлого нь макро түвшний нөлөөлөх хүчин зүйлс мөн бөгөөд микро түвшний байгууллагын хувьд гадаад хүчин зүйлс болно. Хэдийгээр чиг үүрэг, үйл ажиллагаа бүрийг тус тусад нь авч үзэж байгаа боловч нэг нь нөгөөгөөсөө маш их хамааралтай байдаг. Өөрөөр хэлбэл, нэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга нь нөгөөг хэрэгжүүлэх аргад нөлөөлдөг. Байгууллагад нөлөөлөх хүчин зүйлсээс шалтгаалж хүний нөөцийн удирдлагын чиг үүрэгт өөрчлөлт орж болно (Бурмаа, Төрийн байгууллагын хүний нөөцийн аудит, 2021, хуудсд. 222-237). 1960-аад оны сүүл үеэс эхлэн байгууллагын гадаад орчин буюу нийгэм, улс төр, эдийн засаг, хууль эрх зүйн орчин дахь нөхцөл байдал байгууллагын менежментийн үйл ажиллагаанд хүчтэй нөлөөлөх болсноор нөхцөл байдалд дасан зохицох менежментийн стратегиуд шаардагдаж эхэлжээ. Эрдэмтэн P.R.Lawrence & Lorch нар "Ямар ч орчинд амьдрах чадвартай шилдэг байгууллага гэж байхгүй тиймээс байгууллага орчны өөрчлөлтөд дасан зохицох чадвартай байхын тулд өөрчлөлт шинэчлэлийг зайлшгүй хэрэгжүүлэх ёстой" гэж үзжээ. Орчинд дасан зохицох өөрчлөлт шинэчлэлтийн үед "Системийн онол" гарсан бөгөөд байгууллагыг орчны нөхцөл байдалтай харилцан хамааралтай оршдог “Нээлттэй систем" /System theory/ гэж тодорхойлов. Манлайллын онолууд системийн онолын нөлөөллийг авч эхэлсэн. Жишээлбэл E.Fiedler "Манлайллын үр ашигт байдлын онол"-д тулгуурласан "Нөхцөл байдалд дасан зохицох манлайллын онол" гарсан байна. Өөрчлөлтийн манлайлал нь манлайллын түгээмэл онол гэж үздэг. Энэ нь удирдагчид алсын хараа, ёс зүй, ёс суртахууны өндөр хэм хэмжээгээр хүмүүсийг удирдаж, урам зориг өгдөг ба тэдний дагалдагчдын хооронд үүссэн нягт уялдаа холбоо юм. Өөрчлөлтийн манлайллаар удирдуулсан байгууллагуудад өндөр хүлээлт байдаг нь доод албан тушаалтнууд бэрхшээлтэй тулгарах үед өөртөө итгэл итгэлийг өгдөг бөгөөд бусад төрлийн манлайллаас илүү гүйцэтгэлтэй байдаг. Өөрчлөлтийн манлайллын ойлголтыг анх James MacGregor Burns нэвтрүүлж, дараа нь Bernard Bass боловсронгуй болгон хөгжүүлсэн (Бурмаа, Төрийн байгууллагын хүний нөөцийн аудит, 2021, хууд. 161). Avolio ба бусад судлаачид өөрчлөлтийн манлайллын дөрвөн хүчин зүйлийг тодорхойлсон (Avolio, Bass, & Jung, 1999, pp. 441-462).

1) Оюуны өдөөлт,
2) Хувь хүнд анхаарал хандуулах,
3) Урам зориг өгөх сэдэл,
4) Төгс нөлөө,

Tony Buon өөрчлөлтийн манлайллын хэв маягийг хувиргах хэв маягтай харьцуулж болохыг дурдсан (Buon, 2014). Хувиргах манлайллын онолыг анх социологич Макс Вебер тодорхойлж, 1980-аад оны эхээр Bernard M.Bass үргэлжлүүлэн судлав. Энэ нь ажиллагсдын гүйцэтгэлийг урамшуулахын тулд арга хэмжээ болон олон төрлийн урамшууллын аргыг ашигладаг үйл ажиллагааны хэвийн байдлыг хадгалахтай холбоотой ойлголтыг багтаадаг. Гурав дахь манлайллын хэв маяг нь өөрсдийн зорилго, зорилтоо тодорхойлох сайн дураар дагалдагчдыг багаар ажиллахыг уриалсан үл оролцох манлайлал юм (Бурмаа, Төрийн байгууллагын хүний нөөцийн аудит, 2021, хууд. 162). Bernard M.Bass: “Сайн удирдагчид үл оролцох манлайллын хандлагаас зайлсхийж, ажлын орчин, шагнал урамшууллын системийг бүтцийн менежментийн хариуцлагатай чиг үүргийг үр дүнтэй гүйцэтгэдэг, мөн өөрчлөлтөд аль болох их анхаарал хандуулдаг

байх хэрэгтэй” (Tracey, Montgomery, & Xiao, 2018, p. 321)-г сануулсан. Өнөөгийн өрсөлдөөний их зуунд аливаа улс орон, байгууллага, хувь хүний өрсөлдөх чадвараа дээшлүүлэх цорын ганц арга зам бол өөрчлөлт, шинэчлэл юм. Эрдэмтэн J.Howell, C.Higgins “Өөрчлөлт шинэчлэл нь байгууллагад хөгжих боломжийг олгодог" гэсэн бол P.F.Drucker "Менежментийн үйл ажиллагаа бүхэлдээ өөрчлөлт шинэчлэл бөгөөд өөрчлөлт шинэчлэл байхгүйгээр өрсөлдөх чадвартай шилдэг байгууллага болж өсөж хөгжиж чадахгүй” гэжээ. Өөрчлөлт шинэчлэлтийг хэрэгжүүлэх явцад ялангуяа хэрэгжүүлэлтийн эхний үе шатанд эсэргүүцэл зайлшгүй гарч байдаг. Эсэргүүцлийн хэлбэр болоод шалтгаан мөн түүнд авах хариу арга хэмжээний талаар авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 8. Эсэргүүцлийн учир шалтгаан

Сэтгэл зүйн шалтгаан	• Тодорхой бус байдлын талаарх айдас түгшүүр • Эзэмшлийн эрхээ алдахаас үүдэх санаа зоволт • Шинэ техник технологийг дахин суралцах дарамт шахалт • Тайван тогтвортой байх хэрэгцээ алдагдах
Эдийн засгийн шалтгаан	• Хэлтэс тасаг руу шилжих, албан тушаалын сэлгэлт хөдөлгөөн • Орчны өөрчлөлтийг дагасан эдийн засгийн дарамт шахалт
Нийгмийн шалтгаан	• Байгууллага дотор эрх мэдлээ алдах • Бие даах эрхээ алдахаас үүдэх айдас түгшүүр, санаа зоволт

Өөрчлөлт шинэчлэлийг зөвхөн “Хэрэгжүүлбэл болно" гэж хялбархан ойлгон хүлээн авч болохгүй. Учир нь өөрчлөлт шинэчлэл бол хүний сэтгэл зүйтэй салшгүй холбоотой ойлголт юм. Байгууллагын өөрчлөлт, шинэчлэл нь эцэстээ ажиллагчдын ухамсар ба хандлага, ажил үүрэг гүйцэтгэх арга барил өөрчлөгдсөнөөр хэрэгжих боломжтой байх тул өөрчлөлт шинэчлэлийг хэрэгжүүлэх явцад хүнтэй холбоотой асуудал ялангуяа тэдний сэтгэл зүйн талын асуудлуудыг шийдвэрлэж байж эсэргүүцлийг даван туулах боломжтой байдаг.

АНУ-ын төрийн албаны хүний нөөцийн удирдлага

1860-аад оны үед АНУ-д холбооны түвшинд Европийнхний ойлголтоор мэргэжлийн бюрократ гэсэн ойлголт үндсэндээ байгаагүй. 1829 онд Ерөнхийлөгч Э.Жэксоны нэвтрүүлсэн “victors spoils system” буюу сонгуульд ялсан намын төлөөлөл албан тушаалд томилогддог тогтолцоо хэрэгжиж байв. XIX зууны эцэс, XX зууны эхээр АНУ-д европын төрийн албаны боловсронгуй загварын тухай үзэл санаа өргөн хүрээнд

яригдах болсон байна. 1883 онд батлагдсан Пендлтоны хуулиар “Төрийн дийлэнх албан хаагчдын албан тушаал, цалин хөлс, мэргэжлийн шалгаруулалтын нэгдмэл тогтолцоо”-г хэрэгжүүлж эхэлснээр “victors spoils system”-д хязгаарласан хууль бол 1939 онд Конгрессоор батлагдсан Хэтчийн хууль бөгөөд түүгээр төрийн албан хаагчид аль ч шатны сонгуулийн кампанит ажилд оролцох, өөрийн албан тушаалын байдлаа аль нэг улс төрийн намын ашиг сонирхолд ашиглахыг хориглосон байна. 1960-1970 онуудад төрийн албыг улс төржүүлэх хандлага дахин зонхилж байв. 1978-1979 онуудад хийгдсэн төрийн албаны өөрчлөн байгуулалтаар төрийн албанд “merit system” буюу “ажлын үр дүнгийн систем”, төрийн албан хаагчдын байнгын аттестатчилал, ажлын үр дүнгийн хяналтыг нэвтрүүлснээр хуучин системийг үндсээр эргүүлсэн байна. Төрийн албаны удирдах байгууллагуудыг эмхлэн байгуулсны дотор Холбооны хүний нөөцийг удирдах газар, Ажлын үр дүнгийн тогтолцоог хамгаалах зөвлөлийг байгуулсан байна. Түүнчлэн улс төрийн болоод албан тушаалд дэвших хүний нөөц /1994 онд тэдгээрийн тоо 7560-д хүрсэн/-ийг бүрдүүлэх зорилгоор дээд түвшний захиргаа-улс төрийн элитүүдийн эмхлэн байгуулах тогтолцоо /Дээд түвшний удирдагчдын алба/-ыг байгуулжээ. 1978 онд энэхүү өөрчлөлтийг бататгах үүднээс төрийн иргэний албаны тухай хуулийг баталсан байна. АНУ-ын төрийн иргэний албаны орчин үеийн загварын онцлог нь:

1. Төрийн иргэний албаны тогтолцоонд улс төрийн томилгоо зонхилох байр суурьтай,,
2. Төрийн иргэний албан тушаалтны цалингийн хэмжээ, албан тушаалд дэвших нь ажлын үр дүнгээс хамаарах “ажлын үр дүнгийн систем”-тэй,
3. Төрийн иргэний албан тушаалтныг ажлаас халах хялбаршуулсан журамтай,
4. Холбооны төрийн алба, Холбооны субъектүүдийн төрийн алба /Холбооны субъектүүдийн төрийн албаны тухай хууль нь хоорондоо болон холбооны хуультайгаа бараг адил/-тай учраас төвлөрлийг өндөр түвшинд сааруулж чадсан,
5. Төрийн иргэний албаны ангилал тогтоохдоо:
    - АНУ-ын байгууллагуудад хөдөлмөрийн гэрээгээр ажиллах иргэний нийтийн албан хаагч,
    - дээд түвшний улс төрийн томилгооныхон-төр засгийн албан хаагч,
    - төрийн албан хаагчдын 60%-ийг эзлэх иргэний албан хаагч–мэргэжлийн өөрчлөгдөшгүй түшмэдүүд гэж ангилжээ.

1993-1999 онд АНУ-д төрийн албаны дараагийн өөрчлөлтийг хийсэн бөгөөд түүнийг ердийн төрийн албан хаагчид бус улс төрийн томилгооныхон удирдсан байна. 1992 онд явуулсан үндэсний хэмжээний ажлын үр дүнгийн шалгалтын үндсэн дээр 1993 онд “Төр засгийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийн тухай хууль” батлагдаж, түүний дагуу төрийн албан хаагчдын үйл ажиллагааны үр дүнг үнэлж, холбооны төрийн албан хаагчдын тоог 17%-иар цомхтгосон байна (УИХ-ын ТГ-ын Судалгаа, шинжилгээний хэлтэс, 2014, хуудсд. 428-429). АНУ-д төрийн албан хаагчийн албан тушаалын цалинг тухайн албан хаагч албан тушаалын ангилалд эзлэх рангийг үндэслэн тогтооно. Гэхдээ ангиллын ранг бүрийн хүрээнд албан тушаалын цалингийн тодорхой зааг, ялгаа байх бөгөөд үүнд үндэслэн цалингийн хэмжээг албан тушаалтны чиг үүргийн гүйцэтгэлийн чанар, мэргэжлийн мэдлэг чадвараас хамааран өөрчилж болдог. Албан байгууллага бүрийн дэргэд төрийн албан хаагчдын мэргэжлийн үйл

ажиллагааны үр дүнг үнэлэх, үнэлгээний систем тогтоодог тусгай зөвлөлүүд байдаг. Ерөнхийдөө АНУ-ын төрийн албан хаагчийн албан тушаалын цалинг ажлын үр дүнгээс хамаарахгүйгээр жил бүр нэмэгдүүлдэг боловч дээр дурдсан зөвлөлийн саналыг үндэслэн албан тушаалтан чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн бол цалингийн хэмжээг нь багасгах, эсвэл сайн ажилласан бол нэмэгдүүлэх боломжтой. Хасах болон нэмэх хэмжээ нь албан хаагчийн үндсэн цалингийн 5 хувиас багагүй, 20 хувиас ихгүй байх бөгөөд энэ нь нэг жилийн хугацаатай байна. АНУ-д төрийн албан хаагчид цалингаас гадна төрөл бүрийн нэмэгдлүүд авдаг: дүрэмт хувцас худалдан авах нэмэгдэл, хилийн чанадад ажиллаж байгаа иргэний албан хаагчдын хувьд доллар үнэгүйдсэний нэмэгдэл, хилийн чанадад ажиллаж буй ажилтанд олгох хөдөлмөрийн аюултай нөхцөлийн нэмэгдэл (үндсэн цалингийн 25 хувиас хэтрэхгүй), алслагдсан орон нутагт ажилласны нэмэгдэл, АНУ-ын эх газрын хэсгээс гадна ажилласны нэмэгдэл (үндсэн цалингийн 25 хувиас хэтрэхгүй), тээврийн нэмэгдэл зэрэг байдаг. АНУ-ын төрийн албан хаагчдын хөдөлмөрийн хөлсний системийн нэг онцлог нь улс орны нийгэм, эдийн засгийн байдлаас хамаардаг явдал юм. Жил болгон дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, ажилгүйдлийн түвшин, төсвийн алдагдлын хэмжээ, хэрэглээний үнийн индекс зэрэг үзүүлэлтээс хамаарч АНУ-ын ерөнхийлөгч, төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх түвшинг тогтооно эсвэл царцаана. Жишээлбэл, 2010 онд ерөнхийлөгч Барак Обама төсвийн алдагдалтай тэнцэх зорилтуудын хүрээнд төрийн албан хаагчдын цалинг 2 жилийн хугацаагаар царцаасан байна. Америкийн төрийн албан хаагчдын цалингийн системийн гол онцлогууд нь:

- Төрийн байгууллага бүрийн дэргэдэх төрийн албан хаагчийн хөдөлмөрийн үр дүнг үнэлэх системд үндэслэн үндсэн цалин, нэмэгдлийг төвлөрсөн биш журмаар тогтоох,
- Албан тушаалын цалинг хүн бүрээр тогтоох,
- Хөдөлмөрийн нөхцөлтэй холбоотой нэмэгдлийн систем,
- Боломжит нэмэгдлийн хэмжээг тодорхой зохицуулах,
- Нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдээс хамаарах зэрэг болно.

Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн хөлсийг дараах зарчмыг үндэслэн тогтоодог. Цалингийн түвшин нь хуулиар тогтоогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх мэргэжил, чадвар бүхий шаардлагатай тооны мэргэжилтнүүдийг төрийн албанд татахад хангалттай байх, эдгээр чиг үүргийг хэрэгжүүлэх мөнгөн хөрөнгө нь улсын ерөнхий эдийн засаг, санхүүгийн нөхцөл, төрөөс баримталж буй нийгмийн бодлогод нийцсэн, улсын боломжоос хэтрээгүй байх (УИХ-ын ТГ-ын Судалгаа, шинжилгээний хэлтэс, 2014, хуудсд. 236-237).

Дүгнэлт: Төрийн байгууллагын хүний нөөцийн удирдлага нь зөвхөн ажилтан бүрдүүлэх бус, тэднийг үр дүнтэйгээр сургах, хөгжүүлэх, урамшуулах, байгууллагын зорилго, гүйцэтгэлтэй уялдуулан манлайлах цогц систем юм. Хүний нөөцийн бодлого нь стратегийн түвшинд, шинжлэх ухааны хандлагаар төлөвлөгдөж, хэрэгжих ёстой. Түүнчлэн өөрчлөлт, шинэчлэлийг хэрэгжүүлэхэд байгууллагын соёл, ажилтны сэтгэл зүй, оролцоо чухал нөлөөтэй байдаг. Тиймээс төрийн байгууллагын хүний нөөцийн удирдлагыг улам боловсронгуй болгоход олон улсын туршлага, манлайллын орчин үеийн онолууд, ажилтны амьдралын чанар, бүтээмж зэрэгт суурилсан бодлого шаардлагатай байна.

Ашигласан материал:

1. Бурмаа, Д. (2021). Төрийн байгууллагын хүний нөөцийн аудит. Улаанбаатар: ШУТИС-ийн хэвлэл.
2. Цэцэгмаа, Д. (2014). Төрийн албаны хүний нөөцийн менежмент. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэл.
3. Blau, P. M., & Scott, W. R. (1962). Formal organizations: A comparative approach. Stanford University Press.
4. Lundgren, R. (1974). The organization and its environment. Academic Press.
5. Levitt, H. J. (1972). Applying organizational behavior. Prentice Hall.
6. Miller, K. (2012). Organizational communication: Approaches and processes (6th ed.). Wadsworth Cengage Learning.
7. Dessler, G. (2016). Human resource management (15th ed.). Pearson Education.
8. Ulung, S. (2013). Human resources planning. Open University Press.
9. Avolio, B. J., Bass, B. M., & Jung, D. I. (1999). Re-examining the components of transformational and transactional leadership using the Multifactor Leadership Questionnaire. Journal of Occupational and Organizational Psychology, 72(4), 441–462. https://doi.org/10.1348/096317999166789
10. Tracey, J. B., Montgomery, D. C., & Xiao, Q. (2018). Leadership effectiveness: A meta-analysis. Management Journal, 44(3), 321–335.

SPSIRPA FORUM 2025

Session 6-9

Stability of Operations in Government Organizations

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Магистрант: Б.Хоролжүсэм

Д.Чанцал

Хураангуй:

Төрийн байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдал нь улс орны хөгжлийн үндэс суурь бөгөөд төрийн байгууллагууд урт хугацаанд үр нөлөөтэй, тасралтгүй, мэргэшсэн үйл ажиллагаа явуулж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэх суурь нөхцөл билээ. Урьдчилан тааварлахад төвөгтэй болж буй өнөө үед гарч болзошгүй бүх талын эрсдэл, сорилтын эсрэг сөрөн зогсох үндэсний дархлаа бол төрийн албаны тогтвортой бодлого, үйл ажиллагаа гэдэг нь улам бүр тодорхой болсоор байна.

Монгол Улсад улс төрийн орчин нөхцөл, төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдал, хүний нөөцийн бодлого, төсөв санхүүгийн үр ашигтай зарцуулалт, засаглалын ил тод, нээлттэй байдал, хяналт, хариуцлагын тогтолцоо бүх түвшинд алдагдсанаар төрийн байгууллагын үйл ажиллагааны залгамж чанар, тогтвортой, тасралтгүй үр дүнтэй байдалд сөрөг нөлөө үзүүлж байна.

Тиймээс энэхүү илтгэлд төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлын ач холбогдол, тулгарч буй гол сорилтыг онолын болон практик үндэслэлээр авч үзэн, тогтвортой байдлыг бэхжүүлэх бодлого, арга зам, шийдлийг тодорхойлсон болно.

Түлхүүр үг:

Тогтвортой байдал, төрийн захиргааны байгууллага, улс төр, хүний нөөц, эдийн засаг, хууль эрх зүй, шалгуур үзүүлэлт

Удиртгал

1.1. Судалгааны үндэслэл

Монгол Улсын хувьд 2017 онд шинэчлэгдэн батлагдсан Төрийн албаны тухай хуулийн 7.1.2 дугаар зүйлд төрийн албанд мэргэшсэн, тогтвортой байх зарчмыг баримтална; харин хуулийн зорилтыг төрийн албаны мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх, төрийн албаны төв байгууллага, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгааг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино (Төрийн албаны тухай хууль, 2017) хэмээн эрх зүйн үндсийг тодорхойлсон байдаг.

Гэвч сүүлийн жилүүдэд Монгол Улсад төрийн захиргааны байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн, удирдлагын тогтолцоо байнга өөрчлөгдөж, тухайн байгууллагын үндсэн чиг үүрэг, эрх зүйн зохицуулалт болон хүний нөөцийн тогтвортой байдалд тодорхойгүй

байдал үүсгэж, улс төрийн орчин нөхцөл, төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдал, хүний нөөцийн бодлого, төсөв санхүүгийн үр ашигтай зарцуулалт, засаглалын ил тод, нээлттэй байдал, хяналт, хариуцлагын тогтолцоо бүх түвшинд алдагдсанаар төрийн байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэх хандлага ажиглагдаж байна.

Үндэсний хөгжлийн газрын судалгаагаар Монгол Улсад 1990 оноос хойш нийт хөгжлийн бодлогын 567 дунд болон урт хугацааны стратеги, үзэл баримтлал, хөтөлбөр, бодлого, мастер төлөвлөгөө зэрэг баримт бичгүүд батлагдан мөрдөгдөж ирсэн (Баярсайхан, Б., Мөнхболд, А, 2018) бөгөөд Монгол Улсад Засгийн газрууд эмхлэн байгуулагдах бүрт урт хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлт, яам, агентлагийн тоо, бүтэц, чиг үүргийг өөрчилж, үүнийг дагасан хүний нөөцийн шилжилт, хөдөлгөөн ихсэж байгаа нь үүний тод жишээ юм.

Тиймээс дэлхий даяар төрийн байгууллагын тогтвортой хөгжил, ил тод байдал, тасралтгүй хөгжил улам бүр чухал болсоор байгаа энэ үед тогтвортой байдлын тухай ойлголт, мөн чанарыг судалж, Монгол Улсын төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдал алдагдахад нөлөөлж буй хүчин зүйл, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох, цаашлаад төрийн захиргааны байгууллагын тогтвортой үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулж, шийдвэрлэх арга замын зураглал, санал, зөвлөмжийг дэвшүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

1.2. Судалгааны сэдвийн ач холбогдол, шинэлэг тал

Монголын нөхцөлд төрийн захиргааны байгууллагын тогтвортой байдлын талаарх судалгаа, тайлан, мэдээллүүд байдаг боловч шалгуур үзүүлэлтээр үнэлсэн нь ховор. Иймд энэ чиглэлд судалгаа хийснээр онолын ба практик шинэ мэдлэгийн орон зайг нөхөж, шийдвэр гаргагч нарт зөвлөмж өгөх боломжтой юм.

1.3. Судалгааны зорилго, зорилт

Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны тогтворгүй байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох замаар байгууллагын тогтвортой байдлыг үнэлэх оновчтой шалгуур үзүүлэлтүүдийг Олон улсад ашиглагддаг индексүүдэд үндэслэн Монгол Улсын онцлогт нийцсэн байдлаар боловсруулж, тогтвортой байдлыг хангах арга зам, бодлогын санал дэвшүүлэхэд судалгааны зорилго оршино.

Судалгааны зорилт

- Төрийн захиргааны байгууллагын тогтвортой байдлын ойлголт, мөн чанарыг судлах
- Төрийн захиргааны байгууллагын тогтвортой байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох
- Тогтвортой байдлыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах
- Төрийн захиргааны байгууллагын тогтвортой байдлыг хангах арга зам боловсруулах

1.4. Судалгааны арга зүй, хамрах хүрээ

Монгол Улсын төрийн захиргааны үйл ажиллагааны тогтвортой байдлын шалгуур үзүүлэлтийг боловсруулахдаа “Bertelsmann Transformation Index”-г тооцох арга зүйд тулгуурлав. Тэрчлэн төрийн захиргааны өнөөгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны тогтвортой байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг авч үзэхдээ баримт бичгийн дүн шинжилгээ болон холбогдох судалгааны тайланд тулгуурласан болно. Судалгаанд ашигласан индексүүдийн онооны үр дүнг тооцохдоо эерэг хариултад 10-с эхлэн 9-7, 6-4, 3-1 оноо өгөх байдлаар дата мэдээлэлд хоёрдогч боловсруулалт хийж үр дүнг тооцсон.

1.5. Судлагдсан байдлын тойм

Төрийн захиргааны байгууллагын тогтвортой байдал нь тухайн байгууллагын эрх зүйн орчин, улс төрийн дэмжлэг, төсвийн хүртээмж, хүний нөөцийн тогтворжилт, гүйцэтгэлд суурилсан хяналт-шинжилгээний тогтолцоо зэрэг олон талт хүчин зүйлүүдтэй уялдан хөгждөг болохыг олон улсын болон үндэсний түвшний судалгаанууд баталдаг. Байгууллагын тогтвортой байдлын талаарх судалгаанаас захиргааны системийн тогтвортой байдалд нөлөөлдөг 5 хүчин зүйлийн судалгаа түгээмэл ашиглагддаг бөгөөд (i)бүтцийн, (ii)эрхэм зорилго буюу зорилтот чиг үүргийн, (iii)үйл ажиллагааны, (iv)хүний нөөцийн, (v)үйлчилгээ болон технологийн талаас нь судалж, эдгээрийн аль нэг нь тогтворгүй байх нь нийт системд сөргөөр нөлөөлдөг болохыг онцолсон байдаг (Toole, O., & Meier, K. J, 2003). Харин B.G.Peters улс төрийн тогтворгүй байдал төрийн бодлого хэрэгжих явцад тасалдал, үр дүнгүй байдал үүсгэдэг гэдгийг онцолж, ялангуяа хөгжиж буй орнуудад улс төрийн намуудын эрх барих мөчлөгөөс шалтгаалан төрийн захиргааны байгууллагуудын институцийн үргэлжлэл тасалдах эрсдэлтэйг тэмдэглэсэн байдаг (Peters, 2019). Түүнчлэн Дэлхийн банкны "Governance Indicators" үзүүлэлтүүдэд улс төрийн тогтвортой байдал нь төрийн хариуцлага, үйлчилгээний хүртээмжид хэрхэн шууд нөлөөлдгийг нотолжээ. Харин "Public finance" онолд төрийн зардал тогтмол, урьдчилан таамаглахуйц байх нь төрийн үйлчилгээний үргэлжлэл, тогтвортой байдалд чухал ач холбогдолтой гэж үздэг (Musgrave, 1959). Улмаар (OECD, 2015)-ийн судалгаагаар төсвийн тасралтгүй байдал, хэмнэлттэй хэрэглээний бодлого нь төрийн байгууллагуудын урт хугацааны үйл ажиллагааг хангаж, уян хатан болгох нэг чухал нөхцөл гэж дүгнэжээ. Хууль эрх зүйн орчны тогтвортой байдал талаас (North, 1990) институцийн онолын хүрээнд тогтвортой, ойлгомжтой эрх зүйн орчин нь эдийн засагт эерэгээр нөлөөлж, дүрэм журам тогтвортой байснаар албан хаагчдын хандлага, байгууллагын соёл ч мөн тогтвортой болдог гэж тайлбарласан (Trondal, 2023). 40 жилийн хугацаанд 13,173 ажиглалтад үндэслэсэн, яам, агентлагийн түвшний төрийн албан хаагчдыг хамарсан есөн удаагийн судалгааны мэдээллийг ашиглан төрийн байгууллагын бүтэц нь цаг хугацааны туршид тогтвортой, системтэй төрийн удирдлагын чадамжийг хэрхэн илэрхийлж байгааг судлаад “тогтвортой байдалд суурилсан хүчтэй төрийн удирдлага” (robustness-as-stability) гэдэг нь төрийн албан хаагчдын зан үйл, хандлага нь тухайн байгууллагын систем дотор болон хоорондоо тогтсон, тасралтгүй үргэлжилж буй хэв шинжтэй болохыг тогтоосон байна.

1.6. Судалгааны хязгаарлалт:

Судлаачдын зүгээс төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлыг үнэлэхдээ тогтвортой байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг хууль эрх зүй,

эдийн засаг, улс төр, засаглал гэсэн дөрвөн үндсэн хүрээнд авч үзэн, нийт 19 дэд үзүүлэлтийн үнэлгээнд суурилан судалсан болно. Судалгаанд ашигласан олон улсын индексүүд нь ихэвчлэн макро түвшний мэдээлэлд үндэслэсэн тул тухайн байгууллагын (микро түвшин) үйл ажиллагааны тогтвортой байдлыг шууд хэмжихэд тохиромжгүй байх магадлалтай. Индекс бүр нь өөр өөр аргачлал, хэмжүүр, жинлэлтийн зарчим ашигладаг учраас тэдгээрийг нэгтгэн харьцуулах явцад арга зүйн зөрүү, зөрчилдөөн гарах эрсдэлтэй. Судалгаанд олон улсын нөхцөл байдал, тэр дундаа цар тахал зэрэг гадаад хүчин зүйлсийн шууд болон шууд бус нөлөөллийг нарийвчлан тусгаагүй нь судалгааны үр дүнг тайлбарлахад хязгаар үүсгэж болзошгүй.

Онолын хэсэг

2.1. Тогтвортой байдлын талаарх ерөнхий ойлголт

"Тогтвор" гэх үг нь “тогтох”, “байх”, “сахих” гэх утгатай бөгөөд аливаа зүйл өөрчлөлтгүйгээр, хэвийн, тасралтгүй оршин тогтнохыг илэрхийлдэг. Энэхүү үгийг Монгол толь бичигт юмны хөдлөхгүй байх бололцоо: тогтвор сайтай (эд зүйл тулгуур суурь сайтай), журамласан толь бичигт тогтоц, суурь, суурьшил, Я.Цэвэлийн Монгол хэлний товч тайлбар тольд тогтвор бүхий, суурьшилтай, тогтоцтой; тогтвортой суух; тогтвортой санаа, Захиргааны шинжлэх ухааны нэр томъёоны тайлбар тольд аливаа үзэгдлийн төлөв байдал, чанар, оршихуйн хэлбэр нь хэлбэлзэл багатай, тогтуун байхыг тогтвортой байдал хэмээн тус тус тодорхойлсон байдаг. Харин Кембриджийн толь бичигт “тогтвортой байдал” (sustainability) хэмээх ойлголтыг аливаа зүйлийг тодорхой хугацаанд үргэлжлүүлэх, оршин байлгах чадвар, чанар, Merriam-webster толь бичигт удаан хугацаанд оршин тогтнох чадвар, Оксфордын толь бичигт ямар нэг өөрчлөлт, үймээн самуунгүй, тогтвортой, хэвийн байдалд байх чанар гэж, Langeek толь бичигт аливаа зүйлийг тогтворжуулах, хэлбэлзэхээс сэргийлэх, бат бөх болгох, эсвэл нэг газарт хөдөлгөөнгүйгээр бэхэлж тогтоох гэж тодорхойлсон байдаг. Үүнээс харахад “stability” буюу тогтвортой байдал нь аливаа систем, үзэгдэл, төлөв байдал хэлбэлзэлгүй, тогтуун, тогтмол буюу оршихуйн хэлбэр нь тогтвортой, тогтсон шинжтэй байхыг илтгэж байна.

Харин тогтвортой үйл ажиллагаа гэдэг нь байгууллага тодорхой зорилго, чиг үүргийн хүрээнд дараах шинжүүдийг хангасан байдлаар үйл ажиллагаа явуулахыг хэлнэ. Үүнд:

- Үр дүнтэй (*үр өгөөжтэй*)
- Үр ашигтай (*нөөцийг оновчтой зарцуулдаг*)
- Тасралтгүй (*сааталгүй, зогсолтгүй*)
- Дасан зохицох чадвартай (*шинэ нөхцөлд түргэн нийцдэг*)

Тогтвортой ажиллагаа нь олон хүмүүсийн хамтын ажиллагааг уялдуулах нөхцөлийг бүрдүүлж, тухайн системийн чадавхыг хэт ачаалалгүйгээр хангаж өгдөг (Allison, 1971).

2.2. Төрийн захиргааны байгууллага, онцлог

Төрийн албаны тухай хуулийн 12.1 дахь хэсэгт Төрийн захиргааны албан тушаалд төрийн бодлого боловсруулахад мэргэшлийн зөвлөгөө өгөх, уг бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах, зохион байгуулах чиг үүрэг бүхий албан тушаалыг хамааруулан гэж заасан байдаг. Төрийн захиргаа бол нийгэм

оршин тогтноход шаардлагатай нийтэд тустай үйлчилгээг үзүүлэх менежмент, удирдлагын “урлаг” юм.(Стелла З.Теодулу)

Төрийн захиргааны байгууллагын онцлог:

1. Хуульд үндэслэн ажиллах
2. Тогтворгүй орчныг тогтворжуулах
3. Мэргэшсэн, тогтвортой бүрэлдэхүүн
4. Ил тод, хариуцлагатай байдал
5. Иргэдэд чиглэсэн үйлчилгээ
6. Удирдлагын шаталсан бүтэцтэй

2.3. Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдал

Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдал нь төрийн захиргааны үйл ажиллагааг үр дүнтэй, хариуцлагатай, иргэдийн эрх ашгийг хамгаалсан, хууль ёсны дагуу явуулахыг хэлнэ. Энэ нь засгийн газрын бодлого, шийдвэрүүдийг амжилттай хэрэгжүүлэх, нийгмийн сайн сайхан байдлыг хангах үндсэн хүчин зүйлсийн нэг юм. Жишээлбэл, төрийн захиргааны байгууллага нь засгийн газрын бүрэлдэхүүний өөрчлөлт, удирдлагын солигдолт, эсвэл эдийн засгийн савлагаа зэрэг гадаад хүчин зүйлсийн нөлөөнд оролгүйгээр үндсэн чиг үүрэг, үйлчилгээгээ хэвийн, найдвартай үргэлжлүүлэн гүйцэтгэж байвал, энэ нь тогтвортой үйл ажиллагааны тод илэрхийлэл болно. Аливаа улс орны төрийн алба хэдий чинээ мэргэшсэн, тогтвортой байх тусам тухайн орны улс төр, эдийн засаг, нийгмийн хүрээг хамарсан өөрчлөлт, шинэтгэлийн үр дүн төдий чинээ сайжирч нийгмийн хөгжлийн хөтөч болж чаддаг байна. (Тэмүүжин, 2025) Манай Улсын хувьд 2008 онд “Төрийн албаны тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, төрийн албыг улс төрийн зүй бус нөлөөллөөс ангид байлгах, төрийн мэргэшсэн, тогтвортой албыг төлөвшүүлэн бэхжүүлэх чиглэлд чухал алхам хийсэн юм. (Удирдлагын академи, 2018) 1993 оноос хойш төрийн албаны шинэтгэл хийхтэй холбоотой батлагдан гарсан бодлогын баримт бичгүүдийн үзэл санаа нь төрийн албыг цомхон, чадварлаг болгох, төрийн албаны зардлыг бууруулах, үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх, ... төрийн мэргэшсэн, тогтвортой алба төлөвшүүлэх зэрэгт чиглэгдэж байсан. (Удирдлагын академи, 2018)

Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдалд нөлөөлөх хүчин зүйлс:

1. Төрийн захиргааны чадавхи, ТАХ-дын чадавх: Төрийн албан хаагчдын мэргэжлийн түвшин, удирдлагын чадавхи нь захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнд шууд нөлөөлнө.

2. Ил тод байдал, хариуцлага:Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх нь иргэдийн итгэлийг нэмэгдүүлж, үр дүнтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэх үндэс болдог.

3. Хууль эрх зүйн тогтолцоо: Хууль, дүрмийг хэрэгжүүлэх нь захиргааны байгууллагын үйл ажиллагааг тогтвортой болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг.

4. Бодлого, шийдвэрийн хэрэгжилт: Засгийн газрын болон бусад төрийн байгууллагуудын боловсруулсан бодлого, шийдвэрийг зөв хэрэгжүүлэх нь захиргааны байгууллагын тогтвортой байдалд чухал нөлөөтэй.

5. Авлигаас ангид байдал: төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа нь авлигаас ангид байх ёстой. Авлига нь захиргааны байгууллагын үйл ажиллагааг тогтвортой байлгахад томоохон саад болж, төрийн байгууллагын итгэлийг бууруулахад хүргэдэг.

7. Иргэдийн оролцоо: Иргэдийн оролцоо нь захиргааны байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдалд шууд нөлөөлдөг. Иргэдийн санал хүсэлт, оролцоог хүлээн авсан төрийн шийдвэрүүд илүү үр дүнтэй хэрэгждэг.

8. Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийг хангах: Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилтыг бодитой биелүүлэхгүйгээр ямар ч үр дүн, ололт дэвшил хүлээх боломжгүйг бидний туулж ирсэн тогтворгүй засаглалын туршлага харуулж байна. Тиймээс ТХЗ-ын 17 зорилтыг хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллах шаардлагатай.

Судалгааны хэсэг

3.1. Төрийн захиргааны байгууллагын өнөөгийн нөхцөл байдал

Монгол Улсын төрийн захиргааны байгууллагууд 2024 онд бүтцийн шинэчлэл, хяналт үнэлгээний тогтолцооны сайжруулалт, ёс зүйн хэм хэмжээний шинэчлэл зэрэг олон талт өөрчлөлтүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд: 2024 оны 10-р сарын 2-нд Засгийн газрын 109 дүгээр тогтоолоор төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалтнуудын ёс зүйн хэм хэмжээг шинэчлэн баталсан, төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийх, үр дүнг сайжруулах чиг үүрэгтэй Хяналт, үнэлгээний Үндэсний хороо байгуулагдсан зэргийг дурдаж болно. Гэсэн хэдий ч өнөөдрийг хүртэл чиг үүргийн давхардал, хүний нөөцийн асуудал, авлига зэрэг сорилтуудыг шийдвэрлэх шаардлага хэвээр байгаа бөгөөд төрийн захиргааны байгууллагууд байнгын хөдөлгөөнд оршиж байна. Монгол улсад ерөнхий чиг үүргийн болон чиглэлийн 16 яам, тохируулагч, хэрэгжүүлэгч 40 агентлаг, болон нутгийн захиргааны байгууллагууд төрийн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Зураг 1. Төрийн захиргааны байгууллагын бүтэц

2023 оны байдлаар Монгол Улсад нийт 226,496 /эмэгтэй 144,183 63.66%, эрэгтэй 82,313 36.34%/ төрийн албан хаагч байгаагаас 21,639 буюу 9.56% нь захиргааны албан хаагч байна. Төрийн захиргааны албанын албан хаагчийн хувьд 2014 онд 19,522 байсан бол 2023 онд 21,639 болж өссөн байна.

Зураг 2. Төрийн албан хаагчдын тоо /2014-2023/

Харин яам, агентлагийн хувьд тооны хувьд өөрчлөлт багатай харагдаж байгаа боловч, бүтэц чиг үүрэг түүнийг дагасан нэршлийг өөрчилсөөр ирсэн.

Зураг 3. Яам, агентлагийн тооны өөрчлөлт

Зураг 4.*Засгийн газрын хэрэгжүүлэгч, тохируулагч агентлагийн тооны өөрчлөлт /2013-2023/*

/2013-2023/





Эх сурвалж: Төрийн албан хаагчийн 2023 оны Улсын нэгдсэн тоо бүртгэл

Төрийн албан хаагчдыг насны бүлгээр авч үзэхэд 25-34 насны эзлэх хувь хамгийн их буюу 31,03 байна. Тиймээс төрийн албаны хүний нөөцийг тогтвортой байлгахын тулд залуучуудад чиглэсэн бодлогын арга хэмжээ шаардлагатай байна.

3.2. Монгол улсын төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлын хүчин зүйлийн шинжилгээ

3.2.1 Хүний нөөцийн орчин

"Төрийн алба" хэмээх ойлголт нь нийтлэг утгаараа төрөөс нийтийн сайн сайхны төлөө үзүүлэх үйлчилгээ буюу үйл ажиллагааг илэрхийлсэн ойлголт бөгөөд энэ нь төрийн байгууллагад ажиллах албан хаагчдаар дамжин хэрэгждэг. (Дэмбэрэл, 2018) Төрийн албан хаагч нь байгууллагын бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, туршлага, алдаа, онооны ой санамж байдаг бөгөөд хамгийн чухал нөөц билээ. Тиймээс төрийн албан хаагчид гадаад болон дотоод орчны хүчин зүйлээс шалтгаалан шилжилт, хөдөлгөөн ихсэх нь төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдал, чанартай, үр ашигтай үйлчилгээ дагаад алдагдахад хүрнэ. Тиймээс манай улсын хувьд төрийн захиргааны байгууллагын тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж буй чухал хүчин зүйлийн нэг нь хүний нөөц хэмээн үзэж байна.

Хэдийгээр Төрийн албаны тухай хуулиар төрийн албан хаагчид хамгаалагдсан гэж харагдаж байгаа ч үнэндээ сонгуулийн дараа аль улс төрийн нам ялснаас хамаараад албан хаагчдыг халж, сольж байна. Тэр битгий хэл нэг нам дотроо удирдлага солигдоход өмнөх даргын ажилд авсан албан хаагчдыг их сольж байна. (Удирдлагын академи, 2021)

Үүнийг мөн Дэлхийн банкнаас хийсэн судалгаанд Засгийн газар удаа дараа солигдох, чадахуйн зарчимд тулгуурласан тогтолцоо бүрдээгүйгээс үүдэлтэйгээр албан хаагчдыг халж сэлгэх нь төрийн албаны ард иргэдэд төрийн үйлчилгээг үр дүнтэй хүргэх ерөнхий чадварт сөргөөр нөлөөлж байна хэмээн тэмдэглэсэн байдаг. (Дэлхийн банк, 2020)

Монгол улсын төрийн албанд шилжилт хөдөлгөөн 2009-2012 онд ойролцоогоор 9% байсан бол 2019 онд 22% болж огцом өссөн байна.

Зураг 5. Төрийн албан хаагчийн шилжилт хөдөлгөөн



Харин Төрийн захиргааны албан хаагчид 2023 оны байдлаар нэг жилийн хугацаанд төрийн албанаас халагдсан 50, чөлөөлөгдсөн 1698, түр чөлөөлөгдсөн 613, шилжсэн 862, сэлгэсэн 157 буюу нийт 3380 шилжилт хөдөлгөөн хийсэн байна. Түүнчлэн Төрийн албан хаагчдын ажилласан жилийн тоон үзүүлэлтийг 2023 оны байдлаар авч үзэхэд 0-5 жил ажилласан төрийн албан хаагч хамгийн их буюу 6379 байгаа нь байгууллагын тогтвортой байдалд нөлөөлж байгааг бататгаж байна.

Зураг 6. Төрийн албан хаагчийн ажилласан жилийн тоон үзүүлэлт



Эх сурвалж: Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайлан

Мөн Удирдлагын академиас 2021 онд 21 аймаг, нийслэлийн нийт 2193 төрийн албан хаагчдаас авсан судалгаанаас харахад нийт албан хаагчдын 47 хувь нь ажлаа солих бодолтой гэжээ. Харин Төрийн албаны зөвлөл болон Философийн хүрээлэнгээс 2025 онд 1720 төрийн албан хаагчийг хамруулсан судалгаанд ердөө 20 орчим хувь буюу таван хүний нэг нь тогтвортой ажиллана гэж хариулсан бол таван хүний дөрөв нь ямар нэгэн байдлаар ажлаа солихыг хүсэж, төлөвлөж байгаа бөгөөд Төрийн тусгай албанд тогтвортой байдал харьцангуй сайн байгаа бол төрийн захиргааны байгууллагад харьцангуй сул байна гэсэн дүн гарсан байна. (Баасантогтох, О., Номун-Эрдэнэ, Д., Пүрэвханд, Ж, 2025) Эдгээр нь хувь хүний бодол хэдий ч төрийн албаны хувьд мэдлэг туршлага гадагш урсах, тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж, төрийн ой санамж алдагдах аюултай юм.

3.2.2. Улс төрийн орчин

Өнгөрсөн 27 жилд Монгол Улсад төрийн уламжлалт нэгдсэн тогтолцоо алдагдсан, улс төрийн намууд төрийн эрх мэдлийг гартаа авч, төрийнхөө дээр гарсан эрх мэдэлтэй болж, мэргэшсэн төрийн албыг намын харъяалал, танил тал, хамаатан садангийн сувгаар сонгосон хүмүүсээр байнга сольж, өөрчилж ирсэнээс төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байдал, уламжлалт залгамж чанар алдагдаж, эцсийн дүндээ засаглал улам муудсаар ирсэн. (Батмөнх, 2018) Төрийн албаны тухай хуульд 2008 онд нэмэлт өөрчлөлт оруулж төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчдын улс төрийн намын гишүүн байх явдлыг хязгаарласан байдагч бодит байдал дээр улс төрийн нөлөөлөл оршсоор байна. Түүнчлэн улс төрийн сонгуулийн дүн төрийн албаны тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөг гэсэн таамаг олон нийтийн дунд байдаг. (Удирдлагын академи, 2020) Захиргааны байгууллага улс төрөөс ангид, мэргэшсэн байдлаар ажиллах ёстой ч, улс төрийн намуудын оролцоо, нөлөө улам бүр нэмэгдэж байгаа нь мэргэшсэн албан хаагчдын ажлын тогтвортой байдал, байгууллагын уур амьсгалд сөргөөр нөлөөлдөг. Энэ үзэгдлийг “улс төржилт” хэмээн нэрлэж, Монголын төрийн байгууллагуудад нэн хортой нөлөөтэй гэж судлаачид онцолдог. Мөн Азийн Сангаас 2022 онд хийсэн “Монгол Улсын засаглалын индекс”-т дурдсанаар: “Бодлогын тогтворгүй байдал нь ялангуяа сонгуулийн дараа шинээр томилогдсон удирдлагуудын хүрээнд илүү ихээр мэдрэгддэг бөгөөд энэ нь төсвийн үр ашиг, төрийн үйлчилгээний хүртээмжид сөргөөр нөлөөлж байна.” Түүнчлэн судлаач Д.Батсүхийн “Монголын төрийн албаны улс төржилт: үр дагавар ба шийдэл” судалгаанд: “Улс төрийн нөлөөтэй томилгоо нь байгууллагын дотоод зохион байгуулалтад сөрөг нөлөө үзүүлж, ажилтнуудын хоорондын үл итгэлцэл, бүлэглэлд хуваагдах байдал бий болгодог” гэсэн байдаг. Төрийн захиргааны төв байгууллага үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад улс төр нөлөөлж байгааг 2024 оны сонгуулийн дараа 7 яамны нэршил, бүтэц, чиг үүрэг өөрчлөгдөж, хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн ихсэж, өмнө нь гүйцэтгэдэг чиг үүрэг нь өөрчлөгдөх, өөр яамны асуудал болох зэргээс харж болно.

Түүнчлэн манай улсын Засгийн газрын дундаж насжилт 1 жил 10 сар буюу 2 жил ч хүрэхгүй байна. Доорх зургаас харахад өмнөх Ерөнхий сайдуудаас 2 ерөнхий сайд нь 4 жилийн бүрэн эрхийн хугацаагаа дуустал ажиллажээ. Хэдийгээр Засгийн газар огцрох болон шинээр эмхлэн байгуулагдахыг байж болох асуудал гэж улс төрийн хүрээнд

тайлбарладаг боловч төрийн бодлогын залгамж чанар, түүний тууштай, тогтвортой, тасралтгүй байдлыг хангах олон нийтийн нийтлэг эрх ашгийн үүднээс ихээхэн таагүй үзэгдэл юм. ХБНГУ 1949 оноос эдүгээ хүртэл 8 канцлер буюу засгийн газрын тэргүүнээ сольсон бол мөн хугацаанд Монгол улсын хувьд 17 Ерөнхий сайдын нүүрийг үзсэн байна. (Ариунбаяр, 2019)

Зураг 7. Монгол Улсын Засгийн газрын дундаж наслалт /1992-2025 он/, сараар



Ариунбаяр, Б. (2019).

Өнөөдөр Монгол Улсад хөгжлийн бодлогыг улс төрийн намууд тодорхойлж байна. Өнөөгийн нөхцөлд улс төрийн намууд нийт ард түмэн, улс үндэстний язгуур эрх ашгийг бүрэн төлөөлж хараахан чадахгүй, бүрэн төлөвшөөгүй байгаа билээ. Улс төрийн намуудын гол зорилго нь сонгуульд ялалт байгуулж, төрийн эрх мэдлийг авахад оршдог. Намын бодлого нь энэхүү зорилгоосоо урган гарсан ихэвчлэн сонгуулийн 4 жилд баримтлах, богино хугацаатай хэрнээ сонгуульд ялалт байгуулахад чиглэсэн явцуу бодлого байдаг. Ийм бодлого нь урт хугацааны үндэсний хөгжлийн стратегитэй тэр бүр таардаггүй. (Батмөнх, 2018) Монгол Улс дахь улс төрийн намууд нь хөгжлийн нийтлэг хандлагаас хазайж буй илрэл нь “төрийн албанд” төрийн шалгууруар бус намын шалгууруар алба хаадаг төрийн захиргааны хэврэг системийг /Spoile system/ бий болгох үндэс нь болж байна. Төрийн албаны хэврэг систем бий болсны муу үр дагавар нь төрийн захиргааны байгууллагуудын удирдлага солигдоход тухайн байгууллагад ажиллаж буй төрийн албан хаагчид давхар солигдож байгаа явдал юм. Улс төрийн намуудын чадавхи бүх талаар сул /хариуцлагагүй бохир улс төрийг хийх, иргэдийг нийгэмшүүлэх чадвар сул, нийгэмд хэрэгжүүлэх бодлого адил г.м/, хариуцлагагүй байгаа байдлаас үүдсэн төрийн албаны хэврэг тогтолцоог ямар арга замаар бэхжүүлэх, төрийн албаны тогтвортой, бат бөх тогтолцоог /мерит загвар/ яаж бий болгох вэ? гэдэг асуудал тулгараад байна. (Бат-Эрдэнэ, 2023)

3.2.3. Эдийн засгийн орчин

Төсөв нь аливаа улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийг тодорхойлох суурь баримт бичиг бөгөөд төрийн байгууллагуудын үйл ажиллагааг санхүүжүүлэх гол эх үүсвэр

болдог. Төсвийн тогтвортой байдал гэдэг нь орлого, зарлагын зохистой тэнцвэрийг хадгалах, өрийн дарамтыг хэт өсгөхгүй байх, эдийн засгийн савлагаанд дасан зохицох чадвар бүхий санхүүгийн бодлого хэрэгжүүлэхийг хэлнэ. Харин төрийн захиргааны байгууллагууд нь энэхүү төсвийн хүрээнд бодлого боловсруулж, хэрэгжүүлдэг гол гүйцэтгэгчид билээ. Монгол Улсад төсвийн ужгирсан алдагдал үүсч, төсвийн тогтвортой байдал алдагдахад нэгдмэл бус олон төсөв, түүнийг санхүүжүүлэх эх үүсвэр, төсвийн орлогыг хэт өөдрөг төсөөлөх байдал, сонгуулийн мөчлөг дагаж төсвийн зардлыг огцом нэмдэг байдал, төсвийн зардлыг жилээс жилд өндөр дүнгээр нэмэгдүүлж, алдагдал ихтэй төсөв баталж байсан, “Төсвийн тогтвортой байдлын тухай” хуулийг дагаж мөрдөхгүй тойрох зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна. Доорх графикаас харахад сүүлийн 10 жилийн хугацаанд улсын төсвийн тэнцэл 2018 он, 2023 онуудад алдагдалгүй гарсан бөгөөд бусад жилүүдэд алдагдал давтагдаж байгаа нь цаашид эдийн засгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх талтай.

Зураг 8. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого , зарлага, тэнцэл, /сая. төг/

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Төсөв тогтвортой, алдагдалгүй байснаар:

- **Бодлогын тогтвортой байдал:**Урт хугацааны стратеги, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төсвийн урьдчилан таамаглаж болохуйц, тогтвортой байдал маш чухал
- **Үйл ажиллагааны санхүүжилтийн тасралтгүй байдал:** Тогтвортой төсөвтэй байснаар төрийн байгууллагууд урт хугацааны төлөвлөлттэй ажиллах, үндсэн үйлчилгээг тасралтгүй хүргэх боломжтой. Харин төсвийн алдагдал ихтэй үед төсвийн таналт хийдэг нь байгууллагын үйл ажиллагааг доголдуулах, төсөл хөтөлбөр зогсоход хүргэдэг.

- **Төрийн албан хаагчдын тогтвор суурьшил:** Тогтвортой төсөвтэй үед цалин хангамж, нийгмийн баталгаа, ажлын ачаалал зохистой байна. Алдагдалтай төсөв нь халаа сэлгээ, бүтцийн өөрчлөлт, санхүүгийн дарамтад хүргэж, төрийн албан хаагчдыг тогтворгүй байдалд оруулдаг.

Төсвийн алдагдал нь төрийн үйлчилгээний хүртээмж, чанарт сөргөөр нөлөөлж, хүний нөөц, хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны үр дүнд тасалдал үүсгэх эрсдэлийг бий болгодог. Үүний улмаас төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа тасалданги, тогтворгүй болж, иргэдийн итгэл буурах, бодлогын хэрэгжилт сулрах зэрэг сөрөг үр дагавар бий болдог. Тиймээс төсвийн сахилга бат, санхүүгийн үр ашигт байдал нь зөвхөн эдийн засгийн биш, төрийн институцийн тогтвортой байдалд чухал нөлөөтэй нь эндээс харагдаж байна.

3.2.4. Хууль эрх зүйн орчин

Олон улсын туршлагаас харахад институцийн (төрийн байгууллагын) урт хугацааны хөгжилд **хууль эрх зүйн орчны тогтвортой байдал, урьдчилан таамаглах боломжтой байдал** чухал үүрэгтэй гэж үздэг. Төрийн албаны тухай хууль бол хуулийн хүчин чадлын ангиллаар органик хуульд багтдаг. Энэ нь хүссэн улс төрийн хүчин органик хуулийн тодорхой нэг зүйл, эсхүл заалтыг өөрчлөх боломжгүй гэсэн үг. Бодит байдал дээр төрийн албыг улс төрийн сонгуулийн дүнгээр өөрчлөх боломжийг сонгууль бүрийн дараа хуульд өөрчлөлт оруулах замаар хийж болдгийг Төрийн албаны тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөс харж болно. Төрийн албаны тухай хуулийн 23.2 буюу төрийн жинхэнэ албан хаагч сонгуульд нэр дэвшүүлэхтэй холбоотой заалтад дараах байдлаар 4 удаа нэмэлт өөрчлөлт оржээ. (Дэмбэрэл, 2018)

- 2006 оны 01 сарын 12-нд өөрчлөлт
- 2008 оны 05 сарын 06-нд нэмэлт \сонгуулиас сар гаруйн өмнө\
- 2011 оны 12 сарын 15-нд өөрчлөлт \сонгуулиас 6 сарын өмнө\
- 2016 оны 01 сарын 29-нд өөрчлөн найруулсан \сонгуулиас 5 сарын өмнө\

Үндэсний хөгжлийн газрын судалгаагаар Монгол Улсад 1990 оноос хойш нийт хөгжлийн бодлогын 567 дунд болон урт хугацааны стратеги, үзэл баримтлал, хөтөлбөр, бодлого, мастер төлөвлөгөө зэрэг баримт бичгүүд батлагдан мөрдөгдөж ирсэн (Баярсайхан, Б., Мөнхболд, А, 2018) бөгөөд Монгол Улсад Засгийн газрууд эмхлэн байгуулагдах бүрт урт хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийг хариуцсан байгууллагын статус, бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг, хариуцлага, үйл ажиллагааны цар хүрээ байнга өөрчлөгдөж, зарим яам, агентлагийн хавсарга болж, зарим чиг үүрэг нь давхардан саармагжсан байдалтай байсаар байгаа нь төрийн байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй хэвийн явагдахад нөлөөлж байна. Иймд хууль эрх зүйн орчны тогтвортой байдал нь төрийн захиргааны байгууллагын урт хугацааны үр дүнтэй, хариуцлагатай, иргэдэд чиглэсэн үйл ажиллагааг хангах үндэс суурь болдог. Цаашид хууль тогтоомжийн чанар, давхардал, зөрчлийг арилгаж, эрх зүйн орчны тогтвортой байдлыг хангах чиглэлээр тогтвортой шинэтгэл хийх шаардлагатай.

Төрийн бодлогыг хуулиар хэрэгжүүлдэг. Монгол Улсын хууль эрх зүйн орчин тогтворгүй байнга өөрчлөгдөж ирсэн байдаг. Энэ нь гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд ихээхэн тодорхой бус байдлыг үүсгэж ирсэн. УИХ- аас батлан гаргаж ирсэн олон хуулиуд нь судалгаа шинжилгээнд сайн тулгуурлаагүй гардгийг амьдрал дээр бэлээхэн нотлогддог. Энэ байдал нь бүхэлдээ манай улсын төрийн бодлогын тогтвортой залгамж чанар алдагдаж ирсний жишээ болно.

3.3 ХБНГУ-ын туршлага

ХБНГУ-ын төрийн албаны үндсэн загварын хувьд хаалттай загвар бөгөөд орчин үеийн загварын хамгийн гол онцлог бол хүний нөөцийн асуудалд улс төрийн намын оролцоо, улс төрийн томилгоог нэлээн өргөжүүлсэн явдал юм гэж судлаачид тэмдэглэдэг. Тухайлбал сонгуулийн үр дүнгээр сайд солигдоход зөвхөн төрийн нарийн бичгийн дарга болон газар, хэлтсийн дарга нар л солигддог. Удирдах албан тушаалтан солигдож байгаа энэ үндэслэл нь сайдын баг болж удирдлагын түвшинд бодлого тодорхойлоход оролцдог гэж үздэгтэй холбоотой. Гэхдээ ХБНГУ-д төрийн нарийн бичгийн дарга нь 2 хүн байдаг бөгөөд нэг нь яамны дотоод асуудлыг голчлон хариуцаж улс төрөөс хараат бусаар тогтвортой ажил үүргээ гүйцэтгэдэг бол нөгөө нь сайдын улс төрийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр ажилладаг. Тус улсад төрийн албан хаагч намын гишүүн байж болох бөгөөд харин улс төрийн үзэл бодлоо даруу илэрхийлэх, аль нам гэдгээ ил тод байлгах хэрэгтэй, харин нууцлах нь сөрөг нөлөөтэй гэж үздэг. Төрийн албан хаагчид нь хэдийгээр ил тодоор намын харьяаллаа мэдээлдэг ч улс орныхоо төлөө үнэнчээр зүтгэдэг бөгөөд олон нийт ч төрийн албан хаагчиддаа маш хүндэтгэлтэй ханддаг. Энэ уламжлалыг эрдэмтэд, судлаачид Пруссын эзэнт улсын үеэс үүдэлтэй гэж үздэг ба олон улсад үүнийг ‘Герман соёл” гэж нэрлэдэг байна. Түүнчлэн тухайн албан хаагч улс төрийн сонгуулийн нөлөөгөөр ажлаасаа чөлөөлөгдсөн тохиолдолд албан тушаалынхаа цалингийн 70 хувийг дараагийн ажилд ортлоо авдаг байна. (Дэмбэрэл, 2018)

3.4. Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлыг үнэлэх шалгуур үзүүлэлт

Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдалд нөлөөлж буй үндсэн 4 хүчин зүйлд (улс төр, хууль эрх зүй, эдийн засаг, засаглалын чадавх) үндэслэн тогтвортой байдлыг үнэлэх 19 шалгуур үзүүлэлтийг боловсруулаа. Ингэхдээ “Bertelsmann Transformation Index”-г тооцох арга зүйд тулгуурлан шалгуур индексүүдийн оноог харгалзан судалгаанд ашиглах 10, 9-7, 6-4, 3-1 оноог хувилж тооцох байдлаар боловсруулалт хийсэн. Жишээ нь: улс төрийн намын институтчлалын индексээр 1 оноо авсныг 10 оноотой гэвэл 0,4 оноо авбал 4 гэсэн зарчмаар тооцоолов.(Тооцоолол:0.4*10/1=4) Тогтвортой байдлыг үнэлэхдээ нийлбэр онооны дундаж нь 1-3 бол маш сул, 4-6 дунд зэрэг, 7-9 сайн, 10 маш сайн гэж тус тус тодорхойлов.

Хүснэгт 1. Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлыг үнэлэх шалгуур үзүүлэлт

Орчин	***Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлыг үнэлэх шалгуур үзүүлэлт***					
	Үзүүлэлт 1	***Үзүүлэлт 2***	***Үзүүлэлт 3***	***Үзүүлэлт 4***	***Үзүүлэлт 5***	***Үзүүлэлт 6***
Улс төрийн орчин	Улс төрийн намын институтчиллын индекс	Эмэгтэйчүүдийн улс төрийн эрх мэдлийн индекс	Сонгуулийн ардчиллын индекс	Иргэдийн оролцоотой ардчиллын индекс	ИНБ-ын улс төрийн тогтвортой байдлын индекс	Улс төрийн тогтвортой байдлын индекс
Хууль эрх зүйн орчин	Хууль дээдлэх ёсны индекс	Хүний эрх хууль дээдлэх ёсны индекс				
Эдийн засгийн орчин	Өрсөлдөх чадварын индекс	1 хүнд ногдох ДНБ	Төсвийн зарлагын үр ашигтай байдлын үнэлгээ	ДНБ-д төрийн зардлын эзлэх хувь	Бизнес эрхлэх нөхцөл байдлын индекс	
Засаглалын чадавх	Засгийн газрын хариуцлагын индекс	Авлигын индекс	Засгийн газрын авлигыг хянах чадварын индекс	Ардчиллын индекс	Ил тод байдлын индекс	Засгийн газрын үр ашигтай байдлын индекс

Улс төрийн орчны 6, Хууль эрх зүйн 2, Эдийн засгийн орчны 5, Засаглалын чадавхын 6 үзүүлэлтээр Монгол Улсын оноог тус тус дээр дурдсан аргачлалын дагуу тооцоолсон бөгөөд индексүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаар оруулав.

Зураг 9. Монгол Улсын төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлын үнэлгээ

Дээрх 4 орчин тус бүрийн дундаж болон нийт онооны дунджийг тооцоолоход Монгол Улс 10 онооноос **4,6** оноо авснаар тогтвортой байдлын “дунд зэрэг” түвшинд хамаарч байна. Энэ нь “маш сул” түвшинтэй ойрхон байгаа бөгөөд цаашид төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдалд анхаарал хандуулж, сууриас нь эхэлж арга хэмжээ авах шаардлагатайг харуулж байна.

4. Дүгнэлт

Төрийн бодлого боловсруулахад мэргэшлийн зөвлөгөө өгөх, уг бодлогыг амжилттай хэрэгжүүлэх гол үүргийг гүйцэтгэдэг төрийн захиргааны байгууллагын тогтвортой үйл ажиллагаа, тасралтгүй сайжруулалт, хүний нөөцийн тогтвортой байдал өнөөдөр нэн чухал асуудал болсоор байгаа бөгөөд төрийн бодлогын залгамж чанар, сайн засаглал, иргэдийн итгэлийг бий болгох гол цөм нь юм. Гэвч өнөөдөр төрийн албан хаагчийн дийлэнх нь 0-5 жил ажилласан, Засгийн газрын дундаж наслалт 1 жил 10 сар, хууль бодлогын баримт бичиг нь сонгуулийн тогтолцоогоор өөрчлөгддөг, төсвийн үр ашиггүй зарцуулалт зэргээс хамааран тогтвортой байдал алдагдаж байна. Энэхүү судалгаагаар төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлын шалгуур үзүүлэлтийг боловсруулж үр дүнг тооцоход Монгол улс 4,6 оноотой байгаа нь цаашид үр дүнтэй, бодитой арга хэмжээ авахыг сануулж байна. Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдал алдагдаж ирсэн нь төрийн албаны тогтворгүй байдал, засаглалын доройтолтой холбоотой байна. Улсын Их хурлаас хууль тогтоомжийг тогтвортой мөрдүүлэх, Засгийн газар бүрэн эрхийн хугацаандаа тогтвортой, үр дүнтэй ажиллах, төрийн байгууллагуудын зохион байгуулалтын бүтцийн зохистой бөгөөд тогтвортой байдлыг хадгалах төрийн албан хаагч албан тушаалдаа тогтвортой мэргэшин ажиллах баталгааг хангах зэрэг нь өөр хоорондоо маш нарийн уялдаа хамаарал бүхий, нэг нь нөгөөгүйгээр дангаараа төлөвшиж тогтворжих боломжгүй хүчин зүйлүүд юм. Эдгээр асуудлуудыг цогцоор нь урагш ахиулж чадвал гадаад талдаа олон улсын

хэмжээнд өрсөлдөх чадвар дээшилж, дотооддоо нийгмийн тогтвортой байдлыг хангах үндсэн нөхцөл бүрдэх учиртай.

Зураг 9. Төрийн захиргааны байгууллагын тогтвортой байдал хийсэн SWOT шинжилгээ

4.1 САНАЛ ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын захиргааны байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлыг сайжруулах арга хэмжээ:

- Иргэдийн улс төрийн мэдлэгийг боловсролын системээр дамжуулан нэмэгдүүлэх
- Төрийн үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх
- Өндөр ур чадвартай ажилтан, албан хаагчдыг ажилд авах, тогтвор суурьшилтай ажиллуулах,q сэдэлжүүлэх зохистой хөшүүргийг бий болгох
- Үр дүнд суурилсан төсөвлөлтийн зааварчилгааг ашиглан төсвийн шууд болон шууд бус захирагчдын төсвийн зарцуулалтын шинжилгээг (Spending review) болон Төсвийн зарлагын шинжилгээ (Public expenditure review)-г тогтмол хийж, гүйцэтгэх
- Удирдлагын академийн богино болон дунд хугацааны сургалтад сэтгэл судлал, стресс менежментийн бие даасан хичээлийг оруулах
- Төрийн албанд ажиллах хүчнийг сонгон шалгаруулах, томилохдоо мэргэжлийн хүнийг тухайн ажлын байранд ажиллуулах хөдөлмөрийн сэдлийг дээшлүүлж, сэтгэл ханамжийг сайжруулан, тэдний тогтвортой ажиллах боломжийг нэмэгдүүлэх

- Улс төрийн намын төлөвшил, дотоод ардчиллыг бэхжүүлж, бодлогын нам болоход дэмжлэг үзүүлэх
- Шийдвэр гаргалтад мэргэжлийн байгууллага, их дээд сургууль, эрдэмтэн судлаачдыг оролцуулах, оролцогч талуудын оролцоог хангах
- Жендэрийн эрх тэгш байдлыг бүх түвшинд хангаж, эмэгтэйчүүдийн манлайллыг нэмэгдүүлэх

Ном зүй

- Төрийн албаны тухай хууль. (2017). Retrieved from https://www.legalinfo.mn/mn/detail/13025
- OECD. (2015). Achieving Public Sector Agility at Times of Fiscal Consolidation. OECD Publishing.
- Удирдлагын академи. (2018). Төрийн албаны үнэт зүйлс: Тулгамдаж буй асуудлууд. Улаанбаатар: Мөнхийн Үсэг.
- Удирдлагын академи. (2021). Төрийн албаны хүний нөөцийн бодлого, зохицуулалтын өнөөгийн байдалд хийсэн шинжилгээ. Улаанбаатар: Мөнхийн Үсэг.
- Дэлхийн банк. (2020). Өндөр чадавхтай төрийн албыг бий болгох нь: Шинэтгэлийн явц, сургамж. Улаанбаатар.
- Удирдлагын академи. (2020). Төрийн захиргааны албан тушаалд шатлан дэвшүүлэх зарчмын хэрэгжилтэд хийсэн судалгаа. Улаанбаатар: Мөнхийн Үсэг.
- Баярсайхан, Б., Мөнхболд, А. (2018). Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн өнөөгийн байдал, шийдэл. Мөнгө, санхүү, баялаг, 35-47.
- Peters, B. G. (2019). Institutional theory in political science: The ‘new institutionalism’ (4nd ed.). UK: Edward Elgar Publishing.
- Toole, O., & Meier, K. J. (2003). Plus ca change: Public management, personnel stability, and organizational performance. Journal of Public Administration Research and Theory(13(1)), 43-64.
- Musgrave, R. A. (1959). The theory of public finance: A study in public economy. NY: McGraw-Hill.
- North, D. (1990). Institutions, institutional change and economic performance. Cambridge University Press.
- Trondal, J. (2023). “Let's organize”: The organizational basis for stable public governance. Public Administration, 101(1), 201-220.
- Тэмүүжин, А. (2025). Төрийн албаны хариуцлагын тогтолцоог сайжруулахад анхаарах асуудал. Хууль сахиулахуйн удирдлага, 30(4), 131-141.
- Дэмбэрэл, Д. (2018). Төрийн албаны тогтвортой байдалд нөлөөлөх зарим хүчин зүйл. Хууль сахиулахуйн удирдлага, 8(2), 11-22.
- Баасантогтох, О., Номун-Эрдэнэ, Д., Пүрэвханд, Ж. (2025). Төрийн албан хаагчдын сэтгэл ханамж, хандлага. Улаанбаатар.
- Батмөнх, Б. (2018). Төрийн бодлогын тогтворгүй байдал.
- Ариунбаяр, Б. (2019). Засгийн газрын тогтвортой байдал: Үндсэн хууль дахь сонгуулийн систем. Шинэ толь, 80.

- Бат-Эрдэнэ, Э. (2023). Монгол Улсын парламентат ёсны төлөвшил, бэхжилтэнд тулгарч буй түгээмэл асуудал, вестминистерийн загварын нөлөө. Политологи, 13(442).
- Allison, G. (1971). Essence of Decision: Explaining the Cuban Missile Crisis. Boston: Little, Brown.

ХАВСРАЛТ.

Судалгаанд ашигласан индексийн жагсаалт

№	Индексийн нэр	Тайлбар
А. Улс төрийн орчинг үнэлэх индексүүд		
1	Party Institutionalization index /PII/ Намын институцчлалын индекс[327]	Улс төрийн намуудын харилцаа холбоо, тэдний дотоодын зохион байгуулалт, гишүүдийн идэвх оролцоо, нийгэмд үзүүлэх нөлөөллийг тодорхойлоход ашиглагддаг бөгөөд улс төрийн тогтвортой байдал болон засаглалын чадавхийг судлахад чухал үүрэг гүйцэтгэдэг. **Тооцох аргачлал:** Тус үзүүлэлтээр 1 оноо авсан бол 10 оноотой гэж үзэж оноог хувилан бодно.
2	Political Empowerment Inde[328]: Эмэгтэйчүүдийн улс төрийн эрх мэдлийн индекс	Дэлхийн эдийн засгийн форумаас гаргадаг. Эмэгтэйчүүдийн улс төрд оролцох, парламент болон засгийн газрын байгууллагуудад суудал эзлэх, улс төрийн амжилт, сургалт, жендэрийн тэгш байдал зэрэг олон хүчин зүйлийг харгалзан үнэлдэг. **Тооцох аргачлал:** Тус үзүүлэлтээр 1 оноо авсан бол 10 оноотой гэж үзэж оноог хувилан бодно.
3	Electoral Democracy Index[329] /EDI/ Сонгуулийн ардчиллын индекс	Улс орнуудын сонгуулийн шударга байдал, иргэний эрх чөлөө, улс төрийн оролцооны түвшинг хэмждэг. **Тооцох аргачлал:** Тус үзүүлэлтээр 1 оноо авсан бол 10 оноотой гэж үзэж оноог хувилан бодно.
4	Participatory democracy	**А**рдчилсан нийгэмд иргэдийн улс төрийн шийдвэр гаргах, төрийн

[327] https://prosperitydata360.worldbank.org/en/indicator/VDEM+CORE+v2xps_party
[328] Women's political empowerment index, 2024
[329] https://www.eiu.com/n/campaigns/democracy-index-2024/

	index[330] /PDI/- иргэдийн оролцоотой ардчиллын индекс	үйл ажиллагаанд оролцох боломж, түвшинг хэмждэг. **Тооцох аргачлал:** Тус үзүүлэлтээр 1 оноо авсан бол 10 оноотой гэж үзэж оноог хувилан бодно.
5	Civil Society Participation Index[331] (CSPI)-Иргэний нийгмийн оролцооны индекс	Иргэний нийгмийн байгууллагууд болон иргэдийн улс төрийн, нийгмийн үйл ажиллагаанд оролцооны түвшинг хэмждэг индекс. **Тооцох аргачлал:** Тус үзүүлэлтээр 1 оноо авсан бол 10 оноотой гэж үзэж оноог хувилан бодно.
6	Political stability[332] Улс төрийн тогтвортой байдлын индекс	Дэлхийн банкнаас 1996 оноос хойш тооцоолсон. Энэ нь улс төрийн зорилготой хүчирхийллийн аргаар засгийн газрыг тогтворгүй болгох, түлхэн унагах магадлалын талаарх төсөөллийг хэмждэг. Улс төрийн тогтвортой байдлын индекс (-2.5 сул; 2.5 хүчтэй) **Тооцох аргачлал** -2.5 – (-1.5) бол 1-3 оноо -1.6 - 0 бол 4-6 оноо 0.1 - 1.5 бол 7-9 оноо 1.6 - 2.5 бол 10 оноо
Б. Хууль эрх зүйн орчинг үнэлэх индексүүд		
7	Rule of law index- Хууль дээдлэх ёсны индекс	Тухайн улс оронд хууль хэр хэмжээнд шударгаар, бүх хүнд тэгш үйлчилж байгаа, төрийн байгууллагууд болон иргэд хуульд захирагдаж байгаа байдалд суурилан үнэлгээ өгдөг үзүүлэлт юм. **Тооцох аргачлал:** Тус үзүүлэлтээр 1 оноо авсан бол 10 оноотой гэж үзэж оноог хувилан бодно.
8	Human Rights and Rule of Law Index -Хүний эрх ба хууль дээдлэх ёсны индекс[333]	Улс оронд хүний эрх хэрхэн хамгаалагдаж байгаа болон хууль дээдлэх ёс хэр хэмжээнд хэрэгжиж буйг хэмждэг. Ардчиллын чанар, төрийн засаглалын ёс зүй, шударга шүүх, хууль хэрэгжилт, иргэдийн эрх, эрх чөлөөг хангасан байдал зэргийг харгалзан үнэлдэг. 0-өндөр, 10- маш бага. **Тооцох аргачлал:** Тус үзүүлэлтээр 1 оноо авсан бол 10 оноотой гэж үзэж оноог хувилан бодно.

[330] https://www.theglobaleconomy.com/rankings/participatory_democracy_index/
[331] https://ourworldindata.org/grapher/civil-society-participation-index
[332] https://www.theglobaleconomy.com/rankings/wb_political_stability/
[333] https://www.theglobaleconomy.com/rankings/human_rights_rule_law_index/

В. Эдийн засгийн орчинг үнэлэх индексүүд		
9	Global Competitiveness Index (GCI)[334] Эдийн засгийн өрсөлдөх чадварын индекс	Улс орнуудын өрсөлдөх чадварыг эдийн засгийн тамир тэнхээ, засаглалын үр ашиг, бизнесийн байгууллагын ашигт ажиллагаа, дэд бүтцийн үзүүлэлтүүдээр 336 шалгуур үзүүлэлтээр үнэлдэг. **Тооцох аргачлал:** Тус үзүүлэлтээр 100 оноо авсан бол 10 гэж үзэж тухайн улс орны оноог хувилан бодно.
10	ДНБ-д төрийн зардлын эзлэх хувь	$\textbf{Төрийн зардлын ДНБ-д эзлэх хувь} = \left(\frac{\text{Төрийн нийт зардал}}{\text{ДНБ}}\right) \times 100$ Төрийн зардлын ДНБ-д эзлэх хувиар олон улсад Засгийн газрын хэмжээг тодорхойлдог. Төрийн зардлын ДНБ-д эзлэх хувь 30-аас доош байвал хэвийн, 30-40 хооронд байвал хэвийн бус, 40-өөс дээш хувийг эзэлж байвал үрэлгэн гэж үздэг. **Тооцох аргачлал:** >30 бол 6-10 оноо 31-40 бол 3-5 оноо 41< бол 1-2 оноо
11	Төсвийн зарлагын үр ашигтай байдлын үнэлгээ	0-7 оноогоор үнэлдэг. Тус үзүүлэлтээр 7 оноо авсан бол 10 гэж үзэж тухайн улс орны оноог хувилан бодно.
12	ДНБ өсөлт	**Тооцох аргачлал:** Нэг хүнд ногдох хэмжээ: 1,145 ам.доллар буюу түүнээс доош (Low-income economies) - 1-2 оноо 1,146 – 4,515 ам.доллар (Lower-middle-income economies): 3-4 оноо 4,516 – 14,005 ам.доллар (Upper-middle-income economies): 5-7 оноо 14,005 ам.доллароос дээш (High-income economies): 8-10 оноо
13	Бизнес эрхлэх нөхцөл байдлын индекс (Ease of	Улс орнуудыг 1-ээс 190 хүртэл байр эзлүүлдэг. Энэ нь тухайн улсын **хуулийн зохицуулалтын орчин** нь дотоодын бизнесийг эхлүүлэх, ажиллуулахад хэр зэрэг таатай байгааг харуулдаг. Өндөр

[334] https://prosperitydata360.worldbank.org/en/indicator/WEF+GCI+GCI4

	Doing Business Rankings)	байр эзэлсэн улс орнуудын хувьд бизнес эхлүүлэх, эрхлэх үйл явц **хялбар, үр ашигтай** гэсэн үг юм. Энэхүү байр суурийг 10 үзүүлэлтээр хэмждэг. **100 оноо** нь тухайн үзүүлэлт дээр хамгийн сайн гүйцэтгэлтэй тэнцүү, **0 оноо** нь хамгийн муу гүйцэтгэлийг илэрхийлнэ. **Тооцох аргачлал:** 100 оноо авсан бол 10 оноо гэх маягаар үнэлнэ. Монгол Улс 67.8.
Г. Засаглалын чадавхийг үнэлэх индексүүд		
14	Government Accountability Index /GAI/[335] Засгийн газрын хариуцлагын индекс	Төрийн байгууллагууд иргэдийн өмнө үйл ажиллагаагаа тогтмол, ил тод, үр нөлөөтэй тайлагнадаг эсэх, хууль дээдлэх зарчмыг дагаж мөрддөг эсэх, авлигаас ангид байдал, хууль тогтоох болон хяналтын байгууллагуудын өмнө хариуцлага хүлээдэг эсэх зэргийг цогцоор нь үнэлдэг. 0-2 оноогоор үнэлдэг. 2 руу ойртох тусмаа сайн. **Тооцох аргачлал:** Тус үзүүлэлтээр 2 оноо авсан бол 10 оноотой гэж үзэж оноог хувилан бодно.
15	Засгийн газрын үр ашигтай байдлын индекс	Үр ашигтай байдлыг хэмжиж 0-100 оноо хүртэл хэмждэг. **Тооцох аргачлал:** Тус үзүүлэлтээр 100 оноо авсан бол 10 оноотой гэж үзэж оноог хувилан бодно.
16	Corruption Perceptions Index (CPI) Авлигын төсөөллийн индекс[336]	Улс орон бүрийн төрийн албан тушаалтнууд, засгийн газрын түвшинд авлига хэр элбэг байгаа талаарх мэргэжилтнүүд, бизнес эрхлэгчдийн ойлголтод тулгуурласан үнэлгээ юм. 100 оноо хүртэл үнэлгээ өгдөг. **Тооцох аргачлал:** Тус үзүүлэлтээр 100 оноо авсан бол 10 оноотой гэж үзэж оноог хувилан бодно.
17	Control of Corruption Index /CCI/ [337]Засгийн газрын авлигыг хянах чадварын индекс	Төрийн эрх мэдэл, албан тушаалыг хувийн ашиг сонирхолд ашиглах үзэгдлийн түвшин, засгийн газрын авлигатай тэмцэх институцийн чадавх, бодлого хэрэгжүүлэх шударга байдал, ил тод байдал; иргэдийн болон бизнес эрхлэгчдийн авлигатай холбоотой хүлээлт зэргийг харгалзан үнэлдэг үзүүлэлт юм. (-2.5 сул; 2.5 хүчтэй) **Тооцох аргачлал:**

[335] https://prosperitydata360.worldbank.org/en/indicator/VDEM+CORE+v2x_accountability

[336] Corruption Perceptions Index 2024 - Transparency.orghttps://www.transparency.org/en/cpi/2024?gad_source=1&gclid=CjwKCAjwwe2_BhBEEiwAM1I7sYy_YtK_X606h6dfZ5zH5T_7CzPt6FX3r5-FPqTRQrQD9tvNx2zN1BoCa18QAvD_BwE

[337] Control of corruption by country, around the world | TheGlobalEconomy.com

		-2.5 – (-1.5) оноотой бол 1-3 оноо -1.6 - 0 оноотой бол 4-6 оноо 0.1 - 1.5 оноотой бол 7-9 оноо 1.6 - 2.5 оноотой бол 10 оноо хэмээн тооцов.
18	Democracy Index-Ардчиллын индекс[338]	Улс орнуудын ардчиллын түвшинг сонгуулийн үйл явц, засаглал, улс төрийн оролцоо, соёл, иргэний эрх чөлөө зэрэг үндсэн шалгуураар үнэлэн 1–9 онооны системээр хэмждэг олон улсын үзүүлэлт юм. **Тооцох аргачлал:** Тус үзүүлэлтээр 9 оноо авсан бол 10 оноотой гэж үзэж оноог хувилан бодно.
19	Ил тод байдлын индекс[339]	Засгийн газрын ил тод байдал, мэдээллийн нээлттэй байдлыг үнэлэх индекс бөгөөд, мэдээллийг иргэдэд хэрхэн хялбар, нээлттэй дамжуулж байгааг харуулдаг. 100 оноо хүртэл үнэлгээ өгдөг. **Тооцох аргачлал:** Тус үзүүлэлтээр 100 оноо авсан бол 10 оноотой гэж үзэж оноог хувилан бодно.

[338] https://www.voronoiapp.com/politics/The-State-of-Democracy-Around-the-World--4294
[339] Open Data Barometer